Тогтвортой хөгжлийн боловсролыг суралцахуйд интеграцчилах бодлого, арга хандлага




# ТХЗ-ЫН ТӨЛӨӨХ БОЛОВСРОЛЫГ СУРАЛЦАХУЙД ИНТЕГРАЦЧИЛАХ АРГА ЗҮЙ

# БАГА БОЛОВСРОЛ

## БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

Энэхүү гарын авлагыг ШХА-ийн санхүүжилтээр БШУЯ-ны харьяа
Боловролын хүрээлэнгийн хэрэгжүүлж буй “**Тогтвортой хөгжлийн боловсрол-II**”
төслийн хүрээнд боловсруулан хэвлүүлэв.

# ТХЗ-ЫН ТӨЛӨӨ ТХБ-ЫГ СУРАЛЦАХУЙД ИНТЕГРАЦЧИЛАХ АРГА ЗҮЙ

## (БАГА БОЛОВСРОЛ)

БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

Хоёр дахь хэвлэл

Улаанбаатар хот
2021 он

ННА 74
ДАА 370
Т-441

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra
Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг
БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН

Энэхүү гарын авлагыг "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн хүрээнд гүйцэтгэв

**Захиалагч:** "ТХБ-II төсөл"-ийн түшиц байгууллага - Боловсролын Хүрээлэн
**Гүйцэтгэгч:** Зөвлөхийн баг

Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэвлэв.
©2021. Боловсролын хүрээлэн, ТХБ-II төсөл

ISBN: 978-9919-9714-1-0

# ӨМНӨХ ҮГ

Дэлхийн улс орнуудын хөгжил, хүн амын өсөлт, техник технологийн хурдацтай дэвшил, уур амьсгал, байгаль орчны өөрчлөлт нь хүн төрөлхтний түүх, ахуй амьдралын хэв маягт олон шинэ сорилтыг бий болгож байна. Дэлхий нийтээрээ байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалахын зэрэгцээ нийгэм, эдийн засгаа тогтвортой хөгжүүлэх, харилцан ашигтайгаар хамтран хөгжих бүхий л боломжийг эрэн хайж, хүн төрөлхтөний хийгээд түүний өлгий болсон Эх Дэлхийнхээ тогтвортой байдлын төлөө ихээхэн хүчин чармайлт гаргасаар ирлээ.

Тухайлбал, Нэгдсэн Үндэсний Байгууллагаас “Эх Дэлхийгээ хувирган өөрчилье: Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг 2015 онд баталж, энэхүү хөтөлбөрт ядуурлыг бууруулах, хүн амын эрүүл, аюулгүй байдлыг хангах, боловсролын хүртээмж ба чанарыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг чиглэлээр 2030 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээг ТХ-ийн 17 зорилго, 169 товлосон зорилт болгон дэвшүүлж, хамтран хэрэгжүүлэхийг гишүүн орнуудаа уриалсан билээ.

Хүмүүс илүү сайн сайхан, тогтвортой ирээдүйг цогцлоож, тогтвортой амьдралын гол арга хэрэгсэл буюу замчлагч (driver) нь боловсрол мөн гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч, 2017 онд ЮНЕСКО-оос “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол” буюу “Education for Sustainable Development Goals” гэсэн баримт бичгийг гаргасан юм. Түүнд дэлхийн хүн бүрийг суралцагч хэмээн үзэж, ТХ-ийн дээрх баримт бичигт буй зорилго, зорилтуудыг хангахад чиглэсэн суралцахуйн зорилтууд, агуулгын сэдвүүд, арга хандлага, арга техникийг тусгайлан тодорхойлсон байна.

Энэхүү удирдамжид улс орнуудын олон жил хэрэгжүүлэхээр зорьж байгаа Бүх нийтийн Тогтвортой хөгжлийн боловсролын үйл хэргийг эрчимжүүлж, боловсролд тогтвортой хөгжлийн зорилго, агуулга, арга зүйг интеграцчилах замаар “Боловсролыг тогтвортой хөгжлийн төлөө хувирган өөрчлөх” гэсэн дэлхий нийтийн шинэ санаачилгыг бодит үйл хэрэг болгох арга замыг тодруулж өгсөн юм.

Түүнчлэн 2020 онд дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахал нь зөвхөн эрүүл мэндийн хямрал төдий биш юм. Энэ бол хүмүүн төрөлхтний амьдралын бүхий л талыг хамарсан гүн гүнзгий хямрал бөгөөд тухайн нэг улс орны төдийгүй, дэлхий нийтийн

байгаль, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээний засаглал тэр тусмаа дэлхийн хүн бүрт өдөр тутмын ажиллаж, аж төрөх арга ухаан, зан үйлээ эргэн харж өөрчлөхийг тод томруун мэдрүүлсэн үйл явдал болж байна. Товчоор хэлбэл, COVID-19 цар тахлын энэ сорилт нь нэг талаас, эх дэлхий болон хүн төрөлхтөний оршихуй нь ямар нарийн нийлмэл, ил далд харилцан хамааралтай, эмзэг хэврэг байдгийг нөгөө талаас, хэрвээ энэхүү олон талт, чанадын харилцан хамаарлыг алдагдуулбал ямар гай зовлон, сорилтууд тулгарч болохыг, түүнийг даван туулахад хэр зэрэг бэлтгэлтэй байгааг улс орон, хүн бүрт мэдрүүллээ.

Монгол Улс, Монголын боловсролын салбар нь ТХ, ТХБ-ын түүхэн хөгжлийн үе шат бүрд Дэлхий нийтийн шинэ санаачлага, үйл хэргийг ажиглаж, тэдгээрийг хэрэгжүүлэхийн төлөө чармайж ирсэн. Тухайлбал, УИХ-аас 2015 онд “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, 2020 онд энэ үзэл баримтлалыг өргөтгөн ”Алсын хараа 2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” түүнчлэн 2015 онд БСШУ-ны Сайдын А/458 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага”, 2020 онд БСШУ-ны Сайдын А/96 дугаар тушаалаар “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө: 2021-2030” зэрэг бодлогын баримт бичгүүдийг тус тус батлан хэрэгжүүлж байгааг дурьдаж болно. Түүнчлэн 2000-аад оноос хойш ТХ, ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүйг бага дунд боловсролын стандартууд, сургалтын үндэсний болон цөм хөтөлбөрүүд, сурах бичгүүдэд зохих түвшинд тусгасаар ирсэн бөгөөд энэ хугацаанд олон тооны судалгааны тайлан, эрдэм шинжилгээний бүтээл, гарын авлагууд боловсрогдож, суралцагч, багш нарын гарт хүрсэн билээ. Өргөн утгаар нь, бид олон жил ТХ, ТХЗ, ТХБ, тогтвортой байдлын талаар хангалттай уншиж, бичиж, ярьж ирсэн.

Гэвч дорвитой өөрчлөлт, хангалттай үр дүнд хараахан хүрч чадаагүй байна. Тэр тусмаа Монголын бүх насны нийт суралцагчид өөрсдийн ажил хөдөлмөрөө эрхлэх арга ухаан, харилцаа хандлага, өдөр тутмын зан үйлээ ТХ-ийн төлөө тодруулбал, ТХ-ийн бүх 17 зорилгын хэрэгжилтэд бодитой ахиц дэвшил гаргахуйц түвшинд хувирган өөрчлөх үйл явц жигд бус, харьцангуй удаашралтай явагдаж байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн шууд дэмжлэгтэй “Тогтвортой хөгжлийн боловсрол I” төслийн хүрээнд “Тогтвортой хөгжлийн боловсролыг ерөнхий боловсролын сургуулийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй” гэсэн урт нэртэй, хэрэглэгчдийн дунд “том, зузаан ногоон ном” гэж яригддаг 4 бүлэг, 21 дэд бүлэг бүхий анхны ном нь доктор, профессор Н.Нэргүй, доктор Ч.Нямгэрэл, магистр Э.Шинэцэцэг нарын бүрэлдэхүүнтэй Зөвлөх багийн удирдлагын дор БМДИ-ийн арга зүйчид болон бусад мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэй 7 дэд баг бүтэн жилийн туршид хамтран ажиллаж 2018 онд бүтээсэн билээ.

Уг номны эрэлт нэмэгдэж, хүртээмжийг өсгөх шаардлагатай байгааг харгалзан "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн хүрээнд төслийн түшиц байгууллага болох Боловсролын хүрээлэнгийн манлайлал дор анхны "зузаан" номны I, II, III бүлгийг тусад нь 1 ном (хөтөч), IV бүлгийг бага, суурь, бүрэн дунд боловсролын 3 түвшингээр бүлэглэн зохиомжилж 3 гарын авлага бүхий нийт **4 номоос бүрд**сэн багц болгон дахин хэвлүүлж, уншигч Танд өргөн барьж байна.

Энэхүү хоёр дахь хэвлэлийг бүтээхдээ анхны номын зөвлөх багийг Т.Өнөрцэцэг, Ш.Пүрэвсүрэн нараар өргөтгөж ажиллуулсан бөгөөд Д.Бадарч, А.Цанжид, Д.Гомбо, Д.Дагвадорж нарын боловсролын салбарын экспертүүдээр хянуулж тохиолдууллаа.

Зөвлөх баг нь захиалагчийн даалгаврын дагуу анхны хэвлэлийн 1 номыг 4 тусгай ном болгон салгах, мөн анхны хэвлэлээс хойших үеийн шинэ агуулгыг зайлшгүй нэмэх шаардлагын үүднээс номны анхны хэвлэлийн бүтэц, зохиомж болон агуулгын хэмжээ ба тавилд дараах өөрчлөлтүүд хийж шинэчилсэн болно. Тухайлбал,

- "Хөтөч" номонд 2015 оноос хойш дэлхий нийтийн түвшинд НҮБ, ЮНЕСКО-оос болон Монгол Улсын төрөөс ТХ, ТХЗ, ТХБ-ын чиглэлээр боловсруулан баталгаажуулсан хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйлийн хүрээний цөм агуулгыг шинээр нэмж орууллаа. Энэ нэмэлтийг хийхдээ анхны хэвлэлийн 2.2.3 дэд бүлгийн "Дэлхий нийтийн түвшин дэх ТХБ-ын хөгжлийн стратегийн замнал өрнөл" хэсгийн агуулгыг "ТХБ: 1972-2014", "ТХБ: 2015-2019", ТХБ: 2020 (ТХБ-2030") гэсэн 3 дэд хэсэгтэй, харин 2.3.1 дэд бүлгийн "ТХ ба ТХБ-ын хөгжлийн бодлого, стратегийн замнал, өрнөл" хэсгийн агуулгыг "ТХ ба ТХБ: 1996-2015", "ТХ ба ТХБ-той холбоотой томоохон судалгааны тойм", "ТХ ба ТХБ: 2016 оноос хойш" гэсэн 3 дэд хэсэгтэй болгон тус тус өөрчилсөн
- Анхны хэвлэлийн номны III дугаар бүлгийг "Хөтөч" номонд оруулахдаа 3.1 ба 3.5 дэд бүлэгт олон улсад болон Монгол улсад суралцахуйн цогц чадамжийн чиглэлээр хийгдсэн зарим судалгааны үр дүнг тодорхой хэмжээнд тоймлож, цаашид энэ чиглэлийн судалгааг гүнзгийрүүлэх хэрэгцээг хөндсөн агуулгыг нэмсэн бөгөөд 3.2-3.4 дэд бүлгийн орчуулгын агуулгыг хянан сайжруулж, ЮНЕСКО-оос 2020 онд гаргасан *"ТХБ-2030: Замын зураглал"-д* тодорхойлсон ТХ-ийн бүх 17 зорилгод ТХБ-ын оруулах хувь нэмрийг суралцахуйн зорилт бүрийн өмнө шинээр нэмж оруулсан юм.
- Анхны номны IV дүгээр бүлгийн 7 дэд бүлгийг боловсролын түвшингээр 3 хуваахдаа анхны хэвлэлд а) бага боловсролын бүх судлагдахуун, б) суурь, болон бүрэн дунд боловсролд нэвт авч үзсэн судлагдахууны агуулгын 5 чиглэл, в) боловсролын бүх түвшинд нэвт авч үзсэн хичээлээс гадуурх үйл ажиллагаа гэсэн 7 багцлалыг ч эдгээр дэд бүлэг бүрийн удиртгал хэсэг болох "... судлагдахууны интеграц" гэсэн хэсгийг ч хоёр дахь хэвлэлд хэвээр нь хадгалж, хоёр дахь хэвлэлийн

3 гарын авлага тус бүрт анхны хэвлэлд байсан хэвээр нь оруулсан. Ингэхийн учир нь нэгдүгээрт, цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцчилсан байдлыг судлагдахууны агуулгын чиглэл бүрээр шинжилж, үр дүнг боловсруулахдаа боловсролын түвшин хооронд илэрч буй ялгаатай, эсвэл төсөөтэй илэрцүүдийг харьцуулж тодорхойлсныг “суурь боловсролын”, “бүрэн дунд боловсролын” гэх мэтээр ялгах нь ач холбогдолгүй, хоёрдугаарт, зохиогчийн эрхийн талаас авч үзвэл, 50 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 7 дэд баг тус бүрийн төлөөлөлгүйгээр агуулгын болон үр дүнгийн боловсруулалтын өөрчлөлт хийх нь зохисгүй бөгөөд боломжгүй байсан тул сайжруулалтыг зөвхөн хэл найруулга талаас нь хянан тохиолдуулсан болно. Харин анхны номын 3 дугаар бүлгийн 3.2-3.4 дэд бүлгийн агуулгыг бүх 3 гарын авлагад Хавсралт болгон нэмж оруулсан. Ингэх нь багш тухайн гарын авлагаа ширээний ном болгож, өдөр тутмын хичээл, үйл ажиллагаандаа ТХЗ-ын төлөөх боловсролын суралцахуйн зорилтууд, сэдэв, арга техникүүдийг боломжоороо тусгаад явахад ач холбогдолтой юм. Мөн тухайн гарын авлагыг хэрэглэхдээ түүнийг багц номны нэг бүрэлдэхүүн хэсэг гэсэн утгаар хандаж, хүртээмжээ нэмэгдүүлэхийн тулд боломжийнхоо хэрээр хоорондоо дамжуулж хэрэглэх нь илүү тустай биз ээ.

Танд өргөн барьж буй бидний хамтын бүтээл болох Хөтөч ном болон 3 гарын авлагаас бүрдэх энэхүү багц номонд бид юуны өмнө 1972 оноос хойших дэлхий нийтийн түвшин дэх ТХ ба ТХБ-ын түүхэн замнал, үйл явцын өрнөл, тэдгээрийн зорилго, агуулга, арга хандлагын интеграцыг НҮБ-ын тулгуур баримт бичгүүдэд үндэслэн тоймлож бүхэлд нь харах, улмаар түүний Монгол Улс дахь тусгалыг “тольдох” боломжийг уншигчдад олгож байгаа юм. Энэ боломж бүрдсэнээр бид тогтвортой байдлын асуудалд хандахдаа тухайн цаг үе, үйл явдлаар хязгаарлахгүй, өмнөх туршлага, сургамждаа тулгуурлан үйл явцын динамик тасралтгүй шинжийг хадгалан бүхэл бүтэн, дотоод саланги чанарынх нь нэгдлийг голлон барьж, алсын хараатайгаар сэтгэн бодож, үйлдэн гүйцэтгэх нь илүү үр өгөөжтэй болохын чухлыг ойлгуулахыг хичээсэн болно.

Түүнчлэн ТХ, ТХБ-ын үзэл баримтлалын агуулгыг тодруулж, 2030 он хүртэл дэвшүүлсэн 17 зорилго тус бүрээр ТХЗ-д хүрэх суралцахуйн зорилтууд, гол сэдвүүд, арга хандлагууд ба арга техникүүд нь ЕБС-д хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичгүүдэд хэрхэн тусгагдсан байдлыг үнэлсэн судалгааны үр дүнд үндэслэн эдгээр зорилго, агуулга, арга техникийг анги бүрээр судлагдахуун бүрийн хичээлүүд болон сургалтыг дэмжих үйл ажиллагаандаа хэрхэн интеграцчилах өргөн боломжууд байгааг багш нарт харуулж, нэгж хичээлүүдийн жишээнүүдтэй танилцах боломжоо олгохыг зорилоо.

Энэхүү багц ном нь уншигчийн ТХ, ТХБ, ТХЗ-ын талаарх ойлголтыг тодорхой хэмжээнд цэгцэлсэн, багш, ажилтнуудад эдгээр асуудлаар олон талт судалгаа явуулах өргөн талбар байгааг

харуулсан, судалгааны баялаг материалыг ашиглан, сургалтын хөтөлбөр дэх ТХБ-ын зохистой агуулгыг сонгож, суралцахуйн дэвшилтэт арга хандлага, арга техникүүд (transformative learning or transformational teaching)-ийг багш, сурагчид хамтран хэрэгжүүлэх олон боломжийг санал болгосон, сургууль, анги танхимын түвшинд хичээл ба сургалтыг дэмжих үйл ажиллагааны интеграцийг дэмжсэн, сурагчийн ба багшийн хэн хэнийх нь хөгжилд бодит хувь нэмэр оруулахуйц шинэлэг бүтээл болсон гэдэгт итгэж байна.

Энэ талаас нь авч үзвэл багц номыг бүтээсэн арга зүй, арга хэрэгсэл нь Монгол улсдаа төдийгүй олон улсад ч туршлага болгон авч хэрэгжүүлж болох бүх шатны боловсролын бодлогын болон сургалтын баримт бичгүүдийн шинжилгээ, үнэлгээнд ашиглаж болохуйц инноваци болох боломжтой гэдэгт найдаж байна.

Багц номыг боловсруулахад ТХ, ТХБ-ын төлөө манлайлан ажиллаж, өөрсдийн эрдэм мэдлэг, сэтгэл зүтгэлээ шингээн оролцсон үндэсний зөвлөхүүд, экспертүүд, түүний анхны хэвлэлийн менежмент багийн ахлагч болон зохицуулагчаар ажилласан БМДИ-ийн захирал асан А.Туяа, орлогч захирал асан О.Оюунтунгалаг, мөн цөм хөтөлбөрт ТХ-ийн зорилгын төлөөх боловсролын тусгагдсан байдлын судалгаа хийж, загвар хичээлүүд боловсруулсан тус байгууллагын арга зүйчид ба бусад мэргэжлийн байгууллагыг төлөөлөн ажилласан ажилтнуудад талархал илэрхийлье.

Тэрбээр анхны болон хоёр дахь энэхүү багц номыг бүтээх, хэвлэх зардлыг санхүүжүүлж, түншлэн ажилласан Швейцарын хөгжлийн агентлагийн нөхөрсөг хамт олон, “Тогтвортой хөгжлийн боловсрол I ба II” төслийн багийнхан, Төслүүдийн Удирдах Зөвлөлийн гишүүдэд чин сэтгэлийн талархал дэвшүүлэхийн ялдамд Та бүхний ажил хөдөлмөрт өндөр амжилт хүсэж, бидний хамтын ажиллагаа, түншлэл улам бэхжин хөгжихийн ерөөлийг өргөн дэвшүүлье.

Багш Танд хандан “Та бол хүн төрөлхтний, Монгол Улсын ТХЗ-ыг амжилтад хүргэх түлхүүрийг атгагч, бүх суралцагчдыг ТХБ-той болоход нь туслан замчлагч” гэдгээ ямагт ухамсарлаж, түүхэн цаг үеийнхээ хэнтэй ч хуваалцахгүй мэргэжлийн үүрэг хариуцлагаа нэр төртэй биелүүлэхийг уриалж байна.

Энэхүү багц номтой танилцсан бүх түвшний бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, гадаад, дотоодын түншлэгч байгууллагууд, орон нутгийн олон нийт, эцэг эх, иргэдэд хандан ТХБ-ын төлөө боловсрол ба суралцахуй, түүний хэрэгжих орчныг хувирган өөрчлөх талаар сургууль, багш нарын гаргаж буй бүхий л санаачилга, хүчин чармалтыг тал бүрээр дэмжих ажиллахыг хүсэж байна.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

*Пүрэвийн Лхагвасүрэн*
*Боловсролын Хүрээлэнгийн захирал, (Доктор.Ph)*

# ЗОХИОГЧДЫН БАГ

| ЗӨВЛӨХИЙН БАГ | |
|---|---|
| **Багийн ахлагч:** | |
| Нэрэндоогийн Нэргүй<br>(“Тэгш таван ухаан” НҮТББ, PhD.) | Хавсралт 1-д “ТХБ-ын ТХЗ-д оруулах хувь нэмрүүд, Хавсралт 1, 2, 3-ын редакц |
| **Гишүүд:** | |
| Чойжилсүрэнгийн Нямгэрэл<br>(МУИС, PhD.) | Удиртгал, 2.1, 3.1, 4.1 дэд бүлгийн шинэчилсэн техник боловсруулалт |
| Эрдэнэбаярын Шинэцэцэг<br>(“Байгаль орчны мэдээлэл сургалтын төв” НҮТББ, Докторант) | Хавсралт 1, 2, 3-ын редакц |
| Тахадын Өнөрцэцэг<br>(“Тэгш таван ухаан” НҮТББ, Магистр.) | Нэгж хичээлүүдийн төлөвлөлтийн бүтэц, зохиомжийн редакц |
| ДЭД БАГУУД | |
| Бага боловсрол | |
| **Багийн ахлагч:** | |
| Амгалангийн Энхтогтох (БХ) | Бага боловсролын судлагдахуунуудын интеграц. Хүн ба орчин нэгж хичээлийн жишээ |
| **Гишүүд:** | |
| Пүрэвсүрэнгийн Одсүрэн (БМДИ, PhD.) | Монгол хэлний нэгж хичээлийн жишээ |
| Дондовын Энхтулга (БМДИ) | Математикийн нэгж хичээлийн жишээ |
| Энхжаргалын Даваахүү (БМДИ) | Хүн ба байгаль нэгж хичээлийн жишээ |
| Цагаанбаатарын Нарантуяа (БМДИ) | Хүн ба нийгэм нэгж хичээлийн жишээ |
| Бат-Өлзийн Батчимэг (БХ) | Англи хэлний нэгж хичээлийн жишээ |
| Зоригтын Самданжамц (БМДИ) | Биеийн тамирын нэгж хичээлийн жишээ |
| Урлаг, дизайн технологи | |
| **Багийн ахлагч:** | |
| Халтарын Энхжаргал (БХ) | Урлаг, дизайн технологийн судлагдахуунуудын интеграц. Бага боловсролын хөгжмийн нэгж хичээлийн жишээ |
| **Гишүүд:** | |
| Сияатовын Отгонтуяа (БХ) | Бага боловсролын дүрслэх урлагийн нэгж хичээлийн жишээ |

| | |
|---|---|
| Сургалтыг дэмжих үйл ажиллагаа | |
| **Багийн ахлагч:** | |
| Рэнцэнгий Золзаяа (БМДИ) | Сургалтыг дэмжих үйл ажиллагаануудын интеграц |
| **Гишүүд:** | |
| Ганжуурын Шүрэнцэцэг (Мон-Турк сургууль) | Бага боловсролын иргэний боловсрол нэгж хичээлийн жишээ |
| Навааны Мөнхбаяр (БМДИ) | Бага боловсролын амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны нэгж хичээлийн жишээ |
| Нямаагийн Цогзолмаа (МУБИС, PhD.) | Бага боловсролын хичээлээс гадуурх үйл ажиллагааны нэгж хичээлийн жишээ |
| МЕНЕЖМЕНТИЙН БАГ | |
| Пүрэвийн Лхагвасүрэн (БХ, PhD.) | Захиалагч талын ахлагч |
| Оросоогийн Оюунтунгалаг (ТХБ-II төсөл, Магистр.) | Захиалагч талын зохицуулагч |
| Лхагвын Уранчимэг (ТХБ-II төсөл, Магистр.) | Захиалагч талын ажилтан |
| ЭХ БЭЛТГЭЛ, ХЯНАЛТЫН БАГ | |
| **Зохиолын эх бэлтгэл** | |
| Пүрэвийн Дагвадорж (Эксперт, Магистр.) | Хянан тохиолдуулсан |
| Тахадын Өнөрцэцэг (“Тэгш таван ухаан” НҮТББ, Магистр.) | Техникийн редактор |
| Шагдаржавын Пүрэвсүрэн (“Тэгш таван ухаан” НҮТББ) | Хэл найруулгын редактор |
| Болдын Жамъяндорж (“ВЭП энтертаймент продакшнс” ХХК) | Техник боловсруулалтын туслах |
| **Хэвлэлийн эх бэлтгэл** | |
| Тогтмолын Анхбаяр “БИТ ПРЕСС” ХХК | Хэвлэлийн эх бэлтгэгч |

# АГУУЛГА


ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ ........ 11
ЗУРГИЙН ЖАГСААЛТ ........ 13
ТОВЧИЛСОН БА ТҮЛХҮҮР ҮГИЙН ЖАГСААЛТ ........ 14

**1. УДИРТГАЛ ........ 16**
- 1.1. Танилцуулга ........ 16
- 1.2. ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэв, арга зүй, ТБ-ын цогц чадамж болон ЕБС-ийн цөм хөтөлбөр хоорондын хамаарал ........ 20

**2. БАГА БОЛОВСРОЛ ........ 25**
- 2.1. Бага боловсролын судлагдахууны интеграц ........ 25
- 2.2. Монгол хэл ........ 40
- 2.3. Математик ........ 55
- 2.4. Хүн ба байгаль ........ 65
- 2.5. Хүн ба орчин ........ 78
- 2.6. Хүн ба нийгэм ........ 101
- 2.7. Англи хэл ........ 113
- 2.8. Биеийн тамир ........ 122

**3.УРЛАГ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИ ........ 133**
- 3.1. Урлаг, дизайн, технологийн судлагдахууны интеграц ........ 133
- 3.2. Хөгжим ........ 142
- 3.3. Дүрслэх урлаг, технологи ........ 151

**4. СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ........ 162**
- 4.1. ТХБ-ыг сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах нь ........ 162
- 4.2. Иргэний боловсрол ........ 174
- 4.3. Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа ........ 191
- 4.4. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа ........ 205

**НОМ ЗҮЙ ........ 216**

**ХАВСРАЛТ ........ 217**
- Хавсралт 1. ТХЗ-ын тогтвортой боловсролын суралцахуйн зорилт ........ 217
- Хавсралт 2. ТХЗ-ын тогтвортой боловсролын сэдэв ........ 234
- Хавсралт 3. ТХЗ-ын тогтвортой боловсролын арга хандлага, арга техник ........ 241
- Хавсралт 4. Тогтвортой байдлын түлхүүр 8 цогц чадамж ........ 249
- Хавсралт 5. Сургалтын цөм хөтөлбөрийн ТХЗБ-д хамаарах суралцахуйн зорилт ........ 251
- Хавсралт 6. Сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗБ-д хамаарах сургалтын арга ........ 255
- Хавсралт 7. Тогтвортой байдлын цогц чадамжийн төлөвшилд цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр ........ 256

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Анхны 2018 оны гарын авлага ба салгаж багцалсан 3 гарын авлагын агуулгын тойм ..... 16
Хүснэгт 2.1. Цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт, ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан байдлыг илрүүлсэн үзүүлэлт ..... 26
Хүснэгт 2.2. Бага боловсролын цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт ..... 27
Хүснэгт 2.3. Бага боловсролын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗ-ыг хангах сургалтын арга ..... 30
Хүснэгт 2.4. ТБ-ын цогц чадамжийн төлөвшилд бага боловсролын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр ..... 31
Хүснэгт 2.5. Бага боловсролын судлагдахууны жишээ нэгж хичээлийн төлөвлөлтийн товчоо ..... 32
Хүснэгт 2.6. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Монгол хэлний хичээлийн матриц 1-ээс) ..... 33
Хүснэгт 2.7. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролыг Математикийн хичээлийн матриц 1-ээс) ..... 34
Хүснэгт 2.8. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хүн ба байгаль хичээлийн матриц 1-ээс) ..... 34
Хүснэгт 2.9. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хүн ба орчин хичээлийн матриц 1-ээс) ..... 35
Хүснэгт 2.10. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хүн ба нийгэм хичээлийн матриц 1-ээс) ..... 37
Хүснэгт 2.11. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Англи хэлний хичээлийн матриц 1-ээс) ..... 38
Хүснэгт 2.12. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Биеийн тамир хичээлийн матриц 1-ээс) ..... 39
Хүснэгт 2.13. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Монгол хэл) ..... 42
Хүснэгт 2.14. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Математик) ..... 57
Хүснэгт 2.15. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хүн ба байгаль) ..... 67
Хүснэгт 2.16. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хүн ба орчин) ..... 81
Хүснэгт 2.17. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хүн ба нийгэм) ..... 104
Хүснэгт 2.18. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Англи хэл) ..... 115

Хүснэгт 2.19. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Биеийн тамир) ... 124
Хүснэгт 3.1. Урлаг, дизайн технологийн сургалтын цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт ... 136
Хүснэгт 3.2. Урлаг, дизайн технологийн сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗ-ыг хангах сургалтын арга ... 138
Хүснэгт 3.3. ТБ-ын цогц чадамжийн төлөвшилд урлаг, дизайн технологийн сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр ... 139
Хүснэгт 3.4. Урлаг, дизайн технологийн судлагдахууны нэгж хичээлийн товчоо ... 140
Хүснэгт 3.5. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хөгжим хичээлийн матриц 1-ээс) ... 141
Хүснэгт 3.6. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Дүрслэх урлаг, технологи хичээлийн матриц 1-ээс) ... 141
Хүснэгт 3.7. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хөгжим) ... 144
Хүснэгт 3.8. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Дүрслэх урлаг, технологи) ... 154
Хүснэгт 4.1. СДҮА болон СМЦ-ийн хөтөлбөрийн зорилго ... 163
Хүснэгт 4.2. СМЦ болон СДҮА-ны хөтөлбөр түвшингээр ... 164
Хүснэгт 4.3. Хөтөлбөр тус бүрийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны зорилтыг (завсрын бүтээгдэхүүн) тодорхойлсон байдал ... 165
Хүснэгт 4.4. СМЦ, СДҮА ба ТХЗ-ын хамаарах байдал (тоогоор) ... 166
Хүснэгт 4.5. СМЦ, СДҮА ба ТХЗБ-ын суралцахуйн зорилтын айн хамаарал (тоогоор) ... 167
Хүснэгт 4.6. СМЦ, СДҮА ба ТХЗ-ыг хангах сургалтын арга ... 168
Хүснэгт 4.7. СМЦ болон СДҮА-ны цагийн жишээ Интеграц боловсруулсан мэдээлэл ... 170
Хүснэгт 4.8. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Иргэний боловсролын матриц 1-ээс) ... 171
Хүснэгт 4.9. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны матриц 1-ээс) ... 172
Хүснэгт 4.10. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хичээлээс гадуурх үйл ажиллагааны матриц 1-ээс) ... 173
Хүснэгт 4.11. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Иргэний боловсрол) ... 177
Хүснэгт 4.12. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа) ... 194
Хүснэгт 4.13. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хичээлээс гадуурх үйл ажиллагаа) ... 208

# ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1.1. Матриц 1-ийн ажлын хуудасны бүтэц ........ 21

Зураг 1.2. Матриц 1-ийн товчоолох “list” хуудасны бүтэц ........ 21

Зураг 1.3. Матриц 1-ээс бэлтгэсэн “Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга” нэртэй хүснэгтийн жишээ ........ 22

Зураг 1.4. Сонгосон нэгж хичээлд харгалзах цөм хөтөлбөрийн суралцахуй зорилтын ТХЗ-д хамаарах байдлын бүдүүвч ........ 22

Зураг 1.5. Матриц 2-ын бүтэц ........ 24

Зураг 2.1. Бага боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөний цаг (хувиар) ........ 27

Зураг 2.2. ТХЗ-т хамаарах Бага боловсролын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт (хувиар) ........ 28

Зураг 3.1. Урлаг, дизайн технологийн цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт (ТХЗ-оор, хувиар) ........ 136

Зураг 3.2. ТХЗ-д хамаарах Урлаг, дизайн технологийн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт (хувиар) ........ 137

Зураг 4.1. ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй холбогдсон давтамж ба тархалт ........ 166

# ТОВЧИЛСОН БА ТҮЛХҮҮР ҮГИЙН ЖАГСААЛТ

## Товчилсон үг (Монгол, Англи)

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | БНБ | EFA | Бүх нийтийн боловсрол | Education for all |
| 2 | ДНҮХ | GAP | Дэлхий нийтийн үйлийн хөтөлбөр | Global Action Programme |
| 3 | НХ | GD | Ногоон хөгжил | Green Development |
| 4 | ТБ | | Тогтвортой байдал | Sustainability |
| 5 | ТХ | SD | Тогтвортой хөгжил | Sustainable Development |
| 6 | ТХБ | ESD | Тогтвортой хөгжлийн боловсрол | Education for Sustainable Development |
| 7 | ТХЗ | SDG | Тогтвортой хөгжлийн зорилго | Sustainable Development Goals |
| 8 | ТХЗБ | ESDG | Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол | Education for Sustainable Development Goals |
| 9 | ШХА | SDC | Швейцарын хөгжлийн агентлаг | Swiss Agency for Development and Cooperation |
| 10 | ЮНЕП | UNEP | Байгаль орчны хөтөлбөр | United Nations Environment Programme |
| 11 | ЮНЕСКО | UNESCO | Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага | United Nations Educational, Scientific and Cultural Organization |

## Товчилсон үг (Монгол)

| | | |
|---|---|---|
| 1 | АЧСҮА | Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа |
| 2 | БМДИ | Багшийн мэргэжил дээшлүүлэх институт |
| 3 | БОНХАЖЯ | Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам |
| 4 | БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| 5 | БСШУЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам |
| 6 | ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| 7 | НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| 8 | СБ | Суурь боловсрол |
| 9 | СДҮА | Сургалтыг дэмжих үйл ажиллагаа |
| 10 | СМЦ | Сургуулийн мэдлийн цаг |
| 11 | ХГҮА | Хичээлээс гадуурх үйл ажиллагаа |
| 12 | ЦХ | Сургалтын цөм хөтөлбөр |

## Түлхүүр үг (Монгол, Англи)

| № | Монгол | Англи |
|---|---|---|
| 1 | Алсын хараа | Vision |
| 2 | Арга зүй | Methodology |
| 3 | Арга хандлага | Approach |
| 4 | Байгаль орчин | Natural |
| 5 | Боловсролын стандарт | Educational Standard |
| 6 | Бүх нийтийн боловсрол | Education for All |
| 7 | Насан туршийн суралцахуй | Life long learning |
| 8 | Ногоон хөгжил | Green development |
| 9 | Суралцахуй | Learning |
| 10 | Суралцахуйн арга хандлага | Learning Approaches |
| 11 | Суралцахуйн арга, техник | Learning Method and Techniques |
| 12 | Суралцахуйн зорилт | Learning Objectives |
| 13 | Суралцахуйн зорилтын зан үйлийн ай | Behavioral domain of Learning objectives |
| 14 | Суралцахуйн зорилтын нийгэмшил-сэтгэл хөдлөлийн ай | Socio-emotional domain of Learning objectives |
| 15 | Суралцахуйн зорилтын танин мэдэхүйн ай | Cognitive domain of Learning objectives |
| 16 | Суралцахуйн хүлээгдэж буй үр дүн | Learning Outcomes |
| 17 | Сургалтын хөтөлбөр | Curriculum |
| 18 | Сургалтын төлөвлөгөө | Syllabus |
| 19 | Тогтвортой байдал | Sustainability |
| 20 | Тогтвортой байдлын (түлхүүр) цогц чадамж | (Key) Competencies for Sustainability |
| 21 | Тогтвортой хөгжил | Sustainable Development |
| 22 | Тогтвортой хөгжлийн боловсрол | Education for Sustainable Development |
| 23 | Тогтвортой хөгжлийн боловсролын цогц чадамж | Competencies of Education for Sustainable Development |
| 24 | Тогтвортой хөгжлийн зорилгууд | Sustainable Development Goals |
| 25 | Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол | Education for Sustainable Development Goals |
| 26 | Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсролын суралцахуйн зорилтууд | Education for Sustainable Development Goals: Learning objectives |
| 27 | ТХЗ-д хамаарах сэдвүүд | Suggested Topics for SDG |
| 28 | Хувирган өөрчлөлт | Transformation |
| 29 | Үйлийн хүрээ | Framework |
| 30 | Хувь нийлүүлэгчид | Stakeholders |
| 31 | Хүрээлэл орчин | Environment |
| 32 | Тэгш оролцоо, тусгай хэрэгцээг хангах[1] | Inclusive education |
| 33 | Олон янз байдал | Diversity |
| 34 | Ялварлах байдал/нөхцөл | Disparity |
| 35 | Тэгш байдал/боломж/нөхцөл | Equality |
| 36 | Тэгш бус байдал | Inequality |
| 37 | Үл алагчлах шудрага байдал/нөхцөл | Equity |

1 "Inclusive education" гэсэн энэ нэр томьёо нь "ТХЗ 4: Боловсрол-2030" үйлийн хүрээнд тодорхойлсон боловсролын алсын хараанд хамаарах түлхүүр ойлголтын нэг бөгөөд үүнийг манайд янз бүрээр орчуулан хэрэглэж байна. ЮНЕСКО-ийн Үндэсний Комисс болон Яам, ЗГ, УИХ-аас гаргасан баримт бичгүүдэд "тэгш хамран сургах боловсрол" гэсэн нэр томьёог хэрэглэж байгаа боловч энэ нь "equality", "equity" гэх мэт бусад түлхүүр нэр томьёоноос илт ялгарахгүй, хүн бүрийн тусгай хэрэгцээнүүдээ хангахаар насан туршдаа суралцах боловсрол гэсэн цаад мөн чанарын агуулгыг бүрэн илэрхийлж чадахгүй байгаа юм. Иймд багш нар энэ нэр томьёог мөн чанараар нь ойлгох шаардлагатай бөгөөд, нэр томьёо жигдэртэл "инклюсив боловсрол" гэж галиглан хэрэглэж ч болох юм.

# 1. УДИРТГАЛ

## 1.1. ТАНИЛЦУУЛГА

***"ТХЗ-ын төлөв ТХБ-ыг суралцахуйд интеграцчилах арга зүй: Бага боловсрол"*** хэмээх энэхүү гарын авлагад "ТХБ-ыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй, 2018" (цаашид "анхны 2018 оны гарын авлага" гэх)-ын 4 дүгээр бүлгээс гурван дэд бүлгийн *"судлагдахууны агуулгын чиглэл"* тус бүрийн интеграц түүнчлэн бага боловсролын *"хичээл болон СДҮА-д ТХБ-ыг интеграцчилах боломж, нэгж хичээл"*-ийг тус тус ялгаж (*Хүснэгт 1.1*) шинээр бүтэцчилсэн. Гарын авлагын энэхүү шинэ бүтцэд нийцүүлэн холбогдох танилцуулга, тайлбарыг шинээр бэлтгэн оруулахын зэрэгцээ анхны 2018 оны гарын авлагын 3 дугаар бүлгээс шаардлагатай хэсгүүдийг Хавсралт болгон нэмж оруууллаа.

*Хүснэгт 1.1. Анхны 2018 оны гарын авлага ба салгаж багцалсан 3 гарын авлагын агуулгын тойм*

| "ТХБ-ыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй, 2018" (Багшийн гарын авлага) | *ТХЗ-ын төлөв ТХБ-ыг суралцахуйд интеграцчилах арга зүй* | | |
|---|---|---|---|
| | **Бага боловсрол** | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| 4.1. Бага боловсрол | ✓ | | |
| 4.2. Хэл, хүмүүнлэгийн боловсрол | | ✓ | ✓ |
| 4.3. Математик, мэдээллийн технологи | | ✓ | ✓ |
| 4.4. Байгалийн ухаан | | ✓ | ✓ |
| 4.5. Нийгмийн ухаан | | ✓ | ✓ |
| 4.6. Урлаг, дизайн, технологи | ✓ | ✓ | |
| 4.7. Сургалтыг дэмжих үйл ажиллагаа | ✓ | ✓ | ✓ |

Төслийн үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан Матриц 1-ээр ЕБС-ийн цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг боловсролын түвшин болон хичээл тус бүрээр шинжилж, нийт 46 хичээлээр агуулгын интеграцчиллыг тодорхойлсон. Анхны 2018 оны гарын авлагад судлагдахууны агуулгын чиглэлийг боловсролын түвшингээр ялгаж агуулгын чиглэлүүдээр долоон дэд бүлэгтэй байхаар боловсруулсан бөгөөд эдгээр судлагдахууны агуулгын чиглэл бүрээр Цөм хөтөлбөрт ТХБ-ыг интеграцчилсан байдлыг боловсролын түвшингийн хооронд илэрч буй ялгаатай, эсвэл төсөөтэй илрэлийг харьцуулж, боловсруулсан тул энэ гарын авлагад зөвхөн "бага боловсролын" гэж ялгах боломжгүй гэж үзлээ. Иймд энэхүү гарын авлагын "3.1. Урлаг, дизайн, технологийн судлагдахууны интеграц", "4.1. ТХБ-ыг сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах нь" дэд бүлгүүдэд бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд бичигдсэн анхны 2018 оны гарын авлагын дэд бүлэг бүрэн эхээрээ орсон болно.

**Тодруулга:** Анхны 2018 оны гарын авлага хэвлэгдсэнээс хойш 2019 онд бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан боловсруулж БСШУ-ны Сайдын 2019 оны А/492 дугаар тушаалаар батлан мөрдөж байгаа билээ. Харин энэхүү гарын авлагад 2014, 2015, 2016 онд батлагдсан бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрт хийсэн шинжилгээний дүн, ЦХ-ийн суралцахуйн зорилтыг ТХБ-той интеграцчилан хэрэгжүүлэх жишээ болгосон нэгж хичээлийн төлөвлөлтийг “хэвээр” оруулсан тул шинэчилсэн хөтөлбөртэй нийцүүлэн бүтээлчээр хэрэглэх шаардлагатай болохыг анхаарна уу.

Боловсролд ТХБ-ыг интеграцчилах гэдгийн доор суралцахуйн зорилт, судлах сэдвийн агуулга, сургалтын арга хандлага, үнэлгээг боловсролын шинэ алсын хараанд чиглүүлэн ТХЗ-ын төлөөх боловсрол болгон хувиргаж, суралцагчдын ТБ-ын цогц чадамжийн төлөвшилд хувь нэмэр оруулахыг ойлгоно.

Анхны 2018 оны гарын авлага нь төсөл хэрэгжүүлэх хугацаа, төслийн батлагдсан дизайн зэргээс хамаарч доор дурдсан <u>*хязгаарлалтууд*</u> байсан бөгөөд энэхүү гарын авлагад ч энэ хязгаарлалт бүрэн үйлчилнэ. Үүнд:

1. Монголын ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг илрүүлэх судалгааны тусгай арга хэрэгсэл, арга зүйг боловсруулахдаа голдуу 2015 оноос хойш ТХ, ТХБ-ын чиглэлээр гарсан ЮНЕСКО-ын баримт бичиг, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны материалуудад илүү төвлөрсөн болно.
2. Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг илрүүлэх судалгааны объектыг ерөнхий боловсролын сургуульд 2017 оны байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичиг зэрэг сургалтын зөвхөн үндсэн баримт бичгүүдээр хязгаарласан.
3. Гарын авлагад жишээ болгон оруулсан нэгж хичээлүүдийн нэгдсэн туршилтыг тусгайлан явуулаагүй.
4. ТХБ-ыг цөм хөтөлбөр болон сургалтад интеграцчилах боломжийг тодорхойлохдоо энэ удаад үнэлгээний асуудлыг тухайлан авч үзээгүй болно.

## Зорилго, зориулалт

Гарын авлагыг ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн багш нар төдийгүй, боловсролын салбарт ажилладаг, суралцдаг бусад хүмүүс хэрэглэх боломжтой.

Энэхүү гарын авлагын онол арга зүйн үндсийг тодорхойлсон *“Дэлхий нийтийн болон Монгол Улсын ТХ ба ТХБ-ын хөгжлийн замнал, өрнөл, чиг хандлага: ЕБС-д ТХБ-ыг интеграцчилах гол чиглэлүүд”* сэдэвт <u>номын зорилго</u> нь ТХ, ТХБ, ТХЗ-ын үзэл баримтлалын мөн чанар, ТХЗ-д хүрэх суралцахуйн зорилго, арга зүйн үндэс, ТХ-ийн гол сэдвүүдийг багш нарт зэгцтэйгээр ойлгуулахад оршиж байв. Харин энэхүү <u>*гарын авлагын зорилго*</u> нь сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичгүүдээ дээрх үзэл баримтлалын үүднээс нягтлан судлуулж, тэдгээрт тусгагдсан ТХБ-ын агуулга, тогтвортой байдал (ТБ)-ын цогц чадамжийг ТХЗ-д хүрэх агуулга, арга зүй болгон хувиргаж, сургалт болон сургалтыг дэмжих үйл ажиллагаандаа хэрхэн *интеграцчилж* болохыг харуулах, дидактик нэгжээ томсгон хичээлээ төлөвлөж, туршуулах замаар ТХ, ТХБ, ТХЗ-ын хэл (SD/ESD/SDG literacy)-д тайлагдах сэдэл төрүүлж, боловсролын хөгжлийн шинэ алсын хараанд

чиглүүлэн өөрсдийн үйлээ тохируулан өөрчилж, ТХЗ-ын бодит хэрэгжилтийг дэмжих итгэл үнэмшил төрүүлэхэд оршино.

Боловсролын алсын хараа шинэчлэгдэж, ТХЗ 4 болон ТХБ-оор дамжуулан хойч залуу үеийнхний идэвх, санаачилга, оролцоотойгоор тэдний тогтвортой ирээдүйг хангахад зайлшгүй шаардлагатай ТХ-ийн бүх 17 зорилгыг амжилтад хүргэх томоохон сорилтууд тулгарч байна. Эргэлтийн шинжтэй ийм цаг үед энэхүү гарын авлага нь багш нарт боловсролыг хувирган өөрчлөхөд нь шаардлагатай дэлхий нийтийн, үндэсний болон салбарын түвшний цэгцтэй мэдээлэл өгч, тэднийг зайлшгүй судлах тодорхой эх үүсвэрүүдээр хангах, ТХБ, ТБ-ын цогц чадамжийг тэд өөрсдөө эзэмшиж, суралцагчдадаа эзэмшүүлэх замаар аль ч салбарын олон төрөл, хэлбэрийн үйл ажиллагаанд тодорхой, мэдлэг мэдээлэлтэйгээр бүтээлчээр оролцох, улмаар ТХЗ-ыг хангахад хүлээх өөрсдийн ухамсар, хариуцлагаа нэмэгдүүлэхэд тус тус дэмжлэг үзүүлэх *зориулалттай*.

## Арга, аргачлал

Боловсролын хөгжлийн төлөөх сүүлийн 50-иад жилийн дэлхий нийтийн хүчин чармайлтыг нэгтгэж, ЮНЕСКО-оос 2017 онд "тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол" буюу "Education for Sustainable Development Goals[2]" гэсэн баримт бичгийг гаргаж, түүнд ТХЗ-д хүргэх суралцахуйн зорилт, агуулгын сэдвийн хүрээ, арга хандлага, арга техникийг тусгайлан тодорхойлсон байна. Энэхүү баримт бичиг болон бусад холбогдох эх сурвалжийг бүрэн эхээр нь уншиж судлан ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөр (цаашид цөм хөтөлбөр (ЦХ) гэнэ)-т ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг шинжлэх арга хэрэгсэл (Матриц 1 болон Матриц 2)-ийг бүтээж, арга зүйг боловсруулахад хэрэглэсэн.

Судалгааны объект болгож ЕБС-ийн бүх ангийн бүх хичээлийн сургалтын цөм хөтөлбөр, шаардлагатай тохиолдолд суралцахуйн удирдамж, сурах бичгүүдийг нэмж, сургалтын нийтдээ 230 гаруй үндсэн баримт бичгийг ашигласан. Судалгааны объект болгосон сургалтын эдгээр баримт бичгүүдийг энэхүү гарын авлагад цаашид "*цөм хөтөлбөр*" гэсэн ерөнхий нэр томьёогоор илэрхийлнэ. Харин "Ном зүй"-д зөвхөн сургалтын цөм хөтөлбөрийг оруулсан бөгөөд бусад эх сурвалжийг тухайн холбогдох хэсэгт "footnote" байдлаар эшилсэн.

## Бүтээсэн багаж, тэдгээрийг ажиллуулах аргачлал

Энэхүү гарын авлагын зориулалтын хүрээнд үндсэн хоёр арга хэзгсэл буюу Матриц 1 ба Матриц 2-ыг тус тус бүтээж ашигласан. ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүй нь манай цөм хөтөлбөрийн агуулга, арга зүйд хэрхэн интеграцчилагдсан байдлыг үнэлэх шалгуураар ЮНЕСКО-ийн "ТХЗ: Суралцахуйн зорилт" (2017) зөвлөмжид өгөгдсөн ТБ-ын 8 цогц чадамж, ТХ-ийн 17 зорилгын хүрээнд нийт 255 суралцахуйн зорилт (Хавсралт 1), 171 сэдэв (Хавсралт 2), 119 арга хандлага, арга, техник (Хавсралт 3)-ийг тус тус сонгож, нийт 553 индикатораар бүх ангийн бүх хичээлийн бүх цөм хөтөлбөрт үнэлгээ хийх боломжтой энэхүү хоёр матрицыг бүтээсэн болно.

ТБ-ын 8 цогц чадамж (Хавсралт 4), ТХ-ийн 17 зорилгын хүрээнд нийт 255 суралцахуйн зорилт, 171 сэдэв, 119 арга хандлага, арга, техникийг тус тус сонгож, нийт 553 индикатораар бүх ангийн бүх хичээлийн бүх цөм хөтөлбөрт үнэлгээ хийх, улмаар үр дүнг нэгтгэхэд томоохон хэмжээний өгөгдөл, тоо баримттай ажиллах болсон учраас бид мэдээллийг хураангуйлах, загварчлах, нууцлах, мэдээлэл хоорондын холбоог тогтоон эрэмбэлэх боломж олгодог, агуулгыг бүхэлд

2 UNESCO, (2017), Education for Sustainable Development Goals: Learning Objectives

харж төсөөлөх, ухамсартайгаар хэрэглэх нөхцөл хангадаг, мэргэжлийн түвшинд хэрэглэхэд тохиромжтой мэдээлэл солилцооны дэвшилтэт хэл, хэрэгсэл болох КОД-ыг боловсруулж хэрэглэсэн.

| Код | Түүний тайлал |
|---|---|
| ТХ301.ТМ2. | ТХ-ийн 1-р зорилгын Танин мэдэхүйн айн 2 дахь суралцахуйн зорилт |
| ТХ315.НСХ1. | ТХ-ийн 15-р зорилгын Нийгэмшил-сэтгэл хөдлөл айн 1 дэх суралцахуйн зорилт |
| ТХ310.ЗҮ5. | ТХ-ийн 10-р зорилгын Зан үйлийн айн 5 дахь суралцахуйн зорилт |
| ТХ313.Сэ01. | ТХ-ийн 13-р зорилгын санал болгосон 1-р сэдэв |
| ТХ302.Аз4. | ТХ-ийн 2-р зорилгын жишээ болгосон 4 дэх арга |

Эхний арга хэрэгсэл буюу Матриц 1 нь бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрүүд дэх суралцахуйн зорилтод ТХБ-ын *агуулга* буюу ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдвийн интеграцчилагдсан байдлыг шинжлэх зориулалттай.

Харин хоёр дахь арга хэрэгсэл буюу Матриц 2 нь цөм хөтөлбөрт агуулгаараа ТХБ-той интеграцчилагдсан гэж тогтоогдож, сонгогдсон суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын хүрээнд санал болгосон арга хандлага, арга техниктэй хэрхэн интеграцчилж болохыг, улмаар ТБ-ын аль цогц чадамжийн төлөвшилд хувь оруулах боломжтойг тогтоож, үндэслэлийг илрүүлэх зориулалттай.

Энэхүү хоёр Матрицаар ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг хэрхэн шинжилсэн болохыг “1.2. ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэв, арга зүй, ТБ-ын цогц чадамж болон ЕБС-ийн цөм хөтөлбөр хоорондын хамаарал” дэд бүлгээс дэлгэрэнгүй танилцана уу.

## Үр дүн

Нийт 6 чиглэлийн 24 судлагдахуунаар боловсролын гурван түвшинд а) Агуулгын интеграцын 46 үр дүнгийн матриц 1-ээс ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдвийн (Хавсралт 5); б) Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцын 46 үр дүнгийн матриц 2-оос ТХЗБ-ын арга, техник, ТБ-ын цогц чадамжийн давтамж, тархалт (Хавсралт 6, 7)-ыг тус тус нэгтгэн тархалт, давтамж дахь зүй тогтол, хандлагыг энгийн дискриптив статистикийн түвшинд илэрхийлж, зарим боломжит тайлбарыг хийсэн. Үүнийг “***Тогтвортой хөгжлийн боловсролыг суралцахуйд интеграцчилах бодлого, арга хандлага: Дэлхий нийтийн түвшинд болон Монгол Улс дахь ТХ ба ТХБ-ын хөгжлийн замнал, өрнөл***” сэдэвт номын 1.5 дугаар бүлгээс үзэж дэлгэрэнгүй танилцаж болно.

Энэхүү гарын авлагын 2, 3, 4 дүгээр бүлгээс Бага боловсролын, “Урлаг, дизайн, технологи”-ийн судлагдахууны агуулгын чиглэлийн, мөн “Сургалтыг дэмжих үйл ажиллагаа”-ны хувьд цөм хөтөлбөр дэх ТХЗ, ТХЗБ-ын арга зүй, ТБ-ын цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдлын тайлбарыг дэлгэрүүлэн үзнэ үү. Агуулгын интеграц тодорхойлоход ажиглагдсан онцлог, ялгаа нь арга зүй, цогц чадамжийн хувьд ч мөн залгамж холбоотойгоор тайлбарлагдаж байгаа болно.

## 1.2. ТХЗБ-ЫН СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТ, СЭДЭВ, АРГА ЗҮЙ, ТБ-ЫН ЦОГЦ ЧАДАМЖ БОЛОН ЕБС-ИЙН ЦӨМ ХӨТӨЛБӨР ХООРОНДЫН ХАМААРАЛ

ЮНЕСКО-ийн “ТХЗ-ын төлөөх боловсрол: Суралцахуйн зорилт[3]” зөвлөмжид ТХБ-ыг ЕБС-ийн хичээл, үйл ажиллагаанд интеграцчилах үйлийн түвшин болон чиглэлийг тодорхой зааж өгсөн байна. Үүнд:

- Бодлого, стратеги, үндэсний хөтөлбөрт ТХБ-ын интеграцчилах
- Сургалтын хөтөлбөр, сурах бичигт ТХБ-ыг интеграцчилах
- Багшийн боловсролд ТХБ-ыг интеграцчилах
- ТХБ-ыг танхимын болон сургалтын бусад үйл ажиллагаагаар хангах
    - Байгууллагыг бүхэлд нь хамарсан хандлага
    - Туршлагад суурилсан, өөрчлөн хувиргах суралцахуйг хэрэгжүүлэх

Мөн ТХБ-ын суралцахуйн үр дүн болон ТХБ-ын хөтөлбөрийн чанарыг хэрхэн үнэлэх асуудлыг ч авч үзсэн байна.

Гэвч энэ олон түвшинд, үйлийн өргөн хүрээг хамарсан системийн шинжтэй интеграцчиллыг нэг удаагийн богино хугацааны төслийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй нь ойлгомжтой.

Иймд 2017 онд хэрэгжүүлсэн төслөөр үндсэн 2 интеграцчиллыг тодорхойлох зорилго тавьж ажилласан.

1. Агуулгын интеграцчиллыг тодорхойлох
2. Арга зүйн интеграцчиллыг тодорхойлох

Бид дээрх зорилгоо хэрэгжүүлэхийн тулд үндсэн хоёр арга хэрэгсэл буюу Матриц 1, Матриц 2-ыг бүтээж ашигласан болно. Эхний багаж буюу Матриц 1 нь бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрүүд дэх суралцахуйн зорилтод ТХБ-ын *агуулгын* интеграцчилагдсан байдлыг шинжлэх зориулалттай. Харин хоёр дахь арга хэрэгсэл буюу Матриц 2 нь цөм хөтөлбөрт агуулгаараа ТХБ-той интеграцчилагдсан гэж тогтоогдож, сонгогдсон суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын арга хандлага, арга техниктэй хэрхэн интеграцчилж болохыг, улмаар ТБ-ын аль цогц чадамжийн төлөвшилд хувь оруулах болох үндэслэлийг тогтоох зориулалттай.

Эхний интеграцчиллыг үнэлэх судалгааны хүрээнд 2017 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан сургалтын цөм хөтөлбөр[4]-ийн заавал судлах агуулгын хүрээнд тодорхойлсон ба “цөм хөтөлбөрийн суралцахуй зорилт”-ыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт болон сэдэвт хэрхэн хамаарч буй байдлыг тодорхойлсон.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтод ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг шинжлэх эхний арга хэрэгсэл буюу матриц 1 нь хоёр хэмжээст хөлгийн зарчмаар ажиллана. Хоёр хэмжээст нэг хөлөг нь мөрийн дагуулд ТХЗ тус бүрээр тодорхойлсон 15 суралцахуйн зорилт, баганы дагуд тухайн ТХЗБ-ын 10 сэдэв (зөвхөн ТХЗ13-т 11 сэдэвтэй)-ийг авч, эдгээр суралцахуйн зорилт ба сэдвийн огтлолцлын 150 нүд (зөвхөн ТХЗ13-т 165 нүд)-тэй (*Зураг 1.1*) хөлөг юм. ТХЗ тус бүрээр ийм бүтэцтэй нийт 17 хоёр хэмжээст хөлөг байна. Тухайн түвшний, тухайн судлагдахууны цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт нэг бүрийг шинжлээд ТХ, ТХЗ-той хамааралтай байвал 17 хоёр хэмжээст хөлгийн 2565 нүд

3 UNESCO, (2017), Education for Sustainable Development Goals: Learning Objectives

4 Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан боловсруулж 2019 онд БСШУ-ын Сайдын А/429 дүгээр тушаалаар баталснаар өмнөх цөм хөтөлбөрүүд хүчингүй болсон.

(150 x 16 + 165)-ний харгалзах нүдэнд тэрхүү суралцахуйн зорилтыг оноосон кодын хамтаар бичнэ.

*Зураг 1.1. Матриц 1-ийн ажлын хуудасны бүтэц*

ТХЗБ-ын сэдэв

ТХЗБ-ын суралцахуйн зорилт

| | A | B | C |
|---|---|---|---|
| 1 | | | |
| 2 | Сэдэв<br>Суралцахуйн зорилт" | ТХ307.Сэ01. Эрчим хүчний төрлүүд. Нар, салхи, ус, газрын гүний дулаан, далайн түрлэг зэргээр үүсэх сэргээгдэх эрчим хүч. | ТХ307.Сэ02. Улс орнуудын эрчим хүчний үйлдвэрлэл, эрэлт, нийлүүлэлт, хэрэглээ. |
| 2 | ТХ307.ТМ1. Суралцагч сэргээгдэх болон үл сэргээгдэх эрчим хүчний төрөл бүрийн нөөцийн тухай, тэдний харьцангуй давуу болон сул талууд тухайлбал, хүрээлэл орчинд үзүүлэх нөлөөлөл, эрүүл мэндийн асуудал, хэрэглээ, аюулгүй байдал, эрчим хүчний хүрэлцээ хангамж болон орон нутгийн, үндэсний, дэлхийн нийтийн түвшинд эрчим хүчний анхдагч түүхий эдийн төрөл (energy mix)-үүдэд харгалзах үйлдвэрлэсэн эрчим хүчний эзлэх хувь зэргийг мэддэг болох | 10, 11.3.а. Биотүлшийг тодорхойлох, түүний хэрэглээг нэрлэх | |
| 3 | ТХ307.ТМ2. Суралцагч дэлхийн өнцөг булан бүрт ямар эрчим хүчийг гол төлөв ашигладгийг мэддэг болох | | 11, 12.4.в. Алканы шатах урвалыг тээврийн хэрэгсэл, гэр, үйлдвэрт хэрхэн түлш болгон хэрэглэдэг шалтгааныг тодорхойлох, учирлан тайлбарлах |

list | sdg1 | sdg2 | sdg3 | sdg4 | sdg5 | sdg6 | sdg7 | sdg8 | sdg9 | sdg10 | sdg11 | sdg12 | sdg13 | sdg14 | sdg15 | sdg16 | sdg17 | sum

Суралцахуйн зорилтын тоог тоолох, дүнг товчоолох sheet

ТХЗ тус бүрийн 17 sheet

*Зураг 1.2. Матриц 1-ийн товчоолох "list" хуудасны бүтэц*

ТХЗБ-ын суралцахуйн зорилтыг ай ба анги тус бүрээр тоолно.

| | A | B | C | D | E | F | G | H | I | J | K | L | M | N | O |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | БҮГД | | ТМ | | | | НСХ | | | | ЗТ | | | |
| 2 | Тогтвортой хөгжлийн зорилт | Суралцахуйн зорилт | нийт | нийт | анги | | | нийт | анги | | | нийт | анги | | |
| 3 | | | (нүд) | (нүд) | 10 | 11 | 12 | (нүд) | 10 | 11 | 12 | (нүд) | 10 | 11 | 12 |
| 4 | ТХ301. Ядууралгүй байх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 5 | ТХ302. Өлсгөлөнгүй тэглэх | 1 | 1 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 6 | ТХ303. Сайн эрүүл мэнд ба сайн сайхан байдал | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | ТХ304. Чанартай боловсрол | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 8 | ТХ305. Жендэрийн тэгш байдал | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 9 | ТХ306. Цэвэр ус ба ариун цэвэр | 1 | 1 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 10 | ТХ307. Боломжийн үнэтэй, цэвэр эрчим хүч | 4 | 4 | 4 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 11 | ТХ308. Зохистой ажил ба эдийн засгийн өсөлт | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 12 | ТХ309. Үйлдвэрлэл, инноваци, дэд бүтэц | 5 | 4 | 4 | 4 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 13 | ТХ310. Тэгш бус байдлыг багасгах | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 14 | ТХ311. Тогтвортой хот суурин, оршин суугчид | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 15 | ТХ312. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл | 5 | 5 | 5 | 2 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 16 | ТХ313. Уур амьсгалын төлөөх үйл хэрэг | 2 | 2 | 2 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 17 | ТХ314. Усан доорх амьдрал | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 18 | ТХ315. Газар дээрх амьдрал | 1 | 1 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 19 | ТХ316. Энх тайван, шударга ёс, хүчирхэг институцууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 20 | ТХ317. ТХЗ-ын төлөөх түншлэл | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 21 | | 19 | 18 | 18 | 8 | 11 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

22 Нөхцөлт форматын тайлбар:

23 ☝ А багананд ягаан өнгөөр будагдвал тухайн ТХЗ-той интеграци бүхий суралцахуйн зорилт тодорхойлогдсон болохыг илэрхийлнэ. Харгалзах С багананд 0-ээс их утгатай, харгалзах sheet tab улаан өнгөтэй байна.

24 ☝ D, H, L баганаанд шар өнгөөр будагдвал тухайн төрөл (ТМ, НСХ, ЗТ)-ийн суралцахуйн зорилт нэг нүдэнд 1-ээс илүү бичигдсэн гэсэн үг. Үүнийг матриц 2-ыг хөтлөхдөө анхаарч үзээрэй.

25 ☝ С баганаанд ногоон өнгөөр будагдвал тухайн sheet-д бөглөгдсөн нүдийг тоолоход ямар нэг алдаа гарсан байна.

26 ☝ В баганаанд цэнхэр өнгөөр будагдвал тухайн sheet-д тодорхой ангид харгалзахгүй ямар нэг тэмдэгтээр эхэлсэн бичвэр аль нэг нүдэнд байна.

list | sdg1 | sdg2 | sdg3 | sdg4 | sdg5 | sdg6 | sdg7 | sdg8 | sdg9 | sdg10 | sdg11 | sdg12

ТХЗ тус бүрээр суралцахуйн зорилтын тоог нэгтгэж гаргана.

Нөхцөлт форматаар файл дахь алдаа болон ижил оттолцолд тодорхойлогдсон суралцахуйн зорилтын тоог гаргах боломжтой.

Матриц 1 нь судлагдахуун хариуцсан шинжээчийн бичиж тэмдэглэсэн суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилтын аль айд, хэддүгээр ангид хамаарахыг тоолох, дүнг товчилж нэгтгэх *(Зураг 1.1, Зураг 1.2)*-ээр “автоматчилагдсан” excel-ийн файл юм.

Матриц 1 нь бүрэн эхээр нь тайлан, гарын авлагад хавсаргахад тохиромжгүй бүтэц, зохион байгуулалттай юм. Иймээс Матриц 1-ээс тухайн хичээл тус бүрийн хувьд “Цөм хөтөлбөрийн ТХЗБ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга”-ыг хүснэгт байдлаар бэлтгэсэн. *Зураг 1.3*-т Бага боловсролын Монгол хэлний хичээлийн матриц 1-ээс бэлтгэсэн хүснэгтээс харуулав. Энэхүү хүснэгтийн ***1*** баганад “Бүлэг сэдэв/Агуулгын хүрээ”-г, харин ***2*** баганад ТХЗБ-д хамаарах суралцахуйн зорилтыг жагсаасан. Иймд хүснэгт тус бүрээс тухайн судлагдахууны хувьд бага боловсролын цөм хөтөлбөрийн ямар ямар суралцахуйн зорилтуудыг ТХБ-той интеграцчилах боломжтойг тодорхойлсон болохыг үзнэ үү. ***3*** болон ***4*** баганад бичигдсэн харгалзах ТХЗБ-ын суралцахуйн зорилт, ТХЗБ-ын сэдвийн кодыг үндэслэн “Хавсралт 1 болон 2”-оос тэдгээрийн агуулгыг дэлгэрүүлж үзнэ үү.

*Зураг 1.3. Матриц 1-ээс бэлтгэсэн “Цөм хөтөлбөрийн ТХЗБ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга” нэртэй хүснэгтийн жишээ*

*Хүснэгт 2.7 Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Суурь боловсролын Монгол хэлний хичээлийн матриц 1- ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 9. Унших | 9. У 2. Эхийг уншихдаа баримт ба мэдээллийг ялгах, шалтгаан ба үр дагаврын холбоо харьцааг гаргах, баримт ба үзэл бодлыг ялгах, таамаглал дэвшүүлсэн ба нотолж баталсан хэсгийг ялган тодруулах зэрэг чадвар эзэмшинэ.<br>(Монгол хэл, XI анги сурах бичиг, 97-101 тал “Элсэн чихэр” эх, “Бэлэн бүтээгдэхүүн” эх, “Сурагч бүр биеийн жингээ хянаж сурах нь хамгийн сайн хэвшил юм.” эх, “Жингийн илүүдэл” эх) | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ09. |
| 9. Унших | 9, Б.1. Байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвээр олон нийтийн анхаарал татсан асуудлаас сонгож бичихдээ тухайн сэдвийн хүрээнд мэдээлэл цуглуулах, эмхлэн цэгцлэх, өөрийн санаа бодлыг оруулан дүгнэж бичих, үзэл бодлоо үндэслэлтэй гаргах, шалтгаан ба үр дагаврын холбоог илэрхийлэх аргад суралцана. (Монгол хэл, XI анги сурах бичиг, 97-101 тал) | ТХ303.ТМ3. | ТХ303.Сэ09. |
| | 9, У.2. Эхийг уншихдаа баримт ба мэдээллийг ялгах, | | |

Хичээл тус бүрийн хувьд жишээ болгон боловсруулсан нэгж хичээлд харгалзаж буй “Цөм хөтөлбөр”-ийн суралцахуйн зорилт нь ТХЗБ-д хамаарах байдлыг матриц 1-ээс бэлтгэж бүдүүвч байдлаар илэрхийлсэн. *Зураг 1.4*-т Бага боловсролын Монгол хэлний хичээлээр жишээ болгон боловсруулсан “Тогтвортой бат бөх гүүр” сэдэвт нэгж хичээлийн хувьд цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт нь ТХЗБ-д хамаарах байдлын бүдүүвчийг харуулав.

*Зураг 1.4. Сонгосон нэгж хичээлд харгалзах цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын ТХЗБ-д хамаарах байдлын бүдүүвч*

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвт харгалзах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын сэдэв<br>ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХ303.Сэ09. Илүүдэл жин ба таргалалт хөдөлгөөний дутагдал, эрүүл бус хоол хүнс |
| ТХ303.ТМ3. Суралцагч эрүүл мэнд, сайн сайхан байдлын нийгэм-улс төр-эдийн засгийн хэмжүүрийг ойлгодог болж, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих стратеги болон тэдгээрийг ухуулан сурталчлахын үр нөлөөг мэддэг болгох<br>ТХ303.ЗҮ1. Суралцагч эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох | 9, Б.1. Байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвээр олон нийтийн анхаарал татсан асуудлаас сонгож бичихдээ тухай сэдвийн хүрээнд мэдээлэл цуглуулах, эмхлэн цэгцлэх, өөрийн санаа бодлыг оруулан дүгнэж бичих, үзэл бодлоо үндэслэлтэй гаргах, шалтгаан үр дагаврын холбоог илэрхийлэх аргад суралцах (“Монгол хэл, IX” сурах бичиг, 97-101 тал)<br>Цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт |

Хавсралт 1-д анхны хэвлэлээс ялгаатай нь ТХ-ийн 17 зорилгын суралцахуйн зорилтууд тус бүрийн өмнө ЮНЕСКО-оос 2020 онд боловсруулан хэвлүүлсэн “ТХБ-2030 үйлийн хүрээ”-нд шинээр дэвшүүлсэн *ТХБ бол ТХ-ийн бүх 17 зорилгын амжилтад хүргэх боломжийг олгогч* гэсэн шинэ дүгнэлтийн товч агуулгыг нэмж оруулсан. Иймд өмнө дурьдсан “Цөм хөтөлбөрийн ТХЗБ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга” нэртэй хүснэгт болон бидний боловсруулсан нэгж хичээлүүдийн жишээг багшлах үйл ажиллагаанд хэрэглэхдээ *“ТХБ бол ТХ-ийн бүх 17 зорилгын амжилтад хүргэх боломжийг олгогч гэсэн шинэ дүгнэлт”*-ийг бүтээлчээр холбож ашиглана уу.

Хоёр дахь арга хэрэгсэл буюу матриц 2-оор ТХЗБ-ын суралцахуйн зорилттой интеграцчилагдсан гэж тогтоогдсон цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын хүрээнд санал болгосон арга хандлага, арга техникээр хэрхэн хэрэгжүүлж, ТБ-ын аль цогц чадамжийн төлөвшилд хувь оруулах болох үндэслэлийг тогтоосон.

Матриц 2 нь нийт 10 баганатай нэг хэмжээст хөлгийн зарчмаар ажиллана (*Зураг 1.5*). Төслийн багийн гишүүдийг Матриц 2-той хэрхэн ажиллах, тухайн суралцахуй зорилтыг хэрэгжүүлэх сургалтын техник, арга, хандлагын сонголт, үндэслэл мөн ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмэр, түүний үндэслэлийг тус тус хэрхэн тодорхойлох аргачлалаар хангаж, сургалт семинарын үед харилцан ярилцаж, тайлбарлаж, зөвлөж ажилласан.

*Зураг 1.5. Матриц 2-ын бүтэц*

***1 – 5 гэсэн баганын мэдээллийг Матриц 1-ийн үр дүнгээс авах бол 6 баганад “үндэслэл, тайлбар”-ыг тодорхойлж бичнэ:***

1-ЦХ-ийн бүлэг сэдэв/агуулгын хүрээ 2-ЦХ дэх суралцахуйн зорилт
3-Аль ангийн суралцахуйн зорилт болох
4, 5-ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдвийн код

6-Цөм хөтөлбөр дэх тухайн суралцахуй зорилт нь ТХБ-той хэрхэн интеграцчилагдсан болохыг тодорхойлсон үндэслэл, тайлбар

| | A | B | C | D | E | G | H | I | J | K | L | M | N | O | P |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | | | Анги | | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
| 3<br>4 | | Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | 10 | 11 | Learning Objectives for SDGs | Topics for SDGs | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд | Шинжилгээ/ судалгаа хийх | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх | Алсын хараатай болох | Аргын сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар /суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| 16 | 12 | 9. Үелэх хүснэгт. Үелэх хандлага | 11, 09.4.к. Галоген, тэдгээрийн нэгдлийн үйлдвэрлэлийн ач холбогдол, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг томьёолох | | ✓ | TX309.TM4 | TX309.Сэ04 | Галоген агуулсан нэгдлийн үйлдвэрлэл, хэрэглээний түүх (инноваци, аж үйлдвэржилт), хөргөгч бодис (фреон), хортон шавьж устгах бодис (гербицид, пестицид)-ын хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөө, тэдгээрийн хэрэглээг хориглох (тогтворгүй үйлдвэрлэлийн тооцоолоогүй, гэнэтийн аюул, бэрхшээл) болсон, мөн өөр бодис орлуулан хэрэглэж буй шалтгаан, үндэслэлийг химийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах | | ✓ | ✓ | | Химийн шинжлэх ухааны үүднээс асуудлын мөн чанарыг тайлбарлах нь шинжилгээ, судалгаа хийхийг шаардах ба харин эдгээр бодисын хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөө, түүнийг багасгах, зохистой хэрэглээний талаар авч үзэхэд суралцачдын бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээг шаардсан хэлэлцүүлэг, шүүмж чухал байр суурьтай байна. | 2, 3 | “2 - Фреон болон бусад галоген агуулсан хэрэглээний түүх нь “”тооцоолоогүй, гэнэтийн аюул, бэрхшээл””-ийн нэгэн сонгодог тохиолдол бөгөөд өмнөх түүхийн сургамжаар ирээдүйг баримжаалахад хувь нэмэр оруулах тул 3 - хортон шавьж устгах бодисын хэрэглээний стандартыг чанд мөрдөх нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөөг нөлөөллийг хамгийн бага байлгахад нөлөөлөх тухай эрэгцүүлэл хийх тул” |
| 17 | 13 | 10. Химийн бодисын үйлдвэрлэл, хэрэглээ | 11, 10.1.д. Нитратын бордооны зохисгүй хэрэглээний хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг дурьдах, учирлан тайлбарлах | | ✓ | TX302.TM5 | TX302.Сэ03 | Ургамалд тэжээлийн үүргээр бороог хэрэглэх нь хүн амын хүнс тэжээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх (өлсгөлөнгөөс сэргийлэх) бөгөөд харин бордооны зохисгүй хэрэглээ нь хөрс, усны бохирдол, экологийн тэнцвэр алдагдах эх сурвалж болдог учраас зохистой байдлаар газар тариаланг эрхлэх талаарх ойлголт мэдлэгтэй холбоотой болно. | | ✓ | ✓ | | учирлан тайлбарлах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд заавал задлан шинжилгээ хийж асуудлыг таньж тодорхойлох, улмаар шалтгаан-үр дагаврыг холбоог олж тайлбарлах учраас 2, 3-р төрлийн арга зүйг сонгох, эдгээрт харгалзах тодорхой аргуудыг орон нутаг, сургуулийн хам нөхцөл болон сурагчдын онцлогийг тооцож арга зүйг дэглэнэ. | 1, 3, 7, 8 | “1-системийн сэтгэлгээ: хөрс, усан дахь азотын эргэлт, хөрс-ургамал-азотын бордоо гэсэн нийлмэл системийн хүрээнд асуудлыг авч үзэх тул, 3-хэм хэмжээний: бордоо хэрэглэх нормативыг мөрдөх асуудал хэлэлцэгдэх тул, 7-өөрийгөө: бордооны зохистой хэрэглээнд оруулж чадах өөрийн хувь нэмэр, хариуцлага, 8-бордооны хими, газар тариалан, хүрээлэн буй орчин гэсэн нийлмэл асуудлыг шийдвэрлэх тул” |

sheet1

7 - баганад ТХБ-той арга зүйн интеграцчиллыг хэрэгжүүлэхийн тул ТХЗБ-ын аргын 4 төрлөөр аль алийг нь хэрэглэх боломжтойг тэмдэглээд, үүний үндэслэлийг 8 – баганад тодорхойлно.

9 - баганад ТБ-ын аль цогц чадамжийн төлөвшилд хувь нэмэр оруулах боломжтой дугаараар нь тэмдэглээд 10 - р баганад тодорхойлсон цогц чадамж тус бүрээр үндэслэл, тайлбар гаргана.

Ялангуяа ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмэр, түүний үндэслэлийг тодорхойлох нь *“нэн шинэ”* асуудал байсан. Учир нь ТБ-ын аль цогц чадамжийн аль чадварын төлөвшилд ямар хувь нэмэр оруулах асуудал нь тухайн суралцахуйн зорилтыг аль ангид ямар сэдвийн хүрээнд ямар түвшинд томьёолсноос, мөн түүнийг ямар чиг хандлагын хүрээнд ямар арга техникийг хэрэглэн хичээл болон үйл ажиллагаагаар дэглэхээс ихээхэн хамаардаг. Өөрөөр хэлбэл, ТХ-ын цогц чадамжид оруулах хувь нэмэр нь нэг талаас үндэсний түвшинд боловсруулан баталсан сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг болон сургалтын орчноос, нөгөө талаас, багшийн арга зүйн ур чадвар, “бурхан ухаан”-аас хамаарах олон хүчин зүйлсийн давхар хамаарлын үр дүн болон илэрдэг юм.

Тухайн хичээл тус бүрийн хувьд матриц 2-ын бүтээгдэхүүнийг бүрэн эхээр нь “Суралцахуйн зорилт арга зүй, цогц чадамжийн интеграц” нэртэй хүснэгтээр гарын авлагад оруулсан.

Төслийн багийн гишүүдийг Матриц 1 болон Матриц 2-той хэрхэн ажиллах тухай тодорхой аргачлалаар хангаж, сургалт семинарын үед харилцан ярилцаж, тайлбарлаж, зөвлөж ажилласан.

# 2. БАГА БОЛОВСРОЛ

## 2.1. БАГА БОЛОВСРОЛЫН СУДЛАГДАХУУНЫ ИНТЕГРАЦ

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын баримт бичигт “Бага боловсролыг эх хэлний чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлэн бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвших үе хэмээн хөгжүүлнэ”[5] гэж заасан билээ.

Бидний өнөөдрийн үйл ажиллагаа маргаашийн ирээдүйд эерэгээр эсвэл эсрэгээр нөлөөлж болох учир бүх шатны боловсролын байгууллагуудын хичээл сургалт болон үйл ажиллагаа нь хүүхэд залуучуудыг хариуцлагатай, дэлхийн иргэн болгон төлөвшүүлэх, хамтран аж төрөх, хамтран суралцахад чухал үүрэг гүйцэтгэх ёстой билээ.

ЕБС-ийн бага ангийн хичээл сургалт болон үйл ажиллагаагаар дамжуулан ус, хог хаягдал, уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйл гэх мэт хүрээлэн буй орчны асуудлууд, соёлын өв, ард түмний уламжлалт зан үйл, эрүүл мэндээ хамгаалах зэрэг нийгмийн асуудлууд, тогтвортой үйлдвэрлэл болон хэрэглээ, ядуурал, аялал жуулчлал, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зэрэг нийгэм, эдийн засгийн асуудлуудыг хамарсан ТХБ-ын суурь мэдлэг, чадварыг эзэмшүүлэх боломжтой юм.

Бид бага боловсролын монгол хэл, математик, хүн ба байгаль, хүн ба орчин, хүн ба нийгэм, англи хэл, биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын агуулга, арга зүйг хэрхэн интеграцчилж тусгасан болохыг шинжиллээ.

Дээрх хичээлүүдийн цөм хөтөлбөрт шинжилгээ хийхэд дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

1. Цөм хөтөлбөрт суралцахуйн зорилтуудыг дугаарлаагүй тул шинжилгээ хийхдээ дараах байдлаар кодолсон болно. Үүнд:

**Анги** (1-5 дугаар анги тус бүрийг 1,2,3,4,5 гэж кодолсон) ← **1, 10. 2а** → **Чадварыг тоогоор** (математик, англи хэл)**, суралцахуйн зорилтыг үсгээр кодолсон**
↓
**Сэдэв**

Бага боловсролын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан байдлыг илрүүлэхэд хичээл судлагдахууны онцлогийг харгалзан үзсэн. Ихэнх хичээлүүдийн цөм хөтөлбөрт агуулга буюу суралцахуйн зорилтоор дамжуулан ТХЗБ-ын сэдвүүдийг, суралцахуйн үйлээр дамжуулан ТХЗБ-ын суралцахуйн зорилтыг интеграцчилах байдлаар тусгасан байна. Харин англи хэлний хичээл нь сурагчийн эзэмших чадвараар, монгол

хэлний хичээл нь хэрэглэгдэхүүнээр дамжуулан интеграц агуулгыг тусгах, ТБ-ын цогц чадамжийг эзэмшүүлэх онцлогтой байна (*Хүснэгт 2.1*).

*Хүснэгт 2.1. Цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт, ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан байдлыг илрүүлсэн үзүүлэлт*

| Хичээл | Цөм хөтөлбөрт тусгасан суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан байдлыг ирүүлэхэд баримталсан шалгуур | | | |
|---|---|---|---|---|
| | Агуулга буюу суралцахуйн зорилтын томьёолол | Суралцахуйн үйл | Эзэмших чадвар | Хэрэглэгдэхүүн |
| Монгол хэл | + | | | + |
| Математик | + | + | | |
| Хүн ба байгаль | + | + | | |
| Хүн ба орчин | + | + | | |
| Хүн ба нийгэм | + | + | | |
| Англи хэл | | | + | |
| Биеийн тамир | + | + | | |
| Нийт | 6 | 5 | 1 | 1 |

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилго нь "Хүүхэд бүрийг эх хэл, үндэсний соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг, сурах арга барилтай, авьяас чадвараа нээн хөгжүүлдэг, өөртөө итгэлтэй, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл аж төрөх зөв дадал хэвшилтэй, насан туршдаа суралцах, хамтран ажиллаж амьдрах чадвартай, иргэн болж төлөвшихөд чиглэсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна"[6] гэсэн байна. Ингэснээр

- Эх хэл, үндэсний соёл, ёс заншил, уламжлалыг мэдэж хүндэтгэх, эх орноороо бахархах, хүрээлэн буй орчноо таних, хайрлан хамгаалах, хүн төрөлхтний хэл, соёлоос суралцах;
- Суралцах үйл ажиллагаагаа зохион байгуулах, мэдээлэлтэй ажиллах, оюуны үйл, үйлдлийг гүйцэтгэх арга барил эзэмшиж, сурах хүсэл эрмэлзэлтэй болох;
- Авьяас, сонирхол, ур чадвараа нээн илрүүлэх, хөгжүүлэх хүсэлтэй болох;
- Өдөр тутмын ахуй, амьдралдаа харилцааны болон ёс зүйн хэм хэмжээг баримтлах, эрүүл аж төрөх зөв дадал, хэвшилд суралцах гэсэн зорилтыг хэрэгжүүлнэ гэж тусгасан нь ТХБ-ын агуулга, арга зүйг тусган тогтвортой байдлын цогц чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой байгаа боловч хичээл тус бүрийн цөм хөтөлбөрт тусгасан байдал харилцан адилгүй байгаа нь шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.

Улмаар цөм хөтөлбөрт тусгасан интеграц агуулгыг анги танхимын болон сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагийн хэрхэн хэрэгжүүлж болох жишээ нэгж хичээлийн төлөвлөлтийг боловсруулав.

Эдгээр сургалт, үйл ажиллагааг БСШУ-ны сайдын 2014 оны 06 дугаар сарын 03-ны А/240 тоот тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөний цагаар хэрэгжүүлнэ.

*Зураг 2.1. Бага боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөний цаг (хувиар)*




## Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын монгол хэл, математик, хүн ба байгаль, хүн ба орчин, хүн ба нийгэм, англи хэл, биеийн тамирын цөм хөтөлбөрт ТХБ-ын агуулгын интеграцчилагдсан байдлыг илрүүлэхэд (матриц 1) нийт 96 суралцахуйн зорилт тодорхойлогдсоныг хичээл судлагдахуунаар,ТХЗБ-ын суралцахуйн зорилтын айгаар ялгаж харууллаа *(Хүснэгт 2.2)*.

*Хүснэгт 2.2. Бага боловсролын цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт*

| ТХЗ | Ай | Монгол хэл | Математик | Хүн ба байгаль | Хүн ба орчин | Хүн ба нийгэм | Англи хэл | Биеийн тамир |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТХЗ01. Ядууралгүй байх | ТМ | 1 | | | | | | |
| ТХЗ03. Сайн эрүүл мэнд ба сайн сайхан байдал | ТМ | 1 | | | 2 | | | 3 |
| | НСХ | 2 | | | 3 | 1 | | 1 |
| | ЗҮ | 1 | 1 | 1 | 2 | 2 | | 5 |
| ТХЗ04. Чанартай боловсрол | ТМ | | | | | | 3 | |
| | НСХ | | | | | | 2 | |
| ТХЗ05. Жендэрийн тэгш байдал | ЗҮ | 1 | | | 3 | | | |
| ТХЗ06. Цэвэр ус ба ариун цэвэр | ТМ | 1 | | | | | | |
| | НСХ | 1 | | | | | | |
| | ЗҮ | 1 | | | | | | |
| ТХЗ07. Боломжийн үнэтэй, цэвэр эрчим хүч | ТМ | | 1 | | | | | |
| | НСХ | | | 1 | | | | |
| ТХЗ10. Тэгш бус байдлыг багасгах | НСХ | | | | 1 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТХ311. Тогтвортой хот суурин, оршин суугчид | ТМ | | | | 11 | 2 | | |
| | НСХ | 1 | | 1 | 7 | 1 | | |
| | ЗҮ | 2 | 1 | | 1 | 1 | | |
| ТХ312. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл | ТМ | | | | | 1 | | |
| | НСХ | 2 | | | 3 | | | |
| ТХ313. Уур амьсгалын төлөөх үйл хэрэг | ТМ | | | | 5 | | | |
| | НСХ | | | | 3 | | | |
| | ЗҮ | | | | 1 | | | |
| ТХ315. Газар дээрх амьдрал | ТМ | | 1 | 3 | | | | |
| | НСХ | | | | 3 | 1 | | |
| ТХ316. Энх тайван, шударга ёс, хүчирхэг институцууд | НСХ | 1 | | | | | | |
| ТХ317. ТХЗ-ын төлөөх түншлэл | НСХ | | | | | 3 | | |
| Нийт | | 15 | 4 | 6 | 45 | 12 | 5 | 9 |

ТХ-ийн 17 зорилгоос “ТХ303. Сайн эрүүл мэнд ба сайн сайхан байдал”, “ТХ311. Тогтвортой хот суурин, оршин суугчид”, “ТХ315. Газар дээрх амьдрал” гэсэн гурван зорилгод хамаарах суралцахуйн зорилт 4-5 судлагдахууны цөм хөтөлбөрөөс тодорхойлогдсон байгаа нь бага боловсролын түвшний болон цөм хөтөлбөрийн зорилго, зорилтоос хамааралтай байна гэж үзлээ.

Харин “ТХ302. Өлсгөлөн”, “ТХ308. Хөдөлмөр эрхлэлт”, “ТХ309. Үйлдвэр, инноваци, дэд бүтэц”, “ТХ314. Далай тэнгисийн амьдрал” гэсэн хоёр зорилгод хамаарах суралцахуйн зорилт бага боловсролын цөм хөтөлбөрүүдээс тодорхойлогдоогүй нь энэ насны сурагчийн нас сэтгэхүй болон манай орны газар зүйн байршил, бүс нутгийн онцлогтой холбоотой байна. Мөн “ТХ301. Ядуурлгүй байх”, “ТХ304. Чанартай боловсрол”, “ТХ310. Тэгш бус байдлыг багасгах”, “ТХ313. Уур амьсгалын төлөөх арга хэмжээ” “ТХ317. ТХЗ-ын төлөөх түншлэл” гэсэн ТХ-ийн нийт 5 зорилгод хамаарах суралцахуйн зорилт зөвхөн нэг сургалтын хөтөлбөрөөс тодорхойлогдсон байгааг харгалзан үзэж, цаашид сургалтын цөм хөтөлбөрт тусгах боломжийг судлах хэрэгтэй.

Бага боловсролын цөм хөтөлбөрөөс ТХЗ-той интеграцчилагдсан гэж тодорхойлогдсон 96 суралцахуйн зорилтыг ТХ-ийн зорилгын суралцахуй зорилтын 3 айгаар авч үзвэл танин мэдэхүйн суралцахуйн зорилт 36%, нийгэмшил-сэтгэл хөдлөлийн суралцахуйн зорилт 39%, зан үйлийн суралцахуйн зорилт 25% байгаа нь зохистой харьцаатай байна гэж үзэж байна *(Зураг 2.2, Хүснэгт 2.2).*

*Зураг 2.2. ТХЗ-т хамаарах Бага боловсролын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт (хувиар)*



Судлагдахуун бүрээр онцлогийг авч үзвэл:

1. Бага боловсролын “Монгол хэл”-ний цөм хөтөлбөрийн 15 суралцахуйн зорилт нь ТХ-ийн 7 зорилгод хамаарах суралцахуйн зорилттой холбогдож байна. Тэдгээр суралцахуйн зорилтоос 2 нь ТХЗБ-ын танин мэдэхүйн, 8 нь нийгэмшил-сэтгэл хөдлөлийн, 4 нь зан үйлийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах байдлаар тусгагджээ. Цөм хөтөлбөрт туссан суралцахуйн зорилтуудын үйлийн харьцааг задлан үзвэл:
   - Унших чадварын 3
   - Ярих-сонсох чадварын 7
   - Бичих чадварын 5 суралцахуйн зорилт байна.

   Эндээс харахад ярих-сонсох үйл ажиллагаан дээр суурилан суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдвийг интеграцчилах боломжтой байна. Харин анги тус бүрийн агуулгыг авч үзэхэд ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй холбоотой агуулгын 80 хувь нь IV, V ангийн суралцахуйн зорилтуудтай интеграцчилагдсан байгаа нь хэрэглэгдэхүүн буюу эхийн сонголттой холбоотой байна.

2. Бага боловсролын “Математик”-ийн цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан байдлыг илрүүлэхэд ТХ-ийн 4 зорилгод хамаарах суралцахуйн зорилттой холбогдож байна. Тэдгээр суралцахуйн зорилтоос 2 нь ТХЗБ-ын танин мэдэхүйн, 2 нь зан үйлийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах байдлаар боловсруулагдсан байна.

3. “Хүн ба байгаль”-ийн цөм хөтөлбөрт 6 суралцахуйн зорилт нь ТХ-ийн 4 зорилгод хамаарах суралцахуйн зорилт, сэдэвтэй интеграц болох боломжтой боловсруулагдсан байгаа нь хичээлтэй харьцуулахад харьцангуй бага агуулга туссан харагдаж байна.

4. “Хүн ба орчин”-ы цөм хөтөлбөрт 45 суралцахуйн зорилт ТХ-ийн 7 зорилгод хамаарах суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан байгаа бөгөөд I ангид танин мэдэхүйн түвшний, II ба III ангид нийгэмшил-сэтгэл хөдлөлийн айд харгалзах суралцахуйн зорилт буюу агуулга түлхүү тусгагдсан байгаа нь сурагчийн нас сэтгэхүйн онцлог, сургалтын арга зүйтэй холбоотой байна.

5. “Хүн ба нийгэм” хичээлийн цөм хөтөлбөрт 12 суралцахуйн зорилт ТХ-ийн 5 зорилгод хамаарах суралцахуйн зорилттой уялдсан байна. Бага боловсролын “Хүн ба нийгэм” хичээлийн IV, V ангийн сургалтын цөм хөтөлбөрт ТХЗБ-ын нийгэмшил-сэтгэл хөдлөлийн айд харгалзах агуулга бусад айд харгалзах агуулгаас арай илүү тусгагдсан нь судлагдахууны онцлогтой холбоотой байх талтай.

6. Бага боловсролын хүрээнд англи хэлийг хязгаарлагдмал сэдвийн хүрээнд, энгийн үг, хэллэгийн түвшинд судлах тул ТХ-ийн “Чанартай боловсрол” зорилгод хамаарах суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдаж байна

7. Бага боловсролын биеийн тамирын цөм хөтөлбөрийн зөвлөмжид дэвшүүлсэн суралцахуйн зорилтуудаас 9 зорилт нь ТХЗ-ыг дэмжих боловсролын ТХ303 кодтой “эрүүл мэнд ба сайн сайхан байдал” гэсэн сэдэвтэй илүү уялдаж байна.

## *Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал*

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт тусгагдсан суралцахуйн зорилт

- ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй холбогдох байдал;
- Сургалт зохион байгуулах арга зүйг дэглэх үндэслэл, хэрэгжүүлэх боломж;
- ТБ-ын цогц чадамжийн үндэслэл зэргийг матриц 2-т тайлбарласан бөгөөд арга зүйг дэглэх үндэслэл, цогц чадамжийн үндэслэл зэргийн тоон мэдээллийг *Хүснэгт 2.3, Хүснэгт 2.4*-т үзүүллээ.

*Хүснэгт 2.3. Бага боловсролын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗ-ыг хангах сургалтын арга*

| Хичээл | Сургалт зохион байгуулах арга зүй | | | | Санал болгосон сургалтын арга |
|---|---|---|---|---|---|
| | Бодит хамтын үйл ажиллагаанд оролцох аргууд | Шинжилгээ судалгаа хийх аргууд | Бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд | Алсын хараатай болох аргууд | |
| Монгол хэл | 7 | 6 | 6 | 6 | 25 |
| Математик | 3 | 2 | 2 | 3 | 10 |
| Хүн ба байгаль | 4 | 2 | 2 | 3 | 11 |
| Хүн ба орчин | 14 | 31 | 9 | 12 | 66 |
| Хүн ба нийгэм | 7 | 3 | 8 | 3 | 21 |
| Англи хэл | 1 | 4 | 5 | 0 | 10 |
| Биеийн тамир | 9 | 2 | 0 | 0 | 11 |
| Нийт | 45 | 50 | 32 | 27 | 154 |

Бага боловсролын дээрх 7 хичээлээр ТХБ-той интеграц хийх сургалтын арга зүйд хийсэн шинжилгээний үр дүнгээс харахад 32% нь шинжилгээ судалгаа хийх, 29% нь бодит хамтын үйл ажиллагаанд оролцох, 21% нь бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан арга, 18% нь алсын хараатай болох аргуудыг хэрэгжүүлэх боломжтой гэж сонгосон байна. “Хүн ба орчин”-ы цөм хөтөлбөрт шинжилгээ судалгаа хийх арга зүйг, “Хүн ба нийгэм”-ийн цөм хөтөлбөрт бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба бодит хамтын үйл ажиллагаанд оролцох аргуудыг, “Биеийн тамир”-ын цөм хөтөлбөрт бодит хамтын үйл ажиллагаанд оролцох аргуудыг 82%-иар сонгон хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэнийг эс тооцвол аль ч судлагдахуун аль нэг аргыг голлон хэрэглэнэ гэхээсээ илүүтэйгээр хэд хэдэн аргыг хэрэглэн суралцахуйн зорилтыг ТХБ-той интеграцчилан ТБ-ын цогц чадамжийг эзэмшүүлэх боломжтой гэж үзсэн байна.

Бага боловсролын 7 хичээлээр ТБ-ын 8 цогц чадамжийн төлөвшилд хувь нэмэр оруулах боломж 173 тодорхойлогдсон байна.

*Хүснэгт 2.4. ТБ-ын цогц чадамжийн төлөвшилд бага боловсролын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр*

| Хичээл | ТБ-ын цогц чадамж | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1. Тогтолцоон сэтгэлгээ | 2. Урьдчилан тооцоолох | 3. Хэм хэмжээний | 4. Стратегийн | 5. Хамтран ажиллах | 6. Шүүмжлэлт сэтгэлгээ | 7. Өөрийгөө таньж мэдэх | 8. Асуудал шийдвэрлэх | Нийт |
| Монгол хэл | 5 | 7 | 3 | 3 | 7 | 6 | 7 | 0 | 38 |
| Математик | 0 | 3 | 1 | 1 | 0 | 0 | 1 | 1 | 7 |
| Хүн ба байгаль | 1 | 2 | 0 | 2 | 1 | 0 | 1 | 0 | 7 |
| Хүн ба орчин | 12 | 11 | 6 | 7 | 14 | 10 | 4 | 14 | 78 |
| Хүн ба нийгэм | 4 | 2 | 0 | 0 | 6 | 3 | 5 | 4 | 24 |
| Англи хэл | 1 | 4 | 0 | 0 | 4 | 0 | 0 | 0 | 9 |
| Биеийн тамир | 1 | 0 | 2 | 0 | 6 | 0 | 1 | 0 | 10 |
| Нийт | 24 | 29 | 12 | 13 | 38 | 19 | 19 | 19 | 173 |

Бага боловсролын цөм хөтөлбөрт туссан суралцахуйн зорилтуудын ТБ-ын цогц чадамжийн хөгжилд оруулах хувь нэмрийг тоон үзүүлэлт талаас нь авч үзвэл хамтран ажиллах, урьдчилан тооцоолох, тогтолцоот сэтгэлгээний цогц чадамжид оруулах хувь нэмэр бусад цогц чадамжаас арай илүү туссан байна.

- Хамтран ажиллах цогц чадамж нь бусдын үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож хүндэтгэх, бусдаас суралцах, багаар хамтран ажиллах, хамтын хүчээр зөрчил мөргөлдөөн болон оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэхэд зохицуулах чадвар юм.
- Урьдчилан тооцоолох цогц чадамжид ирээдүйд болох олон үйл явдлыг ойлгож, өөрийн үзэл бодлыг бий болгох, урьдчилан сэргийлэх, үйлийн үр дагаврыг үнэлэх, дүгнэх, эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадвар хамаарна.
- Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамжид аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох, нийлмэл тогтолцоог задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг сэтгэн бодох чадвар багтана.

Багш арга зүйгээ зөв төлөвлөн хэрэгжүүлж чадвал ТБ-ын 8 цогц чадамжтай буюу сурах арга барилтай, авьяас чадвараа нээн хөгжүүлдэг, өөртөө итгэлтэй, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл аж төрөх зөв дадал хэвшилтэй, хамтран ажиллаж амьдрах болон насан туршдаа суралцах чадвартай, иргэн болж төлөвшихөд чиглэсэн цөм хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах боломжтой байна.

Бага боловсролын 7 нэгж хичээлийн төлөвлөлтийн товчоог *Хүснэгт 2.5*-д үзүүллээ. Үүнд I ангийн 1, III ангийн 1, IV ангийн 4, V ангийн 1 хичээлийн төлөвлөлтийг санал болгож байна. II ангийн хичээл төлөвлөлт байхгүй байгаа нь ТХБ-ын агуулга, арга зүй тусгагдаагүй гэж үзэх үндэслэл болохгүй, зөвхөн энэ удаагийн боловсруулагчдын сонголтоор сонгосон жишиг хичээлийг санал болгож байгааг анхаарна уу. Багш нар энэхүү хичээл төлөвлөлтийн санааг өөр бусад хичээлийн төлөвлөлт хийхдээ улам дэлгэрүүлэн хөгжүүлж хэрэглэх боломжтой.

*Хүснэгт 2.5. Бага боловсролын судлагдахууны жишээ нэгж хичээлийн төлөвлөлтийн товчоо*

| Хичээл | Анги | Сэдэв | Танин мэдэхүйн агуулга | ТХБ-ын агуулга | Боловсруулсан хүний нэр |
|---|---|---|---|---|---|
| Монгол хэл | IV | Тогтвортой бат бөх гүүр | Эхийн гол санааг ойлгох, тайлбарлах<br>Бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлэх<br>Бичихдээ төсөөлөн бодох чадвараа ашиглах | Тогтвортой, бат бөх, байгууламж бүхий эх зохиолыг унших;<br>Гүүрийг барих шийдвэрийг дэмжиж эсвэл эсэргүүцэж буйг хэлэхдээ бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлэх, бусадтай зөв харилцаж сурах;<br>Өөрийн үзэл санаа тусган бичиж, тогтвортой орон нутгийг хамтран бүтээлцэхэд хувь нэмэр оруулна. | БМДИ-ийн арга зүйч Пүрэвсүрэнгийн Одсүрэн |
| Математик | IV | Математик тооцоололд тулгуурлаж байшингаа дулаалцгаая | Бодлого бодох, тайлбарлах, асуудал шийдвэрлэх | Эрчим хүчний зардлаа хэмнэснээр байгаль орчин, ирээдүйгээ хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулах явдал юм. Бодит амьдрал дээр барилга орон сууц болон бусад байгууламжууд цонх, хаалга, ханаа сайн дулаалаагүйгээс ан цав, завсар гарч, түүгээр дулаан алддаг. Барилга байгууламжийг хэдий чинээ сайн дулаална төдий чинээ эрчим хүчийг хэмнэх тооцоолол хийх | БМДИ-ийн арга зүйч Дондовын Энхтулга |
| Хүн ба байгаль | IV | Амьд бие амьдралын орчин | Амьтан ургамлын харилцан хамаарал, идэш тэжээлийн хэлхээг зурж тайлбарлах | Хуурай газрын экосистемүүдийн тогтвортой ашиглалтыг хамгаалах, биологийн төрөл зүйлийн алдагдлыг зогсоох | БМДИ-ийн арга зүйч Энхжаргалын Даваахүү |
| Хүн ба орчин | III | Миний хичээлийн хэрэглэл | Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагааны талаар мэдэх | Ургамлын үр соёолоход дулаан ялгардаг болохыг термометр хэрэглэн тодорхойлно. Өнөөдөр манай сургалтын практикт ихэвчлэн мөнгөн уст термометрийг хэрэглэж байгаа тул тэдгээрийг зөв хэрэглэх, хадгалах тухай мэдлэг, чадвар эзэмших нь ТХБ-той холбогдох болно. | Боловсролын хүрээлэн. Секторын эрхлэгч Амгалангийн Энхтогтох |
| Хүн ба нийгэм | IV | Нутгийн амьдралд хүүхэд бидний оролцоо | Сурагч орон нутгийн нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулах | Нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн ялгаа, нутгийнхаа хөгжил, нутгийн зохион байгуулсан ажилд оролцох эрмэлзэл бий болох | БМДИ-ийн арга зүйч Цагаанбаатарын Нарантуяа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Англи хэл | V | Англи хэл сурахын ач холбогдол | Хос болон бүлэг, ангиар ажиллахад өөрийн хувь нэмрээ оруулах | Бусадтай хамтран ажиллах цогц чадамж төлөвших | Боловсролын хүрээлэн. ЭША Бат-Өлзийн Батчимэг |
| Биеийн тамир | I | Биеийн үндсэн хөдөлгөөн | Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг сурах, тогтмол хийж хэвших | Сурагч эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох | БМДИ-ийн арга зүйч Зоригтын Самданжамц |

*Хүснэгт 2.6 Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Монгол хэлний хичээлийн матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| Я. Ярих-сонсох чадвар | 2, 10.в. Харилцагчдаа хүндэтгэн эелдэг үг хэрэглэн ярих | ТХ301.НСХ3. | ТХ301.Сэ06. |
| У. Унших чадвар | 3, 02.а. Эхийн агуулгыг ойлгож, чухал гэж үзсэн хэсгийг ялгах | ТХ303.ТМ1. | ТХ303.Сэ09. |
| Я. Ярих чадвар | 3, 07.а. Тохиолдсон явдлаа нарийн тодорхой ярих | ТХ306.НСХ3. | ТХ306.Сэ06. |
| У. Унших чадвар | 4, 02.а. Эхийн гол санааг ойлгох, тайлбарлах | ТХ311.НСХ3. | ТХ311.Сэ06. |
| Я. Ярих чадвар | 4, 07.д. Нөхцөл байдалдаа тохируулан өгүүлбэрийн хэлбэрийг оновчтой сонгох | ТХ303.НСХ1. | ТХ303.Сэ07. |
| Я. Ярих-сонсох чадвар | 4, 09.б. Бусдын үзэл бодлыг сонсох, сонссон зүйлээ дүгнэх | ТХ316.НСХ5. | ТХ316.Сэ05. |
| Я. Ярих-сонсох чадвар | 4, 10.в. Бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлэх | ТХ311.ЗҮ3. | ТХ311.Сэ06. |
| Б. Бичих чадвар | 4, 13.г. Бичихдээ төсөөлөн бодох чадвараа ашиглах | ТХ311.ЗҮ3. | ТХ311.Сэ06. |
| Б. Бичих чадвар | 4, 15.а. Зорилгодоо тохируулан уриалга бичих | ТХ303.ЗҮ3. | ТХ303.Сэ08. |
| У. Унших чадвар | 5, 02.д. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүр дэх цогцолборуудын холбоо хамаарлыг олох | ТХ306.ТМ1. | ТХ306.Сэ03. |
| Я. Ярих-сонсох чадвар | 5, 09.б. Үзэл бодлоо зөвшөөрүүлэх үндэслэлээ төлөвлөх | ТХ305.ЗҮ1. | ТХ305.Сэ03. |
| Я. Ярих, бичих чадвар | 5, 15.а. Зорилгодоо тохируулан зар сурталчилгаа бичих | ТХ306.ЗҮ4. | ТХ306.Сэ05. |
| Б. Бичих чадвар | 5, 15.а. Зорилгодоо тохируулан зар сурталчилгаа бичих | ТХ312.НСХ4. | ТХ312.Сэ07. |
| Б. Бичих чадвар | 5, 15.а. Зорилгодоо тохируулан өдрийн тэмдэглэл бичих | ТХ312.НСХ3. | ТХ312.Сэ05. |
| Б. Бичих чадвар | 5, 15.в. Бусдын үзэл бодлыг дэмжиж бичих | ТХ303.НСХ4. | ТХ303.Сэ05. |

*Хүснэгт 2.7. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролыг Математикийн хичээлийн матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 4. Өгөгдөлтэй ажиллах. Шинж зүй тогтол болон учир холбогдлын талаарх мэдээллийг олж цуглуулах, ойлгох, дүрслэх, боловсруулах | 4, 07.б. Өгөгдөл мэдээллийг олж цуглуулах, бүртгэх түүнийг хүснэгт графикаар дүрслэх харьцуулах тайлбарлах, дүгнэлт гаргах, тодорхой нөхцөлөөр түүвэрлэсэн өгөгдөлд боловсруулалт хийх | ТХ307.ТМ3 | ТХ307.Сэ3 |
| 4. Өгөгдөлтэй ажиллах. Шинж зүй тогтол болон учир холбогдлын талаарх мэдээллийг олж цуглуулах, ойлгох, дүрслэх, боловсруулах | 5, 07.б. Өгөгдөл мэдээллийг олж цуглуулах, бүртгэх түүнийг хүснэгт графикаар дүрслэх харьцуулах тайлбарлах, дүгнэлт гаргах, тодорхой нөхцөлөөр түүвэрлэсэн өгөгдөлд боловсруулалт хийх | ТХ311.ЗҮ1 | ТХ311.Сэ07 |
| 4. Өгөгдөлтэй ажиллах. Шинж зүй тогтол болон учир холбогдлын талаарх мэдээллийг олж цуглуулах, ойлгох, дүрслэх, боловсруулах | 4, 07.б. Өгөгдөлтэй ажиллах, зүй тогтлыг олох, үргэлжлүүлэх, тоон таавар, логик бодлого бодох, боломжийг тооцоолох агуулгатай асуудал шийдвэрлэх | ТХ303.ЗҮ4 | ТХ303.Сэ09. |
| 1. Тоо тоолол. Бүхэл тоо энгийн ба аравтын бутархайн үйлдлийг ойлгох, гүйцэтгэх хэрэглэх | 5, 03.ё. Процентыг ойлгох хэсгийг процентоор илэрхийлэх, тоо ба хэмжээний тодорхой процентод ногдох тоо, хэмжээг олох, тодорхой процентод ногдох тоо ба хэмжээгээр уул тоо ба хэмжээг олох, процентоор тооцоолох асуудал шийдвэрлэх | ТХ315.ТМ2. | ТХ315.Сэ04 |

*Хүснэгт 2.8. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хүн ба байгаль хичээлийн матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. Өсөлт хөдөлгөөн | 4, 01.в. Хүний араг ясны хэвийн өсөлт, булчингийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүд, хөдөлгөөний ач холбогдлыг мэдэх | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ09. |
| 2. Амьд бие ба амьдралын орчин | 4, 02.а. Амьтан бүр өөрийн амьдралын орчиндоо зохицсон байдгийг ойлгох | ТХ315.ТМ1. | ТХ315.Сэ01. |
| 3. Амьд бие ба амьдралын орчин | 4, 02.б. Амьтан ургамлын харилцан хамаарал, идэш тэжээлийн хэлхээг зурж тайлбарлах | ТХ315.ТМ1. | ТХ315.Сэ01. |
| 4. Амьд бие ба амьдралын орчин | 4, 02.в. Амьдралын орчинд хүний үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, байгаль орчноо хайрлан хамгаалах санал санаачилга гаргах | ТХ315.ТМ2. | ТХ315.Сэ02. |

| | | | |
|---|---|---|---|
| 1. Цэцэгт ургамлын амьдралын эргэлт | 5, 01.д. Сургуулийн гаднах талбай болон орон нутгийн цэцэрлэгт хүрээлэнгээр аялж цэцэгт ургамлыг ажиглаж, хэрхэн тоос хүртэж, үр тогтолт явагддаг талаар баримт цуглуулах | ТХ311.НСХ3. | ТХ311.Сэ05. |
| 4. Энерги | 5, 04.д. Энерги, хувирдаг, дамждаг болохыг ойлгох, туршилтын үр дүнд үндэслэн дүгнэлт гаргах | ТХ307.НСХ1. | ТХ307.Сэ03. |

*Хүснэгт 2.9. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хүн ба орчин хичээлийн матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. Миний тоглоом | 1, 01.б. Тоглоом тоглох ба эрүүл ахуйн дэглэм сахих | ТХ303.НСХ3 | ТХ303.Сэ4 |
| 2. Миний тоглоом | 1, 02.в. Эцэг эх, ахмад хүмүүс, багш, найз нөхөдтэйгөө мэндэлж сурах | ТХ305.ЗТ1 | ТХ305.Сэ2 |
| 3. Миний хичээлийн хэрэглэл | 1, 03.а. Хичээлийн хэрэглэлээ ялган таних, үүрэг зориулалтаар нь хэрэглэх, хадгалах талаар бусдад ярих | ТХ312.НСХ1. | ТХ312.Сэ8 |
| 4. Миний бие | 1, 04.г. Хичээл, амралтаа зөв зохицуулах, өдрийн дэглэм баримтлах | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ03. |
| 5. Манай гэрийнхэн | 1, 05.а. Гэр бүлийнхнээ танилцуулах, утасны дугаарыг мэдэх, шаардлагатай үед бусадтай холбоо барих | ТХ311.ТМ1 | ТХ311.Сэ1 |
| 5. Манай гэрийнхэн | 1, 05.б. Гэр байраа цэвэр байлгахад юу хийж чадахаа тайлбарлах, гэр бүлийн гишүүддээ туслах | ТХ311.ТМ2 | ТХ311.Сэ1 |
| 6. Миний гэр орон | 1, 06.а. Орчин тойрны зүйлстэй харьцуулж гэр байраа хаана оршдогийг мэдэх | ТХ311.ТМ1 | ТХ311.Сэ10 |
| 6. Миний гэр орон | 1, 06.б. Гэр, байрны орчин тойронд юу ханаа байдгийг нэрлэх, таних, гэр ахуйн цахилгаан хэрэгсэлтэй болгоомжтой харьцах | ТХ311.ТМ2 | ТХ311.Сэ10 |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 1, 07.а. Сургууль орчмын дуу чимээг судлах | ТХ311.ТМ1 | ТХ311.Сэ5 |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 1, 07.б. Анги, хамт олон, сургуулийн орчинд дасан зохицох, сургуулийнхаа дэг журмын талаар мэдлэгтэй болох | ТХ311.НСХ3. | ТХ311.Сэ05. |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 1, 07.в. Ангид ургаж байгаа ургамлын бүтцийн хэсгүүдийг зааж, нэрлэх, ялган таних | ТХ313.НСХ5 | ТХ313.Сэ10 |
| 9. Орон нутаг ба байгаль | 1, 09.а. Орон нутагт түгээмэл тохиолдох ургамал, амьтныг нэрлэх, ялган таних | ТХ313.ТМ3 | ТХ313.Сэ10 |
| 9. Орон нутаг ба байгаль | 1, 09.б. Нутгийнхаа томоохон уул, ус, байгалийн болон түүхийн дурсгалт газрыг нэрлэх, танилцуулах | ТХ311.ТМ2 | ТХ311.Сэ2 |
| 10. Эх орон, эх дэлхий | 1, 10.б. Байгаль, нийгмийн юмс үзэгдэл өдөр шөнөөс хэрхэн хамаарч байдгийг ойлгож мэдэх | ТХ313.ТМ5 | ТХ313.Сэ6 |

| | | | |
|---|---|---|---|
| 10. Эх орон, эх дэлхий | 1, 10.г. Байгалийн үзэгдэл улирлаас хамаардгийг ажиглаж, ялгах | ТХ313.ЗТ1 | ТХ313.Сэ03. |
| 1. Миний тоглоом | 2, 01.б. Уламжлалт болон орчин үеийн тоглоомоос сонгож тоглох, эрүүл ахуйн дэглэм сахих | ТХ303.НСХ4. | ТХ303.Сэ03. |
| 1. Миний тоглоом | 2, 01.в. Тоглоом тоглох үеийн дэгийг дагаж мөрдөх, хожиж хожигдож сурах, тэвчээртэй, хүлээцтэй хандах, тоглоом бүтээх | ТХ303.ЗТ1 | ТХ303.Сэ4 |
| 2. Миний тоглоом | 2, 02.б. Найз нөхдөө хүндэтгэн харилцах | ТХ305.ЗТ2 | ТХ305.Сэ2 |
| 3. Миний хичээлийн хэрэглэл | 2, 03.а. Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг юугаар хийгдсэн болохыг судлах, зөв хэрэглэх талаар найздаа зөвлөх | ТХ312.НСХ1. | ТХ312.Сэ03. |
| 4. Миний бие | 2, 04.б. Биеийн бүтцийн хэсгүүдийн үүргийг тайлбарлах | ТХ303.ТМ5. | ТХ303.Сэ04. |
| 5. Манай гэрийнхэн | 2, 05.б. Нэн шаардлагатай утасны дугаарыг мэдэж бусдад туслах | ТХ311.ТМ3 | ТХ311.Сэ1 |
| 6. Миний гэр орон | 2, 06.а. Гэр байрнаасаа сургууль хүрэх замыг заах, үндсэн ба завсрын зүг чигийг тодорхойлох | ТХ311.НСХ3 | ТХ311.Сэ10 |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 2, 07.а. Сургууль орчмын дуу чимээний эх үүсвэрийг тодорхойлох, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг тайлбарлах | ТХ311.ТМ2 | ТХ311.Сэ5 |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 2, 07.б. Сургуулийн орчинд баримтлах дэгийг сахиж мөрдөх, хэвшил болгох, хамтран шийдвэр гаргах арга барилд суралцах | ТХ311.ЗТ2 | ТХ311.Сэ8 |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 2, 07.в. Ангид ургадаг ургамал олон төрөл болохыг тодорхойлох, усалж арчилж ургуулах | ТХ313.ТМ5 | ТХ313.Сэ10 |
| 8. Орон нутаг ба хүмүүс | 2, 08.а. Нутаг орныхоо хүмүүсийн юу хийж, хэрхэн аж төрдгийг мэдэж танилцах, хувь нэмрээ оруулах, бахархан хүндэтгэх | ТХ311.ТМ4 | ТХ311.Сэ8 |
| 9. Орон нутаг ба байгаль | 2, 09.а. Ургамал, амьтны амьдрах орчныг нэрлэх, орчиндоо хэрхэн зохицдогийг ажиглах, турших, жишээгээр тайлбарлах | ТХ313.ТМ3 | ТХ313.Сэ6 |
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.б. Жилийн 4 улирал бүрд хамаарах саруудыг ялгах, улирлын ялгааг мэдэх ба харьцуулах | ТХ315.НСХ3. | ТХ315.Сэ08. |
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.в. Улирлын ялгаанаас байгаль ба хүмүүс,нийгмийн юмс үзэгдэл хэрхэн хамаарахыг таньж мэдэх, тайлбарлах | ТХ315.НСХ4. | ТХ315.Сэ08. |
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.г. Цаг агаарыг ажигладаг, шинждэг чадвар эзэмших | ТХ313.ТМ5. | ТХ313.Сэ06. |
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.д. Цаг агаарын байдал хүмүүсийн амьдрал, ахуйд хэрхэн нөлөөлдөг талаар мэдэх | ТХ315.НСХ5. | ТХ315.Сэ08. |
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.ё. Юмсын хэлбэр, хэмжээ, орших байрлал, ба зүг чигийг ялган харьцуулж орон зайн төсөөлөлтэй болох | ТХ311.НСХ5. | ТХ311.Сэ01. |
| 1. Миний тоглоом | 3, 01.б. Тоглоомоо цэвэр, ариг гамтай, цэгцтэй байлгах, хэрэглэх, гараа угаах | ТХ303.НСХ4 | ТХ303.Сэ03. |

| | | | |
|---|---|---|---|
| 2. Миний тоглоом | 3, 02.б. Эцэг эх, ахмад хүмүүс, багш, найз нөхөдтэйгөө харилцан ойлголцож өөрийн хариуцлагыг ухамсарлаж, бусдыг хүндэтгэх | ТХ305.ЗТ4 | ТХ305.Сэ2 |
| 3. Миний хичээлийн хэрэглэл | 3, 03.а. Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагааны талаар мэдэх | ТХ312.ЗҮ1. | ТХ312.Сэ08. |
| 4. Миний бие | 3, 04.б. Биеийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлийг тайлбарлах | ТХ303.ТМ5. | ТХ303.Сэ04. |
| 5. Манай гэрийнхэн | 3, 05.а. Угийн бичгийг зураглан дүрслэх | ТХ311.НСХ4 | ТХ311.Сэ1 |
| 6. Миний гэр орон | 3, 06.а. Гэр, сургууль орчмын план зургийг зурах, нэрлэх | ТХ311.НСХ4 | ТХ311.Сэ10 |
| 6. Миний гэр орон | 3, 06.б. Гэр, байрнаас сургууль хүрэх орчин тойрны аюулгүй байдлыг үнэлэх | ТХ311.ТМ5 | ТХ311.Сэ10 |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 3, 07.б. Сургуулийн гадаад орчны судалгаа хийх, аюулгүй байдлаа хамгаалах | ТХ311.НСХ5 | ТХ311.Сэ1 |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 3, 07.в. Сургуулийн дүрэм, журмыг хэрхэн биелүүлж байгааг судлах | ТХ311.ТМ5 | ТХ311.Сэ8 |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 3, 07.г. Ангид ургаж байгаа ургамлын өсөлт хөгжлийг ажиглаж, тэмдэглэл хөтлөх, арчилж сурах | ТХ313.ЗТ1 | ТХ313.Сэ10 |
| 8. Миний нутаг | 3, 08.б. Нийтийн эзэмшлийн газруудад баримтлах дэг журамтай танилцаж түүнийг мөрдөх | ТХ311.НСХ5. | ТХ311.Сэ05. |
| 9. Орон нутаг ба байгаль | 3, 09.а. Орон нутгийн ургамал, амьтдыг ангилах, амьдрах орчин хэрхэн бүрдсэнийг судлах | ТХ313.ТМ5. | ТХ313.Сэ10. |
| 10. Манай дэлхий | 3, 10.е. Дэлхийн хүмүүсийн амьдардаг газар, амьдрал, арьс өнгө ялгаатай байдгийг мэдэх, газрын зураг ба глобус дээр ялгах | ТХ310.НСХ1 | ТХ310.Сэ1 |

*Хүснэгт 2.10. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хүн ба нийгэм хичээлийн матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал | 4, 01.а. Гэр бүл, сургуулийн орчинд өөрийн бодол санаа, хүсэлтийг илэрхийлэн харилцах | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ05 |
| 2. Нутгийн хүмүүсийн нийгэм, аж ахуй, соёлын амьдрал | 4, 02.б. Орон нутгийн аж ахуй, үйлдвэрлэл, соёл, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг мэдэх, оролцох | ТХ311.НСХ5 | ТХ311.Сэ01 |
| 2. Нутгийн хүмүүсийн нийгэм, аж ахуй, соёлын амьдрал | 4, 02.в. Орон нутгийн үйлчилгээний газруудыг үүрэг, үйл ажиллагаагаар нь ялгах, тайлбарлах | ТХ312.ТМ1 | ТХ312.Сэ03 |

| | | | |
|---|---|---|---|
| 2. Нутгийн хүмүүсийн нийгэм, аж ахуй, соёлын амьдрал | 4, 02.г. Суралцагч орон нутгийн нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулах | ТХ311.ЗҮ1. | ТХ311.Сэ05 |
| 3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх, үүрэг, хариуцлага | 4, 03.г. Хувь хүн өөртөө ямар үүрэг, хариуцлага хүлээхийг ойлгох, биелүүлэх, үнэлэх | ТХ317.НСХ5 | ТХ317.Сэ05 |
| 3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх, үүрэг, хариуцлага | 4, 03. д. Өөрийн нийгэм соёлын орчны талаар мэдэх, түүнээс суралцах, нөлөөлөх | ТХ317.НСХ5 | ТХ317.Сэ05 |
| 3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх, үүрэг, хариуцлага | 4, 03.е. Өөрийн аюулгүй байдлыг хангах талаар ойлгох, холбогдох шийдвэр гаргах | ТХ303.ЗҮ1 | ТХ303.Сэ08 |
| 1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал | 5, 01. а. Гэр бүл, найз нөхөд, үе тэнгийнхэн, сургуулийн багш, ажилтан, ахмад хүмүүст өөрийгөө зөв илэрхийлэн харилцах | ТХ303.НСХ5. | ТХ303.Сэ05 |
| 1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал | 5, 01.в. Хүмүүсийн ялгаатай байдлыг / нас, хүйс, нийгэм, соёлын гэх мэт/ мэдэж, харилцаж чаддаг болох | ТХ317.НСХ5 | ТХ317.Сэ05 |
| 4.Миний эх орон Монгол бахархал | 5, 04.б. Эх орныхоо байгалийн онцлог, үзэсгэлэнт газруудыг таньж мэдэх | ТХ315.НСХ3 | ТХ315.Сэ08 |
| 4.Миний эх орон Монгол бахархал | 5, 04.г. Монгол хүний ахуй, амьдрал, эрхлэх аж ахуйн онцлогийг тодорхойлж чаддаг болох | ТХ311.ТМ3 | ТХ311.Сэ05 |
| 4.Миний эх орон Монгол бахархал | 5, 04.ө. Ардчилсан Монголын нийгэм, аж ахуй, соёлынололт, амжилтаас тодорхойлж чаддаг болох | ТХ311.ТМ1 | ТХ311.Сэ08 |

*Хүснэгт 2.11. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Англи хэлний хичээлийн матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| Миний орчин | 5, 4.1.г.сэдвийн хүрээнд богино эхийн гол санааг ойлгох- Миний орчин | ТХ304.ТМ4. | ТХ304.Сэ07. |
| Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ | 5, 0.2.ё. сэдвийн хүрээнд бусадтай хамтран ажиллан ярилцах- | ТХ304.ТМ4. | ТХ304.Сэ08. |
| Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ | 5, 0.2.е. сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллахад өөрийн хувь нэмрээ оруулах | ТХ304.ТМ5. | ТХ304.Сэ08. |
| Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ | 5, 0.2.е. сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллахад өөрийн хувь нэмрээ оруулах | ТХ304.НСХ3. | ТХ304.Сэ08. |
| Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ | 5, 0.2.е. сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллахад өөрийн хувь нэмрээ оруулах | ТХ304.НСХ4. | ТХ304.Сэ08. |

*Хүснэгт 2.12. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Биеийн тамир хичээлийн матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 1, 01.а.Биеийн тамирын хувцсаа солих, тохируулж өмсөх, зөв хадгалах арга барил эзэмших | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ04. |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 1, 01.г. Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг сурах, тогтмол хийж хэвших | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ03. |
| 2. Алхах, гүйх | 2, 02.г. Гүйж тоглох тоглоомоор хөдөлгөөний эвсэл ба хурдыг хөгжүүлж, гүйх болон хамтран тоглох чадвараа сайжруулах. | ТХ303.ЗҮ2. | ТХ303.Сэ03. |
| 4. Шидэлт, дамжуулалт | 2, 04.ё. Зөөлөн бөмбөгийг шидэх тоглоомоор хөдөлгөөний эв дүйг сайжруулж, хамтран тоглох чадвартай болно. | ТХ303.ЗҮ2. | ТХ303.Сэ03. |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 3, 01.в. Алжаал тайлах цогц дасгалыг сурч, ашигладаг болох. | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ09. |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 3, 01.г. Нөхөртөө туслах, аюулгүй байдлаа хангах аргыг ойлгож, хосоор сунгалтын дасгал гүйцэтгэх арга барил эзэмших. | ТХ303.ТМ5. | ТХ303.Сэ03. |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 4, 01.а. Биеийн тамирын хичээлийн үед мөрдөх аюулгүй байдлын дүрмийг ойлгон, хэрэгжүүлж хэвших. | ТХ303.ТМ5. | ТХ303.Сэ03. |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 4, 01.д. Гимнастикийн саваатай цогц дасгалыг зохиох, гүйцэтгэх чадвар эзэмшиж, өөрсдийн зохиосон саваатай дасгалаа бусдад үзүүлж, өөрийгөө илэрхийлэх чадвар эзэмших | ТХ303.ЗҮ2. | ТХ303.Сэ03. |
| 4. Шидэлт, дамжуулалт | 5, 04.г. Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээнд оролцож, өөрийгөө дайчлах, өөртөө хяналт тавих, өөрийн чадвараа бусадтай харьцуулах, бие даах чадвараа харуулах. | ТХ303.НСХ4. | ТХ303.Сэ03. |

# 2.2. МОНГОЛ ХЭЛ

## 2.2. А. БАГА БОЛОВСРОЛЫН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Бага боловсролд монгол хэлний хичээлийг судлах хэрэгцээг "Эх хэлнийхээ бүтэц, зүй тогтол утгыг ухаарч, нийгмийн харилцааны янз бүрийн орчинд бүтээлчээр хэрэглэх; Монгол үндэсний хэл, соёл, сэтгэлгээг өвлөн авч, дээдлэн хүндлэх, хамгаалах, хөгжүүлэх эх оронч үзэл хандлага төлөвших"-д оршино гэж цөм хөтөлбөрт тусгасан байна. Мөн монгол хэлний сургалтын арга зүй нь "аман зохиол, уран зохиолын болон найруулгын бусад төрлөөр бичигдсэн эхийг төсөөлөх, унших, хэлэлцэх, боловсруулах, бүтээлчээр зохион найруулж бичих замаар эх хэлээ хэрэглэх, бүтээлчээр сэтгэх арга барил хөгжүүлэх технологид суурилна" гэж тодорхойлсон нь ТХЗБ-ын суралцахуйн зорилтуудтай эх хэлний сургалт, үйл ажиллагааг уялдуулах бүрэн боломжтой байна. Харин ТХБ нь ТХ-ийг хангах хөдөлгөгч хүч, суурь гэдгийг анхааран монгол хэлний сургалтын хөтөлбөр, сурах бичигт ТХ-ийн 17 зорилгын хүрээнд санал болгож байгаа сэдвүүдтэй уялдах эхийн сонголтыг сурагчийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан тусган хэрэгжүүлэхэд анхаарах шаардлага тулгамдсан асуудал хэвээр байна.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын монгол хэлний цөм хөтөлбөр ба цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмжид үндэслэн монгол хэлний хичээлийн агуулга, арга зүйг ТХБ-той хэрхэн интеграцчилж болохыг тодрууллаа. ТХЗБ-ын суралцахуйн зорилтууд ба тэдгээрийн хүрээнд санал болгосон сэдвүүдийг судалж, бага боловсролын монгол хэлний цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудтай уялдсан байдлыг тодруулахдаа

1. Эх зохиол буюу хэрэглэгдэхүүний утга агуулга нь ТХЗБ-ын сэдвүүдтэй уялдаж байгаа эсэхийг нягтлах
2. Монгол хэлний цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын томьёолол буюу танин мэдэхүйн үйлийг шалгуур болголоо.

Тодруулбал, монгол хэлний хичээлээр сурагч

- <u>уншихдаа</u> тайлбарлах, таамаглах, төсөөлөх, тодорхойлох, ялгах, харьцуулах, үнэлэх, дүгнэх зэрэг чадварыг эзэмших,
- ярьж сонсохдоо тод, чанга, ойлгомжтой зөв ярих, харсан сонссоноо ярьж илтгэх, янз бүрийн нөхцөл байдалд тохируулж ярих, хамтрах, саналаа солилцох зэрэг чадварыг эзэмших
- <u>бичихдээ</u> төлөвлөх, байршуулах, нооролох, засан сайжруулах, бусдаас санал сонсох, зөвлөх зэрэг чадварыг эзэмшинэ гэж заасан тул эдгээр үйлээр дамжуулан ТХЗБ-ын суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх боломжтой байна.

Бага боловсролын монгол хэлний сургалтын цөм хөтөлбөрт тусгагдсан 276 суралцахуйн зорилтоос 15 суралцахуйн зорилт ТХ-ийн 1, 3, 5, 6, 11, 12, 16-р зорилгод уялдсан байна. Тэдгээр суралцахуйн зорилтоос 2 нь ТХЗБ-ын танин мэдэхүйн, 8 нь нийгэмшил-сэтгэл хөдлөлийн, 4 нь зан үйлийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах байдлаар тусгагдсан байна. Цөм хөтөлбөрт туссан суралцахуйн зорилтуудын үйлийн харьцааг задлан үзвэл:

- Унших чадварын нийт 40 суралцахуйн зорилтоос 3

- Ярих-сонсох чадварын нийт 55 суралцахуйн зорилтоос 7
- Бичих чадварын нийт 109 суралцахуйн зорилтоос 5.

Эндээс харахад ярих-сонсох үйл ажиллагаанд суурилсан суралцахуйн зорилтуудыг ТХЗБ-ын суралцахуйн зорилттой уялдуулан хэрэгжүүлэх боломж нийт тусгагдсан суралцахуйн зорилтуудын 50 орчим хувийг эзэлж байна. Харин ангийн түвшнээр нь авч үзэхэд 80 хувь нь IV, V ангийн зорилтууд байгаа нь ТХЗ, түүний хүрээнд санал болгож буй сэдэвтэй уялдсан хэрэглэгдэхүүний сонголттой холбоотой байна. Цаашид монгол хэлний хичээлийн унших чадварыг хөгжүүлэх суралцахуйн зорилтыг ТХБ-той холбохын тулд сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгах унших эхийн сонголтод анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

### Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Монгол хэлний цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх арга зүйн үндэслэл, ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмрийг матриц 2-т тайлбарлалаа.

Монгол хэлний хичээлээр ТХЗБ-ын суралцахуйн зорилтууд, санал болгож байгаа сэдвүүдийг хэрэгжүүлэх сургалтыг зохион байгуулахдаа

- Эхийг ойлгож унших үйл дээр суурилан бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээг шаардсан аргуудыг;
- Бичих, ярих үйл дээр суурилан алсын хараатай болох буюу ирээдүйн сайн сайхныг төсөөлөн бичих, ярих үйл ажиллагааг зохион байгуулна.
- Мөн сэдвийн хүрээнд судалгаа явуулах, анги хамт олноороо төсөлт ажил зохион байгуулах арга зүйг баримтална.

Монгол хэлний хичээлийн арга зүйгээр дамжуулан өөрийгөө таньж мэдэх, хамтран ажиллах ТБ-ын цогц чадамжийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах боломж их байна. Унших, ярих, бичих үйлээр дамжуулан орчин тойрныхоо тогтвортой хөгжлийн асуудалд шүүмжлэлтэй хандах; ярих, бичих гэсэн бүтээлч чадвараар дамжуулан ирээдүйгээ тогтвортой хөгжүүлэх урьдчилан тооцоолох цогц чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой.

*Хүснэгт 2.13.* *Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Монгол хэл)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | | | | | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | алсын хараатай болох аргууд | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар /суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| 1 | 2 | 3 | | | | | 4 | 5 | 6 | 7 | | | | 8 | 9 | 10 |
| Я. Ярих-сонсох чадвар | 2, 10.в. Харилцагчдаа хүндэтгэн зөлдөг үг хэрэглэн ярих | | □ | | | | ТХ301.НСХ3. | ТХ301.Сэ06. | Ядууралтай холбоотой ажлын нөхцөл байдлаас шалтгаалсан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд мэдрэмжтэй хандаж, ядуу болон эмзэг нөхцөлд байгаа хүмүүсийн сэтгэл санаар дэмжиж, эв нэгдэлтэй байгаагаа харуулахдаа тэдний хүндэтгэн, зөлдөг үг хэрэглэж сурахтай холбоотой. | □ | | | | 1 - Багшийн судалгаанд үндэслэн эмзэг нөхцөлд амьдарч буй сурагчдын хамт тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаа төлөвлөх, оролцох явцдаа зөлдөг үг хэрэглэх арга зүйг төлөвлөнө. Ядуурлаас болж хөдөлмөр эрхэлж байгааг мэдрүүлэх зорилго тавина. Ийм нөхцөлд хэнтэй хэрхэн харилцах вэ гэсэн асуудлыг дэвшүүлнэ. | 3, 5,7 | 3- Хүүхэд насандаа хөдөлмөр эрхэлж буйн учир шалтгааныг ойлгож, түүний талаар эргэцүүлэн бодох учир<br>5- Харилцан ярилцах тул бусдыг ойлгож, мэдрэмжтэй хандах чадвар төлөвшинө.<br>7- Бусдын эмзэг асуудлыг ойлгох, дэмжих зорилготой учраас өөрийн үүрэг, оролцоог эргэцүүлэн бодох цогц чадамж хөгжинө. |
| У. Унших чадвар | 3, 02.а. Эхийн агуулгыг ойлгож, чухал гэж үзсэн хэсгийг ялгах | | | □ | | | ТХ303.ТМ1. | ТХ303.Сэ09. | Сурагч эрүүл мэнд, зөв хооллолтын тухай ухагдахуун, үзэл баримтлалыг ойлгохын тулд монгол үндэсний хоол хүнсний ач тусын тухай өгүүлсэн эхийг уншин, эхийн сэдвийн хүрээнд шүүмжлэлтэй хандан эргэцүүлэхдээ эхээс чухал гэсэн хэсгийг ялган, уншиж, эрүүл бус хооллолт гэсэн сэдвийн талаар дэлгэрүүлэн ярилцахтай холбоотой. | | □ | □ | | 2 - Сурах бичгийн 4 дүгээр бүлгийн эхийн агуулгатай холбон, шинжлэн судлах, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх арга зүйг баримтална.<br>3 - Сурагч эрүүл байхын ач холбогдлыг эхээс ойлгохдоо хоол хүнсний зөв сонголтын тухай хэсгийг ялган уншин, эрүүл зөв хоолыг монголчууд хэрхэн сонгон хэрэглэж ирснийг шүүмжлэлт сэтгэлгээний үүднээс ярилцахад, мөн уншсан зүйл дээрээ тулгуурлан сурагч хэрхэн эргэцүүлж байгаагаа илэрхийлэхэд багш анхаарна. | 1, 6 | 1- Улирлын онцлогийг даган, зөв хооллох, энэ нь эрүүл мэнд, сайн сайхан байдалтай харилцан хамааралтай болохыг таньж мэдэх учир<br>6- Эхээс мэдээллийг ялган уншсанаар өөрийн үнэлэмж, үйл хөдлөл ялангуяа хэрхэн зөв хоол хүнсээ сонгон хэрэглэдгээ эргэцүүлэх учир |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Я. Ярих чадвар | 3, 07.а. Тохиолдсон явдлаа нарийн тодорхой ярих | | | □ | | | ТХ306.НСХ3. | ТХ306.Сэ06. | Усны хомсдол ба зохистой хэрэглээний тухай хэлэлцэхдээ усыг зүй зохистой хэрэглэж байсан эсэх талаар өөртөө болон бусдад тохиолдсон явдлыг ярьснаар сурагч нь усны өөрийн хэрэглээг хянаж, хариуцлагаа мэдэрч чаддаг чадварыг хөгжүүлэхтэй холбоотой. | | | | □ | 4 - Хүүхэд бүр гэр бүлийнхэн юм уу ангийнхан, сургуулийнхан усыг хэрхэн хэрэглэдгийг судлан тооцоолон, бодит үйл ажиллагааг бий болгох, мөн ирээдүйд тодорхой нөхцөлд усны хомсдолд орохгүйн төлөө хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах зэргээр алсын хараатай болоход чиглүүлсэн арга зүйг сонгоно. | 2, 3, 4, 5,6 | 2- Усны хэрэглээгээ хянах, тооцох зэргээр урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлж байгаа учраас урьдчилан тооцоолох цогц чадамжийг хөгжүүлнэ.<br><br>3- Хэн нэгний тохиолдлын тухай сонсоод, усны тухай үнэлэмжийг ойлгож, түүний талаар эргэцүүлэх тул хэм хэмжээний цогц чадамжийг төлөвшүүлнэ гэж үзнэ.<br><br>4- Хамт олноороо ирээдүйн төлөвлөгөө боловсруулах тул стратегийн цогц чадамж хөгжинө.<br>5- Харилцан ярьж, санал солилцож байгаа учраас хамтран ажиллах цогц чадамжийг хөгжүүлнэ.<br><br>6- Усны зохистой хэрэглээний талаарх өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох учир өөрийгөө танин мэдэх чадвар хөгжинө. |
| У. Унших чадвар | 4, 02.а. Эхийн гол санааг ойлгох, тайлбарлах | | | | □ | | ТХ311.НСХ3. | ТХ311.Сэ06. | Тогтвортой, бат бөх байгууламж бүхий эх зохиолын **гол санааг унших, ойлгон** улмаар сурагч орон нутгийн материалыг ашиглан баталгаатай барилга байгууламж барих онцлогийн талаар эргэцүүлэхтэй холбоотой | | | □ | | 3 - IV ангийн сурах бичгийн 144-145 дугаар хуудсан дахь эхийг уншуулж, хэврэг гүүр барих болсон талаар хэлэлцүүлэг өрнүүлж, хүүхдийн бүтээлчээр шүүмжилж хандах хандлагыг төлөвшүүлэхэд анхаарна. Сурагч бүс нутгийнхаа гүүр болон бусад барилга байгууламж, түүнийг барих техник хэрэгслийн талаар эргэцүүлэн, зохиолын гол санаатай холбон тайлбарлана. | 1 | 1- Бүс нутгийнхаа талаар, сайн гүүр барих техник хэрэгслийн тухай эргэцүүлж ярилцаж байгаа учраас аливаа зүйлийг харилцан хамаарлыг таньж мэдэх тогтолцоот сэтгэлгээний чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна. |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Я. Ярих чадвар | 4, 07.д. Нөхцөл байдалдаа тохируулан өгүүлбэрийн хэлбэрийг оновчтой сонгох | | | | □ | | ТХ303.НСХ1. | ТХ303.Сэ07. | Нөхцөл байдалдаа тохируулан өгүүлбэрийн хэлбэрийг оновчтой сонгож хэрэглэхийн тулд өвчнөөс шалтгаалан зовж шаналж байгаа хүмүүстэй харилцаа тогтоож, тэдний нөхцөл байдал, зовнилыг мэдэрсний үндсэн дээр ХДХВ-ийн халдвартай хүмүүс, бусад өвчин, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байх хандлага төлөвшихтэй холбоотой. | □ | | | | 1 - Сургууль, анги, хамт олны хэмжээнд компанит ажил зохион байгуулах боломжтой тул энэ аргыг сонгож болно. Тусламж хэрэгтэй хүмүүсийг сурвалжлан, харилцаа тогтоохоос гадна хүмүүсийн нөхцөл байдлыг урьдчилан тооцсоны үндсэн дээр хэрэглэх үгсийн жагсаалт гаргах, өгүүлбэрийн хэлбэрийг сонгоход анхаарч ажиллана. | 3, 5,7 | 3- Хэн нэгэн өвдөж шаналсан хүмүүсийн үйл хөдлөлийн учир шалтгаан болсон хэм хэмжээг ойлгож, түүний талаар эргэцүүлэн бодох учир<br><br>5- Харилцан ярилцах тул бусдыг ойлгож, мэдрэмжтэй хандах чадвар төлөвшинө.<br><br>7- Бусдын эмзэг асуудлыг ойлгох, дэмжих зорилготой учраас өөрийн үүрэг, оролцоог эргэцүүлэн бодох цогц чадамж хөгжинө. |
| Я. Ярих-сонсох чадвар | 4, 09.б. Бусдын үзэл бодлыг сонсох, сонссон зүйлээ дүгнэх | | | | □ | | ТХ316.НСХ5. | ТХ316.Сэ05. | Хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн мөлжлөг сэдвийн хүрээнд ярилцлага өрнүүлэхдээ сурагч хувь хүнийхээ хувьд яс үндэстэнд харьяалагдах байдал болон жендэр, ёс суртахуун, ээзмших чадвар зэргээр шударга ёс, хүмүүнлэг чанар өөрт нь хэрхэн үйлчилж байгаа талаар эргэцүүлнэ. Ярилцлагыг үнэлэхдээ сурагчид ээлж дараатай ярьж байгаа эсэх, бусдын үзэл бодлыг сонсож байгаа эсэх, сонссон зүйлээ дүгнэж байгаа эсэхэд багш анхаарал хандуулахтай холбоотой. | | □ | | | 2 - Багш урьдчилан асуулт, асуулга бэлдэх шаардлагатай. Хүүхдийн нас бие онцлогт тохируулсан асуулт нь сурагчдыг хувь хүний хувьд өөрийг нь эргэцүүлэхэд чиглэгдсэн байхад анхаарна. Сурагчдаар тохиолдол шинжлүүлж, харилцааны чадварт сургаж байгааг анхаарч, сурагчдад урьдчилсан байдлаар үнэлгээний шалгуурыг нээлттэй тавих шаардлагатай. Энэ нь сурагчдын суралцах арга барилыг дэмжих зорилготой юм. Багш хүүхэдтэй ярилцлага хийснээр хүүхэд бүрийн онцлогийг мэдэрч, хэрхэн харилцаж, сэдэлжүүлэх вэ гэдгийг олж харах боломж гарч байна. | 7, 5 | 7- Ярилцлагын явцад хүүхэд бүр өөрийн байр суурь, үүрэг оролцоог эргэцүүлж, ангийн хүүхдүүдийн үйл ажиллагааг сонсож, үнэлэлт өгч, урам зориг хайрлаж байгаа учраас өөрийгөө танин мэдэх чадвар хөгжинө гэж үзэж байна.<br>5- Ярилцах явцад бусдыг ойлгох, мэдрэмжтэй хандах байдал илрэх, бусдаас суралцах, бусдын ярьсныг дүгнэх учраас хамтран ажиллах цогц чадамжийг төлөвшүүлэхэд хичээлийн үйл ажиллагааг чиглүүлж болно. |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Я. Ярих-сонсох чадвар | 4, 10.в. Бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлэх | | | | □ | | ТХ311.ЗУ3. | ТХ311.Сэ06. | Уншсан эхийн хүрээнд бат бөх барилга, байгууламжийн талаар хэлэлцэхдээ гүүрийг барьсан шийдвэрийг дэмжиж эсвэл эсэргүүцэж буй дуу хоолойго нэгтгэн зохион байгуулалтад орох үед бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлж сурахтай холбоотой. | | | | □ | 4 - Хэврэг гүүр барих болсон талаарх хэлэлцүүлгийн явцад гол сэдвийнхээ талаар саналаа хэлэх боломжийг олгож, хэрэв эсэргүүцэж байвал ямар үг хэрэглэвэл зөв харилцаа болох вэ гэдгийг багш анхаарч, монгол хэлний IV ангийн агуулгатай холбон интеграцчилна. Тогтвортой, бат бөх гүүрэн байгууламжийг барих талаар STEM боловсролтой интеграцчилан шинэ түүхийг урьдчилан төсөөлж бүтээх чиглэлийг баримтална. | 2, 4, 5, 6 | 2- Нутаг орондоо ээлтэй, зөв байршилтай, бат бөх гүүрийг барих зэргээр төсөөлөн урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлж байгаа учраас урьдчилан тооцоолох цогц чадамжийг хөгжүүлнэ.<br><br>4- Бат бөх гүүр барих зэргээр орон нутгийн хүрээнд шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо нэгдэн боловсруулах учраас стратегийн цогц чадамж хөгжих боломжтой.<br><br>5- Асуудлын талаар дэмжих, эсэргүүцэх шаардлага гарах учир багаараа хамтран аливаа зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх чадварыг хөгжүүлнэ.<br><br>6- Бат бөх гүүртэй байх тогтвортой байдлын тухай яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадамж чухал юм. |
| Б. Бичих чадвар | 4, 13.г. Бичихдээ төсөөлөн бодох чадвараа ашиглах | | | | □ | | ТХ311.ЗУ3. | ТХ311.Сэ06. | Тогтвортой, бат бөх байгууламж бүхий гүүрийг **төсөөлөн бичиж,** өөрийн санаа бодлыг тусгаснаар сурагч аюулгүй, уян хатан, тогтвортой орон нутгийг хамтран бүтээлцэхэд хувь нэмэр оруулж чаддаг болсноо харуулах боломжтой. | | | | □ | 5 - Орон нутагтаа аюулгүй, гүүрэн байгууламж хэрхэн барихаа төсөөлж бичих чадварыг хөгжүүлэхэд арга зүйг баримтална. | 4, 6 | 4- Бат бөх гүүр барих зэргээр орон нутгийн хүрээнд шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо нэгдэн боловсруулах учраас стратегийн цогц чадамж хөгжих боломжтой.<br>6- Бат бөх гүүртэй байх тогтвортой байдлын тухай яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадамж чухал юм. |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Б. Бичих чадвар | 4, 15.а. Зорилгодоо тохируулан уриалга бичих | | | | □ | | ТХ303.ЗУ3. | ТХ303.Сэ08. | Сурагч бусдад тусламж хэрэгтэй үед нь тэднийг мэдэрч ойлгох чадавхтай байж, өөрийн болон бусдын эрүүл байхын төлөө тусламж гуйж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор уриалга бичиж сурахтай холбоотой. | □ | | | | 1 - Зам тээврийн ослоос болж хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийн тухай бичлэг үзүүлж, эсвэл уулзан, түүхийг нь яриулан, тэмдэглэнэ. Эдгээр баримт дээр тулгуурлан уриалга бичнэ. | 2, 7 | 2- Уриалга бичихэд эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадвар тусална.<br>7- Тусламж хэрэгтэй хэн нэгний хүсэл, зориг, мэдрэмжийг хүлээн авах тул |
| У. Унших чадвар | 5, 02.д. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүр дэх цогцолбор-уудын холбоо хамаарлыг олох | | | | | □ | ТХ306.ТМ1. | ТХ306.Сэ03. | Усны чанар ба хэмжээ болон эрүүл ахуйн сэдвийн хүрээнд усны хэмжээ, чанарын ач холбогдол, усны бохирдол, хомсдолын учир шалтгаан, нөлөө, үр дагаврыг тодруулж,өөрийн үзэл бодлоор дүгнэн, ярьж бичихдээ эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэг бүр дэх утга агуулгын холбоон дээр тулгуурлан ярих үйл ажиллагаатай холбох юм. | | □ | | | 2 - V ангийн сурах бичгийн "Усаа хамгаалах уламжлалт ёсон" эхийг уншин шинжлэн судалж байгаа болохоор усны бохирдол, хомсдолын учир шалтгааныг тодруулан дүгнэхдээ цогцолбор бүрд илрэх утгын холбоо хамаарлыг олж, бодит жишээ баримт татахад багш чиглүүлнэ. | 1 | 1- Уншсан эхийн мэдээлэл дэх утгын харилцан хамаарлыг таньж мэдэн, ойлгож, асуулт зохиох учраас тогтолцоот сэтгэлгээний чадвар хөгжих боломжтой. |
| Я. Ярих-сонсох чадвар | 5, 09.б. Үзэл бодлоо зөвшөөрүүлэх үндэслэлээ төлөвлөх | | | | | □ | ТХ305.ЗУ1. | ТХ305.Сэ03. | Шийдвэр гаргалт дахь жендэрийн эрх тэгш байдал, оролцооны тухай үзэл бодлоо илэрхийлэхдээ жендэрийн чиг хандлагаас болоод ялгаварлан гадуурхагдаж буй хүмүүсийг эсвэл өөрийгөө дэмжүүлэхийн тулд үзэл бодлоо зөвшөөрүүлэх үндэслэлээ төлөвлөж, эргэн тойрныхондоо хандсан арга хэмжээ авч чаддаг болно. | □ | | □ | | 1 - Анги, сургуулийн түвшний хичээлээс гадуурх үйл ажиллагаанд эрэгтэй, эмэгтэй сурагчдын оролцооны талаар, шийдвэрт хэн нь илүү нөлөөлж байсан эсэх талаар судалгаа явуулж, бусдын өмнө илтгэх гэх мэтээр V ангийн илтгэл тавих агуулгатай холбож болох юм.<br>3 - Охидууд анги хооронд түншлэлийн харилцаа тогтоож, нэг баг болон жендэрийн тэгш оролцооны талаар үзэл бодлоо зөвшөөрүүлэх алхмыг хийнэ. Ямар үг сонговол үзэл бодлоо зөвшөөрүүлж болох эсэх агуулгыг V ангийн ятгах эх унших гэсэн агуулгатай холбож болно. | 2, 5,7 | 2- Ирээдүйд зориулж өөрийн үзэл бодлыг бий болгох, эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадваруудыг хөгжүүлнэ.<br>5- Бусадтай харилцах тул бусдаас суралцах чадвар төлөвшинө.<br>7- Хэн нэгний мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх чадвар хөгжинө. |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Я. Ярих, бичих чадвар | 5, 15.а. Зорилгодоо тохируулан зар сурталчилгаа бичих | | | | | ☐ | ТХ306.ЗУ4. | ТХ306.Сэ05. | Бохирдол, химийн хорт бодис болон бусад материалыг хаяж, асгаснаас үүдэлтэй усны чанарт үзүүлэх нөлөөллийн талаар эргэцүүлэн, усны чанар, аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах үйл ажиллагаар төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор зар сурталчилгаа бичихтэй холбоотойгоор | ☐ | | ☐ | ☐ | 4 - V ангийн сурах бичгийн "Усаа хамгаалах уламжлалт ёсон" эхийг уншин судалсны дараа усны чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр ирээдүйдээ тогтвортой амьдрах зорилго тавьж байгаа учраас алсын хараатай болгох аргуудыг санал болгож байна.<br>1 - Гэрийнхээ болон ангийн, эсвэл нутаг орныхоо усны чанарт хяналт шинжилгээ хийж, бодит үйл ажиллагаар төлөвлөж болно.<br>3 - Түүнчлэн ятгах эхийн агуулга буюу зар сурталчилгаа бичүүлэхдээ бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээний үүднээс хандахыг багш чиглүүлнэ. | 1, 2, 6, 7 | 1- Усны чанарыг муутгаж байгаа зүйлсийн талаар ярих тул аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэддэг болж, тогтолцоот сэтгэлгээ хөгжинө гэж үзнэ.<br>2- Ирээдүйдээ тогтвортой амьдрах зорилго тавьж байгаа учраас урьдчилан тооцоолж сурна.<br>6- Асуудал дэвшүүлж, зар сурталчилгаа бичих учир энэхүү цогц чадамж хөгжинө гэж үзнэ.<br>7- Өөрийн хувь нэмрээ, саналаа хэлэх тул өөрийгөө таньж мэдэх чадвар хөгжинө. |
| Б. Бичих чадвар | 5, 15.а. Зорилгодоо тохируулан зар сурталчилгаа бичих | | | | | ☐ | ТХ312.НСХ4. | ТХ312.Сэ07. | Хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, дахин боловсруулах, дахин ашиглах сэдэв бүхий мэдээллийн эх уншин, ятгах эхийн онцлогтой харьцуулан ярилцаад, хоггүй байх, хогоо дахин ашигладаг тогтвортой амьдралын хэв маягийн талаар урьдчилан төсөөлж чаддаг болсноо харуулахдаа зар сурталчилгааны эхийн хэв маягийг ашиглах нь оновчтой. | | ☐ | | ☐ | 2 - V ангийн сурах бичгийн 61 дүгээр талд буй "Хүүхдүүд хогийг урлагийн бүтээл болголоо" мэдээллийн эхийг уншаад, 79, 97 дугаар талд буй онолын мэдээллийн талаар яриулж, хоёр эхийг харьцуулахад багш анхаарна.<br><br>4 - Зар сурталчилгаа бичихийн тулд ямар асуудлыг хөндөж, ямар үгийг хэрэглэх талаар багш чиглүүлж өгнө. Зар сурталчилгаа бичнэ гэдэг нь ятгах эхийн хэв маягийг илтгэх бөгөөд юунд хэнийг яах гэж ятгаж, сурталчилгаа болгон тараах гэж байгааг сайн ярилцаны үндсэн дээр зөв найруулгатай, үгийн оновчтой сонголтоор, цөөн үгэнд багтааж бичүүлэхэд анхаарч ажиллана. Иймийн тулд тохиолдол шинжлэх замаар шинжилгээ судалгаа хийдэг арга зүй, түүх намтар зохиох замаар алсын хараатай болгох арга зүйг хэрэглэхэд тохиромжтой. | 1, 2, 6 | 1- Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах гэх мэт тодорхойгүй байдлыг авч үзэх учир тогтолцоот сэтгэлгээний чадамж хөгжинө гэж үзнэ.<br><br>2- Хүний үйл ажиллагааны ээлтэй ээлгүйг ялган харж, дүгнэлт хийж, ээлтэй байлгах талаарх зар сурталчилгаа хийх тул урьдчилан тооцоолох цогц чадамжийг төлөвшүүлэх боломжтой юм.<br><br>6- Бусдын үйл ажиллагаа болон өөрийн үйл ажиллагаар эргэцүүлэн дүгнэж, асуудал дэвшүүлэх учир шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжийг хөгжүүлж болно. |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Б. Бичих чадвар | 5, 15.а. Зорилгодоо тохируулан өдрийн тэмдэглэл бичих | | | | | □ | ТХ312.НСХ3. | ТХ312.Сэ05. | Хоол хүнсний үйлдвэрлэл, хэрэглээ, хоол хүнсний боловсруулалт, диетийн сонголт ба дадал зуршил, хог хаягдал, ойн хомсдол, хоол хүнсний хэт их хэрэглээ ба өлсгөлөн зэргийн сэдвүүдийн хүрээнд хувь хүний хэрэгцээ болон хүслийн тухай эргэцүүлэн өдрийн тэмдэглэл бичихдээ (нэг өдөр нэг сэдвийн хүрээнд эргэцүүлж), бусад хүмүүс, ирээдүй залгамж үеийнхний бүх хэрэгцээг бодолцон хувийн хэрэглээний зан үйлийг тусгахтай холбоотой. | | □ | | □ | 2 - Хэрэгцээ ба хүслийг ялгахын тулд амьдралд тохиолддог элдэв зүйлсийг "Тохиолдол шинжлэх" аргаар шинжилнэ. Ингэхдээ<br>1.хэрэгцээ, хүсэл гэсэн хоёр үгийнхээ утгыг ойлгох 2.хэрэгцээгээ дагах, эсвэл хүслээ дагаж амьдралдаа шийдвэр гаргахад тулгарч байгаа асуудлаа илрүүлж гаргаж хэлэлцэх 3.асуудлаа шийдвэрлэх гэсэн дараалаар шинжилж, хүн-нийгэм хичээлийн агуулгатай холбож болно.<br>4 - Тогтвортой хөгжлийн боловсролын санал болгосон сэдвүүдийн хүрээнд эргэцүүлж бичсэн өдрийн тэмдэглэлдээ хувийн хэрэглээгээ ирээдүйд хэрхэн зөв зохицуулахаа төлөвлөхөд чиглүүлж болно. | 2, 7 | 2- Өдрийн тэмдэглэлдээ ирээдүйд зориулж өөрийн үзэл бодлыг өөрчилж, ирээдүйн залгамж үеийнхний бүх хэрэгцээг бодолцон хувийн хэрэглээний зан үйлийнхээ талаар эргэцүүлэн бодож байгаа учраас урьдчилан тооцоолох цогц чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.<br>7- Өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодож, өдрийн тэмдэглэл хөтлөх учир өөрийгөө таньж мэдэх цогц чадамж хөгжинө гэж үзнэ. |
| Б. Бичих чадвар | 5, 15.в. Бусдын үзэл бодлыг дэмжиж бичих | | | | | □ | ТХ303.НСХ4. | ТХ303.Сэ05. | Аз жаргал, сайн сайхан байдлын тухай сэдвийн хүрээнд мэдээллийг уншин, бусдын эрүүл мэнд, сайн сайхан байдалд ач тустай шийдвэр гаргаж, үйл хэрэг бүтээхэд нь урамшуулан зоригжуулж, бусдын үзэл бодлыг дэмжин бичихтэй холбоотой. | | | □ | | 3 - V ангийн монгол хэлний сурах бичгийн 12-р хуудаснаас "Бага ангийн хүүхдүүд хичээлдээ гар утас авч явахыг хориглож магадгүй" эхийг уншуулж, сурагч тухайн сэдвийн талаар хэрхэн ойлгодгоо хэлэлцэнэ. Харилцан ярианаас бусдын үзэл бодлыг ойлгож мэдрэн, дэмжин бичихийн тулд урьдчилан ярьж бэлтгэх шаардлагатай юм. Гар утас хичээлийн үед ямар нөлөөтэй болон эрүүл мэндэд яаж нөлөөлдөг талаар бусад оролцогч хэрхэн харилцан ярилцаж, үзэл бодлоо хэрхэн илэрхийлж байгааг ойлгох, ойлгосны үндсэн дээр урамшуулах, дэмжих санаа бүхий өгүүлбэрийг бэлтгэхэд багш анхаарна. Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэнэ гэдэг нь уншсан, сонссон, харсан зүйлийн талаар асуудал дэвшүүлэхийн зэрэгцээ өөрийн үнэлэмж, ойлголт, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодож, өөрийн байр сууриа илэрхийлэх нь чухал. | 5, 6 | 5- Харилцан ярилцах тул бусдаас суралцах, бусдын хэрэгцээ, шаардлага, үйл хөдлөлийг ойлгох чадвар, өөрийгөө бусдын оронд тавих чадвар хөгжинө.<br><br>6- Гар утсаа байнга хэрэглэдэг дадал туршлага, санаа бодолд асуудал дэвшүүлж байгаа учраас шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна. |

## 2.2.Б. НЭГЖ ХИЧЭЭЛ: ТОГТВОРТОЙ БАТ БӨХ ГҮҮР

### Нэгж хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр

2015 оны 09 дугаар сарын 25-27-нд Нью-Йорк-д хуралдсан НҮБ-ын ТХ-ийн Дээд хэмжээний чуулга уулзалтаар "Эх дэлхийгээ шинэчилье-Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030" баримт бичгийг баталсан юм. Уг хөтөлбөрт ТХ-ийн асуудлыг хамруулсан 17 зорилгын хүрээнд 169 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан билээ. Энэ хөтөлбөр нь 21-р зууны хүмүүс, гараг ертөнцийн дүрэм бөгөөд энэхүү дүрмээр амьдарч тогтвортой хөгжлийн аянд амжилттай хүрэх хөтөч болсон баримт бичиг юм.

Дэлхий нийтээр боловсролын өөрчлөлтийг хөдөлгөгч хүч, ТХБ нь ТХ-ийг хангах хамгийн чухал суурь гэж үзэж байгаа энэ цаг үед ЕБС-ийн бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөрт ТХЗБ-ын суралцахуйн зорилт, санал болгож байгаа сэдвийн туссан байдлыг шинжиллээ. ТХ-ийн зорилгын 11 дүгээрт "Хот суурин газруудын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих" хэмээн заасан билээ. Дэлхийн хүн төрөлхтний нэг асуудал бол тогтвортой хэрэглээ, аюулгүй, бат бөх барилга байгууламжийн төлөвлөлт юм. Иймд дэлхийн улс орон, иргэн бүр эрсдэлгүй амьдрахын тулд байгальд илүү ээлтэй хэрэглээг чухалчлан, эдийн засгийн өртгийг багасгаж, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг хангахад хувь нэмрээ оруулах нь чухал болоод байгааг үндэслэн сургалтын цөм хөтөлбөрийн 4,02.а, 4,10.в, 4,13.г. суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт (**ТХЗ11.НСХ3, ТХЗ11.ЗҮ3, ТХЗ11.ЗҮ3),** сэдэв*(***ТХЗ11.Сэ06)-**тэй харгалзуулан нэгж хичээлийн төлөвлөлтийг санал болгож байна. Энэхүү шинжилгээний үр дүн, жишээ нэгж хичээлийн төлөвлөлт сургалтын хөтөлбөр сурах бичиг боловсруулагчид болон хэрэгжүүлэгч багш нарт тус болно гэдэгт итгэж байна.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| ТХЗБ-ын сэдэв →<br>ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ | ТХЗ11.Сэ06. Тогтвортой, бат бөх байгууламж ба байршлын төлөвлөлт |
|---|---|
| ТХЗ11.НСХ3. Сурагч өөрсдийн онцлогоо хөгжүүлэхдээ тухайн нутгийнхаа байгаль, нийгэм, техникийн үүрэг зориулалт болон тэдгээрийг бүтээсэн, бүтээж байгаа соёл, өвөрмөц зүйлсээ ухааран ойлгож, бүс нутгийнхаа талаар эргэцүүлж чаддаг болох<br><br>ТХЗ11.ЗҮ3. Сурагч орон нутгийнх нь олон нийтийн төлөө гаргасан шийдвэрийг дэмжиж эсвэл эсэргүүцэж ярьж чаддаг, мөн дэмжсэн эсвэл эсэргүүцсэн дуу хоолойгоо нэгтгэн зохион байгуулалтад орж чаддаг болох<br><br>ТХЗ11.ЗҮ4. Сурагч тусгай эрэлт хэрэгцээг хангасан (inclusive), аюулгүй, уян хатан, тогтвортой орон нутгийг хамтран бүтээлцэж чаддаг болох | 4,02. а. Эхийн гол санааг ойлгох, тайлбарлах<br><br>4,10. в. Бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлэх<br><br>4,13. г. Бичихдээ төсөөлөн бодох чадвараа ашиглах<br><br>↑ Цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт |

ТХБ-ыг монгол хэлний цөм хөтөлбөрийн агуулгатай интеграцчилахдаа хэрэглэгдэхүүн буюу эхийн агуулгатай холбосон учир IV ангийн сурах бичгээс ТХЗ-ын санал болгосон сэдвийг баримжаалан эхийг сонголоо. Сонгосон эхэд нутаг орныхоо хүмүүсийн амьдралыг тогтвортой байлгахын төлөө байгалийн аюулт үзэгдэлд орж нурах гэж буй гүүрийг нураахгүйн төлөө тэмцэж байгаа эх хоёрын тухай үйл явдал гарна. Энэхүү агуулгын хүрээнд сурагчид өөрийн оршин суугаа нутаг орныхоо гүүрэн байгууламжийн талаар хэлэлцэн, бат бөх гүүр яагаад нутаг орныхны тогтвортой амьдралыг бий болгох талаар хэлэлцэн төсөөлөн бичнэ. Ингэхдээ ТХЗ11.НСХЗ. суралцахуйн зорилтыг цөм хөтөлбөрийн 4, 02.а. эхийн гол санааг ойлгох, тайлбарлах зорилттой;ТХЗ11.ЗҮЗ.суралцахуйн зорилтыг цөм хөтөлбөрийн 4,10.в. бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлэх зорилттой; ТХЗ11.ЗҮ4. суралцахуйн зорилтыг цөм хөтөлбөрийн 4,13.г. бичихдээ төсөөлөн бодох чадвараа ашиглах гэсэн суралцахуйн зорилтуудтай тус тус уялдуулсан болно.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ***ТХЗ11.ХСХ.*** | **ТХЗ11.Сэ06.** | Тогтвортой, бат бөх байгууламжтай холбоо бүхий эх зохиолыг уншиж, гол санааг ойлгон улмаар сурагч орон нутагтаа баталгаатай бат бөх гүүрэн байгууламж барих онцлогийн талаар эргэцүүлэхтэй холбоотой. |
| ***ТХЗ11.ЗҮЗ.*** | ***ТХЗ11.Сэ06.*** | Уншсан эхийн хүрээнд тогтвортой, бат бөх байгууламж барих шийдвэрийг гарган, түүнийг дэмжиж эсвэл эсэргүүцэж буй дуу хоолойгоо нэгтгэн зохион байгуулалтад орох үед бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлж сурахтай холбоотой. |
| ***ТХЗ11.ЗҮЗ.*** | ***ТХЗ11.Сэ06.*** | Тогтвортой, бат бөх гүүрийн талаар төсөөлөн бичиж, өөрийн санаа бодлыг тусгаснаар сурагч аюулгүй, тогтвортой байгууламж бүхий орон нутгийг хамтран бүтээлцэхэд хувь нэмэр оруулж чаддаг болсноо харуулах боломжтой. |

Цөм хөтөлбөрт тусгасан эхийн агуулгыг унших, эргэцүүлэх үйл нь ТХЗБ-ын суралцахуйн зорилтын нийгэмшил-сэтгэл хөдлөлийн айд, ярих, хэлэлцэх, төсөөлөн бичих үйл нь зан үйлийн айн суралцахуйн зорилттой арга зүйн хувьд холбогдож байна.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх ТХБ-ын арга зүйн сонголт, хувь нэмэр оруулах боломжтой ТБ-ын цогц чадамжийг тодорхойлсон үндэслэл (матриц 2-ын 8, 10 дугаар баганыг харна уу)*

| Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар | Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар |
|---|---|
| 8 | 10 |
| 3- Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэлгээ шаардсан аргуудаас сонгосон болно. Тодруулбал уншсан эхийн гол санааг тайлбарлах явцад хэлэлцүүлэг хийх арга зүйг баримталж байна. IV ангийн сурах бичгийн 144-145 дугаар хуудсан дахь эхийг уншуулж, сурагч бүс нутгийнхаа гүүрний бат бөх байгаа эсэх талаар эргэцүүлэн, зохиолын гол санаатай холбон тайлбарлана. | 1- Бүс нутагтаа бат бөх сайн гүүр барих технологи, техник хэрэгслийн тухай эргэцүүлж ярилцаж байгаа учраас аливаа зүйлийг харилцан хамаарлыг таньж мэдэх тогтолцоот сэтгэлгээний чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна. |
| 4 – Орон нутагтаа тогтвортой бат бөх гүүрийг хэрхэн барих талаар төсөөлсний үндсэн дээр шийдвэр гарган, санал солилцон хэлэлцэх тул алсын хараатай болох аргуудаас ялангуяа хэтийн зорилгоо тодорхойлох арга зүйг сонгон боловсруулլаа. Ингэхдээ бодит хамтын үйл ажиллагаанд суурилан STEM боловсролтой интеграцчилан Fischertechnik тоглоомыг угсрах замаар шинэ түүхийг урьдчилан төсөөлж бүтээх чиглэлийг баримтална. | 2- Нутаг орондоо ээлтэй, бат бөх гүүрийг барих зэргээр төсөөлөн, эрсдэлээс урьдчилан сэргийлж байгаа учраас урьдчилан тооцоолох цогц чадамжийг хөгжүүлнэ.<br>4- Бат бөх гүүр барих зэргээр орон нутгийн хүрээнд шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо нэгдэн боловсруулах учраас стратегийн цогц чадамж хөгжих боломжтой.<br>5- Асуудлын талаар дэмжих, эсэргүүцэх шаардлага гарах учир багаараа хамтран аливаа зөрчлийг шийдвэрлэх чадварыг хөгжүүлнэ.<br>6- Бат бөх гүүртэй байх тогтвортой байдлын тухай яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадамж чухал юм. |
| 5 - Орон нутагтаа аюулгүй, тогтвортой, бат бөх гүүрэн байгууламж хэрхэн барихаа төсөөлж, бүтээхэд чиглүүлж бичих чадварыг хөгжүүлэхэд арга зүйг баримтална. | 4- Бат бөх гүүр барих зэргээр орон нутгийн хүрээнд шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо нэгдэн боловсруулах учраас стратегийн цогц чадамж хөгжих боломжтой.<br>6- Бат бөх гүүртэй байх тогтвортой байдлын тухай яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадамж чухал юм. |

Тогтвортой бат бөх гүүрэн байгууламжийн тухай асуудлыг хөндсөн эх уншиж, асуудлын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэн, орчиндоо эрсдэлгүй амьдрахад, аюулгүй байгууламжийг барихад хүн бүр ямар хувь нэмэр оруулж болох талаар санал бодлоо солилцон, тогтвортой барилга байгууламж буюу гүүрийг барихдаа хэрхэн барих талаар STEM боловсролтой холбон төсөөлөн бичиж байгаа учраас “ТХ311.Сэ06. Тогтвортой, бат бөх - уян хатан барилга, байгууламж ба байршлын төлөвлөлт” сэдвийн хүрээнд ТХЗБ-ын суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд болон ТБ-ын цогц чадамжийг эзэмшүүлэхэд дэмжлэг болно гэж үзэж байна.

## Нэгж хичээлийн төлөвлөлт

***<u>Нэгж хичээлийн сэдэв:</u>*** Тогтвортой, бат бөх гүүр

***<u>Нэгж хичээлийн зорилго:</u>*** Тогтвортой, бат бөх гүүрний талаар хэлэлцэн, төсөөлөн бичиж, өөрийн санаа бодлыг тусгаснаар сурагч аюулгүй, тогтвортой орон нутгийг хамтран бүтээлцэхэд хувь нэмэр оруулж чаддаг болно.

***<u>Зорилт:</u>***

- Унших: “Эх хүү хоёрын гүүр” эхийн гол санааг ойлгох, тайлбарлах, тогтвортой бат бөх гүүрний талаар эргэцүүлэх
- Ярих: Уншсан эхийн хүрээнд бат бөх гүүр барих шийдвэр гарган, түүнийг эсэргүүцэн эсвэл дэмжин хэлэлцэхдээ бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлэх
- Бичих: Тогтвортой, бат бөх гүүр барих талаар бичихдээ төсөөлөн бодох чадвараа ашиглах

***<u>Агуулга:</u>***

Багш тухайн Нэгж хичээлийн цөм хөтөлбөрийн

- 4, 02.а. Эхийн гол санааг ойлгох, тайлбарлах,
- 4, 10.в. Бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлэх,
- 4, 13.г. Бичихдээ төсөөлөн бодох чадвараа ашиглах

гэсэн суралцахуйн зорилтын агуулгыг хэрэгжүүлэхдээ “Эх хүү хоёрын гүүр” эхийг сонгон “ТХЗ11 хот суурин газрын тэгш хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих” гэсэн зорилгод хамаарах “Тогтвортой, бат бөх - уян хатан барилга, байгууламж ба байршлын төлөвлөлт “сэдэвтэй интеграцчилах боломжтой.

Орон нутгийнхаа хүмүүсийн аюулгүй байдал, тогтвортой амьдралыг хангахын төлөө гүүрийг тулж зогсож байгаа эх хүү хоёрын тухай өгүүлсэн эхийг уншаад байгаль, нийгэм, эдийн засгийн харилцан хамаарал, уялдаатай байдлын талаар хэлэлцэн, санал солилцоно. Хүүхэд бүр бат бөх гүүрийг ямар материалаар яаж барихыг төсөөлөн, бичгээр үзэл бодлоо илэрхийлэн аюулгүй, тогтвортой орон нутгийг хамтран бүтээлцэхэд хэрхэн оролцохоо илэрхийлнэ.

***<u>Арга зүй:</u>***

| Ээлжит хичээл | Арга зүйн тайлбар, дэг | ТБ-ын цогц чадамж |
|---|---|---|
| <u>Үйл ажиллагаа 1</u> /Унших чадварыг хөгжүүлэх хичээл/ | <u>Алхам 1.</u> Үлгэрийн утгыг ойлгож уншина.<br><u>Алхам 2.</u> Эхийн гол санааг тайлбарлана.<br>- Гүүрийн чулуун багана нурах болсон шалгаан<br>- Гүүр нурах болсон, мөн дахин барих нь тосгоны ард түмэнд ямар хүндрэл учруулах<br>- Бат бөх гүүр барих талаар гэх мэт<br><u>Алхам 3.</u> Бүс нутгийнхаа гүүр, түүнийг барьсан техник хэрэгслийн талаар эргэцүүлэн, зохиолын гол санаатай холбон тайлбарлана. | Бүс нутгийнхаа талаар, сайн гүүр барих техник хэрэгслийн тухай эргэцүүлэн ярилцах нь байгаль, нийгэм, эдийн засгийн харилцан хамаарлыг таньж мэдэх тогтолцоот сэтгэлгээний чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна. |

| | | |
|---|---|---|
| Үйл ажиллагаа 2 /Ярих-сонсох чадварыг хөгжүүлэх хичээл/ | Алхам 1. Өөрийн бүс нутагтаа барих гүүрийг яаж баривал бат бөх байх талаар хэлэлцэн, STEM боловсролтой интеграцчилан шинэ түүхийг урьдчилан төсөөлж бүтээснээ тайлбарлана.<br>Алхам 2. Бусдын гаргасан шийдвэрийг дэмжиж эсвэл эсэргүүцэн санал нийлэхгүй байгаагаа илэрхийлэхдээ зөв үг сонгон хэрэглэх | Нутаг орондоо аюулгүй, бат бөх гүүрийг барих зэргээр төсөөлөн бичих нь урьдчилан тооцоолох цогц чадамжийг хөгжүүлнэ.<br>Бат бөх гүүр барих зэргээр орон нутгийн хүрээнд шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо нэгдэн боловсруулах учраас стратегийн цогц чадамж хөгжих боломжтой.<br>Асуудлын талаар дэмжих, эсэргүүцэх шаардлага гарах учир багаараа хамтран аливаа зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх чадвар хөгжинө. |
| Үйл ажиллагаа 3 /Бичих чадварыг хөгжүүлэх хичээл/ | Алхам 1. ТХЗБ-ын “тогтвортой, бат бөх байгууламж” гэсэн сэдвийн хүрээнд сурагч аюулгүй, тогтвортой орон нутгийг хамтран бүтээлцэхэд хувь нэмэр оруулж чаддаг болох гэсэн зорилгын дор угсарсан тоглоомоо бодит үйл ажиллагаа болгох талаар төсөөлөн бичнэ | Бат бөх гүүртэй байх тогтвортой байдлын тухай яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр сууриа илэрхийлэх чадамж хөгжинө. |

***Үнэлгээ:***

| Хичээл № | Юуг үнэлэх вэ? | Яаж үнэлэх вэ? |
|---|---|---|
| Ээлжит хичээл 1 | Эхийн гол санааг тайлбарлах чадварыг<br>Баталгаатай гүүрэн байгууламжийн тухай эргэцүүлэх чадварыг | Асуулт даалгавраар<br>1. Баталгаатай гүүрэн байгууламж барихын тулд юу чухал вэ? Гүйцээж тэмдэглэнэ үү. Техник хэрэгсэл.....<br>2. Бат бөх гүүр гэж ямар гүүрийг хэлэх вэ? |
| Ээлжит хичээл 2 | Бусадтай санал нийлэхгүй байгаагаа хэрхэн соёлтой илэрхийлж байгааг<br>Шийдвэрийг дэмжиж эсвэл эсэргүүцэж буй дуу хоолойгоо нэгтгэн зохион байгуулалтад орж байгаа эсэхийг | Тэмдэглэсэн байдлаар<br>Зөрчлийг шийдвэрлэхдээ, санал нийлэхгүй байгаагаа илэрхийлэхдээ хэрэглэсэн үгээ бичнэ үү.<br><br>Ярилцлагын хэлбэрээр<br>Асуудлын талаар дэмжих, эсэргүүцэх шаардлага гарсан үед зөрчлийг яаж шийдвэрлэсэн бэ?<br>Хэлэлцүүлэгт ямар байр суурьтай оролцсон бэ? |
| Ээлжит хичээл 3 | Төсөөлөн бодсоноо хэрхэн илэрхийлж бичсэнийг<br>Сурагч аюулгүй, тогтвортой орон нутгийг хамтран бүтээлцэхэд ямар хувь нэмэр оруулсныг | Ярилцлагын хэлбэрээр<br>Ямар гүүр төсөөлсөн бэ? Бат бөх гүүрийг барихад юу юу чухал вэ? Тогтвортой, бат бөх гүүрийг барихад юуг хамтран бүтээлцсэн бэ? Яаж бичсэн бэ? |

***<u>Хэрэглэгдэхүүн:</u>***

*Fischertechnik тоглоом:*

STEM боловсролын fiesher техник тоглоомын гүүрэн байгууламжуудаас хамгийн бат бөхийг сонгон угсарна. “Fischertechnik, mechanic&Static2” номын 93-аас 104 дүгээр хуудсан дахь зааврыг хэрэглээрэй.




*Ашиглах эх: “Эх хүү хоёрын гүүр” Хятад ардын үлгэр*

**ЭХ ХҮҮ ХОЁРЫН ГҮҮР**

Дээр цагт нэгэн тосгонд Паньвань гэдэг хүүтэй настай хөгшин эх амьдран суудаг байжээ. Тэдэнд алга дарам газар үгүй тул настай эх нь ууланд очиж, модны гишүү түүж зарах бөгөөд харин хүү нь бусдын малыг хариулна.

Хүү маш их сэргэлэн цовоо хүү ажээ. Тэр гүйж, үсэрч харайх дуртай бөгөөд мод өөд ч сайн асаж авирна, том шавар чулууг өргөж даана, мөн гүйж байхдаа годройтон эргэж чаддаг байлаа.

Тэдний тосгоны ойролцоо нэг томгүй гол урсдаг байлаа. Тэр голын дээгүүр саравчтай, сайхан чулуун гүүр хөндлөн байдаг байв. Гүүрийг доороос нь таван чулуу тулгуур болон тулж байдаг ажээ.

Хүйтэн өвлийн нэгэн өдөр хойд зүгийн зэврүүн салхи гойд жихүүн хүйтнээр шуурахад, түүний хүчит давлагаа нь том том моддыг үндэстэй нь сугалан хаяжээ. Хүү үхэр сүргээ туусаар чулуун гүүрээр гарахад, гүүр яг л хулсаар хийсэн аятай ганхаж байв. Түүнийг доош харахад нэг чулуун багана нь юу юугүй нурж унах шахсан байв. Хэрэв гүүр унавал тосгоныхонд дахиж барина гэдэг хэцүү тул хүү нэг арга сэдэв.

Нэг их удаан бодсонгүй, өмднийхөө шуумгийг дээшлүүлэнгээ гүүрнээс ус руу үсэрч орлоо.

- Ай тий, тий гэж, ийм хүйтэн устай билүү? гээд гүүрэн доогуур шурган, толгойгоороо доод хэсгээс нь тулж, огт хөдлөлгүй зогсов. Гар нь цуцавч тэр гараа ер тавьсангүй. Тавих л юм бол гүүр нь нурах байлаа.

Энэ үеэр хөгшин эх нь гишүүгээ үүрэн буцаж явж байв. Гүүр мөдхөн нурах нь, дараа нь хэрхэн засах билээ гээд ус руу үсрэн ортол хүү нь зогсож байхтай таарав. Хүү ээждээ:

- Та яв. Би ганцаараа л ингээд барьж байя гэж хашхирав. Хүүгээ удаан зогссоныг эх нь мэдээд:
- Үгүй дээ, хүү минь. Чи ганцаараа ингээд барьж дийлэхгүй. Ээж нь чамд тусалъя гэв.

Ингээд эх хүү хоёр мөс шиг хүйтэн усан дотор толгойгоороо гүүрийг тулан зогсжээ.

Тэгээд хэдэн өдөр өнгөрчээ. Гүүрний дэргэд хөвж явж байсан загасчин эр, гүүрэн дор хүнтэй адил хоёр чулуун багана байхыг харвал Паньвань болон түүний эх хоёр чулуун багана болж хувираад гүүрийг бат бэхээр тулан зогсох аж. Загасчин тосгон руугаа гүйн очиж хүмүүсийг цуглуулан авчрав. Хүмүүс тэр чулуужсан баатруудыг харан нулимс дуслуулан байлаа. Түүнээс хойш тэр гүүрийг “Эх хүү хоёрын гүүр” гэж нэрлэв.

# 2.3. МАТЕМАТИК

## 2.3. А. БАГА БОЛОВСРОЛЫН МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт математикийн хичээлийг судлах хэрэгцээг “математикийн анхан шатны мэдлэг эзэмшүүлэх, хэл сэтгэлгээг хөгжүүлэх, математик сурах сонирхолтой болж, өдөр тутмын ахуйн асуудлыг тооцоолон шийдвэрлэх чадвар эзэмшүүлэх” гэж тодорхойлсон байна

Математикт суралцахуй нь эзэмшихүйн зүй тогтлын дагуу сурагч танин мэдэх бүтээлч үйл ажиллагаагаараа мэдлэг чадвар бүтээн хэрэглэх зарчимд тулгуурладаг. Бага ангийн сурагчид математик сургалтаар дамжуулан

- Сэдэв агуулгын хүрээнд бодит юмс зураглал, бичвэр зэргийг ажиглах, турших судлах, таамаглал дэвшүүлэх, загварчлах, тооцоолох, эргэцүүлэн бодох, дүгнэлт гаргах, ярилцах зэрэг үйл хийх явцад мэдлэг бүтээх
- Эрэмбэ дараалалтай, бүтээлчээр сэтгэх
- Хэл сэтгэлгээ, учир зүйг танилцуулах, өөртөө итгэлтэйгээр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх
- Бие даан болон бусадтайгаа хамтран ажиллах
- Анхаарал татсан асуудлыг тодруулах, асуудал үүсэх нөхцөл буюу тохироог илрүүлэх, асуудлыг шийдвэрлэх, асуудал дэвшүүлэх
- Сурах идэвх сонирхолтой байхын зэрэгцээ суралцах үйл ажиллагаандаа хариуцлагатай ханддаг болох зэрэг мэдлэг, чадвар эзэмшинэ.

Түүнчлэн ТХЗБ-ын суралцахуйн зорилт, санал болгосон сэдвүүдийг бага боловсролын “Математик”-ийн сургалтын цөм хөтөлбөрийн зөвлөмж дэх суралцахуйн зорилтуудтай холбож кодолсон. Кодыг бичихдээ ангийн дугаарыг бичээд, тусгай чадварыг тоогоор дугаарласан бол суралцахуйн зорилтуудыг үсгээр тэмдэглэсэн. Уг кодыг ашиглан 1 дүгээр матриц дээр ТХЗ ба цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудын хамаарлыг холбогдох сэдэвт нийцүүлэн томьёолсон. Харин 2 дугаар матриц дээр тэрхүү томьёоллын ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй холбогдож буй үндэслэлийг тайлбарласан. Мөн тухайн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх хичээлд хэрэглэх арга зүйн үндэслэл болон хүүхдэд төлөвших ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмрийг тодруулсан болно.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын математикийн хөтөлбөрийн агуулга нь ТХЗБ-ын сэдэв болон суралцахуйн зорилттой хэрхэн холбогдож буй байдлыг дараах шалгуураар тодорхойлов. Үүнд:

1. Сурах бичиг дэх бодлого, даалгавар нь агуулгын хувьд ТХЗБ-ын сэдэвт нийцэж буй байдал
2. Бодлого даалгаврыг гүйцэтгэх арга, аргачлал нь ТХЗБ-ын суралцахуйн зорилттой уялдсан байх

Бага боловсролын математикийн сургалтын цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан байдлыг илрүүлэхэд ТХ-ийн 3, 7, 11, 15-р зорилгод нийцэх 4 суралцахуйн зорилт тусгагдсан байна.

Эдгээр 4 суралцахуйн зорилт нь математикийн сурах бичиг, суралцахуйн удирдамжид сонгосон бодлогын агуулгаар дамжин дараах байдлаар холбогдож байна. Өөрөөр хэлбэл бодлого бодох, тооцоолол хийх, бодлогын агуулгыг ойлгох, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх явцад хүүхэд ТХБ-ын тодорхой мэдлэг, чадвар эзэмших юм. Үүнд:

*ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвт хамаарах " математик"-ийн сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын тоо*

| Ай | Танин мэдэхүй | Нийгэмшил-сэтгэл хөдлөл | Зан үйл |
|---|---|---|---|
| Суралцахуйн зорилтын тоо | 2 | | 2 |

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй интеграцчилхад тогтвортой хөгжлийн зорилтын урьдчилан тооцоолох цогц чадамжийн хөгжил болон багаар хамтран ажиллах, хамтын хүчээр асуудлыг шийдвэрлэхэд өөрийгөө таньж мэдэх зэрэг үйл ажиллагаагаар цогц чадамжийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц байна.

Санал болгож буй нэгж хичээлийн агуулга нь бага боловсролын цөм хөтөлбөрийн математикийн "Өгөгдөлтэй ажиллах" бүрэлдэхүүн хэсгийн Шинж зүй тогтол болон учир холбогдлын талаарх мэдээллийг олж цуглуулах, ойлгох дүрслэх, боловсруулах чадварын "Өгөгдөл мэдээллийг олж цуглуулах, бүртгэх түүнийг хүснэгт графикаар дүрслэх харьцуулах тайлбарлах, дүгнэлт гаргах, тодорхой нөхцөлөөр түүвэрлэсэн өгөгдөлд боловсруулалт хийх" суралцахуйн зорилтод хамаарах бөгөөд ТХЗ-ын ТХЗ07.ТМ3. болон ТХЗ07.Сэ06-тай холбогдож, сурагчдад математик тооцоололд тулгуурлан эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээнд сургах зорилготой болно.

Бага боловсролын математикийн хичээлийн хувьд ихэвчлэн тоо бодоод чимээгүй сууж байгаа нь түлхүү ажиглагддаг. Тиймээс бодлого бодож буй явцдаа тооцоолох, тооцоололд тулгуурлан өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, хамтран ажиллах замаар асуудалд бодитой хандах чадварт суралцах боломжтой байна.

*Хүснэгт 2.14.* ***Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Математик)***

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | | | | | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ….) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ….) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/ өнгөрсний нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар / суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| ***1*** | ***2*** | ***3*** | | | | | ***4*** | ***5*** | ***6*** | ***7*** | | | | ***8*** | ***9*** | ***10*** |
| 4. Өгөгдөлтэй ажиллах. Шинж зүй тогтол болон учир холбогдлын талаарх мэдээллийг олж цуглуулах, ойлгох, дүрслэх, боловсруулах | 4, 07.б. Өгөгдөл мэдээллийг олж цуглуулах, бүртгэх түүнийг хүснэгт графикаар дүрслэх харьцуулах тайлбарлах, дүгнэлт гаргах, тодорхой нөхцөлөөр түүвэрлэсэн өгөгдөлд боловсруулалт хийх | | | | □ | | ТХ307.ТМ3 | ТХ307.Сэ3 | Сурагч эрчим хүчний үр ашигтай байх, өөрийн хэрэгцээг хангах тухай ухагдахуун үзэл баримтлалыг ойлгож, эрчим хүчний хэрэглээний өөрийн хэрэгцээг хангах байдал ба эрчим хүчийг хэмнэх талаар өгөгдөл мэдээллийг олж цуглуулах, тухайлбал дулаалсан барилгад зарцуулах нэг өдрийн хэрэглээний эрчим хүч, дулаалаагүй барилгад зарцуулахаас ямар зөрүү байх эрчим хүчний хэрэглээг тооцож, өрхийн санхүүд нэг, хоёр, гурван жилээр бодож бүртгэх түүнийг хүснэгт графикаар дүрслэх харьцуулах тайлбарлах, дүгнэлт гаргах, тодорхой нөхцөлөөр түүвэрлэсэн өгөгдөлд боловсруулалт хийх. | | □ | | □ | 2- Эрчим хүчний хэрэглээний талаар эргэцүүлэн бодож, судалгаа гаргах, хэлэлцэх. *Тухайлбал суурь хэрэгцээ / хоол хийхэд эсвэл тансаг амьдралын хэв маягт /усан санг ашиглахад/ зориулан хэрэглэж байна уу гэсэн чиглэлээр сурагчдыг эрчим хүчний хэрэглээний шалтгаанаа эрэмбэлэх, хэмнэх* тооцоолол хийж тайлбарлах<br>4- Сурагч эрчим хүчний үйлдвэрлэл, зохистой хэрэглээг хангаж үр ашгийг нэмэгдүүлэх тооцоолол гаргах, дүгнэлт хийх /IV анги Математик. Хуудас 74.75. бодлого 385/ | 2 | 2- Эрчим хүчийг цаашид өдөр тутам зохистой хэрэглэхийг эрмэлзэх нь урьдчилан тооцоолох цогц чадамжид харгалзаж байна. |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4. Өгөгдөлтэй ажиллах. Шинж зүй тогтол болон учир холбогдлын талаарх мэдээллийг олж цуглуулах, ойлгох, дүрслэх, боловсруулах | 5, 07.б. Өгөгдөл мэдээллийг олж цуглуулах, бүртгэх түүнийг хүснэгт графикаар дүрслэх харьцуулах тайлбарлах, дүгнэлт гаргах, тодорхой нөхцөлөөр түүвэрлэсэн өгөгдөлд боловсруулалт хийх | | | | | □ | ТХ311.ЗУ1 | ТХ311.Сэ07 | Сурагч орон нутгийнхаа олон нийтэд суурилсан тогтвортой хөгжлийн хүрээнд хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах талаар тооцоолох, төслүүдийг төлөвлөх, сургууль орчноо цэвэр үзэмжтэй хог хаягдалгүй байлгах боломжийг тооцоолох өгөгдөл мэдээллийг олж цуглуулах, бүртгэх түүнийг хүснэгт графикаар дүрслэх, дүгнэлт гаргаж боловсруулалт хийх | □ | □ | | □ | 1- Хог хаягдлыг бууруулж дахин ашиглагдаж болох өргөн хэрэглээний барааны жагсаалтыг гаргах, төлөвлөх, хэрэгжүүлэх, оролцох<br><br>2- Жагсаалтад үндэслэн өөрсдийн хэрэглээ болон гэр бүл, сургуулийн орчинд дахин ашиглах боломжтой хог хаягдлыг төрөлжүүлэх аян өрнүүлэх, хэлэлцэх<br><br>4- Сургуулийн орчинд, анги танхимдаа цэвэр, нямбай байх дэг журмыг мөрдөх, түүнээс гарах хэмнэлтээр юу хийж болох талаар тооцоолох, хэрэгжүүлэх. V анги. Математик. Хуудас 36.37 Бодлого 173.174 | 3, 8 | 3- Орон нутаг, өөрийн гэр, сургуулийн орчинд хог хаягдлыг бууруулах хэм хэмжээг мөрддөг болж, шинэлэг санааг гаргах, хэрэгжүүлэх<br><br>8- Энэхүү суралцахуйн зорилтын хэрэгжилтийн явцад сурагчид хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, шийдлийн хувилбаруудыг боловсруулах чадвараа хөгжүүлэх боломжтой. |
| 4. Өгөгдөлтэй ажиллах. Шинж зүй тогтол болон учир холбогдлын талаарх мэдээллийг олж цуглуулах, ойлгох, дүрслэх, боловсруулах | 4, 07.б. Өгөгдөлтэй ажиллах, зүй тогтлыг олох, үргэлжлүүлэх, тоон таавар, логик бодлого бодох, боломжийг тооцоолох агуулгатай асуудал шийдвэрлэх | | | | □ | | ТХ303.ЗУ4 | ТХ303.Сэ09. | Сурагч эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хөхиүлэн дэмжиж, эрүүл бус хоол хүнсний хэрэглээг багасгах, өөрсдийн хүнсний хэрэглээг хянах, ангийн сурагчдаас мэдээлэл цуглуулж, учир холбогдлыг тооцоолох зөв дадал хэвшилтэй болох талаар хэлэлцэх | □ | | □ | | 1- Эрүүл зөв хооллолтыг харуулсан зураг видео үзэж, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, харьцуулах.<br>4- Өдөр тутмын хооллолтын зөв дадал хэвшилтэй болж, эрүүл бус хооллолтын жишээг ярьж хэлэлцэх, зөв дадалд суралцах. /IV анги. Математик. Хуудас 56.57. бодлого 283/ | 2 | Сурагч эрүүл байж сайн сайхан амьдрахын үндэс нь зөв хооллолт юм гэдгийг ойлгосноор эрүүл бус хоол хүнсний хэрэглээг багасгаснаар эрүүл зөв хооллолтын дадал хэвшилтэй болох учраас энэ нь урьдчилан тооцоолох цогц чадамжид хувь нэмэр оруулна гэж үзэж байна. |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Тоо тоолол. Бүхэл тоо энгийн ба аравтын бутархайн үйлдлийг ойлгох, гүйцэтгэх хэрэглэх | 5, 03.ё. Процентыг ойлгох хэсгийг процентоор илэрхийлэх, тоо ба хэмжээний тодорхой процентод ногдох тоо, хэмжээг олох, тодорхой процентод ногдох тоо ба хэмжээгээр уул тоо ба хэмжээг олох, процентоор тооцоолох асуудал шийдвэрлэх | | | | | □ | ТХ315.ТМ2. | ТХ315.Сэ04 | Сурагч ой мод устаж мөхөхөөс сэргийлэх, хүмүүс нь онгон байгалиа сэргээн анагаагч хүч гэж үзэх, ойлгох өөрийн амьдарч буй орон нутгийн талбайн хэмжээ, тоо ба хэмжээний тодорхой процентод ногдох ой модны тоо, хэмжээг олох, тооцоолох асуудал шийдвэрлэх | □ | | □ | □ | 1- Жил бүрийн мод тарих өдрийг бүтээлч байдлаар өнгөрүүлэх, тариад орхих биш хамгаалж арчилж ургуулах хөдөлгөөн өрнүүлэх. Тухайн газар нутагт хүний үйл ажиллагааны нөлөөгөөр сүйдсэн ой модыг цэвэрлэх хамгаалах ажилд томчуудыг уриалах, тоо баримтыг цуглуулах<br><br>3- Сүүлийн жилүүдэд тухайн орон нутагт тарьсан болон ургасан модны талаар мэдээлэл цуглуулж, ойг нөхөн сэргээхэд гарах зардлыг тооцоолох /гарсан өөрчлөлтийг хэлэлцэх/<br><br>4- Цаашид өөрийн амьдарч буй орчиндоо мод тарих, хамгаалах арга замуудыг дэвшүүлэн төлөвлөгөө боловсруулах, тооцоолох, зохион байгуулах /V анги. Математик. Хуудас 125. бодлого 638/ | 2, 4, 7 | 2- Байгаль орчин, ногоон байгууламжид хандах зөрэг хандлага, үзэл бодлыг сурагчид өөртөө бий болгох<br><br>4- Өөрийн орон нутгийнхаа ой модыг хамгаалах, нөхөн сэргээж ойжуулах ажилд анги хамт олноороо оролцох<br><br>7- Амьдрах орчиндоо зөрэгээр хандахад бусдад нөлөөлөх. Өөрийнхөө юу хийж чадахыг эргэцүүлэн бодох чадварыг хөгжүүлэх |

## 2.3.Б. НЭГЖ ХИЧЭЭЛ: МАТЕМАТИК ТООЦООЛОЛД ТУЛГУУРЛАЖ БАЙШИНГАА ДУЛААЛЦГААЯ.

### Нэгж хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр

Дэлхийн хүн ам өсөх, хүмүүсийн ахуй амьдрал, аж төрөх байдал өөрчлөгдөхийн хэрээр дэлхий даяар ТХ-ийн талаарх асуудал анхаарал татаж, эрчим хүчний хэмнэлтийн талаар ихээхэн анхаарал хандуулах болсон. Бид эрчим хүчний зардлаа хэмнэснээр хүрээлэл орчин, ирээдүйгээ хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулах юм. Бодит амьдрал дээр барилга орон сууц болон бусад байгууламжууд цонх, хаалга,ханаа сайн дулаалаагүйгээс ан цав, завсар гарч, түүгээр дулаан алддаг. Барилга байгууламжийг хэдий чинээ сайн дулаална төдийчинээ эрчим хүчээ хэмнэж чадна. Сурагчдад хүрээлэл орчноо хамгаалах, хадгалах нөхөн сэргээх асуудлын талаар зааж сургаснаар тэднийг цаашид орчиндоо ээлтэй ухамсартай шийдвэр гаргахад нь туслах юм. “Математик тооцоолold тулгуурлаж байшингаа дулаалцгаая” сэдэв нь эрчим хүчний хэмнэлтийн асуудлыг хамрах бөгөөд хүрээлэл орчиндоо ээлтэй шийдвэр гаргахад нь математикийг хэрхэн ашиглаж болохыг харуулах зорилготой юм. Дээрх сэдвийн хувьд цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвт харгалзах байдлыг харуулбал:

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ ТХЗБ-ын сэдэв → | ТХ307.Сэ06. Эрчим хүчний үйлдвэрлэл, нийлүүлэлт, ашиглалтаас үүсэх асуудлууд болон хүрээлэл орчинд үзүүлэх нөлөөлөл |
| ТХ307.ТМ3. Суралцагч эрчим хүчний үр ашигтай байх, өөрийн хэрэгцээг хангах тухай ухагдахуун, үзэл баримтлалыг ойлгож, энэ чиглэлээр баримталж буй бодлого, нийгэм-технологийн стратегиудын талаар мэддэг болох | 4, 07.б. Өгөгдөл мэдээллийг олж цуглуулах, бүртгэх түүнийг хүснэгт графикаар дүрслэх харьцуулах тайлбарлах, дүгнэлт гаргах, тодорхой нөхцөлөөр түүвэрлэсэн өгөгдөлд боловсруулалт хийх ↑ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ТХ307.ТМ3 | ТХ307.Сэ3 | Суралцагч эрчим хүчний үр ашигтай байх, өөрийн хэрэгцээг хангах тухай ухагдахуун үзэл баримтлалыг ойлгож, эрчим хүчний хэрэглээний өөрийн хэрэгцээг хангах байдал ба эрчим хүчийг хэмнэх талаар өгөгдөл мэдээллийг олж цуглуулах, тухайлбал дулаалсан барилгад зарцуулах нэг өдрийн хэрэглээний эрчим хүч, дулаалаагүй барилгад зарцуулахаас ямар зөрүү байх эрчим хүчний хэрэглээг тооцож, өрхийн санхүүд нэг, хоёр, гурван жилээр бодож бүртгэх түүнийг хүснэгт графикаар дүрслэх харьцуулах тайлбарлах, дүгнэлт гаргах, тодорхой нөхцөлөөр түүвэрлэсэн өгөгдөлд боловсруулалт хийх. |

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх ТХБ-ын арга зүйн сонголт, хувь нэмэр оруулах боломжтой ТБ-ын цогц чадамжийг тодорхойлсон үндэслэл (матриц 2-ын 8, 10 дугаар баганыг харна уу)*

| Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар | Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар |
|---|---|
| 8 | 10 |
| 2- Эрчим хүчний хэрэглээний талаар эргэцүүлэн бодож, судалгаа гаргах, хэлэлцэх. Тухайлбал суурь хэрэгцээ /хоол хийхэд/ эсвэл тансаг амьдралын хэв маягт /усан санг ашиглахад/ зориулан хэрэглэж байна уу гэсэн чиглэлээр сурагчдыг эрчим хүчний хэрэглээний шалтгаанаа эрэмбэлэх, хэмнэх тооцоолол хийж тайлбарлах<br>4- Суралцагч эрчим хүчний үйлдвэрлэл, зохистой хэрэглээг хангаж үр ашгийг нэмэгдүүлэх тооцоолол гаргах, дүгнэлт хийх /Математик. IV анги. Хуудас 74-75. бодлого 385/ | 2- Эрчим хүчийг цаашид өдөр тутам зохистой хэрэглэхийг эрмэлзэх нь урьдчилан тооцоолох цогц чадамжид харгалзаж байна. |

## Нэгж хичээлийн төлөвлөлт

***Нэгж хичээлийн сэдэв:*** Математик тооцоололд тулгуурлаж байшингаа дулаалцгаая.

***Хамрах хүрээ:*** Ерөнхий боловсролын сургуулийн IV анги

***Нэгж хичээлийн зорилго:*** Энэхүү хичээлээр гурван өөр төрлийн дулаалгын багц тус бүрийн өртгийг тооцоолон хооронд нь харьцуулж, алийг нь сонгож дулаалга хийлгэвэл эдийн засгийн хувьд хамгийн хэмнэлттэй болохыг тодорхойлох зорилготой. Түүнчлэн эрчим хүчний зардлыг бууруулахын тулд байшингийн дулаалгыг хэрхэн хийх талаарх шийдвэр гаргалтад математикийг ашиглах боломж бололцоог сурагчдад жишээ болгон харуулсан. Мөн энэхүү сэдвийн хүрээнд дулаалгын зардал нь хэдийд санхүүгийн хувьд хэмнэлттэй болохыг математик тооцооллоор илэрхийлж шинжилсэн. Сурагчдаар эдгээр дасгалуудыг ажиллуулснаар тэдний эрчим хүчний талаарх ойлголтыг нэмэгдүүлж өөрсдийн санал бодлоо математикаар дүгнэн тайлбарлах чадвараа хөгжүүлэхэд нь туслах юм.

***Агуулга ба арга зүй:***

| Хичээл № | Агуулга | Арга зүйн чиглэл |
|---|---|---|
| 1 | Сурагчдын өмнөх мэдлэг чадвар<br>• Олон оронтой тооны нэмэх үйлдлийг гүйцэтгэж чаддаг.<br>• Тодорхой нөхцөлөөр түүвэрлэсэн өгөгдөлд боловсруулалт хийх, дүгнэлт гаргах чадвартай | |
| | Алхам 1. Хэлэлцүүлэг: Дэлхий нийтээр эрчим хүч ямар их чухал болон хүмүүс өдөр тутмынхаа амьдралд эрчим хүчийг хэмнэх талаар юуг хийж чадах тухай товчхон хэлэлцүүлгээр эхэлнэ. | Багш сурагчдыг тэгш хамруулах, хүүхэд бүрийн санаа бодлыг сонсоход анхаарна. Үүнд:<br>• Байгалийн гэрэлтэй үед цахилгаанаа унтраах<br>• Цахилгаан хэрэгслийг ашиглаж дуусаад залгуураар нь салгах<br>• Ашиглаагүй байгаа анги, өрөө, байрныхаа гэрлийг унтрааж хэвших<br>• Эрчим хүчийг үйлдвэрлэхийн тулд хэчнээн их байгалийн баялаг ашиглагддаг болох талаар |

| | | |
|---|---|---|
| | <u>Алхам 2.</u> Хэлэлцүүлгийн дараа байшингийн цонх, дээвэр, хана зэргээрээ дулаанаа алдсан зургийг сурагчдад үзүүлнэ.<br>Дараах бодлогыг сурагчдаар бодуулна.<br><br><u>Алхам 3.</u> Бодлогыг шинжлэх<br><u>Алхам 4.</u> Бодлогыг 1-р нөхцөлийн дагуу бодно.<br>Нөхцөл1. Ганаа дулаалгын багц бүрийг сонгосноор эрчим хүчинд жилд хэдэн төгрөг зарцуулах тооцоог хийнэ үү. | Багш сурагчдыг 4, 4-өөр нь баг болгон хувааж ажиллуулах ба бодлогын өгүүлбэрийг анхааралтай уншихыг сануулна.<br>**Бодлого:** Ганаа том талбайтай хувийн орон сууц худалдаж авсан юм. Тэр эхний жилээ байшингийн дулаалгад ямар ч мөнгө зарцуулаагүй бөгөөд энэ нь илүүц зүйл гэж боджээ. Ингээд нэг жил өнгөрөхөд байшингаа дулаахан байлгахын тулд цахилгаандаа 960000 төг зарцуулчихсан байв. Тэрээр нэг жилийн турш төлсөн цахилгааны мөнгөө тооцож үзэхэд сар бүр дунджаар 80000 төлж байснаа мэджээ. Ганаа мэргэжлийн байгууллагад хандаж энэхүү барилгыг хэрхэн дулаалах талаар санал зөвлөгөө авч үүн дээрээ үндэслэн доорх хүснэгтэд үзүүлсэн гурван багцаас сонгохоор шийджээ. Та нарын хийх ёстой зүйл бол Ганаад аль дулаалгын багцыг сонгох нь хамгийн зөв сонголт болохыг шийдэж өгөх юм.<br>• Ганаа яагаад худалдаж авсан байшингаа дулаалахаар болсон бэ?<br>• Байшин халуун дулаан байхад дулаалга яаж нөлөөлнө гэж та нар бодож байна вэ?<br>• Тог цахилгааны төлбөрт дулаалга хэрхэн нөлөөлөх вэ?<br>• Дулаалга хийснээр мөнгөө хэмнэх үү? Яагаад?<br>Ийнхүү сурагчид дулаалгын ач холбогдол учир шалтгааны талаарх анхны ойлголтыг авсны дараа Хүснэгт- д өгөгдсөн гурван асуултын дагуу ажиллана. Доор өгөгдсөн гурван ялгаатай дулаалгын багц бүрийн зардлыг харьцуулах бөгөөд алийг нь захиалж хийлгэвэл эдийн засгийн хувьд хэмнэлттэй сонголт болохыг тодорхойлно. |

*<u>Даалгавар:</u>*

| Шалгуур | I багц | II багц | багц |
|---|---|---|---|
| Дулаалгын төрөл | Зөвхөн цонх | Цонх ба дээвэр | Цонх, дээвэр, хана |
| Дулаалгын зардал | 180000 төг | 420000 төг | 600000 төг |
| Багцыг сонгосноор жилд эрчим хүчинд зарцуулах төгрөг | Хэдэн төгрөг -? | Хэдэн төгрөг -? | Хэдэн төгрөг -? |

<u>Бодолт:</u> Сурагчдын бодолтыг дараах байдлаар урьдчилан тооцож байна.

Эхлээд сурагчид дулаалгын багц бүрийг сонгосноор сар бүр хэдэн төгрөг хэмнэхийг тооцох хэрэгтэй болно. /*Сурагчид Хүснэгтэд дулаалгын багц бүрийг сонгосноор эрчим хүчинд жилд хэдэн төгрөг зарцуулах тооцоог олсон байна.*/

*<u>1-р баг:</u>* 1 сард хэмнэх мөнгийг 12 удаа нэмж /*олон оронтой тооны нэмэх чадвараа ашиглаж*/ жилийн турш хэмнэх мөнгөний тоог олсон.

*<u>2-р баг:</u>* 1 сард хэмнэх мөнгийг 12 сараар үржүүлж, /*Олон оронтой тоог 2 оронтой тоогоор үржүүлэх мэдлэгээ ашиглаж*/ жилийн турш хэмнэх мөнгөний тоог олсон.

*<u>3-р баг:</u>* Дулаалгын багцад зарцуулах нийт мөнгийг цонх дулаалах 15000 төгрөгөнд хувааж 12 сар төлөгдөнө гэсэн тооцоог гаргажээ.

*Доорх хэсэгт 1-р багийн сурагчид өөрсдийн арга барилаа хэрхэн тодорхойлсныг үзүүлэв.*

| Дулаалгын төрөл | Зөвхөн цонх | Цонх ба дээвэр | Цонх, дээвэр, хана |
|---|---|---|---|
| Дулаалгын зардал | 180000 | 420000 | 600000 |
| Сар бүр хэмнэх мөнгө | 15000₮ | 35000₮ | 50000₮ |
| 1-р баг | 15000x12=180000<br>“12 сар” | 35000x12=420000<br>“12 сар” | 50000x12=600000<br>“12 сар” |
| 2-р баг | 15000: 30000: 45000: 60000: 75000: 90000: 105000: 120000: 135000: 150000: 165000: 180000: “12 сар” | 35000: 70000: 105000: 140000: 175000: 210000: 245000: 280000: 315000: 350000: 385000: 420000: “12 сар” | 50000: 100000: 150000: 200000: 250000: 300000: 350000: 400000: 450000: 500000: 550000: 600000: |
| 3-р баг | 180000/15000=12 сар | 420000 / 35000=12 сар | 600000 / 50000=12 сар |

| Хичээл № | Агуулга | Арга зүйн чиглэл |
|---|---|---|
| 2 | Өмнөх мэдлэгийг сэргээх | Өмнөх хичээл дээр сурагчид тухайн багцыг сонгосноор жилд хэдэн төгрөгний хэмнэлт хийх талаар тооцоолж гаргасан. Энэ цагийн хичээл дээр багц бүрээс 5 жилийн дараа хэр их мөнгө хэмнэж болох тооцоог хийнэ. |
| | Бодлого 1: Багц бүрээс 5 жилийн дараа хэр их мөнгийг хэмнэж чадсан байх вэ? Ганаагийн хувьд аль багцыг сонгох нь хамгийн зөв сонголт болохыг тайлбарлаж өгөх | Бодлого 2-ыг бодох аргыг урьдчилан тооцсон байдал: Энэхүү асуултад сурагчид хэд хэдэн ялгаатай хувилбараар хариулт өгнө. Тухайлбал: Дулаалгын багц бүрийг сонгож, сар бүр хэмнэх мөнгийг олсны дараа зарим сурагчид 5 жил = 60 сар учраас үүнийгээ 60-аар үржүүлж, Ганаагийн 5 жилийн турш хэмнэх мөнгийг олно. |
| | Хичээлийн хэлэлцүүлэг | Хичээлийн төгсгөлд багш өөрийн бодол санаа, арга барилыг сурагчидтай хуваалцаж,<br>- Гурван багцын аль нь хамгийн сайн сонголт болох, мөн аль нь хамгийн муу болохыг хэлэлцэж шийдвэрлэхэд нь сурагчдад тусална.<br>- Багш таван жилийн турш Ганаагийн дулаалгын багц бүрт төлөх мөнгөний хэмжээг харуулсан дээрх өгөгдлийг сурагчдад үзүүлнэ.<br>- Үүний дараа сурагчдыг дулаалгын зардал болон эрчим хүчний төлбөрт нийт хэдий хэмжээний мөнгө зарцуулахыг тооцсон сурагчдын тооцооллыг ажиглаж дүгнэлт гаргана<br>- Сурагчид тэдгээр тооцооллыг харж дүгнэлт гаргасны дараа багш, сурагчдыг Ганаад хандаж аль дулаалгын багц нь эдийн засгийн хувьд хамгийн хэмнэлттэй сонголт болохыг тайлбарласан захидал бичих даалгавар өгнө. |
| | Хичээлийн дүгнэлт | Дулаалгын багц сонгох дасгал ажлаар сурагчид дулаалгын гурван багцуудын зардал болон тэдгээрийн жил бүр хэмнэх мөнгөөр байшингийн дулаалгын үр ашигтай байдлыг тооцоолсон. Даалгаврын төгсгөлд сурагчид зөвхөн Ганаагийн дулаалгын багцаа зөв сонгож шийдвэр гаргахад нь туслаад зогсохгүй дулаалга хийснээр эрчим хүчийг хэмнэж, газрын малтмал түлшийг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах зэрэг хүрээлэл орчинд ээлтэй шийдэл болж байгааг ойлгох юм. |

*Дараах хүснэгтэд 2-р асуултад багууд хэрхэн хариулсныг харуулсан байна.*

| Сар бүр хэмнэх мөнгө | 15000төг | 35000төг | 50000төг |
|---|---|---|---|
| 1-р баг | 65000 x 60=900000төг | 45000 x 60=2700000 төг | 30000 x 60=1800000төг |
| 2-р баг | 15000x 60=900000: төг 4800000– 180000= 3000000 | 35000 x 60=2100000 4800000– 2100000= 2700000 төг | 450000 x 60=27000000 4800000 – 1800000= 3000000 төг |
| 3-р баг | 80000 x 60=4800000₮“Дулаалаагүй байшингийн эрчим хүчний 5 жилийн зардал” | | |
| | 65000x60=3900000₮ 2-р багцыг сонгож дулаалсан тохиолдолд эрчим хүчний 5 жилийн зардал” 4800000 – 3900000= 900000 “2-р багцыг сонгосноор 5 жилийн турш хэмнэх мөнгө” | 45000x 60=2700000₮ “2-р багцыг сонгож дулаалсан тохиолдолд эрчим хүчний 5 жилийн зардал” 4800000 – 2700000= 2100000 “2-р багцыг сонгосноор 5 жилийн турш хэмнэх мөнгө” | 30000x60=1800000₮ “ 2-р багцыг сонгож дулаалсан тохиолдолд эрчим хүчний 5 жилийн зардал” 4800000 –1800000= 3000000 “2-р багцыг сонгосноор 5 жилийн турш хэмнэх мөнгө” |

1-р баг: Зарим сурагчид үүнийг арай өөрөөр буюу дулаалгад зарцуулсан зардлаа тооцсон.

2-р баг: Сурагчид 5 жилийн туршид дулаалсан болон дулаалаагүй үеийн эрчим хүчний мөнгийг тус тус олж хооронд нь харьцуулах замаар нийт хэмнэх мөнгийг тооцсон.

3-р баг: Сурагчид өөр өөрсдийн бодсон аргаа бие биетэйгээ хуваалцсаны дараа 1-р багийн сурагчид бусад сурагчдын бодолтоос суралцаж өөрсдийнхөө алдааг олжээ.

*Тэд 5 жилийн турш нийт хэмнэсэн мөнгөнөөсөө нийт дулаалгын зардлаа хасаагүй байв. Анги нийтээрээ хэлэлцсэний дараа 1-р багийн гишүүд 5 жилийн туршид хэмнэсэн нийт мөнгийг олоход дулаалгын зардлаа хасах нь чухал байсныг ойлгож авсан. Мөн дулаалгад хэдийчинээ их ач холбогдол өгч ажиллана төдийчинээгээр дулаанаа хадгалж, эрчим хүчинд зарцуулах зардлаа хэмнэж чадах юм байна гэсэн дүгнэлтийг сурагчид хийнэ.*

## Үнэлгээ:

Бодлогын нөхцөлийн дагуу тооцооллоо зөв хийж буй эсэхийг багш анхаарч дэмжлэг шаардлагатай хүүхдэд бүрд тусалж, эрчим хүчийг хэмнэх зөв дадал хэвшилтэй болж буй эсэхийг ангид хийж буй үйлдлээр нь дүгнэж болно. Үүнд:

| Хичээл № | Үнэлгээний даалгавар | Үнэлэх арга, хэрэгсэл |
|---|---|---|
| 1 | Бодлогын нөхцөлийг ойлгож, тооцооллыг хэрхэн хийж буй байдал | - Бодлогыг зөв бодсон эсэх<br>- Бодсон бодлогоо тайлбарлаж буй эсэх |
| 2 | Бодлогын нөхцөлийг ойлгож, тооцооллыг хэрхэн хийж буй байдал | - Танай багийн тооцоо яаж гарсан бэ?, Танай багийн тооцоо яагаад зөрүүтэй гарав? гэсэн асуулт тавьж алдсан алдааг хэлэлцэх, засах<br>- Гэрэлтэй үед ангийн цахилгааныг унтрааж буй эсэх дээр хяналт тавьж хэвшүүлэх |

## Хэрэглэгдэхүүн:

- Байшингийн зурагт үзүүлэн
- Бодлогын нөхцөлийг үзүүлсэн тоон хүснэгт
- Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, товч зөвлөмж бүхий тараах материал



# 2.4. ХҮН БА БАЙГАЛЬ

## 2.4. А. БАГА БОЛОВСРОЛЫН ХҮН БА БАЙГАЛЬ ХИЧЭЭЛИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт хүн ба байгаль хичээлийг судлах хэрэгцээг

- Байгалийн юмс үзэгдэл, учир шалтгаан, холбоо хамаарлыг судлах, танин мэдэх
- Шинжлэн судлах арга барилд суралцах. Шинжлэн судлах арга барилд асуулт асуух, таамаглал дэвшүүлэх, үйл ажиллагаагаа төлөвлөх, төлөвлөсний дагуу хийж гүйцэтгэх, мэдээлэл боловсруулах, дүгнэлт гаргах чадварыг багтаан ойлгоно гэж тодорхойлсон байна

Энэ нь ТХЗБ-ын сэдэв, суралцахуйн зорилттой цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг уялдуулах бүрэн боломжтой байгааг харуулж байна.

Бага боловсролын хүн ба байгаль хичээлийн цөм хөтөлбөрт тусгасан тус агуулга нь цаашид эзэмших суурь, бүрэн дунд боловсролын байгалийн ухааны хичээлийн суурь болох тул байгалийг танин мэдэх, байгалийн үзэгдлийг ойлгох, судлах сонирхлыг төрүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмших, байгалийг хайрлах, зөв зохистой харилцах хандлага төлөвшихөд чиглэх ёстой хичээлүүдийн нэг билээ. Тиймээс багш нар хүн ба байгаль хичээлийг төлөвлөж хэрэгжүүлэхдээ ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй нягт уялдуулахад анхаарах хэрэгтэй юм.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын хүн ба байгаль хичээлийн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй хэрхэн холбогдож байгааг дараах хоёр шалгуураар тодорхойлсон.

1. Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын агуулга, үйл үгийн томьёоллоор
2. Хүн ба байгаль хичээлийн арга зүйн зөвлөмж дэх санал болгож буй суралцахуйн үйл, сурах бичиг дэх дасгал даалгаврын уялдаагаар шинжилсэн.

*ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвт хамаарах “хүн ба байгаль”-ийн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт*

<table>
<tr><th rowspan="2">ТХЗ</th><th colspan="5">ТХЗБ-ын сэдвүүд</th></tr>
<tr><th>ТХ303.Сэ09.</th><th>ТХ307.Сэ03.</th><th>ТХ311.Сэ05.</th><th>ТХ315.Сэ01.</th><th>ТХ315. Сэ02.</th></tr>
<tr><td>ТХ303. Сайн эрүүл мэнд ба сайн сайхан байдал</td><td>4, 01.в.</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>ТХ307. Боломжийн үнэтэй, цэвэр эрчим хүч</td><td></td><td>5, 04.д.</td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>ТХ311. Тогтвортой хот суурин, оршин суугчид</td><td></td><td></td><td>5, 01.д.</td><td></td><td></td></tr>
<tr><td rowspan="2">ТХ315. Газар дээрх амьдрал</td><td rowspan="2"></td><td rowspan="2"></td><td rowspan="2"></td><td>4, 02.а.</td><td rowspan="2">4, 02.в.</td></tr>
<tr><td>4, 02.б.</td></tr>
</table>

Шинжилгээний үр дүнгээс харахад бага боловсролын хүн ба байгаль хичээлийн IV ангид 8 сэдвийн 35, V ангид 8 сэдвийн 42, нийт 16 сэдвийн 77 суралцахуйн зорилтоос 6 суралцахуйн зорилт нь ТХ-ийн 3, 7, 11, 15-р зорилгын хүрээнд санал болгосон 5 сэдэвтэй уялдаж байна. Энэ нь бага боловсролын хүн байгаль хичээлийн цөм хөтөлбөрийн зорилго болон бусад хичээл судлагдахууны хөтөлбөртэй харьцуулахад бага туссан байгааг илтгэж байна.

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан "Хүн ба байгаль" хичээлийн 6 суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх арга зүйг шинжилсэн үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Аргазүйн төрлийг сонгосон байдал*

| Хичээл | Сургалт зохион байгуулах арга зүй | | | |
|---|---|---|---|---|
| | Бодит хамтын үйл ажиллагаанд оролцох аргууд | Шинжилгээ судалгаа хийх аргууд | Бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд | Алсын хараатай болох аргууд |
| Хүн ба байгаль | 4, 02.б.<br>4, 02.в.<br>5, 01.д.<br>5, 04.д. | 4, 01.в.<br>5, 01.д. | 4, 02.а.<br>4, 02.в. | 4, 01.в.<br>4, 02.в.<br>5, 01.д. |

Хүснэгтээс үзэхэд бодит хамтын үйл ажиллагаанд оролцох, алсын хараатай болох аргуудыг түлхүү тусган хэрэгжүүлэх боломжтой нь харагдаж байна. Мөн санал болгож буй бусад арга зүйгээр баяжуулан хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.

Интеграц болж буй дээрх 6 суралцахуйн зорилтын агуулга, эзэмших чадварыг хөгжүүлэхэд сурах бичгийн дасгал, даалгавар хэрхэн дэмжлэг үзүүлэхийг ТХБ-ын арга зүйтэй уялдуулан судалсан. Санал болгож буй арга зүйгээр дээрх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлбэл ТБ-ын цогц чадамжид ямар хувь нэмэр оруулж болохыг дараах хүснэгтээр харууллаа.

*ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмэр*

| Хичээл | ТХБ-ын цогц чадамж | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1. Тогтолцоон сэтгэлгээ | 2. Урьдчилан тооцоолох | 3. Хэм хэмжээний | 4. Стратегийн | 5. Хамтран ажиллах | 6. Шүүмжлэлт сэтгэлгээ | 7. Өөрийгөө таньж мэдэх | 8. Асуудал шийдвэрлэх |
| Хүн ба байгаль | 4, 02.а.<br>4, 02.б. | 4, 01.в.<br>5, 04.д. | | 4, 02.в.<br>5, 01.д. | 5, 01.д. | | 4, 02.в. | |

Хүн ба байгаль хичээлийн ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан 6 суралцахуйн зорилтыг ТХБ-ын санал болгосон арга зүйгээр хэрэгжүүлэхэд дээрх 5 цогц чадамжийн хөгжилд тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлэхээр байна. Энэ нь байгалийн ухааны хичээлийн шинжлэн судлах арга барилтай уялдаж байна.

*Хүснэгт 2.15.* ***Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хүн ба байгаль)***

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4 | 5 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/ өнгөрсний нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар /суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| **1** | **2** | **3** | | **4** | **5** | **6** | **7** | | | | **8** | **9** | **10** |
| 1. Өсөлт хөдөлгөөн | 4, 01.в. Хүний араг ясны хэвийн өсөлт, булчингийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүд, хөдөлгөөний ач холбогдлыг мэдэх | ☐ | | ТХЗ03.ЗҮ1. | ТХЗ03.Сэ09. | Хүний араг ясны хэвийн өсөлт, булчингийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судалж, хөдөлгөөний ач холбогдлыг мэдсэнээр хөдөлгөөний дутагдалд орохоос урьдчилан сэргийлэх, сурагч эрүүл амьдралын зан үйлийг \идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх, зөв суух, цүнхээ 2 мөрөндөө үүрэх гэх мэт\ өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох | | ☐ | | ☐ | 1- Эрүүл зан үйлийг харуулсан /зөв суух, цүнхээ зөв үүрэх гэх мэт/ видео үзэж, нурууны муруйлт үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, харьцуулах. 4- Өдөр тутмын амьдралын зөв хэв маяг, дасгал хөдөлгөөн нь нуруу цэх байх, цаашлаад араг ясны хэвийн өсөлт, булчингийн хөгжилд ач холбогдолтойг хэлэлцэх. Урьдчилан сэргийлэх арга замуудыг санал болгож өөртөө хэвшүүлэх | 2 | Сурагч эрүүл байж сайн сайхан амьдрахын үндэс нь зөв дадал хэвшил юм гэдгийг ойлгосноор хөдөлгөөний дутагдал болон нуруу муруйлтаас урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэхэд нь хувь нэмэр оруулна гэж үзсэн. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. Амьд бие ба амьдралын орчин | 4, 02.а. Амьтан бүр өөрийн амьдралын орчиндоо зохицсон байдгийг ойлгох | □ | | ТХ315.ТМ1. | ТХ315.Сэ01. | Сурагч амьтан бүр амьдралын орчиндоо зохицсон байдгийг / онцлог шинжүүд/ өөрийн орон нутгийн амьтдын жишээ дээр тайлбарлах, амьдралын төлөөх тэмцэл, араатан-идэш буюу идэш тэжээлийн хэлхээгээр холбогдож өөр хоорондоо нарийн зохицож байдгийг тайлбарлах. | | | □ | 3- Амьтан ургамал амьдралын орчиндоо хэрхэн зохицсон байдгийг илрүүлэх ажиглалт хийх, ажигласан зүйлээ зураг болон бичвэрээр илэрхийлэх, ярилцах, мини экскурс, аялал хийх, аяллаас цуглуулсан баримтад тулгуурлан хэлэлцүүлэг өрнүүлэх. | 1 | Сурагчид энэхүү сэдвийг судалснаар амьдралын орчны нөхцөлүүдийг нэрлэх, амьд биес өөрийн амьдрах орчиндоо хэрхэн зохицсон байдгийг \амьд биеийн онцлог шинжүүд\ тодорхой жишээн дээр тайлбарлах. Амьдралын төрөл бүрийн орчныг гарын доорх материал ашиглан бүтээж бусдад танилцуулах учир тогтолцоот сэтгэлгээний цогц чадамжид хамааралтай гэж үзлээ. |
| 3. Амьд бие ба амьдралын орчин | 4, 02.б. Амьтан ургамлын харилцан хамаарал, идэш тэжээлийн хэлхээг зурж тайлбарлах | □ | | ТХ315.ТМ1. | ТХ315.Сэ01. | Тухайн амьдралын орчинд зохицон амьдарч буй амьд биес өөр хоорондоо идэш тэжээлээрээ холбогддог ба энэхүү хэлхээ нь нарны энергийг ашиглан хооллодог ногоон ургамлаар /бүтээгч/ эхэлдэг болохыг ойлгох. | □ | | | 1- Амьдралын орчиндоо амьтан ургамал өөр хоорондоо нарийн холбоотой болохыг олж мэдэх, жишээ дурдах. Идэш тэжээлийн хэлхээг харуулсан зураг схемийг ойлгож унших, идэш тэжээлийн хэлхээ юугаар эхэлдэг болохыг ярилцаж, өөрсдийн таамаглалыг видео бичлэгтэй \хоол тэжээлийн хэлхээ нь нарны энерги ашиглан хооллодог бүтээгч буюу ногоон ургамлаар эхэлдэг болохыг\ харьцуулах. Бүтээгч, хэрэглэгч, задлагч, махан идэштэн, өвсөн идэштэн зэрэг нэр томьёог ойлгох, зурж тайлбарлах | 1 | Сурагчид энэхүү сэдвийг судалснаар амьд биес өөрийн амьдрах орчиндоо хэрхэн нарийн уялдаж, харилцан хамааралтай байдгийг танин мэдэх учир тогтолцоот сэтгэлгээний цогц чадамжид хамааралтай гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, бүтээгч, хэрэглэгч, задлагч гэсэн нийлмэл системийн хүрээнд асуудлыг авч үзэх тул. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4. Амьд бие ба амьдралын орчин | 4, 02.в. Амьдралын орчинд хүний үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, байгаль орчноо хайрлан хамгаалах санал санаачилга гаргах | □ | | ТХ315.ТМ2. | ТХ315.Сэ02. | Сурагчид хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хүрээлэн буй орчинд үзүүлэх хор хохирлыг /агаар, ус, хөрс, хоол хүнсний бохирдол/ хэлэлцэх. Улмаар амьтан, ургамал амьдрах орчноо алдах,хэт ашиглалтаас үүдэн талын чоно /биологийн төрөл зүйл/ устаж мөхөх, хог хаягдал зэрэг хүчин зүйлүүд өөрийн орон нутагт / сургууль орчмын/ нь ямар түвшинд байгааг тодорхойлох, байгаль орчноо хайрлан хамгаалах санал санаачилга гаргах | □ | | □ | □ | 1- Эх дэлхийн өдөр /04 сарын 22/ -ийг жил бүр тэмдэглэн өнгөрүүлэх. Тухайн газар нутагт хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хүрээлэн буй орчны нөхцөл алдагдсан эсэх баримтыг хэлэлцэх<br>3- Биологийн төрөл зүйлүүд амьдрах орчноо алдах, идэш тэжээлийн хэлхээ алдагдсанаас үүсч буй асуудлыг талын чонын жишээгээр авч үзэх, хэлэлцэх, санал санаачилга гаргах Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хүрээлэн буй орчинд үзүүлэх хор хохирлыг хэлэлцэх. Тухайлбал: агаар, ус, хөрс, хоол хүнсний бохирдол<br>4- Цаашид амьдарч буй орчноо хамгаалах арга замуудыг дэвшүүлэн уриалга гаргах, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх | 4, 7 | 4- Өөрийн орон нутаг / сургууль орчим/-ийн байгаль орчноо хайрлан хамгаалах санал санаачилгыг анги хамт олноороо боловсруулах учраас<br>7- Сургууль орчмын ногоон байгууламжийг сэргээхийн тулд би, бид юу хийх хэрэгтэй вэ гэдгийг хэлэлцэж байгаа учраас |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Цэцэгт ургамлын амьдралын эргэлт | 5, 01.д. Сургуулийн гаднах талбай болон орон нутгийн цэцэрлэгт хүрээлэнгээр аялж цэцэгт ургамлыг ажиглаж, хэрхэн тоос хүртэж, үр тогтолт явагддаг талаар баримт цуглуулах | | □ | ТХ311.НСХ3. | ТХ311.Сэ05. | Сургууль, анги, сургуулийн гаднах талбайгаар аялж цэцэгт ургамлыг ажиглаж, хэрхэн тоос хүртэж, үр тогтолт явагддаг талаар баримт цуглуулах, тасалгааны болон таримал ургамлыг тоолох. Сургуулийн болон гэр, хашаа орчмын ногоон ургамлаар зургийн цомог хийх. Тасалгааны болон таримал ургамлууд нь хүний суурьшилд хэрхэн дасан зохицож байгааг цэцэгт ургамлын амьдралын эргэлтийн жишээгээр тайлбарлах. Сурагч ургамлын талаар олж авсан мэдлэг, чадвараа ахуй амьдралдаа хэрэглээ болгох. Ногоон орчныг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах. | □ | □ | | □ | 1- Аяллын зорилго, ажиглалт хийх аргаа боловсруулах /цэцэгт ургамлыг ажиглах, тоолж хүснэгтэд тэмдэглэх/, төлөвлөх, хэрэгжүүлэх<br><br>2- Ажиглалтын үр дүнд үндэслэн тасалгааны болон таримал ургамлууд нь хүний суурьшилд хэрхэн дасан зохицож байгааг цэцэгт ургамлын амьдралын эргэлтийн жишээгээр тайлбарлах, хэлэлцэх<br><br>4- Сургуулийн орчинд, анги танхимдаа мини эко булан, амьдралын лаборатори / Цэцэгт ургамлын/ байгуулахад оролцох | 4, 5 | 4- Орон нутаг, өөрийн сургуулийн орчинд амьдралын лаборатори / цэцэгт ургамлын/, эко булан байгуулах шинэлэг санааг гаргах, турших, хэрэгжүүлэх<br><br>5- Энэхүү суралцахуйн зорилтын хэрэгжилтийн явцад сурагчид хамтран ажиллах, бусдын үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож хүндэтгэх чадвараа хөгжүүлэх боломжтой. |
| 4. Энерги | 5, 04.д. Энерги, хувирдаг, дамждаг болохыг ойлгох, туршилтын үр дүнд үндэслэн дүгнэлт гаргах | | □ | ТХ307.НСХ1. | ТХ307.Сэ03. | Энерги нэгээс нөгөөд хувирдаг, дамждагийг судлах явцдаа сурагч эрчим хүчний өөрийн хэрэгцээг хангах, үр ашигтай байхын хэрэгцээ шаардлагыг ойлгох /орчин үеийн хэмнэлттэй чийдэн/, бусдад эрчим хүчний үр өгөөж, бүтээмж, үр ашигтай зарцуулалтын талаар мэдээлэх, танилцуулах | □ | | | | Сурагч аймаг орон нутгийнхаа эрчим хүчний үйлдвэрлэл, н у у р с н и й хэрэглээний талаар судалж танилцуулах, зохистой хэрэглэх, үр ашгийг нэмэгдүүлэх талаар ярилцах | 2 | Сурагчид цаашид цахилгаан эрчим хүчийг өдөр тутмын амьдралдаа зохистой хэрэглэхийг эрмэлзэх санал санаачилга гаргаж хэлэлцэх тул урьдчилан тооцоолох цогц чадамжид харгалзана гэж үзсэн. |

## 2.4. Б. НЭГЖ ХИЧЭЭЛ: АМЬД БИЕИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ, ИДЭШ ТЭЖЭЭЛИЙН ХЭЛХЭЭ

### Нэгж хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр

IV ангийн хүн ба байгалийн “Амьд бие амьдралын орчин” сэдвийн 3 суралцахуйн зорилт нь бүгд ТХЗБ-ын суралцахуйн зорилттой интеграц болох онцлогтой байна. Сургалтын цөм хөтөлбөрт тусгасан энэ нэгж хичээлийн 3 зорилтын 2 дугаар суралцахуйн зорилт /4, 02.б. Амьтан ургамлын харилцан хамаарал, идэш тэжээлийн хэлхээг зурж тайлбарлах/ нь “ТХ315 Газар дээрх амьдрал” гэсэн зорилгод хамаарах танин мэдэхүйн суралцахуйн зорилт, Сэ01-ийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахаар байна

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ ТХЗБ-ын сэдэв → | ТХ315.Сэ01. Экологи: Амьдралын төлөөх тэмцэл, араатан-идэш (predators & prey), бүлгэмдлийн динамик, хоол тэжээлийн хэлхээгээр энергийн урсгал, тархалт ба хүрээ. Онцлог шинжтэй экосистемүүд-тухайн газар нутгийн болон дэлхийн хэмжээн дэх унаган экосистемүүд болон таримал ой зэрэг хүний гараар бүтээгдсэн экосистемүүд |
| ТХ315.ТМ1. Сурагч орон нутгийнхаа болон дэлхийн экосистемтэй холбоотой үндсэн экологийг ойлгож, орон нутгийн амьтдын төрөл зүйлийг тодорхойлох, биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хэмжихийн чухлыг ойлгодог болох | **4. Амьд бие, амьдралын орчин**<br>4, 02.б. Амьтан ургамлын харилцан хамаарал, идэш тэжээлийн хэлхээг зурж тайлбарлах<br>↑ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |

IV ангийн хүн ба байгалийн сургалтын цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид амьтан ургамлын идэш тэжээлийн хэлхээг судлах явцдаа тэдгээрийн хоорондын харилцан хамаарлыг ойлгох юм. Ингэхдээ өөрийн орон нутгийн амьтан ургамлын жишээн дээр судлах бүрэн боломжтой тул энэ утгаараа ТХ315-ын танин мэдэхүйн 1 дүгээр зорилттой уялдаж байна. Сурагчид идэш тэжээлийн хэлхээ нь нарны энергийг ашиглан хооллодог ногоон ургамлаар /бүтээгч/ эхэлдэг гэдгийг судалсан өмнөх туршлагад тулгуурлан шинэ мэдлэг бүтээнэ.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ТХ315.ТМ1. | ТХ315.Сэ01. | Амьд бие амьдралын орчин сэдвийг судлах явцдаа сурагчид тухайн амьдралын орчинд зохицон амьдарч буй амьд биес өөр хоорондоо идэш тэжээлээрээ холбогддог тухай судлах замаар идэш тэжээлийн хэлхээ нь нарны энергийг ашиглан хооллодог ногоон ургамлаар /бүтээгч/ эхэлдэг болохыг ойлгох тул ТХЗБ-ын энэ суралцахуйн зорилттой холбогдох чухал тал болно. |

Цөм хөтөлбөрийн сонгож авсан суралцахуйн зорилт нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт*(15)* "Газар дээрх амьдрал"-ийн (1) танин мэдэхүйн зорилт (*ТХЗ15 ТМ1),*сэдэв (*ТХЗ15.Сэ01)*-тэй агуулга, арга зүйн хувьд холбогдож байна.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх ТХБ-ын арга зүйн сонголт, хувь нэмэр оруулах боломжтой ТБ-ын цогц чадамжийг тодорхойлсон үндэслэл (матриц 2-ын 8, 10 дугаар баганыг харна уу)*

| Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар | Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар |
|---|---|
| 8 | 10 |
| Амьдралын орчиндоо амьтан ургамал өөр хоорондоо нарийн холбоотой болохыг олж мэдэх, жишээ дурдах. Идэш тэжээлийн хэлхээг харуулсан зураг схемийг ойлгож унших, идэш тэжээлийн хэлхээ юугаар эхэлдэг болохыг ярилцаж, өөрсдийн таамаглалыг видео бичлэгтэй \хоол тэжээлийн хэлхээ нь нарны энерги ашиглан хооллодог бүтээгч буюу ногоон ургамлаар эхэлдэг болохыг\ харьцуулах. Бүтээгч, хэрэглэгч, задлагч, махан идэштэн, өвсөн идэштэн зэрэг нэр томьёог ойлгох, зурж тайлбарлах тул бодит хамтын үйл ажиллагаанд оролцох аргыг сонгосон. | Сурагчид энэхүү сэдвийг судалснаар амьд биес өөрийн амьдрах орчиндоо хэрхэн нарийн уялдаж, харилцан хамааралтай байдгийг танин мэдэх учир тогтолцоот сэтгэлгээний цогц чадамжид хамааралтай гэж үзсэн. Өөрөөр хэлбэл бүтээгч, хэрэглэгч, задлагч гэсэн нийлмэл системийн хүрээнд асуудлыг авч үзэх тул. |

"Амьд бие амьдралын орчин" сэдвийн 4, 02.б. "Амьтан ургамлын харилцан хамаарал, идэш тэжээлийн хэлхээг зурж тайлбарлах"суралцахуйн зорилтыг бодит хамтын үйл ажиллагаанд оролцох аргаар хэрэгжүүлж сурагчдын тогтолцоот сэтгэлгээний цогц чадамжийн хөгжилд хувь нэмэр оруулах бүрэн боломжтой гэж үзсэн.

## Нэгж хичээлийн төлөвлөлт

***Зорилго:*** Амьд биеийн идэш тэжээлийн хэлхээн дэх бүтээгч, хэрэглэгч, задлагч гэсэн нийлмэл системийн хүрээнд асуудлыг авч үзэх тогтолцоот сэтгэлгээний цогц чадамжийн хөгжилд хувь нэмэр оруулах

***Зорилт:*** Амьд биеийн идэш тэжээлийн хэлхээг судлах, тэдгээрийн харилцан хамаарлыг таньж мэдэх, ойлгох

***Агуулга:*** Сурагчид амьд биесийн идэш тэжээлийг судалснаар ургамал, амьтдын хоорондын холбоо хамаарлыг ойлгох идэш тэжээлийн хэлхээн дэх бүтээгч, хэрэглэгч /өвсөн идэштэн, махан идэштэн/, задлагчийг таних, ялган тодорхойлно.

Идэш тэжээлийн хэлхээний аль нэг амьд биеийн тоо толгойн өөрчлөлт нь бусад зүйлийн амьд биест хэрхэн нөлөөлдгийг ойлгох. Үүгээр дамжуулан орон нутгийнхаа болон дэлхийн экосистемтэй холбоотой суурь ойлголтыг эзэмшинэ.

***Арга зүй:*** Энэхүү хичээлээр ангид туршилт хийх боломж бага байдаг тул сурагчдад зурган карт, бичлэг үзэх, хэлэлцүүлэг хийх арга зүйг төлөвлөх нь тохиромжтой.

### ИДЭШ ТЭЖЭЭЛИЙН ХЭЛХЭЭ

| Бүтээгч | Хэрэглэгч | Задлагч |
|---|---|---|
| НОГООН УРГАМАЛ<br>Ногоон ургамал нарны гэрлийн оролцоотойгоор ус, нүүрс хүчлийн хий хоёроос шим бодис нийлэгжүүлдэг. Тийм учраас ногоон ургамлыг бүтээгчид буюу продуцент гэдэг. | ӨВСӨН ИДЭШТЭН ДООД, ДЭЭД ЭРЭМБИЙН МАХЧИН<br>Ногоон ургамлын бий болгосон шим бодисоор хооллодог организмуудыг хэрэглэгчид буюу консумент гэнэ. Хэрэглэгчдийг дотор нь 1-р зэргийн хэрэглэгчид: өвсөн тэжээлтнүүд, 2-р зэргийн хэрэглэгчид: доод эрэмбийн махан идэштнүүд, 3-р зэргийн хэрэглэгчид: дээд эрэмбийн махан идэштнүүд гэж хуваана. | БАКТЕР<br>Шим бодисын үлдэгдэл, хаягдал, ургамлын үлдэгдэл амьтдын хүүр сэгийг бичил биетнүүд задалж, эрдэс бодис, энгийн нэгдэл болгоно. Тэдгээрийг задлагчид буюу редуцент гэнэ. Үүнд нян зарим сапрофит мөөг, бичил организмууд орно. |

***<u>Хугацаа:</u>*** 2 цаг /Үйл ажиллагаа тус бүр нэг цаг үргэлжилнэ/

<u>Үйл ажиллагаа 1.</u> Тухайн амьдралын орчиндоо амьд биес зохицон, өөр хоорондоо нарийн уялдаа холбоотой амьдардгийг ойлгох

1.1. Бүх сурагчдыг тойруулж зогсоогоод сурагч бүрд өнгийн тэмдэглэгээ бүхий нэг нэг амьд биеийн зураг өгнө /ТӨМ-1/. Сурагчид тэрхүү зургийг духандаа наах юм уу энгэртээ зүүнэ. Ингэснээр сурагчид тухайн амьд бие боллоо гэж төсөөлөх хэрэгтэй.

<u>Анхаарах зүйл:</u>

Зурган карт дээрх өнгийг дараагийн алхамд багаар суухад ашиглана. Өөрөөр хэлбэл ижил өнгөтэй карт авсан сурагчид нэг багт сууна. Нэг өнгийн картуудад бүтээгч, хэрэглэгч буюу өвсөн тэжээлтэн, махан идэштэн, задлагчид бүгд байхаар тооцох хэрэгтэй.

1.2. Амьд бие бүр өөрийнхөө юугаар хооллодог тухай бодох даалгавар өгнө.

1.3. Багш ямар нэг ургамлын нэрийг дуудаж ангийн голд зогсооно. Дараа нь тэрхүү ургамлаар хооллодог амьд биесийг гарч ирэхийг хүснэ. Гарч ирсэн амьд биес тухайн ургамал болсон сурагчид гараа хүргэнэ гэх мэт бүх амьд бие өөрийн иддэг амьд биедээ гараа хүргэсэн байна.

1.4. Гарсан үр дүнд үндэслэн сурагчид амьд биес идэш тэжээлээрээ хэрхэн холбогддогийг тайлбарлана.

1.5. Хичээлийн сэдвийг багш самбарт бичиж сурагчдыг багаараа суухыг хүснэ.

1.6. Баг бүрд нэг нэг амьдралын орчны нэр өгнө /ус, хуурай газар, ой, говь цөл/. Тухайн орчинд амьдардаг амьд биесийн идэш тэжээлээрээ холбогдож буй нэг жишээг зурах даалгавар өгнө. Эсвэл тухайн амьд биесийн нэр, зураг бүхий аягыг багуудад өгч дээрх даалгаврын дагуу аягыг дээр дээрээс нь хөмөрч тавьж болно.




1.7. Идэш тэжээлийн хэлхээн дэх амьд биеийн аль нэг нь үгүй бол тэрхүү хэлхээнд ямар өөрчлөлт болох вэ? Амьд бие тус бүрд ярилцаж үр дагаврыг бичих даалгавар өгнө.

*Сурагчдын дэвтэрт доорх хүснэгтийг зуруулж бичүүлээрэй.*

| Амьд биес /Хэлхээний дараалаар нэрийг бичүүлнэ/ | Тухайн амьд бие байхгүй бол энэ идэш тэжээлийн хэлхээнд ямар өөрчлөлт болох вэ? | Яагаад ийм өөрчлөлт болно гэж үзсэнээ бичээрэй. |
|---|---|---|
| Шар шувуу | | |
| Могой | | |
| Хулгана | | |
| Царцаа | | |
| Ургамал | | |

1.8. Амьтан, ургамал өөр хоорондоо нарийн холбоотой болохыг багууд хийсэн ажлынхаа үр дүнд үндэслэн тайлбарлана.

Үйл ажиллагаа 2. Идэш тэжээлийн хэлхээ нь нарны энерги ашиглан хооллодог бүтээгч буюу ногоон ургамлаар эхэлдэг болохыг мэдэх

1.1. Идэш тэжээлийн хэлхээнд бүх амьд бие ач холбогдолтой байна. Гэхдээ ургамал байхгүй бол яах вэ? Ургамал юугаар хооллодог вэ?



Энэ алхмын үр дүнд сурагчид ногоон ургамал нь идэш тэжээлийн хэлхээг бүтээдэг гэдгийг ойлгоход багш анхаарлаа хандуулаарай.

Мөн ногоон ургамлын хооллолтын тухай, нарны гэрэл түүнд ямар үүрэгтэйг сурах бичгийн зураг ашиглан тайлбарлана.

1.2. Сурах бичгийн 72 дугаар хуудасны нэмэлт мэдээллийг сурагчдад уншуулах. Уншсан мэдээлэлдээ үндэслэж тухайн орчны амьд биесийн идэш тэжээлийн хэлхээн дэх бүтээгч, хэрэглэгч буюу өвсөн тэжээлтэн, махан идэштэн, задлагчдыг ялгуулна.

1.3. Хэд хэдэн идэш тэжээлийн хэлхээ харуулсан зурган схем өгч сурагч бүрийг ажиллуулах даалгавар өгөх.

*<u>Даалгавар:</u>*

Схем зургийг ажиглаад тухайн идэш тэжээлийн хэлхээн дэх бүтээгч, хэрэглэгч, задлагчдыг ялгаж нэрийг бичээрэй. Бичсэний дараа хүснэгт дэх 2-р даалгавар буюу асуултад хариулна. Зарим багуудын зурагт задлагч байхгүй байж ч болно. Сурагчид задлагч байхгүй байна гэдгийг өөрсдөө илрүүлэх хэрэгтэй. Даалгавар гүйцэтгэхийн өмнө багшийн номны 61-р хуудасны хичээлийн бэлтгэл хэсэгт зөвлөмжилсөн линкээр орж махчин ба золиос бичлэгийг үзүүлж болох юм.

<u>Зургийн хувилбар-</u>1:



<u>Зургийн хувилбар-</u>2:



<u>Зургийн хувилбар-</u>3:



*Сурагчдын дэвтэрт доорх хүснэгтийг зуруулж нэрийг бичүүлнэ.*

| ***Даалгавар-1.*** *Дээрх идэш тэжээлийн хэлхээн дэх бүтээгч, хэрэглэгч, задлагчдын нэрийг харгалзах хэсэг ялган бичнэ үү.* | | |
|---|---|---|
| Бүтээгч амьд бие | Хэрэглэгч амьд бие | Задлагч амьд бие |
| | | |
| ***Даалгавар-2.*** *Дээрх бүтээгч, хэрэглэгч, задлагчдын идэш тэжээлийн хэлхээндээ гүйцэтгэх үүргийг бичнэ үү. Хэрэв дээрх 3-ын аль нэгнийх нь тоо толгойд өөрчлөлт орвол ямар асуудал үүсэх вэ? Яагаад?* | | |
| *Гүйцэтгэх үүрэг:*<br><br>*Бүтээгч байхгүй бол:* | *Гүйцэтгэх үүрэг:*<br><br>*Хэрэглэгч байхгүй бол:* | *Гүйцэтгэх үүрэг:*<br><br>*Задлагч байхгүй бол:* |

Хэрэглэгч амьд биесээс өвсөн идэштэн амьтдын нэрний доогуур ногоон, махан идэштэн амьтдын нэрний доогуур улаан өнгийн харандаагаар зурах даалгавар өгөөрэй.

1.4. Даалгаврын тухай ангиараа зураг тус бүр дээр ярилцана.

1.5. Гэрийн даалгавар: Сурах бичгийн 72 дугаар хуудасны Махчин ба золиос гэж юу вэ? Зураг болон графикийг ажиглан асуулт 1, 2-ын хариултыг дэвтэртээ бичих. /Энэхүү даалгавар нь дараагийн хичээлийн үндсэн ойлголт болохыг анхаараарай/

***Үнэлгээ:***

Хичээлийн явцад сурагчдын хийсэн даалгаврын явц, гүйцэтгэлээр үнэлгээ хийж болно. Мөн хичээлийн дараа асуулт, хариултаар ч үнэлгээ өгөх боломжтой.

| Хичээлийн үйл ажиллагаа | | Юуг үнэлэх | Яаж үнэлэх |
|---|---|---|---|
| 1 | 1.7 | Идэш тэжээлийн хэлхээгээр дамжуулан экосистемийн ургамал, амьтдын **харилцах холбоог** ойлгосон эсэх буюу амьд бие бүхэн тухайн идэш тэжээлийн хэлхээнд чухал ач холбогдолтой буюу тэрхүү амьд **биеэс хамааралтай** бүх амьд биетүүдэд нөлөөлдөг гэж үзсэн эсэхийг | Асуултын **хариулт** болон **багуудын тайлбараас** илрүүлнэ. |
| 2 | 2.3 | Даалгавар-1. Идэш тэжээлийн хэлхээн дэх бүтээгч, хэрэглэгч, задлагчдыг **ялган таньсан** эсэхийг | Даалгавар 1-ийн **бичвэрийг уншиж** илрүүлнэ. |
| | | Даалгавар-2.<br>Идэш тэжээлийн хэлхээн дэх бүтээгч, хэрэглэгч, задлагч гэсэн **нийлмэл системийн хүрээнд** асуудлыг авч үзэж байгаа эсэхийг | Даалгавар 2-ын **бичвэрийг уншиж** илрүүлнэ. |

<u>Үнэлгээний тайлбар:</u>

1.7 дугаар үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээгээр ТХЗБ-ын 15-р суралцахуйн зорилтыг илрүүлэх боломжтой гэж үзсэн.

2.3 дугаар үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээгээр сурагчдын нийлмэл системийн хүрээнд асуудлыг авч үзэж байгаа эсэх буюу тогтолцоот сэтгэлгээний цогц чадамжийг үнэлэх боломжтой гэж үзлээ.

***<u>Хэрэглэгдэхүүн:</u>***

ТӨМ-1.

| | | |
|---|---|---|
|  |  |  |
|  |  |  |
|  |  |  |
|  |  |  |
|  |  |  |
|  | |  |
|  |  |  |

# 2.5. ХҮН БА ОРЧИН

## 2.5. А. БАГА БОЛОВСРОЛЫН ХҮН БА ОРЧИН ХИЧЭЭЛИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт хүн ба орчин хичээлийг судлах хэрэгцээг

- Ойр орчныхоо хүмүүс, байгаль, нийгэмтэй харилцах явцад өөрийгөө нээн таних
- Сурах арга барил эзэмших
- Эрүүл аж төрөх энгийн дадал хэвшилд суралцах

гэж тодорхойлсон байгаа нь цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын танин мэдэхүй, нийгэм сэтгэл хөдлөл, зан үйлийн айд хамаарах суралцахуйн зорилт, санал болгож байгаа сэдэвтэй уялдуулан хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх бүрэн боломжтой байна.

Бага боловсролын “хүн ба орчин”-ы сургалтын цөм хөтөлбөрт тусгасан суралцахуйн зорилтууд нь хүүхэд бүр эрүүл мэндээ хамгаалах мэдлэг, чадвар эзэмших, эрүүл амьдралын зөв дадал хэвшилтэй болох, харилцааны ур чадвар эзэмших, бусадтай хамтран ажиллах, бусдыг ялгаварлан гадуурхахгүй байх, тогтвортой хэрэглээг эрхэмлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, оролцоотой байхад суралцах зэргийг тодорхойлсон байгаа нь ТХЗБ-ын суралцахуйн зорилттой уялдаж, ТХБ-д хувь нэмэр оруулахаар боловсруулагдсан болохыг харуулж байна.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын “Хүн ба орчин”-ы цөм хөтөлбөрт шинжилгээ хийхэд ТХБ-д хувь нэмэр оруулах өөрөөр хэлбэл ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах нийт 45 суралцахуйн зорилт тодорхойлогдсон байна.

*ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвт хамаарах “Хүн ба орчин”-ы цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын тоо*

| Ай | Танин мэдэхүй | Нийгэмшил, сэтгэл хөдлөл | Зан төлөв |
|---|---|---|---|
| Суралцахуйн зорилтын тоо | 18 | 20 | 7 |

Бага боловсролын “Хүн ба орчин”-ы цөм хөтөлбөрт тусгасан эдгээр 45 суралцахуйн зорилтуудыг анги тус бүрээр авч үзвэл I ангид танин мэдэхүйн түвшний, II ба III ангид нийгэмшил-сэтгэл хөдлөлийн айд харгалзах суралцахуйн зорилт буюу агуулга түлхүү тусгагдсан байна.

ТХЗБ-ын (3) “эрүүл мэнд ба сайн сайхан байдал”; (5) “жендэрийн тэгш байдал”; (10) “тэгш бус байдлыг багасгах”; (11) “тогтвортой хот суурин, оршин суугчид”; (12) “хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл”; (13) “уур амьсгалын төлөөх үйл хэрэг”; (15) “газар дээрх амьдрал” гэсэн сэдвүүдийг бага боловсролын “хүн ба орчин”-ы агуулгатай интеграцчилах боломжтой байна.

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын “Хүн ба орчин”-ы цөм хөтөлбөр нь байгаль ба нийгмийн ухааны хичээлийн суурь мэдлэг ойлголт, чадварыг эзэмшүүлэх, зөв хандлага төлөвшүүлэх зарчимд үндэслэн боловсруулагдсан тул суралцахуйн зорилт нь шинжлэн судлах арга барилыг эзэмшүүлэхэд чиглэсэн байдаг. Энэ нь ТХЗБ-ын санал болгосон үндсэн 4 аргазүйг хэрэгжүүлэхэд хялбар болж байна.

*Аргазүйн төрлийг сонгосон байдал (давхардсан тоогоор)*

| Санал болгож буй сургалтын арга зүй | Бодит хамтын үйл ажиллагаанд оролцох аргууд | Шинжилгээ судалгаа хийх аргууд | Бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд | Алсын хараатай болох аргууд |
|---|---|---|---|---|
| Суралцахуйн зорилтын тоо | 14 | 31 | 9 | 12 |

Цөм хөтөлбөрт тусгасан суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх арга зүйг сонгохдоо сурагч нэг бүрийн хэрэгцээ, онцлог; эзэмшүүлэх агуулга; сурах арга барил; хүрэх үр дүнд үндэслэн

- сурагчдын нас сэтгэхүйн ялгаатай байдал;
- суралцахуйн зорилт, тогтвортой хөгжлийн зорилт ба сэдвийн хамаарал;
- сурагч өөрийн туршлагад тулгуурлан мэдлэг бүтээх буюу тэдний гүйцэтгэх үйл;
- тогтвортой байдлын цогц чадамжтай иргэн болон төлөвшихөд оруулах хувь нэмэр зэргийг харгалзсан болно.

Сургалтын арга бүр өөр өөрийн онцлогтой тул хослон хэрэглэснээр бүтээлч болж, сурагчдыг идэвхжүүлэн оролцоог дээшлүүлдэг ч, багш суралцахуйн онолд суурилсан харилцан хамааралтай цогц үйл ажиллагааг төлөвлөхөд анхаарах хэрэгтэй. Тухайлбал:

Шинжилгээ судалгаа хийх арга зүйг дэглэхдээ дараах 4 үе шат бүхий үйлийг төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнд:

- Баримт нотолгоо цуглуулах: Асуулт асуух, ажиглах, урьдчилан таамаглах, боломжуудыг олж харах, мэдээлэл цуглуулах
- Судлах ажлыг төлөвлөх: Заавар, дэглэм баримтлах, багаж хэрэгслийг зөв ашиглах, таамаглалаа шалгах, хэрхэн судлахаа төлөвлөх
- Баримт нотолгоог гаргах, илэрхийлж танилцуулах: Хийж гүйцэтгэх, туршилт хийх, хэмжих, харьцуулах, ангилах, тэмдэглэх, үр дүнг гаргаж танилцуулах
- Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах: Үр дүнг таамаглалтай харьцуулах, дүгнэх, задлан шинжлэх, үнэлэх, батлах, сайжруулах санал гаргах, тайлбарлах зэрэг болно.

Бага боловсролын “Хүн ба орчин”-ы цөм хөтөлбөрт тусгасан суралцахуйн зорилтуудыг ТХБ-той холбож интеграцчилах арга зүйг хэрэгжүүлснээр тогтвортой байдлын цогц чадамжид хувь нэмэр оруулах боломж давхардсан тоогоор 78 тодорхойлогдсон байгаа нь энэ хичээл тогтвортой хөгжлийн цогц чадамжтай иргэн болон төлөвшихөд нөлөөлж чадаж байна гэж үзэж болно.

*ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмэр (давхардсан тоогоор)*

| ТБ-ын цогц чадамж | Цогц чадамжийн төлөвшилд хувь нэмэр оруулах боломжтой суралцахуйн зорилтын тоо |
|---|---|
| 1. Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж | 12 |
| 2. Урьдчилан тооцоолох цогц чадамж | 11 |
| 3. Хэм хэмжээний цогц чадамж | 6 |
| 4. Стратегийн цогц чадамж | 7 |
| 5. Хамтран ажиллах цогц чадамж | 14 |
| 6. Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж | 10 |
| 7. Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж | 4 |
| 8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамж | 14 |

Бага боловсролын “Хүн ба орчин”-ы сургалтын агуулга, арга зүй нь байгаль, нийгмийн юмс үзэгдлийн харилцан хамаарлыг танин мэдэх ойлгох, нэгдмэл тогтолцоо болохыг сэтгэн бодохын тулд бусадтай харилцах, тэдний үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож, хүндэтгэх, хамтран ажиллах, тэднээс суралцах, хамтын хүчээр оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх, хэрэглэх чадварыг эзэмшихэд оршдог тул тогтолцоот сэтгэлгээний болон урьдчилан тооцоолох, хамтран ажиллах, асуудал шийдвэрлэхцогц чадамжийг дэмжиж байна.

*Хүснэгт 2.16.* ***Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хүн ба орчин)***

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | | | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/өнгөрснийг нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар / суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| 1 | 2 | 3 | | | 4 | 5 | 6 | 7 | | | | 8 | 9 | 10 |
| 1. Миний тоглоом | 1, 01.б. Тоглоом тоглох ба эрүүл ахуйн дэглэм сахих | ☐ | | | ТХ303.НСХ3 | ТХ303.Сэ4 | Сурагч эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжин, тоглоом тоглох үеийн эрүүл ахуйн дэглэм баримтлан эрүүл мэнд, сайн сайхан байдлын тухай цогц ойлголттой болохтой холбоотой. | ☐ | | | ☐ | 1- Тоглоом тоглох үеийн дэгийг дагаж мөрдөх оролцооны арга зүйг дэглэнэ<br>4- Тоглоом тоглосны дараа гараа угааж сурахад чиглэсэн оролцооны арга зүйг дэглэнэ. | 5,8 | 5- Хүлээцтэй, тэвчээртэй чадварыг хөгжүүлнэ.<br>8- Тоглоом тоглосны дараа гараа угаах зөв зан үйл төлөвших асуудал шийдвэрлэх чадварт суралцана. |
| 2. Миний тоглоом | 1, 02.в. Эцэг эх, ахмад хүмүүс, багш, найз нөхөдтэйгөө мэндэлж сурах | ☐ | | | ТХ305.ЗТ1 | ТХ305.Сэ2 | Сурагч уламжлалт үүрэг оролцоог ухамсарлан,жендэрийн эрх тэгш байдалд үнэлгээ өгч эцэг эх, ахмад хүмүүс, багш, найз нөхөдтэйгөө мэндэлж сурахтай холбоотой. | ☐ | | | | Мэндлэх, хүндлэх ёс зүйд сургах оролцооны арга зүйг дэглэнэ. Видео хичээл зохион байгуулна. | 2 | Ойлгох, өөрийн үзэл бодлыг бий болгох чадварт суралцана. |
| 3. Миний хичээлийн хэрэглэл | 1, 03.а. Хичээлийн хэрэглэлээ ялган таних, үүрэг зориулалтаар нь хэрэглэх, хадгалах талаар бусдад ярих | ☐ | | | ТХ312.НСХ1. | ТХ312.Сэ8 | Тогтвортой амьдралын хэв маяг ба хэрэглээн дэх тогтвортой практик туршлагад үндэслэн хичээлийн хэрэглэлээ үүрэг зориулалтаар нь хэрэглэх, хадгалах тухайгаа бусдад танилцуулахтай холбоотой. | | ☐ | | | Ялган таних, хэрэглээ зориулалтаар нь ангилах, үр дүнгээс дүгнэлт гаргах, хэрэглэх санал хэлэх шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө. | 4,5,8 | 4, 5- Харилцах, хамтран суралцах<br>8-Асуудал шийдвэрлэх цогц чадамж: Өөрт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадварт суралцана. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4. Миний бие | 1, 04.г. Хичээл, амралтаа зөв зохицуулах, өдрийн дэглэм баримтлах | ☐ | | | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ03. | Сурагч эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болохын тулд биеийн тамирын дасгал хийх, гэрийнхнийхээ тусламжтайгаар өдрийн дэглэмийн хуваарь хийж мөрдөхтэй холбоотой. | ☐ | | | ☐ | 4- Өдрийн дэглэмийн хуваарь хийх талаар бодох асуудал шийдвэрлэх арга зүйг төлөвлөнө. 1- Гэрийнхнийхээ тусламжтайгаар өдрийн дэглэмийн хуваарь хийж (дасгал хөдөлгөөн хийх), түүнийг мөрдөж, хэрэгжүүлэх зэрэг оролцооны арга зүйг төлөвлөж хэрэгжүүлнэ. | 2, 7 | 2- Урьдчилан сэргийлэх, эрсдэл, өөрчлөлтийг шийдвэрлэх чадварт суралцана. 7- Өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох, хүсэл зорилгодоо хүрэх төлөвлөлт хийхэд суралцана. |
| 5. Манай гэрийнхэн | 1, 05.а. Гэр бүлийнхнээ танилцуулах, утасны дугаарыг мэдэх, шаардлагатай үед бусадтай холбоо барих | ☐ | | | ТХ311.ТМ1 | ТХ311.Сэ1 | Сурагч хүний биет болон сэтгэлзүйн, нийгмийн үндсэн хэрэгцээ шаардлагыг ойлгож, аюулгүй байдлыг хангах үүднээс гэр бүлийнхнийхээ утасны дугаарыг мэдэхтэй холбоотой. | ☐ | | | | Сурагч аюулгүй байдлыг хангах үүднээс гэр бүлийн гишүүдийнхээ утасны дугаарыг мэдэх, шаардлагатай үед бусдад мэдээлэх оролцооны арга зүйг дэглэнэ. | 7 | Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж: Ойлгох, өөрийн аюулгүй байдлыг эрхэмлэх чадварт суралцана. |
| 5. Манай гэрийнхэн | 1, 05.б. Гэр байраа цэвэр байлгахад юу хийж чадахаа тайлбарлах, гэр бүлийн гишүүддээ туслах | ☐ | | | ТХ311.ТМ2 | ТХ311.Сэ1 | Өөрийн болон бусад суурьшлын тогтвортой байдлыг үнэлж, орон сууцны хэрэгцээ, шаардлага, аюулгүй байдал, тусгай хэрэгцээг хангах үүднээс гэр байраа цэвэр байлгах, гэр бүлийн гишүүддээ туслахтай холбоотой. | ☐ | | | ☐ | 4- Сурагч аюулгүй байдлыг хангах үүднээс гэр байраа цэвэр байлгахад юу хийж чадахаа төлөвлөх арга зүйг дэглэнэ. 1- Үйл ажиллагаанд оролцох санаачилга гаргах арга зүйг дэглэнэ. | 8 | Асуудал шийдвэрлэх цогц чадамж: Өөрт тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, тогтвортой хэрэгжүүлэх асуудлыг эрхэмлэх чадварт суралцана. |
| 6. Миний гэр орон | 1, 06.а. Орчин тойрны зүйлстэй харьцуулж гэр байраа хаана оршдогийг мэдэх | ☐ | | | ТХ311.ТМ1 | ТХ311.Сэ10 | Сурагч хүний биет болон сэтгэлзүйн, нийгмийн үндсэн хэрэгцээ шаардлагыг ойлгож, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үүднээс орчин тойрны зүйлстэй харьцуулж гэр байраа хаана оршдогийг мэдэхтэй холбоотой. | | ☐ | | | Сурагч аюулгүй байдлыг эрхэмлэх үүднээс зүг чигийн тухай ойлголттой болж, гэр байраа хаана оршдогийг тодорхойлох шинжлэн судлах арга зүйг дэглэнэ. | 2 | Урьдчилан тооцоолох цогц чадамж: Эрсдэлийг шийдвэрлэх чадварт суралцана. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6. Миний гэр орон | 1, 06.б. Гэр, байрны орчин тойронд юу ханаа байдгийг нэрлэх, таних, гэр ахуйн цахилгаан хэрэгсэлтэй болгоомжтой харьцах | ☐ | | | ТХ311.ТМ2 | ТХ311.Сэ10 | Өөрийн болон бусад суурьшлын тогтвортой байдлын тогтолцоонд үнэлгээ хийж, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үүднээс гэр, байрны орчин тойронд юу ханаа байдгийг нэрлэх, таних, гэр ахуйн цахилгаан хэрэгсэлтэй болгоомжтой харьцахтай холбоотой. | | ☐ | | | Аюулгүй байдлыг эрхэмлэх үүднээс гэр байрны хаана юу байдгийг мэдэх, цахилгаан хэрэгслийг зөв, зохистой хэрэглэх шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө. | 2, 7 | 7- Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж: Ойлгох, өөрийн аюулгүй байдлыг эрхэмлэх чадварт суралцана. 2- Урьдчилан тооцоолох цогц чадамж: Эрсдэлийг шийдвэрлэх чадварт суралцана. |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 1, 07.а. Сургууль орчмын дуу чимээг судлах | ☐ | | | ТХ311.ТМ1 | ТХ311.Сэ5 | Сурагч нийгмийн суурь хэрэгцээг ойлгож, суурин газрын экологи хүний суурьшилд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх үүднээс сургууль орчмын дуу чимээг судлахтай холбоотой. | | ☐ | | | Сурагчийн аюулгүй байдлыг эрхэмлэх үүднээс сургууль орчмын дуу чимээг судлах арга зүйг дэглэнэ. | 3, 6 | 3- Учир шалтгаан, хэм хэмжээг ойлгох 6- Учир шалтгаанд үндэслэн тогтвортой байдлыг дэмжсэн асуудал дэвшүүлэх чадварт суралцана. |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 1, 07.б. Анги, хамт олон, сургуулийн орчинд дасан зохицох, сургуулийнхаа дэг журмын талаар мэдлэгтэй болох | ☐ | | | ТХ311.НСХ3. | ТХ311.Сэ05. | Сурагч амьдралын хэв маягийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөлд хүлээх хариуцлагаа мэдэрч, сургуулийнхаа дэг журмын талаар мэдлэгтэй болж, өөрийн сургуулийн орчинд засан зохицохтой холбоотой. | ☐ | | | ☐ | 1- Сургуулийн орчин дахь асуудлыг олж харж шийдвэр гаргах, дэг журмыг даган мөрдөхөд оролцох оролцооны аргуудыг төлөвлөнө. 2- Дэг журмыг мөрдөх, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах арга зүйг дэглэнэ. | 2, 4, 5, 8 | 2- Боломжтой олон янзын үйл явдлыг ойлгож, үнэлэх чадвар 4- Хамтрах 5- Бусдаас суралцах 8- Асуудал шийдвэрлэх чадварт суралцана. |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 1, 07.в. Ангид ургаж байгаа ургамлын бүтцийн хэсгүүдийг зааж, нэрлэх, ялган таних | ☐ | | | ТХ313.НСХ5 | ТХ313.Сэ10 | Сурагч биологийн олон янз байдлын эко системд үзүүлэх нөлөөлөл болон дэлхийн уур амьсгалыг хамгаалах нь хүн бүрийн өдөр тутмын үндсэн үүрэг болохыг ухамсарлан ангид ургаж байгаа ургамлын бүтцийн хэсгүүдийг зааж, нэрлэх, ялган танихтай холбоотой. | | ☐ | ☐ | | 2- Ангид ургаж байгаа ургамлыг ажиглах, бүтцийн хэсгүүдийг ялгаатай байдлаар нь ангилах, үр дүнг танилцуулах гэх мэт шинжлэн судлах арга зүйг дэглэнэ. 3- Тасалгааны ургамлыг ажиглах дадлага ажил зохион байгуулна. | 5, 3 | 5- Дадлага ажил хийхэд бусдыг ойлгож хамтран ажиллах чадварт суралцана. 3-шинжлэх ухааны зөв үг хэллэг хэрэглэж сурна. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9. Орон нутаг ба байгаль | 1, 09.а. Орон нутагт түгээмэл тохиолдох ургамал, амьтныг нэрлэх, ялган таних | □ | | | ТХ313.ТМ3 | ТХ313.Сэ10 | Сурагч биологийн олон янз байдлын эко системд үзүүлэх нөлөөлөл болонорон нутгийн түвшинд хүний үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөө үзүүлдэг болохыг ойлгохын тулд орон нутагт түгээмэл тохиолдох ургамал, амьтныг нэрлэх, ялган танихтай холбоотой. | □ | □ | | | 1- Орон нутгийн ургамал, амьтдыг ажиглах дадлага ажил<br><br>2- Орон нутгийн зарим ургамал, амьтныг ялган таних туршилтын хичээлийн арга зүйг төлөвлөнө. | 4 | 4- стратегийн цогц чадамж: Орон нутгийн ургамал, амьтдыг хамгаалах хамт олны нэгдсэн үйл ажиллагаар хэрэгжүүлэх чадвар хөгжинө. |
| 9. Орон нутаг ба байгаль | 1, 09.б. Нутгийнхаа томоохон уул, ус, байгалийн болон түүхийн дурсгалт газрыг нэрлэх, танилцуулах | □ | | | ТХ311.ТМ2 | ТХ311.Сэ2 | Байгалийн нөөц баялгийн ашиглалт, ногоон орчинг бүрдүүлсэн байдал зэргийг үнэлэх,нутгийнхаа томоохон уул, ус, байгалийн болон түүхийн дурсгалт газрыг нэрлэх, танилцуулахтай холбоотой. | | | □ | □ | 3- Аялал экскурс зохион байгуулах<br>4- Түүх, домгийг судлах хичээлийн арга зүйг дэглэнэ. | 5, 6 | 5- Бусдаас суралцах, бусдыг хүндэтгэх чадварт суралцана.<br>6- Өөрийн үнэлэмж, үзэл бодлоо эргэцүүлэн бодох чадварт суралцана. |
| 10. Эх орон, эх дэлхий | 1, 10.б. Байгаль, нийгмийн юмс үзэгдэл өдөр шөнөөс хэрхэн хамаарч байдгийг ойлгож мэдэх | □ | | | ТХ313.ТМ5 | ТХ313.Сэ6 | Сурагч байгаль, нийгмийн юмс үзэгдэл өдөр шөнөөс хэрхэн хамаарч байдгийг мэдэж,өөр өөр нөхцөлд хэрэгжүүлж болохуйц гамшгийн эрсдлийг бууруулахтай холбоотой стратегийг ойлгон, урьдчилан сэргийлэхтэй холбоотой. | | □ | □ | | 2-Байгалийн үзэгдэл өдөр, шөнөөс хэрхэн хамаарч өөрчлөгддөгийг ажиглах, таамаглах, нотлох арга зүйг төлөвлөнө.<br>3- Хүмүүс өглөө, өдөр, орой юу хийдэг вэ? гэх мэт асуултаар нийгмийн үйл явц өдөр, шөнөөс хэрхэн хамаардгийг нотлох, бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх хэлэлцүүлэг хийх арга зүйг дэглэнэ. | 6 | Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж: Тогтсон хэм хэмжээ, дадал туршлага, санаа бодолд асуудал дэвшүүлэх чадварт суралцана. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10. Эх орон, эх дэлхий | 1, 10.г. Байгалийн үзэгдэл улирлаас хамаардгийг ажиглаж, ялгах | ☐ | | | ТХ313.ЗТ1 | ТХ313.Сэ03. | Цаг агаарын онцгой үзэгдэлээс урьдчилан сэргийлэх, дасан зохицох стратегиудыг мэддэг болохын тулд байгалийн үзэгдэл улирлаас хамаардгийг ажиглаж, ялган тайлбарлахтай холбоотой. | | ☐ | ☐ | | 2- Байгалийн үзэгдэл улирлаас хамаардгийг ажиглах, таамаглах, турших, нотлох шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө.<br>3- Намар өвс ургамал шарладаг, яагаад? гэх мэт асуулт асууж бүтээлч сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, аялал экскурс хийх арга зүйг төлөвлөнө. | 1, 6 | 1- Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж: Аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох чадварт суралцана.<br>6- Тогтсон хэм хэмжээ, дадал туршлага, санаа бодолд асуудал дэвшүүлэх чадварт суралцана. |
| 1. Миний тоглоом | 2, 01.б. Уламжлалт болон орчин үеийн тоглоомоос сонгож тоглох, эрүүл ахуйн дэглэм сахих | | ☐ | | ТХ303.НСХ4. | ТХ303.Сэ03. | Амьдралын олон талт цогц ойлголт, үнэ цэн итгэл үнэмшил, хандлагын талаар ойлголттой болж, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжин,тоглох үеийн эрүүл ахуйн дэглэм сахихтай холбоотой. | ☐ | | | ☐ | 1- Тоглоом тоглох үеийн дэгийг дагаж мөрдөх оролцооны арга зүйг дэглэнэ<br>4- Тоглоом бүр өөр өөр боловч, бүгд тогтсон дүрэм журамтай болохыг судалж мэдэх эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, асуудал шийдвэрлэх арга зүйг дэглэнэ. | 5, 8 | 5- Хүлээцтэй, тэвчээртэй чадварыг хөгжүүлнэ.<br>8- Бусдын зан үйл, хандлагыг хүлээн зөвшөөрөх, эрүүл зан үйлийг эрхэмлэх асуудал шийдвэрлэх чадварт суралцана. |
| 1. Миний тоглоом | 2, 01.в. Тоглоом тоглох үеийн дэгийг дагаж мөрдөх, хожиж хожигдож сурах, тэвчээртэй, хүлээцтэй хандах, тоглоом бүтээх | | ☐ | | ТХ303.ЗТ1 | ТХ303.Сэ4 | Сурагч эрүүл мэнд болон сайн сайхан амьдралыг дэмжих үүднээс тоглоом тоглох үеийн дэгийг дагаж мөрдөх, хожиж хожигдож сурах, тэвчээртэй, хүлээцтэй хандах, тоглоом бүтээх зэргээр эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэхтэй холбоотой. | ☐ | | | ☐ | 1- Тоглоом тоглох үеийн дэгийг дагаж мөрдөх, төлөвлөх, хэрэгжүүлэх арга зүйг төлөвлөнө.<br>4-Тоглоом тоглох дүрэм боловсруулах, дүрмээ баримтлан тоглох арга зүйг дэглэнэ | 5, 8 | 5- Хожих хожигдож сурах, хүлээцтэй, тэвчээртэй хандах чадварыг хөгжүүлнэ.<br>8- Бусдын зан үйл, хандлагыг хүлээн зөвшөөрөх, эрүүл зан үйлийг эрхэмлэх асуудал шийдвэрлэх чадварт суралцана. |
| 2. Миний тоглоом | 2, 02.б. Найз нөхдөө хүндэтгэн харилцах | | ☐ | | ТХ305.ЗТ2 | ТХ305.Сэ2 | Сурагч жендэрийн ялгаварлан гадуурхлыг ажиглаж, найз нөхдөө хүндлэн ялгаварлан гадуурхахгүй харилцахтай холбоотой. | | | ☐ | | Бусдыг сонсож, ялгаварлан гадуурхахгүй байх дүрд хувилан тоглох арга зүйг төлөвлөнө. | 2 | Ойлгох, өөрийн үзэл бодлыг бий болгох чадварт суралцана. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. Миний хичээлийн хэрэглэл | 2, 03.а. Ангид байгаа сургалтын хэрэглэг-дэхүүнийг юугаар хийгдсэн болохыг судлах, зөв хэрэглэх талаар найздаа зөвлөх | | ☐ | | ТХ312.НСХ1. | ТХ312.Сэ03. | Сурагчид ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг юугаар хийгдсэн болохыг судалж, хэрэглээний байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөөллийг ойлгож, зөв хэрэглэх талаар бусдад таниулан сурталчилж чаддаг болохтой холбоотой. | | ☐ | | | Ялган таних, таамаглал дэвшүүлэх, ангилах, хэрэглэх, үр дүнгээс дүгнэлт гаргах шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө. | 4, 5, 8 | 4-Харилцах<br>5-Хамтран суралцах<br>8-Өөрт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадварт суралцана. |
| 4. Миний бие | 2, 04.б. Биеийн бүтцийн хэсгүүдийн үүргийг тайлбарлах | | ☐ | | ТХ303.ТМ5. | ТХ303.Сэ04. | Сурагч бие махбодын эрүүл мэндийг дэмжихэд шаардлагатай урьдчилан сэргийлэх стратегиудыг мэдэхийн тулд биеийн бүтцийн хэсгүүдийг үүрэгтэй нь холбон тайлбарлаж, урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулж чаддаг болохтой холбоотой. | | ☐ | | | Хүний биеийн бүтцийн нүдэнд харагдах хэсгүүдийг ялган нэрлэхийн тулд төсөөлөн бодох, үүрэгтэй нь холбон тайлбарлахын тулд шинжлэн судлах, үр дүнг бусдад тайлбарлах арга зүйг төлөвлөнө. | 1, 5 | 1-Хүний биеийн гадаад бүтцийн хэсгүүдийг үүрэгтэй нь холбон тайлбарлана.<br>5- Багаар ажиллах, өөрсдийн хийсэн ажлын үр дүнг бусдад танилцуулж зөвлөгөө өгнө. |
| 5. Манай гэрийнхэн | 2, 05.б. Нэн шаардлагатай утасны дугаарыг мэдэж бусдад туслах | | ☐ | | ТХ311.ТМ3 | ТХ311.Сэ1 | Сурагч суурьшлын хэв маягийн түүхэн шалтгааныг ойлгож, аюулгүй байдлыг хангах үүднээс нэн шаардлагатай утасны дугаарыг мэдэж бусдад туслахтай холбоотой. | ☐ | | | | Ахмад болон мэргэжлийн хүмүүсийг урьж ярилцлага хийх үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой. | 2 | Урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх чадварт суралцана. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6. Миний гэр орон | 2, 06.а. Гэр байрнаасаа сургууль хүрэх замыг заах, үндсэн ба завсрын зүг чигийг тодорхойлох | | □ | | ТХ311.НСХ3 | ТХ311.Сэ10 | Сурагч өөрсдийн оршин суугаа бүс нутгийнхаа талаар эргэцүүлэн бодож, гамшгийн бэлэн байдалд дасан зохицох үүднээсгэр байрнаасаа сургууль хүрэх замыг заах, үндсэн ба завсрын зүг чигийг тодорхойлохтой холбоотой. | | □ | | | Гэр байрнаасаа сургууль хүрэх замыг ажиглах, зүг чигийг баримжаалан зураглал гаргах шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө. | 3 | Тогтсон хэм хэмжээ буюу завсрын зүг чигийн тухай мэдлэг ойлголт эзэмшинэ. |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 2, 07.а. Сургууль орчмын дуу чимээний эх үүсвэрийг тодорхойлох, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг тайлбарлах | | □ | | ТХ311.ТМ2 | ТХ311.Сэ5 | Суурин газрын экологи хүний суурьшилд хэрхэн дасан зохицож байгааг ажиглах, суурин газрын тогтвортой байдлыг үнэлэх,дуу чимээний эх үүсвэр эрүүл мэндэд нөлөөлөх байдлыг тайлбарлахтай холбоотой. | | □ | | | Сургууль орчмын дуу чимээний эх үүсвэрийг тодорхойлох, шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө. | 1 | Үр нөлөөг задлан шинжлэх, дүгнэлт гаргах чадвар хөгжинө. |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 2, 07.б. Сургуулийн орчинд баримтлах дэгийг сахиж мөрдөх, хэвшил болгох, хамтран шийдвэр гаргах арга барилд суралцах | | □ | | ТХ311.ЗТ2 | ТХ311.Сэ8 | Сургуулийн орчинд баримтлах дэгийг сахиж мөрдөх, хэвшил болгох,хамтын шийдвэр гаргах үйл явцад оролцож, төлөвлөлтөд нөлөөлөл үзүүлэх тэй холбоотой. | □ | | | □ | 4- Сургуулийн орчин дахь сайн туршлага, асуудлыг олж харж шийдвэр гаргах<br><br>1- Дэг журмыг даган мөрдөх аяны ажилд оролцох оролцооны аргуудыг төлөвлөнө. | 2, 4, 5, 8 | 2- Үйл явцыг ойлгож үнэлэх<br><br>4-Сургуулийн үйл ажиллагааг алдагдуулахгүй, хамт олноороо нэгдсэн зохион байгуулалттай оролцох<br><br>5- Бусдыг ойлгож, аливаа зөрчил маргалдааныг хамтран шийдвэрлэх<br><br>8- Тогтвортой хөгжлийн асуудал шийдвэрлэх чадварт суралцана. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 2, 07.в. Ангид ургадаг ургамал олон төрөл болохыг тодорхойлох, усалж арчилж ургуулах | | □ | | ТХ313.ТМ5 | ТХ313.Сэ10 | Сурагч биологийн олон янз байдлын үр дагаврыг тайлбарлахын тулд өөр өөр нөхцөл байдалд хэрэгжүүлж болохуйц шаардлагатай аргыг мэдэж, ангид ургадаг ургамал олон төрөл болохыг тодорхойлон, усалж арчилж ургуулж сурахтай холбоотой. | □ | □ | | | 1- Тасалгааны ургамлыг ажиглах, ангилах шинжлэн судлах арга зүйг дэглэнэ.<br>2- Ургамлыг арчлах арга зүйг эзэмших, хэрэгжүүлэх үйлийг төлөвлөнө. | 3, 8 | 3- Хэм хэмжээг дагах, түүний талаар эргэцүүлэн бодох чадвар хөгжинө.<br>8- Асуудлыг шийдвэрлэх чадварт суралцана. |
| 8. Орон нутаг ба хүмүүс | 2, 08.а. Нутаг орныхоо хүмүүсийн юу хийж, хэрхэн аж төрдгийг мэдэж танилцах, хувь нэмрээ оруулах, бахархан хүндэтгэх | | □ | | ТХ311.ТМ4 | ТХ311.Сэ8 | Орон нутгийнхаа хөгжил, илүү тогтвортой, тусгай эрэлт хэрэгцээг хангасан байдлыг мэдэхийн тулд нутаг орныхоо хүмүүсийн юу хийж, хэрхэн аж төрж буйтай танилцах, хувь нэмрээ оруулах, бахархан хүндэтгэхтэй холбоотой. | | | □ | □ | 3- Аялал экскурс зохион байгуулах<br>4- Нутаг орны хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэлтийн талаар эргэцүүлэн бодох, түүх намтар сонсох, бичих арга зүйг төлөвлөнө. | 5, 6 | 5-Хамтран ажиллах, бусдаас суралцах чадвар хөгжинө.<br>6-Өөрийн гэсэн байх суурьтай болох, хэлэлцүүлэг хийх чадварт суралцана. |
| 9. Орон нутаг ба байгаль | 2, 09.а. Ургамал, амьтны амьдрах орчныг нэрлэх, орчиндоо хэрхэн зохицдогийг ажиглах, турших, жишээгээр тайлбарлах | | □ | | ТХ313.ТМ3 | ТХ313.Сэ6 | Ургамал, амьтны амьдрах орчныг нэрлэх, жишээгээр тайлбарлах, амьдрах орчиндоо хэрхэн зохицдогийг ажиглаж, турших,уур амьсгалын өөрчлөлтөд хувь хүний зүгээс үзүүлдэг нөлөөллийн тухай ойлголттой болохтой холбоотой. | | □ | | | Ургамал, амьтан орчиндоо хэрхэн дасан зохицдог болохыг ажиглах, туршилт хичээл зохион байгуулна. | 1 | Аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох, задлан шинжлэх чадварт суралцана. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.б. Жилийн 4 улирал бүрд хамаарах саруудыг ялгах, улирлын ялгааг мэдэх ба харьцуулах | | ☐ | | ТХ315.НСХ3. | ТХ315.Сэ08. | Сурагч орон нутгийн байгаль орчинтой харилцаж, хүмүүс амьд байгалийн нэг хэсэг бөгөөд тэдний байгальтайгаа холбогдох байдлыг ажиглан жилийн 4 улирал бүрд хамаарах саруудыг ялган улирлын ялгаag мэдэх ба хүний үйл ажиллагаа, улирлын онцлогийг харьцуулахтай холбоотой | | ☐ | | | Сурагчид улиралд хамаарагдах саруудыг мэдэх, улирлын ялгаатай байдлыг харьцуулах бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө. | 6 | Тогтсон хэм хэмжээ, дадал, туршлага, санаа бодолд үндэслэн асуудал дэвшүүлэх чадварт суралцана. |
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.в. Улирлын ялгаанаас байгаль ба хүмүүс, нийгмийн юмс үзэгдэл хэрхэн хамаарахыг таньж мэдэх, тайлбарлах | | ☐ | | ТХ315.НСХ4. | ТХ315.Сэ08. | Сурагч хүмүүс амьд байгалийн нэг хэсэг бөгөөд тэдний байгальтайгаа холбогдох байдлыг ажиглан, хүмүүс бид байгалиас салангид бус харин байгалийн нэг хэсэг нь болохыг ухаарч, улирлын ялгаанаас байгаль ба хүмүүс,нийгмийн юмс үзэгдэл хамаардаг болохыг тайлбарлаж чаддаг болохтой холбоотой | | ☐ | | | Улирлын ялгаанаас байгаль, хүмүүс, нийгмийн юмс үзэгдэл хэрхэн хамаарахыг илрүүлэх шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө. | 4, 6 | 4- Орон нутгийн тогтвортой байдлыг дэмжсэн үйл ажиллагааг мэдэх, хэрэгжүүлэх чадварт суралцана.<br><br>6- Өөрийн үнэлэмж, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох чадвар хөгжинө. |
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.г. Цаг агаарыг ажигладаг, шинждэг чадвар эзэмших | | ☐ | | ТХ313.ТМ5. | ТХ313.Сэ06. | Сурагч өөр өөр нөхцөлд хэрэгжүүлж болохуйц урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдлийг бууруулахтай холбоотой стратегийг мэдэхийн тулд цаг агаарыг ажигладаг, шинждэг чадвар эзэмшин, дасан зохицох, урьдчилан сэргийлэх, гамшгийн үед хариу арга хэмжээ авахтай холбоотой. | | ☐ | | | Цаг агаарыг ажиглах дадлага ажил болон тохиолдлын шинжилгээ хийх арга зүйг төлөвлөнө. | 8 | Өөрт тохиолдсон асуудлыг шийдвэрлэх арга барилд суралцана. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.д. Цаг агаарын байдал хүмүүсийн амьдрал, ахуйд хэрхэн нөлөөлдөг талаар мэдэх | | ☐ | | ТХ315.НСХ5. | ТХ315.Сэ08. | Сурагч хүмүүс амьд байгалийн нэг хэсэг бөгөөд тэдний байгальтайгаа холбогдох байдлыг ажиглан, цаг агаарын байдал хүмүүсийн амьдрал, ахуйд нөлөөлдөг болохыг ойлгон байгальтай харилцан зохицсон аж амьдралын алс хэтийн хараатай болохтой холбоотой | | ☐ | | | Мэдээлэл цуглуулах, мэдээлэлд боловсруулалт хийх, үр дүнг нэгтгэн танилцуулах, тохиолдолд шинжилгээ хийх арга зүйг төлөвлөнө. | 1 | Аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох, задлан шинжлэх чадварт суралцана. |
| 10. Эх орон, эх дэлхий | 2, 10.ё. Юмсын хэлбэр, хэмжээ, орших байрлал, ба зүг чигийг ялган харьцуулж орон зайн төсөөлөлтэй болох | | ☐ | | ТХ311.НСХ5. | ТХ311.Сэ01. | Сурагч аюулгүй байдлыг хангах үүднээс өөрийн амьдралын хэв маягийн хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөлд хүлээх хариуцлагаа мэдэрч, юмсын хэлбэр, хэмжээ, орших байрлал, ба зүг чигийг ялган харьцуулж,орон зайн төсөөлөлтэй болохтой холбоотой. | | ☐ | | | Орон зайн байрлал, зүг чиг, юмсын байрлалыг загварчлах арга зүйг төлөвлөнө | 6, 7 | 6-Тогтсон хэм хэмжээ болох зүг чигийн тухай мэдлэг ойлголт эзэмшинэ.<br>7-Өөрийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, өөрийгөө хөгжүүлнэ. |
| 1. Миний тоглоом | 3, 01.б. Тоглоомоо цэвэр, ариг гамтай, цэгцтэй байлгах, хэрэглэх, гараа угаах | | | ☐ | ТХ303.НСХ4 | ТХ303.Сэ03. | Сайн сайхан байдлын олон талт цогц ойлголт, үнэ цэнэ итгэл үнэмшил, хандлагын талаар ойлголттой болж, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжин,тоглоомоо ариг гамтай хэрэглэн эрүүл ахуйн дэглэм баримтлах | ☐ | | | ☐ | 1- Тоглоомоо ариг гамтай хэрэглэх, эмх цэгцтэй байлгах үйл ажиллагааг төлөвлөнө.<br><br>4-Гараа угааж сурахад чиглэсэн оролцооны болон асуудал шийдвэрлэх арга зүйг дэглэнэ. | 5, 8 | 5-Хамтран ажиллах, бусдаас суралцах чадвар хөгжинэ.<br><br>8- Тоглоомыг ариг гамтай, эмх цэгтэй хэрэглэх, хадгалах, тоглоом тоглосны дараа гараа угаах зөв зан үйл төлөвшүүлэх асуудал шийдвэрлэх чадварт суралцана. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. Миний тоглоом | 3, 02.б. Эцэг эх, ахмад хүмүүс, багш, найз нөхөдтэйгөө харилцан ойлголцож өөрийн хариуцлагыг ухамсарлаж, бусдыг хүндэтгэх | | | ☐ | ТХ305.ЗТ4 | ТХ305.Сэ2 | Сурагч бусдыг дэмжихийн тулд,эцэг эх, ахмад хүмүүс, багш, найз нөхөдтэйгөө харилцан ойлголцож, өөрийн хариуцлагыг ухамсарлан,бусдыг ялгаварлан гадуурхахгүй харилцах | | ☐ | ☐ | | Бусдыг хүндлэн, ялгавартай хандахгүй байхын тулд<br>2- тохиолдолд шинжилгээ хийх<br>3- дүрд тоглох гэх мэт арга зүйг дэглэнэ. | 2 | Ойлгох, өөрийн үзэл бодлыг бий болгох чадварт суралцана. |
| 3. Миний хичээлийн хэрэглэл | 3, 03.а. Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагааны талаар мэдэх | | | ☐ | ТХ312.ЗҮ1. | ТХ312.Сэ08. | Сурагч тогтвортой амьдралын хэв маяг, хэрэглээний олон янзын практик туршлагад үндэслэн, хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагаар баримтлан, хэрэглээтэй холбоотой үйл ажиллагаар төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх чадвартай болохтой холбоотой. | | ☐ | | ☐ | 2- Хичээлийн хэрэглэлийг ялган таних, аюулгүй ажиллагаар төлөвлөж мөрдөх шинжлэн судлах арга зүйг дэглэнэ.<br>4- Аюулгүй ажиллагаар эрхэмлэн, хичээлийн хэрэглэлийг сонгож хэрэглэх үйлийг төлөвлөнө. | 2, 8 | 2- Эрсдэлтэй үйлийг ойлгож, урьдчилан сэргийлэх чадварт суралцана.<br>8- Хичээлийн хэрэглэлийг зөв сонгон хэрэглэх зэрэг асуудал шийдвэрлэх чадварт суралцана. |
| 4. Миний бие | 3, 04.б. Биеийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлийг тайлбарлах | | | ☐ | ТХ303.ТМ5. | ТХ303.Сэ04. | Сурагч биеийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлийг мэдэж,бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжихэд шаардлагатай урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга замыг ойлгохын тулд өсөж том болохын баяр, сэтгэгдлээ жишээгээр тайлбарлахтай холбоотой. | | ☐ | ☐ | | 2- Биеийн жин, өндрийг хэмжин, баганан диаграммаар зурж биед гарч байгаа өөрчлөлтийг тайлбарлах чадварыг хөгжүүлэх шинжлэн судлах арга зүйг дэглэнэ.<br>3- Бусдаас ямар ялгаатай болон ижил байгаа талаар хэлэлцэнэ. | 1, 5 | 1- Бидний биеийн өндөр ойролцоо байгаа ч гэсэн эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн өндөр нэлээд ялгаатай байна гэдгийг олж харна.<br>5- Биеийн жин өндрийг хэмжихэд бусдадаа тусална |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. Манай гэрийнхэн | 3, 05.а. Угийн бичгийг зураглан дүрслэх | | | ☐ | ТХ311.НСХ4 | ТХ311.Сэ1 | Тусгай эрэлт хэрэгцээнд тулгуурланхүн төрөлхтний тогтвортой суурьшлын төлөө гэр бүлийнхээ угийн бичгийг зураглан дүрслэх | | ☐ | | | Угийн бичгийг зураглан дүрслэх, танилцуулах, бүтээлч эрэлхийллийн арга зүйг төлөвлөнө. | 1 | Харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох, нэгтгэн дүгнэх чадварт суралцана. |
| 6. Миний гэр орон | 3, 06.а. Гэр, сургууль орчмын план зургийг зурах, нэрлэх | | | ☐ | ТХ311.НСХ4 | ТХ311.Сэ10 | Сурагч ногоон байгууламж, эрчим хүч, тээврийн аюулгүй байдалд өөрийн үнэлгээ хийж,гамшгаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах зорилгооргэр, сургууль орчмын план зургийг зурах, нэрлэх | | ☐ | | | Ажиглах, төлөвлөх, зурах, бусдад танилцуулах үйл бүхий шинжлэн судлах арга зүйг хэрэгжүүлнэ. | 1. 3. 6 | 1-Орчны аюулгүй байдлыг үнэлэх<br>3-Тогтсон хэм хэмжээ бүхий тэмдэг тэмдэглэгээг ойлгох<br>6-Өөрийн ойлголт, үнэлэмжээ эргэцүүлэн бодох чадвар хөгжинө. |
| 6. Миний гэр орон | 3, 06.б. Гэр, байрнаас сургууль хүрэх орчин тойрны аюулгүй байдлыг үнэлэх | | | ☐ | ТХ311.ТМ5 | ТХ311.Сэ10 | Урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үүднээсгэр, байрнаас сургууль хүрэх орчин тойрны аюулгүй байдлыг үнэлж, өөрсдийн оршин буй газрын төлөвлөлт, бодлогод тогтвортой дуу хоолойгоо хүргэх | | ☐ | | | Гэр байрнаасаа сургууль хүрэх замыг ажиглах, аюулгүй байдлын зураглал хийх шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө. | 1 | Үр нөлөөг задлан шинжлэх, дүгнэлт гаргах чадвар хөгжинө. |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 3, 07.б. Сургуулийн гадаад орчны судалгаа хийх, аюулгүй байдлаа хамгаалах | | | ☐ | ТХ311.НСХ5 | ТХ311.Сэ1 | Сурагч байгаль орчин, нийгэмд өөрсдийн амьдралын хэв маягийн үзүүлэх нөлөөлөлд хариуцлагатай хандан, аюулгүй байдлыг хангах үүднээссургуулийн гадаад орчны аюулгүй байдлыг судлах | | ☐ | | | Сургуулийн гадаад орчинг ажиглах (замын хөдөлгөөн, гарц), аюулгүй байдлыг үнэлэх арга зүйг дэглэнэ. | 1 | Үр нөлөөг задлан шинжлэх, дүгнэлт гаргах чадвар хөгжинө. |
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 3, 07.в. Сургуулийн дүрэм, журмыг хэрхэн биелүүлж байгааг судлах | | | ☐ | ТХ311.ТМ5 | ТХ311.Сэ8 | Сургуулийн дүрэм, журмыг хэрхэн биелүүлж байгааг судлан өөрсдийн оршин буй газрын төлөө төлөвлөлт, бодлогод тогтвортой дуу хоолойгоо хүргэх, шийдвэр гаргалтад нөлөөлөл үзүүлэх | | ☐ | | | Сургуулийн орчинд мөрдөх дүрэм, журмыг хэрхэн биелүүлж байгааг ажиглах, шинжлэн судлах арга зүйг дэглэнэ. | 1 | Сэтгэн бодох, ойлгох, танин мэдэх чадвар хөгжинө. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. Сургуулийн дотоод, гадаад орчин | 3, 07.г. Ангид ургаж байгаа ургамлын өсөлт хөгжлийг ажиглаж, тэмдэглэл хөтлөх, арчилж сурах | | | □ | ТХ313.ЗТ1 | ТХ313.Сэ10 | Сурагч биологийн олон янз байдлын эко системд үзүүлэх нөлөөлөл болон хувийн болон ажил хэргийн үйл ажиллагаа нь уур амьсгалд зэрэг нөлөө үзүүлж байгаа эсэхийг үнэлж, ангид ургаж байгаа ургамлын өсөлт хөгжлийг ажиглаж, тэмдэглэл хөтлөх, арчилж сурах | □ | □ | □ | 1- Тасалгааны ургамлын өсөлт хөгжлийг ажиглаж тэмдэглэл хөтлөх туршилтыг төлөвлөнө.<br>2- Ургамлыг арчлах арга зүйг хөгжүүлэх үйлийг төлөвлөнө.<br>3- Асуудал шийдвэрлэх сургалтын арга зүйг хэрэгжүүлж болно. | 3, 8 | 3- Хэм хэмжээг дагаж дадлага туршлага, санаа бодолд асуудал дэвшүүлэх чадвар хөгжинө.<br>8- Асуудлыг шийдвэрлэх чадварт суралцана. |
| 8. Миний нутаг | 3, 08.б. Нийтийн эзэмшлийн газруудад баримтлах дэг журамтай танилцаж түүнийг мөрдөх | | | □ | ТХ311.НСХ5. | ТХ311.Сэ05. | Сурагч өөрийн амьдралын хэв маягийн хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөлд хүлээх хариуцлагаа мэдэрч, хүний суурьшилд, хэрхэн дасан зохицож амьдардаг болохыг ойлгон,нийтийн эзэмшлийн газруудад баримтлах дэг журамтай танилцаж түүнийг мөрдөх | | □ | | Тохиолдолд шинжилгээ хийх арга зүйг төлөвлөж хэрэгжүүлнэ | 2, 4, 5, 8 | 2- Үйл явцыг ойлгож үнэлэх<br>4-нийтийн эзэмшлийн газруудад баримтлах дэгийг хамт олноороо даган хэвшүүлэх<br>5- Бусдыг ойлгож, аливаа зөрчил маргалдааныг хамтран шийдвэрлэх<br>8- Асуудал шийдвэрлэх чадварт суралцана. |
| 9. Орон нутаг ба байгаль | 3, 09.а. Орон нутгийн ургамал, амьтдыг ангилах, амьдрах орчин хэрхэн бүрдсэнийг судлах | | | □ | ТХ313.ТМ5. | ТХ313.Сэ10. | Сурагч биологийн олон янз байдлын үзүүлэх нөлөөллийг тайлбарлахын тулд орон нутгийн ургамал, амьтдыг ангилах, амьдрах орчин хэрхэн бүрдсэнийг судлан дасан зохицох зохилдолгоог мэдэж, тэдгээр амьтдыг хамгаалахтай холбоотой. | | □ | □ | 2- Туршилтын хичээлийг төлөвлөнө.<br>3-Экскурс, танилцах аялал зохион байгуулна. | 1, 6 | 1- Амьд биеийн дасан зохилдолгоог танин мэдэх<br>6- эргэцүүлэн бодох, шүүмжлэлт сэтгэлгээ хөгжинө. |
| 10. Манай дэлхий | 3, 10.е. Дэлхийн хүмүүсийн амьдардаг газар, амьдрал, арьс өнгө ялгаатай байдгийг мэдэх, газрын зураг ба глобус дээр ялгах | | | □ | ТХ310.НСХ1 | ТХ310.Сэ1 | Ялгаварлан гадуурхдаг түгээмэл төрлүүд буюу тэгш бус байдлыг арилгах тухай ойлголтыг дэлхийн хүмүүсийн амьдардаг газар, амьдрал, арьс өнгө ялгаатай байдагтай холбон тайлбарлах | | □ | | Дэлхийн хүмүүсийн амьдардаг газар, амьдрал, арьс өнгө ялгаатай байдгийг мэдэх, газрын зураг ба глобус дээр тэмдэглэх чадвар эзэмшүүлэх шинжлэн судлах арга зүйг төлөвлөнө. | 1, 6 | 1- Хүлээн зөвшөөрөх, тодорхойгүй байдлыг шинжлэх чадварт суралцана.<br>6- Өөрийн үнэлэмжийг хөгжүүлнэ. |

## 2.5. Б. НЭГЖ ХИЧЭЭЛ: МИНИЙ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭЛ

### Нэгж хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр

2015 онд дэлхийн 193 орон тогтвортой хөгжлийн 17 зорилтыг дэвшүүлэн тавьж түүний 12 дугаарт “хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих” хэмээн заасан билээ. Дэлхий нийтэд тулгараад байгаа хэт хэрэглээ, үйлчилгээний өсөлт нь дэлхийн оршин тогтнолд эрсдэл учруулаад байна. Иймд дэлхийн улс орон, иргэн бүр өөрсдийн хэрэглээ, үйлдвэрлэл, ахуй амьдралынхаа хэв маягийг эрс өөрчилж, байгальд илүү ээлтэй хэрэглээг чухалчлан, эдийн засгийн өртгийг багасгаж, ядуурлыг бууруулан нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг хангахад хувь нэмрээ оруулах нь чухал болоод байгаа билээ.

Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагааны талаар мэдэх нь энэ насны хүүхдүүдийн хувьд чухал асуудал юм. Учир нь, тэд хичээлд хэрэглэж байгаа багаж хэрэгслийг хэрхэн, яаж хэрэглэх, хадгалах талаар төсөөлөл бага байдаг. Ургамлын үр соёолохыг ажиглах, турших, үр дүнг тэмдэглэх шинжлэн судлах арга зүйг төлөвлөн хэрэгжүүлэхэд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, тухайлбал, термометрийг зөв унших, зөв хэрэглэх, хадгалах тухай чадвар эзэмшүүлэх зорилгоор III ангид судлах “Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагааны талаар мэдэх” гэсэн суралцахуйн зорилтыг сонгон нэгж хичээлийн төлөвлөлтийг санал болгож байна. Хичээлийн агуулга нь дөрөвдүгээр улиралд судлах “Үрнээс үр хүртэл” “Ургамал ургахад гэрэл, ус хэрэгтэй юу” (сурах бичгээс харна уу) хичээлийн агуулгатай холбогдох тул энэ хичээлээр сургалтад хэрэглэгддэг хэрэглэгдэхүүнийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ашиглах чадвар эзэмшүүлэх, мөн дээрх хичээлүүдийг явуулах бэлтгэл буюу өмнөх төсөөллийг бий болгоход анхаарна. Гэхдээ багш хичээлийн хэрэглэлийг зөв, аюулгүй хэрэглэх гэдэгт голлон анхаарал хандуулаарай.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ ТХЗБ-ын сэдэв → | ***ТХ312.Сэ03.*** Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээний байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөө |
| ***ТХ312.НСХ5.*** Сурагч нь үйлдвэрлэгч ба хэрэглэгч болохынхоо тухайд хувийн амьдралын хэв маяг нь хүрээлэн буй орчин, нийгэмд хэрхэн нөлөөлдөгт хүлээх хариуцлагаа мэдэрдэг болох | ***3, 03.а.*** Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагааны талаар мэдэх<br>↑ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |

Ургамлын үр соёолоход дулаан ялгардаг болохыг термометр хэрэглэн тодорхойлно. Өнөөдөр манай сургалтын практикт ихэвчлэн мөнгөн ус термометрийг хэрэглэж байгаа тул тэдгээрийг зөв хэрэглэх, хадгалах тухай мэдлэг, чадвар эзэмшүүлэх нь ТХБ-той зайлшгүй холбогдож байна.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ТХ312.НСХ5. | ТХ312.Сэ03. | Сурагч хэрэглээний байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөөг ойлгон, хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагааг баримтлан хэрэглэгч болохынхоо тухайд хувийн амьдралын хэв маяг нь хүрээлэн буй орчин, нийгэмд хэрхэн нөлөөлдөгт хүлээх хариуцлагаа мэдэрдэг болохтой холбоотой. |

Цөм хөтөлбөрийн сонгож авсан суралцахуйн зорилт нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт *(12) “*Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл”-ийн (5) нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилт (*ТХ312.НСХ5),* сэдэв (*ТХ312.Сэ03)*-тэй агуулга, арга зүйн хувьд холбогдож байна.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх ТХБ-ын арга зүйн сонголт, хувь нэмэр оруулах боломжтой ТБ-ын цогц чадамжийг тодорхойлсон үндэслэл (матриц 2-ын 8, 10 дугаар баганыг харна уу)*

| Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар | Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар |
|---|---|
| 8 | 10 |
| 1- Хичээлийн хэрэглэлийг ялган таних, аюулгүй ажиллагааг төлөвлөж мөрдөх шинжлэн судлах арга зүйг дэглэнэ.<br>4- Аюулгүй ажиллагааг эрхэмлэн, хичээлийн хэрэглэлийг сонгож хэрэглэх үйлийг төлөвлөнө. | 2- Эрсдэлтэй үйлийг ойлгож, урьдчилан сэргийлэх чадварт суралцана.<br>8- Хичээлийн хэрэглэлийг зөв сонгон хэрэглэх зэрэг асуудал шийдвэрлэх чадварт суралцана. |

Шинжилгээ судалгаа хийх, алсын хараатай болох аргуудыг сонгон хэрэглэхэд багшийн чиглүүлэх асуулт чухал тул багш асуултаар удирдан чиглүүлэхэд анхаарна.

## Нэгж хичээлийн төлөвлөлт

***Нэгж хичээлийн сэдэв:*** Миний хичээлийн хэрэглэл

***Хамрах хүрээ:*** III анги

***Нэгж хичээлийн зорилго:*** Амьдралын хэв маягаа эрүүл мэнд, аюулгүй байдал, байгальд ээлтэйгээр өөрчилж болох санаачилгыг эхлэх хүсэл эрмэлзлийг бий болгоход оршино.

***Цөм хөтөлбөр, сурах бичигт тусгасан агуулга:***

| Анги | I | II | III |
|---|---|---|---|
| Сургалтын цөм хөтөлбөрт | | | |
| Анги хоорондын залгамж холбоо | **1, 03.а.**Хичээлийн хэрэглэлээ ялган таних, үүрэг зориулалтаар нь хэрэглэх, хадгалах талаар бусдад ярих | **2, 03.а.**Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг юугаар хийгдсэн болохыг судлах, зөв хэрэглэх талаар найздаа зөвлөх | **3, 03.а.** Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагааны талаар мэдэх |

| | | | |
|---|---|---|---|
| Агуулгын өргөсөл | Хичээлийн хэрэглэлээ үүрэг зориулалтаар нь хэрэглэх, хадгалах | Сургалтын хэрэглэгдэхүүнийг юугаар хийгдсэн болохыг судлах, зөв хэрэглэх | Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх |
| Агуулгын гүнзгийрэл | Бусдад ярих | Найздаа зөвлөх | Аюулгүй ажиллагааг эрхэмлэх |
| Сэдэв хоорондын залгамж холбоо | Хүрээлэн буй орчны юмсыг мэдэрч, хэрхэн зохицдогийг таньж мэдэх (гар, хуруугаар тэмтэрч мэдрэх, туршилт хийх) | | Ангид ургаж байгаа ургамлын өсөлт хөгжлийг ажиглаж, тэмдэглэл хөтлөх |
| Сурах бичигт | | | |
| Сургалтын цөм хөтөлбөртэй уялдсан агуулга | ***Сурагчийн цүнх*** (сурах бичгийн 12 дугаар хуудас)<br>***Юугаар хийсэн бэ?***(сурах бичгийн 23-24 дүгээр хуудас) | ***Зөв хэрэглээрэй*** (сурах бичгийн 14 дүгээр хуудас) | ***Яаж хэмжих вэ?*** (сурах бичгийн 38-40 дүгээр хуудас)<br>***Үрнээс үр хүртэл*** (сурах бичгийн 65-66 дугаар хуудас) |

***<u>Хэрэгжүүлэх арга зүй:</u>***

| № | Арга зүй (код) | Сурагчийн эзэмших чадвар | ТБ-ын цогц чадамж (код) |
|---|---|---|---|
| 1 | Шинжлэн судлах (2) | - Хүрээлэн буй орчноо ажиглах (танилцах)<br>- Сонирхсон зүйлийн талаар асуулт асуух<br>- Юу болохыг баримжаалах<br>- Асуултад хариулт авч мэдээлэл цуглуулах<br>- Хичээлийн хэрэглэлээ бэлтгэх, сонгох<br>- Хичээлийн хэрэглэлийг зориулалтын дагуу хэрэглэх, зааварчилгааг сахих<br>- Болсон зүйлийг таамаглалтай харьцуулах<br>- Шинэ санааг бичвэр, хүснэгт, диаграмм, зургаар илэрхийлэх | Эрсдэлтэй үйлийг ойлгож, урьдчилан сэргийлэх чадварт суралцана (2).<br><br>Хичээлийн хэрэглэлийг зөв сонгон хэрэглэх зэрэг асуудал шийдвэрлэх чадварт суралцана (8). |
| 2 | Асуултаар удирдан чиглүүлэх (4) | - Аюулгүй, цэвэр орчин бүрдүүлэх санаа гаргах<br>- Санал бодлоо илэрхийлэх, тайлбарлах<br>- Байгаль, хүрээлэн буй орчинд зөрөг хандах | Өөрт тохиолдсон асуудлыг шийдвэрлэх чадварт суралцана(8). |

1. Хичээлийн агуулга нь хичээлд хэрэглэдэг багаж хэрэгслүүдийг үүрэг зориулалтаар нь зөв сонгож хэрэглэх, зохистой хадгалах, аюулгүй ажиллагааг эрхэмлэн эрүүл мэндээ хамгаалах, байгальд ээлтэй, ухаалаг, аюулгүй хэрэглээг найздаа зөвлөхөд орших тул багш хичээлийн хэрэгслүүдийг ашиглах бодит үйлийг сонгон арга зүйг төлөвлөнө (Энэ удаа ургамлын үрийг соёолуулах явцад багаж хэрэгслийг зохистой хэрэглэх шинжлэн судлах арга зүйг сонгосон).
2. Багш танин мэдэхүйн агуулгыг ТХБ-той холбосон асуултаар хичээлийн арга зүйг чиглүүлж удирдана.

***Багшийн чиглүүлэх асуултын жишээ:***

| | |
|---|---|
| Танин мэдэхүйн асуулт | • Уртыг хэмждэг хичээлийн хэрэгслийг нэрлэнэ үү, яаж хэрэглэх вэ?<br>• Халуун, хүйтнийг хэмжигч багажийг нэрлэнэ үү, түүний заалтыг хэрхэн унших вэ?<br>• Нүдэнд харагдахгүй зүйлийг харахад хэрэглэдэг жижиг хэрэгслийг нэрлэнэ үү, хэрхэн ашиглах вэ?<br>• Хугацааг хэмждэг хэрэгслийг нэрлэнэ үү, заалтыг нь хэрхэн уншиж тэмдэглэх вэ?<br>• Ажигласан зүйлийг баримтжуулдаг хэрэгслийг нэрлэнэ үү, түүнийг хэрхэн хадгалах вэ? гэх мэт |
| ТХБ-ын асуулт | • Дээрх хичээлийн хэрэгслийг эрүүл мэндэд аюулгүй, зөв зохистойгоор хэрхэн хэрэглэх вэ?<br>• Буруу хэрэглээнээс үүдэлтэй ямар хохирол үүсч болох вэ?<br>• Ухаалаг, аюулгүй хэрэглээг найздаа хэрхэн сурталчлах вэ? |

***Сургалтын орчин:***

| Материаллаг | Сэтгэл зүйн | Үйлийн |
|---|---|---|
| Туршилтын хичээл явуулах орчин, хэрэглэгдэхүүнийг бэлтгэсэн байна. | - Өөртөө итгэлтэй байх<br>- Багаар ажиллах<br>- Аюулгүй ажиллагааг эрхэмлэх<br>- Бусдыг сонсох, бусдад нөлөөлөх | - Ургамлын ургах явцыг ажиглаж тэмдэглэл хөтлөх<br>- Шугам, цаг, өсгөгч шил, термометр зэрэг хэмжигч багаж ашиглан хэмжилт хийх<br>- Үр дүнг зураг, диаграмм болон хүснэгтээр илэрхийлэх<br>- Хэмжилтийнхээ үр дүнг бусдадаа тайлбарлах |

***Үнэлэх стратеги, арга хэлбэр:***

Сурагчид тухайн сонгосон үйлийг гүйцэтгэхдээ ажиглах, турших, үр дүнг тооцох, багаж хэрэгслийг хэрхэн аюулгүй ашиглаж буй байдлыг ажиглан тэдний сурах хүсэл эрмэлзэл, санаачилга, хандлагад гарч байгаа өөрчлөлтийг тэмдэглэнэ.

- Мэдлэг, чадварын ахиц өөрчлөлтөд дүн шинжилгээ хийнэ.
- Сурагчдын санал санаачилгыг урамшуулна.
- Сурах хүсэл эрмэлзэл, сэтгэл ханамжийг үнэлнэ.

**Ээлжит хичээл: Яаж хэмжих вэ?**

Зорилт:

1. Ургамлын үрийг соёолуулах, багаж хэрэгслийг үүрэг зориулалтаар нь зөв сонгож хэрэглэх
2. Аюулгүй ажиллагааг эрхэмлэн эрүүл мэндээ хамгаалах
3. Байгальд ээлтэй, ухаалаг, аюулгүй хэрэглээг найздаа зөвлөх

Цаг: Танхимд -2 цаг (Хичээлийн эхний ба сүүлийн 1 цагийг танхимд хичээллэнэ). Хичээлээс гадуурх үйл ажиллагаа -5 цаг

Багшийн үйл ажиллагаа

Бага ангийн сурагчдад ургамал нь амьтдын амьдрах орчин болох тухай мөн хөрсийг нөхөн сэргээх, бэлчээрийн доройтлыг бууруулах, биологийн төрөл зүйлийг хамгаалах зэрэг ТХЗБ-ын сэдэв буюу агуулгын үндэс суурийг эзэмшүүлэхийн тулд бичил ногоон орчинг бүрдүүлэхэд оролцох, аюулгүй ажиллагааг эрхэмлэх чадвар эзэмшүүлэх энгийн хялбар туршилтыг төлөвлөн хэрэгжүүлж болно.

Ургамлын үр соёолуулах дадлага ажил хийх бэлтгэлийг хангана.

*Багш хичээлийн бэлтгэлээ үнэлэх рубрик (Бичиж тэмдэглэнэ)*

| № | Шалгуур үзүүлэлт | Маш сайн | Хангалттай | Сайжруулах шаардлагатай. |
|---|---|---|---|---|
| 1 | Хичээлийн сэдэв, зорилго ТХБ-ын сэдэв, суралцахуйн зорилттой уялдаатай эсэх | | | |
| 2 | Ажлын хуудас, даалгаврын агуулгыг сургалтын цөм хөтөлбөр болон ТХБ-ын сэдэв, суралцахуйн зорилттой уялдаатай боловсруулсан эсэх | | | |
| 3 | Хэрэглэгдэхүүн, сургалтын орчинг бэлтгэсэн эсэх | | | |
| 4 | Ганцаарчилсан болон багаар ажиллах арга зүйг төлөвлөсөн эсэх | | | |
| 5 | Ажлын хуудас дахь даалгаврын жингийн хамаарал зохистой эсэх (сурагчийн хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар, санаачилгатай байдлыг илрүүлэхүйц байх) | | | |
| 6 | Сурагчийн мэдлэгийг үнэлэх даалгаврын тавил оновчтой эсэх | | | |
| 7 | Сурагчийн чадварыг үнэлэх даалгаврын тавил оновчтой эсэх (бичвэр, зураг, схем, диаграмм, графикаар илэрхийлсэн өгөгдөл) | | | |

Сурагчийн хийх үйл ажиллагаа (Туршилт)

1. Хэрэглэгдэхүүнийг бэлтгэнэ: Буудайн үр, шугам, цаг, өсгөгч шил, термометр, зургийн аппарат, шилэн аяга, ус, хөвөн, цаг тооны бичиг, ажлын хуудас

*Багшийн чиглүүлэх асуулт*

| | |
|---|---|
| *Танин мэдэхүйн асуулт* | • Дараах туршилтыг хийхэд бид ямар багаж хэрэгслийг хэрэглэх вэ?<br>• Тэдгээрийг хэрхэн ашиглах вэ?<br>• Үр соёолсон шилэн аяганы халуун хэрхэн өөрчлөгдөж байна вэ?<br>• Термометрийн заалтыг тэмдэглээрэй. Ангийн агаарын хэмээс ямар ялгаатай байна вэ? |
| *ТХБ-ын асуулт* | • Ногоон орчин амьтан, хүн, хөрс, бэлчээрийн чанарт нөлөөлөх үү?<br>• Термометрийг буруу ашигласнаас байгаль орчинд ямар нөлөө үзүүлэх вэ? |

2. Аргачлалын дагуу туршилт хийнэ (Сурах бичгийн 38, 39 дүгээр хуудас).
   2.1. Сурах бичигт тусгасан аргачлалын дагуу туршилтыг хийнэ.
   2.2. Туршилтын үр дүнг тэмдэглэж, бусдад танилцуулна (Сурах бичгийн 40 дүгээр хуудасны ажлын хуудсыг сурагч нэг бүрт өгч ажиллуулна).Үр дүнг тэмдэглэж дүгнэлт гаргахад дэмжлэг үзүүлэх чиглүүлэх асуултыг бэлтгэнэ. Үүнд:

*Багшийн чиглүүлэх асуулт*

| | |
|---|---|
| *Танин мэдэхүйн асуулт* | • Ургамлын үр соёолоход нөлөөлсөн хүчин зүйлүүдийг нэрлэнэ үү (ус, гэрэл, дулаан гэх мэт)<br>• Хүснэгтийн багана ба мөрөнд ямар үр дүнг тэмдэглэх вэ?<br>• Үр дүнг харьцуулахад ямар зүй тогтол ажиглагдаж байна вэ?<br>• Ургамлын соёолоптын уртыг хэрхэн хэмжих вэ? Үр дүнг баганан диаграммаар хэрхэн илэрхийлэх вэ? |
| *ТХБ-ын асуулт* | • Туршилтын үр дүнд үндэслэн ухаалаг зохистой хэрэглээний тухай бусдад танилцуулна уу? |

***Үнэлгээ:***

Багш хичээлийн явцад ажиглалт хийн, рубрикт √ гэж тэмдэглэл хөтөлнө. Сурагчдаар өөрийн үнэлгээ хийлгэж болно.

| | Болж байна | Анхаарах шаардлагатай | Дэмжлэг хэрэгтэй |
|---|---|---|---|
| Мэдлэг | ☐ Шугам, термометрийн заалтыг зөв унших тухай мэдлэг<br>☐ Аюулгүй, цэвэр орчин бүрдүүлэх тухай ойлголт | ☐ Шугам, термометрийн аль нэгнийх нь заалтыг уншиж чадахгүй байгаа<br>☐ Зарим нэг мэдлэг ойлголт дутмаг | ☐ Шугам, термометрийн аль алиных нь заалтыг уншиж чадахгүй байгаа<br>☐ Энэ талын мэдлэг ойлголт аваагүй |
| Чадвар | ☐ Ургамлын ургах явцыг ажиглаж бичвэр мэдээллийг нягт нямбай хөтөлсөн<br>☐ Шугам, цаг, өсгөгч шил, термометр зэрэг хэмжигч багажийг зөв ашиглаж хэмжилт хийсэн<br>☐ Хэмжилтийнхээ үр дүнг хүснэгтэд зөв тэмдэглэсэн<br>☐ Үр дүнг зураг, диаграммаар зөв илэрхийлсэн | ☐ Ургамлын ургах явцыг ажиглаж бичвэр мэдээллийг тэмдэглэсэн боловч зарим нь алдаатай<br>☐ Шугам, цаг, өсгөгч шил, термометр зэрэг хэмжигч багажийн заримыг нь зөв ашиглаж хэмжилт хийсэн<br>☐ Хэмжилтийнхээ үр дүнг хүснэгтэд тэмдэглэхдээ зарим нэг алдаа гаргасан<br>☐ Үр дүнг зураг болон диаграммын аль нэг байдлаар зөв илэрхийлсэн | ☐ Ургамлын ургах явцыг ажиглаж бичвэр мэдээллийг ажлын хуудаст тэмдэглээгүй<br>☐ Шугам, цаг, өсгөгч шил, термометр зэрэг хэмжигч багажийг ашиглаж хэмжилт хийхдээ алдаа гаргасан<br>☐ Хэмжилтийнхээ үр дүнг хүснэгтэд зөв тэмдэглээгүй<br>☐ Үр дүнг зураг болон диаграммаар илэрхийлж чадаагүй |
| Хандлага | ☐ Аюулгүй байдлыг эрхэмлэхэд байнга анхаардаг<br>☐ Байгаль, хүрээлэн буй орчинд ээрэг ханддаг | ☐ Байнгын хэвшил болоогүй<br>☐ Хааяа алдаа гаргадаг | ☐ Саваагүйтэж аз туршсан үйлдэл хийдэг<br>☐ Байнга алдаа гаргадаг |
| Сурах хүсэл эрмэлзэл | ☐ Хичээлийн хэрэгслээ байнга ухаалаг зөв хэрэглэдэг | ☐ Хааяа | ☐ Ихэнхдээ |
| Санаачилга | ☐ Бусадтай хамтран ажилладаг, тэдэнд тусалдаг<br>☐ Багаар ажиллахдаа бусдад нөлөөлөл үзүүлж чаддаг | ☐ Бусадтай хамтран ажилладаг ч тэдэнд бага тусалдаг<br>☐ Багаар ажилладаг ч, бусдад нөлөөлөл багатай | ☐ Ганцаараа байх дуртай<br>☐ Бусдын үгийг сонсдоггүй |

## Хэрэглэгдэхүүн (сурах бичгийн 38-39 дүгээр хуудас).

МИНИЙ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭЛ

### ЯАЖ ХЭМЖИХ ВЭ?



Бид өмнөх ангиудад өөрийн хичээлийн хэрэглэл болон ангид байдаг сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрхэн хэрэглэх, хадгалах тухай үзсэн.

Туршилт хийхэд зайлшгүй ашигладаг зарим сургалтын багаж хэрэгсэлтэй танилцацгаая.



Хэрэглэгдэх зүйлс:

- Шилэн аяга
- Ус
- Шугам
- Өсгөгч шил
- Цаг
- Хөвөн
- Буудайн үр
- Халуун хэмжигч багаж (термометр)
- Цаг тооны бичиг
- Зургийн аппарат



**Туршилт 1.**

Туршилт хийх аргачлал

1. Чийгтэй хөвөн дэвссэн шилэн аяганд хэдэн ширхэг буудайн үрийг 2-3 см зайтай тараан байрлуулаарай.
2. Дараа нь шилэн аяганы амсрыг нь гялгар уутаар бүрхэж ба уутыг нүхэлж халуун хэмжигч багажийг шилэн аяганд дүрж байрлуулна.
3. Халуун хэмжигч багажийн заалтыг шилэн аяганы гаднаас харахад харагдаж байхаар байрлуулна.
4. Бэлэн болсон үрээ гэрэлтэй, дулаан байранд (цонхон дээр) тавиарай.
5. Өдөр бүр тогтсон цагт шилэн аяган доторх халууныг хэмжиж тэмдэглэнэ. Ангийн агаарын хэмэс ямар ялгаатай байгааг харьцуулан зөрүүг тэмдэглээрэй.
6. Мөн үрийн ургалтыг ажиглана. Ямар өөрчлөлт гарч байгаар өдөр бүр ажиглаж тэмдэглээрэй.
7. Үр соёолж эхлэнээс хойш өдөр бүр тогтсон цагт өндрийг нь хэмжээрэй
8. Үр дүнг баганан диаграммаар илэрхийлээрэй.
9. Навчийн судлыг ажиглаж дэвтэртээ зураарай.

Дээрх туршилтыг хийж үр дүнгээ гаргахад бид ямар багаж хэрэгслийг яаж ашиглах вэ? Төлөвлөөрэй.

25

МИНИЙ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭЛ

1. Шугам





Ихэнх тохиолдолд шугамаар уртыг хэмждэг боловч бид эгц шулуун зурах зорилгоор ч бас ашигладаг.

2. Термометр





Термометрийн заалтыг зөв харж тэмдэглэх нь чухал. Термометрийг унагаж хагалахаас болгоомжлоорой.

3. Өсгөгч шил





Ихэнх өсгөгч шил бодит байдлаас 2-25 дахин их өсгөдөг. Бидний нүдээр харагдахгүй зүйлийг өсгөгч шил ашиглан харна.

4. Зургийн аппарат





Ажигласан зүйлээ баримтжуулах зорилгоор зураг авч болно.

5. Цаг тооны бичиг, цаг

| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ургамлын өндөр (см) | | | | | | | |

Сар, өдөр, хугацаар тэмдэглэх зорилгоор ямар ч судалгаанд хэрэглэдэг.

26

МИНИЙ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭЛ

Туршилтын үр дүнг дараах хүснэгтэд тэмдэглээрэй.

| Асуулт | Сар. өдөр. цаг | Үр дүн |
|---|---|---|
| Хэдэн ширхэг үрийг хэдэн сантиметр зайтай байрлуулж үрслүүлсэн бэ? | | |
| Хаана, ямар газар байрлуулж ажигласан бэ? | | |
| Үрийн бүтэц, ургалтад ямар өөрчлөлт гарч байгааг тэмдэглээрэй. | | |
| Шилэн аяган доторх халууны хэм хэд байсан бэ? | Өдөр бүр 12 цагт харж тэмдэглэнэ. | Өдөр / $t^0$ |
| Тасалгааны агаарын хэм хэд байсан бэ? | Өдөр бүр 12 цагт харж тэмдэглэнэ. | Өдөр / $t^0$ |
| Температурын зөрүүг олоорой. | | Өдөр / Зөрүү |
| Ямар нөхцөлд үр ургасан вэ? | | |
| Соёолoлтын уртыг шугамаар хэмжиж баганан диаграмм байгуулаарай. | |   |
| Навчийн судлыг ажиглаад зураарай. Ямар судалтай болохыг багшаасаа асууж тэмдэглээрэй. | | |

$t^0$ -Шилэн аяган доторх халуун болон тасалгааны агаарын хэмийг тэмдэглээрэй.



Хүмүүс олон янзын хэмжих багажийг зохион бүтээж ашиглаж байна. *Уртыг хэмжих багаж* - төрөл бүрийн шугамыг ашиглан урт өргөн, зузаан нимгэн, мөн муруй шугамыг уртыг олж болно. Хэмжилт хийхдээ шугамын хуваарийг эгц харна. *Хугацааг хэмжих багаж* - хугацаар хэмжихдээ төрөл бүрийн цагийг хэрэглэсээр ирсэн. *Халуун хэмждэг багаж* - термометр. Термометрийн заалтыг эгц урдаас нь харж тэмдэглэнэ.

27

# 2.6. ХҮН БА НИЙГЭМ

## 2.6. А. БАГА БОЛОВСРОЛЫН ХҮН БА НИЙГЭМ ХИЧЭЭЛИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Боловсролын чанарын шинэчлэлийн тогтолцоо нь хүний төлөө тэднийг дэмжин хөгжүүлэх агуулгаар хүмүүнлэг үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн насан туршийн тасралтгүй хөгжлийг хангахад чиглэнэ. Иймээс сургууль нь нийгэм, олон нийтийн оролцоонд тулгуурласан, гэр бүл, нийгмийн хөгжилд үүрэг гүйцэтгэдэг хүний хөгжлийн төв болж хөгжих учиртай билээ. “Тогтвортой хөгжлийн зорилго 4- Боловсрол 2030-ийг дэлгэрүүлж ойлгох нь” гарын авлагад "Тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих” хэмээн тодорхойлсны зэрэгцээ тогтвортой хөгжлийн бүх зорилгод хүрэх түлхүүр нь боловсрол хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл ТХ-ийн 4 дэх зорилгын бүх зорилт нь сурах үйл явцыг үр өгөөжтэй болгож, тэгш хамрагдах боломжийг баталгаажуулахад чиглэгдсэн юм. Тэр дундаас ТХЗ 4.7 нь дэлхийн иргэн болон суралцахад чиглүүлсэн байгаа нь Хүн ба нийгэм хичээлтэй салшгүй холбоотой юм.

**Зорилт 4.7.** 2030 он гэхэд бүх сурагчид боловсролоор дамжуулан тогтвортой хөгжлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадварт, тухайлбал, тогтвортой хөгжил, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендэрийн тэгш байдал, энхтайван, хүчирхийллийг үл дэмжих соёлыг дэмжих, дэлхийн иргэн байх, тогтвортой хөгжилд соёлын оруулах хувь нэмэр, соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх зэрэгт суралцсан байна.

Бага боловсролын хүн ба нийгэм хичээлээр сурагчид өөрийн гэр бүл, сургууль, нутгийн нийгэм аж ахуй, соёлын амьдрал, эх орны түүхийн нэн гол үйл явдлуудтай танилцах явцдаа нийгэм хэрхэн зохион байгуулагдаж, хөгжиж байдаг, ямар дүрэм журмыг мөрддөг, хүмүүс өөрөөр үзэл бодол, хандлагаараа ялгарч байдаг, бас сурагч өөрөө бусдаас ямар ялгаатай юугаараа онцлог болох хувийн өвөрмөц соёл, нийгэмшлийг ойлгох, оролцох зэргээр боловсролоор дамжуулан хүний эрхийг хангах, энхтайвныг тогтоох, дэлхийн хэмжээний хариуцлагатай иргэн төлөвшүүлэх, жендэрийн тэгш байдал, тогтвортой хөгжил, эрүүл мэнд, сайн сайхан амьдралыг дэмжих зэрэг тогтвортой хөгжлийн гол үнэт зүйл, хандлагыг эзэмших боломжтой юм.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Хүн ба нийгэм хичээлийн цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэв, цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудтай хэрхэн холбогдож байгаа хамаарлыг хүснэгтээр харууллаа.

*ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвт хамаарах “хүн ба нийгэм”-ийн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт*

| | TX311.Сэ01. | TX303.Сэ05. | TX303.Сэ08. | TX311.Сэ05. | TX311.Сэ08. | TX312.Сэ03. | TX315.Сэ08 | TX317.Сэ05. |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТХ303.НСХ5 | | 5,1,а | | | | | | |
| ТХ303.ЗҮ1 | | 4,1,а | 4,3,е | | | | | |
| ТХ311.ТМ1. | | | | | 5,4,ө | | | |
| ТХ311.ТМ3. | | | | 5,4,г | | | | |
| ТХ311.НСХ5. | 4,2,б | | | | | | | |
| ТХ311.ЗҮ1. | 4,2,г | | | | | | | |
| ТХ312.ТМ1. | | | | | | 4,2,в | | |
| ТХ315.НСХ3. | | | | | | | 5,4,в | |
| ТХ317.НСХ5. | | | | | | | | 4,3,г<br>4,3,д<br>5,1,в |

Хүн ба нийгэм хичээлийн хам сэдвийн хүрээн дэх дэд сэдвүүд нь сурагчид өөрийн гэр бүл, сургууль, нутгийн нийгэм аж ахуй, соёлын амьдрал, эх орны түүхийн нэн гол үйл явдлуудтай танилцах явцдаа нийгэм хэрхэн зохион байгуулагдаж, хөгжиж байдаг, ямар дүрэм журмыг мөрддөг, хүмүүс өөр өөр үзэл бодол, хандлагаараа ялгарч байдаг, бас сурагч өөрөө бусдаас ямар ялгаатай юугаараа онцлог болох хувийн өвөрмөц соёл, нийгэмшлийг ойлгох, оролцоход чиглэгддэг тул ТХЗ03. Сайн эрүүл мэнд, сайн сайхан амьдрал, ТХЗ11. Тогтвортой хот суурин, оршин суугчид, ТХЗ12. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл, ТХЗ15. Газар дээрх амьдрал ТХЗ17 ТХЗ-ын төлөөх түншлэл гэсэн ТХЗБ-ын суралцахуйн зорилтуудтай уялдаж байна.

*ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвт хамаарах “хүн ба нийгэм”-ийн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын тоо*

| Ай | Таних мэдэхүй | Нийгэм, сэтгэл хөдлөл | Зан төлөв |
|---|---|---|---|
| Суралцахуйн зорилт | 3 | 6 | 3 |

Бага боловсролын хүн ба нийгэм хичээл нь хувь хүнийхээ хувьд хөгжих, төлөвших, болон тэдний хамт олон, гэр бүлийн, бүлгийн, нийгмийн гишүүн байх, нийгэм түүхийн үйл явдлыг сонирхох, ойлгох, түүнд оролцох, хэм хэмжээг баримтлан харилцах чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн тул нийгэмшил-сэтгэл хөдлөлийн айд хамаарах суралцахуйн зорилт илүү давамгай тусгагджээ.

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Хүн ба нийгэм хичээлээр эзэмших чадварыг сурагч бие даан болон хамтран ажилласны үр дүнд эзэмшинэ. Багш хичээлийг удирдан зохион байгуулахдаа үйл ажиллагааг зөв чиглүүлж, сурагчдыг хүрээлэн буй нийгэм соёлын бодит үйл явцтай танилцах, жишээ баримтад тулгуурласан тохиолдол шинжлэх, дүрийн тоглолт хийж үйл явдлыг ажиглах, эргэцүүлэх, хэлэлцэх замаар аливаа тулгамдсан асуудлыг ээрэгээр шийдвэрлэх, өөрийн үнэлэлт дүгнэлт өгөх, хамтран ажиллах чадварт сургах олон хэлбэрийн аргыг ашиглах хэрэгтэй. Иймээс ТБ-ын цогц чадамжид суурилсан бүтээлч аргыг эрэлхийлэхэд энэхүү зөвлөмж гарын авлага багшид хөтөч болох юм.

Өөрөөр хэлбэл ТБ-ын цогц чадамж, хүн ба нийгэм хичээлээр олгогдох тусгай чадваруудын харилцан уялдаатай болохыг дараах хүснэгтээс харж болно. Хүн ба нийгэм хичээлийг дараах хам сэдвийн хүрээнд IV ангид долоо хоногт 1 цаг, V ангид долоо хоногт 2 цаг судална.

*Хүн ба нийгэм хичээлээр эзэмшүүлэх чадварууд ТБ-ын цогц чадамжтай уялдах байдал*

| **ТБ-ын цогц чадамжууд** | **Хүн ба нийгэм хичээлийн тусгай чадвар** | **ТХБ-ыг эзэмшүүлэх нийтлэг арга зүй** | **Хам сэдэв** |
|---|---|---|---|
| Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж-4<br>Урьдчилан тооцоолох цогц чадамж-2<br>Хэм хэмжээний цогц чадамж-0<br>Стратегийн цогц чадамж-0<br>Хамтран ажиллах цогц чадамж-6<br><br>Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж-3<br><br>Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж-8<br><br>Асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамж-4 | Харилцах, хамтран ажиллах:<br>• Өөртэйгээ харилцах<br>• Бусадтай харилцах<br>• Бусадтай хамтран ажиллах | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | • Би, гэр бүл, сургуулийн амьдрал |
| | Асуудал шийдвэрлэх:<br>• Хүн ба нийгмийн холбогдолт асуудлыг олох, шийдвэрлэх<br>• Холбогдох мэдээллийг олох, ашиглах, боловсруулах | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, тохиолдол шинжлэх) | • Нутгийн хүмүүс, аж ахуй, соёлын амьдрал |
| | Нийгэм түүхийн үйл явдлыг мэдэх, ойлгох:<br>• Гэр бүл, сургуулийн хүрээний үйл явдлыг мэдэх, тайлбарлах<br>• Орон нутаг, эх орны нийгэм, түүхийн үйл явдлыг ойлгох, тодорхойлох | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр....) | • Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх үүрэг, хариуцлага |
| | Үнэт зүйлсийг эрхэмлэх:<br>• Түүх, соёл, уламжлал, зан заншлын үнэт зүйлсийг эрхэмлэх<br>• Өөрийн болон гэр бүлийн үнэт зүйлийг эрхэмлэх | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх) | • Миний эх орон-Монгол бахархал |

Эдгээрээс бага боловсролын хүн ба нийгмийн хичээлд дүрд хувирах, тохиолдол жишээ баримтыг шинжлэх, бодит үйл явдалд оролцох явцдаа эргэцүүлэх, тунгаах, үнэлэлт дүгнэлт өгөх ТХБ-ийн арга зүйг илүү түлхүү хэрэглэнэ. Тэрхүү аргуудыг хичээлд хэрэглэх тайлбар үндэслэлийг матриц 2-д тайлбарласан болно.

Багшийн сургалтад хэрэглэж буй арга нь сурагчдыг бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан мэдлэг бүтээлгэх, таамаглал дэвшүүлэх, эргэлзээ төрүүлэх улмаар бусдыг сонсож өөрийгөө илэрхийлэх, харилцан ярилцаж, санал бодлоо солилцох боломжийг олгоно.

***<u>Анхаарах зүйл:</u>***

- Сурагч бүрт бүтээлч сэтгэлгээ, итгэл, үнэмшил, үнэт зүйл, чадвар, чадамж төлөвших боломжийг хангах
- Сурагчийн төлөвших, хөгжих, чадваржих хэрэгцээнд тулгуурлах
- Багш сургалтын хөтөлбөрийг хөгжүүлж, баяжуулах боломжтой байх
- Агуулгыг дахин боловсронгуй болгох, ерөнхий боловсролын түвшин бүрийн агуулгын зохистой харьцаа тогтоох, онолын болон практик чадварын шүтэлцээг хангах
- Нийгмийн ухааны тогтсон үг хэллэг, нэр томьёог хэрэглэх

*Хүснэгт 2.17*. *Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хүн ба нийгэм)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги 4 | Анги 5 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Арга зүй: Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Арга зүй: Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Арга зүй: Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | Арга зүй: Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/өнгөрснийг нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар / суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Цогц чадамж: Код | Цогц чадамж: Үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 | 7 | | | | 8 | 9 | 10 |
| 1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал | 4, 01.а. Гэр бүл, сургуулийн орчинд өөрийн бодол санаа, хүсэлтийг илэрхийлэн харилцах | ☐ | | ТХ303.ЗҮ1 | ТХ303.Сэ05 | Сайн сайхан байдал, амьдралын чанарын талаарх ойлголттой болж, гэр бүл, сургуулийн орчинд өөрийн бодол санаа, хүсэлтийг илэрхийлэн харилцах, эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутамдаа хэвшүүлэхтэй холбоотой. | ☐ | | | | 1-Хог хаяхгүй, эрүүл зөв зан үйлийг харуулсан видео үзэх, сайн сайхан байдлын утга учрыг тайлбарласан үйл ажиллагаанд оролцох /Сурах бичгийн 4-5-р хуудас/ | 2, 8 | 2-Үйл явдлыг ойлгож, үйлийн үр дагаврыг үнэлж дүгнэх чадвартай болно.<br>8- Сургуулийн орчинд дүрэм журам мөрдөж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, анги сургуулийн орчинд болж буй зарим зөрчилтэй асуудлыг эерэгээр шийдэх чадвартай болно. |
| 2. Нутгийн хүмүүсийн нийгэм, аж ахуй, соёлын амьдрал | 4, 02.б. Орон нутгийн аж ахуй, үйлдвэрлэл, соёл, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг мэдэх, оролцох | ☐ | | ТХ311.НСХ5 | ТХ311.Сэ01 | Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээний газруудаар үйлчлүүлэхдээ тусгай эрэлт хэрэгцээг хангасан байдлыг ухамсарлан зөв, соёлтой үйлчлүүлж байгаа нь нийгэм соёлд нөлөөлж үүрэг хариуцлагаа мэдрэхтэй холбоотой. | | ☐ | | ☐ | 2- Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаар танилцах аялал хийх<br>4- Аюулгүй байдлыг бий болгох, үйл ажиллагаанд оролцох төлөвлөгөө боловсруулах /Өөрийн оршин суугаа газарт орших үйлчилгээний байгууллагаар жишээ авна./ | 7, 8 | 7- Орон нутгийн түвшинд үйл ажиллагаанд оролцож, өөрийн үүрэг оролцоог бодох, тунгаах чадвар нэмэгдэнэ.<br>8- Үйлчилгээний газруудад өөрийн болон бусдын эрх үүргийг зөв зохицуулж оролцох, аливаа маргаантай асуудлыг эерэгээр шийдэх чадвар нэмэгдэнэ. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. Нутгийн хүмүүсийн нийгэм, аж ахуй, соёлын амьдрал | 4, 02.в. Орон нутгийн үйлчилгээний газруудыг үүрэг, үйл ажиллагаагаар нь ялгах, тайлбарлах | □ | | ТХ312.ТМ1 | ТХ312.Сэ03 | Орон нутгийн үйлчилгээний газруудыг үүрэг, үйл ажиллагаатай танилцаж, хувийн амьдралын хэв маягийн сонголт хэрэглээ болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөөг ойлгохтой холбоотой. | | | □ | | 3- Орон нутгийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, дэлгүүрийн худалдагч, хэрэглэгч болох зэргээр дүрд хувиран тоглох /Өөрийн оршин суугаа газарт ойр орших үйлчилгээний байгууллагаар жишээ авна./ | 5, 7 | 5- Бусдыг ойлгож, харилцан хамааралтай байж, мэдрэмжтэй ажиллах чадвартай болно.<br>7- Орон нутгийн түвшинд үйл ажиллагаанд оролцож, өөрийн үүрэг оролцоог нэмэгдүүлнэ. |
| 2. Нутгийн хүмүүсийн нийгэм, аж ахуй, соёлын амьдрал | 4, 02.г. Сурагч орон нутгийн нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулах | □ | | ТХ311.ЗҮ1. | ТХ311.Сэ05 | Сурагч орон нутагтаа мод тарих, тэмдэглэлт үйл ажиллагаанд оролцох явцдаа тогтвортой хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх байдлаар суурьшилд хэрхэн дасан зохицохыг ойлгож, орон нутгийн нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулахтай холбоотой. | □ | | □ | | 1- Орон нутгийн нийгмийн амьдралд хувь нэмэр оруулахын тулд тэмдэглэлт өдрийг хэрхэн өнгөрүүлэх аян, компанит ажил, үйл ажиллагаанд оролцох /Сурах бичгийн 24-25-р хуудас/<br>3- Орон нутгийн амьдралд оруулж буй хувь нэмрийн талаар эргэцүүлэхийн тулд сургуулийн түүхийг судалж хэлэлцүүлэг хийх / Сурах бичгийн 27-р хуудас/ | 5, 1 | 5-Бусдын хэрэгцээ, шаардлага, үзэл бодол, үйл хөдлөлийг хүндэтгэх чадвартай болно.<br>1- Аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэх, ойлгож, орон нутгийн нийгмийн амьдралд хувь нэмрээ оруулж чаддаг болно. |
| 3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх, үүрэг, хариуцлага | 4, 03.г. Хувь хүн өөртөө ямар үүрэг, хариуцлага хүлээхийг ойлгох, биелүүлэх, үнэлэх | □ | | ТХ317.НСХ5 | ТХ317.Сэ05 | Хувь хүн өөртөө ямар үүрэг, хариуцлага хүлээхийг ойлгож, өөрсдийн үнэт зүйлс, хариуцлагыг мэдэрч, үүргээ биелүүлж, тогтвортой хөгжлийн төлөөх өөрчлөлтийг бүтээгч иргэн болон төлөвших үйлийг үнэлэхтэй холбоотой. | □ | | □ | | 1- Чанартай боловсролын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулахад чиглэсэн сурталчилгааны компанит ажил төлөвлөн хэрэгжүүлэх<br>3- Сургууль хамт олны дунд хувь хүний хүлээх үүрэг хариуцлагыг мэдрүүлэх тохиолдол жишээ баримт дээр тулгуурлан дүрийн тоглолт хийх /Өөрийн ангийн дүрэм, сургуулийн дүрмийг судлах/ | 5, 7, 8 | 5- Бусдыг ойлгож, харилцан хамааралтай байж, мэдрэмжтэй ажиллах чадвартай болно.<br>7- Орон нутгийн түвшинд үйл ажиллагаанд оролцож, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох чадвартай болно.<br>8- Тусгай хэрэгцээ шаардлагыг хангасан эрх тэгш хувилбарыг боловсруулах чадвартай болно. |
| 3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх, үүрэг, хариуцлага | 4, 03. д. Өөрийн нийгэм соёлын орчны талаар мэдэх, түүнээс суралцах, нөлөөлөх | □ | | ТХ317.НСХ5 | ТХ317.Сэ05 | Өөрийн нийгэм соёлын орчны талаар мэдэх, түүнээс суралцах байдлаар нийгэм соёлын үнэт зүйлсийг, хариуцлагыг мэдэрч, тогтвортой хөгжлийн төлөөх өөрчлөлтийг бүтээгч дэлхийн иргэн болоход нөлөөлөхтэй холбоотой. | | □ | | | 2- Сонгож авсан тодорхой нэг нутагт эсвэл нийгмийн тодорхой хэсгийн нийгэм соёлын орчны талаар тохиолдол баримт цуглуулж шинжилгээ хийх /Сургуулийнхаа түүхийг судлах, сургуулийн номын сангаар аялах/ /Сурах бичгийн /29-р хуудас Суут хүмүүс ном их уншдаг/ | 1, 5 | 1- Аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэх, ойлгох чадвартай болно.<br>5- Бусдаас суралцах, бусдыг ойлгож, харилцан хамааралтай мэдрэмжтэй байх чадвар хөгжинө. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх, үүрэг, хариуцлага | 4, 03.е. Өөрийн аюулгүй байдлыг хангах талаар ойлгох, холбогдох шийдвэр гаргах | ☐ | | ТХ303.ЗҮ1 | ТХ303.Сэ08 | Машинаас буух суухдаа даруулга, бүс заавал хэрэглэх, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, гэрлэн дохиогоор зорчих зэрэг зам тээврийн осол аюулгүй байдлыг хангах талаар ойлгож, эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлж, зөв шийдвэр гаргахтай холбоотой. | ☐ | | | ☐ | 1- Сургууль, гэр бүлийн орчинд аюулгүй байдлаа хангаж үйл ажиллагаанд оролцох, боловсролын байгууллагын үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагатай түншлэлийг хөгжүүлэх<br>4- Сургууль, гэр бүл, хороо дүүрэг хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, шийдвэр гаргах /Сурах бичгийн 53-57-р хуудас/ | 6, 7 | 6- Тогтсон хэм хэмжээ, дадал туршлага, санаа бодолд асуудал дэвшүүлэх чадвартай болно.<br>7- Орон нутгийн түвшинд үйл ажиллагаанд оролцож, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох чадвартай болно. |
| 1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал | 5, 01. а. Гэр бүл, найз нөхөд, үе тэнгийнхэн, сургуулийн багш, ажилтан, ахмад хүмүүст өөрийгөө зөв илэрхийлэн харилцах | | ☐ | ТХ303.НСХ5. | ТХ303.Сэ05 | Сайн сайхан байдлын төлөө уучлалт гуйх, эелдгээр мэндлэх зэргээр өөрийн хүлээх үүрэг оролцоогоо нэмэгдүүлж, амьдралын чанарын талаарх философи ухагдахууны хүрээнд гэр бүл, найз нөхөд, үе тэнгийнхэн, сургуулийн багш, ажилтан, ахмад хүмүүст өөрийгөө зөв илэрхийлэн хүндэтгэн харилцахтай холбоотой. | ☐ | | ☐ | | 1-Эрүүл зан үйлийг харуулсан видео үзэх, сайн сайхан байдлын утга учрыг тайлбарласан үйл ажиллагаанд оролцох<br>3- Найз нөхөд, ахмад хүмүүстэй харилцах аялал уулзалт зохион байгуулахдаа уучлаарай, намайг сонс доо, чи юу гэж бодож байна зэрэг үгийг сонгож хэрэглэх / Сурах бичиг 6-11/ | 1, 2, 5 | 1- Аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэх, ойлгох чадвартай болно.<br>5- Бусдаас суралцах, бусдыг ойлгож, харилцан хамааралтай мэдрэмжтэй байх чадвар хөгжинө. |
| 1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал | 5, 01.в. Хүмүүсийн ялгаатай байдлыг / нас, хүйс, нийгэм, соёлын гэх мэт/ мэдэж, харилцаж чаддаг болох | | ☐ | ТХ317.НСХ5 | ТХ317.Сэ05 | Сурагч миний эрх бусдын эрхээр хязгаарлагддаг шүү гэдгийг мэдэрч, хүмүүсийн ялгаатай байдлыг хүндэтгэн харилцах, хүний эрхээс үүдсэн бусадтайгаа өөрсдийн үнэт зүйлсийг, хариуцлагыг хамтран үүрэх нийтлэг шинжийг мэдрэх чадвартай иргэн болон төлөвшихтэй холбоотой. | | ☐ | ☐ | | 2- Хүмүүсийн ялгаатай байдлыг задлан шинжлэх тохиолдол, жишээ баримтад шинжилгээ/ судалгаа хийх аргад үндэслэн хүмүүсийн ялгаатай байдал, онцлог шинжийг илрүүлэх<br>3-" Хулгар шар" сэдвийг уншиж амьтдын дүрд хувилан тоглох замаар зам тавих боломжтой эсэхийг задлан шинжилж зөв шийдвэр гаргах, хариуцлага хүлээх чадвартай болох /Сурах бичиг 13-15/ | 7, 8 | 7- Тохиолдол, жишээ баримт шинжилж, дүрд хувиран тоглосноор дэлхийн болон орон нутгийн түвшинд өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох чадварыг хөгжүүлнэ.<br>8- Бэрхшээлтэй байгаа асуудлыг шийдвэрлэх, өөрийгөө таньж мэдэх цогц чадамжид өөрчлөлт орно. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.Миний эх орон Монгол бахархал | 5, 04.б. Эх орныхоо байгалийн онцлог, үзэсгэлэнт газруудыг таньж мэдэх | | ☐ | ТХ315.НСХ3 | ТХ315.Сэ08 | Орон нутгийн байгаль орчинтой харилцаж, хүмүүс амьд байгалийн нэг хэсэг бөгөөд тэдний байгальтайгаа холбогдох байдлыг ойлгон, эх орныхоо байгалийн онцлог, үзэсгэлэнт газруудыг таньж мэдэхтэй холбоотой | ☐ | | ☐ | | 1- Эх дэлхийн өдөр, Дэлхийн хүрээлэн буй орчны өдөр зэргийг тус тус тэмдэглэхдээ байгаль дэлхийгээ хамгаалах үйл ажиллагаанд оролцох<br>3- Эх орныхоо байгалийн үзэсгэлэнт газраар аялал экскурс хийх, түүнийгээ хайрлах хамгаалах сэдэл бүхий видео клип хийх /Сурах бичгийн 27-30-р хуудас/ | 6, 7 | 6- Тогтсон хэм хэмжээ, дадал туршлага, санаа бодолд асуудал дэвшүүлэх чадвартай болно.<br>7- Орон нутгийн түвшинд үйл ажиллагаанд оролцож, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох чадвар нэмэгдэнэ. |
| 4.Миний эх орон Монгол бахархал | 5, 04.г. Монгол хүний ахуй, амьдрал, эрхлэх аж ахуйн онцлогийг тодорхойлж чаддаг болох | | ☐ | ТХ311.ТМ3 | ТХ311.Сэ05 | Монгол хүний ахуй, амьдрал, эрхлэх аж ахуйн онцлог нүүдлийн соёлоос суурин амьдралын хэв маяг руу шилжсэн түүхэн шалтгааныг ойлгож, соёлын өв уламжлалыг хүндэтгэн, суурин амьдралд зохицон амьдрах чадвартай холбоотой. | ☐ | | ☐ | | 1- Монгол ахуй амьдрал, эрхлэх аж ахуйн онцлогоос суралцах судлах үйл ажиллагаанд оролцох<br>3- Соёлын өв уламжлал, ахуй амьдралын онцлогийг хэрхэн хадгалан үлдэх талаар эссэ бичих, хэлэлцүүлэг өрнүүлэх | 1, 5 | 1- Аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэх, ойлгох чадвартай болно.<br>5- Бусдаас суралцах, бусдыг ойлгож, харилцан хамааралтай байх мэдрэмж нэмэгдэнэ. |
| 4.Миний эх орон Монгол бахархал | 5, 04.е. Ардчилсан Монголын нийгэм, аж ахуй, соёлын ололт, амжилтаас тодорхойлж чаддаг болох | | ☐ | ТХ311.ТМ1 | ТХ311.Сэ08 | Хүний материаллаг, сэтгэлзүйн, нийгмийн сууръ хэрэгцээ, олон нийт, тэдний хөгжил, хөдөлгөөн, орон нутгийнхан, хот суурингийн өөрчлөлт хувиралтыг ойлгож,ардчилсан Монголын нийгэм, аж ахуй, соёлын ололт, амжилтыг тодорхойлдог болохтой холбоотой. | | | ☐ | ☐ | 3- Хүний суурь хэрэгцээ, хөгжил хөдөлгөөний өөрчлөлт болон тогтвортой хот суурин харуулсан 2 мин видео клип хийх<br>4- Илүү сайхан нийгмийг цогцлоох хэтийн зорилгоо тодорхойлж, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах<br>/Сурах бичгийн 35-р хуудас/ | 6, 7 | 6- Тогтсон хэм хэмжээ, дадал туршлага, санаа бодолд асуудал дэвшүүлэх чадвартай болно.<br>7- Орон нутгийн түвшинд үйл ажиллагаанд оролцож, өөрийн үүрэг оролцоог тунгаан бодох чадвар нэмэгдэнэ. |

## 2.6.Б. НЭГЖ ХИЧЭЭЛ: НУТГИЙН АМЬДРАЛД ХҮҮХЭД БИДНИЙ ОРОЛЦОО

### Нэгж хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр

Нутгийн амьдралд хүүхэд бидний оролцоо сэдвийн хүрээнд Монголчууд голлон эрхэлдэг аж ахуй, мал аж ахуйн болон газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах арга технологийн талаар сонсох, судлах, нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн ялгаа, үүнд хүүхдийн оролцоо ямар байж болохыг харилцан ярилцаж, гэр бүл, өрхийн аж ахуй, нийгмийн амьдралд өөрийн хувь нэмрээ оруулахын ач холбогдлыг ойлгоход оршино.

ТХБ нь хүмүүсийн мэдлэг, чадвар хандлага, үйлдэл, үнэ цэнийг өөрчлөхийг зорьдог бөгөөд үүний тулд багш та дараах чадварыг хөгжүүлэх нь чухал:

1. Ирээдүйг төсөөлөн харах чадвар;
2. Шүүмжлэлтэйгээр тунгаан бодох чадвар;
3. Цогцоор нь харах чадвар;
4. Оролцоотой байх буюу шийдвэр гаргахад оролцох чадвар;

Энэ ч утгаараа тогтвортой хөгжлийг бий болгох урьдчилсан нөхцөл нь “Нийгмийн бүх бүлгүүд өөрт оногдсон хариуцлагаа мэдэж, энэхүү үйл явцад жинхэнэ ёсоор оролцох” явдал буюу “Хамтын үйл ажиллагаанд оролцох шинэ хэлбэрүүд” хэмээн “Agenda 21”–д тодорхойлсон байдаг. Тиймээс орон нутгийн хөгжилд миний оруулах хувь нэмэр юу билээ гэдгийг эргэцүүлэн бодож, сурагчдын өөрийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү нэгжийн төлөвлөлтийг санал болгож байна.

Бага боловсролын цөм хөтөлбөрийн зорилгыг ТХЗБ-ын суралцахуйн зорилтуудтай интеграц хийх боломжийг харуулахын тулд IV ангийн цөм хөтөлбөрөөс “Нутгийн хүмүүсийн амьдрал” бүлгийн “Нутгийн амьдралд хүүхэд бидний оролцоо” сэдвийг сонгон авлаа.

Сурагч нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн ялгааг мэдэх, оролцоотой байдалд үндэслэн орон нутаг хөгжинө гэдгийг ойлгож, үүнд хүүхэд бидний оролцоо ямар байж болохыг ярилцаж, аливаа үйл ажиллагааг зохион байгуулах, түүнд оролцох эрмэлзэлтэй болгох нь энэхүү нэгжийн гол зорилго бөгөөд гэр бүл, сургууль, орон нутгийн түвшинд хүүхдийн оролцох хүрээ хэрхэн нэмэгдэж буйг ойлгуулах байдлаар цөм хөтөлбөрийн агуулга гүнзгийрч байгаа болно. Өмнөх бүлэг сэдвүүдэд гэр бүл дэх миний оролцоо, сургууль дахь миний оролцоо юу вэ гэдгээ хүүхэд судалсан, дүгнэсэн байгаа тул энд орон нутгийн нийгмийн амьдралд хүүхэд бидний оруулах хувь нэмэр ямар байх боломжтой болохыг бодож, эргэцүүлж, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн болно.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ ТХЗБ-ын сэдэв → | ТХЗ11.Сэ01. Орон гэр, аюулгүй байдал, тусгай эрэлт хэрэгцээг хангасан байдал (inclusiveness)-ын хэрэгцээ: хувийн, хамт олны өөр өөр хүсэл, хэрэгцээг жендэр, нас, орлого, чадварын дагуу хам нөхцөлд нь холбон үзсэн, хүний хэрэгцээ |
| ТХЗ11.ЗҮ1. Сурагч орон нутгийнхаа олон нийтэд суурилсан тогтвортой хөгжлийн төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх чадвартай болох | **Нутгийн амьдралд хүүхэд бидний оролцоо**<br>4, 2.г. Сурагч орон нутгийн нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулах<br>↑ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| **4.** | **5.** | **6.** |
| ТХ311.ЗҮ1. | ТХ311.Сэ01. | Сурагч орон нутагтаа мод тарих, тэмдэглэлт үйл ажиллагаанд оролцох явцдаа тогтвортой хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх байдлаар суурьшилд хэрхэн дасан зохицохыг ойлгож, орон нутгийн нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулахтай холбоотой. |

Бага боловсролын түвшинд хүн ба нийгмийн хичээлээр өөрсдийн амьдарч буй нийгэм, хүмүүсийг илүү сайн ойлгох, хамт олон, гэр бүлийн гишүүн гэдгийг мэдрүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох, нийгмийн аливаа асуудалд өөрийн хувь нэмрийг оруулах арга зүйг төлөвлөж, эргэцүүлэх, шүүмжлэлтэй хандах, үнэлэлт өгөх чадварыг хөгжүүлэхэд анхаарна.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх ТХБ-ын арга зүйн сонголт, хувь нэмэр оруулах боломжтой ТБ-ын цогц чадамжийг тодорхойлсон үндэслэл (матриц 2-ын 8, 10 дугаар баганыг харна уу)*

| Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар | Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар |
|---|---|
| **8.** | **10.** |
| 1-Орон нутгийн нийгмийн амьдралд хувь нэмэр оруулахын тулд тэмдэглэлт өдрийг хэрхэн өнгөрүүлэх аян, компанит ажил, үйл ажиллагаанд оролцох /Сурах бичгийн 24-25 дугаар хуудас/<br>3-Орон нутгийн амьдралд оруулж буй хувь нэмрийн талаар эргэцүүлэхийн тулд сум, дүүргийн түүхийг судалж хэлэлцүүлэг хийх / Сурах бичгийн 27дугаар хуудас/ | 5-Бусдын хэрэгцээ, шаардлага, үзэл бодол, үйл хөдлөлийг хүндэтгэх чадвартай болно.<br>1- Аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэн ойлгож, орон нутгийн нийгмийн амьдралд хувь нэмрээ оруулж чаддаг болно. |

## Нэгж хичээлийн төлөвлөлт

***Нэгж хичээлийн сэдэв:*** Нутгийн амьдралд хүүхэд бидний оролцоо

***Хамрах хүрээ:*** IV анги

***Нэгж хичээлийн зорилго:*** Сурагч орон нутгийн нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулах

***Зорилт:*** Нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн ялгааг мэдэх, нутгийнхаа хөгжил, нутгийн зохион байгуулсан ажилд оролцох хүсэл эрмэлзэл бий болох

***Түлхүүр үг:*** оролцоо

***Арга зүй:*** Суурь, бүрэн дунд боловсролын нийгмийн ухааны агуулгыг сурагчдад эзэмшүүлэхдээ шинжлэн судлах арга барилыг сургалтад түлхүү ашигладаг билээ. Тэрхүү шинжлэн судлах арга барилыг төлөвшүүлэх суурь тулгуур ухагдахуун болгож энэхүү сэдвийг бодох, эргэцүүлэх, судалж хэрэгжүүлэх алхам бүхий үйл ажиллагаанд сурагчдыг сургахад анхаарна.

***Ярилцах асуулт*:**

1. Аливаа үйл ажиллагаанд оролцохын ач холбогдол юу вэ?
2. Нутаг орноо хөгжүүлэхэд хүүхэд бид хэрхэн оролцог вэ?
3. Хүүхэд бүр эрүүл, ногоон орчинд тоглож, хөгжих эрхээ эдлэхийн тулд нутгийн хөгжилд хэрхэн хувь нэмрээ оруулах вэ?

***Суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөхдөө:***

- Нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн ялгааг мэдэх, Үр дүнд нь орон нутаг хөгжил цэцэглэлтийг мэдэрнэ.
- Үүнд хүүхдийн оролцоо ямар байж болохыг ярилцах, Үр дүнд нь зохион байгуулагдах үйл ажиллагаанд оролцох эрмэлзэл бий болгохын тулд бод, эргэцүүл, судал, гүнзгийрүүл, хэрэгжүүл гэсэн алхам бүхий үйл ажиллагаанд сурагчдыг оролцуулна.

| Судлах үе шат | Алхамчлал | Хугацаа |
|---|---|---|
| БОД<br>ЭРГЭЦҮҮЛ<br>СУДАЛ | - Орон нутгийн хөгжилд оролцох нь яагаад чухал вэ гэсэн асуудал дэвшүүлж бодох<br>- Хүүхдийн оролцоо гэдэг тодорхойлолтыг уншиж, эргэцүүлэх<br>- Сурах бичгийн 26 дугаар хуудасны жишээ ашиглан Ротерийн оролцооны шатлалын дагуу ярилцах | 40 мин |
| ГҮНЗГИЙРҮҮЛ | - Сурах бичгийн 24-25 дугаар хуудасны мэдээлэлтэй танилцаж, ТХБ-ын тулгуур гурван баганад хэрхэн холбогдох, байгаль орчноо хамгаалах боломжийг ярилцах | 40 мин |
| ХЭРЭГЖҮҮЛ | - Байгаль орчноо хамгаалах, орон нутгаа хөгжүүлэхэд бид хэрхэн оролцох боломжтойг гүнзгийрүүлэн судалж, түүнд оролцох | 40 мин |

*Энэхүү түлхүүр үйл үг нь сурагчийн цогц чадамжийг хөгжүүлэх хөтөч болно.*

**БОД**

**ЭРГЭЦҮҮЛ**

**СУДАЛ**

**ГҮНЗГИЙРҮҮЛ**

**ХЭРЭГЖҮҮЛ**

**БОД**

Үйл ажиллагаа 1: *Орон нутгийн хөгжилд оролцох яагаад чухал вэ?*

Асуудал дэвшүүлж сурагчдын санаа бодлыг бөмбөг ойх буух арга ашиглан, үр дүнг самбарт тэмдэглэнэ. Сурагч бүр хариулах албагүй. Гэхдээ найзыгаа сонсоод өөр нэмэлт санааг хэн гаргах вэ гэдэг асуулт тавьж бусдын саналыг давхцуулахгүй байхад анхаараарай.

1. Бөмбөг ойх, буух арга-тухайн өрөөгөөр бөмбөг дамжуулж хариултаа хэлнэ. Оролцогчдод илүү сайн хариултыг олохын тулд өөрөө хэнээс хариулт хүсэж байгаа тэр хүн рүү бөмбөгийг дамжуулна. Энэхүү арга нь ташаа ойлголтын талаар илүү сайн тунгаах боломж олгоно.

**ЭРГЭЦҮҮЛ**

Үйл ажиллагаа 2: *Хүүхдийн оролцоо гэдгийг хэрхэн ойлгох вэ?*

2. Хүүхдийн оролцоо гэдэг нь хүүхэд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргахад нөлөөлөх, өөрчлөлт хийхэд олгогдсон боломж юм.

1. Хүүхдийн оролцоо гэсэн тодорхойлолтыг багш самбарт байршуулна.
2. Сурах бичгийн 26 дугаар хуудасны зургуудыг ажиглаад хүүхдүүд ямар үйл ажиллагаанд оролцож буйг ярилцана.
3. Багш тодорхойлолтоос ойлгож авах түлхүүр санааг оюуны зураглалаар илэрхийлнэ.
4. Зураглал гаргахдаа багшид зориулсан нэмэлт мэдээлэлтэй танилцаж, оролцооны шатлал, оролцооны гурван талт зарчимд үндэслэн хүүхэд ямар оролцоог хүсдэг болохыг ойлгуулна.

3. Оюуны зураглал арга нь тодорхой нэг ухагдахууныг түүнд хамаарах дэд хэсгүүдэд задлан, үг болон зургаар цацраглан дүрсэлсэн диаграмм буюу мэдээллийг харааны түвшинд илэрхийлэхэд ашиглагдах бүдүүвч зураг юм.

Хүүхдийн оролцоо гэдгийг ойлгуулахад дараах аргуудыг хэрэглэх боломжтой.

_4.багшид өгөх нэмэлт мэдээлэл_

ОРОЛЦОО

БОЛОМЖ ЭРХ ХӨГЖИЛ ҮҮРЭГ/ХАРИУЦЛАГА

**Хүүхэд ямар оролцоог хүсдэг вэ?**
- Өөрийгөө таньж, мэдэх үнэлэх
- Өөрийн үзэл бодлоо илэрхийлэх
- Өөрийнхөө сонирхсон зүйлийг хийх, хийхэд оролцох
- Өөрт нь хамаатай асуудлаар саналаа хэлэх, шийдвэр гаргахад оролцох
- Мэдээлэл авах, түүнийгээ бусадтай хуваалцах
- Бусдаас суралцах, бусдын дэмжлэг авах

**Хүүхдийн оролцоог хангаж ажиллахдаа:**
- Хүүхдийн эрхэд суурилсан арга зүйд тулгуурлах
- Хүүхдийн оролцоо ба хамгааллыг чухалчлах
- Хүүхдийн сайн дурын оролцоог чухалчлах
- Хүүхдийн санал, бодлыг сонсох, сайн ойлгох, аливаа ажлыг төлөвлөхдөө тусгах
- Хүүхдийн гаргасан шийдвэрт хүндэтгэлтэй хандах, дэмжих, зөвлөх
- Ялгаатай байдлыг харгалзан үзэх
- Ялгаварлахгүй байх




## ГҮНЗГИЙРҮҮЛ

<u>Үйл ажиллагаа 3:</u> *Та бүхэн гэр, сургууль, орон нутагтаа ямар, ямар үйл ажиллагаанд оролцдог вэ?*

1. Аливаа үйл ажиллагаанд оролцохын давуу тал болоод бэрхшээлтэй тал нь юу болох талаар ярилцаж, шооны аргаар мэдээллээ солилцоно.
2. Багийн гишүүд шоог ээлжлэн орхиж, харгалзах талд оногдох асуудлаар санаа бодлоо цэгцэлнэ. /Гэр бүл, сургууль, орон нутгийн түвшинд оролцох хүрээг сайн тал-бэрхшээл гэсэн талаас нь тунгаан бодно/

Шооны арга нь оюуны үйлийг дэмжихэд хэрэглэгддэг бол энэ удаад сурагчдын жигд оролцоог хангахад чиглэгдлээ.

4. Шооны арга нь оюуны үйлийг олон талаар дэмжиж, нөхөх, ажиглах, холбох, харьцуулан жиших, дүгнэлт гаргах, ялгах, ангилах, асуудал дэвшүүлж шийдвэрлэх зэргээр хувирган өөрчилж харьцуулан жиших үйл ажиллагаа юм.

Шооны тал:

1. Гэртээ-сайн тал
2. Гэртээ- бэрхшээл
3. Сургуульдаа-сайн тал
4. Сургуульдаа- бэрхшээл
5. Орон нутагт- сайн тал
6. Орон нутагт-бэрхшээл

<u>Үйл ажиллагаа 4:</u> *Нутгийн амьдралд бидний оруулах хувь нэмэр*

1. Багийн зохион байгуулалтад орно. /4 баг/
2. Сурах бичгийн 24-25 дугаар хуудасны мэдээллээс баг бүр нэгийг сонгон авна.
3. Энэхүү мэдээлэлтэй танилцаж, хүүхдийн оролцож хийж чадах зүйлийг өнгөөр тэмдэглэнэ.
4. Зэрэгцүүлэн тэмдэглэл хөтлөх явцдаа "Нутгийн амьдралд хүүхэд бидний оруулах хувь нэмэр" сэдвээр танилцуулга бэлдээрэй.

5. Зэрэгцүүлэн тэмдэглэл хөтлөх арга нь -Өгөгдсөн санааг тусган авахдаа утга санааг нь шүүн тунгааж өөрийн үзэл бодлыг бусдынхтай харьцуулан эргэлзээтэй талыг илрүүлэх чадвартай болгох арга юм.

*Бага ангийн сурагчдын хувьд мэдээлэл уншаад, хийж чадах ажлыг өнгө ялган будах хэлбэрээр энэхүү аргыг хэрэглээрэй.*

**ХЭРЭГЖҮҮЛ**

<u>Үйл ажиллагаа 5:</u> *Байгаль орчноо хамгаалахын тулд бид юу хийж чадах вэ?*

1. Багийн танилцуулгад дурдагдсан ажлуудыг ТХБ-ын тулгуур гурван багана байгаль, нийгэм, эдийн засгийн алинд илүү холбогдох болохыг ярилцаж өнгийн картан дээр хийх зүйлээ бичиж, харгалзуулан наана.
2. Байгаль орчноо хамгаалахын тулд юу чадах талаар баг бүр нэг санаа дэвшүүлнэ.
   2.1. Мод тарих үйл ажиллагаанд оролцох
   2.2. Албан байгууллага, анги танхимд цэцэг тарих
   2.3. Хаягжуулах, зүлэгжүүлэх




3. Сурах бичгийн 26 дугаар хуудасны дүгнэлт мэдээллийг уншиж, анги хамт олноороо өөрсдийн эрүүл аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд бичил төсөл хөтөлбөр боловсруулж ажиллах шийдвэр гаргана.

***<u>Үнэлгээ:</u>***

Үйл ажиллагаа бүрт хүүхдийн жигд оролцоог хангаж, өөрсдийн үйлд үнэлэлт дүгнэлт өгөх аргад сургахын тулд ажиглалт тэмдэглэл хөтлөн, явцын үнэлгээ хийнэ.

Багш явцын үнэлгээ хийх асуулт, даалгавар, богино хэмжээний эссэ бичих, ярилцлага хийх зэрэг аль тохиромжтой аргыг төлөвлөнө. Сурагчдын өөрийн үнэлгээ хийх, тэдний ахиц өөрчлөлтийг тэмдэглэх ажиглалтын хуудас зэргийг боловсруулан хөтөлнө.

# 2.7. АНГЛИ ХЭЛ



## 2.7. А. БАГА БОЛОВСРОЛЫН АНГЛИ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

“Гадаад хэлний боловсролыг хүн төрөлхтний соёлын үнэт зүйл болохынх нь хувьд хүртэж өөрийн орны тогтвортой хөгжлийг хангах, даяаршлын эрин үед олон хэлний мэдээллийн орчинд өөрийн гэсэн байр сууриа олох” зорилготой гадаад хэлийг судлах тухай гадаад хэлний боловсролын стандартад тусгасан байдаг. Үүнтэй уялдуулан нийгмийн болон хувь хүний хэрэгцээ шаардлагын дагуу ЕБС-ийн англи хэлний боловсролын агуулга, арга зүй шинэчлэгдэн одоогийн сургалтын хөтөлбөр, сурах бичиг суралцах үйл явцыг хөгжүүлэхэд чиглэсэн.

Тухайн хэлийг хэл, соёлын нарийн шүтэлцээгүйгээр дангаар нь судлах явдал өрөөсгөл тул ЕБС-ийн англи хэлний сургалтын агуулгад сурагчдад хэлний хэрэглээний мэдлэг эзэмшүүлэхийн зэрэгцээ судалж буй хэлээр ярьдаг хүмүүсийн соёл, уламжлалаас тусгасан байдаг. Мөн сурагчдад дэлхий ертөнц бидний глобал орчин, бид бүгдээрээ нэг бөмбөрцөгт хамтран амьдарч, хамтран үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн санааг өгч хамтын нийгэмлэгийн бүтээлч үйл ажиллагааны гишүүн болж төлөвшихийн ач холбогдлыг ойлгуулахад чиглэсэн арга зүй, үйлүүд сургалтын хөтөлбөр, сурах бичигт туссан байдаг.

Англи хэлний сургалтын агуулга нь “хувь хүний гэр бүл, сургууль, орон нутаг, дэлхийн ертөнцийн хүрээнд өөрийн байр сууриа олох, бататгах, идэвхтэй үйл ажиллагаанд оролцож өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах” үндсэн санаанд тулгуурласан нь ТХБ-ын үзэл санаатай нийцэж байгаа тул өсвөр, залуу үеийнхний бүх талын хүмүүжилд зохих хувь нэмрээ оруулна.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын түвшинд англи хэлийг сурагчид V ангиас судлах бөгөөд англи хэлний хязгаарлагдмал үгийн нөөц, тодорхой нөхцөлд хэлийг хэрэглэж хэлний мэдлэг бүтээнэ. Бүтээсэн мэдлэгээ агуулгын хүрээнд тусгасан ахуй амьдрал, нийгэм соёлын хам сэдвийн дагуу хэрэглэх суралцахуйн чадвар эзэмшинэ.

ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэв, арга зүйг бага боловсролын Англи хэлний цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилттой хэрхэн интеграцчилагдаж байгаад шинжилгээ хийхэд:

1. Цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан байдлыг илрүүлэхэд суралцахуйн үйл, эзэмших чадварыг шалгуур болгон сонгосон.
2. Сургалтын хөтөлбөрт туссан нийт 43 суралцахуйн зорилтоос ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвт шууд хамаарах суралцахуйн зорилтыг ялган авахад дараах байдалтай байна.

*ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвт хамаарах бага боловсролын англи хэлний цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын тоо*

| Ай | Танин мэдэхүй | Нийгэмшил, сэтгэл хөдлөл | Зан үйлийн |
|---|---|---|---|
| Суралцахуйн зорилтын тоо | 3 | 2 | - |

Дээрх суралцахуйн зорилтыг суралцахуйн үйлээс хамааран сургалтын хөтөлбөрийн “Миний орчин” сэдэвтэй 1, сургалтын хөтөлбөрт нэмэгдэж буй удиртгал бүлэг сэдэвт 4 суралцахуйн зорилтыг тус тус харгалзууллаа.

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын англи хэлний цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт нь суралцахуйн үйл, эзэмших чадварт чиглэсэн, судлах сэдэв, үг, хэллэгийн хувьд энгийн хэлбэртэй байгаа нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт, санал болгосон сэдэв болон аргазүйг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байгаа ч цаашид сургалтын хөтөлбөрт гадаад хэл судлахын ач холбогдлыг хөндсөн удиртгал агуулга оруулах шаардлагатай гэж үзэн энэ бүлэгтэй холбон нэгж хичээлийн төлөвлөлтийг боловсрууллаа. Цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт, ТХЗ ба сэдвийн хамаарал, сурагчдын нас сэтгэхүйн онцлог зэргийг харгалзан тухайн зорилтын хүрээнд сурагчдаар хийлгэх үйлийг чухалчлан авч үзэн, ТБ-ын цогц чадамжтай иргэн болгон төлөвшихөд бага боловч хувь нэмэр оруулахуйц байхаар нэгж хичээлийн аргазүйг сонгосон. Багш уг хичээлийг төлөвлөн боловсруулахдаа доорх аргыг голлон өөр олон аргатай хослуулан ашиглавал сурагчдыг идэвхжүүлж оролцоог нэмэгдүүлнэ.

*Сургалт зохион байгуулах арга зүй (давхардсан тоогоор)*

| Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох арга | Шинжилгээ/ судалгаа хийх арга | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүйн арга | Алсын хараатай болох арга |
|---|---|---|---|
| 1 | 4 | 5 | - |

Сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтоор дамжуулан тогтвортой хөгжлийн цогц чадамж эзэмшүүлэх байдлын үр дүнгээр бага боловсролын англи хэлний хичээлээр хамтран ажиллах цогц чадамж төлөвших боломжтой нь харагдаж байна.

*ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмэр (давхардсан тоогоор)*

| | Тогтолцоон сэтгэлгээ-ний | Урьдчилан тооцоолох | Хэм хэмжээний | Стратегийн | Хамтран ажиллах | Шүүмжлэлт сэтгэлгээ | Өөрийгөө таньж мэдэх | Асуудал шийдвэрлэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Англи хэл | 1 | 4 | - | - | 4 | - | - | - |

*Хүснэгт 2.18. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Англи хэл)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 5 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/өнгөрснийг нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар /суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | | | | 8 | 9 | 10 |
| Миний орчин | 5, 4.1.Сэдвийн хүрээнд богино эхийн гол санааг ойлгох- Миний орчин | √ | ТХ304.ТМ4. | ТХ304.Сэ07. | "Миний орчин" сэдвийн хүрээнд судлах 'байгалийн үзэгдэл ' богино эхийн гол санааг сонсож ойлгосноор 21-р зуунд хэрэгцээтэй чадварын үндэс тавиган, тогтвортой байдалд хүрэхэд соёл /дэлхийн харилцааны хэрэгсэл болох англи хэл/ чухал үүрэгтэйг ухаарч ойлгох | √ | | √ | | 1- байгалийн үзэгдэл илэрхийлсэн видео бичлэгийг англи хэл дээр үзэж давтан хэлэх<br>3- байгалийн үзэгдэл илэрхийлсэн үг хэллэг ашиглан дасгал даалгавар гүйцэтгэхдээ давтах, даган дуурайх, дүрд хувилан тоглох арга зүйд суралцана | 1 | “Байгалийн үзэгдэл' эхийн гол санааг сонсоод ойлгох явцад байгалийн үзэгдлийн талаарх сурагчийн өмнөх төсөөлөл, байгалийн үзэгдэл, тэдгээрийн англи хэл нэршил зэргийн харилцан хамаарлыг таньж ойлгоно. |
| Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ | 5, 0.2.ё. Сэдвийн хүрээнд бусадтай хамтран ажиллан ярилцах- | √ | ТХ304.ТМ4. | ТХ304.Сэ08. | "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд хэл нь тухайн орны соёл болох талаар хамтран ярилцах явцдаа тогтвортой байдалд хүрэхэд соёл чухал үүрэгтэйг ойлгон тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэгийн талаар ерөнхий ойлголттой болно. | | √ | √ | | 2- "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх,<br>3-эхийн хүрээнд өөрийн үгээр ярилцах, хэлэлцүүлэг хийх аргад суралцана. | 2, 5 | "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх явцад<br>2- өөрийн үзэл бодлыг бий болгох чадварт суралцах эхлэл болно.<br>5-эхийн талаар харилцан ярилцах явцад бусдын үзэл бодлыг сонсох, багаараа хамтран нэг шийдэлд хүрэхийн чухал болохыг ухаарна. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ | 5, 0.2.e. Сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллахад өөрийн хувь нэмрээ оруулах | √ | ТХ304.ТМ5. | ТХ304.Сэ08. | "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан даалгавар гүйцэтгэхэд өөрийн хувь нэмрээ оруулахдаа тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйлийг боловсролоор дамжуулан илүү тогтвортой төлөвшүүлэх боломжтойг мэдэж авах | | √ | √ | | 2- "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх,<br>3-эхийн хүрээнд өөрийн үгээр ярилцах, хэлэлцүүлэг хийх аргад суралцана. | 2, 5 | "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх явцад<br>2- өөрийн үзэл бодлыг бий болгох чадварт суралцах эхлэл болно.<br>5-эхийн талаар харилцан ярилцах явцад бусдын үзэл бодлыг сонсох, багаараа хамтран нэг шийдэлд хүрэхийн чухал болохыг ухаарна. |
| Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ | 5, 0.2.e. Сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллахад өөрийн хувь нэмрээ оруулах | √ | ТХ304.НСХ3. | ТХ304.Сэ08. | "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан даалгавар гүйцэтгэхэд өөрийн хувь нэмрээ оруулахдаа хувь хүнийхээ хөгжилд шаардлагатай өөрийн суралцахуйн хэрэгцээгээ шинжлэн тодорхойлох чадварт суралцах суурь тавигдаж цаашлаад тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйлийг өөрт хэрхэн төлөвшүүлэх ойлголттой болно | | √ | √ | | 2- "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх,<br><br>3-эхийн хүрээнд өөрийн үгээр ярилцах, хэлэлцүүлэг хийх аргад суралцана. | 2, 5 | "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх явцад<br><br>2- өөрийн үзэл бодлыг бий болгох чадварт суралцах эхлэл болно.<br><br>5-эхийн талаар харилцан ярилцах явцад бусдын үзэл бодлыг сонсох, багаараа хамтран нэг шийдэлд хүрэхийн чухал болохыг ухаарна. |
| Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ | 5, 0.2.e. Сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллахад өөрийн хувь нэмрээ оруулах | √ | ТХ304.НСХ4. | ТХ304.Сэ08. | "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан даалгавар гүйцэтгэхэд өөрийн хувь нэмрээ оруулахдаа ахуй амьдралаа сайжруулахад өөрийнх нь ур чадвар чухал ач холбогдолтойг ойлгож цаашлаад тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйлийг өөрт хэрхэн төлөвшүүлэх талаар ойлголттой болно. | | √ | √ | | 2- "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх,<br>3-эхийн хүрээнд өөрийн үгээр ярилцах, хэлэлцүүлэг хийх аргад суралцана. | 2, 5 | "Бид яагаад гадаад хэл судлах хэрэгтэй вэ" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх явцад<br>2- өөрийн үзэл бодлыг бий болгох чадварт суралцах эхлэл болно.<br>5-эхийн талаар харилцан ярилцах явцад бусдын үзэл бодлыг сонсох, багаараа хамтран нэг шийдэлд хүрэхийн чухал болохыг ухаарна. |

## 2.7.Б. НЭГЖ ХИЧЭЭЛ: БИД ЯАГААД ГАДААД ХЭЛ СУДЛАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?\

### Нэгж хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр

Бага боловсролын түвшинд англи хэлний сургалтаар 4 сэдвийн хүрээнд, нийт 43 суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхээр цөм хөтөлбөрт тусгасан байдаг. Дээрх сэдвийн хүрээнд энгийн үг, өгүүлбэр, эхийн түвшинд англи хэлээр анги танхимд сургалт явуулахаар тодорхойлсон байдаг ч бид гадаад хэл тэр дундаа англи хэлийг яагаад, ямар зорилгоор судалдаг талаар сургалтын хөтөлбөрт тусгадаггүй билээ. Цаашид бага боловсролын англи хэлний сургалтын хөтөлбөрт удиртгал 1-2 цагийг төлөвлөж энэ хугацаанд гадаад хэл сурахын ач холбогдол, хэрэгцээ шаардлагын талаар сурагчдад зөвлөн туслах зорилгоор энэ удаагийн багшийн гарын авлагад бид энэхүү нэгж хичээлийн төлөвлөлтийг боловсрууллаа. Энэ 2 цагийн хичээлийг багш төрөлх хэл дээр зохион байгуулна.

Англи хэлний цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт, ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй холбогдсон байдлыг хүснэгтээр харууллаа.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓    ТХЗБ-ын сэдэв → | ТХ304.Сэ08. Тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйл |
| ТХ304.ТМ5. Сурагч боловсролоор дамжуулан илүү тогтвортой, эрх тэгш, энх амгалан дэлхийг цогцлоох боломжтойг ойлгодог болох | 5-р анги 0- удиртгал Ярих чадвар (S6) "Англи хэл сурахын ач холбогдол" - сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллахад өөрийн хувь нэмрээ оруулах<br>↑ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |

Англи хэлний цөм хөтөлбөрт хос, бүлэг, ангиар ажиллах, өөрийн хувь нэмрээ хамтын үйл ажиллагаанд оруулах суралцахуйн зорилт ЕБ-ын бүх түвшинд тодорхойлогдсон байдаг. Хамтран даалгавар гүйцэтгэх явцад тухайн сэдвийн хүрээнд тодорхой мэдлэгийг олж авахад илүү дөхөмтэй. Дараах хүснэгтээс англи хэлний цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХБ-ийн суралцахуйн зорилт ба сэдэвтэй хэрхэн холбогдож байгааг харна уу.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ТХ304.ТМ5. | ТХ304. Сэ08. | "Англи хэл сурахын ач холбогдол" сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан даалгавар гүйцэтгэхэд өөрийн хувь нэмрээ оруулахдаа тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйлийг боловсролоор дамжуулан илүү тогтвортой төлөвшүүлэх боломжтойг мэдэж авах |

"Англи хэл сурахын ач холбогдол" эхийн хүрээнд багш сурагчдыг хос, бүлэг, ангиар ажиллуулан даалгавар гүйцэтгүүлэх явцад гадаад хэл тэр дундаа англи хэлийг бид яагаад судлах хэрэгцээ, шаардлага байгаад чиглүүлэн хичээлийг удирдан зохион байгуулна. Гадаад хэлийг амжилттай сурснаар ТХ-ийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйлийг өөрт төлөвшүүлэх боломжтойг ойлгуулахад энэ хичээл чиглэнэ.

Англи хэлний цөм хөтөлбөрт хос, бүлэг, ангиар ажиллах, өөрийн хувь нэмрээ хамтын үйл ажиллагаанд оруулах суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд ТХБ-ын арга зүйн бүтээлчээр сэтгэх, ТБ-ын бусдаас суралцах цогц чадамжийг төлөвшүүлэхэд тохиромжтой.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх ТХБ-ын арга зүйн сонголт, хувь нэмэр оруулах боломжтой ТБ-ын цогц чадамжийг тодорхойлсон үндэслэл (матриц 2-ын 8, 10 дугаар баганыг харна уу)*

| Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар | Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар |
|---|---|
| 8 | 10 |
| 2- "Англи хэл сурахын ач холбогдол" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх.<br>3-эхийн хүрээнд өөрийн үгээр ярилцах, хэлэлцүүлэг хийх аргад суралцана. | "Англи хэл сурахын ач холбогдол" сэдвийн хүрээнд эхэд задлан шинжилгээ хийх явцад<br>2- өөрийн үзэл бодлыг илэрхийлэх чадварт суралцах эхлэл болно.<br>5-эхийн талаар харилцан ярилцах явцад бусдын үзэл бодлыг сонсох, багаараа хамтран нэг шийдэлд хүрэхийн чухал болохыг ухаарна. |

"Англи хэл сурахын ач холбогдол" эхийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан эхэд задлан шинжилгээ хийж түүнд тулгуурлан өөрийн санаа бодлоо багийн гишүүдтэй солилцон гадаад хэл сурахын ач холбогдол, англи хэлийг дэлхий нийтийн хэл болохынх нь хувьд амжилттай сурч цаашлаад ТХ-ийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйлийг төлөвшүүлэхэд сурсан хэлээ хэрхэн ашиглах талаар багаар ярилцан хэлэлцүүлэг хийх аргад суралцана.

## Нэгж хичээлийн төлөвлөлт

***<u>Нэгж хичээлийн зорилго:</u>*** "Англи хэл сурахын ач холбогдол" эхийн түвшинд ТХ-ийн талаарх хэрэгцээт мэдлэгийг англи хэлний сургалтаар дамжуулан илүү тогтвортой хөгжүүлэх боломжтойг багаар хамтран ярилцаж хэлэлцэх явцдаа илрүүлэх

***<u>Зорилт:</u>***

1. "Англи хэл сурахын ач холбогдол" эхийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан эхэд задлан шинжилгээ хийж түүнд тулгуурлан өөрийн санаа бодлоо багийн гишүүдэд танилцуулах
2. Гадаад хэл сурахын ач холбогдол, англи хэлийг дэлхий нийтийн хэл болохынх нь хувьд амжилттай сурч, сурсан хэлээ хэрхэн ашиглан ТХ-ийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйл төлөвших талаар багаар ярилцан, хэлэлцүүлэг хийх аргад суралцах

***<u>Агуулга:</u>*** Англи хэлний хичээлээр мэдээлэлд (эхэд) суурилан англи хэлний ач холбогдлын талаар хамтран ярилцах, бусдыг сонсох, өөрийн санаа бодлоо илэрхийлэх чадварт суралцана.

***Арга зүй:*** Арга зүй нь дараах зүйлээр тодорхойлогдоно:

- Удиртгал хичээлийг хүрээнд ярилцах, хэлэлцэх чадварыг сурагч бүр бие даан болон хамтран ажилласны үр дүнд эзэмшинэ. Багш хичээлийг удирдан зохион байгуулж, сурагчийн үйл ажиллагааг чиглүүлэн хөгжүүлнэ.
- Үүний тулд сурагчийн хүрээлэн буй орчны бодит баримтад тулгуурлан тохиолдол шинжлэх, ажиглах, судлах, харьцуулах, асуудал шийдвэрлэх, үнэлэлт өгөх зэрэг идэвхтэй аргыг хослуулан хэрэглэнэ.
- Аливаа зүйлийг сонирхон судлах, шинжлэх, сэдэл төрүүлэх үйл ажиллагааг зөв чиглүүлэх нь багшийн үүрэг юм. Сурагч аливаа зүйлийг эргэцүүлэн бодож учир шалтгааныг тунгаан дүгнэж, юмсын холбоо хамаарлыг танин мэдсэнээр өөрөө, бусадтай хамтран аливаа асуудлыг шийдэх оновчтой шийдвэр гарган бүтээлчээр хандаж сурна

Энэхүү удиртгал хичээлийг багш ангийн зохион байгуулалт, сонгосон арга зүйгээс шалтгаалан 1-2 цагаар зохион байгуулж болно.

***Ээлжит хичээлийн үндсэн алхам, арга зүй:***

| Алхам | Гүйцэтгэх үйл | Арга, хэлбэр |
|---|---|---|
| 1. | Мэдээллийг хүлээн авах | - Багаар ажиллах<br>- Эхэд задлан шинжилгээ хийх<br>- Түлхүүр үг ашиглан эхийн гол ба туслах санааг таамаглах |
| 2. | Мэдээллийг боловсруулах, хөгжүүлэх | - Өөрийн үгээр ярилцах<br>- Бусдын үзэл бодлыг сонсох<br>- Ажиглах харьцуулах<br>- Мэдээллийг ялгах ангилах |
| 3. | Мэдээллийг илэрхийлэх, хуваалцах | - Асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэх<br>- Хосоор багаар даалгавар гүйцэтгэх<br>- Энгийн мэдээлэл солилцон харилцах<br>- Хэлний бус харилцааны хэрэглүүрийг ашиглах<br>- Нийлмэл өгүүлбэрт холбоос ашиглах санаагаа зөв илэрхийлэх |

***Үнэлгээний хэлбэр:***

- Ажиглах, судлах
- Хэлэлцүүлэх
- Амаар бичгээр илэрхийлэх
- Сорих, шалгах

***Хэрэглэгдэхүүн:***

### *Англи хэл сурахын ач холбогдол*

Англи хэлийг нэн эртний үед хэлэлцэж байсан нэгэн өвөг хэл буюу “Энэтхэг-Европ”-ын төрөл хэлнээс үүссэн гэж үздэг. Барагцаалбал, 4500 жилийн өмнө тэрхүү төрөл хэлний ондоо хэлбэрүүдээр ярьж байсан хүмүүс Европ, Азийн өргөн уудам нутгаар тархан сууж байжээ. Тэдгээр ондоо хэлбэр аажмаар латин мэтийн бие даасан хэлийг үүсгэсэн байна. Энэтхэг–Европ төрөл хэлний бүлгүүдийн нэг нь Германы бүлэг хэл бөгөөд чухамдаа энэ бүлгийн хэл нь өнөөгийн Герман, Англи хэлүүдийн анхдагч өвөг хэл нь болно.

Энэ нь дэлхийн хамгийн түгээмэл хэлний нэг бөгөөд Нэгдсэн Вант Улс, АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд, Ирланд, Карибын орнуудад албан ёсны хэл болдог. Энэ хэлээр дэлхий дээр 310 сая хүн төрөлх хэлний хувиар, мөн тооны хүн хоёрдогч хэлний хувиар ярьж байна. Орчин цагийн англи хэл нь эртний англи буюу англо-саксон хэлний нэгэн аялга байдлаар үүсч, V дугаар зууны үед Британид нэвтэрч, баруун герман аялгаар баяжсан хэл ажээ. Түүнчлэн түүхэн хөгжлийн явцад латин болон франц хэлний норманд аялгаар баяжиж ирсэн байна. 1362 онд франц хэлийг халж, англи хэлийг Английн хууль ёсны хэл болгосноор англи хэлний жинхэнэ сэргэлт эхэлж, XVI зууны Английн утга зохиолын үүсэл, XV зууны хэвлэлийн үүсэл, XVI-XVII зууны Уильям Шекспир, Эдмунд Спэнсэр, Кристофер Марлоуи нарын Англи утга зохиолын суут төлөөлөгчдийн эринг дамжин, хэл зүйч Самуэл Жонсон (1709-1784)-ийн зохиосон англи хэлний стандартчилсан дүрэм гарснаар орчин цагийн төгс хэл болж бүрэлдсэн гэж үздэг байна.

Түүнчлэн дэлхийн улс орнууд англи хэлийг хоёр дахь хэлээ гэж үздэг бөгөөд улс төр, эдийн засаг, соёлын харилцааны дэлхийн гол хэл болон хувирчээ. Үүнд:

1. Худалдааны буюу бизнесийн хэл




1945 оны дараах жилүүдэд Европт сэргээн байгуулалт хийгдэж байх зуур АНУ хөгжин цэцэглэж байлаа. Хэдэн зууны өмнө Британий “British East India Company”-ий Англи хэлийг дэлхийн дахины худалдаа наймааны хэл болгон түгээн дэлгэрүүлж байсныг АНУ бизнесүүд үргэлжлүүлэн буухиалсан юм. Британий эзэнт гүрний дэлхий нийтэд үлдээсэн Англи хэлний нөлөө АНУ-ын бизнесийн хөгжил цэцэглэлттэй хоршсоноор Англи хэл нь өнөөгийн 21-р зууны олон улсын худалдааны гол хэл болсон байна. Өнөө үед дэлхийн шилдэг бизнесийн сургуулиуд сургалтаа Англи хэлээр явуулдаг болжээ.

Аль ч улсад бизнес эрхлэгчид, маркетерууд бараа үйлчилгээгээ борлуулахын тулд тухайн цаг үеийн шинэлэг санаа, мод, үзэл санаа, итгэл үнэмшил дээр тоглож өөрийн барааг сэтгэл татам харагдуулж хэрэглэгчийг татаж чаддаг гэдгээрээ бахархдаг. Үүний нэг жишээ бол бараа үйлчилгээ, нэр хаягаа англиар нэрлэх, англи бичиг үсэг оруулах явдал юм.

Дээрх аргыг үндэстэн дамнасан томоохон компаниуд өөр өөр улс оронд байгаа хэрэглэгчиддээ нэгэн ижил мессэж өгөх зорилгоор ашигладаг бол зарим жижиг компаниуд зориуд хэрэглэгчийн сэтгэл зүйд нөлөөлөх зорилгоор англи үг, үсэг ашиглах нь элбэг билээ. Хувь хүний жишээн дээр бол энэ нь ярианда гадаад үг хольж ярьдагтай яг ижилхэн зүйл юм.

2.Урлагийн хэл

Хамтлаг дуучид, кино бүтээгчид бүтээлээ аль болох үзэгчдэд хүргэхийн тулд бүтээлээ англи хэлээр туурвих хүсэлтэй байдаг. Иймэрхүү хүсэл шаардлагууд нь англи хэлийг дэлхий нийтийн хэл болж хөгжихөд XX зууны 2-р хагаст ихээхэн нөлөөлсөн.

АНУ нь тив алгасан хөрөнгө оруулахаас гадна рок-н-ролл, жааз, сүүлд диско болон хип-хоп урлагаараа дэлхийг байлдан дагуулсан. Холливуудын кинонууд ч дэлхийг шуугиулж, Америкийн телевизийн цувралууд нийгэм соёлын томоохон үнэлэмж, жишгүүдийг тогтоож байсан юм. Америкийн соёл дайнд сүйдсэн дэлхий нийтэд үгүйлэгдэж байсан итгэл найдвар, амжилтыг цацруулсаар хаа сайгүй тархаж байсан. Дэлхий дахинд Англи хэлийг таниулахад Америк дуу хөгжмөөс гадна Британий “The Beatles”, “The Rolling Stones”, “Queen”, “Pink Floyd” зэрэг хамтлаг ихээхэн хувь нэмэр оруулсан билээ.

3.Шинжлэх ухаан, Технологийн хэл

АНУ-ын эдийн засаг, техник технологи хөгжиж хүчирхэгжих үйл явц мөн компьютерын эрин үетэй давхацсан ба англи хэл нь интернэт болон техник технологийн хувьсгалын хэл болсон юм. Жишээ нь: Компьютерын гарыг аваад үзэхэд л энэ нь латин тэмдэгтэд тохируулан зохион бүтээгдсэн байдаг. Тиймээс Ази тивийн зарим улс орны хэрэглэгчид компьютер дээр үг бичихийн тулд нарийн төвөгтэй үйлдлүүдийг хийх шаардлагатай болдог.

Өндөр технологийн бараа бүтээгдэхүүний доторх үйл ажиллагаа нь хүртэл англи хэлээр байдаг. АНУ нь техник технологиор тэргүүлэгч улс хэвээр байсаар байгаа бөгөөд АНУ-ын хэлний бодлогоос улбаалан англи хэл нь дэлхий нийтийн хамгийн түгээмэл хэл мөн юм.

Иймээс англи хэлийг сурах шаардлага дараах байдлаас урган гарч байгаа юм. Үүнд:

- Бизнесийнхээ хүрээг тэлж гадаад хамтрагчтай болох, гадаад харилцаагаа өргөжүүлж, янз бүрийн төсөл хэрэгжүүлэх, гадаад түншээ болох
- Гадаад худалдаа хийх, гэрээ хэлцэл хийх, захидал бичих
- Гадаад найз нөхөдтэй болох
- Гадаадын орноор аялах, зочлох
- Интернэтийг ашиглан, бараа бүтээгдэхүүнээ борлуулах, мэдээлэл солилцох, хувь хүн болоод байгууллагууд хэрэгцээт мэдээллээ олж авах,
- Хамгийн чанартай боловсрол олгодог сургуулийн мэдээллийг хайх,
- Шинжлэх ухааны төрөл бүрийн судалгаа шинжилгээний хайгуул хийх
- Гадаадын хөрөнгө оруулалт, уул уурхай хөгжиж буй өнөө үед гадаадын хөрөнгө оруулалттай компанид ажиллах

# 2.8. БИЕИЙН ТАМИР

## 2.8.А. БАГА БОЛОВСРОЛЫН БИЕИЙН ТАМИРЫН ХИЧЭЭЛИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Бага боловсролын “Биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөр” ба “Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж”-д үндэслэн биеийн тамирын хичээлийг тогтвортой хөгжлийн боловсролтой хэрхэн интеграцчилж болохыг тодруууллаа.

Хүүхэд бага наснаасаа өдөр тутмын эрүүл амьдралын зөв дадал хэвшилтэй болж, бие бялдраа хөгжүүлж чийрэгжүүлэн, эрүүл мэндээ хамгаалах мэдлэг, чадвар олж авах нь ТХБ-д биеийн тамирын хичээлийн оруулж буй хувь нэмэр болно.

Энэхүү гарын авлагыг боловсруулахын тулд бага боловсролын “Биеийн тамир”-ын сургалтын цөм хөтөлбөрийн зөвлөмж дэх суралцахуйн зорилтуудыг ТХЗБ-ын суралцахуйн зорилтууд ба тэдгээрийн хүрээнд санал болгосон сэдвүүдтэй холбож судлахын тулд цөм хөтөлбөрийн зөвлөмжид тусгасан суралцахуйн зорилтуудыг бүлэг сэдвийн хүрээнд нэгтгэж кодолсон. Кодыг бичихдээ бүлэг сэдвийн нэрийг бичээд, анги ба дэд сэдвийг тоогоор, суралцахуйн зорилтуудыг үсгээр тэмдэглэсэн. Уг кодыг ашиглан матриц 1-ээр ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэв, цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудын хамаарлыг тодорхойлсон. Харин матриц 2-д ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэв, цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудын хамаарлыг тодорхойлсон үндэслэлийг тайлбарласан. Мөн тухайн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх хичээлд хэрэглэх арга зүйн үндэслэл болон ТБ-ын цогц чадамжийн хөгжилд оруулах хувь нэмрийг тодруулсан.

Бага боловсролын биеийн тамирын цөм хөтөлбөрийн зөвлөмжид дэвшүүлсэн суралцахуйн зорилтуудаас 9 зорилт нь ТХЗ-ыг дэмжих боловсролын ТХ303 кодтой “ЭРҮҮЛ МЭНД БА САЙН САЙХАН БАЙДАЛ” гэсэн суралцахуйн зорилтод холбогдохоор байна. ТХЗБ-ын “Эрүүл мэнд ба сайн сайхан байдал”-ын суралцахуйн зорилтын:

- Танин мэдэхүйн айд I, II анги тус бүрийн 1, нийт 2 суралцахуйн зорилт;
- Нийгэмшил-сэтгэл хөдлөлийн айд зөвхөн V ангийн 1 суралцахуйн зорилт;
- Зан үйлийн айд I,II,III,IV ангийн нийт 6 суралцахуйн зорилт цөм холбогдож байна.

Эндээс бага боловсролын биеийн тамирын цөм хөтөлбөрийн үндсэн зорилтууд болох төрөл бүрийн дасгалыг гүйцэтгэх чадвар эзэмших, бие бялдраа хөгжүүлж чийрэгжүүлэхэд чиглэсэн суралцахуйн зорилтууд нь хүний эрүүл мэнд, сайн сайхан байдалд чухал нөлөө үзүүлэх боловч цөм хөтөлбөр ба түүний зөвлөмжид ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдсан байдлаар томьёологдоогүй байгаа нь харагдсан. Үүнийг цаашид сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгохдоо анхаарч үзэх шаардлагатай гэж үзэж байна.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын биеийн тамирын сургалтын хөтөлбөрийн агуулга нь ТХЗБ-ын ТХ303 кодтой “ЭРҮҮЛ МЭНД БА САЙН САЙХАН БАЙДАЛ”-ын сэдвүүдээс зөвхөн Сэ3, Сэ04, Сэ09 дэх сэдвүүдтэй холбогдож байна. Үүнээс:

- ТХЗБ-ын сэдэв 03 буюу “Эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих гол стратегиуд” гэсэн сэдвийн биеийн тамирын дасгал, эрүүл мэндийн боловсрол зэрэг сэдэв нь бага боловсролын биеийн тамирын цөм хөтөлбөрийн 7 суралцахуйн зорилттой холбогдсон.

- ТХЗБ-ын сэдэв 04 буюу “Эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих дам стратеги” гэсэн сэдвээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зэрэгт холбогдох 1 агуулга байна гэж үзсэн.
- ТХЗБ-ын сэдэв 09 буюу “Илүүдэл жин ба таргалалт, хөдөлгөөний дутагдал, эрүүл бус хоол хүнс” сэдэв нь биеийн тамир, эрүүл мэндийн хичээлд зайлшгүй холбогдох агуулга бөгөөд бага ангийн сурагч алжаал тайлах дасгалыг сурч, хийж хэвшсэнээр хөдөлгөөний дутагдлаас сэргийлнэ.

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Бага ангийн биеийн тамирын сургалтад багшийгаа дуурайж дасгалыг давтах, хөдөлгөөнт тоглоомоор тоглох, харилцан ярилцах, дасгалыг хувирган өөрчилж давтах аргуудыг голлон хэрэглэдэг. Бид биеийн тамирын хичээлийг ТХБ-той холбож интеграц хийхдээ арга зүйн хувьд *бодит үйл ажиллагаанд оролцох аргыг* түлхүү хэрэглэхээр сонгосон. Бага ангийн сурагч биеийн тамирын төрөл бүрийн дасгалыг биеэр хийж турших нь хүүхдийн бие махбодын хөдөлгөөний хэрэгцээг хангаж буй бодит үйл ажиллагаа болно. Түүнчлэн бусдынхаа дасгал хийхийг ажиглах, багшийн тайлбарыг сонсох, асуулт асуух, асуултад хариулах явцдаа тухайн дасгал хөдөлгөөний ач холбогдол, түүнийг зөв гүйцэтгэх арга зэргийг эргэцүүлэн бодож, өөрийн гэсэн ойлголт мэдлэгтэй болох юм.

Үүнээс гадна ТХЗБ-ын “Эрүүл мэнд, сайн сайхан байдал”-ын суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхдээ :

- Эрүүл мэндийг дэмжсэн видео үзэх
- Сургууль, орон нутгийн “Эрүүл мэндийн өдөр”-ийн үйл ажиллагаанд оролцох
- Өглөөний дасгалын үзүүлэх тоглолтод оролцох зэрэг арга зүйг ашиглавал илүү үр дүнд хүрэх боломжтой.

Бага ангид биеийн тамирын дасгалыг ихэнхдээ нийтээрээ гүйцэтгэдэг ба гүйж, харайж, үсэрч, шидэж тоглохдоо заавал баг болж нэг зорилгын төлөө ажилладаг учраас биеийн тамирын хичээлийн явцад сурагчдад хамтран ажиллах, өөрийгөө таньж мэдэх, шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжууд төлөвшинө.

*Хүснэгт 2.19.* ***Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Биеийн тамир)***

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | | | | | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи /утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/өнгөрснийг нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар /суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| 1 | 2 | 3 | | | | | 4 | 5 | 6 | 7 | | | | 8 | 9 | 10 |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 1, 01.а.Биеийн тамирын хувцсаа солих, тохируулж өмсөх, зөв хадгалах арга барил эзэмших | ☐ | | | | | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ04. | Биеийн тамирын хичээлийн нөхцөлд хувцсаа тохируулж өмсөх, хичээлийн дараа хөлстэй хувцсаа солих, гэртээ хариад угаах, зөв хадгалах арга барил эзэмшсэнээр үе мөчний болон бусад өвчнөөс урдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах нэг арга замыг мэдсэнээр эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох | ☐ | | | | Биеийн тамирын хувцсыг хэрхэн сонгох, тохируулан өмсөх, угааж цэвэрлэх талаар видео бичлэг үзүүлэхээс гадна бодитоор харуулж, хувцасны материалыг эрүүл мэнд, сайн сайхан байдалтай холбон багш тайлбар хийнэ. Сурагчид энэхүү тайлбараас ямар материалын хувцас эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй болохыг ойлгох нь чухал. | 1 | 1- Хүүхэд, эцэг эхчүүд биеийн тамирын хувцас авахдаа материал нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх талаар эргэцүүлж байгаа учраас аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэн, ойлгох чадвар буюу тогтолцоот сэтгэлгээний цогц чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна гэж үзэж байна. |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 1, 01.г. Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг сурах, тогтмол хийж хэвших | ☐ | | | | | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ03. | I ангийн сурагч гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг эзэмшиж, тэдгээр хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг гэртээ өдөр бүр хийх даалгавар өгч хэрэгжүүлснээр эрүүл мэнд, сайн сайхан байдлаа тогтмол дэмждэг болж, эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлнэ. | ☐ | | | | Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг сурч өдөр бүр тогтмол хийж хэвшил болгох даалгавар өгч ажиллана. Хүүхдийн өдөр тутам хийх дасгалыг видео бичлэг болон зурагт зөвлөмж бүхий тараах материал хэлбэрээр сурагч бүрд өгөхөөс гадна эцэг эхэд дасгалыг байнга хийлгэх талаар зөвлөгөө өгч хамтран ажиллана. | 5 | 5- Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн орсон өглөөний цогц дасгалыг багаар хийх, баг дотор ярилцах, хамтран ажиллах бусдаас суралцах чадвар хөгжиж байна. |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. Алхах, гүйх | 2, 02.г. Гүйж тоглох тоглоомоор хөдөлгөөний эвсэл ба хурдыг хөгжүүлж, гүйх болон хамтран тоглох чадвараа сайжруулах. | | □ | | | | ТХ303.ЗУ2. | ТХ303.Сэ03. | Бага ангийн хүүхдийн хийх биеийн тамирын чухал дасгалын нэг болохгүйж тоглох тоглоомоор тоглох явцдаа сурагч өөрийн хөдөлгөөний эвсэл, хурдыг хөгжүүлж, гүйх болон хамтран тоглох чадвараа сайжруулан. бусдыг урамшуулан зоригжуулж , эрүүл мэнд, сайн сайхан байдалд ач тустай шийдвэр гаргахтай холбоотой. | □ | | | | Гүйж тоглох тоглоомоор тоглон бодит хамтын үйл ажиллагаанд оролцох явцдаа өөрийн хөдөлгөөний эвсэл ба хурдыг хөгжүүлнэ. | 5, 3 | 5-Гүйлт бүхий тоглоом тоглох явцад бусдаас суралцах, хамтран ажиллах чадвар төлөвшинө.<br><br>3-Бусад багийн гишүүдийг ажиглаж байгаа нь эргэцүүлэн бодох чадвар хөгжиж байна гэж үзэж байна. |
| 4. Шидэлт, дамжуулалт | 2, 04.ё. Зөөлөн бөмбөгийг шидэх тоглоомоор хөдөлгөөний эв дүйг сайжруулж, хамтран тоглох чадвартай болно. | | □ | | | | ТХ303.ЗУ2. | ТХ303.Сэ03. | Бага ангийн хүүхдийн хийх биеийн тамирын чухал дасгалын нэг болох зөөлөн бөмбөгийг шидэх тоглоомоор хөдөлгөөний эв дүйг сайжруулж, хамтран тоглох чадвараа сайжруулан. бусдыг урамшуулан зоригжуулж , эрүүл мэнд, сайн сайхан байдалд ач тустай шийдвэр гаргахтай холбоотой. | □ | | | | Зөөлөн бөмбөгийг шидэх тоглоомоор хөдөлгөөний эв дүйг сайжруулж, хамтран тоглох чадварыг биеэр хийж гүйцэтгэнэ. | 5, 3, | 5-Бөмбөг шидэх тоглоомоор тоглох явцад бусдаас суралцах чадвар, үзэл бодлоо илэрхийлэх, хамтран ажиллах цогц чадамж хөгжинө.<br>3-Бусад багийн гишүүдийг ажиглаж байгаа нь эргэцүүлэн бодох чадвар хөгжиж байна гэж үзэж байна. |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 3, 01.в. Алжаал тайлах цогц дасгалыг сурч, ашигладаг болох. | | | □ | | | ТХ303.ЗУ1. | ТХ303.Сэ09. | Сурагч алжаал тайлах цогц дасгалыг сурч, хичээлээ давтах, зураг зурах зэргээр удаан хугацаанд суух хичээллэх үедээ хийдэг болсноорэрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлж, улмаар хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлнэ. | □ | | | | Сурагч гар, хөл, их биеийн хосолсон алжаал тайлах цогц дасгалыг багшийн зааврын дагуу өөрийн биеэр гүйцэтгэнэ. Мөн дасгалыг видео бичлэг, зурагт үзүүлэн ашиглан гэртээ удаан хугацаанд суух хичээллэсэн үедээ хийж хэвших. | 6 | 6-Алжаал тайлах энгийн дасгалыг сурагчид хийж үзэж туршин үйл хөдлөлөө эргэцүүлэн өөрийн үнэлгээ өгч байгаа нь шүүмжит сэтгэлгээний цогц чадамж хөгжиж байна. |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 3, 01.г. Нөхөртөө туслах, аюулгүй байдлаа хангах аргыг ойлгож, хосоор сунгалтын дасгал гүйцэтгэх арга барил эзэмших. | | | □ | | | ТХ303.ТМ5. | ТХ303.Сэ03. | Сурагч хосоороо сунгалтын дасгал гүйцэтгэх явцдаа нөхөртөө туслах аргыг ойлгож, аюулгүй байдлаа хангаг эрүүл мэндээ дэмжихэд шаардлагатай урьдчилан сэргийлэх арга замын талаар мэддэг болно. | □ | | | | Хосоор сунгалтын дасгал хийхдээ сурагчийн биеийн жин, өндөр, хүйсийг харгалзан хос болгоно. Хосоор хийх дасгалын сонголт, ачааллыг багш тохируулж, зөлжлэн зохион байгуулж байгаа нь сурагчид бодит хамтын үйл ажиллагаанд оролцож байгаатай холбоотой. | 5 | 5-Хосоор сунгалтын дасгал хийх үед нөхөртөө туслах, хосоор дасгал хийж буй сурагчдаасаа суралцаж байгаа нь хамтран ажиллах цогц чадамжийг дэмжиж байна. |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 4, 01.а. Биеийн тамирын хичээлийн үед мөрдөх аюулгүй байдлын дүрмийг ойлгон, хэрэгжүүлж хэвших. | | | | □ | | ТХ303.ТМ5. | ТХ303.Сэ03. | Гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга замын талаар мэдлэг эзэмшсэнээр биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийхдээ аюулгүй байдлын дүрмийг ойлгон, тогтмол хэрэгжүүлж хэвшил болгохтой холбоотой гэж | □ | | | | Биеийн тамирын хичээл бүрийн эхэнд дасгал хийх үед мөрдөх аюулгүй байдлын дүрмийг өгч сурагчид дасгал хийхэд юуг анхаарч ажиллах талаар уншиж танилцсанаар бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлнэ. Энэ үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж хэвшил болгоход анхаарч ажиллана. | 7 | 7-Хүүхэд бүр дасгал хийх явцад аливаа гарч болох эрсдэлээс сэргийлэх аргыг байнга хэвшил болгох нь юунд хэрэгтэй болох талаар зэрэгцүүлэн бодож ярилцах учраас өөрийгөө танин мэдэх цогц чадамжийг хөгжүүлнэ. |
| 1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | 4, 01.д. Гимнастикийн сааватай цогц дасгалыг зохиох, гүйцэтгэх чадвар эзэмшиж, өөрсдийн зохиосон саваатай дасгалаа бусдад үзүүлж, өөрийгөө илэрхийлэх чадвар эзэмших | | | | □ | | ТХ303.ЗҮ2. | ТХ303.Сэ03. | Бага ангийн хүүхдийн хийх биеийн тамирын чухал дасгалын нэг болох гимнастикийн саваатай цогц дасгалыг зохиох, гүйцэтгэх чадвар эзэмшиж, өөрсдийн зохиосон саваатай дасгалаа бусдад үзүүлж, өөрийгөө илэрхийлэх чадвараа сайжруулж, эрүүл мэнд, сайн сайхан байдалд ач тустай шийдвэр гаргахтай холбоотой. | □ | □ | | | Гимнастикийн саваатай цогц дасгалыг багийн бүх гишүүн ярилцаж дасгалаа зохиогоод, хийж туршин, дахин сайжруулна. Зохиосон дасгалыг өөрийн биеэр сурагчдад хийж үзүүлнэ. | 1, 5 | 1-Гимнастикийн саваатай дасгалыг зохиох явцдаа аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох чадвар хөгжинө. 5-Өөрийн багийн зохиосон дасгалаа бусад багтаа үзүүлэн, бусад багийн зохиосон дасгалыг ажигласнаар үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох , бусдаас суралцах чадвар хөгжинө. |
| 4. Шидэлт, дамжуу-лалт | 5, 04.г. Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээнд оролцож, өөрийгөө дайчлах, өөртөө хяналт тавих, өөрийн чадвараа бусадтай харьцуулах, бие даах чадвараа харуулах | | | | | □ | ТХ303.НСХ4. | ТХ303.Сэ03. | Сурагч гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээнд оролцохдоо бөмбөг шидэлтийн дасгалын талаарх цогц ойлголтоо ашиглах учраас энэ нь " эрүүл мэнд сайн сайхан байдлын тухай бүхэл бүтэн цогц ойлголттой болох" гэсэн ТХБ-ын суралцахуйн зорилттой агуулгын хувьд уялдана. Тэмцээний явцад өөрийгөө дайчлах, өөртөө хяналт тавих, өөрийн чадвараа бусадтай харьцуулах зэргээр бие даах чадвараа харуулж эрүүл мэнд сайн сайхан байдлын итгэл үнэмшил, хандлагаа илрүүлэн тодруулж чаддаг болно. | □ | □ | | | Сурагчдыг баг болгон хуваан жижиг бөмбөг шидэх тэмцээн зохионо. Тэмцээний явцад өөрийгөө дайчлах, өөрийн чадвараа бусадтай харьцуулан хамтран суралцана. | 5 | 5- Жижиг бөмбөг шидэх тэмцээнд оролцох явцдаа бусадтай харилцах, бусдаас суралцах, хамтран ажиллах чадвар төлөвшинө. |

## 2.8.Б. НЭГЖ ХИЧЭЭЛ: БИЕИЙН ҮНДСЭН ХӨДӨЛГӨӨН

### Нэгж хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр

Бага боловсролын биеийн тамирын цөм хөтөлбөрийн зорилго нь бага ангийн сурагч бие бялдраа хөгжүүлэхэд биеийн тамирын хэрэглүүрийг ашиглах мэдлэг эзэмшиж, бие бялдар нь чийрэгжин, эрүүл мэнд нь бэхжиж, хүчтэй, хурдтай, тэсвэртэй, уян болж, хөдөлгөөний эвслийг хөгжүүлэхэд чиглэсэн байна. Улмаар хүүхдийн өдөр тутмын амьдралын хэрэгцээг хангахуйц энгийн хөдөлгөөний чадвар, дадлыг эзэмшин, биеийн тамирын дасгалаар тогтмол хичээллэх сонирхол, хэвшилтэй болно.

Биеийн тамирын цөм хөтөлбөрийн энэ зорилгыг ТХЗБ-ын суралцахуйн зорилтуудтай интеграц хийх боломжийг харуулахын тулд бид I ангийн цөм хөтөлбөрөөс 1, 1.г. кодтой “Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг сурах, тогтмол хийж хэвших” гэсэн суралцахуйн зорилтыг “Биеийн үндсэн хөдөлгөөн” гэсэн нэгж сэдвээр судлахаар сонгож жишээ хөтөлбөр боловсруулсан. Учир нь биеийн тамирын боловсролын цагаан толгой нь гимнастик бөгөөд I ангиас эхлэн гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг зөв нэрлэж, таньж, хэрэглэж хэвшүүлэх ёстой. Энэ мэдлэг, чадварт тулгуурлан сурагч цаашид биеийн тамирын боловсрол олж авна. I ангийн сурагч гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг эзэмшиж, тэдгээр хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг гэртээ өдөр бүр хийх даалгавар өгч хэрэгжүүлснээр эрүүл мэнд, сайн сайхан байдлаа тогтмол дэмждэг болж, эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлнэ.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ ТХЗБ-ын сэдэв → | ТХ303.Сэ03. Эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг дэмжих гол стратегид: Тухайлбал, вакцин, эрүүл хүнс, биеийн тамирын дасгал, сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл мэндийн зөвлөгөө, боловсрол, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол (аюулгүй бэлгийн харилцаа болон хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх аргууд) |
| ТХ303.ЗҮ1. Сурагч эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох | **1. Биеийн ерөнхий хөгжлийн дасгал** 1, 01.г. Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг сурах, тогтмол хийж хэвших ↑ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралц-ахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ТХ303.ЗҮ1. | ТХ303. Сэ03. | Нэгдүгээр ангийн сурагч гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг эзэмшиж, тэдгээр хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг гэртээ өдөр бүр хийх даалгавар өгч хэрэгжүүлснээр эрүүл мэнд, сайн сайхан байдлаа тогтмол дэмждэг болж, эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлнэ. |

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх ТХБ-ын арга зүйн сонголт, хувь нэмэр оруулах боломжтой ТБ-ын цогц чадамжийг тодорхойлсон үндэслэл (матриц 2-ын 8, 10 дугаар баганыг харна уу)*

| Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар | Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар |
|---|---|
| 8 | 10 |
| Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг сурч өдөр бүр тогтмол хийж хэвшил болгох даалгавар өгч ажиллана. Хүүхдийн өдөр тутам хийх дасгалыг видео бичлэг болон зурагт зөвлөмж бүхий тараах материал хэлбэрээр сурагч бүрд өгөхөөс гадна. эцэг эхэд дасгалыг байнга хийлгэх талаар зөвлөгөө өгч хамтран ажиллана. | 5. Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн орсон өглөөний цогц дасгалыг багаар хийх, баг дотор ярилцах, бусдаас суралцах, энэ бүгдээс харахад хамтран ажиллах цогц чадамжид хувь нэмэр оруулна. |

## Нэгж хичээлийн төлөвлөлт

***Нэгж хичээлийн сэдэв:*** Биеийн үндсэн хөдөлгөөн

***Хамрах хүрээ:*** I анги

***Нэгж хичээлийн зорилго:*** Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон өглөөний цогц дасгалыг гүйцэтгэж чаддаг болох ба өглөө бүр дасгал хийх эрмэлзэл төрүүлэх

***Зорилт:***

1. Биеийн үндсэн хөдөлгөөн бүхий өглөөний цогц дасгалыг ангиараа жигд гүйцэтгэх
2. Өглөө бүр гэрийнхэнтэйгээ хамтран дасгалаа хийхийг хичээдэг болох.

***Агуулга ба арга зүй:***

| Хичээл № | Агуулга | Арга зүйн чиглэл |
|---|---|---|
| 1 | *Гарын үндсэн хөдөлгөөн:*<br>- Гараа урагш өргөх, алдлах, дээш өргөх, арагш өргөх, ташаанд авах, толгойн ард авах зэрэг хөдөлгөөнийг нэрлэх, таних, зөв гүйцэтгэх<br>- Гарын үндсэн хөдөлгөөн бүхий цогц дасгалыг гүйцэтгэх<br>- Гарын үндсэн хөдөлгөөнийг янз бүрээр дүрсэлж гүйцэтгэх | - Багш хөдөлгөөнүүдийг үзүүлж, юу гэж нэрлэхийг тайлбарлаад сурагчид багшийг дууриайж хийх<br>- Гараа алдлахдаа алгаа доошоо, бусад хөдөлгөөний үед алгыг дотогшоо харуулахыг анхааруулах<br>- Гарын үндсэн хөдөлгөөн бүрийг 4-6 удаа давтах<br>- 4 өнгийн туузыг сурагчдын бугуйд уяад, нэг өнгийн туузтай сурагчид тухайн өнгийн тууз татсан шугамын ард нэг эгнээнд жагсах байдлаар 4 эгнээнд жагсааж, цогц дасгалыг 3-4 удаа давтах<br>- Дэвэн нисэж буй шувууны зураг үзүүлж, энэ шувууг хөдөлгөөнөөр дүрсэлж үзүүлэхийг хүсэх. Гараа алдлан дэвэх хөдөлгөөн хийж буй сурагчийг урамшуулах<br>- Тэнгэрт буй солонгыг барьцгаая! гэхэд сурагчид гараа өргөн дээш тэмүүлэх гэх мэт байгаль орчны дүрслэлийг ашиглах |

| Хичээл № | Агуулга | Арга зүйн чиглэл |
|---|---|---|
| 2 | *Хөлийн үндсэн хөдөлгөөн:*<br>- Хөлөө урагш өргөх, хажуу тийш өргөх, урагш-дээш өргөх, арагш өргөх зэрэг хөдөлгөөнийг нэрлэх, таних, зөв гүйцэтгэх<br>- Хөлийн үндсэн хөдөлгөөнийг цогц дасгал болгон гүйцэтгэх<br>- Гарын ба хөлийн үндсэн хөдөлгөөнийг хослуулан, өглөөний 2-3 дасгал хийх | - Багш хөлөө урагш, арагш өргөж үзүүлээд энэ хөдөлгөөнийг юу гэж нэрлэхийг асуух<br>- Сурагчдын хариултад үндэслэн хөлийн үндсэн хөдөлгөөн тус бүрийг нэрлэж, эгнээ ба цуваа жагсаалд бүгдээрээ нэгэн зэрэг гүйцэтгэх<br>- Багш тоолж, эсвэл алгаа ташиж, хөдөлгөөнийг нэрлэж удирдах, сурагчид багшийн нэрлэсэн хөдөлгөөнийг зөв хийх<br>- Хөлийн үндсэн хөдөлгөөнтэй цогц дасгалыг багш өөрөө үзүүлэн, дагуулж гүйцэтгэх<br>- Сурагчид бүгдээрээ нэгэн зэрэг хийхээс гадна эгнээ бүр ээлжлэн дасгалаа хийж үзүүлэх ба ямар алдаа гарч байгааг сурагчидтай хамтран ярилцах<br>- Хөлийн үндсэн хөдөлгөөнийг нэг хөлөөр гүйцэтгэх тул гараа алдлах, ташаанд авах зэргээр гарын хөдөлгөөний тусламжтай тэнцвэрээ хадгалахыг сануулах<br>- Өнөөдрийн сурсан дасгалаа гэрийнхэндээ хийж үзүүлэх даалгавар өгөх |
| 3 | *Их биеийн үндсэн хөдөлгөөн:*<br>- Их биеэр бөхийх, гэдийх, баруун ба зүүн тийш хазайх зэрэг хөдөлгөөнийг нэрлэх, таних, зөв гүйцэтгэх<br>- Их биеийн үндсэн хөдөлгөөн бүхий цогц дасгалыг тогтоож авах<br>- Их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон бөмбөг дамжуулах тоглоом тоглох | - Их биеийн үндсэн хөдөлгөөнийг багш хийж үзүүлээд, юу гэж нэрлэхийг асуух<br>- Хэн нэг сурагч уг хөдөлгөөнийг зөв нэрлэсэн эсэхийг хэлэлцэх. Зөв нэрийг тогтоосон эсэхийг үнэлэх<br>- Гэдийх бөхийх үедээ амьсгалаа авч эгцрэх үедээ амьсгалаа гаргахыг анхааруулах<br>- Сурагчдыг тэнцүү тооны тоглогчтой баг болгож хуваах, тоглоомын дүрмийг биеийн тамирын хэлээр ойлгомжтой тайлбарлах<br>- Тоглох явцад багуудыг үгээр урамшуулж дэмжих, хурдан бөгөөд далайцтай хөдөлгөөнөөр бөмбөгөө дамжуулахыг анхааруулах |
| 4 | *Өглөөний цогц дасгал:*<br>- Гар, хөл, их биеийн 4 тоот үндсэн хөдөлгөөн хосолсон өглөөний цогц дасгалыг гүйцэтгэх чадвар эзэмших<br>- Цогц дасгалыг хийхдээ үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох чадвараа сайжруулах<br>- Бусдаас суралцах, хамтран ажиллах чадвараа хөгжүүлэх | - Өглөө босоод дасгал хийдэг үү? Өглөө дасгал хийх нь ямар хэрэгтэй гэж бодож байна? гэх мэт асуултаар ярилцах<br>- Өглөөний цогц дасгалыг бүрдүүлж буй гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг тус тусад нь сурагчид гүйцэтгэхэд багш алдааг засах<br>- Багшийн нэрлэсэн үндсэн хөдөлгөөнийг сурагчид хийж үзүүлэх<br>- Багшийн үзүүлсэн үндсэн хөдөлгөөнийг сурагчид нэрлэх<br>- Хэн нь дасгалаа зөв хийж байна?, хэн ямар алдаа гаргав? гэсэн асуултаар ярилцах<br>- Цогц дасгал зохиож хэсэгчлэн давтуулаад, дараа нь нэгтгэж, зөв, гоё хийхийг сануулж, дэмжих<br>- Өглөөний цогц дасгалын зурагтай тараах материалыг сурагч бүрт өгч, гэрийнхэнтэйгээ хамтдаа өглөө бүр дасгал хийж байхыг зөвлөх<br>- Хэн нэгний гаргасан алдааг бусад сурагч засаж, зөв хөдөлгөөнийг үзүүлэх |

| | | |
|---|---|---|
| 5 | Өглөөний цогц дасгалыг ангиараа уран гоё гүйцэтгэх | - Гарын үндсэн хөдөлгөөнийг хөлийн ба их биеийн үндсэн хөдөлгөөнтэй нэгтгэж, дасгал тус бүрийг 6-8 удаа давтана.<br>- Сурагчид 4-5 эгнээ болж, эгнээгээрээ ээлжлэн цогц дасгалыг хийж үзүүлнэ.<br>- Аль эгнээ нэгэн зэрэг уран гоё хийж байгааг багштай хамтран шалгаруулна.<br>- Цогц дасгалыг сурагчид өөрсдөө дуулж болон хөгжмийн аянд гүйцэтгэвэл хүүхдэд илүү сонирхолтой байхаас гадна хөгжмийн боловсролд нь ч сайнаар нөлөөлнө. Аяыг сонгохдоо дууны багштай хамтрах |
| 6 | Өглөөний цогц дасгалаа сурсан эсэхийг үнэлэх | - Ангиараа өглөөний цогц дасгалаа 2-3 удаа хийж давтах<br>- Ангийн багш, эцэг эхийн төлөөлөл, бусад багш нарыг урьж суулгаад өглөөний дасгалаа хөгжмийн аянд хийж үзүүлэх (үзүүлэх тоглолт)<br>- Энэ үзүүлэх тоглолтод оролцсон сурагч бүрийг магтаж урамшуулсан үг хэлэх. Видео бичлэг хийж эцэг эхэд нь үзүүлэх |

***<u>Нэгж хичээлийн хэрэглэгдэхүүн:</u>***

- Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг тус тусад нь харуулсан зурагт үзүүлэн
- Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн бүхий цогц дасгалын цуглуулга, зурагт үзүүлэн
- Өглөөний цогц дасгалын зурагтай (6 дасгал), дасгал бүрийг гүйцэтгэхэд анхаарах зүйлсийг эцэг эхэд нь зориулан бичсэн товч зөвлөмж бүхий тараах материал
- Дасгалд тохирох ая бүхий CD, DVD бичлэг бэлтгэвэл илүү хэрэгцээтэй байна. Зааланд сонсогдох хөгжим ашиглана.
- Далавчаа дэвэн нисэж буй том шувууны зураг
- Их биеийн хөдөлгөөнөөр дамжуулж тоглох том, зөөлөн бөмбөг 5-6 ширхэг
- Ангийн сурагчид ижил энгийн биеийн тамирын хувцастай байна.
- Багш шүгэл ашиглаж болно.

*I ангийн сурагч 1-р улиралд хийх өглөөний цогц дасгал*
*(Эцэг эхэд зориулсан тараах материал)*

**Дасгал 1**



Б.б 1 2 3 4

Б.б – үндсэн зогсолт. 1-гараа алдална. 2- гараа өргөж, өлмий дээр босно. 3- гараа урагш өргөнө. 4- б.б

**Дасгал 2**



Б.б 1 2 3 4

Б.б – үндсэн зогсолт. 1-гараа алдална. 2- гараа мөрөндөө авч, өлмий дээр босно. 3- гараа алдална. 4- б.б

**Дасгал 3**



Б.б 1 2 3 4

Б.б – эгэмчилж зогсоно. 1-зүүн гараа өргөж, баруун гараа алдална. 2- б.б. 3- баруун гараа өргөж, зүүн гараа алдална. 4- б.б

**Дасгал 4**



Б.б 1 2 3 4

Б.б – гараа ташаандаа авч зогсоно. 1-баруун хөлөө хажуу тийш өргөнө. 2- б.б. 3- зүүн хөлөө хажуу тийш өргөнө. 4- б.б

**Дасгал 5**



Б.б 1 2 3 4

Б.б – гараа ташаандаа авч зогсоно. 1-гараа өргөн, бөхийж алгаа ташна. 2- б.б. 3- гараа урагш өргөн, явган сууж, алгаа ташна. 4- б.б

**Дасгал 6**



Б.б 1 2 3 4

Б.б – гараа мөрөндөө авч зогсоно. 1-гараа өргөж, цээжээр баруун тийш эргэнэ. 2- б.б. 3- гараа өргөж цээжээр зүүн тийш эргэнэ. 4- б

***Үнэлгээ:***

Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг зөв хийдэг болсон ба эдгээр хөдөлгөөнөөс бүрдсэн өглөөний цогц дасгалыг гэртээ тогтмол хийх эрмэлзэлтэй болсон эсэхийг хичээл бүрийн явцад үнэлнэ. Үүнд:

| Хичээл № | Үнэлгээний даалгавар | Үнэлэх арга, хэрэгсэл |
|---|---|---|
| 1-2 | - Багшийн нэрлэсэн гар, хөлийн үндсэн хөдөлгөөнийг хийж үзүүлэх<br>- Сурагчийн хийж үзүүлсэн гар, хөлийн үндсэн хөдөлгөөнийг өөр сурагч нэрлэх | - Багшийнхаа нэрлэсэн хөдөлгөөнийг хэн хийж үзүүлэх вэ? гэж асуух<br>- Аль нэг сурагчийн хийж буй хөдөлгөөнийг бүгдээрээ нэрлэх<br>- Хэн нь зөв хийсэн, хэн нь зөв нэрлэсэн бэ? гэх мэтээр ярилцах<br>- Зөв хийсэн сурагчийг үгээр урамшуулах, алдаатай хийснийг нь дахиад хийгээд үзүүлээрэй гэх<br>- Багш 5-6 сурагчийг дуудан нэг эгнээнд зогсоож, багшийнхаа нэрлэсэн хөдөлгөөнийг хийж үзүүлээрэй гэнэ. “Гараа алдлаарай”, “Хөлөө хажуу тийш өргөөрэй” гэх мэтээр хэд хэдэн хөдөлгөөнийг нэрлэх явцдаа хэн зөв, буруу хийж байгааг ажиглан, тэмдэглэх |
| 3 | - Их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон бөмбөг дамжуулах буухиа тоглоом тоглох | - Буухиаг 3 удаа тоглоход хэний баг олон удаа түрүүлж, хоцров гэдгээр нь үнэлэх<br>- Танай баг яагаад түрүүлсэн бэ?, танайх яагаад хоцров гэсэн асуулт тавих |
| 4-5 | - Багшийн нэрлэсэн гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөний зургийг олох<br>- Зураг дээрх хөдөлгөөнийг нэрлэх<br>- Өглөөний цогц дасгалыг өөрсдөө тоолж гүйцэтгэх | - Нэг багийн сурагч багшийн нэрлэсэн хөдөлгөөний зургийг олж өргөхөд нөгөө багийн сурагч зөв эсэхийг хэлэх. Буруу байвал зөвийг нь олж өгөх<br>- Нэг багийн сурагч ямар нэг хөдөлгөөний зургийг өргөхөд нөгөө багийн сурагч түүнийг нэрлэх. Буруу нэрлэвэл зураг өргөсөн сурагч өөрөө зөв нэрлэж хэлэх<br>- 6-8 сурагч нэг баг болж өглөөний цогц дасгалыг гүйцэтгэж үзүүлэхэд бусад нь хэн зөв, хэн буруу хийж байгааг ажиглан, дасгал дууссаны дараа сайн болон тааруу хийсэн эсэхийг хэлэх<br>- Үндсэн хөдөлгөөнийг маш гоё гүйцэтгэж буй сурагчийг жагсаалын өмнө гарган дасгалыг үзүүлж болно. |
| 6 | Өглөөний 24 тоот цогц дасгалыг хөгжмийн аянд ангиараа хийж үзүүлэх тоглолтод оролцох | - Үзүүлэх тоглолтод оролцсон бүх сурагчийг нэгж хичээлийн хүлээгдэж буй үр дүнг хангасан гэж үзэх<br>- 24 тоот цогц дасгалыг хөгжмийн аянд ангиараа зөв, итгэлтэй, нэгэн зэрэг гүйцэтгэх шалгуурыг хангаж буй эсэхийг харгалзан маш сайн байна, гоё хийгээрэй, дахиад оролдоод үзээрэй гэх зэрэг үгээр үнэлэх<br>- Хэрэв өглөөний дасгалаа сайн сураагүй сурагч байвал энэ үзүүлэх тоглолтын видео бичлэгийг эцэг, эхэд нь өгч өглөө бүр дасгалаа хийж байхыг зөвлөх |

# 3. УРЛАГ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИ

## 3.1. УРЛАГ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН СУДЛАГДАХУУНЫ ИНТЕГРАЦ

Нийгэм, эдийн засаг, техник технологи өндөр хөгжиж буй өнөө үед хөгжлийг дагасан сөрөг үзэгдлүүд, түүнтэй холбоотой яаралтай шийдвэрлэх олон асуудлууд дэлхийн улс орнуудад тулгараад байгаа билээ.

Тогтвортой хөгжил ба ТХБ-ын холбоо хамаарлыг 2016 онд хийгдсэн "Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа"-ны тайланд "Тогтвортой хөгжил бол хүн бүрд хамаатай, газар бүр хэрэгжих учиртай нийгэм бүхэлдээ өөрчлөн шинэчлэгдэх үйл явц харин Тогтвортой хөгжлийн боловсрол бол байнгын шинэчлэл бүхий энэхүү үйл явцыг хэрэгжүүлэх арга зам" хэмээн тодорхойлсон байна. Энэ нь боловсролоор дамжин тогтвортой хөгжилд хүрэх ойлголттой нийцэж байгаа юм.

Дэлхий нийтээр боловсролыг өөрчлөлтийн хөдөлгөгч хүч, тогтвортой хөгжлийн боловсрол нь тогтвортой хөгжлийг хангах хамгийн чухал суурь гэж[7] үзэж байгаа энэ үед суралцагчдыг ухаалаг, хариуцлагатай хэрэглээнд суралцахад нь урлаг, дизайн технологийн хичээл тодорхой хувь нэмэр оруулахаар байна.

ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөний дагуу дуу хөгжмийн хичээлийг I-IX ангид, дүрслэх **урлагийн хичээлийг I-VIII ангид, дизайн технологийн хичээлийг I-XII ангид тус тус судалж** байна. Мөн хөгжим, дүрслэх урлаг, дизайн технологийн хичээл бага боловсролд зорилго, хүрэх үр дүнгээр нэг, агуулга, аргазүй, үнэлэх шалгуур нь тус тусдаа, суурь боловсролд хөгжим, дүрслэх урлагийн хичээл зорилго, зорилт, хүрэх үр дүн нэг бол, дизайн технологийн хичээл нь бие даасан байдлаар судлахаар сургалтын хөтөлбөрт тусгагдсан байдаг. Иймд бид энэхүү судлах агуулгын хүрээнд шинжилгээг хийсэн болно.

Урлагийн бага болон суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго нь "Сурагчийг хүрээлэн буй орчин, юмс, үзэгдэл, урлагийн бүтээлийг танин мэдэх арга барилтай, өөрийн авьяас, гоо сайхны мэдрэмжээ бүтээлчээр илэрхийлж, хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, урлаг соёлыг эрхэмлэдэг иргэн болж төлөвших"-д дэмжлэг үзүүлэх бол дизайн технологийн суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго нь "сурагчийг дизайн, техник, технологийн үйл явцыг танин мэдэх арга барилаа хөгжүүлж, байгаль, үндэсний соёлоо дээдэлсэн, бүтээлч сэтгэлгээтэй, дизайны шийдэл гаргах, бүтээх, үнэлэх чадвар эзэмшсэн иргэн болж төлөвших"-д[8] дэмжлэг үзүүлэхээр тодорхойлсон байдаг.

7 НҮБ-ын ЕА эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр
8 БСШУЯ. (2015). Суурь боловсролын цөм хөтөлбөр. УБ.

Энэхүү сургалтын хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлснээр ТХ-ийн зорилго, зорилт, тогтвортой байдлын цогц чадамжийг төлөвшүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах боломжтой байна. Тухайлбал:

- Уур амьсгалын өөрчлөлт түүний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг яаралтай авах, экологийн системийг хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилттэй тэмцэх, хариуцлагатай тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих зорилгуудтай урын сан, үйлээр дамжин хамаарах боломжтой юм.
- Мөн ТХ-ийн эдгээр агуулгыг дизайн технологийн хичээлд дизайны шийдэл гаргах, бүтээх, үнэлэх, ахуй амьдрал, нийгэмд чиглэсэн дизайн технологийн асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж хамтран ажилладаг, уламжлалт болон орчин үеийнхээр агуулгыг дизайн технологийн хичээлд дизайны шийдэл гаргах, бүтээх, үнэлэх, ахуй амьдрал, нийгэмд чиглэсэн дизайн технологийн асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмүүлнэ. Харин дуу хөгжмийн хичээлийн хувьд дээрх агуулгыг дуулах, хөгжимдөх, зохион найруулах үйлд тулгуурлан, урлагийн бүтээлээр дамжуулан мэдэрч ойлгох, сонирхон судлах, асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, хамтран ажиллах замаар бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцахад чиглэсэн байна.

## Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бүх шатны сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, багшлах арга зүйд тогтвортой хөгжлийн үзэл санааг тусган хэрэгжүүлэх, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд сургалтын байгууллагууд хувь нэмэр оруулах, харилцан туршлага солилцож, хамтран ажиллах нь тогтвортой хөгжлийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх бодит үйл хэрэг болох гол арга зам байна[9] гэж тусгажээ.

Урлаг, дизайн технологийн хичээлүүдийн цөм хөтөлбөр дэх ТХБ-ын агуулгын интеграцчилагдсан байдлыг төслийн ерөнхий дизайны дагуу матриц 1-д тодорхойлоход нийт 37[10] суралцахуйн зорилт тодорхойлогдсоныг судлагдахуунаар, боловсролын түвшнээр, ТХЗБ-ын суралцахуйн зорилтоор ялгаж харууллаа (Хүснэгт 3.1). Хичээл тус бүрээр тодорхойлогдсон суралцахуйн зорилт тус бүрийг ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй холбогдох байдлыг матриц 1-ээс, арга зүйн интеграцчилал буюу ТХЗБ-ын сургалтын аргын төрөл, ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмрийг хэрхэн тодорхойлсныг матриц 2-оос үзнэ үү.

Урлаг, дизайн технологийн хичээлд эдгээрийг хэрхэн интеграцчилах арга замыг тодорхойлохдоо бага боловсролын хөгжим, дүрслэх урлаг-технологи, суурь боловсролын хөгжим, дүрслэх урлаг, дизайн технологийн сургалтын хөтөлбөрийн агуулга болон ТХБ-ын суралцахуйн зорилт, сэдэв нэг бүрийг харьцуулан авч үзсэн болно. Тухайлбал

- Бага боловсролын дүрслэх урлаг-технологийн сургалтын хөтөлбөрийн "3,01.9.[11] Байгалийн материалыг баримлын шавраар холбох аргаар биет тоглоом хийх" агуулга нь ТХ-ийн "Газар дээрх амьдрал"-ын талаарх 15 дугаар зорилгын "Суралцагч орон нутгийн байгаль орчинтой харилцаж, дэлхий дээрх хүний бус аж амьдралыг ойлгож чаддаг болох" суралцахуйн зорилттой холбогдож байна.

---

9 БСШУ-ны сайдын 2016.11.13, хавсралт.,

10 Урлаг, дизайн, технологийн судлагдахууны чиглэлээр бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд нийт 48 суралцахуйн зорилт тодорхойлогдсон хэдий ч техникийн шалтгаанаар Бүрэн дунд боловсролын түвшинд жишээ болгосон Нэгж хичээл боловсруулаагүй тул энд Бага болон Суурь боловсролын хувьд интеграцчиллыг тайлбарлав.

11 Дүрслэх, технологийн матриц 1-ээс

- Харин суурь боловсролын урлагийн сургалтын хөтөлбөрийн "9,03.1.[12] Хөгжмийн бүтээлийг сонирхон судлах замаар орчин үеийн хөгжмийн зохиолчдын арга барил, бүтээлийн талаар мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, сонсох хөгжмийн урын сан бүрдүүлж, бусадтай санаа бодлоо хуваалцана. С.Сансаргэрэлтэх – "Эх дэлхийгээ аварцгаая" зохиолын агуулга нь "Уур амьсгалын төлөөх үйл хэрэг"-ийн талаарх 13 дугаар зорилгод тодорхойлогдсон "Суралцагч нь нийтээрээ хүлээн зөвшөөрсөн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх стратегийг боловсруулж бусадтай хамтран ажиллаж чаддаг болох" суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх боломжтой байна.

*Тайлбар:* Сургалтын хөтөлбөрийн агуулгыг дараах байдлаар кодлон тэмдэглэсэн болно. Тухайлбал: 3,01.9 нь бага боловсролын дүрслэх урлаг-технологийн сургалтын хөтөлбөрийн "анги тус бүрийн агуулга"-ын 3 дугаар ангийн "Урлагийн хэл" хам сэдвийн "Зохиомжийн хэрэгсэл тэдгээрийг ашиглан зурах дүрслэх зохион бүтээх арга барил эзэмших" бүлэг буюу 01, агуулгын 9 дэх суралцахуйн зорилт "Байгалийн материалыг баримлын шавраар холбох аргаар биет тоглоом хийх" гэж ойлгож уншина. (БСШУЯ., Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр., 2015., 58-59)

Харин "9, 03.1" нь суурь боловсролын хөгжмийн сургалтын хөтөлбөрийн "анги тус бүрийн агуулга"-ын 9 дүгээр ангийн 03 буюу "Хөгжимдөх" хэсгийн 1. Хөгжмийн бүтээлийг сонирхон судлах замаар орчин үеийн хөгжмийн зохиолчдын арга барил, бүтээлийн талаар мэдээлэл цуглуулах, задлан шинжлэл хийх, сонсох хөгжмийн урын сан бүрдүүлж, бусадтай санаа бодлоо хуваалцана" агуулгыг кодолсон болно.

Шинжилгээг хийхдээ дараах шаардлагыг баримталсан болно. Үүнд:

- ТХ-ийн зорилго, сэдэв болон суралцахуйн зорилтын холбоо хамаарал, тэдгээрийн ерөнхий зүй тогтол буюу түлхүүр үгийн сонголтыг харгалзах,
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хэрэглэгдэхүүн буюу урын сангийн жагсаалтыг гаргах,
- Урлаг, дүрслэх урлаг-технологийн хичээлийн агуулга алдагдахгүй хэрэгжих боломжтой байх,
- Сургалтын хөтөлбөрийн агуулгыг ТХБ-той интеграцчилахад багш санаа авахаар тодорхой байх

Агуулгыг сонгохдоо ТХ-ийн зорилгын суралцахуйн зорилт болон тогтвортой байдлын цогц чадамжид баримжаалсан бөгөөд багш эдгээрээс санаа авч өдөр тутмын хичээлээ боловсронгуй болгож, хэрэглээ талаас нь суралцагчдад ойлгуулахад дөхөм болох байдлыг түлхүү харгалзсан болно.

Урлаг, дүрслэх урлаг хичээлийн агуулга нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт, агуулга, зорилготой шууд бус давхцаж байна. Тухайлбал: сургалтын хөтөлбөрийн 2-р ангийн "Аялгууны шинж төрхийг ойлгох, сонсож таних, тодорхойлох, ялгах, тайлбарлах" суралцахуйн зорилт нь ТХ-ийн 11-р зорилготой шууд холбогдохгүй хэдий ч "Хувдай ишигний паян" зохиолоор дамжуулан суурин амьдралын хэв маягийн түүхэн шалтгааныг ойлгож, соёлын өв уламжлалыг хүндэтгэдэг, ойлгодог болоход дэмжлэг үзүүлэхээр байна.

Харин Дизайн технологийн хичээлийн агуулга нь ТХБ-ын зарим суралцахуйн зорилт, агуулга, зорилготой шууд холбогдож байна. Тухайлбал: 6-р ангийн "Техник" агуулгын хүрээнд "хэрэглээнээс гарсан боловч дахин ашиглах боломжтой материалуудыг сонгон ашиглах, хэрэгцээт эд зүйлс хийх, бүтээх хандлагатай болно" суралцахуйн зорилт нь ТХ-ийн 12-р зорилготой шууд холбогдож байна.

12 Хөгжмийн матриц 1-ээс

*Хүснэгт 3.1. Урлаг, дизайн технологийн сургалтын цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт*

| ТХЗорилго | Хөгжим | | Дүрслэх урлаг | | Дизайн технологи | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| | бага | суурь | бага | суурь | суурь | |
| ТХ301. Ядууралгүй байх | | | | | | 0 |
| ТХ302. Өлсгөлөнгүй тэглэх | | | | | 1 | 1 |
| ТХ303. Эрүүл мэнд ба сайн сайхан байдал | 2 | 1 | 1 | | 1 | 5 |
| ТХ304. Чанартай боловсрол | 1 | 1 | | 1 | 3 | 6 |
| ТХ305. Жендэрийн тэгш байдал | | | | | | 0 |
| ТХ306. Цэвэр ус ба ариун цэвэр | 1 | 1 | | | | 2 |
| ТХ307. Боломжийн үнэтэй, цэвэр эрчим хүч | | | | | | 0 |
| ТХ308. Зохистой ажил ба эдийн засгийн өсөлт | | | 1 | | 2 | 3 |
| ТХ309. Үйлдвэрлэл, инновац, дэд бүтэц | | | | | 1 | 1 |
| ТХ310. Тэгш бус байдлыг багасгах | | | | | | 0 |
| ТХ311. Тогтвортой хот суурин, оршин суугчид | 1 | | 1 | 1 | | 3 |
| ТХ312. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл | | | 2 | 1 | 3 | 6 |
| ТХ313. Уур амьсгалын төлөөх үйл хэрэг | 1 | 1 | | | | 2 |
| ТХ314. Усан доторх амьдрал | | | | | | 0 |
| ТХ315. Газар дээрх амьдрал | | 1 | 1 | 3 | 1 | 6 |
| ТХ316. Энх тайван, шударга ёс, хүчирхэг институтууд | 1 | | | | | 1 |
| ТХ317. ТХЗ-ын төлөөх түншлэл | | | | | 1 | 1 |
| Нийт | 7 | 5 | 6 | 6 | 13 | |

ТХ-ийн 17 зорилгоос ТХ303, ТХ304, ТХ312, ТХ315-д хамаарах суралцахуйн зорилт түлхүү байна. Энэ нь газар дэлхийн гоо сайхан болон мөхөл сүйрлийг хөгжим, уран зургаар илүү тод томруун илэрхийлдэгтэй холбоотой юм.

ТХ303. Эрүүл мэнд, сайн сайхан байдалд харгалзаж байгаа суралцахуйн зорилт нь хөгжмийн суралцахуйн зорилт байгаа бол ТХ312. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлд харгалзах суралцахуйн зорилт дүрслэх урлаг, дизайн технологийн хичээлийнх байна. Харин хамгийн нийтлэг интеграцчилал нь газар дээрх амьдралд хамаарч байна.

ТХ304. Чанартай боловсролын зорилгод хамаарах ТХ-ийн сэдэв, суралцахуйн зорилт тус гурван хичээлийн хөтөлбөрт тодорхой хэмжээнд орсон байна.

*Зураг 3.1. Урлаг, дизайн, технологийн цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт (ТХЗ-оор, хувиар)*



Урлаг, дизайн технологийн хичээлүүдийн ТХЗ-той интеграцчилагдсан байдлаас харахад бага боловсролын түвшинд НСХ-ийн суралцахуйн зорилт их байгаа нь Урлаг/хөгжим, дүрслэх урлаг, технологи/-ийн агуулгад суралцагч гоо сайхныг мэдрэх, түүнийгээ бүтээлчээр илэрхийлэх аргад суралцахаар тусгагдсантай холбогдож байна. Эдгээрийг хичээлийн арга зүйн шийдэл, урын сангийн сонголтоор сурагчдад хандлага, зан үйл төлөвших, ТХ-ийн асуудалд хувь хүний ёс зүйгээр ханддаг чадвар эзэмшүүлэхэд чиглүүлж өгнө гэж үзэж байна. Тухайлбал:

*Танин мэдэхүйн*: Даяаршил, хөгжлийн асуудалтай холбогдох мэдээлэл цуглуулах, боловсруулах, даяаршсан дэлхий дэх нийгэм-соёл, байгалийн олон янз байдлыг танин мэдэх, даяаршил, хөгжлийн үйл явцад ТХ-ийн зарчмын үүднээс дүн шинжилгээ хийж, танин мэдэхүйгээ хөгжүүлнэ. Ингэхдээ сурагчид урлагийн бүтээлээр дамжуулж ойлгох болно.

*Нийгэмшил сэтгэл хөдлөл*: Хувь хүнээс эхлүүлэн даяаршил хүртэлх нийгмийн харилцааны янз бүрийн түвшнийг мэдэх, хөгжлийн үйл явцад тэдгээрийн үүргийг ойлгох, нийгмийн харилцааны түвшин хоорондын ялгаатай байдал, урлаг, соёлын олон талт хүчин зүйлсийг ойлгох, хүндэтгэхэд чиглэгдэнэ.

*Зан үйлийн*: Хүн төрөлхтөн, хүрээлэн буй орчны өмнө хүлээх хувь хүний хариуцлагаа ухамсарлах, харилцах, хамтран ажиллахад нийгэм-соёлтой холбогдох бэрхшээлийг даван туулах, өөрчлөлтөд нийгмийн зүгээс хийх үйлийн талаар тодруулах, ялангуяа тодорхой бус нөхцөлд санаачилгатай байх, асуудлын бэрхшээлтэй талыг бууруулах, тэвчээртэй хандах зэргээр хувь хүний чадвараа хөгжүүлэх, ТХ-ийн зорилгуудыг амьдрал, сургууль, мэргэжил, ажилдаа хэрэгжүүлэх, түүнд тулгуурлан шийдвэр гаргах, үйл хийх, нийгэм, улс төрийн асуудалд идэвхтэй оролцох зэргээр хувь нэмрээ оруулна.

*Зураг 3.2. ТХЗ-д хамаарах Урлаг, дизайн технологийн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт (хувиар)*




*а. ТХБ-ын суралцахуйн зорилтын айгаар*




*б. Боловсролын түвшнээр*

Сургалтын цөм хөтөлбөрт дүрслэх урлаг, хөгжмийн хичээл нь зорилго, сурах арга барил, хүрэх үр дүнгээр нэгдсэн тус тусдаа бие даасан агуулгыг судална гэж дээр дурдсан бөгөөд аливаа юмс үзэгдэл, урлагийн бүтээлийг мэдэрч ойлгох, сонирхон судлах, бүтээх, хөгжүүлэх, илэрхийлэх, үнэлэх арга барил, гүйцэтгэлийн чадвараа хөгжүүлэх, бүтээлчээр сэтгэн өөрийн санааг илэрхийлэх аргад суралцах, өдөр тутмын амьдралд хэрэглээ болгоход чиглэсэн чадвараар илэрхийлэгдэнэ гэж тодорхойлсон нь ТХ-ийн НСХ-ийн зорилт нэмэгдэж байгаатай илүү хамаарч байгаа харагдаж байна.

Урлаг, дизайн технологийн хичээлийн суралцахуйн зорилт буюу агуулга нь ТХ, ТХБ-той шууд холбогдохгүй хэдий ч тэдгээрт ашиглаж байгаа сургалтын хэрэглэгдэхүүн болох уран бүтээлээр дамжуулан ТХ, ТХБ-ын мэдлэг, ойлголтыг бататгахад дэмжлэг үзүүлэх нь харагдаж байна.

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Урлаг, дизайн технологийн цөм хөтөлбөрийн тухайн суралцахуйн зорилтыг ТХБ-той интеграцчилсан байдлаар хэрэгжүүлэхэд тохиромжтой аргыг сонгож, түүний үндэслэлийг тодорхойлсныг матриц 2-оос дэлгэрэнгүйгээр үзэж болох бөгөөд ТХЗ-ын төлөөх боловсролыг хэрэгжүүлэх аргуудаас бага боловсролд бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд түлхүү ашиглагдахаар харагдаж байна. (Хүснэгт 3.2) Энэ нь бага насны хүүхэд аливаа үйлийг хийх явцдаа сурч, мэддэг онцлогтой нийцэж байна.

Харин суурь боловсролд шинжилгээ/судалгаа хийх, бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд ашиглагдах боломжтой байна. Эдгээр нь эссэ бичих, хэлэлцүүлэг хийх, дүрд тоглох, экскурс, аялал хийх зэргээр хэрэгжих боломжтой юм.

*Хүснэгт 3.2. Урлаг, дизайн, технологийн сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗ-ыг хангах сургалтын арга*

| Арга зүй | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Боловсролын түвшин | Бага | | | | Суурь | | | |
| Цогц чадамж | Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох аргууд | Шинжилгээ/судалгаа хийх аргууд | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд | Алсын хараатай болох аргууд | Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох аргууд | Шинжилгээ/судалгаа хийх аргууд | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд | Алсын хараатай болох аргууд |
| Хөгжим | 4 | - | 6 | 1 | 3 | 6 | 6 | - |
| Дүрслэх урлаг | - | 6 | 5 | 1 | 3 | 5 | 4 | - |
| Дизайн- технологи | | | | | 5 | 4 | 2 | 4 |
| Нийт | 4 | 6 | 11 | 2 | 11 | 15 | 12 | 4 |

Тухайн судлагдахууны болон суралцахуйн зорилтын онцлогоос хамааран нэг суралцахуйн зорилтод 1-2 хүртэл төрлийн арга хэрэглэх боломжтой бөгөөд энэ нь сургалтын хөтөлбөрийн бүтээлч эрэлхийллийн арга барил эзэмшүүлэхэд чиглэгдсэн аргазүй, аргатай нийцэж байгаа юм.

Үүнээс гадна Дүрслэх урлаг - технологи хичээлийн хувьд ТХЗБ-ын суралцахуйн нэг зорилт, сэдэвт хамаарах судлагдахууны хэд, хэдэн суралцахуйн зорилт гарч ирсэнтэй холбоотой *8 дугаар багана буюу Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар, үндэслэлийг* ялгаатай байдлаар бичих боломжгүй байсан. Учир нь тухайн судлагдахууны онцлогтой холбоотойгоор сонгон хийх бүтээл, хийх арга технологи, хэрэглэх багаж, материал, хэрэглэгдэхүүнээс хамааран агуулгын өргөсөл, гүнзгийрэл тодорхойлогддог. Иймээс ерөнхий арга зүйг ялгаатайгаар томьёолох боломж харагдахгүй байна гэж үзээд ижил томьёолоотой суралцахуйн

зорилтуудын *8 дугаар багана буюу “Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар”* гэсэн нүдийг нэгтгэн тайлбар бичсэн болно.(матриц 2-оос дэлгэрүүлж үзнэ үү)

Шинжилгээнээс үзэхэд тогтвортой байдлын цогц чадамжийг сурагчдад эзэмшүүлэхэд урлаг, дизайн технологийн хичээл дараах байдлаар хувь нэмэр оруулах боломжтой байна. Үүнд:

*Хүснэгт 3.3. ТБ-ын цогц чадамжийн төлөвшилд урлаг, дизайн технологийн сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр*

| Цогц чадамж | Бага боловсрол | | Суурь боловсрол | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| | Хөгжим | Дүрслэх, дизайн технологи | Хөгжим | Дүрслэх урлаг | Дизайн технологи | |
| 1. Тогтолцоот сэтгэлгээний | | 4 | 2 | 4 | 4 | 14 |
| 2. Урьдчилан тооцоолох | 1 | | 1 | | 2 | 4 |
| 3. Хэм хэмжээний | | | 1 | 1 | 1 | 3 |
| 4. Стратегийн | | | | | 2 | 2 |
| 5. Хамтран ажиллах | 1 | 2 | 1 | 1 | 2 | 7 |
| 6. Шүүмжлэлт сэтгэлгээний | 3 | 3 | 1 | 2 | 1 | 10 |
| 7. Өөрийгөө таньж мэдэх | 2 | 2 | 1 | 4 | | 9 |
| 8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн | | | | | 1 | 1 |
| Нийт | 7 | 11 | 7 | 12 | 13 | 50 |

- *Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж:* Урлаг, дизайн технологийн хичээлээр тогтолцоот сэтгэлгээг хөгжүүлэх нь сурагчдад аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэж ойлгох, тэдгээрийг хэрхэн уялдан нэгдсэн тухай сэтгэн бодох чадварыг хөгжүүлснээр орон нутаг, улс үндэстэн, дэлхий нийтийн ТХ-ийн зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

- *Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж:* Тогтсон хэм хэмжээ, дадал туршлага, санаа бодолдоо тулгуурласан асуудал дэвшүүлэх, өөрийн үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох, тогтвортой байдлын тухай хэлэлцүүлэгт өөрийн байр сууринаас хандах зэрэг чадваруудыг энэ цогц чадамжид хамруулж үздэг. Урлаг, дизайн технологийн хичээлүүд нь сурагчдын бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн төсөлт ажил гүйцэтгэх, өөрийн үзэл бодлоо бүтээлдээ тусгаж, үнэт зүйлийг бий болгож, эзэмшиж байдаг, өөрийгөө илэрхийлэх, бусдыг сонсох, хүндэтгэх зэргээр ТХ-ийн цогц чадамжийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулдаг учраас суралцахуйн зорилт харьцангуй олон байна.

- *Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж:* Энэ цогц чадамжийн хүрээнд дэлхийн болон орон нутгийн түвшинд өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох, хэн нэгний үйл хэрэгт үнэлэлт дүгнэлт өгөх, урам хайрлах, мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх чадварыг багтаадаг. Урлаг, дизайн технологийн хичээл хүний үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөө, тэдгээрийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд өөрийн үүрэг оролцоо чухал болохыг бүтээлээрээ дамжуулан үзүүлэх боломжтой учраас энэ цогц чадамжид хувь нэмэр оруулах боломжтой гэж үзсэн.

Урлаг, дизайн технологийн судлагдахуунаар боловсруулсан нэгж хичээлийн товчоог Хүснэгт 3.4-д үзүүллээ.

*Хүснэгт 3.4. Урлаг, дизайн технологийн судлагдахууны нэгж хичээлийн товчоо*

| түвшин | хичээл | анги | сэдэв | Хичээлийн зорилго, агуулга | Боловсруулсан |
|---|---|---|---|---|---|
| Бага боловсрол | Хөгжим | III | Ус амьдралыг тэтгэгч /Ногоон дэлхийгээ аваръя/ | Суралцагч урлагийн бүтээлүүдээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг, өөрийнхөөрөө дүрслэн бодож харьцуулдаг болно. | Халтарын Энхжаргал (БХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан) |
| | Дүрслэх урлаг | V | Эрүүл зөв хооллолт ба өглөөний зууш | Эрүүл зөв хооллолт болон хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарын талаар судалж өглөөний хоол бэлтгэж сурна. | Сиятовын Отгонтуяа (БХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан) |
| Суурь боловсрол | Хөгжим | IX | Уур амьсгалын өөрчлөлт /Б.Мөнхболд "Шар тэнгисийн тарчлаан" жүжиг/ | Орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж сонсох, агуулга дүрийг харьцуулан судлах явцдаа уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг, урьдчилан сэргийлэх арга замыг эргэцүүлэн бодож чаддаг болно | Халтарын Энхжаргал (БХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан) |
| | Дүрслэх урлаг | VIII | Монголын орчин үеийн уран бүтээлчдийн зураг бүтээлтэй танилцах | Зураач Я. Булган “Судар ижий”, зураач С. Заяасайхан “Амьд үлдэгсэд” уран бүтээлийн агуулга, утга санаа, уран дүрслэлээр дамжуулан ТХ-ийн үзэл санаа, ойлголтыг нэмэгдүүлэх, бусдад таниулах, сурталчлахад соёлын үүрэг чухал болохыг ойлгодог болно. | Сиятовын Отгонтуяа (БХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан) |
| | Дизайн -технологи | VI | Хэрэгцээ ба ашиглалт | Хэрэглээнээс гарсан дахин ашиглах боломжтой материалуудыг боловсруулахтай холбоотой баримт мэдээллийг судлах, нөөцлөх. хэрэгцээг өрнүүлэх замаар эд зүйл бүтээнэ. | Баатарын Баттулга (БМДИ-ийн арга зүйч) |

*Хүснэгт 3.5. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хөгжим хичээлийн матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. Соёлын үнэт зүйл | 1,3.2 Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах-Шүдээ хайрлая, шүдээ угаацгаая | ТХ303.ЗҮ1 | ТХ33.Сэ3 |
| 1. Соёлын үнэт зүйл | 1,3.3 Хөгжмийн урлагийг ойлгосноор дэлхийн болон ардын урлагийн өв сан, үнэт зүйлсийг хүндлэх, биширэх, хамгаалах-Номын нөхөр болоорой | ТХ304.ТМ4 | ТХ34.Сэ5 |
| 1. Урлагийн хэл | 1,1.4 Хөгжмийн бүтээлийн утга агуулга, дүр дүрслэлээс хурд, хүчний үүргийг ойлгох, илэрхийлэх- Цэвэр гар | ТХ303.ЗҮ1 | ТХ33.Сэ1 |
| 2.Урлагийн хэл | 2, 2.5 Аялгууны шинж төрхийг ойлгох, сонсож таних, тодорхойлох, ялгах, тайлбарлах- Хувдай ишигний паян | ТХ311.ТМ3 | ТХ311.Сэ5 |
| 3. Соёлын үнэт зүйл | 3, 3.2 Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах- Ногоон дэлхийгээ аваръя | ТХ313.НСХ1 | ТХ313.Сэ11 |
| 4. Гоо сайхны илэрхийлэл | 4, 2.1 Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг график дүрслэлээр зурах, бичих, жүжигчлэн тоглох- Д.Дашням "Хиросимо охины цаасан шувуу" | ТХ316.НСХ3 | ТХ316.Сэ6 |
| 5. Соёлын үнэт зүйл | 5,3.1 Өөрийн орны болон гадаадын хөгжмийн зохиолчдын бүтээлтэй танилцах, сэтгэгдлээ ярилцах- Ж.Чулуун "Уулын горхи" | ТХ306.НСХ3 | ТХ36.Сэ6 |

*Хүснэгт 3.6 .Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Дүрслэх урлаг, технологи хичээлийн матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 5. Урлагийн хэл | 5, 01.14. Энгийн орц найрлагатай зууш бэлтгэх | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ09. |
| 4. Урлагийн хэл | 4, 01.14. Ажил мэргэжлийн талаарх ойлголттой болох | ТХ308.НСХ4. | ТХ308.Сэ01. |
| 5. Гоо сайхны илэрхийлэл | 4, 02.15. Хаягдал материал ашиглан бүтээл хийх | ТХ312.ЗҮ1 | ТХ312.Сэ07. |
| 5. Соёлын үнэт зүйл | 5, 03.5. Монголын болон гадаадын уран зураачдын уран зураг унших | ТХ311.ТМ3. | ТХ311.Сэ05. |
| 3. Гоо сайхны илэрхийлэл | 3, 02.4. Бүтээлийн онцлог шаардлагад нийцүүлэн материал багаж хэрэгсэл сонгох, ашиглах | ТХ312.ТМ4. | ТХ312.Сэ02. |
| 3. Гоо сайхны илэрхийлэл | 3, 01.9. Байгалийн материалыг (шарлаж унасан навч, чулуу, хугарч унасан мөчир, боргоцой гэх мэт) баримлын шавраар холбох аргаар биет тоглоом бүтээх | ТХ315.НСХ3. | ТХ315.Сэ08. |

# 3.2. ХӨГЖИМ

## 3.2. А. БАГА БОЛОВСРОЛЫН ХӨГЖМИЙН ХИЧЭЭЛИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Тогтвортой хөгжлийн боловсролоор хүмүүсийн мэдлэг, чадвар, хандлага, үйлдэл, үнэ цэнийг өөрчлөхийг зорьдог тул урлагийн хичээлийн хөтөлбөрийн агуулгад энэхүү үзэл санааг хэрхэн, яаж тусгаж оруулах вэ? гэдэг асуудал гарч ирж байна.

Өөрийн орны болон дэлхийн хөгжмийн зохиолчдын уран бүтээлээр дамжуулан байгаль орчин, ус, тогтвортой хэрэглээ, соёл хоорондын харилцан ойлголцол, соёлын ялгаатай байдал, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийг бүхэлд нь багтаан, харилцан хамааралд нь ойлгуулж, суралцагчдыг тогтвортой хөгжлийн боловсролтой иргэн болгож төлөвшүүлэхэд хөгжмийн хичээлийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол их юм.

Урлагийн аль ч хичээлийн төлөвлөлтөд тогтвортой хөгжлийн үзэл санааг дараах байдлаар тусгаж болно. Үүнд:

- Тогтвортой хөгжилд хамааралтай чадварыг тодорхойлж, сурагчдад эзэмшүүлж, хөгжүүлэхэд анхаарна. Жишээ нь:Сурагчдын ирээдүйг төсөөлөн харах чадвар, асуудал юмсын холбоо хамаарлыг ойлгох, хүлээж авах, шийдвэр гаргахад оролцох, асуудал шийдэх, хамтран ажиллаж нэгдсэн нэг шийдэлд хүрч чаддаг байх, асуудал, юмс үзэгдлийг цогцоор харах, шүүмжлэлтэйгээр эргэцүүлэн боддог байх.

Түүнчлэн сургалтын хөтөлбөрийн арга зүй нь шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлыг энгийн ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэхэд чиглэсэн байна. Сурагч өөрийн үйл ажиллагаагаар мэдлэг бүтээхэд хөтөлсөн орчин, нөхцөлийг бүрдүүлж, хүснэгт, график, бүдүүвч, зураг, бичвэрийг оновчтой сонгох шаардлагатайг анхаарах нь зүйтэй.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Ерөнхий боловсролын сургалтад ТХБ-ын интеграцчилах багшид зориулсан гарын авлагын хүрээнд “Хөгжим”-ийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг ТХ-ийн 17 зорилготой уялдуулахын тулд дараах байдлаар шинжилгээ хийсэн болно. Шинжилгээ хийхдээ:

- Тухайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хэрэглэгдэхүүн буюу урын сангийн жагсаалтыг гаргаж түүн дээр тулгуурлан ТХ-ийн зорилгыг сургалтын хөтөлбөрийн зорилттой уялдуулах оролдлого хийсэн болно.
- ТХЗ-ын сурагчдад эзэмшүүлэх үйл буюу чадварыг суралцахуйн зорилтын танин мэдэхүйн үйлтэй холбохыг оролдсон.

Тогтвортой хөгжлийн зорилго, хөгжмийн хичээлийн суралцахуйн зорилтын хамаарлыг шинжилж үзэхэд бага боловсролын түвшинд нийгэмшил сэтгэл хөдлөл болон зан үйлийн зорилт түлхүү байсан бөгөөд шинжилгээний үр дүнг хүснэгтээр харуулбал:

*ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт*

| Ай | Танин мэдэхүйн | Нийгэмшил, сэтгэл хөдлөл | Зан үйл | Нийт |
|---|---|---|---|---|
| Суралцахуйн зорилтын тоо | 1 | 4 | 2 | 7 |

Бага боловсролд тогтвортой хөгжлийн “Суралцагч экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг болох” зорилгыг сургалтын хөтөлбөрийн “Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах” зорилттой уялдуулахдаа *тайлбарлаж чаддаг болох- тайлбарлах, харьцуулах* гэсэн үйл үгээр нь холбож сонгосон болно. Эдгээр зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд “Ногоон дэлхийгээ аваръя” зохиол гол хэрэглэгдэхүүн болно.

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

ТХЗ-ыг хэрэгжүүлэх арга зүйг суралцахуйн зорилтын хүрээнд хийх үйл ажиллагаатай холбож сонгосон болно. Бага боловсролд бодит үйл ажиллагаанд оролцох, бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх арга зүй голлох бөгөөд экологийн тэнцвэр алдагдах хүчин зүйлсийн нэг нь хувь хүмүүсийн ёс зүй бөгөөд экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж, өөрийнхөөрөө дүрслэн бодож, харьцуулдаг болоход “Ногоон дэлхийгээ аваръя” бүтээл чухал ач холбогдолтой болно.

*Аргазүйн төрлийг сонгосон байдал (давхардсан тоогоор)*

| Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох аргууд | Шинжилгээ/ судалгаа хийх аргууд | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд | Алсын хараатай болох аргууд |
|---|---|---|---|
| 2 | 0 | 4 | 1 |

*Хүснэгт 3.7.* Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хөгжим)

| Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | | | | | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/өнгөрснийг нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар /суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| 2 | 3 | | | | | 4 | 5 | 6 | 7 | | | | 8 | 9 | 10 |
| 1,3.2 Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах-Шүдээ хайрлая, шүдээ угаацгаая | ☐ | | | | | ТХ303.ЗҮ1 | ТХ33.Сэ3 | Эрүүл мэнд болон сайн сайхан амьдралыг дэмжих гол стратегиудад эрүүл хүнс, биеийн тамирын дасгал, эрүүл мэндийн зөвлөгөө, боловсрол байдаг учраас Шүдээ хайрлая дуугаар дамжуулан суралцагч эрүүл амьдралын зан төлөвийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлж сурахад холбоотой юм. | | | ☐ | | 3-р арга зүйн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах үйл ажиллагаанд оролцох учраас эдгээрт тохирох аргуудыг тооцож боловсруулна. | 6 | 6-шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж: урлагийн бүтээлүүдээр дамжуулан эрүүл амьдралын зан төлөвийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэх, үйл хөдөллөө эргэцүүлэн бодох учраас |
| 1,3.3 Хөгжмийн урлагийг ойлгосноор дэлхийн болон ардын урлагийн өв сан, үнэт зүйлсийг хүндлэх, бишрэх, хамгаалах-Номын нөхөр болоорой | ☐ | | | | | ТХ304.ТМ4 | ТХ34.Сэ5 | Хүн амыг бичиг үсгийн боловсролтой болгоход соёл чухал үүрэгтэй болохыг ойлгож, бишрэн, хамгаалах бөгөөд дэлхий дахинд унших, бичих тоолох үндсэн чадварыг эзэмшсэн байдал, хүрсэн түвшин нь улс орны хөгжилд нөлөөлдөг талаарх ойлголт мэдлэгтэй холбоотой болно. | | | ☐ | | хүндлэх, бишрэх, хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дэлхийн болон ардын урлагийн баялаг өв сангаас сонсож ойлгох учраас 3-р арга зүйг сонгон түүнд тохирох аргуудыг тооцож боловсруулалт хийнэ. | 7 | 7- өөрийгөө таньж мэдэх:соёлын үүрэг, ач холбогдлыг ойлгож, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох тул, |
| 1,1.4 Хөгжмийн бүтээлийн утга агуулга, дүрслэлээс дүр хүчний хурд, үүргийг ойлгох, илэрхийлэх-Цэвэр гар | ☐ | | | | | ТХ303.ЗҮ1 | ТХ33.Сэ1 | Гар, амны эрүүл ахуйн буруу хэвшил нь халдварт болон халдварт бус өвчний гол суурь нь болдог учраас эрүүл амьдралын зан төлөвийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлж сурахад Цэвэр гар дуу холбоотой болно. | ☐ | | | | ойлгох, илэрхийлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хөгжмийн бүтээлийг сонсож, өөрийнхөөрөө илэрхийлэх учраас 1-р арга зүйг сонгон боловсруулалт хийнэ. | 6 | 6- шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж: тогтсон хэм хэмжээг дадал, хэвшил болгох, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох тул, |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2, 2.5 Аялгууны шинж төрхийг ойлгох, сонсож таних, тодорхойлох, ялгах, тайлбарлах- Хувдай ишигний паян | | □ | | | | ТХ311.ТМ3 | ТХ311.Сэ5 | Манай улс сүүлийн жилүүдэд нүүдлийн соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжих болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор суурьшлын хэв маягийн түүхэн шалтгааныг ойлгох, соёлын өв уламжлалыг хүндэтгэх, ялгах, хотын экологи болон онгон байгаль хүний суурьшилд хэрхэн дасан зохицож байгаа тухай тайлбарлах, тогтвортой тогтолцоог хөгжүүлэх зөвшилцөлд хүрэх шаардлагатайг ойлгоход холбоотой болно. | | | □ | | тодорхойлох, ялгах, тайлбарлах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд заавал задлан шинжилгээ хийж асуудлыг таньж тодорхойлох, улмаар шалтгаан-үр дагаврыг холбоог олж тайлбарлах учраас 2, 3-р төрлийн арга зүйг сонгох, эдгээрт харгалзах тодорхой аргуудыг орон нутаг, сургуулийн хам нөхцөл болон сурагчдын онцлогийг тооцож арга зүйг дэглэнэ. | 7 | 7-тогтолцоот сэтгэлгээ: хотын экологи болон онгон байгаль хүний суурьшилд дасан зохицож, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох , асуудлыг тайлбарлах тул, |
| 3, 3.2 Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах- Ногоон дэлхийгээ аваръя | | | □ | | | ТХ313.НСХ1 | ТХ313.Сэ11 | Экологийн тэнцвэр алдагдах хүчин зүйлсийн нэг нь хувь хүмүүсийн ёс зүй бөгөөд экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж, өөрийнхөөрөө дүрслэн бодож, харьцуулдаг болоход Ногоон дэлхийгээ аваръя бүтээл холбогдоно. | | | □ | □ | тайлбарлах, харьцуулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд урлагийн бүтээлүүдийг сонсоод ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох учраас 4-р арга зүйг сонгон боловсруулалт хийнэ. | 6 | 6-шүүмжлэлт сэтгэлгээ: уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж, асуудал дэвшүүлэх тул, |
| 4, 2.1 Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг график дүрслэлээр зурах, бичих, жүжиглэн тоглох- Д.Дашням "Хиросимо охины цаасан шувуу" | | | | □ | | ТХ316.НСХ3 | ТХ316.Сэ6 | Дэлхий нийтэд дайн дажингүй, энх тайван байх нь чухал болохыг ойлгож, түүнээс улбаатайгаар өөрийн болон бусад улс оронд шударга бус байдлаас болон зовж шаналж байгаа хүмүүсийг ойлгож, эв найртай хандах чадвартай болоход Хиросимо охины цаасан шувуу дуу холбогдох болно. | □ | | | | үйл ажиллагаанд оролцож, хамрагдах учраас 1-р арга зүйг сонгох бөгөөд тухайн бүтээлийн агуулга, дүрийг график дүрслэлээр зурах, бичих, жүжиглэн тоглох аргуудаас сонгон боловсруулна. | 5 | 5- хамтран ажиллах: Дэлхий нийтэд дайн дажингүй, энх тайван байх нь чухал болохыг ойлгож, оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэхэд тул, |
| 5,3.1 Өөрийн орны болон гадаадын хөгжмийн зохиолчдын бүтээлтэй танилцах, сэтгэгдлээ ярилцах- Ж.Чулуун "Уулын горхи" | | | | | □ | ТХ306.НСХ3 | ТХ36.Сэ6 | Усны зохисгүй хэрэглээ нь хөрс, усны бохирдол, экологийн тэнцвэрт байдал алдагдах хүчин зүйлсийн нэг учраас усны зохистой хэрэглээ болон усны хомсдолын талаар ойлгож, сэтгэгдлээ ярилцах, өөрсдийн усны хэрэглээнд хариуцлагатай хандах чадвартай болоход холбоотой болно. | | | □ | | Өөрийн орны болон гадаадын хөгжмийн зохиолчдын бүтээлийн талаар хэлэлцүүлэг хийх, дүрд хувирч тоглох учраас 3-р төрлийн арга зүйг сонгож боловсруулна. | 2 | 2- урьдчилан тооцоолох: хөгжмийн зохиолчдын бүтээлээр дамжуулан ирээдүйд болох олон янзын үйл явдлыг ойлгож,урьдчилан сэргийлэх талаар сэтгэгдлээ ярилцах тул, |

## 3.2.Б. НЭГЖ ХИЧЭЭЛ: УС АМЬДРАЛЫГ ТЭТГЭГЧ, 3-Р АНГИ

### Нэгж хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр

ТХБ-ыг эзэмшүүлэхэд чиглэсэн арга зүйг сонгох, өөрөө түүнд суралцах нь багш бүрийн хувьд нэн чухал юм.

Багш заадаг хичээл болон заах арга барилаа эргэцүүлж, хичээлийн аль хэсэгт байгаль орчин, нийгмийн асуудлыг тусгаж болохоор байна вэ? гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Жишээ нь: Хөгжмийн талаар юу гэж боддог талаар сурагчид өөрсдийн үзэл баримтлалаа тусгасан байх бөгөөд харьцуулалтын аргыг ашиглана. Дараа нь дэлхий ертөнцөд хөгжмийг хэрхэн ойлгож байна вэ? Соёлын болоод газарзүйн хувьд ялгаатай түүхэн хөгжмийн хоёр жишээг танилцуулна. Сургалтын явцад хөгжмийн боловсролын бусад үйл ажиллагаатай нэгтгэж болно.

Урлагийн олон талт үйл ажиллагааг бие даасан болон хамтарсан хэлбэрээр гүйцэтгэх, мэдрэмжээ хөгжүүлэх, илэрхийлэхэд чиглэсэн дасгал, даалгаврыг боловсруулах бөгөөд даалгаврын тавил нь тэдэнд хийж бүтээх сэдэл сонирхлыг төрүүлсэн, бүтээлч үйлд хөтөлнө.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ ТХЗ-д хүргэх санал болгож буй сэдэв → | ТХЗ13.Сэ11. Ёс зүй ба уур амьсгалын өөрчлөлт |
| ТХЗ13.НСХ1. Суралцагч экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг болох | 3, 3.2 Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах<br>↑ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ТХЗ13.НСХ1 | ТХЗ13.Сэ11 | Экологийн тэнцвэр алдагдах хүчин зүйлсийн нэг нь хувь хүний ёс зүй бөгөөд экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж, өөрийнхөөрөө дүрслэн бодож, харьцуулдаг болоход Ногоон дэлхийгээ аваръя бүтээл холбогдоно. |

## Нэгж хичээлийн төлөвлөлт

***Нэгж хичээлийн сэдэв***: Ус амьдралыг тэтгэгч

***Нэгж хичээлийн зорилго:*** Суралцагч урлагийн бүтээлүүдээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг, өөрийнхөөрөө дүрслэн бодож харьцуулдаг болно.

***Хүрэх үр дүн:*** Хувь хүмүүсийн ёс зүй нь экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг болохыг ойлгож, тэдгээрийг урлагийн бүтээлүүдээр дамжуулан мэдрэх, ойлгон, дүрслэн бодоход дэмжлэг үзүүлнэ.

***Арга зүй сонголт:*** Шинжилгээ/судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах)

Тайлбарлах, харьцуулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд урлагийн бүтээлүүдийг сонсоод ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, хэлэлцүүлэх учраас бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээний арга зүйг сонгосон. Энэ нь сургалтын цөм хөтөлбөрийн хүүхдийн хэрэгцээ, сонирхол, туршлага, чадварт суурилж, тэдний бие даан суралцах арга барилыг хөгжүүлэх, хүүхэд бүр ярилцлага, хэлэлцүүлэг, мэтгэлцээнд оролцох, дүрд тоглох, хамтаар дасгал, бодлого, сорил, даалгавар гүйцэтгэх зэргээр хамтран ажиллах болон оролцооны арга барилд суралцахтай уялдуулан хэрэгжүүлэх боломжтой.

***Тогтвортой байдлын цогц чадамж***

ТБ-ын цогц чадамжууд нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт болон ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд суралцагчийн танин мэдэхүйн, хэл-нийгмийн, амьдрах ухааны чадамжийг хөгжүүлж, тэдгээрт харгалзах ерөнхий чадвар болон сурах арга барил эзэмшихэд хувь нэмэр оруулна. Үнд: 6 шүүмжлэлт сэтгэлгээ: урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох

***Бага боловсролын түвшинд сурагчид:***

- Хүний болон хүрээлэн буй орчинд хувийн хариуцлагыг ухаарч, холбогдох талуудыг хүлээн зөвшөөрөх;
- Харилцах, хамтран ажиллах замаар нийгэм-соёлын саад бэрхшээл, хувийн ашиг сонирхлыг даван туулахад хувь нэмэр оруулах;
- Олон улсын өөрчлөлт, ялангуяа хувийн болон мэргэжлийн салбарт шинэлэг болон нээлттэй нөхцөл байдлыг нийгэмд бий болгох;

Сурагчид өөрсдийн бие даасан шийдвэрийг үндэслэн, хувийн хэвшил, сургууль, мэргэжлийн салбарт тогтвортой хөгжлийг хангах зорилтыг хэрэгжүүлэх, нийгэм, улс төрийн үйл хэрэгт оролцох чадвартай болно.
***Судлах цаг:*** 2 цаг - 80 мин

### *Ээлжит хичээл 1*

Алхам 1.
- Аяллаар хөдөө явцгаая.
- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Байгалийн дуу чимээ. (гол урсах, шувууд жиргэх, хонь, ямаа майлах)
- Энэ юуны дуу чимээ вэ? яаж таньсан бэ?
- Багш сурагчид хөдөө нутгаар аялж буй дүрслэлийг илэрхийлэн дүрд хувирч жүжиглэнэ.

Алхам 2. Сурагчдад "Ногоон дэлхийгээ аваръя" зохиолыг сонсгоно. Хөгжмийн зохиолыг сонсгохын тулд юуны өмнө сонсох бэлтгэлийг хангана. Үүнд:

- Нам гүм орчныг бий болгох,
- Анхаарлаа төвлөрүүлж сонсохыг сануулна,
- Хөгжмийн чанга, сул хүчийг тохируулах (намуухан),
- Боломжтой бол уран зураг харж төсөөлөх.



Алхам 3. Багш хөгжмийг 2-3 удаа сонсгоод дараах асуултын дагуу сурагчидтай ярилцана.

***Асуулт:***

- Хөгжимд ямар ямар дүр гарсан бэ?
- Аялгууны шинж төрх хэрхэн өөрчлөгдөж байна вэ?
- Байгаль яагаад үнс, нурам болов?
- Байгалийн сүйрлийг хөгжмөөр хэрхэн илэрхийлж байна вэ?
- Байгалийг сэргээж амь оруулахад юу тусалсан бэ?

Алхам 4. Зохиолын дүрүүдийн өнгө аяс, эгшиглэх хүч, хурд, агуулгын талаар сурагч бүр бодож эргэцүүлээд, дэвтэртээ дараах чиглэлээр бичих даалгавар өгнө.

| | Мөсөн уул | Сүйрэл | Ногоон гараг |
|---|---|---|---|
| Хурд | | | |
| Хүч | | | |
| Өнгө аяс | | | |
| Агуулга | | | |

Алхам 5. Сурагч бүр өөрсдийн бичсэнээ хамт суугаа найздаа танилцуулж, ус яагаад чухал болох талаар харилцан санал солилцоно. Жишээ нь:

- Усыг хайр гамгүй хэрэглэвэл бидэнд ямар аюул тулгарах вэ?
- Хүн амин хувиа хичээвэл байгаль орчинд ямар сөрөг нөлөө үзүүлж байна вэ?
- Бид усны хэрэгцээгээ хэрхэн яаж зохицуулах ёстой гэж бодож байна вэ?

Алхам 6. Сурагчид 5-8 хүний бүрэлдэхүүнтэй багт хуваагдана. Сурагч бүр өөрсдийн бичсэнээ бусад сурагчдын бичсэнтэй нэгтгэж багийн дүгнэлт гаргана.

**Ээлжит хичээл 2**

Хөгжим нь зохиолын утга санаа, үйл хөдлөл, гол баатруудын бодол санааг үзэгчдэд хүргэхэд гол үүргийг гүйцэтгэдэг тул бүтээлчээр сэтгэх, эрэл хайгуул хийлгэх зорилгоор энэ сэдвийн хүрээнд сурагчдаар дараах үйл ажиллагааг хийлгэж болно. Тухайлбал: үйл явдлын ард хөгжмийн чимэглэл хийх, үйл явдалд хүч оруулах, дуу авианы сонголт хийх, турших гэх мэт

Алхам 1. Сурагчдад зохиолын үйл явдалтай холбоотой 2-оос доошгүй асуулт зохиох даалгавар өгнө.

Алхам 2. Асуулт зохиосны дараа сурагчдыг 2-3 багт хувааж, өөрсдийн багийн зохиосон асуултуудыг “Энэ асуултын хариулт аялгууны аль хэсэгт байна вэ?” гээд зохиолын үйл явдлын дагуу эрэмбэлэх даалгавар өгнө.

Алхам 3. Эрэмбэлсний дагуу хөгжмөө дахин сонсгоно. Зохиолыг сонсох үедээ сонссон хэсгийнхээ талаар тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэл хийхдээ дараах алхмуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

- Сонсож буй хөгжмийнхөө зохиогч, зохиолын нэрийг бичнэ.
- Хөгжмийн зохиолын ямар төрөл зүйлд хамаарах вэ? (дуулаач, дан хөгжим эсвэл дуу, бүжиг, марш гэх мэт)
- Хөгжмийн ямар зэмсгээр хөгжимдсөн бэ? (ардын хөгжим, симфони оркестр, төгөлдөр хуур, нарийн бүрээ, морин хуур гэх мэт)
- Аялгууны шинж төрх, онцлогийг үгээр болон график зураглалаар зурж тэмдэглэх /эрчилсэн, намуун, тайван, тасралтгүй, нэгэн хэвийн, огцом, эрс тэс, эмзэг, тогтворгүйтэх мэт/.
- Хөгжмийн зохиолын агуулга, дүрийн талаар өөрийн төсөөллөө бичих эсвэл зурж тэмдэглэх, өөрийн санал сэтгэгдлийг оруулах
- Зохиолын агуулга, утга санааг өөрийн амьдрал туршлагатай холбож тэмдэглэх.

Алхам 4. Энэ сэдвийн дагуу сурагчид баг багаараа өөрсдийн дуулах, сонсох дуртай дуу хөгжмийн бүтээлд урлагийн бусад төрлүүдийг ашиглан цогц үзүүлбэр бэлтгэн, баг тус бүр нэг номер бэлтгэнэ. Жишээ нь: Өөрсдийн дуулсан дууг ард нь бүжгээр хөдөлгөөнжүүлж, дүрслэх урлагийн бүтээлээр чимж, өгүүлэхүйн урлагийн төрлөөр баяжуулан хүч нэмж болно.

Алхам 5. Баг бүр өөрсдийн сонирхсон дуу, хөгжим, бүжиг, хөгжимдөх үйлийн нэг л хэлбэрийг сонгоно. Сонгосон үйлийн хэлбэртээ тохирох нэг уран бүтээл сонгож авна.

Алхам 6. Багийн гишүүд хэн юу хариуцах, хийх талаар ажлаа хуваарилан авна. Багаараа ярилцаж, тоглолтоо бэлтгэнэ.

Алхам 7. Баг бүр өөрсдийн бэлтгэсэн нэг цогц үзүүлбэрийг хамт олондоо үзүүлнэ. Анги хамт олноороо сэтгэгдлээ илэрхийлэн санал дүгнэлтээ өгнө.

Эндээс сурагчид урлагийн аль ч төрлөөр амьдралыг уран сайхны аргаар илэрхийлэх нийтлэг шинжтэй гэсэн ойлголтоо бататгаж, тэдгээрийг цогцоор илэрхийлэх боломжтой гэсэн дүгнэлтийг энэхүү ажлаараа дамжуулан мэдэрч, гүйцэтгэлийн ур чадвараа хөгжүүлэх боломжтой.

***Хэрэглэгдэхүүн:***

- Сурах бичиг, багшийн ном – 3 анги
- Ногоон дэлхийгээ аваръя - зохиолын видео бичлэг
- Хөгжмийн энгийн зэмсэг, даралтат хөгжим
- CD, DVD

***Үнэлэх стратеги, арга, хэлбэр:***

Хөгжмийн хичээлийн үнэлгээ нь сурагчдын сурах үйлүүдийг төлөвлөх, тэднийг төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцох ажлыг зохион байгуулах, хянах, алдаа дутагдлыг цаг тухайд нь засаж залруулах, туслах, зөвлөх, дэмжих гэх мэт үйлүүд байх бөгөөд нөгөө талаас *сурагчдад хөгжмийн ямар мэдлэг хэрэгтэй вэ?, түүнийг яаж эзэмшүүлэх вэ?, хөгжмийн мэдлэгээ өөр нөхцөлд яаж хэрэглэх вэ?, өөрийнхөө мэдлэгийг яаж хянах вэ?, өөрийгөө хэрхэн бодитой үнэлж дүгнэх вэ?* гэх мэт асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн үйлүүдийн нэгдэл байна. Тухайлбал: Ажиглах, сонсох, хэлэлцүүлэх, амаар, бичгээр илэрхийлэх, үйлдэх, үзүүлэх, харуулах /бүтээл хийх, дүрд тоглох/ г.м

| Юуг үнэлэх вэ? | Ямар шалгуураар үнэлэх вэ? |
|---|---|
| Өөрсдийн болон бусдын үзэл бодол, бүтээлийн ач холбогдлыг ойлгож үнэлж буй байдал | • Хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг сонирхох, ажиглах, сонсох, ойлгох<br>• Хувь хүний мэдрэмж санаагаа илэрхийлэх, бусадтай хуваалцах<br>• Хөгжмийг үнэлэхэд бусдын үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, шүүмжлэлтэй хандах |
| Тогтвортой хөгжил, даяаршил, хөгжлийн асуудлыг бүтээлчээр тайлбарлаж, санал солилцож буй байдал | • Хөгжмийн хэрэглээ, сонсох дадлыг өөрсдийн нөхцөл байдалд нийцүүлж, тогтвортой хөгжлийн зарчмын үндэслэлийг тусгах.<br>• Хувь хүний ойлголтоо илэрхийлэхдээ урлагийн хэлийг ашиглан аливаа үйлийг гүйцэтгэх<br>• Өөрсдийн санаа, бүтээлийг ярьж тайлбарлах |
| Янз бүрийн ашиг сонирхол, нөхцөл байдлыг харгалзан бие даан асуудлыг шийдвэрлэж, дүгнэлтэд хүрч буй байдал | • Тухайн сонгосон хөгжмийн бүтээлийн гол агуулга, үзэл санаа түүний үр нөлөөний талаар үнэлэх.<br>• Сонссон хөгжмийн талаарх өөр өөр ойлголтуудыг хүлээн зөвшөөрч, үнэлдэг байх<br>• Бусадтай санаа бодлоо хуваалцах, өөрийн бүтээлээр бахархах, бусдын бүтээлийг хүндэлж байгаагаа илэрхийлэх |

# 3.3. ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ

## 3.3. А. БАГА БОЛОВСРОЛЫН ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИЙН ХИЧЭЭЛИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Нийгэм, эдийн засаг, техник технологийн өндөр түвшний хөгжилд хүрээд байгаа энэ эрин зуунд хөгжлийг дагасан сөрөг үзэгдлүүд түүнтэй холбоотой дэлхийн улс орнуудад яаралтай шийдвэрлэх олон асуудлууд тулгараад байгаа билээ. Эдгээр асуудлыг шийдвэрлэх гарц нь ТХ ба ТХБ юм. ТХ ба ТХБ-ын холбоо хамаарлыг 2016 онд хийгдсэн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа”-ны тайланд “ТХ бол хүн бүрд хамаатай, газар бүр хэрэгжих учиртай нийгэм бүхэлдээ өөрчлөн шинэчлэгдэх үйл явц, харин ТХБ бол байнгын шинэчлэл бүхий энэхүү үйл явцыг хэрэгжүүлэх арга зам” хэмээн тодорхойлсон байна. Энэ нь боловсролоор дамжин тогтвортой хөгжилд хүрэх ба чанартай боловсрол нь ТХ хэрэгжүүлэх тулгуур хэмээх ойлголттой нийцэж байгаа юм.

БСШУЯ-аас ЕБ-ын сургалт үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн шаардлагыг 2016 онд боловсруулан гаргасан бөгөөд түүнд “ЕБ-ын сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт байгаль орчин, эдийн засаг, нийгэм соёлын уялдаа холбоог хангасан цогц байдлаар агуулгын болон арга зүйн шийдлийг хийх, суралцагчдад хандлага, үнэт зүйлс, хэрэглээний чадварыг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай” гээд сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийн үндсэн агуулгыг тодорхойлсон байна.

Бага боловсролын түвшинд дүрслэх урлаг, технологийн хичээл нь нэгдмэл агуулгаар хэрэгжиж байгаа бөгөөд дүрслэх урлаг, технологийн сургалтын хөтөлбөр нь “хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг ажиглах, мэдэрч ойлгох”[13], илэрхийлэх, үнэлэх чадварыг суралцагчдад олгоход чиглэж байна.

ТХБ-ыг тусгайлсан сургалтын хөтөлбөрөөр бус харин түүнийг боловсролын бүхий л түвшний агуулга, арга зүй, хичээл, үйл ажиллагааны үе шат, үйлийн алхам бүрд хэрэгжүүлснээр хангагдах бүрэн боломжтой юм. Бага боловсролын дүрслэх урлаг, технологийн агуулга, хичээл, үйл ажиллагаанд ТХ-ийн “Эрүүл мэнд ба сайн сайхан байдал”, “Зохистой ажил ба эдийн засаг”, “Тогтвортой хот суурин, оршин суугчид”, “Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл”, “Газар дээрх амьдрал” гэсэн зорилгуудыг интеграцчилах замаар хэрэгжүүлэх боломж байна.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

ТХ-ийн ойлголт, үзэл санааг хичээл, үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх боломжийг авч үзэх үүднээс бага боловсролын дүрслэх урлаг, технологийн сургалтын цөм хөтөлбөрт шинжилгээ хийлээ. Шинжилгээг ТХ-ийн 17 зорилгын суралцахуйн зорилт, сэдвийг гол шалгуур болгон түүнд хамаарах суралцахуйн зорилтыг сонгон авсан. *(Дараах хүснэгтээс харна уу)*

13 БСШУЯ. (2014). Бага боловсролын цөм хөтөлбөр. УБ. 74.

*ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт*

| Тогтвортой хөгжлийн зорилго | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |
|---|---|
| ТХЗ03. Эрүүл мэнд ба сайн сайхан байдал | 5, 01.14. Энгийн орц найрлагатай зууш бэлтгэх |
| ТХЗ08. Зохистой ажил ба эдийн засгийн өсөлт | 4, 01.14. Ажил мэргэжлийн талаарх ойлголттой болох |
| ТХЗ11. Тогтвортой хот суурин, оршин суугчид | 4, 03.4. Монголын болон гадаадын уран зургаас мэдэх, таних, унших |
| ТХЗ12. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл | 3, 2.4. Бүтээлийн онцлог шаардлагад нийцүүлэн материал багаж хэрэгсэл сонгох, ашиглах<br>4, 02.15. Хаягдал материал ашиглан бүтээл хийх |
| ТХЗ15. Газар дээрх амьдрал | 3, 01.9. Байгалийн материалыг баримлын шавраар холбох аргаар биет тоглоом хийх |

Суралцахуйн зорилтуудыг сонгон авахдаа ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэв болон суралцахуйн зорилтын бодит холбоо хамаарал, ерөнхий зүй тогтол зэргийг харгалзан үзсэн. Сонгон авсан суралцахуйн зорилт болон ТХЗБ-ын танин мэдэхүйн, нийгэмшил сэтгэл хөдлөл, зан үйлийн айн хамаарлыг хүснэгтээр харуулав.

*ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилтын тоо*

| Ай | Танин мэдэхүй | Нийгэмшил, сэтгэл хөдлөл | Зан төлөв |
|---|---|---|---|
| Суралцахуйн зорилтын тоо | 2 | 2 | 2 |

Интеграцчилах боломжтой гэж сонгон авсан суралцахуйн зорилтууд нь танин мэдэхүй ай (2), нийгэмшил, сэтгэл хөдлөл ай (2), зан үйл ай (2) харьцангуй тэнцвэртэй байгаа бөгөөд зөвхөн эдгээр суралцахуйн зорилтуудын хүрээнд л тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжинэ. Харин бусад суралцахуйн зорилтуудын хүрээнд ТХБ-ыг хэрэгжүүлэх боломжгүй гэж шууд утгаар ойлгож болохгүй. Учир нь сургалтын цөм хөтөлбөрт ижил томьёологдсон суралцахуйн зорилтууд хэд хэд байна. Энэ нь тухайн судлагдахууны онцлог, бүтээл хийх арга технологи, хэрэглэх багаж, материал, хэрэглэгдэхүүнээс хамааран агуулгын өргөсөл, гүнзгийрэлтэй холбоотой бөгөөд тэдгээр суралцахуйн зорилтуудыг сургалтын хөтөлбөрийн зөвлөмж, сурах бичигт илүү тодруулж өгсөн байна. Үүнтэй холбоотой ТХЗБ-ын нэг суралцахуйн зорилт, нэг сэдэвт хамаарах хэд, хэдэн суралцахуйн зорилт гарч ирсэн учир нэгийг нь төлөөлүүлэн сонгон авсан. Иймд багш нар ижил томьёологдсон судлагдахууны суралцахуйн зорилтуудын хүрээнд ТХЗБ-ын суралцахуйн зорилт болон сэдвийн хамаарлыг авч үзэн агуулгыг хэрэгжүүлнэ.

*Анхаарах зүйл:*

Монголын болон гадаадын уран зураачдын уран зураг унших гэсэн суралцахуйн зорилтын хүрээнд интеграцыг хэрэгжүүлэхдээ багш ТХ-ийн суралцахуйн зорилт, агуулгад нийцүүлэн уран бүтээлийн сонголтыг хийх нь нэлттэй юм. Тухайлбал, Монголчуудын ахуй амьдралын хэв маяг, түүх, соёлын өв уламжлалыг дүрсэлсэн болон тогтвортой хөгжлийн асуудлыг хөндсөн уран бүтээлчдийн уран бүтээлүүдийг сонгон авч хичээл, үйл ажиллагаагаа төлөвлөх хэрэгтэй. Сурах бичигт тусгасан сэдэв, агуулга, уран бүтээл нь ТХ-ийн зорилгод нийцүүлэн интеграцчилах боломжтой хувилбарыг багтаан өгсөн ба илүү сайн хувилбарыг сонгох үүднээс уран зураачдын бүтээлүүдээс судалж, сонгон авч болно. (Жич: Аливаа суурьшлын бүс нутаг, түүний өөрчлөлтийн түүхийг авч үзэх боломжтой зураг бүтээл гэх мэт).

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Арга зүйг сонгохдоо суралцахуйн зорилт, тогтвортой хөгжлийн зорилт, сэдвийн хамаарал болон тухайн насны суралцагчийн сонирхол хэрэгцээ, онцлогийг харгалзсан. Агуулга, арга зүй хоёр нь салшгүй холбоотой. Агуулгыг эзэмшүүлэх технологи нь арга зүй буюу арга юм. “Агуулга нь тодорхой бөгөөд оновчтой, арга нь төгөлдөр бөгөөд яруу байх ёстой”[14] гэж тодорхойлсон байна. Арга бүр өөр өөрийн онцлогтой бөгөөд зорилго чиглэлтэй эрэмбэлэгдсэн үйлүүд юм. Судлагдахууны суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх энэхүү арга зүйг сонгохдоо агуулга, арга зүйн шүтэлцээ болон үйл ажиллагааны үе шат, үйлийн алхам бүрд ТБ-ын цогц чадамжийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах байдлыг харгалзан үзсэн. Бага боловсролын дүрслэх урлаг, технологийн сургалтын цөм хөтөлбөрийн агуулга, арга зүй бүтээлч эрэлхийллийн арга барил эзэмшүүлэхэд чиглэж байгаа нь дараах санал болгож буй арга зүйг хэрэгжүүлэхэд дөхөм болж байна. Суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх арга зүйг сонгосон байдлыг хүснэгтээр харуулав.

*Арга зүйн сонголт ба тоо*

| Аргууд | | | |
|---|---|---|---|
| Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох | Шинжилгээ/ судалгаа хийх | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх | Алсын хараатай болох |
| 1 | 2 | 3 | |

Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох арга, 1 (видео үзэх), Шинжилгээ/судалгаа хийх арга, 2 (шинжилгээнд суурилсан төсөл, туршилт хийх), Бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан арга, 3 (хэлэлцүүлэг, экскурс) байгаа нь тогтолцоот сэтгэлгээний, хамтран ажиллах, өөрийгөө таньж мэдэх чадамжууд болон асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамжийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна.

*Зөвлөмж:* Бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргуудаас хэлэлцүүлгийн аргыг сонгосон 2 удаагийн тохиолдол байна. Хэлэлцүүлгийн арга нь суралцагчийн оролцоог хангах арга хэрэгсэл бөгөөд багш үр дүнтэй өрнөж буй эсэхийг анхаарах, хэлэлцүүлэгт өнгөц хандахаас сэргийлэх нь чухал тул хэлэлцүүлгийг урьдчилан бодож, нарийн төлөвлөх нь зүйтэй.

14 Мира, Н. (2006). Суралцах арга барилын технологийн шинэчлэл. УБ, 68.

*Хүснэгт 3.8.* ***Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Дүрслэх урлаг, технологи)***

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | 1 | 2 | 3 | 4 | 5 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/өнгөрснийг нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар /суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | | | | 4 | 5 | 6 | 7 | | | | 8 | 9 | 10 |
| 5. Урлагийн хэл | 5, 01.14. Энгийн орц найрлагатай зууш бэлтгэх | ☐ | | | | ☐ | ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ09. | Суралцагч зууш бэлтгэхдээ амин дэмээр баялаг эрүүл хоол хүнсний талаарх ойлголтоо нэмэгдүүлэх ба зөв хооллолттой холбоотой эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэхэд дэмжих нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно. | | ☐ | | | Эрүүл мэндийг дэмжиж, өвчнөөс сэргийлэх стратегийн талаар сургалтыг зохион байгуулах, эрүүл хоол хүнс бэлтгэх учир 2 дугаар арга зүйг сонгосон. | 1,5,6 | 1-системийн сэтгэлгээ: Эрүүл хоол хүнс бэлтгэхтэй холбоотой хүнсний бүтээгдэхүүний харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох учир.. 5-хамтран ажиллах: Бусдыг ойлгох, мэдрэмжтэй хандах, хамтран суралцах учир.. 6- шүүмжлэлт сэтгэлгээ: дадлага туршлага, өөрийн үнэлэмж, ойлголтоо илэрхийлэх учир... |
| 4. Урлагийн хэл | 4, 01.14. Ажил мэргэжлийн талаарх ойлголттой болох | ☐ | | | ☐ | | ТХ308.НСХ4. | ТХ308.Сэ01. | Суралцагч ажил мэргэжлийн талаарх ойлголттой болох нь хүний сайн сайхан байдал, эдийн засагт оруулах хувь нэмэр гэсэн сэдэвтэй уялдахын зэрэгцээ ажил хөдөлмөртэй холбоотой хэрэгцээ, үнэт зүйлсээ илрүүлэн тодруулах нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно. | | ☐ | ☐ | | Өөрийн гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжил, албан тушаалын түүхэн замналыг талаар тэмдэглэл хөтлөх, зураглал хийх, хэлэлцүүлэх учир 3 дугаар арга зүйг сонгосон. | 6 | 6-шүүмжлэлт сэтгэлгээ: Ажил мэргэжлийн хэрэгцээ, үнэт зүйлсийг илрүүлэхтэй холбоотой асуудал дэвшүүлж буй учир ... |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. Гоо сайхны илэрхийлэл | 4, 02.15. Хаягдал материал ашиглан бүтээл хийх | | | | ☐ | ☐ | ТХ312.ЗҮ1 | ТХ312.Сэ07. | Хаягдал материал ашиглах нь хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах гэсэн сэдэвтэй шууд холбогдох ба хэрэглээтэй холбоотой үйл ажиллагаар төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх чадварт хувь нэмэр оруулах нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно. | | ☐ | ☐ | | Хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах талаар шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, сурталчлах учир 2 дугаар арга зүйг сонгосон. | 1, 7 | 1-системийн сэтгэлгээ: Аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэх, ойлгох нийлмэл тогтолцоог задлан шинжлэх учир... 7-Өөрийгөө таньж мэдэх Багаараа хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, өөрийн оролцоог эргэцүүлэх учир... |
| 5. Соёлын үнэт зүйл | 5, 03.5. Монголын болон гадаадын уран зураачдын уран зураг унших | | ☐ | | | ☐ | ТХ311.ТМ3. | ТХ311.Сэ05. | Монголын болон гадаадын уран зураачдын уран зураг унших ньсуурин амьдралын хэв маягийн түүхэн шалтгааныг ойлгож, соёлын өв уламжлалд хүндэтгэлтэй хандахад дэмжлэг болохын зэрэгцээ амьд байгаль хүний суурьшилтай холбоотойгооөөрчлөгдөн буй талаар асуудал дэвшүүлэн хэлэлцэх, бүтээлчээр илэрхийлэх зэрэг нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно. | | | ☐ | | Монголын болон гадаадын уран зураачдын асуудал хөндсөн зураг бүтээлийг ашиглан аливаа суурьшлын бүс нутаг түүний өөрчлөлттэй холбоотой түүхийг судалж мэдэх учир 3 дугаар арга зүйг сонгосон. | 5, 6 | 6-шүүмжлэлт сэтгэлгээ: Амьд онгон байгаль, хүний суурьшилтай холбоотойгоор өөрчлөгдөн хувирч буй талаарх асуудлыг дэвшүүлж буй учир... 5- хамтран ажиллах: Хэн нэгний мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх, хүндэтгэх |
| 3. Гоо сайхны илэрхийлэл | 3, 02.4. Бүтээлийн онцлог шаардлагад нийцүүлэн материал багаж хэрэгсэл сонгох, ашиглах | | | ☐ | | | ТХ312.ТМ4. | ТХ312.Сэ02. | Материал, багаж хэрэгсэл сонгох, ашиглах нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба хэрэглээний түүх, хэв маягтай холбогдохын зэрэгцээ тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээний стратегиуд, практик туршлагыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох юм. Энэ нь суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно. | ☐ | | ☐ | | Бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба хэрэглээний хэв загварыг ойлгож мэдэхэд нь туслах зорилгоор богино хэмжээний кино, видео үзүүлэх учир 1 дүгээр арга зүйг сонгосон. | 1 | 1-системийн сэтгэлгээ: Бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба хэрэглээний хэв загварын харилцан хамаарлыг таньж мэдэх, ойлгох учир.. |
| 3. Гоо сайхны илэрхийлэл | 3, 01.9. Байгалийн материалыг (шарлаж унасан навч, чулуу, хугарч унасан мөчир, боргоцой гэх мэт) баримлын шавраар холбох аргаар биет тоглоом бүтээх | | | ☐ | | | ТХ315.НСХ3. | ТХ315.Сэ08. | Суралцагч байгалийн хаягдал материалаар биет тоглоом бүтээхдээ орон нутгийнхаа байгаль орчинтой харилцаж хүмүүний бус аж амьдралын талаарх ойлголттой болох ба бусадтайгаа хуваалцахдаахүмүүс амьд байгалийн нэг хэсэг болохыг ойлгож ухаарах нь энэ суралцахуйн ТХБ-той холбогдох тал болно. | | ☐ | ☐ | | Байгалийн хаягдал материалыг (унасан навч, боргоцой, мөчир гэх мэт) баримлын шавраар холбож бүтээл хийх зорилгоор ойролцоох цэцэрлэгт хүрээлэнд экскурс аялал хийх учир 3 дугаар арга зүйг сонгосон. | 1, 7 | 1-тогтолцоот сэтгэлгээ: Орон нутгийнхаа байгаль орчинтой харилцаж хүн ба байгалийн харилцан хамаарал, хүмүүний бус амьдралын талаар мэдэх, ойлгох учир... 7-Орон нутгийнхаа байгаль орчинтой харилцах, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэх |

## 3.3. Б. НЭГЖ ХИЧЭЭЛ: ЭРҮҮЛ ЗӨВ ХООЛЛОЛТ БА ӨГЛӨӨНИЙ ЗУУШ, 5 ДУГААР АНГИ

### Нэгж хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр

5 дугаар ангийн “Энгийн орц найрлагатай зууш бэлтгэх” гэсэн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын хүрээнд “Эрүүл зөв хооллолт ба өглөөний зууш” нэгж хичээлийн сэдвийг сонгон авсан ба энэхүү нэгж хичээлийн агуулга ТХ-ийн “Эрүүл мэнд ба сайн сайхан байдал” гэсэн зорилтын суралцахуйн зорилт, сэдэвтэй шууд холбогдох ба шинжилгээ/ судалгаа хийх арга зүйн шийдэл нь ТБ-ын цогц чадамж эзэмшихэд хувь нэмэр оруулна.

Дүрслэх урлаг, технологийн цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвт харгалзах байдлыг дараах хүснэгтэд харуулав. (Матриц 2-оос)

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ ТХЗБ-ын сэдэв → | ТХ303.Сэ09. Илүүдэл жин ба тархалалт хөдөлгөөний дутагдал, **эрүүл бус хоол хүнс** |
| ТХ303.ЗҮ1. Суралцагч **эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох** | 5, 01. 14. Энгийн орц найрлагатай зууш бэлтгэх<br>↑ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |

Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй харгалзуулсан үндэслэлийг дараах хүснэгтэд авч үзэв. *(Матриц 2-оос, багана 4, 5, 6)*

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ТХ303.ЗҮ1. | ТХ303.Сэ09. | Суралцагч зууш бэлтгэхдээ зөв хооллолт болон эрүүл хоол хүнсний талаарх ойлголтоо нэмэгдүүлэх ба зөв хооллолттой холбоотой эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэхэд дэмжих нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно. |

“Өглөөний хөнгөн зууш бэлтгэх” нэгж хичээл нь суралцагчийн эрүүл хоол хүнс, хооллолттой холбоотой ойлголтыг нэмэгдүүлэх (хүний иллэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг судлах, өглөөний ундны илчлэгийн хэмжээг тодорхойлох, эрүүл хооллолтын ач холбогдлыг танин мэдэх гэх мэт), тухайн мэдлэг, ойлголтоо ашиглан туршилт хийх (өглөөний унд бэлтгэх, турших) эрүүл хооллолтын ач холбогдлыг хэлэлцэх өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болоход хувь нэмэр оруулна. Энэ нь ТХБ-той холбогдох тал болно.

## Нэгж хичээлийн төлөвлөлт

***Нэгж хичээлийн зорилго:*** Эрүүл зөв хооллолт болон хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарын талаар судалж өглөөний хоол бэлтгэж сурна.

***Хүлээгдэж буй үр дүн:*** Эрүүл хоол хүнсний талаарх болон хүнсний бүтээгдэхүүний харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох, эрүүл хоол хүнс бэлтгэхэд хамтран суралцах, туршлагаа хуваалцах, өөрийн ойлголтоо илэрхийлдэг болно.

***Судлах цаг:*** 2 цаг - 80 мин

*Сургалтын зохион байгуулалтын хэлбэр:* Хэсгээр (Суралцагчдыг 5-6-аар нь баг болгон зохион байгуулна).

***Арга зүйн сонголт:***

Шинжилгээ/ судалгаа, туршилт хийх) *(Матриц 2-оос, багана 8-ТХБ арга зүйн сонголт)*

*ТХБ-ын арга зүйн сонголт*

Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж тайлбар

Эрүүл мэндийг дэмжиж, өвчнөөс сэргийлэх стратегийн талаар сургалтыг зохион байгуулах, эрүүл хоол хүнс бэлтгэх учир 2 дугаар арга зүйг сонгосон.

***ТБ-ын цогц чадамж:***

*Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж*: Эрүүл хоол хүнс бэлтгэхтэй холбоотой хүнсний бүтээгдэхүүний харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох

*Хамтран ажиллах цогц чадамж*: Бусдыг ойлгох, мэдрэмжтэй хандах, хамтран суралцах.

*Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж*: шүүмжлэлт сэтгэлгээ: дадлага туршлага, өөрийн үнэлэмж, ойлголтоо илэрхийлэх *(Матриц 2-оос, багана 10)*

Эрүүл хоол хүнс бэлтгэх хүрээнд эрүүл хооллолт, иллэгийн талаар судлах, туршилтын ажил хийх арга зүй нь тогтолцоот, шүүмжлэлт сэтгэлгээний болон хамтран ажиллах чадамжуудад хувь нэмэр оруулна.

### *Ээлжит хичээл 1.* Эрүүл зөв хооллолт болон хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарыг судлах өглөөний зуушны орц найрлагыг тодорхойлох

Алхам 1. Багш хичээлийн эхэнд нийт суралцагчдаас “Та нар өглөөний цайгаа тогтмол уудаг уу?” гэсэн асуулт тавьж хариултыг авна. *(Асуултын хариултыг сурагчдыг гар өргөх байдлаар авч болно. Тогтмол уудаг, заримдаа гэх мэт).*

Багуудад дараах чиглэлээр асуултыг дэлгэрүүлэн тавьж баг тус бүрээс 1 хариултыг авна. Асуулт асуухаас өмнө багш самбарт дараах хүснэгтийг зурж бэлтгэсэн байна. Хүснэгтийн “мэдээлэлтэй танилцахаас өмнө” гэсэн баганад баг тус бүрээс авсан асуултын хариултыг багш бичиж тэмдэглэнэ. Асуулт:

- Өглөөний цайг тогтмол уухын ач холбогдол юу вэ?
- Эрүүл зөв хооллолтын талаар юу мэддэг вэ?

| Асуулт 1. Өглөөний цайг тогтмол уухын ач холбогдол юу вэ? | | |
|---|---|---|
| Багууд | Мэдээлэлтэй танилцахаас өмнө | Мэдээллийн танилцсаны дараа ойлгосон зүйл |
| 1-р баг | | |
| 2-р баг | | |
| ........ | | |
| Асуулт 2. Эрүүл зөв хооллолтын талаар юу мэдэх вэ? | | |
| Багууд | Мэдээлэлтэй танилцахаас өмнө | Мэдээллийн танилцсаны дараа ойлгосон зүйл |
| 1-р баг | | |
| 2-р баг | | |
| ........... | | |

Алхам 2. Багш дараах мэдээллийн нийт суралцагчдад ойлгомжтойгоор уншиж өгнө. Багшийг мэдээлэл унших явцад багууд ойлгосон зүйлээ тэмдэглэнэ. Уншиж дууссаны дараа багаараа ярилцаж дээрх асуултад дахин хариулт өгөхөд бэлтгэнэ.

Багш баг тус бүрд дээрх 2 асуултыг дахин тавьж, хүснэгтийн “Мэдээлэлтэй танилцсаны дараа” баганад хариултыг тэмдэглэнэ.

*Унших материал*

**Эрүүл зөв хооллолт**

Бага насны хүүхдийн эрүүл саруул байлгах гол нөхцөл нь зөв зохистой хооллолт юм. Хоол тэжээл сайтай хүүхдийн оюун ухааны хөгжил сайн байхын зэрэгцээ амжилттай суралцах нөхцөл нь болдог байна. Зөв зохистой хооллох гэдэг нь хүүхдийг эрүүл, хэвийн өсөж хөгжих хэрэгцээг хангахыг хэлнэ. Эрүүл бус хоолонд чихэр, давс, тос ихтэй хоол ордог байна.

Өглөөний цайг тогтмол ууж хэвших нь эрүүл мэндэд ихээхэн ач тустай. Хүүхдийг өдөрт 4-5 удаа хооллох хэрэгтэй. Хооллох цагийн хуваарийг танилцвал:

- Өглөөний цай - 7.30 – 8.30
- Бага үдийн цай- 10.30-11.30 г
- Үдийн хоол– 14.30-15.30
- Оройн хоол – 18.30-19.30

Хүүхдүүд та нар хооллохдоо маш сайн зажилж идэх хэрэгтэй. Мөн шингэн зүйлийн дутагдлаас сэргийлэх үүднээс ус сайн уух ба өнгө будагтай жүүс, хийжүүлсэн ундааг хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.

Алхам 3. Мэдээлэлтэй танилцахаас өмнөх болон мэдээллийг судалсны дараах тэмдэглэлийг харьцуулан ярилцаж, багштайгаа хамтран дүгнэлт гарна.

Алхам 4. Дараах нэмэлт мэдээллийг 2 суралцагчийн дунд нэг байхаар тарааж өгнө. Мэдээллийг суралцагчид хамтран чанга уншина. Багш мэдээлэлтэй холбоотой нэмэлт тайлбарыг суралцагчдад хэлж өгнө.

**Нэмэлт мэдээлэл:** Илчлэг чанар гэдэг нь хоолны шим тэжээлийг тодорхойлдог. Илчлэгийн хэмжих нэгж нь ккал бөгөөд хүний хоол хүнснээс авах илчлэгийн хоногийн хэрэгцээ 2500-2550 ккал байдаг байна.

Хүүхдийг өдөрт 4-5 удаа хооллох ба 1 өдөрт шаардлагатай нийт илчлэгийг дараах байдлаар хуваарилдаг байна.

- Өглөөний хоолонд 20%
- Бага үдийн цайнд 10-15%
- Үдийн хоолонд 30-35%
- Их үдийн цайнд 10%
- Оройн хоол, цайнд 20-25%

Алхам 5. *Багш багуудад дараах даалгаврыг өгнө.*

*Даалгавар:*

Хүний хоол хүнснээс авах илчлэгийн хоногийн нийт хэрэгцээ 2500 ккал ба өглөөний хоолны илчлэг 20%-ийг эзэлнэ. Өглөөний хоолны илчлэгийн хоногийн хэрэгцээг ккал-аар тооцон олно уу. Тооцон олсон тайлбарыг бичиж тэмдэглээрэй.

| Илчлэгийн хоногийн хэрэгцээ | Өглөөний хоолны | | Тайлбар |
|---|---|---|---|
| | Илчлэгийн хэрэгцээ /хувь/ | Илчлэгийн хэрэгцээ /ккал/ | |
| 2500 ккал | 20% | ? | ? |

*Даалгаврын гүйцэтгэлийн үр дүн:*

| Илчлэгийн хоногийн хэрэгцээ | Өглөөний хоолны | |
|---|---|---|
| | Илчлэгийн хэрэгцээ /хувь/ | Илчлэгийн хэрэгцээ /ккал/ |
| 2500 ккал | 20% | 500 |

*Даалгаврын дүгнэлт: Өглөөний хоолны илчлэгийн хэрэгцээ илчлэгийн хоногийн хэрэгцээний 20%-ийг эзэлдэг ба энэ нь 500 ккал юм байна.*

Алхам 6. *Баг тус бүрд дараах тараах материалыг өгнө.*

*Тараах материал: Хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ[15]-нд үндэслэсэн болно.*

| Чиний зохиосон цэсэд орсон хүнсний бүтээгдэхүүний нэр | Өглөөний хоолонд хэрэглэх хэмжээ (гр ба мл) | Илчлэг (ккал)хэмжээ |
|---|---|---|
| Сүү | 150 гр | 120 ккал |
| Талх | 110 гр | 22. ккал |
| Хиам | 50 гр | 94 ккал |
| Хүнсний ногоо | 200 гр | 14 ккал |
| Өндөг | 1ш | 225 ккал |
| Алим | 90 гр | 44 ккал |

15 Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаас.

*Алхам 7. Багш багуудад дараах даалгаврыг өгнө.*

*Даалгавар:* Баг тус бүр өөрсдийн бэлтгэх өглөөний хоолны орц, найрлагыг тодорхойлж, цэс зохионо. Цэс зохиохдоо илчлэг тооцох ба өглөөний хоолны иллэгийн хэмжээ 500 ккал хэтрэхгүйг анхаарах хэрэгтэй.

*Бидний зохиосон өглөөний хоолны цэс:*

| Чиний зохиосон цэсэд орсон хүнсний бүтээгдэхүүний нэр | Илчлэг (ккал)хэмжээ |
|---|---|
| ....... | |
| ...... | |
| Өглөөний хоолны илчлэгийн хэмжээ нийт | 500 ккал |

**Ээлжит хичээл 2. Өглөөний хөнгөн зууш хийх, турших**

Бэлтгэл ажил: Багш тухайн хичээлийг зохион байгуулах ажлын орчныг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүнийг төрөл зүйлээр ангилан, зориулалтын саванд угааж, хэрчиж бэлтгэсэн байна.
- Халуунаар боловсруулах шаардлагатай зарим бүтээгдэхүүнийг чанаж боловсруулсан байна.
- Ил хачиртай талх бэлтгэхэд зориулж талхыг 1см зузаанаар эсвэл хавчмал талх бэлтгэх бол 6 мм-ээс зузаантайгаар цэвэрхэн зүсэн бэлтгэсэн байна.
- Хүүхэд бүрийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн ажиллахад чиглүүлэх, ажлын хувцас (хормогч) өмсгөсөн байх.

Алхам 1. Баг тус бүр өөрсдийн зохиосон цэсээр өглөөний хөнгөн зууш бэлтгэнэ.

- Суралцагчид хормогч өмсөж, гараа сайтар угааж, ажиллах орчинтойгоо танилцана.
- Багууд өөрсдийн зохиосон цэс, орц найрлагад орох хүнсний бүтээгдэхүүнийг сонгон авна.
- Өөрсдийн зохиосон орц, найрлагын дагуу өглөөний хөнгөн зууш бэлтгэж дуусгана.

Алхам 2. *Эрүүл зөв өглөөний хөнгөн* зуушны амталгаа хийх, үнэлгээ өгөх

Багш ширээ засах, зөв хооллох талаар суралцагчдад мэдээлэл өгөх хэрэгтэй.

**Нэмэлт мэдээлэл**: Хүн өдөрт 4-5 удаа хооллох ёстой бөгөөд өглөө, өдөр, оройн хоол өөр өөрийн онцлогтой байдаг. Хооллож сурах нь соёл юм.

Хооллохдоо сандал дээр цэх суух, хөвгүүд нь охидыг суусны дараа суудлаа эзлэх. Амны алчуураа хэрэглэж дууссаны дараа сул нугалж тавгийн хажууд тавих. Ширээн дээр тохойлдож суух, амандаа хэт их хоол хийж идэх, амандаа хоолтой байхдаа ярих зэрэг нь зохимжгүй үйлдэл юм.

Алхам 3. Багууд өөрсдийн цэсээр бэлтгэсэн хөнгөн зуушаа ширээнд байрлуулан, амталгаа хийхэд бэлтгэнэ. (Жич: Бэлтгэсэн зуушаа зүсч, чигчлүүр хатган амталгаа хийхэд бэлтгэсэн байж болно).

Алхам 4. Баг тус бүр өөрийн бэлтгэсэн өглөөний хоолны талаар танилцуулах (Үүнд: орц найрлага, хүнсний бүтээгдэхүүний илчлэг болон эрүүл зөв хооллолттой холбоотой багийн нэгдсэн саналаа илэрхийлэхэд бэлтгэсэн байна.)

Алхам 5. Бусад багуудын бэлтгэсэн өглөөний хоолонд үнэлгээ өгнө. Үнэлгээг дараах шалгуураар багштайгаа хамтран 1, 3, 5 хүртэлх оноо өгч үнэлнэ.

- Амт шаардлага хангасан эсэх
- Гадаад өнгө үзэмж, харагдах байдал
- Орц найрлагад орсон хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарыг тооцсон эсэх
- Эрүүл зөв хооллолттой болон эрүүл амьдрал зан үйлтэй холбон үзэл бодлоо илэрхийлж буй байдал
- Баг болон ажиллаж чадсан эсэх

*Хэрэглэгдэхүүн:*

- Сурах бичиг V анги
- “Хоол тэжээлийн гарын авлага” хоол судлалын төв, УБ, 2000,
- Зурагт болон видео үзүүлэн
- Ажлын хуудас, тараах материал, үзүүлэн
- Хүнсний бүтээгдэхүүн:
  - Сүү, цэвэр ус
  - Талх
  - Чанасан өндөг
  - Төрөл бүрийн чанаж боловсруулсан хүнсний ногоо
  - Бэлэн боловсруулсан, мах, махан бүтээгдэхүүн
  - Жимс жимсгэнэ гэх мэт.

***Багш өөрөө судлах нэмэлт материал:*** *“Хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г (Эрүүл мэндийн сайдын тушаал сэрүүний болон зуны улирлаар нь тогтоон гаргасан байдаг байна.)*

*Хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ*[16]

| Д/д | Хүнсний бүтээгдэхүүний нэр | Сэрүүний улиралд | |
|---|---|---|---|
| | | Хоногт хэрэглэх хэмжээ (гр ба мл) | Илчлэг (ккал) |
| 1 | Мах, махан бүтээгдэхүүн | 200 | 374 |
| 2 | Сүү | 150 | 120 |
| 3 | Тараг, аарц | 200 | 113 |
| 4 | Гурил | 100 | 325 |
| 5 | Гурилан бүтээгдэхүүн | 220 | 452 |
| 6 | Төрөл бүрийн будаа | 78 | 269 |
| 7 | Сахар, чихрийн зүйл | 23 | 92 |
| 8 | Төмс | 140 | 123 |
| 9 | Хүнсний ногоо | 200 | 28 |
| 10 | Буурцагт ургамал (вандуй, шош) | 90 | 265 |
| 11 | Жимс | 180 | 84 |
| 12 | Өндөг | 19 | 30 |
| 13 | Ургамлын тос | 25 | 225 |
| Бүгд | | 1625 | 2500 |

16 Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаас.

# 4. СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 4.1. ТХБ-ЫГ СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИНТЕГРАЦЧИЛАХ НЬ

ТХБ нь соёлын олон төрөл байдлыг хүндэтгэн үзэхийн хамт одоогийн ба ирээдүй үеийнхэн байгаль орчинд ээлтэй, эдийн засагт өгөөжтэй, шударга зүй ёсны нийгмийн төлөө хариуцлагатай үйл хийж, мэдээлэлд үндэслэсэн шийдвэр гаргах талаар суралцагчдыг чадавхжуулахыг зорьдог.[17] ЕБС-ийн бага, дунд, ангид хэрэгжүүлж буй “Сургалтыг дэмжих үйл ажиллагаа” болон ахлах ангид хэрэгжүүлж буй сургуулийн мэдлийн цаг нь энэхүү зорилгыг үйл хэрэг болгоход чухал хувь нэмэр оруулах боломжтой юм. Тухайлбал: Иргэний боловсролын цаг нь сурагчдын хүн, байгаль, нийгэмтэй зөв харьцах чадварыг хөгжүүлж, хүнлэг, энэрэнгүй, ёс суртахуунлаг зан чанар, дадлыг хэвшүүлэхэд чиглэгдэж байгаа нь тогтвортой хөгжлийн үзэл санаа, тогтвортой хөгжлийн боловсролын чадвар, чадамжийг дэмжиж байна. Мөн “... иргэн бүрд үр бүтээлтэй амьдрах, зөв шийдвэр гаргах, орон нутаг болон дэлхийн өмнө тулгарч буй сорилт, бэрхшээлийг шийдвэрлэхэд идэвхтэй оролцоход шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагыг Тогтвортой хөгжлийн боловсролоор олж авч болно”[18] гэсэн Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийн стратегийн 62 дахь чиглэлийг хэрэгжүүлэхэд амьдрах чадвар болон хичээлээс гадуурх үйл ажиллагаа, сургуулийн мэдлийн цаг нь чухал үүрэгтэй болно.

“Сургалтыг дэмжих үйл ажиллагаа” (СДҮА) нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төлөвлөгөө” батлах тухай 2014 оны А/240 дүгээр тушаалаар бага боловсролын түвшинд 29-58 цагаар, 2015 оны А/220 дугаар тушаалаар суурь боловсролын түвшинд 35 цагаар заавал судлахаар тус тус тусгагдсан бөгөөд “Иргэний боловсрол” (ИБ), “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа” (АЧСҮА), “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа” (ХГҮА) гэсэн 3 үндсэн хөтөлбөрөөр хэрэгжиж, хичээлийн цагт[19] тооцогдох юм. Эдгээрээс “Иргэний боловсрол”, “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа” нь I-IX ангид орох бол “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа”, нь IV-IX ангид орно.

Мөн БСШУС-ын сайдын 2017 оны А/61-р тушаалаар “Сургуулийн мэдлийн цаг” (СМЦ)-ийн хөтөлбөрийг ЕБС-ийн ахлах ангид сургууль зохицуулах цагийн хүрээнд 70 цагаар хэрэгжүүлэхээр заасан.

Сургалтыг дэмжих үйл ажиллагаа болон сургуулийн мэдлийн цагийн хөтөлбөрүүд нь сурагчдыг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, хариуцлагатай шийдвэр гаргаж, хамтран ажиллаж амьдрах чадвартай, үндэсний дэвшилтэт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг дээдлэн хайрладаг, орон нутгийн хөгжил, орчны тогтвортой байдлыг сайжруулахад оролцдог үнэнч шударга, ёс суртахуунлаг иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгддэг.

17 Боловсрол 2030-Инчоны тунхаглал УБ.,2015 он хуудас-46
18 Боловсрол 2030-Инчоны тунхаглал УБ.,2015 он хуудас-46
19 Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр УБ.,2014 он. Хуудас -15
Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр УБ.,2015 он. Хуудас -14

Энэхүү үйл ажиллагааны цагуудын хөтөлбөр тус бүрийн зорилго, зорилт, хөгжүүлэх чадвар, арга барил нь ТХБ-ын суралцахуйн зорилт, Тогтвортой байдлын цогц чадамжуудтай дийлэнх нь шууд хамааралтай гэж үзэж болохоор байна.

*Хүснэгт 4.1. СДҮА болон СМЦ-ийн хөтөлбөрийн зорилго*

| Үйл ажиллагаа | Бага боловсрол | Суурь боловсрол |
|---|---|---|
| Иргэний боловсрол | Иргэний боловсролын хөтөлбөрийн зорилго нь сурагч бүрийг зөв төлөвшилтэй болох хүсэл, эрмэлзэл төрүүлэх, монгол ёс заншил, уламжлалт үнэт зүйл болон хүүхдийн ирээдүйн амьдралд хүч нэмэх дотоод итгэл үнэмшил, ёс суртахуун, зан чанарын үндсийг бэхжүүлэхэд чиглэнэ. | Сурагч нь хүнлэг энэрэнгүй сэтгэлтэй, ёс суртахуунлаг үйлдэл хийх, дадал хэвшилтэй, хүн, нийгэм, байгальтай зөв харилцдаг монгол ёс заншил, соёлын үнэт зүйлсийг эрхэмлэн хэрэглэдэг иргэн болж төлөвшинө. |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа | - Суралцагч бодит үйл ажиллагаанд оролцох явцдаа эрэл хайгуул хийх, асуудал олж харах, эргэцүүлэн бодох, илүү сайнаар шийдвэрлэх арга барил эзэмшинэ.<br>- Суралцагч эрэл хайгуулын явцад бүтээлчээр хамтран ажиллах, өөрийн амьдрах арга ухааныг эргэцүүлэн бодох, суралцах хүсэл эрмэлзэл, бие даан ажиллах, суралцах, нийгэм, амьдралын өөрчлөлтөд зохицон амьдрах чадварт суралцана. | Амьдралын бодит асуудлыг олж, шийдвэрлэх явцдаа судлан шинжлэх арга барилд суралцаж, бусадтай харилцаа холбоо тогтоон хамтран ажиллаж, өөрийн амьдрах арга ухаан, суралцах арга барилаа эргэцүүлэн бодож, улам сайжруулан түүнийгээ хэрэгжүүлэх замаар суралцах хүсэл эрмэлзэлтэй амьдрах чадвартай иргэн болж төлөвшинө. |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | Хамт олноороо хийх үйл ажиллагаагаар дамжуулан хүмүүс хоорондын зүй зохистой, хүнлэг харилцааг бий болгох, хамт олныхоо гишүүний хувьд амьдралаа илүү сайхан болгох, өөрийнхөө амьдрах ухааны талаар эргэцүүлэх, бодлоо улам гүнзгийрүүлж өөрийгөө хөгжүүлэх чадварт сургахад чиглэнэ. | Сурагч нь хамт олны үйл ажиллагааны явцад өөртөө итгэлтэй, өөрийгөө удирдах хөгжүүлэх, бусдыг манлайлах чадвартай хөгжилтэй эвсэг хамт олныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг, бүтээлч санаачилгатай оролцоот иргэн болж төлөвшинө. |
| **Үйл ажиллагаа** | **Бүрэн дунд боловсрол** | |
| Сургуулийн мэдлийн цаг | Сурагчид өөрийгөө хөгжүүлэх, ажил мэргэжлээ сонгох, ирээдүйн амьдралаа төлөвлөх, сайн үйл хийх, сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах, орон нутгийн үнэт зүйлийг эрхэмлэн хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах, мэдлэг чадвар, хүсэл эрмэлзэлтэй, амьдрах чадвартай иргэн болгон төлөвшүүлэх | |

Өнөөгийн байгаль, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудал нь ихэнхдээ хүний хандлага, харилцаа, буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж байна. Ялангуяа байгаль орчны доройтол нь хүмүүсийн байгаль, эх дэлхийгээ хайрлан хүндэтгэх, хамгаалах үүргээ үл биелүүлэн, ёс заншил уламжлал, заншлаа умартан ёс зүйгүй хандаж байгаатай холбоотой бол нийгмийн тэгш бус хуваарилалт, шударга бус үйлдэл, хүний эрхийн зөрчил зэрэг нь мөн л хүний ёс зүй, хандлагатай холбоотой. Эдгээр нь орон нутаг, хийгээд улс үндэстэн, дэлхий нийтийн тогтвортой хөгжилд тулгамдаж буй гол сорилт, бэрхшээл бөгөөд түүнийг шийдвэрлэхэд Иргэний боловсролын цаг нь чухал ач холбогдолтой юм. Сурагч СМЦ-аар өөрийн болон бусад хүмүүсийн ёс суртахуун, зан үйл, хандлагатай холбоотой асуудлыг эргэцүүлж, түүнд шүүмжлэлтэй хандаж, зөв дадал, хэвшилд суралцах нь тогтвортой хөгжлийн боловсролын суурь чадвар болно.

Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны онцлог нь суралцагч өөрсдийн орчин тойрон дахь асуудлаас сонгон шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх зэрэг тодорхой арга барил, чадваруудад суралцах явдал бөгөөд эдгээр нь тогтвортой байдлын хамтран ажиллах цогц чадамжийг хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтой. Учир нь АЧСҮА, ХГҮА-ны цагаар сурагч дан ганцаараа гэхээс илүүтэй анги хамт олноор, баг бүлгээр тодорхой асуудлыг шинжлэн судлах тул сурагчид үйл ажиллагааны явцад бусдаас суралцах, бусдын хэрэгцээ шаардлага, үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож, хүндэтгэх, мэдрэмжтэй хандах, багаараа хамтран аливаа зөрчил, тэмцлийг шийдвэрлэх, мөн хамтын хүчээр, оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх, зохицуулах зэргээр хамтран ажиллах чадварт суралцах юм.

СМЦ, АЧСҮА, ХГҮА-ны цагаар цөм хөтөлбөрт тусгагдсан үлгэрчилсэн сэдэв, агуулгаас өөрсдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн агуулгаа сонгон судлахаас гадна орон нутаг, сургууль, анги хамт олны онцлог, хэрэгцээнд үндэслэн, хэрэгжүүлэх үйл ажиллагааны сэдвээ суралцагч өөрсдөө сонгох боломжийг санал болгосон. Энэ нь тогтвортой хөгжлийн зорилттой холбогдох агуулгыг сонгон, ТХБ-ын чадвар, чадамжийг эзэмшүүлэхэд таатай нөхцөл, боломж бүрдүүлж байна. Харин ИБ-ын цагаар цөм хөтөлбөрт тодорхойлсон суралцахуйн зорилтын хүрээн дэх агуулгуудыг хэрэгжүүлэх бөгөөд тусгагдсан суралцахуйн зорилтууд нь ТХБ-ын суралцахуйн зорилттой нягт холбогдох боломжтой байна.

Бид энэхүү ажлын хүрээнд бага, суурь боловсролын СДҮА, бүрэн дунд боловсролын СМЦ"-ийн хөтөлбөр нь ТХБ-той хэрхэн интеграцчилагдаж буйг тодорхойлон, үйл ажиллагаа тус бүрээс ТХБ-той холбогдож буй нэг зорилтыг сонгон авч түүнийг анги танхимд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үлгэрчилсэн төлөвлөлт боловсруулав.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

СМЦ болон СДҮА-ны нийт 7 хөтөлбөрийн хүрээнд ТХЗ болон ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй хэрхэн холбогдож байгаад шинжилгээ хийв.

*Хүснэгт 4.2. СМЦ болон СДҮА-ны хөтөлбөр түвшингээр*

| Үйл ажиллагааны нэр | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
|---|---|---|---|
| Иргэний боловсрол | I-V анги | VI-IX анги | |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа | IV-V анги | VI-IX анги | |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | I-V анги | VI-IX анги | |
| Сургуулийн мэдлийн цаг | | | X-XII анги |

*Шинжилгээний аргын онцлог:* СМЦ болон АЧСҮА, ХГҮА-ны цөм хөтөлбөрт бусад судлагдахуунтай адил шууд хэрэгжүүлэх суралцахуйн зорилт, агуулга анги тус бүрээр тодорхойлогдоогүй байна. Тиймээс бид цөм хөтөлбөр тус бүрд санал болгосон үлгэрчилсэн сэдэв, эзэмшүүлэх цогц чадамжийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагаануудыг зорилт байдлаар шинээр (завсрын бүтээгдэхүүн) томьёолж түүнийг ТХЗ, ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй хэрхэн холбогдож болохыг тодорхойлов. Харин суурь боловсролын ИБ-ын цөм хөтөлбөрт V-VII, VIII-IX ангийн түвшинд хэрэгжүүлэх суралцахуйн зорилт, агуулга тодорхойлогдсон тул тэдгээрийг ТХЗ, ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй хэрхэн холбогдож байгааг шинжлэв. Мөн энэхүү шинжилгээг хийхдээ ангиар бус боловсролын түвшнээр

нь авч үзсэн. Учир нь СМЦ, АЧСҮА, ХГҮА-аар ямар зорилтын хүрээнд, ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь тухайн анги, сургууль орон нутгийн хэрэгцээ, онцлогт тулгуурлан тодорхойлогдох тул багш, суралцагчид энэхүү онцлогт тохируулан анги харгалзахгүйгээр аль зорилтыг хэрэгжүүлэхээ сонгох боломжтой гэж үзэв.

*Хүснэгт 4.3. Хөтөлбөр тус бүрийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны зорилтыг (завсрын бүтээгдэхүүн) тодорхойлсон байдал*

| Үйл ажиллагааны нэр | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
|---|---|---|---|
| Иргэний боловсрол | 4 бүлэг сэдэв 16 зорилт | Цөм хөтөлбөрт тодорхойлогдсон | |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа | 16 сэдэв, 5 чадвар, 18 арга барил | 3 бүлэг сэдэв 17 зорилт | |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | 5 бүлэг сэдэв 18 зорилт | 15 сэдвийн хүрээнд 15 зорилт | |
| Сургуулийн мэдлийн цаг | | | 5 бүлэг сэдэв 14 зорилт |

Цөм хөтөлбөрийн хүрээнд бидний тодорхойлсон дээрх зорилтууд нь нийт 116 удаа ТХЗ, ТХЗБ-ын суралцахуйн зорилт, түүнд хүрэх сэдэвтэй холбогджээ. Эдгээрээс ТХ-ийн аль зорилготой хамгийн олон болон цөөн давтамжтай холбогдсон байдлыг эрэмбэлэн авч үзвэл:

- ТХ304. “Чанартай боловсрол” зорилгын хүрээн дэх суралцахуйн зорилт, сэдэвтэй 22 удаа,
- ТХ303. “Сайн эрүүл мэнд ба сайн сайхан байдал” зорилгын хүрээн дэх суралцахуйн зорилт, сэдэвтэй 14 удаа,
- ТХ315. “Газар дээрх амьдрал” зорилгын хүрээн дэх суралцахуйн зорилт, сэдэвтэй 11 удаа,
- ТХ306. “Цэвэр ус ба ариун цэвэр” зорилгын хүрээн дэх суралцахуйн зорилт, сэдэвтэй 10 удаа холбогдсон байгаа нь нийт зорилтоос олон давтамжтай байна.

Харин хамгийн бага холбогдсон зорилгын тухайд

- ТХ314. “Усан доорх амьдрал” зорилготой 2 удаа,
- ТХ309. “Үйлдвэрлэл, инноваци, дэд бүтэц” зорилготой 3 удаа,
- ТХ317. “ТХЗ-ын төлөөх түншлэл” зорилготой 3 удаа тус тус холбогдсон нь хамгийн бага давтамжтай байна.

*Хүснэгт 4.4. СМЦ, СДҮА ба ТХЗ-ын хамаарах байдал (тоогоор)*

| Үйл ажиллагааны нэр | Тогтвортой хөгжлийн зорилт | | | | | | | | | | | | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | |
| Иргэний боловсрол (бага) | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 17 |
| Иргэний боловсрол (суурь) | | | 2 | 7 | 1 | | | 1 | | 2 | | | 1 | | 4 | 1 | | 19 |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа (бага) | 3 | 2 | 1 | 1 | 1 | 2 | 2 | | | | 1 | | 1 | | 2 | | | 16 |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа (суурь) | 1 | 1 | 2 | 1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | | 1 | 1 | 1 | | 2 | 1 | 1 | 19 |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (бага) | | | 2 | 5 | 1 | | | | | | 1 | | | | 1 | | | 10 |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (суурь) | 0 | 1 | 5 | 4 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 15 |
| Сургуулийн мэдлийн цаг ахлах | 1 | 0 | 1 | 3 | 1 | 3 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 20 |
| Нийт | 6 | 5 | 14 | 22 | 7 | 9 | 6 | 4 | 3 | 5 | 6 | 4 | 5 | 2 | 11 | 4 | 3 | 116 |

СДҮА-г ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй холбогдож буй байдлыг боловсролын түвшнээр нь харьцуулбал зарим үйл ажиллагаа нь харьцангуй ойролцоо давтамжтай байна. Тухайлбал: бага боловсролын иргэний боловсрол нь 17 удаа холбогдсон бол суурь боловсролын иргэний боловсрол нь 19 удаа холбогдож байна. Бага боловсролын АЧСҮА нь 16 удаа, суурь боловсролын АЧСҮА нь 19 удаа холбогдсон бөгөөд 2-3 буюу харьцангуй цөөн тооны зөрүүтэй байна.

Харин ХГҮА нь бага, суурь боловсролын түвшинд холбогдсон байдал нь нэлээд зөрүүтэй байгаа ба бага боловсролын түвшинд тэдний нас, бие, сэтгэл зүйн онцлог нь зарим зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэнтэй холбоотой.

*Зураг 4.1. ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй холбогдсон давтамж ба тархалт*




Мөн цөм хөтөлбөрийн хүрээнд бидний тодорхойлсон дээрх зорилтууд нь ТХЗБ-ын суралцахуйн зорилтын 3 айд ямар тархалт, давтамжтай байгааг авч үзвэл, Нийгэмшил- сэтгэл хөдлөлийн айтай хамгийн олон буюу 55 зорилт нь уялдаж байгаа бол зан үйлийн айтай 36, танин мэдэхүйн айтай 25 зорилт тус тус уялдаж байна.

Энэ нь СДҮА-ны онцлогтой холбоотой бөгөөд тус цагуудаар шинжлэх ухааны онол, агуулга, ухагдахууныг судлахаас илүү хичээл, судлагдахуунаар эзэмшсэн ойлголт, мэдлэг, чадвараа ашиглан бодит үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх явцад сурагчид бусдыг ойлгох, зөрчлийг шийдвэрлэх, харилцах, холбоо харилцаа үүсгэх, зэрэг нийгэмшихүйн чадвараа хөгжүүлэх бол хамтын сайн сайхны төлөө хичээн зүтгэх, аливаад хариуцлагатай, ёс зүйтэй хандах зэргээр зан үйлийн чадвараа хөгжүүлэх боломжтой юм.

*Хүснэгт 4.5. СМЦ, СДҮА ба ТХЗБ-ын суралцахуйн зорилтын айн хамаарал (тоогоор)*

| Үйл ажиллагааны нэр | Танин мэдэхүйн | Нийгэмшил сэтгэл хөдлөл | Зан үйл |
|---|---|---|---|
| Иргэний боловсрол (бага) | 4 | 11 | 2 |
| Иргэний боловсрол (суурь) | 6 | 11 | 2 |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа (бага) | 7 | 6 | 3 |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа (суурь) | 0 | 8 | 11 |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (бага) | 3 | 2 | 5 |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (суурь) | 5 | 6 | 4 |
| Сургуулийн мэдлийн цаг (ахлах) | 0 | 11 | 9 |
| Нийт | 25 | 55 | 36 |

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

СДҮА болон СМЦ-ийг хэрэгжүүлэхдээ сурагчдын бүтээлч санаачилга, сургуулийн бодит байдал, сурагчдын онцлог, хөгжлийг харгалзан гэр бүл, нутгийн оршин суугчид, орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах нь үр дүнтэй.

Мөн үйл ажиллагааны цагууд нь харилцан уялдаатай хэрэгжих бөгөөд бусад судлагдахуунтай нягт уялдаатай төлөвлөгдөх ёстой. Өөрөөр хэлбэл, тус цагуудаар хичээл судлагдахуунаар эзэмшсэн мэдлэг, чадвараа бататгах, баяжуулан хөгжүүлэх, амьдрал практикт хэрэглэж сурах юм.

СДҮА-ны цагийн арга зүй нь хөтөлбөр бүрийн хувьд онцлогтой. Тухайлбал: АЧСҮА нь шинжлэн судлах (тулгамдсан асуудлаа тодорхойлох, мэдээлэл цуглуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, хэлэлцэх) арга барилд суралцуулахад чиглэж байгаа бол, ХГҮА нь асуудал шийдвэрлэх арга барилд суралцуулж өөрийгөө хөгжүүлэх чадвар, манлайлах чадвар, харилцах чадвар, оролцооны чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Дээрх үйл ажиллагааны цагуудын ТХЗ-той интеграцчилагдаж байгаа зорилт, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд ТХЗ-ыг хангах аргуудаас бодит үйл ажиллагаанд оролцох арга 69 удаа, судалгаа шинжилгээ хийх арга нь 48 удаа буюу бусад аргуудаас илүү сонгосон. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

*Хүснэгт 4.6.* *СМЦ, СДҮА ба ТХЗ-ыг хангах сургалтын арга*

| Үйл ажиллагааны нэр | Бодит үйл ажиллагаанд оролцох аргууд | Шинжилгээ, судалгаа хийх аргууд | Бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд | Алсын хараатай болох аргууд |
|---|---|---|---|---|
| Иргэний боловсрол (бага) | 6 | 2 | 6 | 3 |
| Иргэний боловсрол (суурь) | 7 | 5 | 4 | 2 |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа (бага) | 7 | 5 | 4 | 0 |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа (суурь) | 16 | 9 | 8 | 6 |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (бага) | 10 | 2 | 0 | 6 |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (суурь) | 13 | 11 | 13 | 12 |
| Сургуулийн мэдлийн цаг (ахлах) | 10 | 14 | 6 | 12 |
| Нийт | 69 | 48 | 41 | 41 |

Дээрх аргуудаас бодит үйл ажиллагаанд оролцох, шинжилгээ, судалгаа хийх аргууд илүү сонгогдсон байгаа нь СДҮА-ны онцлогтой нийцсэн нэлээн оновчтой сонголт гэж үзэж байна.

ТХ-тэй холбогдож буй асуудлуудыг шийдэхийн тулд санал, санаачилга гарган тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн хүмүүс, байгууллагатай хамтран ажиллах, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, тодорхой чиглэлээр уриалга гаргах, аян өрнүүлэх, сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах зэрэгт бодит үйл ажиллагаанд оролцох аргыг ихэвчлэн сонгожээ.

Мөн АЧСҮА, ХГҮА болон СМЦ-ийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд 2 ба түүнээс дээш аргыг сонгосон тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал:

- Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагийн хэрэгжүүлэх “Эрүүл зөв хооллолтын талаар өөрийн байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх” гэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд дараах аргуудаар зохион байгуулах ба анги, сурагчдын онцлогт тохируулан үйл ажиллагаанаас сонгохыг санал болгосон байна.
  - *Бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээний аргаар*: Хоол хүнс болон эрүүл зөв хооллолт нь хүний бие бялдар, сэтгэл хөдлөлд хэрхэн яаж нөлөөлдөг тухай бодит тохиолдлуудыг шинжлэх /кэйс/
  - *Шинжилгээ, судалгаа хийх аргаар*: Сурагчдын идэх дуртай хоолны талаар судалгаа авч нэгтгэх, үр дүнд үндэслэн сургуулийн цайны газрын цэсэд өөрчлөлт оруулах санал дэвшүүлэх
  - *Шинжилгээ, судалгаа хийх аргаар*: Орон нутгийн түвшинд хүнс тэжээлийн дутагдал, тоо хэмжээ, тархалтыг судалж, дүгнэн эрүүл зөв хооллолт, хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх талаар зааварчилгаа боловсруулж, бусдад түгээх

- Бага боловсролын АЧСҮА-ны цагаар хэрэгжүүлэх “Орон нутгийн хүмүүс болон байгууллагуудтай бүтээлчээр хамтран, орон нутгийн хэмжээнд мөхөх устах аюулд өртсөн, ховордсон амьтан ургамлыг илрүүлэн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах” зорилтыг:
  - *Шинжилгээ, судалгаа хийх аргаар*: Мөхөх устах аюулд өртсөн,

ховордсон амьтан, ургамлын талаар эцэг эх, орон нутгийн хүмүүс болон байгууллагуудтай хамтран судалгаа хийх

- *Бодит үйл ажиллагаанд оролцох аргаар:* Ажиглалт, судалгааны үр дүнд санал, санаачилга гарган, ховордсон ан амьтдыг хамгаалах аян өрнүүлэх зэргээр хэрэгжүүлэхийг санал болгожээ.

- Сургуулийн мэдлийн цагийн “Суралцагч өөрийн орон нутгийн түвшинд ядуурлыг бууруулахад чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг анги хамт олонтойгоо хамтран хэрэгжүүлэх” гэсэн зорилтыг:
  - *Шинжилгээ, судалгаа хийх аргаар*: “Орон нутгийн түвшинд ядуурал өртөж байгаа айл өрх, хүмүүсийн тооцоо судалгааг гаргах,
  - *Бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээний аргаар*: тэдгээр хүмүүст туслах ажлын талаар санаачилга гаргаж хамтаараа хэлэлцэх, хамгийн үр дүнтэй ажлыг анги хамт олноороо хамтран хэрэгжүүлэх Тухайлбал: ганц бие өндөр настанд туслах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх жижиг төсөл боловсруулах, хэрэгжүүлэх зэргээр энэхүү зорилтуудыг хэрэгжүүлэх юм.

Шинжилгээнээс үзэхэд СМЦ болон СДҮА-ны хүрээнд бидний томьёолсон зорилтуудыг хэрэгжүүлснээр суралцагчдын тогтвортой байдлын цогц чадамжуудыг хөгжүүлэхэд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах боломжтой байна. Үүнд:

- АЧСҮА, ХГҮА-ны цагийн хувьд тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж, хамтран ажиллах цогц чадамж, шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж, асуудлыг урьдчилан тооцоолох цогц чадамж зэргийг хөгжүүлэхэд түлхүү хувь нэмэр оруулах боломжтой талаар дээрх үйл ажиллагааны интеграцыг боловсруулсан гишүүд үзсэн байна. Учир нь АЧСҮА-ны цагаар шинжлэн судлах арга барилд суралцаж “асуудлыг олох тодорхойлох, төлөвлөх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, үнэлэх, үр дүнг нэгтгэн дүгнэх, хэлэлцэх” чадваруудаа хөгжүүлэхийг чухалчилсан. Эдгээр сурах арга барилыг эзэмшихэд аливаа асуудлыг цогцоор нь харах, асуудалд бүтээлч шүүмжлэлтэй бодитой хандах, түүнийг шийдвэрлэхийн тулд бүтээлчээр хамтран ажиллах зэрэг шаардлага тулгардаг.
- Иргэний боловсролын цагийн хувьд өөрийгөө таньж мэдэх, хамтран ажиллах, асуудал шийдвэрлэх болон хэм хэмжээний цогц чадамжид хувь нэмэр оруулах боломж нь илүү давамгай байна. Энэ нь тус үйл ажиллагааны цагийн онцлог бөгөөд иргэний боловсролын цагаар хүнлэг, энэрэнгүй, ёс суртахуунлаг дадал, хэвшилтэй, хүн байгаль нийгэмтэй зөв харилцдаг иргэнийг төлөвшүүлэхийг зорьдог талаар дээр өгүүлсэн. Тиймээс энэхүү цагийн хүрээнд суралцагч өөрийн болон бусдын үйл, үйлдэл, харилцаа хандлагаа эргэцүүлэн өөрийгөө таньж, өөртөө шүүмжлэлтэй хандан алдаа дутагдлаа засах нь хамгийн чухал.
- СМЦ-ийн хүрээнд сурагчид өөрийгөө хөгжүүлэх, ажил мэргэжлээ сонгох, ирээдүйн амьдралаа төлөвлөх зэргээр урьдчилан тооцоолох цогц чадамжаа хөгжүүлэх боломжтой бол сайн үйл хийх, сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах, орон нутгийн үнэт зүйлийг эрхэмлэн, нутгаа хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах үйл ажиллагааг бусадтай хамтран хэрэгжүүлснээр бусдаас суралцах, бусдын хэрэгцээ шаардлага, үзэл бодлыг ойлгож, бусдыг хүндэтгэх, хамтын хүчээр асуудлыг шийдвэрлэх зэргээр хамтран ажиллах цогц чадамжаа илүү хөгжүүлэх боломж байна.

## СМЦ, СДҮА-ны үлгэрчилсэн төлөвлөлт боловсруулсан байдал

АЧСҮА, ХГҮА, ИБ-ын цагуудыг хоорондоо болон бусад бүх төрлийн хичээлүүдтэй нягт уялдаатай хэрэгжиж, хүүхэд бүрийн хөгжил, сургууль, орон нутгийн зорилгод хувь нэмрээ оруулах байдлаар зохион байгуулахыг цөм хөтөлбөрт зөвлөсөн.

Бид үүнд үндэслэн эдгээр цагуудаар хэрэгжүүлэх нэгж үйл ажиллагааны интеграцыг ТХЗБ-ын суралцахуйн нэг зорилт, түүнд хүрэх сэдвийг сонгон авч үйл ажиллагаа бүрийн онцлогт тохирсон байдлаар боловсруулахыг хичээсэн болно. Өөрөөр хэлбэл бага, суурь боловсролын түвшин тус бүрд ИБ, ХГҮА, СДҮА-ны цагаар ТХЗБ-ын суралцахуйн ижил зорилт, сэдвийг тухайн үйл ажиллагааны онцлогийг тусган хэрхэн хэрэгжүүлж болох талаар жишээ төлөвлөлт хийж та бүхэнд санал болгож байна.

*Хүснэгт 4.7. СМЦ болон СДҮА-ны цагийн жишээ Интеграц боловсруулсан мэдээлэл*

| Хариуцсан чиглэл | ТХЗ | Нэгжийн сэдэв | Анги | Боловсруулсан |
|---|---|---|---|---|
| Бага боловсрол | | | | |
| Иргэний боловсрол | ТХЗ13. Уур амьсгалын төлөөх үйл хэрэг | Уур амьсгалын өөрчлөлт миний амьдралд нөлөөлдөг үү? | 5 | Ганжуурын Шүрэнцэцэг (Мон-Турк сургууль, сургалтын менежер) |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа | | Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг судлан хэрэгжүүлье | 5 | Наваань Мөнхбаяр (БМДИ, албаны дарга) |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | | Уур амьсгалын өөрчлөлтөд-хүүхэд бидний оролцоо | 5 | Нямаагийн Цогзолмаа (МУБИС, Багшийн сургуулийн багш) |
| Суурь боловсрол | | | | |
| Иргэний боловсрол | ТХЗ03. Сайн эрүүл мэнд ба сайн сайхан байдал | Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдал: PC тоглоомын донтолтоос үе тэнгийнхнийгээ аваръя | 7 | Лхагваагийн Отгонсүрэн (БСШУСЯ-ны мэргэжилтэн) |
| Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа | | Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдал: Ганцаардлаас урьдчилан сэргийлэх арга замуудад суралцъя. | 7 | Равдангийн Туяа (БМДИ, албаны дарга) |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | | Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдал: Аз жаргалтай суралцацгаая | 7 | Ламжавын Сосорбарам (СБД-ийн БХ-ийн мэргэжилтэн) |
| Бүрэн дунд боловсрол | | | | |
| Сургуулийн мэдлийн цаг | ТХЗ04. Чанартай боловсрол | Сургууль завсардсан хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд нь нөлөөлөх | 11 | Сосорбурамын Ариунгэрэл (БМДИ, арга зүйч) |

*Хүснэгт 4.8. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Иргэний боловсролын матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.2. Өдөр тутмын амьдралдаа ёс суртахуунлаг байр сууринаас хандах | ТХ301.НСХ3. | ТХ301. Сэ08 |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.5. Өдөр тутмын амьдралдаа ёс суртахуунлаг шийдвэр гаргах | ТХ302.ТМ3. | ТХ302. Сэ03. |
| 4.Ёс суртахуунлаг дадал, хэвшил | 15, 4.3. Ёс суртахуунлаг дадал хэвшлээ өдөр тутмын амьдралдаа хэрэглэх | ТХ303.ЗҮ1 | ТХ303. Сэ03. |
| 1. Ёс суртахуунлаг зүрх сэтгэл | 15, 1.2. Ёс суртахуунлаг үнэт зүйлийг эрхэмлэхийн чухлыг мэдрэх | ТХ304.ТМ2. | ТХ304. Сэ01. |
| 3. Ёс суртахуунлаг үйлдэл | 15, 3.2. Амьдралын янз бүрийн нөхцөлд ёс суртахуунлаг үйлдэл хийх | ТХ305.НСХ4. | ТХ305. Сэ05. |
| 4.Ёс суртахуунлаг дадал, хэвшил | 15, 4.2. Тодорхой хугацааны туршид хийсэн ёс суртахууны дадал хэвшилтэй болох | ТХ306.НСХ3. | ТХ306. Сэ06. |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.3. Өдөр тутмын амьдралдаа ёс суртахуунлаг байр сууринаас хандах | ТХ307.НСХ4 | ТХ307. Сэ03. |
| 3. Ёс суртахуунлаг үйлдэл | 15, 3.4. Ёс суртахууны чадвараас шалтгаалан зохистой үйлдэл хийх | ТХ308.НСХ4. | ТХ308. Сэ02. |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.2. Өдөр тутмын амьдралдаа ёс суртахуунлаг хандах | ТХ309.НСХ5. | ТХ309. Сэ09 |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.4. Ёс суртахуунлаг байр сууринаас сайн мууг ялгах, таних | ТХ310.ТМ5. | ТХ310. Сэ03. |
| 1. Ёс суртахуунлаг зүрх сэтгэл | 15, 1.2. Ёс суртахуунлаг үнэт зүйлийг эрхэмлэх мэдрэмжтэй болох | ТХ311.НСХ3. | ТХ311. Сэ07. |
| 4.Ёс суртахуунлаг дадал, хэвшил | 15, 4.1. Ёс суртахуунлаг дадал хэвшилтэй болох | ТХ312.НСХ3. | ТХ312. Сэ05. |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.4. Ёс суртахуунлаг байр сууринаас сайн мууг ялгах, таних | ТХ313.НСХ1. | ТХ313. Сэ03 |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 3.4. Ёс суртахууны чадвараас шалтгаалан зохистой үйлдэл хийх | ТХ314.ТМ3. | ТХ314. Сэ06. |
| 3. Ёс суртахуунлаг үйлдэл | 15, 3.3. Амьдралын янз бүрийн нөхцөлд зохистой үйлдэл хийх | ТХ315.ЗҮ4. | ТХ315. Сэ06. |
| 1. Ёс суртахуунлаг зүрх сэтгэл | 15, 1.4. Ёс суртахуунлаг зүрх сэтгэлээр муу зүйлийг жигших мэдрэмжтэй болох | ТХ316.НСХ3 | ТХ316. Сэ06. |
| 3. Ёс суртахуунлаг үйлдэл | 15, 4.2. Тодорхой хугацааны туршид хийсэн ёс суртахуунлаг дадал хэвшилтэй болох | ТХ317.НСХ5. | ТХ317. Сэ02 |

*Хүснэгт 4.9. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| Орон нутгийн онцлогт тохирсон сэдэв | 45, 6.2.д. Орон нутгийн хүмүүсийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж тусламж дэмжлэг хэрэгтэй хүмүүсийн талаар асуудлыг олж харан шийдлийн гарцыг тодорхойлох | ТХ301.НСХ3 | ТХ301. Сэ07. |
| Сургуулийн онцлогт тохирсон сэдэв | 45, 8.5.в. Сургуулийн амьдрал буй тэгш бус байдлыг бусадтай харилцах явцад илрүүлэх, өөрийнхөө харилцааны ур чадварыг эргэцүүлэн бодож, тэгш бус байдлаас үүдэн гарах үр дагаврыг ойлгож, ухаарсан зүйлээ хэрэгжүүлэх | ТХ301.НСХ5. | ТХ301. Сэ08. |
| Хоол хүнстэй холбоотой сэдэв | 45, 13.1.б. Хоол хүнс, хоол хүнсний шим тэжээлт бодисын талаар судалж, шим тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх ойлголт мэдлэгээ нэмэгдүүлэх | ТХ302.ТМ1. | ТХ302. Сэ01. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 15.2.д. Байгаль орчин, байгальд ээлтэй хөдөө аж ахуйн хөгжлийн талаар мэдээлэл цуглуулан, сонирхсон асуудлаа судлагдахуунаар олж авсан мэдлэг чадвараа ашиглан шийдвэрлэх | ТХ302.НСХ1. | ТХ302. Сэ03. |
| Хоол хүнстэй холбоотой сэдэв | 45, 5.4.а Хүний амьдралд хоол хүнсний гүйцэтгэх үүргийг эргэцүүлэн бодож гэр бүл хамт олны нэг гишүүний хувьд юу хийх, яаж хувь нэмэр оруулах, үүрэг оролцоогоо эргэцүүлэх | ТХ302.НСХ5. | ТХ302. Сэ05. |
| Эрүүл мэндтэй холбоотой сэдэв | 45, 12.2.д. Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр ямар ямар үйл ажиллагаа хийгдэж байгааг олж харан ач холбогдлыг хэлэлцэн дэмжин сурталчлах | ТХ303.ТМ3. | ТХ303. Сэ03. |
| Орон нутгийн онцлогт тохирсон сэдэв | 45, 7.4.в. Орон нутгийн хөгжил, түүх, бүтээн байгуулалт, эрхлэх аж ахуйн хүрээнд амжилт гаргасан хүмүүстэй харилцаа тогтоон хамтран ажиллах | ТХ304.НСХ4. | ТХ304. Сэ06. |
| Үндэсний онцлогт тохирсон сэдэв | 45, 5.1.д. Амьдралын үнэ цэнэ, утга учир, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагын талаар мэдээлэл цуглуулан судлан шинжлэх | ТХ305.ТМ1. | ТХ305. Сэ10. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 5.2.д. Байгаль орчин, байгальд ээлтэй усны хэрэглээний талаар судалж усны бохирдол, хомсдолын учир шалтгааныг танин мэдэх | ТХ306.ТМ1. | ТХ306. Сэ10. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 15.1.г. Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ, усны хэрэглээний талаар асуудлыг олж харан шийдвэр гаргах | ТХ306.ЗҮ3. | ТХ306. Сэ06. |
| ШУ, технологийн хөгжил | 45, 16.1.б. Шинжлэх ухаан технологийн хөгжил, эрчим хүчний төрөл, эрчим хүчний бидний амьдралд нөлөөлж буй нөлөөллийг ойлгох | ТХ307.ТМ1. | ТХ307. Сэ01. |
| ШУ, технологийн хөгжил | 45, 7.5.б. Шинжлэх ухаан технологийн хөгжлийн үр дүн эрчим хүчний хэрэглээ бидний амьдралд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэн өөрийн үүрэг оролцоогоо нэмэгдүүлэх | ТХ307.ЗҮ1. | ТХ307. Сэ06. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 7.1.а. Байгаль орчин, байгаль орчинд ээлтэй хог хаягдлын менежментийг судлан өөрийн үүрэг оролцоогоо нэмэгдүүлэх | ТХ311.НСХ5. | ТХ311.Сэ07. |

| | | | |
|---|---|---|---|
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 15.1.г. Байгаль орчныг бохирдуулж буй хүний буруутай үйл ажиллагаа түүнээс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн айл өрх, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг илрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлэх арга замыг судлан хэрэгжүүлэх | ТХ313.ТМ3. | ТХ313. Сэ03. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 15.2.д. Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээг олж харах, байгальд хор хөнөөл учруулж сүйтгэж байгаа шалтгааныг эрж хайн байгаль хамгаалахад хувь нэмрээ оруулах | ТХ315.ТМ4. | ТХ315. Сэ08. |
| Орон нутгийн онцлогт тохирсон сэдэв | 45, 8.3.а. Орон нутгийн хүмүүс болон байгууллагуудтай бүтээлчээр хамтран , орон нутгийн хэмжээнд мөхөх устах аюулд өртсөн, ховордсон амьтан ургамлыг судлан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулна. | ТХ315.ЗҮ1. | ТХ315. Сэ03. |

*Хүснэгт 4.10. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсролын Хичээлээс гадуурх үйл ажиллагааны матриц 1-ээс)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | ТХБ | |
|---|---|---|---|
| | | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв |
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа | 15, 1.1. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа "Үдийн цай" хөтөлбөрөөр эрүүл, зөв хооллох соёлд суралцах | ТХ303.ЗҮ1 | ТХ303.Сэ03 |
| 1. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа | 15, 1.3.Сургуулийн өдөр тутмын ажлын хүрээнд “Хөгжимт, хөдөлгөөнт гимнастик” үйл ажиллагаагаар Хүүхдийн эрүүл мэнд болон бие бялдрын хөгжлийг хангах | ТХ303.ЗҮ1 | ТХ303.Сэ09 |
| 1. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа | 15, 1.5.Уншлагын цаг үйл ажиллагааны хүрээнд ном унших чадвараа хөгжүүлэх | ТХ304.ЗҮ5 | ТХ304.Сэ01. |
| 2. Урлаг спортын үйл ажиллагаа | 15, 2.1.Урлаг спортын оролцоогоор дамжуулан зөв дадал хэвшил эзэмшүүлэх т сэдэл төрүүлэх,Үнэт зүйлээ мэдрэх | ТХ304.НСХ2 | ТХ304.Сэ07 |
| 3.Ангийн ажлын хүрээнд “Ангийн хурал, цуглаан ” | 15, 3.1.Ангийн хурлаар тулгамдсан асуудлаа хэлэлцэж хамтын шийдвэр гаргах, түүнийг дагаж мөрдөх | ТХ304.ЗҮ4 | ТХ304.Сэ01 |
| 3.Ангийн ажлын хүрээнд “Ангийн хурал, цуглаан ” | 15,3.2.Ангийн цуглаанаар гаргасан шийдвэрийн дагуу өөрийн үүргийг ухамсарлаж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах | ТХ304.ЗҮ4 | ТХ304.Сэ07 |
| 4. Тэмдэглэлт өдөр | 15, 4.5.Орон нутгийн уламжлал, соёлоор бахархах, өвлөх | ТХ305.ТМ1 | ТХ305.Сэ02 |
| 4. Тэмдэглэлт өдөр | 15.4.3.Монгол үндэсний тоглоомоор дамжуулан өв уламжлалыг сайжруулан хадгалах, хойш үедээ өвлүүлэн тогтвортой авч үлдэх | ТХ311.ТМ3 | ТМ311.Сэ08 |
| 5. Сайн дурын үйл ажиллагаа | 15, 5.1. Бусдын сайн сайхны төлөө хийх үйлүүд | ТХ317.НСХ3 | ТХ317.Сэ09 |
| 5. Сайн дурын үйл ажиллагаа | 15, 5.2.Сайн дурын үйл ажиллагаанд оролцож бусадтай нөхөрлөх, итгэл хүлээх, зүй зохистой хүнлэг харилцах чадвараа хөгжүүлэх | ТХ317.НСХ4 | ТХ317.Сэ10 |

# 4.2. ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ

## 4.2. А. БАГА БОЛОВСРОЛЫН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ЦАГИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Иргэний боловсролын хөтөлбөрийн зорилго нь хүүхэд бүрийг зөв төлөвшилтэй болох хүсэл, эрмэлзэл төрүүлэх, монгол ёс заншил, уламжлалт үнэт зүйл болон хүүхдийн ирээдүйн амьдралд хүч нэмэх дотоод итгэл үнэмшил, ёс суртахуун, зан чанарын үндсийг бэхжүүлэхэд чиглэгдсэн ба дараах зорилтуудыг хэрэгжүүлэх юм. Үүнд:

- Ёс суртахуунлаг зүрх сэтгэл, ёс суртахуунлаг үнэт зүйлийг эрхэмлэхийн чухлыг ойлгох, ёс суртахуунлаг зүрх сэтгэлээр сайн зүйл хийхийн баяр баясгаланг мэдрэх, ёс суртахуунлаг бус муу зүйлийг жигших мэдрэмжтэй болох замаар сурах арга барил эзэмшинэ.
- Ёс суртахуунлаг шийдвэр гаргахын тулд аливаа асуудалд ёс суртахуунлаг байр сууринаас хандаж сайн мууг ялган таних, өдөр тутмын амьдралдаа ёс суртахуунлаг шийдвэр гаргадаг байхад суралцана.
- Ёс суртахуунлаг үйлдэл хийж суралцахын тулд амьдралын янз бүрийн нөхцөлд ёс суртахуунлаг зүй зохистой үйлдэл хийх, арга ухаанд суралцана.
- Ёс суртахуунлаг дадал хэвшилтэй болохын тулд тодорхой хугацааны туршид хийсэн зөв дадал хэвшлээ төлөвшүүлэх, энэ дадал хэвшил нь өдөр тутмын амьдралын соёл болон төлөвшиж, монгол ёс заншил, уламжлалт зан чанарын үндсийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг болно.

Дээрх зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд ТХЗ, ТХЗБ-ын суралцахуйн зорилт, ТБЦЧ-тай холбогдож байна. Иргэний боловсролын цагаар "Ёс суртахуунлаг зан чанар" үндсэн агуулгын хүрээнд хүүхдийн зөв зан чанартай сайн сайхан амьдрах чин хүслийг төрүүлэх улмаар хүний амьдралын зөв, буруу, болох, болохгүй, зүйлийг өөрөөр нь ухааруулж, эргэцүүлэн бодуулах, өөрийн гэсэн шийдвэр гаргах, өөрөө өөртөө амлалт авах түүнийгээ хэрэгжүүлдэг болох 4 суралцахуйн зорилт байгаа ба тэдгээр нь тогтвортой хөгжлийн 17 зорилгын 17 суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдаж болохоор байна.

### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Иргэний боловсролын хөтөлбөрийн агуулга ба тухайн суралцахуйн зорилт нь ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй аль болох шууд болон дам утгаар нийцэх байдал, суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирох байдал, хичээлийн үндсэн агуулгын хүрээнд хэрэгжих боломж зэргийг харгалзан агуулгын интеграцыг авч үзлээ.

*Бага боловсролын ИБ-ын цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах зорилт (тоогоор)*

| Сургалтын хөтөлбөр | Тогтвортой хөгжлийн зорилго | | | | | | | | | | | | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | |
| Иргэний боловсрол бага | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 17 |

Дээрх хүснэгтээс дүгнэж үзвэл иргэний боловсролын 1-р сэдвийн 15,1, 15,1.3. 2-р сэдвийн 15, 2.1. 3-р сэдвийн 15,3.1. 4-р сэдвийн 15,4.4 ТХЗБ-ын суралцахуйн зорилттой холбогдох боломжгүй байсан бол харин үлдсэн 9 сэдэв нь холбогдох боломжтой ажээ.

Мөн ИБ-ын суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилтын 3 айтай хэрхэн холбогдсоныг авч үзвэл:

- Танин мэдэхүй айд- 5,
- Нийгэмшил-сэтгэл хөдлөлийн айд-11,
- Зан үйлийн айд- 2 байна.

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Иргэний боловсролын цагийн агуулгын 33 хувь нь ТХЗ, ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдвийн талаар судлах, танилцах, танин мэдэх, 61 хувь нь ойлголтыг тодорхойлох, эргэцүүлэн бодох, анхаарлаа хандуулах, байр сууриа илэрхийлэх, хамтран асуудал шийдэх зэрэг үйлдэл хийх, үлдсэн 10 хувь нь зарим нэг нөлөөллийн арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулахад оролцох чадварыг хөгжүүлэхэд чиглэж байна.

Тухайлбал: Иргэний боловсролын үйл ажиллагааны цагийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдэл зэрэг гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүдийн талаар ойлгож авна. Уур амьсгалын өөрчлөлтөд хүний үйл ажиллагаа нь хамгийн их нөлөөлдгийг тодорхой жишээн дээр дүгнэлт хийж, ёс суртахуунлаг байр сууринаас хүмүүсийн сайн, муу үйлийг ялган таних, өөрийн зүгээс ёс суртахуунлаг шийдвэр гаргах аргад суралцах замаар ТХЗ-д хувь нэмрээ оруулах болно. Ямар арга илүү сонгогдож, ямар үйл ажиллагаанд суралцаж байгааг нэгтгэн хүснэгтэд үзүүлэв.

*СМЦ, СДҮА ба ТХЗ-ыг хүрэх сургалтын арга (хувиар)*

| Аргууд | хувь | Үйл ажиллагаа |
|---|---|---|
| Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | 6 буюу 35.2% | Ярилцах, зөвлөгөө өгөх, тайлбарлах, видео бичлэг үзэх дүгнэх, дүрд тоглох, шүүн хэлэлцэх, баримт цуглуулах, биеэр оролцох, бяцхан ном ханын сонин хийх, клубт элсэн, оролцох |
| Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | 2 буюу 11% | Баримт судлах, цуглуулах, тэмдэглэл хөтлөх, эргэцүүлэх, ажиглалт хийх, санал бичих, аялах уулзалтад оролцох, зураглал зохиох, шинжлэх дүгнэх |
| Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | 6 буюу 35.2% | Баримт цуглуулах, хэлэлцэх, ялгах, түүх судлах тэмдэглэл хөтлөх, тайлан бичих, дүрд тоглох, төлөвлөх, эссэ бичих, унших, уламжлалаас суралцаж хэвшүүлэх |
| Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/ өнгөрснийг нэхэн санах) | 3 буюу 17.6% | Тооцоолох, хэрэглэх, суралцах, харьцуулах, сурталчилгаа бэлдэх, мэдээлэл бэлтгэх, цомог бүтээх, төлөвлөх, төсөөлөх, зурагт тэмдэглэх, зохион бичлэг бичих |

Тогтвортой байдлын цогц чадамжийг хөгжүүлэх байдлыг авч үзэхэд :

- Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж: 2
- Урьдчилан тооцоолох цогц чадамж: 2
- Хэм хэмжээний цогц чадамж: 1
- Стратегийн цогц чадамж: 3
- Хамтран ажиллах цогц чадамж: 5
- Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж 3
- Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж: 1
- Асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамж: 2

Үүнээс дүгнэвэл, стратегийн болон хамтран ажиллах, шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж дийлэнх хувийг эзэлж байгаа тул эдгээр чадварыг Бага боловсролын иргэний боловсролын цагаар хөгжүүлэх боломжтой гэж үзлээ.

Бага ангийн сурагчдын хувьд ТХЗ-ын агуулга түүний уялдаа холбоо учир шалтгаан, нэр томьёо ухагдахууны утгыг ойлгох нь чухал юм. Энэ үндсэн дээр эргэцүүлэн бодох, анги хамт олны дунд зохион байгуулсан болон нийтийг хамарсан олон нийтийн ажилд ёс суртахуунлаг байр сууринаас идэвхтэй оролцохыг эрмэлзэх, зарим үйл ажиллагааны талаар үзэл бодлоо илэрхийлэх, өөрийн санаачилгаар оролцдог байх зарим чадварыг эзэмших явдал юм.

*Хүснэгт 4.11.* ***Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Иргэний боловсрол)***

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | | | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 15 | 11 | 12 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ….) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ….) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/өнгөрснийг нөхөн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар / суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| 1 | 2 | 3 | | | 4 | 5 | 6 | 7 | | | | 8 | 9 | 10 |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.2. Өдөр тутмын амьдралдаа ёс суртахуунлаг байр сууринаас хандах | ☐ | ☐ | | ТХ301.НСХ3. | ТХ301.Сэ08 | Ёс суртахуунлаг байх нь ТХ-д хэрхэн нөлөөлдөг болохыг авч үзэх, Тухайлбал, ядуурлаас шалтгаалан хоол хүнсний дутагдалд орж, хүчирхийлэлд өртөж байгаа болон эмзэг нөхцөлд дэх хүмүүсийн сэтгэл санааг ойлгож эв нэгдэлтэй байгаагаа илэрхийлэх, тэдэнд урмын үг хэлэх, эвтэй байх зэргээр ёс суртахуунлаг байр сууринаас ханддаг болоход суралцах | ☐ | ☐ | ☐ | | Ядуурлын улмаас хоол тэжээлийн дутагдалд орсноос хүний сэтгэл санаанд ямар өөрчлөлт үзүүлж, сэргээр нөлөөлдгийг ярилцах, Эдгээр хүмүүсийн, сэтгэл санааны байдлыг зэрэгээр дэмжих талаар бие биедээ зөвлөгөө өгөх, ном бэлэглэх талаар хүмүүст тайлбарлах | 5,6 | 2- Ядуурлын улмаас хоол тэжээлийн дутагдалд орох, хүчирхийлэлд өртөж сэтгэл санааны гутралд орж байгаа үе тэнгийн хүүхдүүдэд эрдэм ном сурахад дэмжлэг үзүүлэх ном бэлэглэх аян өрнүүлж, ирээдүйд болох олон янзын үйл явдлыг ойлгох хамтран ажиллах чадамжаа хөгжүүлнэ. |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.5. Өдөр тутмын амьдралдаа ёс суртахуунлаг шийдвэр гаргах | ☐ | | | ТХ302.ТМ3. | ТХ302.Сэ03. | Уур амьсгалын өөрчлөлт, хөрсний чанарын доройтол нь хүмүүст нүүрлээд байгаа өлсгөлөн болон хүнс тэжээлийн дутагдлыг бий болгодог үндсэн шалтгаан болж байгааг ухааран ойлгож, өөрсдийн хэрэглэдэг өдөр тутмын хоол хүнсний зөв сонгохдоо ёс суртахуунлаг шийдвэр гаргаж чаддаг болох | ☐ | ☐ | ☐ | ☐ | Өлсгөлөнд нэрвэгдэж буй орнуудыг судлах, хөрсний бүтэц,чанар уур амьсгалд нөлөөлдөг, хүнс тэжээлийн хомсдол, өлсгөлөнг гэтлэх аргын талаар баримт мэдээлэл цуглуулах, уламжлалт хоол хүнсийг хэрхэн бэлтгэж, ашиглах тухай бяцхан ном бүтээх | 4 | 4- Орон нутгийн түвшинд хүнсний брэнд бүтээгдэхүүнийг хэрэглэж, шинэлэг үйл санаачилга түгээн дэлгэрүүлсэн сурталчлахад анги хамт олноороо оролцож, ёс суртахуунлаг шийдвэр гаргах ТХ-ийн стратегийн чадвараа төлөвшүүлнэ. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.Ёс суртахуунлаг дадал, хэвшил | 15, 4.3. Ёс суртахуунлаг дадал хэвшлээ өдөр тутмын амьдралдаа хэрэглэх | □ | □ | □ | ТХ303.ЗҮ1 | ТХ303.Сэ03. | Өдөр тутмын амьдралдаа эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг дэмжих аргууд: Тухайлбал, вакцин хийлгэх, эрүүл хүнс хэрэглэх, биеийн тамирын дасгал хийх, эрүүл мэндийн зөвлөгөө авч байх зэргийг хэрэгжүүлснээр, суралцагч эрүүл амьдралын зөв зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлж, эрүүл мэндийг дэмжсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд оролцдог байх | □ | □ | □ | □ | Эрүүл мэндийг дэмжих аргуудаас суралцаж, өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлснээр биеийн тамир спортын арга хэмжээнд тогтмол оролцох, эрүүл амьдралын зохистой хоол өөртөө бэлтгэж, хэрхэн ашиглаж байгаа туршлагаа зөвлөгөө болгон бичиж найз нөхдөдөө түгээх, ТХБ-ын гарын авлагыг ашиглах | 2 | Эрүүл мэндийг дэмжих биеийн тамир спортын тэмцээн уралдаанд тогтмол оролцож, эрүүл амьдралын зохистой хоол өөртөө бэлтгэх, бусдад тайлбарлан, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх аргыг хэрэгжүүлснээр ТХ-ийн урьдчилан тооцоолох чадамжаа хэвшүүлнэ. |
| 1. Ёс суртахуунлаг зүрх сэтгэл | 15, 1.2. Ёс суртахуунлаг үнэт зүйлийг эрхэмлэхийн чухалыг мэдрэх | □ | □ | □ | ТХ304.ТМ2. | ТХ304.Сэ01. | Сурч боловсрох нь хүний үндсэн эрх бөгөөд бусад эрхээ эдлэх бүрэн баталгаа болж байгаар ойлгох, амжилтад хүрсэн эрдэмтдийн бодит түүхийг цуглуулж ярилцах, боловсрол нь дэлхий нийтийн өмч болохын жишээ болсон тэмдэглэлт үйл явдлын үйл ажиллагаанд оролцох замаар боловсрол нь үнэт зүйл болохыг ухаарч ойлгох | □ | □ | □ | □ | Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа нь сурч боловсрох ёс суртахуунлаг үнэт зүйл төлөвшүүлдэг анги болохыг ойлгосноор анги бүлгийн хэмжээнд "Дэлхийн болон багш нарын өдөр"-ийг тэмдэглэх, чанартай боловсрол өгч байгаа багш нартаа чин сэтгэлийн талархал хүргэх аян, сайн сурдаг сурагчдын арга туршлагаас хуваалцах үйл ажиллагааг зохион байгуулах | 5 | 5-Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа нь боловсролын үнэт зүйл төлөвшүүлдэг талаар ярилцдаг, сайн боловсрол олгож буй багш нартаа чин сэтгэлийн талархлаа хүргэх, сайн сурч байгаа сурагчдын арга туршлагаас хуваалцсанаар ТХ-ийн хамтран суралцах чадвараа хөгжүүлэх болно. |
| 3. Ёс суртахуунлаг үйлдэл | 15, 3.2. Амьдралын янз бүрийн нөхцөлд ёс суртахуунлаг үйлдэл хийх | □ | □ | □ | ТХ305.НСХ4. | ТХ305.Сэ05. | Анги болон сургуулийн түвшинд\ жендэрийн\ эрх үүрэг, ялгаварлан гадуурхал байгаа эсэхийг ажиглаж, эдгээр хүмүүст сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх итгэлийн аянг дэмжих, бага боловсролын түвшинд тухайн сургуулийн хэмжээнд жендэрийн тэгш боломжийг хэрхэн хангаж байгаар ажиглаж, ярилцах, суралцагч өөрийн жендэрийн онцлог, үүргийнхээ талаар эргэцүүлж, хэрэгцээгээ тодорхойлох ёс суртахуунлаг үйлдэл хийхэд суралцах | □ | □ | □ | □ | Амьдралын янз бүрийн нөхцөлд жендэрийн ялгаварлан гадуурхал байгаа үйл явдлыг харуулсан бичлэг, сургамжит өгүүлэл, бодит жишээн дээр ярилцах, тэднийг дэмжих ажил өрнүүлж байдаг бусад орны туршлагаас суралцах, өөрсдийн сургуулийн хэмжээнд жендэрийн тэгш боломжийг хэрхэн хангасан талаар ажиглалт хийж хэлэлцэх, өөрийн жендэрийн онцлог, үүргийнхээ талаар эргэцүүлж, өөртөө юу хэрэгжүүлэхийг хүсэж буйгаа илэрхийлсэн саналаа бичих, тухайн ангийн нийгмийн ухааны сурах бичиг удирдамжаас ашиглах | 7 | Өөрийн сургууль, ангийн хэмжээнд жендэрийн тэгш боломжийг хэрхэн хангасан талаарх ажиглалт судалгаагаа хэлэлцэх, өөрийн жендэрийн онцлог, үүргийнхээ талаар эргэцүүлэл,санаа бодлоо илэрхийлсэн эссээгээ ОУ эмэгтэйчүүдийн өдрөөр танилцуулах замаар ТХ-ийн өөрийгөө таньж мэдэх чадвараа хөгжүүлнэ. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.Ёс суртахуунлаг дадал, хэвшил | 15, 4.2. Тодорхой хугацааны туршид хийсэн ёс суртахууны дадал хэвшилтэй болох | ☐ | ☐ | ☐ | ТХ306.НСХ3. | ТХ306.Сэ06. | Хүмүүс усыг хайр гамгүй хэрэглэснээр бидний амьдарч буй дэлхийд усны хомсдол үүсэж байгаа жишээг цуглуулан ярилцах,амьдралын эх сурвалж болох усыг хэрхэн зохистой хэрэглээгээ болгож байгаа дэлхийн орнуудын туршлагаас судлах суралцагч нь усны өөрийн хэрэглээг хянаж, хариуцлагаа ухаарснаар тодорхой хугацааны туршид усыг ариг гамтай хэрэглэх ёс суртахууны дадал хэвшилтэй болох | ☐ | ☐ | ☐ | ☐ | Өөрийн орчин сургууль, гэртээ усыг хэрхэн зөв ашиглаж байгаад дүгнэлт хийж, өөрсдийн усны ашиглалтын тооцоолол хийж, дүгнэж ярилцах, усыг хэрхэн зохистой хэрэглээ болгож байгаа бусад орны сайн туршлагаас суралцах, усыг хайрлаж, гамтай ашиглаж ирсэн ардын зан үйлтэй харьцуулан үзэж зурагт хуудас бэлтгэх, бусдад сурталчлах | 8 | Өөрийнхөө сургууль гэртээ усыг хэрхэн зөв ашиглаж байгаад тооцоолол хийж, өөрсдийн усны ариг гамтай ашиглаж буйгаа ярилцаж, уламжлалт заншил, бусдын сайн туршлагаас суралцаж, зурагт хуудас бэлтгэх, сурталчлах замаар ТХ-ийн асуудал шийдвэрлэх нэгдсэн чадвараа хөгжүүлнэ. |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.3. Өдөр тутмын амьдралдаа ёс суртахуунлаг байр суурийнаас хандах | ☐ | ☐ | ☐ | ТХ307.НСХ4 | ТХ307.Сэ03. | Суралцагчийн хувьд өөрийн суурь хэрэгцээгээ хангахад эрчим хүч хэрхэн зарцуулдаг талаар эргэцүүлэн бодож хэлэлцэх, эрчим хүчний хэрэглээнийхээ хэлбэрүүдийг эрэмбэлэн ялгадаг,өдөр тутмын амьдралдаа эрчим хүчний зөв хэрэглээгээ тооцдог, өөрийн оруулах хувь нэмрээ ухааран ёс суртахуунлаг байр суурийнаас хандахад суралцах | ☐ | ☐ | ☐ | ☐ | Суурь хэрэгцээгээ хангах эрчим хүчний хэрэглээгээ ач холбогдлоор нь эрэмбэлэх, хэрхэн зарцуулдаг талаар тухайлбал, хоол хийх, техник хэрэгсэл ашиглах г.м тооцоо хийж, өөрийн орон нутгийн эрчим хүчний үйлдвэрлэлийн эх сурвалжуудыг судлан ярилцаж, хоргүй ашигтай ирээдүйн эрчим хүчний эх үүсвэрүүдийн талаар мэдээлэл бэлтгэх эргэцүүлэл бичих | 2 | 2-Эрчим хүчний хэт, тансаг хэрэглээ ямар үр дагаварт хүргэх талаар ирээдүйгээ төсөөлөн ярилцаж, байгаль орчинд сөрөг нөлөөгүй сэргээгдэх эрчим хүч ашиглах, ёс суртахуунлаг хэрэглээний тухай эргэцүүлэл эссэ бичиж, ТХ-ийн урьдчилан тооцоолох чадвараа төлөвшүүлнэ. |
| 3. Ёс суртахуунлаг үйлдэл | 15, 3.4. Ёс суртахууны чадвараас шалтгаалан зохистой үйлдэл хийх | ☐ | ☐ | ☐ | ТХ308.НСХ4. | ТХ308.Сэ02. | Өөрийн амьдарч байгаа нийгэмд ашиг тусаа өгч байгаа бизнесийн талаар жишээн дээр тайлбарлан ёс суртахуунлагаар өөрсдийн ирээдүйн мэргэжлээ ярилцдаг, орон нутгийнхаа бизнесийн төрлийн онцлогийг судалж, өрхийн үйлдвэрлэлээ хөгжүүлэх талаар зохистой үйлдэл хийж болохыг ухааран ойлгох | ☐ | | ☐ | ☐ | Өөрийн амьдарч буй нутагт ашиг тусаа өгч байгаа бизнесийн талаар танилцуулга цуглуулж хэлэлцэх, өөрийнхөө ирээдүйн мэргэжлээ сонгоход ач тустай сургамжит өгүүллээс уншиж тэмдэглэл хөтлөх, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж байгаа бодит хүмүүсийн түүхээс судлах, тэдний бизнесийн амжилтын талаар сурталчилгаа, товч тайлан бичих Тухайн ангийн НУ сурах бичгээс ашиглах | 6 | Өөрийн амьдарч байгаа нутгийн бизнесийн салбарууд тэдний орон нутгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг сурталчлах танилцуулга бэлдэх бусдад мэдээлэл өгч өөрийн байр сууриа илэрхийлэх замаар ТХ-ийн шүүмжлэлт сэтгэлгээний чадвараа хөгжүүлнэ. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.2. Өдөр тутмын амьдралдаа ёс суртахуунлаг хандах | □ | □ | □ | ТХ309.НСХ5. | ТХ309.Сэ09 | Нөөц баялгийг их хэмжээгээр олборлосноос, үүдэлтэй учирч буй байгалийн гамшиг дэд бүтцийн хөгжлийн тогтвортой байдалд нөлөөлж байгаа талаар тодорхой жишээ авч үзэл бодлоо ярилцах, өдөр тутмын амьдралын хэрэгцээ болсон мэдээлэл харилцааны технологи, дэд бүтэц, нийтийн тээврийн хэрэглээндээ хэрхэн ёс суртахуунлаг хандах талаар ойлголттой болох | □ | □ | □ | □ | Дэд бүтэц хөгжөөгүй үед хүмүүс хэрхэн амьдарч байсныг эх сурвалжаас ашиглан тухайлбал, өртөө сэдвээр г.м. дүрийн тоглолтоор үзүүлж хэлэлцэх, орон нутгийн байгалийн өвөрмөц нөхцөлд зам тээвэр, эрчим хүч, холбоо, дамжуулах хоолой зэрэг дэд бүтцийн хөгжил ямар байгаар эргэцүүлэн бодож, эдгээрээс аль салбар нь өөрийн нутагт чухал болохыг хэлэлцэх, дэд бүтцийг сэргээн босгох төлөвлөгөө боловсруулж, ирээдүйгээ төсөөлөн ярилцах | 1 | Дэд бүтэц нь зам тээвэр, эрчим хүч, холбоо, дамжуулах хоолойн зэрэг нь хоорондоо уялдаатай хөгжиж байдгийг мэдэж, өөрсдийн зохиосон дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх талаар төсөөлөн ярилцаж, аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэх, тодорхойгүй нөхцөлийг авч үзэх замаар ТХ-ийн тогтолцоот сэтгэлгээний чадамжаа төлөвшүүлнэ. |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.4. Ёс суртахуунлаг байр сууринаас сайн мууг ялгах, таних | □ | □ | □ | ТХ310.ТМ5. | ТХ310.Сэ03. | Тэгш бус байдал яагаад үүсдэг тухай сургамжит эх сурвалжаас судлан шалтгааныг тодруулах, хүний эрх тэгш байдлыг хангахад газар, өмч, байгалийн баялгийг тэгшээр эзэмших эрх эдлэхийн утга учрыг ойлгох, эх сурвалж өгүүллээс тэгш байдлыг тогтоож ирсэн уламжлалт зан заншил, ёс зүйг мэдэж, ялгаварлан гадуурхлыг үүсгэдэг хүний зан араншингийн сөрөг үр дагаврыг ёс суртахуунлаг байр сууринаас дүгнэдэг чаддаг болох | □ | □ | □ | □ | Хүмүүсийн газар, өмч болон байгалийн баялгийг тэгш эзэмших эрх нь ялгаатай байдгаас тэгш бус байдал үүссэн тухай түүхийн эх сурвалж, бодит түүх, кино бичлэгээс үзэж, сургамжит эхээс уншиж судлах, тэмдэглэл хөтлөх, гэр бүл, анги дотор тэгш ба тэгш бус байдлын талаар эргэцүүлэн бодож, тэгш байдлыг хэрхэн тогтоох бодлоо цэгцлэн эссэ бичлэгээр илэрхийлэн ярилцах, ИБ сурах бичиг, удирдамж ашиглах | 6 | 6-Тэгш байдлаа эдлэхийн ач холбогдлын талаар сургамжит өгүүлэл болон киноны дүрийн онцлогийг шинжилж, уламжлалт зан заншил бодит түүхээс хэлэлцэх, өөрийн ойлголтоо эргэцүүлэн бодох, ёс суртахуунлагаар асуудлаа шийдвэрлэх саналаа эссэ бичлэгээр илэрхийлэн бичиж, ярилцах замаар ТХ-ийн шүүмжлэлт сэтгэлгээний чадвараа хөгжүүлнэ. |
| 1. Ёс суртахуунлаг зүрх сэтгэл | 15, 1.2. Ёс суртахуунлаг үнэт зүйлийг эрхэмлэх мэдрэмжтэй болох | □ | □ | □ | ТХ311.НСХ3. | ТХ311.Сэ07. | Хот суурин газар хүмүүс хэт их төвлөрөн суурьшсанаас амьдралын хэв маяг өөрчлөгдөхийн зэрэгцээ хог хаягдал, агаарын бохирдол зэрэг сөрөг үр дагавар үүсэж байгааг үзүүлсэн кино бичлэг үзэж, түүний хор хөнөөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар мэдэх, өөрсдийн нутгийнхаа өөрчлөгдөж ирсэн байдлыг бодит эх сурвалж ашиглан судлах, хүмүүсийн бүтээсэн соёл, зан заншлаа ухааран ойлгож, ёс суртахуунлаг үнэт зүйлийг эрхэмлэх | □ | □ | □ | □ | Хот суурин газар хүмүүс хэт их төвлөрөн суурьшсанаас амьдрах хэв маяг өөрчлөгдсөнийг ажиглах аялал хийж, нутгийн ахмад хүмүүстэй зочинтой ярилцлага хийх, хог хаягдал, агаарын бохирдол зэргийг үүсэхээс сэргийлж ирсэн ардын зан үйлээс судлах, эргэцүүлэн бодох, анги, багаараа уламжлалт суртахуунлаг үнэт зүйлийг эрхэмлэн сургаал, зан үйлээс | 5 | Орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд зохицсон, хот суурин хөгжиж байгаа түүхтэй танилцах, хог хаягдлын дахин боловсруулдаг, ногоон бүс байгуулах зэрэг сайн үйл ажиллагаанд ёс суртахуунлаг ардын уламжлалт үнэт зүйлээ эрхэмлэн, анги хамт олноороо мод, зүлэг тарьж оролцох |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | суралцах, орон нутгийн төвлөрөл суурьшлын зураглал хийж, хэлэлцэх, тухайн ангийн сурах бичгээс ашиглах | | зэрэг хамтын хүчээр, оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх чадвараа хөгжүүлнэ. |
| 4.Ёс суртахуунлаг дадал, хэвшил | 15, 4.1. Ёс суртахуунлаг дадал хэвшилтэй болох | □ | □ | □ | ТХ312.НСХ3. | ТХ312.Сэ05. | Сурагчид өөрсдийн хоол, хүнсний хэт их хэрэглээгүй, хог хаягдлаа ангилан өөрийн хэрэгцээ болон хүслийг ялгаж, хувийн хэрэглээний зан үйлийнхээ талаар эргэцүүлэн бодох, орон нутгийн байгалийн байдлаа ирээдүйд унаган төрхөөр нь хэрхэн үлдээх арга замын талаар сургамжит өгүүллэгээс уншиж, судлах, ёс суртахуунлагаар санал бодлоо солилцох чадвартай болох | □ | □ | □ | □ | Өөрийн хувийн хэрэглээний хэвшлийн сайн муу үйлээ ёс суртахуунлаг байдлаар хэлэлцэж, сурагч нь хоол хүнсний хэт их хэрэглэхгүй, хог хаягдлаа зориулалтын саванд ялгаж хийх дадал зуршлыг ангидаа хэвшүүлэх, байгальд ээлтэй нутгийн брэнд бүтээгдэхүүнээ сонгож хэрэглэдэг байхыг уриалсан дүрийн тоглолт хийж, хоггүй байдлыг эрхэмлэж ирсэн ардын зан үйлээс суралцах, хэрэгжүүлэх талаар тухайн ангийн ИБ сурах бичгээс ашиглах | 5 | 5-Өөрийн хувийн хэрэглээний хэвшлийн сайн муу үйлдээ ёс суртахуунлаг байдлаар хандаж , үйлдвэрлэгч хэрэглэгч, сурталчлагч, хог хаягдлын менежер зэрэг дүрийн тоглолт хийх замаар бусдын хэрэгцээ шаардлагыг ойлгодог, харилцан хамааралтай асуудлыг хамтын хүчээр шийдвэрлэх замаар ТХ-ийн хамтран ажиллах чадварыг хөгжүүлнэ. |
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 2.4. Ёс суртахуунлаг байр сууринаас сайн мууг ялгах, таних | □ | □ | □ | ТХ313.НСХ1. | ТХ313.Сэ03 | Сурагчид ган гачиг, зуд, үер зэрэг цаг агаарын онцгой үзэгдлийн тухай өөрийн орон нутгийн жишээнээс ухааран ойлгож, эдгээр нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүд үзүүлсэн кэйс цуглуулах,уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин эдийн засаг, ёс зүйд нөлөөлөх хүний сайн муу үйл хийж байгааг ойлгох, ёс суртахуунлаг байр сууринаас үзэл бодлоо илэрхийлэхэд суралцах | □ | □ | □ | □ | Уур амьсгалын өөрчлөлт нь хүний ёс суртахуунгүй үйл ажиллагаанаас хамгийн их шалтгаалдаг болохыг баримтаар тайлбарлаж, ёс суртахуунлаг байр сууринаас сайн мууг ялган таних дүрд тоглох, уур амьсгалд ээлтэй уламжлалт зан заншил, сайн ажил хийж байгаа өөрийн болон бусад орны баримт жишээг шүүн хэлэлцэх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад өөрийн хувь нэмрийн талаар зохион бичлэг бичиж, ангийн түвшинд ярилцах, эдгээр асуудлаар холбогдох ИБ сурах бичиг ном ашиглах | 4 | 4-Уур амьсгалын өөрчлөлт нь хүний буруутай үйл ажиллагаанаас их шалтгаалдаг үзэгдэл болохыг ухааран ойлгож, баримт жишээг үндэслэн асуудлыг шийдэхийн тулд дүрд тоглож, орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд ээлтэй шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо хэлэлцэх, дэмжих замаар ТХ-ийн Стратегийн чадвараа хөгжүүлнэ. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. Ёс суртахуунлаг шийдвэр | 15, 3.4. Ёс суртахууны чадвараас шалтгаалан зохистой үйлдэл хийх | ☐ | ☐ | ☐ | ТХ314.ТМ3. | ТХ314.Сэ06. | Амьдрал далайд анх үүссэн бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд далайн чухал үүрэгтэйг харуулсан зураг,тохиолдол жишээг цуглуулан тайлбарлах, далайн усны түвшин нэмэгдсэнээс үүсэх болзошгүй аюулууд тухайлбал, амьдрах газраа алдах, ой устах зэргээр цаг уур өөрчлөгддөг болохыг мэдэх, хүмүүс далайн гаралтай ямар бүтээгдэхүүн ашиглаж байдаг, түүний ач тусын талаар ойлгох, ёс суртахуунлагаар ярилцахад суралцах | ☐ | ☐ | ☐ | ☐ | Далайн усны түвшний нэмэгдэж байгаагаас үүдэлтэй болзошгүй гамшиг бидний амьдарч буй нутагт шууд нөлөөлөх талаар эргэцүүлэн бодож, баримт жишээн дээр хэлэлцэх, далайн гаралтай бүтээгдэхүүний ач тус, түүнийг зохистой хэрэглэх талаар мэдээлэл цуглуулж, зургийн цомог бүрдүүлэх, ирээдүйд хүмүүс далайг ашиглах талаар нэмэлт мэдээлэл ашиглан тайлбарлаж ярилцах, тухайн ангийн БУ сурах бичиг, удирдамжаас ашиглах | 1 | 1-Орон нутгийн байгалийн нөхцөлд далайн нөлөөллийн харилцан хамаарлыг баримт жишээн дээр задлан шинжилж, далайн шууд хамааралгүй ч тодорхой бус байдлаа төсөөлөн бодох, далайн гаралтай бүтээгдэхүүн зохистой ашиглахад суралцах замаар ТХ-ийн тодорхойгүй байдлыг задлан шинжлэх,тогтолцоот сэтгэлгээний чадвараа хөгжүүлнэ. |
| 3. Ёс суртахуунлаг үйлдэл | 15, 3.3. Амьдралын янз бүрийн нөхцөлд зохистой үйлдэл хийх | ☐ | ☐ | ☐ | ТХ315.ЗҮ4. | ТХ315.Сэ06. | Дэлхийд хүн үүссэн цагаас газар болон хөрсийг боловсруулж, ашиглаж ирсэн түүх, хөрс бүрэлдэн үүсэх хугацааны талаар судлах, бүтэц, найрлага нь аж ахуйүйлдвэрлэлд хэрхэн ашигладаг, уул уурхайн ашиглалтаас хөрс эвдэрч түүнээс хамааралтай амьтан ургамал устахад шууд нөлөөлж байгааг жишээнээс ойлгох, газар боловсруулж, ашиглаж байгааг сургамжит эхээс уншиж, мэдэх газар хөрсийг зөв зохистой ашиглах, хамгаалах үйлдэл хийхэд суралцах | ☐ | ☐ | ☐ | ☐ | Хүмүүсийн хоол хүнсээ бэлтгэхэд хөрс нь чухал үүрэгтэй байгааг сургамжит түүхээс, өөрийн нутгийн жишээн ярилцаж, газрын зураг тэмдэглэх, зохисгүй хэрэглээний улмаас үүссэн хөрсний эвдрэлийг зогсоохоод ямар ургамал тариалах шаардлагатай талаар мэргэжлийн хүмүүсийн зөвлөгөө авах, мод цэцэг тарьж зүй зохистой үйлдэл ангиараа хийх , газар шороог дээдэлж ирсэн ардын уламжлалт арга ухаанаас суралцаж, бяцхан ном хийж, нөхдөдөө тайлбарлах БУ тухайн сурах бичигтэй уялдуулан ашиглах | 5 | 5-Хүмүүсийн зохисгүй хэрэглээ буруутай үйлдлээс үүссэн хөрсний эвдрэлийг сэргээх, хөрс бордох, өвс ногоо, зүлэг, мод тарьж буй хүмүүсийн хөдөлмөрийг ойлгож, сургуулийн орчиндоо хөрс арчлах аргачлалд багаараа хамтран суралцаж, хамтын хүчээр асуудлаа шийдэх зохицуулан хэлэлцэх замаар ТХ-ын хамтран суралцах чадвараа хөгжүүлнэ. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Ёс суртахуунлаг зүрх сэтгэл | 15, 1.4. Ёс суртахуунлаг зүрх сэтгэлээр муу зүйлийг жигших мэдрэмжтэй болох | □ | □ | □ | ТХ316.НСХ3 | ТХ316.Сэ06. | Хүмүүсийн ёс суртахуунлаг бус үйлдлээс хүний тэгш байдал алдагдаж, янз бүрийн зөрчил үүсэж байгааг тодорхой бодит жишээн дээр ярилцах, тэдгээрээс үүсэлтэй дайн, зэвсэгт мөргөлдөөний улмаас дүрвэж буй иргэдийг зохицуулдаг, энх тайван байдлыг тогтоодог байгууллагуудыг мэдэх, өөрийн орчин тойрны шударга бус үйлд ёс суртахуунлаг зүрх сэтгэлээр мэдрэмжтэй хандаж, эдгээр хүмүүсийн сэтгэл санааг дэмжиж, эв нэгдэлтэй байгаагаа илэрхийлэх эрмэлзэлтэй болох | □ | □ | □ | □ | Өөрийн болон бусад улс оронд шударга бус байдлын баримт жишээг судалж, ардын үлгэр, сургамжит өгүүллэгээс ишлэл авч ярилцах, тэгш байдал нь алдагдсан хүмүүсийн сэтгэл санааг ойлгож, ёс суртахуунлаг зүрх сэтгэлээр хандах, түүнд туслах, үзэл санаагаа илэрхийлсэн зурагт хуудас, ханын сонин бэлтгэж сургууль дээрээ эв санааны нэгдлийн тэмдэглэлт өдрөөр сурталчлах, тухайн ангийн НУ сурах бичгээс ашиглах | 3 | 3- Хэн нэгний ашиг сонирхлын зөрчил, шударга бус үйлдлээс хохирч байгаа хүмүүсийн талаар бодит жишээг шинжлэх, эргэцүүлэн бодож, зурагт хуудас бэлтгэж, Дэлхийн шударга ёс, энх тайвны өдрөөр сурталчлах, замаар хэн нэгний үйл хөдлөлийн учир шалтгааныг ойлгон мэдрэх замаар ТХ-ийн хэм хэмжээний цогц чадамжаа хөгжүүлнэ. |
| 3. Ёс суртахуунлаг үйлдэл | 15, 4.2. Тодорхой хугацааны туршид хийсэн ёс суртахуунлаг дадал хэвшилтэй болох | □ | □ | □ | ТХ317.НСХ5. | ТХ317.Сэ02 | Хүний эрх, эрх чөлөөг тодорхой хугацааны туршид хийсэн ёс суртахуунлаг дадал хэвшлээрээ хангаж байдгийг бодит мэдээлэл цуглуулан хэлэлцэх, хүний эрхээс үүдсэн маргаантай асуудлыг шийдвэрлэдэг орон нутгийн байгууллагуудыг бусадтайгаа хамтран олж мэдэх, тодорхой байгууллага хувь хүнтэй уулзалт зохион байгуулахад оролцох эрмэлзэлтэй болох | □ | □ | □ | □ | Хүүхдийн эрхийн асуудлаар тохиолдол шинжилж, зөрчигдсөн асуудлаа хэрхэн шийдвэрлэдэг байгууллагуудыг сурвалжлан олж, зочинтой уулзалт, аялал зохион байгуулахад оролцох, сургууль дээрээ хүүхдийн эрхийг хамгаалах клуб, сурагчдын хамтын ажиллагааны байгууллагад элсэж үйл ажилд нь оролцож тодорхой хугацааны туршид ёс суртахуунлаг шинэ дадал хэвшилтэй болоход суралцах, НУ, ИБ сурах бичиг гарын авлага ашиглах | 8 | 8-Хүний болон хүүхдийн эрхийн тодорхой асуудлыг шийдвэрлэж байгаа байгууллага хувь хүмүүстэй уулзаж ярилцах, зөвлөгөө авах, эрхийн талаарх хамтран шийдвэрлэсэн талаар мэдээлэл бэлтгэн хуваалцах, эрх тэгш хэрэгцээгээ хангах замаар ТХ-ийн асуудал шийдвэрлэх нэгдсэн чадвараа хөгжүүлнэ. |

## 4.2. Б. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ: УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ МИНИЙ АМЬДРАЛД НӨЛӨӨЛДӨГ ҮҮ?

### Сэдэв сонгосон үндэслэл, багшид зориулсан тэмдэглэл

Бага боловсролын 5-р ангийн иргэний боловсролын цагийн “Ёс суртахуунлаг зан чанар” цөм агуулгын хүрээнд “Ёс суртахуунлаг шийдвэр гаргах нь” сэдэвтэй ТХ-ийн 13-р зорилгын ТХЗ13.НСХ1[20] зорилт, ТХЗ13.Сэ03[21] сэдвийг интеграцчилсан нэгж үйл ажиллагааны төлөвлөлт хийв. Уг интеграцыг хэрэгжүүлснээр сурагчид ган гачиг, зуд, үер зэрэг цаг агаарын онцгой үзэгдлийн тухай өөрийн орон нутгийн жишээн дээр тайлбарлах, эдгээр нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүд болохыг мэдэхийн тулд баримт цуглуулах, уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин эдийн засагт нөлөөлдөг, хүний сайн муу үйл тэдний ёс зүйтэй байдлыг илэрхийлж буйг ойлгохын тулд үзэл бодлоо илэрхийлж, эссэ бичих, дүрд тоглож, хэлэлцэх замаар ёс суртахуунлаг шийдвэр гаргадаг чадварыг төлөвшүүлэх боломжийг олгох юм.

Иргэний боловсролын цагийн үндсэн агуулга, арга зүйг алдагдуулахгүйгээр ёс суртахуунлаг зүрх сэтгэлээр шийдвэр гаргах сэдвийг тогтвортой хөгжлийн асуудлаар баяжуулан “Уур амьсгалын өөрчлөлт миний амьдралд нөлөөлдөг үү?” нэг нэгж буюу нийт 160 минут хичээлийн төлөвлөлтийн жишээг та бүхэнд санал болгож байна. Тус хичээлийг иргэний боловсролын үндсэн арга зүй болох, уламжлалт зан заншлыг судлах, ёс суртахууны эх дээр ажиллах аргаас гадна, тогтвортой хөгжлийн талаарх баримт жишээг үндэслэн асуудлыг шийдэхийн тулд дүрд тоглож, орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд ээлтэй шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо хэлэлцэх, дэмжих аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн болно.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй уялдах байдал (матриц 1-ээс)*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ ТХЗБ-ын сэдэв → | ТХЗ13.Сэ03. Ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдэл гэх мэт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүд. Тэдгээрийн айл өрх, орон нутаг, улс орон болон улс орнуудын хооронд үзүүлэх нийгэм, эдийн засгийн харилцан адилгүй нөлөөлөл. |
| ТХЗ13.НСХ1. Суралцагч экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг болох | 2. Ёс суртахуунлаг шийдвэр гаргах<br>5-р анги, 2.2. Өдөр тутмынхаа амьдралд ёс суртахуунлаг байр сууринаас сайн мууг ялган, шийдвэр гаргах чадвартай болно.<br>↑ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт |

20 ТХЗ13.НСХ1. Суралцагч экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг болох

21 ТХЗ13.Сэ03. Ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдэл гэх мэт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүд. Тэдгээрийн айл өрх, орон нутаг, улс орон болон улс орнуудын хооронд үзүүлэх нийгэм, эдийн засгийн харилцан адилгүй нөлөөлөл.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл (матриц 2-ын 4, 5, 6 дугаар баганыг харна уу)*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ТХ315.ТМ5 | ТХ315.Сэ02 | Сурагчид ган гачиг, зуд, үер зэрэг цаг агаарын онцгой үзэгдлийн тухай өөрийн орон нутгийн жишээнээс ухааран ойлгож, эдгээр нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүд болохыг үзүүлсэн кэйс цуглуулах, уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин эдийн засагт нөлөөлдөг тухай, хүний сайн, муу үйл хийж байгааг ойлгож, ёс суртахуунлаг байр сууринаас үзэл бодлоо илэрхийлж суралцахад хувь нэмэр оруулах нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох чухал тал болно. |

Суралцагч байгаль орчин, экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин зэрэг нь дэлхийн байгалийн нөхцөл, бусад улсууд болон өөрийн орон нутаг, нийгмийн байдал, эдийн засгийн хөгжил, хүмүүсийн ёс зүйд үзүүлэх нөлөөллийг олж цуглуулсан мэдээлэлдээ тулгуурлан тайлбарлаж чаддаг болоход тусална.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх ТХБ-ын арга зүйн сонголт, хувь нэмэр оруулах боломжтой ТБ-ын цогц чадамжийг тодорхойлсон үндэслэл (матриц 2-ын 8, 10 дугаар баганыг харна уу)*

| Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар | Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар |
|---|---|
| 8 | 10 |
| Уур амьсгалын өөрчлөлт нь хүний ёс суртахуунгүй үйл ажиллагаанаас хамгийн их шалтгаалдаг болохыг баримтаар тайлбарлаж, ёс суртахуунлаг байр сууринаас сайн мууг ялган таних, дүрд тоглох, уур амьсгалд ээлтэй уламжлалт зан заншил үйл, сайн ажил хийж байгаа өөрийн болон бусад орны баримт жишээг шүүн хэлэлцэх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад өөрийн хувь нэмрийн талаар зохион бичлэг бичиж, ангийн түвшинд ярилцах зэргээр бодит үйл ажиллагаанд оролцох, судалгаа шинжилгээ хийх аргуудыг хослуулан хэрэглэнэ. | Уур амьсгалын өөрчлөлт нь хүний буруутай үйл ажиллагаанаас их шалтгаалдаг үзэгдэл болохыг ухааран ойлгож, баримт жишээг үндэслэн асуудлыг шийдэхийн тулд дүрд тоглож, орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд ээлтэй шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо хэлэлцэх, дэмжих замаар ТХ-ийн Стратегийн цогц чадамжаа хөгжүүлнэ. |

## Уур амьсгалын өөрчлөлт - миний амьдралд

<u>Үйл ажиллагаа-1</u> Хугацаа 80 минут

<table>
<tr><th></th><th>Сурахуйн үйл ажиллагаа</th><th>Багшлахуйн үйл ажиллагаа</th><th>хэрэглэгдэхүүн</th></tr>
<tr><td></td><td>Асуулт асууж, хариулах<br>Уур амьсгал гэж юу вэ?<br>Яагаад уур амьсгал өөрчлөгдсөн гэж ярилцаад байна вэ?<br>Та нарт уур амьсгал яаж нөлөөлдөг вэ?</td><td>Сурагчдад оюуны довтолгоо хийж, тэдний хариултыг нэгтгэн дүгнэнэ. Урт удаан хугацаанд үргэлжилж байсан цаг уур, агаарын хэм, улирлын байдал нь өмнөх байдлаас өөрчлөгдөхийг уур амьсгалын өөрчлөлт гэж үздэг. Одоо дэлгэрүүлж ярилцъя.</td><td>Дүгнэлт үзүүлэн<br>Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаврыг харуулсан Видео бичлэг<br><br>Хүлэмжийн хий үүсэж буй дэлхийн агаар мандлын зурагт үзүүлэн</td></tr>
<tr><td>Сэдэлжүүлэх 15 минут</td><td>Өөрсдөд шууд мэдрэгдсэн УА өөрчлөлтийн тухай жишээг хэлнэ үү.<br>Та нар өөрийн мэдэж байгаа жишээгээ сэдвийн хүрээнд гаргаж тайлбарлаарай.<br>Агаарын хэм яагаад өөрчлөгдсөн бэ?...<br>Хот, орон нутгийн орчинд юу болов?....<br>Үйлдвэр ба ахуйн нөлөө..<br>Гэр орноос нөлөөлдөг үү?..</td><td>Жишээ нь: Өвөл цасгүй хүйтэн болсон, зун бороогүй хэт халуун байсан.<br>Агаарын хэм- хүлэмжийн хий үүссэнээс шалтгаална.<br>Харин хүлэмжийн хий нь үйлдвэр, автомашины утаа, тортгоос үйлчилгээний газрын эрчим хүчний хэт хэрэглээнээс үүдэлтэй. Зураг дээр ажиглая.<br>
</td><td></td></tr>
<tr><td>Шинэ мэдлэг олох 40 минут</td><td>Хүлэмжийн хий яагаад дэлхийн дулаарах шалтгаан болдог тухай Видео үзэж хэлэлцэх<br>Та нар дэлхийн дулаарал, хүлэмжийн хий үүсэхэд нөлөөлж буйг дараах бичлэгээс үзээд асуултад хариулна уу.<br>Дэлхий дулаарах нь ямар үр дагаварт хүргэж байна вэ?...<br>Та нар дэлхий дулаарч байгааг яаж мэдэж байна вэ?<br>Яг одоо бодоорой.</td><td>Дэлхийн агаар мандалд хүлэмжийн хий хуримтлагдсанаас дэлхийн агаарын дундаж хэм ихэсдэг. Үүнээс улбаалан, бидний амьдарч буй дэлхий газар нутагт өөрчлөлт гарч байна. Жишээ нь:<br>- Далайн усны түвшин нэмэгдэнэ.<br>- Ургамал амьтан устана.<br>- Хүмүүс эрүүл мэндээр хохирно.<br>- Байгалийн аюулт үзэгдэл ихэснэ.<br>- Ган болж усгүй болж байна.<br>- Уулын цас мөс хайлна.<br>- Бидний хоол хүнс багасаж үнэ нь нэмэгдэнэ.<br>- Эрүүл мэндэд нөлөөлнө.<br></td><td>График зураг үзүүлэх<br><br>Дэлхийн дулаарлаас үүдэлтэй хүнд нөлөөлж буй Видео бичлэг</td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td>Уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нөлөөлж байдаг нь хүмүүсийн үйл ажиллагаа байдаг. Энэ тухай юу мэдэж байгаагаа жишээгээр нотлон ярилцаарай.<br>Миний амьдралд...<br>Монгол улсад..<br>ган гачиг, зуд, шороон шуурга, үер, түймэр<br>Бусад орнуудад...<br>Хар шуурга, үер, газар хөдлөлт,<br>Эдгээр байгалийн гамшигт үзэгдэл уур амьсгалын өөрчлөлт мөн үү?<br>Үүнд хүний үйл ажиллагаа нөлөөлсөн үү? Хариулж бичээд ярилцаарай.<br>Монголчууд байгалиа хамгаалах арга ухаанаа хойч үедээ хэрхэн үлдээж байсан бэ? Ярилцана уу.</td>
<td>Монгол улсад ган гачиг, зуд, шороон шуурга, үер, түймэр зэрэг цаг агаарын онцгой үзэгдэл байнга гарах болсон. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүд бусад орнуудад мөн адил байдаг.<br><br>Уур амьсгалын өөрчлөлт нь хүний буруутай ёс суртахуунгүй үйл ажиллагаанаас хамгийн их шалтгаалдаг.<br>– Эдгээр зураг дээр үзүүлсэн байгалийн нөхцөл хаана үүсэж байна вэ?<br>– Ямар хор уршигтай вэ?<br><br>Монголчууд “байгалийн зүй тогтлыг танин ухаарч, байгалийг хайрлан хүндэлж, хориглон цээрлэснийг сахидаг аваас сайн үйлд, харин гажуудуулан тэрсэлдвээс муу үйлд өртөнө” гэдгийг хувь хүнд, итгүүлэн үнэмшүүлэх арга ухааныг аав, ээж нь үр хүүхдэдээ, ах эгч нь дүү нартаа, ахмад буурлууд нь залуу үедээ өвлүүлсээр ирсэн арга ухаан юм.<br>Эдгээр зүйл хийхийг яагаад хориглож байдаг вэ? Яагаад? Нөхөж бичээрэй.<br>1. Гол мөрөн, булгийн эхэнд хог хаяж болохгүй...<br>2. Мод тарьж байх...<br>3. Газар шороог ухаж сэндийлж болохгүй..<br>4. Жимсийг мөчиртэй нь түүхгүй...<br>5. Үнс, нурам асгаж болохгүй...</td>
<td>Зурагт үзүүлэн<br><br>Тохиолдол жишээ<br><br>Ажлын хуудас<br><br>ардын ёс заншлын толь бичгүүд</td>
</tr>
<tr>
<td>Дүгнэлт 15 минут</td>
<td>Хүмүүсийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг харуулсан зурагт хуудсыг 5 багаар тарааж, асуудлыг шийдвэрлэж, хүснэгтэд бичээд хэлэлцэнэ.<br>1. Ой мод огтолж байгаа<br>2. Уул уурхай, нүүрс олборлолт<br>3. Ой хээрийн түймэр<br>4. Үйлдвэрлэлийн хөгжил<br>5. Газар хагалж, тариалан эрхлэлт</td>
<td>Ёс суртахуунлаг байр суурин аас эдгээр үйлдлийн сайн муур ялган таньж хэлэлцээд, асуудлыг шийдвэрлэнэ.<br>Баг өөрсдийн сонгосон сэдвийн хүрээнд асуултад хариулт бэлтгэнэ.<br>1. Яагаад ой,модыг огтолж байна вэ?<br>2. Уул уурхайн, нүүрс олборлох нь ямар үр дагаварт хүргэж байна вэ?<br>3. Ой хээрийн түймэр үүсдэг шалтгааныг тайлбарлах<br>4. Үйлдвэр хэрхэн хөгжүүлбэл байгаа үр дүн юу вэ?<br>5. Газар тариалан яагаад эрхэлж байна вэ?<br>Ярилцаад, хүснэгт нөхөж бичнэ.<br><table><tr><td>Эерэг тал</td><td>Сөрөг тал</td><td>Бидний амьдралд нөлөөлөх нь</td></tr></table></td>
<td>Зурагт хуудас хүснэгт</td>
</tr>
</table>

<table>
<tr>
<td rowspan="5">Үнэлгээ 10 минут</td>
<td rowspan="5">ТХБ-ын зорилтын хэрхэн хэрэгжиж буй эсэх зураг дээр тайлбарлаж ярилцах<br>Холбогдох үзүүлэн зураг<br>– Монгол ардын уламжлалт зан заншлаас өөрсдийн мэдэх зан үйлээс баяжуулан ярилцах<br>– Дэлхийн дулааралтай тэмцэж буй сайн ажлууд<br>– Монгол ёс заншлын эх сурвалж, баримт жишээг уншиж ухааран ойлгосны дараа эхийн санааг гүйцээн бичнэ үү.<br>– Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй эсэхийг хэлэлцэнэ.</td>
<td>Дэлхийн дулаарлын эсрэг хүмүүсийн хийж байгаа үйл ажиллагааг зураг дээр ажиглаж ярилцах<br>Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдлийн нэрийг хүснэгтээс олоорой.</td>
<td>Фото зураг</td>
</tr>
<tr>
<td colspan="2">
<table>
<tr><td>а</td><td>х</td><td>и</td><td>с</td><td>р</td><td>ш</td><td>т</td><td>у</td><td>г</td><td>з</td><td>е</td><td>ү</td><td>д</td><td>н</td><td>ж</td><td>й</td><td>м</td><td>э</td><td>л</td><td>ц</td></tr>
<tr><td>1</td><td>20</td><td>7</td><td>12</td><td>17</td><td>23</td><td>13</td><td>6</td><td>18</td><td>14</td><td>3</td><td>4</td><td>11</td><td>29</td><td>16</td><td>8</td><td>10</td><td>9</td><td>33</td><td>5</td></tr>
</table>
</td>
</tr>
<tr>
<td>Үгийн утгыг олж бичээд, хэрхэн урьдчилан сэргийлж болох эсэх саналаа ( +,- ) тэмдэглэнэ. (олох үгс: түймэр, дулаарал, цас зуд, салхи, хүлэмжийн хий )</td>
<td></td>
</tr>
<tr>
<td colspan="2">
<table>
<tr><th>Байгалийн үзэгдэл</th><th>Тийм</th><th>үгүй</th></tr>
<tr><td>13 4 8 10 9 17</td><td></td><td></td></tr>
<tr><td>11 6 33 1 1 17 1 33</td><td></td><td></td></tr>
<tr><td>5 1 12 , 14 6 11</td><td></td><td></td></tr>
<tr><td>12 1 33 20 7</td><td></td><td></td></tr>
<tr><td>18 1 29</td><td></td><td></td></tr>
<tr><td>33 9 10 16 , 20 7 8</td><td></td><td></td></tr>
</table>
</td>
</tr>
<tr>
<td>Монголчуудын байгалиа дээдэлж ирсэн ёс заншил арга ухаанаас суралцаж, эхийн санааг хосоороо ажиллан гүйцээж бичнэ үү.<br>– Урсгал усанд юм угаахдаа заавал саванд хийж,<br>– Гол мөрөн, булаг шанд зэрэгт бузар зүйл, ...... цээрлэнэ.<br>– Ус авахдаа, ус авах сав суулга, .... цэвэрлэнэ.<br>– Гол горхи, булаг шандын эхний газрыг ...... цээрлэнэ.</td>
<td></td>
</tr>
</table>

## Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах боломжтой юу?

Үйл ажиллагаа-2 Хугацаа- 80 минут

| Үе шат | Сурахуйн үйл ажиллагаа | Багшлахуйн үйл ажиллагаа | Хэрэглэгдэхүүн |
|---|---|---|---|
| Сэдэлжүүлэлт 10 минут | Уур амьсгалд ээлтэй сайн үйл, ажил өрнүүлж байгаа хүмүүсийн ёс суртахуунлаг үйлдлийг шинжлэн судлах<br>Шийдвэрлэх асуудал:<br>1. Ямар асуудлыг хөндсөн байна вэ?<br>2. Хэрхэн шийдсэн, шинэ санаа юу байв?<br>3. Өөрийн орон нутагт байгаа ижил, төстэй ажил үйлийн жишээг дурдана уу?<br>4. Яагаад байгальд ээлтэй гэж үзэж байна вэ? | Цуглуулсан мэдээлэл болон тохиолдол шинжилж, асуудлыг шийдвэрлэнэ.<br>**Кэйс1.** Иллинойс мужийн Чикаго хотын Таркингтон дунд сургуулийн багш оюутнууд, сургуульдаа шинэ маягийн дээвэр хийж, түүн дээр хөрс дэвсэж, зүлэг тарьсан нь барилгыг өвөл дулаан, зун сэрүүн байлгах нөхцөлийг бүрдүүлж буй аж.<br>**Кэйс2.** Салхины хэмжүүрийн технологийн салбарт тэргүүлэгч " НРЖ Системс" компани нь Хайнсбург хотод байрлах төв барилгын өмнө хиймэл цөөрөм хийж, дээвэр дээр нарны зайг байрлуулж байгальд ээлтэй "ногоон" болгож чаджээ. | Эх сурвалж, тохиолдол,<br><br>Жишээг харуулсан Бичлэг<br>Дэлхийн болон монгол орны газрын зураг |
| | Эх сурвалжийг уншаад 5 багаар бэлтгэж асуултад хариулж хэрхэн шийдсэнээ эргэцүүлэн бодож, хэлэлцэнэ үү.<br>1. Яагаад сэргээгдэх эрчим хүчийг ашиглах хэрэгтэй вэ? | **Кэйс3.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Мод тарих үндэсний өдөр" зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор бүх нийтээр мод тарих өдрөөр үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, дүүрэг, хороод, аж ахуйн нэгж байгууллага, айл өрх, иргэд өргөнөөр оролцож, улсын хэмжээнд 14 удаа зохион байгуулснаар 10,1 сая мод, бут тарьжээ.<br>Орон нутгийн зохион байгуулж байгаа сайн үйл ажиллагаа, жишээг олж ярилцана. | |

<table>
<tr>
<td rowspan="2">Шинэ мэдлэг эзэмших 20 минут</td>
<td>2. Хаанаас гаргаж авч болох вэ?<br>3. Нийт гаргаж авч байгаа эрчим хүчийг диаграммаар үзүүлнэ үү.<br>4. Уур амьсгалын өөрчлөлтийг багасгахад хэрхэн нөлөө үзүүлэх вэ?<br>5. Танай орон нутагт эдгээрээс хэрэглэж байгаа жишээ байна уу.</td>
<td>Уур амьсгалын өөрчлөлт нь хүний үйл ажиллагаанаас их шалтгаалдаг үзэгдэл болохыг ухааран, мэдэрч ойлгохын тулд сэргээгдэх эрчим хүчийг хэрхэн зөв ашиглаж болохыг дараах жишээн дээр хэлэлцэнэ.<br><br>Сэргээгдэх эрчим хүч гэдэг нь байгаль дээр тасралтгүй нөхөн сэргээгдэж байдаг энерги бөгөөд үүнд нарны эрчим хүч, салхины эрчим хүч, усны эрчим хүч, биомассын эрчим хүч, далайн татралт, түрэлтийн эрчим хүч, газрын гүний дулааны эрчим багтдаг. Дэлхий дээр үйлдвэрлэсэн нийт эрчим хүчний 18%-ийг сэргээгдэх эрчим хүчнээс гарган авдаг. Үүний 13%-ийг уламжлалт түлш болох модноос, 3%-ийг уснаас ,1.3%-ийг нарны дулаанаар усыг халаан хэрэглэх, үлдэх 0.8% орчмыг нь газрын гүний дулаан, салхи, нар, далайн эрчим хүчийг ашиглаж байна. Дэлхийн дулаарал, газрын тосны үнийн өсөлт зэрэг нь сүүлийн үед сэргээгдэх эрчим хүчний талаар судалгаа хийх, үйлдвэрлэх, хэрэглэх үндсэн шалтгаан болж байна.</td>
<td>Сэргээгдэх эрчим хүч ишлэл авах<br><br>Баг тус бүрд хийх ажлын хуудас бэлтгэх</td>
</tr>
<tr>
<td>Аливаа зүйлийг дахин ашиглах нь байгаль дэлхийгээ хайрлах бас нэг арга гэдгийг ёс суртахуунлаг зүрх сэтгэлийн үүднээс хандаж хэлэлцэх<br><br>Хог хаягдлыг сургууль гэр бүл, байгууллагууд хэрхэн боловсруулж байгааг хамтран ярилцана.<br><br>Санал болгосон зургуудыг ажиглаад аль байгальд ээлтэй байгааг сонгож хүснэгтэд тэмдэглэнэ.</td>
<td>Хог хаягдлын дахин ашиглах боломжтой эсэхийг зураг дээр ажиглаж, хүснэгтэд тохируулан олох дасгал ажиллаж, ярилцах<br>
<table>
<tr><td><br>А.</td><td><br>Б.</td><td><br>В.</td></tr>
<tr><td><br>Г.</td><td><br>Д.</td><td><br>Е.</td></tr>
</table>
<table>
<tr><td>Байгальд удаан шингэж, задрах боломжгүй нь</td><td></td></tr>
<tr><td>Байгальд удаан шингэж, задрах боломжгүй нь</td><td></td></tr>
<tr><td>Дахин ашиглах боломжтой нь</td><td></td></tr>
</table></td>
<td>Дасгал ажлын хуудас, хүснэгтээр<br><br>Олон хувилбарт сонгож олсон зургууд</td>
</tr>
<tr>
<td>Дүгнэлт, бататгал 10 минут</td>
<td>Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бид юу хийж чадах вэ?<br><br>Эдгээр сэдвээс үндэслэн багаараа сонгож аваад, дүрийн тоглолт бэлтгэж болох юм.<br><br>- Эрчим хүч хэмнэж буй<br>- Ногоон байгаль<br>- Ган гачиг<br>- Эрүүл аж төрөх</td>
<td>Дүрд тоглон уур амьсгалын өөрчлөлттэй холбогдох асуудлын сайн муу үйлийг ёс суртахууны үүднээс ярилцах, тухайлбал,<br>- Байгальд ээлтэй бүтээгдэхүүн хэрэглэх<br>- Эрчим хүч хэмнэдэг гэрэл, чийдэн хэрэглэх<br>- Эрчим хүч бага зарцуулдаг цахилгаан хэрэгсэл ашиглах<br>- Усыг дахин ашиглах<br>- Хүнсээ зөв сонгон хэрэглэх<br>- Ашиглахгүй цахилгаанаа унтрааж байх г.м дүрд тоглож орон нутгийн уур амьсгалд ээлтэй үйл хэргийг хэлэлцэнэ.</td>
<td>Бичих, ярилцах асуултын загвар<br><br>Дүрд тоглох чиглэл</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | Ангийн түвшинд эхийн санааг дэлгэрүүлэн 5 багт хуваагдан урилга зохион бичиж, хэлэлцэх<br>Уриалга бичих санамж:<br>1. Хэнд хандсан бэ?<br>2. Ямар асуудал дэвшүүлсэн бэ?<br>3. Хэрхэн шийдэх вэ?<br>4. ТХБ-н аль зорилтыг хэрэгжүүлэх вэ?<br><br>Байгалийг энэрэн хүндэтгэх ёс заншлыг бүхэлд нь авч үзвэл байгалийг эрт дээр үеэс амьд биет гэдгийг танин мэдэж, ухааран ойлгож байсан. | **Уншиж ажиллах эхүүдийг уншаад утга санааг үргэлжлүүлэн уриалга бичээрэй.**<br><br>**Жишээ 1.** Тамхи татах нь гэрийн тэжээмэл амьтад болох муур, нохой зэрэгт хавдар үүсгэдэг байна. Тэд дам тамхидалтад өртөн, никотинд хорддог аж. Мөн татсан тамхины ишээ гол мөрөн, нуур далайн эргээр хаях нь далайн амьтад ч сөрөг нөлөө үзүүлдэг. Ердөө ганцхан ширхэг тамхины иш загасны бие бүтцийн 50%-ийг үхжүүлэх хүчтэй байдаг аж.<br><br>**Жишээ 2.** Дэлхийн нэг өдрийн хог хаягдлын 30 хувийг гялгар уут эзэлдэг байна. Гялгар уут задардаггүй хог бөгөөд байгаль дээр 100-400 жил оршиж таныг болон үр хүүхэд цаашлаад байгаль орчинд химийн хорт хий ялгаруулж хөрс, ус, агаарыг бохирдуулсаар байдаг байна. | Уриалгын хуудсыг багт тохируулан хувилах |
| | **сургууль дээрээ нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлнэ.**<br><br>Орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд ээлтэй шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо хэлэлцэх, дэмжих өөрийн оруулж чадах хувь нэмрээ бичгээр буюу зурган хэлбэрээр илэрхийлж, бусдад тайлбарлана. | Мөн хүнсний бүтээгдэхүүнтэй урвалд олон төрлийн органик уусгагч ялгаруулж, тэр нь эргээд хүнсэндээ шингэдэг.<br><br>**Жишээ 3.** Гялгар уутан савлагаатай хүнсний бүтээгдэхүүн гэдэсний өвчин, нян дамжих хөрс суурь болж өгдөг. Гялгар уутны 500-600 үйлдвэр байдаг бөгөөд сард дунджаар 800 мянгаас 120 сая ширхэг гялгар уут борлуулагдаж байгаа гэсэн тооцоо бий.<br><br>**Жишээ 4.** Монголчууд амьд байгалийн сэргэн төлжих, хавар зуны дэлгэр цагт өвс ногоо ургах үед газар шороо ухаж сэндийлчих, нойтон мод, бут сөөг, гол горхи, булаг шандын эхийн модыг огтлох, үр жимс, ургамлыг ихээр авч ашиглахыг хориглон цээрлэдэг. | |
| Үнэлгээ 10 минут | | Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг та нар юу хийж чадах вэ? Дараах үйл ажиллагаанд оруулах өөрийн хувь нэмрээ бичиж, уриалгаа зургаар хийж сурталчлаарай.<br>• Мод тарих- ямар төрлийн мод тарих вэ?............<br>• Ногоон эрчим хүчинд шилжих- юу гэж ойлгох вэ?...........<br>• Хөлдөөсөн биш шинэ хүнс хэрэглэх- яагаад?....<br>• Эх орны хөрсөнд ургуулсан хүнс ногоо хэрэглэх- учир нь?<br>• Дахин боловсруулсан цаас ашиглах- яагаад?...<br>• Дэлгүүрт орохдоо даавуун уут ашиглах- тайлбарлах нь.... | Монгол зан заншил, уламжлалын жишээ, сургаал<br><br>То вангийн сургаал |

## 4.3. АМЬДРАХ ЧАДВАРТ СУРАЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 4.3. А. БАГА БОЛОВСРОЛЫН АМЬДРАХ ЧАДВАРТ СУРАЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Сургалтыг дэмжих үйл ажиллагаа нь цөм хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилт, хичээл судлагдахуунаар эзэмших чадварын хөгжлийг дэмжинэ[22] гэж бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт томьёолсон бөгөөд сургалтыг дэмжих үйл ажиллагаа гэдгийн дор иргэний боловсрол, амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, хичээлээс гадуурх үйл ажиллагааг ойлгоно гэж тодорхойлсон байна. “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа” нь суралцагчид хичээл тус бүрээр эзэмшсэн мэдлэг, чадвараа асуудал дэвшүүлэн шийдвэрлэхэд хэрэглэх ба дараах сурах арга барил, чадвар эзэмших үйл ажиллагааг багшийн дэмжлэгтэйгээр зохион байгуулахыг зөвлөмжилсөн. Үүнд:

Суралцагч бодит үйл ажиллагаанд оролцох явцдаа эрэл хайгуул хийх, асуудал олж харах, эргэцүүлэн бодох, илүү сайнаар шийдвэрлэх арга барил эзэмшинэ.

Суралцагч эрэл хайгуулын явцад бүтээлчээр хамтран ажиллах, өөрийн амьдрах арга ухааныг эргэцүүлэн бодох, суралцах хүсэл эрмэлзэл, бие даан ажиллах, суралцах, нийгэм, амьдралын өөрчлөлтөд зохицон амьдрах чадварт суралцана. Эндээс харахад бодит үйл ажиллагаанд оролцонгоо асуудлыг олж харах, эргэцүүлэн бодох, шийдвэрлэх арга барилд суралцах, бүтээлчээр хамтран ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэсэн болох нь харагдаж байна.

Эндээс харахад бодит үгийн ажиллаагаанд оролцонгоо асуудлыг олж харах, эргэцүүлж бодох, шийдвэрлэх арга барилд суралцах, бүэлчээр хамтран ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэсэн болох нь харагдаж байна.

Харин ямар агуулгаар, агуулгаа хэрхэн сонгож, ямар үе шатаар, ямар арга зүйгээр зохион байгуулах вэ гэх мэтээр хичээл судлагдахуунаас ялгагдах ялгаа бий. Агуулгын сонголтыг орон нутаг, сургуулийн хэмжээнд сонирхсон, тулгамдсан, хэрэгцээтэй агуулгыг хүүхэд өөрөө сонгох боломжийг цөм хөтөлбөрт санал болгосон нь сургууль орон нутгийн бие даасан байдлыг дэмжих тогтвортой хөгжлийн зорилготой холбоотой агуулгыг сонгон судлах боломжийг олгосон давуу тал харагдаж байна.

#### Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал:

Бага боловсролын цөм хөтөлбөрт амьдрах чадварт суралцах цагаар эзэмших тусгай чадварууд болон хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан хэрэгцээтэй, тулгамдсан, сонирхсон агуулгаа сонгох уян хатан байх зарчмыг тусгасан ба хүүхдийн хэрэгцээ сонирхолд үндэслэн сонгох сэдэв, сургууль орон нутаг үндэсний онцлогт тохирсон сонгох сэдэв, нийтлэг сэдэв гэсэн 3 үндсэн агуулгын хүрээнд зарим үлгэрчилсэн сэдвүүдээс сонгож судлахыг санал болгосон байна. Бид үүнд үндэслэн 16 сэдэв, 5 чадварт харгалзах 18 зорилт (арга барил)-ыг тодорхойлж, түүнийг тогтвортой хөгжлийн 17 зорилгын суралцахуйн зорилтын танин мэдэхүйн, нийгэмшил-сэтгэл хөдлөлийн, зан үйлийн ай болон санал болгосон 10 сэдвийн хүрээнд хэрхэн холбогдож болохыг шинжилж үзэв. Шинжилгээний үр дүнгээс үзэхэд бидний тодорхойлсон 16 зорилт (арга барил) холбогдсон байгаа бөгөөд тэдгээрээс танин мэдэхүйн айд 7, нийгэмшил-сэтгэл хөдлөлийн айд-6 зорилт нь холбогдсон байна.

22 Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр, Уб, ху-22

*Бага боловсролын АЧСҮА ба ТХЗБ-ын холбогдсон байдал (тоогоор)*

| Зорилт | ТХ31 | ТХ32 | ТХ33 | ТХ34 | ТХ35 | ТХ36 | ТХ37 | ТХ311 | ТХ313 | ТХ315 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | НСХ | ТМ | ТМ/НСХ | НСХ | ТМ | ЗТ/ТМ | ЗТ/ТМ | НСХ | ТМ | ТМ/ЗТ | |
| | 2 | 3 | 1/2 | 1 | 1 | 1/1 | 1/1 | 1 | 1 | 1/1 | 16 |

*Бага боловсролын АЧСҮА нь ТХЗБ-ын суралцахуйн зорилтын айтай холбогдсон байдал (тоогоор)*

| ТМ | НСХ | ЗТ | Бүгд |
|---|---|---|---|
| 7 | 6 | 3 | 16 |

*АЧСҮА ба ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдвийн харгалзах байдал*

| | |
|---|---|
| ТХЗБ-ын суралцахуйн зорилт ↓ ТХЗБ-ын сэдэв → | ТХ313.Сэ03. Ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдэл гэх мэт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүд. Тэдгээрийн айл өрх, орон нутаг, улс орон болон улс орнуудын хоорондын үзүүлэх нийгэм, эдийн засгийн харилцан адилгүй нөлөөлөл. |
| ТХ313.ТМ3. Суралцагч дэлхий нийт, улс үндэстэн, орон нутаг, хувь хүний түвшин дэх хүний үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нөлөө үзүүлдгийг мэддэг болох | 45, 15.2.г. Байгаль орчныг бохирдуулж буй хүний буруутай үйл ажиллагаа түүнээс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн айл өрх, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг илрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг судлан хэрэгжүүлэх ↑ Цөм хөтөлбөрийн зорилт |

*АЧСҮА-г ТХЗБ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл*

| ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|
| 4 | 5 | 6 |
| ТХ313.ТМ3 | ТХ313.Сэ13 | Хүний үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нөлөө үзүүлдгийг ойлгон түүнээс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн айл өрх, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг ойлгон уур амьсгалын өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлэх арга замыг судлан хэрэгжүүлж тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох чухал тал болно. |

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

Суралцахуйн зорилт, сэдэв агуулгын хүрээнд хэрхэн холбогдож байгааг тайлбарлахын зэрэгцээ сэдэв агуулгыг ямар аргаар төлөвлөх цаашлаад энэ арга зүй нь хүүхдийн тогтвортой байдлын ямар цогц чадамжийг эзэмшүүлэхэд чиглэж байна вэ гэдэгт анхаарлаа.

*АЧСҮА-ны цагаар ТХЗ-ыг хангах аргын сонгогдсон байдал (тоогоор)*

| Аргууд | Холбогдсон байдал |
|---|---|
| Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, | 7 |
| Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | 5 |
| Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | 4 |
| Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/өнгөрсөнийг нэхэн санах) | - |

Амьдрах чадварт суралцах цагаар ТХЗ-ыг дэмжихэд бодит үйл ажиллагаанд оролцох, шинжилгээ судалгаа хийх, бүтээлч шүүмжлэлтэй сэтгэх аргууд нь илүү холбогдсон байна. Энэ нь цөм хөтөлбөрт амьдрах чадварт суралцах цагийн зорилгыг бодит үйл ажиллагаанд оролцонгоо асуудлыг олж харах, шийдвэрлэх арга замыг эрж хайн суралцах гэж дэвшүүлсэнтэй нийцэж байна гэж харж болохоор байна.

*Тогтвортой байдлын цогц чадамжийг дэмжиж буй байдал (тоогоор)*

| Цогц чадамж | Холбогдсон байдал |
|---|---|
| Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж (Systems thinking) | 2 |
| Урьдчилан тооцоолох цогц чадамж (Anticipatory) | 3 |
| Хэм хэмжээний цогц чадамж (Normative) | 1 |
| Стратегийн цогц чадамж (Strategic) | 3 |
| Хамтран ажиллах цогц чадамж (Collaboration) | 2 |
| Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж (Critical thinking) | 2 |
| Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж (Self-awareness) | 2 |
| Асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамж (Integrated problem-solving) | 1 |

| Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар | Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар |
|---|---|
| 8 | 10 |
| Уур амьсгалын өөрчлөлтөд хамаарах асуудлыг танин мэдэх, шийдвэрлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх санал санаачилга гаргах зэргээр бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээ, хэлэлцүүлэг хийх 2-р аргыг хэрэглэнэ. | Байгаль орчныг бохирдуулдаг хүний буруутай үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг болохыг ойлгон, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн өрх гэр, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг тайлбарлан уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах олон нийтийн оролцоог дэмжсэн санал санаачилга гаргах замаар урьдчилан тооцоолох цогц чадамжаа хөгжүүлнэ. |

*Онцлог, анхаарах зүйл:*

Бага боловсролын түвшинд АЧСҮА нь IV-V ангид орохоор сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан ба анги тус бүрээр эзэмшүүлэх чадвар, арга барил тодорхойлогдоогүй тул бид түүнийг тухайн цагийн онцлог гэж үзэн ТХЗ-ын агуулга, арга зүйн интеграцыг гаргахдаа IV-V ангийг 45 гэж кодлов.

Суралцахуйн зорилтын код: 45, 15.2.г.

45- Бага боловсролын 4-5-р ангид энэ цаг ордог учир 45 гэж бага боловсролын түвшнийг тодорхойлсон

15- Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт амьдрах чадварт суралцах цагийн агуулгын хүрээнд хамаарах сэдвүүдийг зааж өгсөн бөгөөд түүнийг эхнээс дугаарлаад түүний 15 дахь сэдэвт хамааралтайг илэрхийлсэн байдал *(хавсралтад өгсөн хүснэгтийн 15- Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ)*

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт амьдрах чадварт суралцах цагаар хүүхдэд эзэмшүүлэх 5 тодорхой чадварыг гаргасан бөгөөд түүний 2-рт дугаарласан чадварыг илэрхийлсэн код *(Асуудлыг олж харан, шийдлийн гарцыг тодорхойлох)*

г- Тухайн чадварт хүрэх зорилт (арга барил)-ыг тэмдэглэсэн код *(Асуудлыг шийдвэрлэх, хүсэл эрмэлзэл нэмэгдэх)*

45, 15.2.г. Байгаль орчныг бохирдуулж буй хүний буруутай үйл ажиллагаа түүнээс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн айл өрх, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг илрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг судлан хэрэгжүүлэх гэж суралцахуйн зорилтыг томьёолж бичлээ.

*Хүснэгт 4.12. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 45 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/өнгөрсний нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар /суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| ***1*** | ***2*** | ***3*** | ***4*** | ***5*** | ***6*** | ***7*** | | | | ***8*** | ***9*** | ***10*** |
| Орон нутгийн онцлогт тохирсон сэдэв | 45, 6.2.д. Орон нутгийн хүмүүсийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж тусламж дэмжлэг хэрэгтэй хүмүүсийн талаар асуудлыг олж харан шийдлийн гарцыг тодорхойлох | ☐ | ТХ301.НСХ3 | ТХ301.Сэ07. | Тусламж хэрэгтэй байгаа хүмүүстэй (ядуу эмзэг бүлгийн) туслах, тэдний дасан зохицох чадвар, сэтгэл зүйг дэмжин гэр бүл, хүний амь, амьдралын үнэ цэн, үнэт зүйл, эрх ашгийг хүндэтгэн харилцана. | ☐ | ☐ | ☐ | | Тусламж дэмжлэг хэрэгтэй (ядуу, эмзэг бүлгийн) хүмүүст туслах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, хүмүүнлэгийн байгууллагад хандах зэргээр бодит үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, | 5 | 5- Бусдын хэрэгцээ шаардлагыг ойлгож хүндэтгэх чадвар, урам зориг өгөх зэргээр хамтран ажиллах цогц чадамжийг хөгжүүлнэ. |
| Сургуулийн онцлогт тохирсон сэдэв | 45, 8.5.в. Сургуулийн амьдралд буй тэгш бус байдлыг бусадтай харилцах явцад илрүүлэх, өөрийнхөө харилцааны ур чадварыг эргэцүүлэн бодож, тэгш бус байдлаас үүдэн гарах ур дагаврыг ойлгож, ухаарсан зүйлээ хэрэгжүүлэх | ☐ | ТХ301.НСХ5. | ТХ301.Сэ08. | Сургууль, багш, эцэг, эх, суралцагчдын хамтын ажиллагаа, харилцаан дахь тэгш бус байдлыг илрүүлэнтэгш бус байдлын ур дагаврыг тодорхойлж, өөрийн үүрэг оролцоондоо шүүмжлэлтэй хандана.. | | | ☐ | | Сургууль дээрх харилцааны тэгш бус байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, ур дагаврыг тодорхойлох, байгууллага хүмүүстэй хамтран ажиллаж өөрийн оролцоог нэмэгдүүлнэ. | 8 | 8- Сургууль дээр болон бидний эргэн тойронд харагдаж буй тэгш бус байдлын талаар хэлэлцэн, тусгай хэрэгцээ шаардсан шийдлийн хувилбар боловсруулах чадамж, эрх тэгш шийдлийн хувилбар боловсруулах замаар асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамж хөгжинө. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хоол хүнстэй холбоотой сэдэв | 45, 13.1.б. Хоол хүнс, хоол хүнсний шим тэжээлт бодисын талаар судалж, шим тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх ойлголт мэдлэгээ нэмэгдүүлэх | ☐ | ТХ302.ТМ1. | ТХ302.Сэ01. | Хоол хүнс, хоол хүнсний шим тэжээлийн талаар судалж энэ сэдвийн хүрээнд боломжит эх сурвалжуудаас мэдээлэл цуглуулан ойлголт мэдлэгээ нэмэгдүүлж шим тэжээл сайтай хоол хүнсний ач тусыг ойлгон амьдралд хэрэгжүүлнэ.. | | ☐ | | | Өдөр тутам хэрэглэгддэг хүнсний бүтээгдэхүүний найрлага, шим тэжээлийн талаар судалгаа хийн илчлэгийг тодорхойлон шим тэжээлт хоол хүнсний ач тусыг ойлгон өөрийн амьдралд хэрэгжүүлэх. | 7 | 7- Хоол хүнс, хоол хүнсний шим тэжээл, шим тэжээлийн дутагдлын талаар боломжтой эх сурвалжуудаас мэдээлэл цуглуулж ойлголт мэдлэгээ нэмэгдүүлэн өдөр тутам хэрэглэгддэг хүнсний бүтээгдэхүүний найрлага илчлэгийг тодорхойлон шим тэжээлт хоол хүнсээр хооллохын ач холбогдлыг ойлгон өөрийн амьдралдаа хэрэгжүүлэн өөрийгөө таньж мэдэх цогц чадамжийг хөгжүүлнэ. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 15.2.д. Байгаль орчин, байгальд ээлтэй хөдөө аж ахуйн хөгжлийн талаар мэдээлэл цуглуулан, сонирхсон асуудлаа судлагдахуунаар олж авсан мэдлэг чадвараа ашиглан шийдвэрлэх | ☐ | ТХ302.НСХ1. | ТХ302.Сэ03. | Хөдөө аж ахуйн хөгжил, хоолны шим тэжээлд хэрхэн нөлөөлж байгаа асуудлыг олж харан шийдлийн гарцыг тодорхойлж хэрэгцээтэй, сонирхсон, тулгамдсан асуудлаа математикийн хичээлээр олж авсан мэдлэг чадвараа ашиглан шийдвэрлэнэ. | ☐ | | | | Тогтвортой хөдөө аж ахуйн чиглэлээр сайн туршлага хуримтлуулж буй газруудад аялал экскурс хийнгээ математик тооцоолол хийх, хөдөө аж ахуйн техник технологийн хөгжлийн дэвшлийг тодорхойлох | 4 | 4- Тогтвортой хөдөө аж ахуйн чиглэлээр сайн туршлага хуримтлуулж буй газруудад аялал экскурс хийх, цаашдын үйл ажиллагаар нь дэмжсэн шинэлэг, дэвшилтэт үйл ажиллагаар нь сурталчлан хөгжүүлж стратегийн цогц чадамжийг хөгжүүлнэ. |
| Хоол хүнстэй холбоотой сэдэв | 45, 5.4.а Хүний амьдралд хоол хүнсний гүйцэтгэх үүргийг эргэцүүлэн бодож гэр бүл хамт олны нэг гишүүний хувьд юу хийх, яаж хувь нэмэр оруулах, үүрэг оролцоогоо эргэцүүлэх | ☐ | ТХ302.НСХ5. | ТХ302.Сэ05. | Хүний бие бялдар, сэтгэл хөдлөл, нийгэм соёлын хүрээнд хоол хүнсний гүйцэтгэх үүргийг ойлгон гэр бүлийнхнийгээ хүнс тэжээлийн дутагдлаас сэргийлэхийн тулд юу хийх, үүрэг оролцоогоо эргэцүүлнэ. | | | ☐ | | Хоол хүнсний гүйцэтгэх үүргийг тодорхойлон эрүүл мэндийг дэмжих хоол хүнсний хэрэглээний талаар мэдээлэл цуглуулан хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх хэлэлцүүлэг хийнэ. | 2 | 2- Хүний бие бялдар, сэтгэл хөдлөл, эрүүл мэндийг дэмжихэд хоол хүнсний гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, харилцан хамаарлыг ойлгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх чадварт суралцан урьдчилан тооцоолох цогц чадамжийг хөгжүүлнэ. |
| Эрүүл мэндтэй холбоотой сэдэв | 45, 12.2.д. Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр ямар ямар үйл ажиллагаа хийгдэж байгааг олж харан ач холбогдлыг хэлэлцэн дэмжин сурталчлах | ☐ | ТХ303.ТМ3. | ТХ303.Сэ03. | Эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжсэн нийгмийн хүрээний энгийн үйл ажиллагаануудыг олж харан, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих вакцин, дасгал хөдөлгөөний ач холбогдлыг ойлгон хэлэлцэж,дэмжих чадварт суралцана. | ☐ | ☐ | ☐ | | Эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжсэн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бусдыг идэвхжүүлэх, уриалах, дасгал хөдөлгөөн хийж хэвших | 2 | 2- Эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжсэн үйл ажиллагаанд идэвхтэй оролцон, дасгал хөдөлгөөн болон тодорхой насанд хийгддэг вакцины ач холбогдлыг ойлгож урьдчилан сэргийлэх зарчим, үр дагаврыг үнэлж дүгнэн урьдчилан тооцоолох цогц чадамжийг хөгжүүлнэ. |
| Орон нутгийн онцлогт тохирсон сэдэв | 45, 7.4.в. Орон нутгийн хөгжил, түүх, бүтээн байгуулалт, эрхлэх аж ахуйн хүрээнд амжилт гаргасан хүмүүстэй харилцаа тогтоон хамтран ажиллах | ☐ | ТХ304.НСХ4. | ТХ304.Сэ06. | Орон нутгийн алдартай, амжилт гаргасан хүмүүстэй уулзалт ярилцлага хийж, ахуй амьдралаа сайжруулан, хөдөлмөр, бизнес эрхлэхэд боловсрол, үр чадвар чухал болохыг ухаарч ойлгох | ☐ | | | | Амжилттай суралцаж, ажиллаж хөдөлмөрлөж буй ахлах ангийн, үе тэнгийн сурагч, зочин урьж ярилцан уулзалт хэлэлцүүлэг өрнүүлэх | 5 | Ахуй амьдралаа сайжруулан, амжилттай ажиллаж, хөдөлмөрлөж байгаа ахмад хүмүүс, амжилт гаргасан сурагч, үе тэнгийнхэнтэй уулзаж ярилцангаа боловсрол, үр чадвар чухлыг ойлгон хамтран ажиллах чадамжаа нэмэгдүүлнэ. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндэсний онцлогт тохирсон сэдэв | 45, 5.1.д. Амьдралын үнэ цэнэ, утга учир, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагын талаар мэдээлэл цуглуулан судлан шинжлэх | ☐ | ТХ305.ТМ1. | ТХ305.Сэ10. | Уламжлалт ёс заншилд гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагын талаар юу гэж сургасныг эрэл хайгуул хийн мэдээлэл цуглуулж мэдээллийн дагуу ярилцан харилцан хамаарлыг ойлгоно. | ☐ | ☐ | | | Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн уламжлалт ажил үйлд нэг өдрийн турш оролцох, ажил үүргээ сольж гүйцэтгэх замаар үүрэг хариуцлагыг ухамсарлах | 3 | Уламжлалт зан үйлээс суралцан гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, ажил үүргийн талаар мэдээлэл цуглуулан, тодорхой ажил үүргийг биеэр хийж мэдрэн уламжлалт дэг жаягт суралцангаа хэм хэмжээний цогц чадамжаа хөгжүүлж байна. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 5.2.д. Байгаль орчин, байгальд ээлтэй усны хэрэглээний талаар судалж усны бохирдол, хомсдолын учир шалтгааныг танин мэдэх | ☐ | ТХ306.ТМ1. | ТХ306.Сэ10. | Амьдралыг тэтгэгч усны ач холбогдол, усны хэрэглээ, бохирдол, хомсдолын учир шалтгааныг танин мэдэж усны зохистой хэрэглээнд суралцана | | ☐ | | | Ус түүний ач холбогдол, усны бохирдол хомсдолын талаар судалгаа хийн олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ухуулга, сурталчилгааны ажил зохион байгуулах | 1 | Ус амьдралын эх булаг, амьдралыг тэтгэгч, усгүйгээр амьдрал оршин тогтохгүй ойлгон ухуулга сурталчилгаа хийж харилцан хамаарлыг ойлгож байгаагаараа тогтолцоот сэтгэлгээний чадамжийг хөгжүүлж байна. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 15.1.г. Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ, усны хэрэглээний талаар асуудлыг олж харан шийдвэр гаргах | ☐ | ТХ306.ЗУ3. | ТХ306.Сэ06. | Усны хувийн хэрэглээгээ багасган, өдөр тутамдаа ус хэмнэх дадал зуршилтай болж,усны хомсдол, зохистой хэрэглээний ач холбогдлыг ойлгон хэрэгжүүлнэ. | | ☐ | | | Өөрсдийн усны хэрэглээний ул мөрийг тооцох судалгаа хийх, усны хэрэглээгээ багасгах зан үйлд суралцан дадал зуршил болгох | 7 | Усны хувийн хэрэглээгээ хянах, тооцох, судалгаа хийх замаар өөрийн үйлд үнэлгээ дүгнэлт өгөн, цаашид зан үйл хандлагад өөрчлөлт орж энэ нь өөрийгөө таньж мэдэх цогц чадамжийг хөгжүүлнэ. |
| ШУ, техно-логийн хөгжил | 45, 16.1.б. Шинжлэх ухаан технологийн хөгжил, эрчим хүчний төрөл, эрчим хүчний бидний амьдралд нөлөөлж буй нөлөөллийг ойлгох | ☐ | ТХ307.ТМ1. | ТХ307.Сэ01. | Эрчим хүчний төрлүүд (нар, салхи, усны, газрын гүний эрчим хүчний)-ийн талаар ойлголттой болж хүний эрүүл мэнд, хүрээлэн орчин,бидний амьдралд хэрхэн нөлөөлж байгааг судлан ач холбогдлыг ойлгоно. | | ☐ | ☐ | | Эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлтийн газарт аялал, экскурс хийх, эрчим хүчний төрөл хэлбэрийн давуу сул талын талаар хэлэлцүүлэг хийх | 1 | Эрчим хүчний төрөл, үйлдвэрлэл, түгээлтийн талаар анхны ойлголттой болж эрчим хүчний бидний амьдралд үзүүлж буй нөлөө, харилцан хамаарлыг хэлэлцэн шинжлэх ухаан технологийн дэвшил нь эрчим хүчний хөгжилд хэрхэн нөлөөлж буйг хэлэлцэн тогтолцоот сэтгэлгээний чадамжаа хөгжүүлнэ. |
| ШУ, техно-логийн хөгжил | 45, 7.5.б. Шинжлэх ухаан технологийн хөгжлийн үр дүн эрчим хүчний хэрэглээ бидний амьдралд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэн өөрийн үүрэг оролцоогоо нэмэгдүүлэх | ☐ | ТХ307.ЗУ1. | ТХ307.Сэ06. | Өөрийн гэр, орон нутаг, байгууллагын эрчим хүчний ашиглалт, ашиглалтаас үүдэн хүрээлэн орчинд үзүүлэх нөлөөг эргэцүүлэн эрчим хүчний хэрэглээгээ багасгах талаар өөрийн үүрэг оролцоогоо нэмэгдүүлэхэд анхаарна. | ☐ | | | | Өөрийн гэр, орон нутаг, байгууллагын эрчим хүчний хэрэглээний талаар тооцоо судалгаа хийх, эрчим хүчний хэрэглээ, хүрээлэл орчинд үзүүлж буй нөлөөллийг илрүүлэн эрчим хүчийг хэмнэх бодит ажил зохион байгуулах | 6 | 6- Өөрийн гэр, орон нутаг, байгууллагын эрчим хүчний хэрэглээний талаар тооцоо судалгаа хийн хүрээлэл орчинд үзүүлж буй нөлөөллийг илрүүлэн асуудал дэвшүүлэн шийдвэрлэхийн тулд хүмүүсийг бодит үйл ажиллагаанд уриалах санал санаачилга гаргах зөргээр шүүмжлэлт сэтгэлгээний чадамжаа хөгжүүлнэ. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 7.1.а. Байгаль орчин, байгаль орчинд ээлтэй хог хаягдлын менежментийг судлан өөрийн үүрэг оролцоогоо нэмэгдүүлэх | □ | ТХ311.НСХ5. | ТХ311.Сэ07. | Суралцагч өөрийн хүрээлэл орчинд хог хаягдлын үзүүлэх нөлөөллийг ойлгож, нийгмийн үүрэг хариуцлагаа ухамсарлах чадвартай болно | □ | | | | Хог хаягдлын хүрээлэл орчинд нөлөөлөх нөлөөллийг ойлгон, хог хаягдлын үр дүнтэй менежментийг нэвтрүүлж буй газартай танилцах, үйл ажиллагаанд оролцох, бусдад уриалах | 4 | Орон нутгийн сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулах зорилгоор хог хаягдлын талаар орон нутгийн асуудлыг олж харан мэдээлэл цуглуулж үр дүнтэй үйл ажиллагаа явуулж буй газрын цаашдын тогтвортой байдлыг дэмжин хүмүүст хүргэн стратегийн цогц чадамжаа хөгжүүлнэ. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 15.1.г. Байгаль орчныг бохирдуулж буй хүний буруутай үйл ажиллагаа түүнээс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн айл өрх, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг илрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлэх арга замыг судлан хэрэгжүүлэх | □ | ТХ313.ТМ3. | ТХ313.Сэ03. | Хүний үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нөлөө үзүүлдгийг ойлгон түүнээс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн айл өрх, орон нутаг, улс орны хөгжилд ямар нөлөө үзүүлж буйг тайлбарлаж чаддаг болно. | ь | | □ | | Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх арга замуудыг хэлэлцэн, олон нийтэд таниулах ажил зохион байгуулах | 2 | Байгаль орчныг бохирдуулдаг хүний буруутай үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг болохыг ойлгон, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн өрх гэр, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг тайлбарлан уур амьсгалын өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлэх олон нийтийн оролцоог дэмжсэн санал санаачилга гаргах замаар урьдчилан тооцоолох цогц чадамжаа хөгжүүлнэ. |
| Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээ | 45, 15.2.д. Байгаль орчин, байгальд ээлтэй хэрэглээг олж харах, байгальд хор хөнөөл учруулж сүйтгэж байгаа шалтгааныг эрж хайн байгаль хамгаалахад хувь нэмрээ оруулах | □ | ТХ315.ТМ4. | ТХ315.Сэ08. | Хүмүүс бол амьд байгалийн нэг хэсэг бөгөөд байгальд хор хөнөөл өөрсдөө учруулж байгалийг, хөрсийг бохирдуулж нөхөн сэргээгдэх хугацаанаас нь өмнө сүйтгэж, устгаж байгаа баримт жишээг хэлэлцэж байгаль хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулна. | | □ | □ | | Орон нутгийн байгууллага, хүмүүсийн бодит жишээн дээр шинжилгээ судалгаа хийх судалгааны дүнг хэлэлцэн байгаль хамгаалах талаар бодит ажлын санаачилга гаргах, Орон нутгийн байгаль хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, хувь хүмүүстэй уулзалт хийх | 6 | Орон нутагт байгальд хохирол (хор хөнөөл) учруулж буй хүмүүс, байгууллагын бодит жишээг хэлэлцэн байгалийн нөхөн сэргээгдэх хугацаанаас өмнө сүйтгэж, устгаж байгаа байдалд эргэцүүлэл, дүгнэлт хийн шүүмжлэлт сэтгэлгээний чадамжаа хөгжүүлнэ. |
| Орон нутгийн онцлогт тохирсон сэдэв | 45, 8.3.а. Орон нутгийн хүмүүс болон байгууллагуудтай бүтээлчээр хамтран , орон нутгийн хэмжээнд мөхөх устах аюулд өртсөн, ховордсон амьтан ургамлыг судлан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулна. | □ | ТХ315.ЗҮ1. | ТХ315.Сэ03. | Мөхөх устах аюулд өртсөн, ховордсон амьтан ургамлын талаар эцэг эх, орон нутгийн хүмүүс болон байгууллагуудтай хамтран судалгаа хийж, асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулна.. | □ | ь | | | Мөхөх устах аюулд өртсөн, ховордсон амьтан ургамлын талаар эцэг эх, орон нутгийн хүмүүс болон байгууллагуудтай хамтран судалгаа хийх Ажиглалт, судалгааны үр дүнд санал санаачилга гарган, ховордсон ан амьтдыг хамгаалах аян өрнүүлэх | 4 | Устаж үгүй болж буй ургамал, ховордсон ан амьтан зэргийг хамгаалах талаар бүтээлч санаачилга гарган хэрэгжүүлснээр орон нутгийнхаа тогтвортой байдлыг дэмжин стратегийн цогц чадамжаа хөгжүүлнэ. |

## 4.3. Б. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ: УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫГ СУДЛАН ХЭРЭГЖҮҮЛЬЕ

***Суралцахуйн зорилт:*** Байгаль орчныг бохирдуулж буй хүний буруутай үйл ажиллагаа түүнээс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн айл өрх, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг илрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг судлан хэрэгжүүлэх

***Цөм хөтөлбөрийн зорилт*:** Байгаль орчныг бохирдуулж буй хүний буруутай үйл ажиллагааны талаар асуудлыг олж харан, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй нөлөөллийг илрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг судлан хэрэгжүүлэх

***ТХЗБ-ын суралцахуйн зорилт*:** ТХЗ13.ТМ3. Суралцагч дэлхий нийт, улс үндэстэн, орон нутаг, хувь хүний түвшин дэх хүний үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нөлөө үзүүлдгийг мэддэг болох

***Тогтвортой хөгжлийн зорилгод хамаарах сэдэв*:** Ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдэл гэх мэт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүдийн айл өрх, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөлөл

***Арга зүйн сонголт*:** “Уур амьсгалын өөрчлөлтөд хамаарах асуудлыг шийдвэрлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх санал санаачилга гаргах” замаар “Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх хэлэлцүүлэг хийх арга зүй

***ТХБ-ТХ-цогц чадамжууд*:** Байгаль орчныг бохирдуулдаг хүний буруутай үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг болохыг ойлгон, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн өрх гэр, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг тайлбарлан уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг судлан хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, санал санаачилга гаргах замаар байгаль орчин, эх дэлхийгээ хамгаалах урьдчилан тооцоолох цогц чадамжаа хөгжүүлнэ.

***Агуулга:*** Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг хүчин зүйлүүд, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдсэн ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдлийн үзүүлж буй нөлөөллийг танин мэдэж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг судлан, хэрэгжүүлж, олон нийтийн хэлэлцүүлэг хийх, санал санаачилга гаргах замаар тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

***Арга зүй:*** Бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээ, хэлэлцүүлэг хийх

***Үйл ажиллагааны төлөвлөлт:***

| № | Үйл ажиллагаа | Зорилт | Арга зүй, алхам | Хэрэглэгдэхүүн |
|---|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл цуглуулах (1 цаг) | Орон нутгийн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээллийн олон эх үүсвэрийг тодорхойлж тодорхой эх сурвалжуудаас мэдээлэл цуглуулах | Судалгааны баг болон хуваагдах<br>Баг бүр нэг мэдээллийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах<br>Мэдээлэл цуглуулах, тэмдэглэх хуудсыг бэлтгэх<br>Асуулт бүрийг ойлгосон эсэх, хариултын хуудсыг хэрхэн тэмдэглэх тухай ярилцах<br>Олж авсан бүх мэдээллээ баримт хуудсыг ашиглан тэмдэглэж хадгалах | Мэдээллийн эх сурвалжийн санал:<br>Ном, гарын авлага, сонин сэтгүүл<br>Орон нутгийн байгууллагууд<br>Сонирхлын бүлгүүд |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td>Судалгааны багийн гишүүд мэдээллийн эх сурвалжтай холбоо тогтоохдоо өөрсдийгөө танилцуулахаас эхлээд зорилго, шалтгаанаа нэг бүрчлэн танилцуулах</td><td>Интернет<br>Ажиглалтаар<br>Зочин багш<br>Бусад</td></tr>
<tr><td colspan="5">Дүгнэх нь: Дүгнэх асуултууд<br>Мэдээлэл цуглуулахдаа ямар бэрхшээлтэй тулгарсан бэ?<br>Мэдээлэл цуглуулахдаа багийн бусад гишүүдтэй хамтран ажиллаж чадсан уу? Тийм. Яагаад? Үгүй. Яагаад?<br>Мэдээлэл цуглуулах явцад орон нутгийн цаг агаар, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн талаар тодорхой ойлголт авч чадсан уу?<br>Мэдээлэл цуглуулах явцад байгаль орчин, уур амьсгалын талаарх өмнө байсан ойлголт тань өөрчлөгдсөн үү? Тийм бол яаж өөрчлөгдсөн бэ?</td></tr>
<tr><td>2</td><td>Мэдээллээ боловс-руулж, нэгтгэн дүгнэх<br>(1 цаг)</td><td>Уур амьсгалын өөрчлөлтөд хүмүүсийн үйл ажиллагаа хэрхэн нөлөөлдгийг илрүүлэн хүмүүсийн буруутай үйл ажиллагааг багасгах арга зам, цаашид анхаарах саналыг дэвшүүлэх.</td><td>Судалгааны багууд мэдээллээ танилцуулна.<br>Танилцуулахдаа өөрсдийн судалгааг илтгэн харуулж чадах сайн баримт материалыг танилцуулна.<br>Баримт материалыг схем, график, хүснэгт, зурган хэлбэрээр боловсруулж болно.<br>Эдгээр мэдээллийг бодитой эх сурвалжаас авсан байх бөгөөд сурагчид өөрсдөө ч судлагдахууны мэдлэг чадвараа ашиглан боловсруулсан байж болно.<br>Баг бүр танилцуулгадаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг хүний үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ялган тодотгоно.<br>Хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болж уур амьсгалын өөрчлөлт явагдаж буй жишээ, баримт, тохиолдлыг ярина.<br>Цаашид хэрхэн анхаарах тухай багийн саналыг дэвшүүлнэ.</td><td>Сонин сэтгүүлийн хайчилбар, ярилцлага авсан тухай бичгэн мэдээлэл, радио телевизийн мэдээ зэргийг нэгтгэнэ.<br>Хүмүүсийн ямар ямар үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буйг илтгэсэн багуудын мэдээлэл</td></tr>
<tr><td colspan="5">Дүгнэх нь: Дүгнэх асуултууд<br>Багийн гишүүд өгсөн даалгавраа хугацаанд нь хийж дуусгахын тулд ажил үүргээ хуваан авч ажилласан уу? Тийм бол яаж, үгүй бол яагаад?<br>Багийн гишүүдтэй амжилттай хамтарч ажиллаж чадсан уу? Тийм бол яаж, үгүй бол яагаад?<br>Танай бүлэг өөрсдийн хийсэн ажлыг сайн танилцуулж чадсан уу?<br>Таныг сонссон хүмүүс та нарын саналыг хүлээн авч дэмжсэн үү?<br>Танай багийн танилцуулга бусад багаас юугаараа онцлог, өөр вэ?<br>Хүмүүсийн ямар ямар буруутай үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байна вэ?<br>Хүмүүсийн буруутай үйл ажиллагааг багасгах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах ямар санал дэвшүүлсэн бэ? Оновчтой байсан уу? Биелэх боломжтой юу?</td></tr>
<tr><td>3</td><td>Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаврыг танин мэдэх<br>(1 цаг)</td><td>Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган зуд, үер ус, гал түймрийн аюулын талаар ойлголтоо нэмэгдүүлж эдгээр үзэгдлүүдийн айл өрх, улс оронд үзүүлж буй нөлөөллийг танин мэднэ.</td><td>Байгалийн аюулт үзэгдэл үү, эсвэл хүний үйл ажиллагаанаас үүдсэн аюул осол уу? (Ажлын хуудас 1)<br>Танай орон нутагт ямар төрлийн аюулт үзэгдэл, осол хамгийн түгээмэл тохиолддог вэ? (Хүүхдүүдийн өөрсдийн орчин нөхцөлөөс жишээ гаргуулна, бүтээлчээр сэтгэн бодуулж, хэлэлцүүлэг зохион байгуулна)<br>Гамшигт үзэгдлүүдийн айл өрх, улс оронд үзүүлж буй нөлөөллийг чи юу гэж бодож байна вэ?</td><td>Ажлын хуудас 1-ийг ашиглана. Багш бүтээлчээр дэлгэрүүлж болно<br>Бодит жишээ баримт дээр тулгуурлан хэлэлцүүлэг хийж дүгнэнэ. Багшийн мэдээлэлд ашиглах БАРИМТ мэдээлэл ашиглана.</td></tr>
</table>

<table>
<tr><td colspan="5">Дүгнэх нь: Дүгнэх асуултууд<br>Байгалийн аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаанаас үүдсэн аюул ослын ялгаа юу вэ?<br>Бидний үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй танай орон нутгийн бодит жишээ баримтыг нэрлэж ярилцана уу?<br>Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшигт үзэгдлүүдийн хүний сэтгэл санаа, гэр бүл, улс оронд үзүүлж буй нөлөөллийг юу гэж бодож байна вэ? Нөлөөллөөс үүдэн гарах үр дагаврууд.<br>Гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хувь хүн, албан байгууллага, гэр бүл ямар арга хэмжээ авах хэрэгтэй гэж бодож байна.<br>Хүмүүсийн буруутай үйл ажиллагааг багасгах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах ямар санал дэвшүүлсэн бэ? Оновчтой байсан уу? Биелэх боломжтой юу?</td></tr>
<tr><td>4</td><td>Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга зам (1 цаг)</td><td>Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг судлан, өөрийн амьдрал зан үйлдээ мөрдөх, олон нийтийн дунд санал санаачилга гарган хэрэгжүүлснээрээ бахархах, үр дүнгээ үнэлэх, цаашид хийж хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болох.</td><td>Та санал нийлэх үү? Ажлын хуудас 2 дээр ажиллах<br>Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй гол хүчин зүйлийг ялгах<br>Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах ямар боломж, арга зам байна вэ ( хэлэлцүүлэг хийх)<br>Таны оруулах хувь нэмэр</td><td>Ажлын хуудас 2-ыг ажиллан уур амьсгалын өөрчлөлтийн талаар ойлголтоо нэмэгдүүлнэ.<br>Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг хүчин зүйлийг ялган ангилж дүгнэлт хийнэ.<br>Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах ямар арга замууд байж болох вэ.<br>Ажлын хуудас 3 уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг багасгах бөгөөд багш ач холбогдлыг дүгнэн ярилцана.</td></tr>
<tr><td colspan="5">Дүгнэх нь: Дүгнэх асуултууд<br>Уур амьсгалын өөрчлөлт цаг агаарын өөрчлөлт 2 ялгаатай юу? Тийм бол яагаад, үгүй бол яагаад<br>Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг гол гол хүчин зүйлүүдийг нэрлэнэ үү? Яагаад ингэж ялгасан бэ?<br>Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хэрэгтэй юу? Тийм бол яагаад, үгүй бол яагаад<br>Хүмүүсийн буруутай үйл ажиллагааг багасгах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах ямар санал дэвшүүлсэн бэ? Оновчтой байсан уу? Биелэх боломжтой юу?<br>Нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг багасгах ямар арга замууд байна вэ. Үүнийг хэрэгжүүлэх боломжтой юу.<br>Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замуудаас алийг нь хэзээ, хэнээс, хаанаас, ямар арга хэлбэрээр эхлүүлж болох тухай зөвлөмж бичнэ үү.<br>Зөвлөмжийг олон нийтэд сурталчлан таниулж, санал санаачилга өрнүүлэх замаар дараагийн ажлын зураглал гаргана уу?</td></tr>
</table>

## Үнэлгээ:

| Зорилт | Шалгуур |
|---|---|
| Орон нутгийн цаг агаар, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл цуглуулан боловсруулж хүний буруутай үйл ажиллагаа хэрхэн нөлөөлж байгаад дүгнэлт гаргах замаар уур амьсгалын өөрчлөлтийг багасгах арга зам эрж хайж, мэдээлэлтэй ажиллаж боловсруулалт хийн ойлголт мэдлэгээ нэмэгдүүлэх | - Мэдээллийн эх сурвалжаа тодорхойлон тэмдэглэх хуудас бэлтгэсэн байдал<br>- Мэдээлэл цуглуулахдаа мэдээллийн эх сурвалжтай харилцаа тогтоон хамтарч буй байдал<br>- Мэдээллээ баримтжуулан хадгалж тэмдэглэсэн байдал<br>- Хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болж өөрчлөгдөж буй уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээллийг ялган ангилж буй байдал<br>- Бусад сурагчидтай эвтэй , үр дүнтэй хамтран ажиллаж байгаа байдал.<br>- Уур амьсгалын өөрчлөлтийг багасгах арга замыг эрж хайн эцэг эх, сургууль, орон нутгийн хүмүүстэй харилцаа тогтоож, хамтран ажиллаж чадаж байгаа байдал |
| Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүдийн айл өрх, орон нутаг, улс оронд үзүүлж буй нөлөөллийг танин мэдэж урьдчилан сэргийлэх замаар өөрийн үзэл бодол төлөвшин бусдад нөлөөлөх арга замд суралцах | – Асуудлыг олон талаас нь авч үзэн харьцуулалт хийж, эргэцүүлэн бодож буй эсэх.<br>- Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлж буй байдал<br>- Бусад сурагчидтай эвтэй , үр дүнтэй хамтран ажиллаж байгаа байдал.<br>- Эцэг эх, сургууль, орон нутгийн хүмүүстэй харилцаа тогтоож, хамтран ажиллаж чадаж байгаа байдал |
| Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг судлан, өөрийн амьдрал зан үйлдээ мөрдөх, олон нийтэд санал санаачилга гарган хэрэгжүүлснээрээ бахархах, үр дүнгээ үнэлэх, цаашид хийж хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болох. | - Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг олж буй байдал<br>- Өөрийн амьдрал, зан үйлдээ хэрэгжүүлж бусдыг уриалан дуудаж буй байдал<br>- Олон нийтийг санал санаачилга гаргах замаар хамтран ажиллаж, үр дүнгээ тооцож буй байдал<br>- Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга замыг хэрэгжүүлснээрээ байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалж байгаагаараа бахархаж хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл нь нэмэгдэж буй байдал |

## Ажлын хуудас 1:

Дасгал 1: Байгалийн аюулт үзэгдэл үү, эсвэл хүний үйл ажиллагаанаас үүдсэн аюул осол уу?

| № | Төрөл | Тайлбар | Аюулт үзэг-дэл | Хүний үйл ажилла-гаанаас үүдсэн аюул осол | Яагаад |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үер | Голын ус эргээ зад тавьж, өөр газарт тархах үзэгдэл | + | + | Бид үерийг байгалийн аюулт үзэгдэл гэж хэлдэг ч заримдаа хог хаягдлаа үерийн далан, шуудуунд хаях, үерийн далан шуудуугүй газар гэрээ барьж, далан сэтлэх зэрэг хүний буруутай үйлдлээс болж ҮЕР БОЛДОГ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Хөрсний нуралт | Өндөр налуу газрын хөрс болон шавар доошоо их хэмжээгээр урсах, нурах үзэгдэл | | | |
| 3 | Ган | Удаан хугацаагаар хур тунадас ороогүйн улмаас усны ноцтой хомсдолд хүргэх үзэгдэл | | + | Энэ нь мөн хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байж болно. Жишээ нь гол мөрний урсгалын дээд талд далан барьснаас болж ган гачиг тохиолддог. |
| 4 | Цасны нуранги | Их хэмжээний цас налуу газар луу нурах үзэгдэл | | | |
| 5 | Ойн хээрийн түймэр | Ой хээрт гал түймэр гарч энэ нь хяналтаас алдагдах | | | Бид ой хээрийн түймрийг байгалийн аюулт үзэгдэл гэж хэлдэг боловч заримдаа хэн нэгэн хүн ойд татсан тамхиа унтраалгүй хаяснаас болж ГАЛ ТҮЙМЭР ГАРДАГ. |
| 6 | Гал түймэр | Объектод галын аюулгүйн дүрэм норм зөрчигдөж гал гарах нөхцөл бүрдэх | | | |
| 7 | Аюул, ахуйн осол | Гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр тодорхой цаг хугацаанд, тодорхой газарт хувь хүн болон түүний хүрээлэн буй орчинд үүсэх гэнэтийн таагүй байдал | | | |
| 8 | Зуд | Их цас унах, эрс хүйтрэх, мал сүрэг өвс усаар гачигдаж өвөл хаврын улиралд бэлчээрээр өл залгаж чадахгүй зутран турж, үй олноороо хорогдоход хүргэх цаг уурын нөхцөл бүрдэхийг хэлнэ. | | | |
| 9 | Аянга цахилгаан | Үүлний хооронд болон үүл газрын гадаргуу хооронд үүсэх цахилгаан цэнэгийн ниргэлгээ | | | |

Ой хээрийн түймэр аянга цахилгаанаас болж гарах тохиолдол нийт түймрийн шалтгааны 10 хүрэхгүй хувийг эзэлдэг. Тиймээс бид хөдөө явах, аялж зугаалахдаа ил гал гаргахгүй байхад л нийт түймрийн 90 хувийг гаргахгүй байж болох нь.

Хөрсний гулгалт, хөрсний нуралт, үерт өртөх байдлыг нэмэгдүүлдэг зүйл юу вэ?

Жишээ нь: Хүчтэй салхи шуурга болоход айлын байшингууд болон сургуулийн дээвэр нурж унах эрсдэлийг бууруулахын тулд дээврийг найдвартай аюулгүй, арга хэлбэрээр барих, мөн галд тэсвэртэй бат бөх материал ашиглан барьж болно. Мөн ой модыг тайрах, устгахаа зогсоовол хөрсний нуралт тохиолдох магадлалыг бууруулна.Хүмүүс голд хог хаяхгүй, цэвэр байлгаснаар тухайн орон нутагт үерийн аюул болох эрсдэлийг бууруулаад зогсохгүй урт хугацаандаа нөхцөл байдлыг дээрдүүлдэг гэх мэтээр багш төрөл бүр дээр сурагчдын гаргасан санааг дүгнэнэ.

## БАРИМТ (Багшид зориулав)

| |
|---|
| Байгаль орчны яамны 2003, 2008 онд хийсэн усны тооллогын мэдээнээс харахад нийтдээ 3580 булаг ширгэсэн байна. Жишээлбэл, Өвөрхангай аймагт 171 булаг ширгэсэн тоо гарсан байна. *(Орхоны хөндийн бэлчээрийн судалгаа, 2011 он)* |
| Монгол улсын бэлчээрийн газар нутгийн 70% -аас илүү нь талхлагдаж бэлчээрийн ургац 20-30% буурсан гэж үзэх болсон. *(Орхоны хөндийн бэлчээрийн судалгаа, 2011 он)* |
| Улсын хэмжээнд явуулсан гадаргын усны тооллого бүртгэлээр 2003 онд нийт 5565 гол горхи тоологдсоноос 683 гол горхи хатаж ширгэн усгүй болсон. 2007 онд 5121 гол горхи тоологдсоноос 887 гол горхи ширгэж усгүй болжээ. Эндээс харахад Монгол орны гадаргын усны нөөцийн хомсдол ихээхэн хурдацтай явагдаж байгаа нь харагдаж байна. *(Хүн байгалийн хүйн холбоог хамгаалах нь, гарын авлага, 2012 он)* |
| Сүүлийн 6 жилд 53 удаа түймэр гарч, 2307686 га талбайг хамран 3125440438 төгрөгийн хохирол учруулжээ. *(ОБЕГ, Гамшиг судлалын хүрээлэнгийн судалгаа, 2012 он)* |

### ***<u>Ажлын хуудас 2: Та санал нийлэх үү.</u>***

| АСУУЛТ | Тийм | Үгүй | Мэдэхгүй | Яагаад |
|---|---|---|---|---|
| Борооны хэмжээ багасаж хааяа нэг орсон бороо нь маш хүчтэй, богино хугацаанд ширүүн ороод өнгөрдөг. | | | | |
| Хаврын улирал хуурай, хүйтэн, зун ер нь сэрүүхэн, хэсэгхэн хугацаанд маш их халдаг болсон. Намар сэрүүсэж өвлийн улирал тогтворгүй болсон. Хэт хүйтэрч хэт дулаарч байгаа. | | | | |
| Гол нуурын усны түвшин мэдэгдэхүйцээр багассан. Зарим жил ширгэж урсахаа ч больсон. | | | | |
| Намайг бага байхад олон янзын гоё гоё цэцэг ургадаг байсан. Өвс ногоо миний өвдөгнөөс дээгүүр татаад л. Ногоон зүлэг яг дэлгэсэн хивс шиг. Үнэхээр сайхан байжээ. *(Эмээгийн ярианаас)* | | | | |
| Орчин үеийн техник технологи, хурдтай хөгжил, суурьшилт, хотжилт, үйлдвэржилт, уул уурхайн олборлолт зэрэг хүний амьдралыг хөнгөвчлөх зорилготой салбаруудаас үүдэлтэй байгаль орчны доройтол бий болоод байна. | | | | |
| Бид бүгд л нэг дэлхийд амьдарч нэг агаар мандлаар амьсгалж байгаа шүү дээ. | | | | |
| Дэлхийн дулаарал уур амьсгалын өөрчлөлтийг өдөөж өгдөг. Өөрөөр хэлбэл агаарын дундаж температур нэмэгдсэнээр байгаль дэлхийн горимд өөрчлөлт ордог. | | | | |
| Дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст цас мөсөн бүрхүүл хайлж байна. | | | | |
| Олон тооны булаг ширгэж, улмаар жижиг голууд усгүй болж түүгээр тэжээгддэг том голуудын ус татарч, гадаргын усны нөөцөд сөрөг нөлөө үзүүлж байна. | | | | |
| Уул уурхайн салбараас үүдэлтэй газрын гадаргын эвдрэл, олон салаалсан эмх цэгцгүй шороон зам, ашиглалтын нөөцөөс нь хэтрүүлсэн усны хэрэглээ зэрэг нь газар доорх усны нөөцийн хомсдолыг үүсгэж байна. | | | | |
| Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй бусад улс оронд хүнсний хомсдол үүсэж байна. | | | | |
| Бэлчээр хомсдож мал аж ахуй эрхлэхэд хүндрэлтэй болж байна. | | | | |

***Ажлын хуудас 3: Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хувь нэмрээ оруулъя.***

Нүүрс хүчлийн хийн ($CO_2$) ялгаруулалтыг бууруулахад айл өрх бүр юу хийж чадах вэ?

| Эрчим хүч хэмнэх үйл ажиллагаа | Нэг өрх айлын хувьд $CO_2$-ийг бууруулах боломж, (кг/жилд) |
|---|---|
| Гар ажиллагаатай зүлэг тэгшлэгч хэрэглэвэл | 40 |
| Дахин хэрэглэх, дахин боловсруулан ашиглах боломжтой баглаа боодол, бүхий эд зүйл худалдан авбал | 110 |
| Халуун усыг хэмнэлттэй зарцуулахын тулд бага гоождог шүршүүр суурилуулбал | 150 |
| Ердийн улайсдаг гэрлийг цахилгаан бага зарцуулдаг сүүн гэрлээр соливол | 250 |
| Ахуйн угаалгад халуун усны оронд бүлээн юм уу, хүйтэн ус хэрэглэвэл | 240 |
| Нарны энерги ашиглан ус халаадаг төхөөрөмж суурилуулбал | 360 |
| Хэрэглэсэн бичгийн болон хатуу цаас, шил төмөр гэрийнхээ хогийг ангилан хаясан тохиолдолд | 400 |
| Долоо хоногт 2 удаа машингүй явган явах, дугуй унах, эсвэл нийтийн тээврийн хэрэгслээр зорчвол | 700 |
| Байшингийнхаа хана таазыг амьдарч байгаа газрынхаа уур амьсгалаас шалтгаалан дулааны эсвэл хүйтний алдагдал багатай тусгаарлагч ашиглан баривал | 2000 |
| Гэрийнхээ ойр орчимд мод тарьж, дулаан уур амьсгалтай газар амьдарч байгаа бол дээврээ цайвар өнгөөр, хүйтэн уур амьсгалтай газар амьдарч байгаа бол дээврээ бараан өнгөөр будсан тохиолдолд | 2500 |

***Багшид өгөх нэмэлт мэдээлэл***

Улс нийгэм, сум орон нутаг, айл өрх яагаад өртөмтгий болдог вэ?

- Байгалийн гамшигт үзэгдэл, аюулт үзэгдэлд удаа дараалан нэрвэгдэх
- Аливаа өөрчлөлтийг урьдчилан харж, тооцоогүйгээс гарз хохирол амсаж гүн цочролд орох
- Өөрт байгаа нөөц боломжоо хадгалж хамгаалаагүйгээс
- Мэдсээр байж тоомжиргүй, хэнэггүйгээсээ болж өртөх
- Мэдлэг, туршлага дутмагаас
- Өмнөх сургамжийг ажил хэрэг болгоогүйгээс
- Өртөмтгий байдалд хүрсэн тохиолдолд учрах аюул занал юу байх вэ?
- Байгаль дэлхийн үр өгөөж муудаж хүн, нийгмийн амьдралыг тэтгэх чанараа бага багаар алдах
- Биологийн олон янз байдал алдагдах
- Хүнд ээлтэй бус зүйл довтлон давамгайлах хандлагатай болно.
- Байгаль дэлхий өөрөө өөрийгөө нөхөн сэргээдэг чадамжаа алдана.
- Бидний зүгээс эдгээр аюул заналыг яаж сааруулах вэ?
- Цаг үеийн явцад нутгийн хувьсан өөрчлөгдөж байгаа онцлогийг ойлгох
- Нутаг орныхоо баялгийг ариглах, хамгаалах, сэргээх, бүтээх гэсэн нутгийн сэтгэлгээг түшиж цаашид түүнийг хөгжүүлэх
- Өөрт байгаа боловч дайчлагдаагүй нөөц бололцоог дайчлах
- Ардын арга ухаанд тулгуурлах, эргэн судлах
- Нутгийн хүмүүсийн сэтгэлгээ ба хандлагын өөрчлөлтийг таньж мэдэх
- Шинэлэг арга туршлага, оновчтой санаа санаачилгаас суралцаж амьдралд хэрэгжүүлэх
- Нутгийн түншлэл, хамтын ажиллагааны олон янзын хэлбэрийг оновчтой ашиглан үр ашгийг нь хүртэх
- Уул уурхайг хариуцлагатай, хяналттай болгох
- Голын эх, булаг шандыг хамгаалах, голын эхэнд олборлолт явуулахгүй байх
- Бэлчээр, усаа хамгаалах бүлэг нөхөрлөлийг зохион байгуулалтад оруулах

# 4.4. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 4.4. А. БАГА БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАГИЙН ТХБ-Д ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Дэлхий нийтээрээ боловсролыг хүмүүнлэг үзэл баримтлал болон хүний эрх, эрх чөлөө, нэр төр, нийгмийн шударга ёсыг эрхэмлэн үзэж, үндэстэн, угсаатны болон хэл, соёлын ялгаатай байдлыг ухамсарлан ойлгож, эрх тэгш байдлаар хамтран оршихдоо байгаль, нийгэм, эдийн засгийн тогтолцоог бүхэлд нь авч үзэж түүнийг үйлдэл, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгарч байна.

Хичээл, судлагдахуунаар шинжлэх ухааны мэдлэг, ойлголттой болж түүнийгээ хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар сурах, хийх бүтээх арга барилыг эзэмшихээс гадна өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох, асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаа санаачлах, зохион байгуулахад оролцох, нөлөөлөх зэргээр нийгэмшиж өөрийгөө хөгжүүлэхдээ өвчин эндэгдэл, ядуурালгүй, хүний эрх, эрх чөлөөг хангасан, үндэсний соёл, уламжлал, ёс заншлаа өөрийн зан үйл болгосон, боловсролыг эрхэм болгодог, сурч мэдсэн зүйлээ амьдралд хэрэглэх чадвартай, монгол хүн гэдгээрээ бахархдаг, ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог, үүрэг, хариуцлагатай, ухамсартай, хүмүүнлэг, бусадтай хамтран ажиллаж чадах шударга иргэн болж төлөвшихөд /ТХЗ/ чиглэгдэнэ. Үүнийг сургуулийн бага наснаас нь эхлэх бөгөөд дан ганц хичээл, сургалтаар хангах боломжгүй тул сургалтыг дэмжих үйл ажиллагаа /СДҮА/ түүний дотор хичээлээс гадуурх үйл ажиллагаа дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй юм.

БШУЯ-ны сайдын 2014 оны 08 сарын 04-ний өдрийн 01 дүгээр тушаалаар 2014-2015 оны хичээлийн жилээс бага боловсролын сургалтын Цөм хөтөлбөрийг үндэсний түвшинд хэрэгжүүлэхтэй холбогдуулан боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, үзэл санаа, зорилго, зорилт, агуулга, арга зүй, хүчин зүйлс болон тогтвортой хөгжлийн зорилгын үзэл санаа зэрэг нь судлагдахуунд суурилсан сургалт (багшийн заах, номлох үйл ажиллагаа голлосон)-аас илүүтэйгээр сургалтыг дэмжих үйл ажиллагаагаар хэрэгжих боломжтой гэдэг нь харагдаж байна.

Тогтвортой хөгжлийн зорилгод хувь нэмэр оруулах үүднээс бага боловсролын хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхдээ дараах зарчим баримтална.

*Нийтлэг зарчим:*

- Үндэсний эрх ашгийг дээдэлж, уламжлал ба шинэчлэлийг хослуулсан байх
- Тогтвортой хөгжлийн болон STEAM боловсрол, хүний эрхийн үзэл санааг тусгасан байх
- Орон нутгийн болон сургуулийн бие даасан байдал, онцлогтой уялдсан байх
- Иргэн хүн болж төлөвшихөд үр дүн нь чиглэсэн байх
- Хүүхэд бүрийн оролцоог хангасан байх

*Хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулахад баримтлах зарчим*

- Тухайн насны оролцогчдын нас, бие, сэтгэц, хөгжлийн онцлогт нийцсэн байх
- Оролцогч бүрийн авьяас, сонирхол, чадвар, хувийн онцлог шинжийг нээн илрүүлэх, дэмжих, хөгжүүлэх арга зүйд суурилан уян хатан төлөвлөх, зохион байгуулах
- Агуулга, хэлбэр нь залгамж холбоотой, Интеграц нь шинжлэх ухааны үндэстэй байх
- Үйл ажиллагаа нь байнгын тасралтгүй, үр дүнтэй байх
- Үр дүн нь хичээл судлагдахуунаар олж авсан шинжлэх ухааны мэдлэгийг амьдралд хэрэглэх чадвар эзэмшүүлэх, бүтээлчээр сурах арга барилд суралцахад дэмжих, туслахад чиглэсэн, зөв хандлагатай иргэн төлөвшүүлэхэд чиглэгдсэн байх
- Үйл ажиллагааны зохион байгуулалт нь суралцагчийг хөгжүүлэхэд чиглэсэн байх /уралдаан, өрсөлдөөн, “уралдуулах”, “түрүүлэх”-д чиглэгдсэн биш байх/
- Зохион байгуулагчийг зөв сонгох/Үйл ажиллагааны зорилго, агуулгаас шалтгаалан зохион байгуулагч хэн ч байж болно./
- Хүүхэд бүрийн оролцоог хангах
- Боловсролын болон сургуулийн бодлого, чиглэлийг дэмжсэн байх
- Үнэлгээ нь хүүхдэд гарах ахиц, дэвшил, оролцоогоор тооцогддог байх

## Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт хичээлээс гадуурх үйл ажиллагааны зорилго, хэлбэр, зохион байгуулалт, загвар, үнэлгээ бүхий 12 ажил, үйл ажиллагаа тусгасан байна. Үүнийг зорилго, чиглэл, ач холбогдлоор нь нэгтгэн 5 бүлэг болгож тэдгээрт холбогдох үйл ажиллагааны зорилт, чиглэлийг тодорхойлж ТХЗБ-ын суралцахуйн зорилт, түүнд хүрэх сэдэвтэй хэрхэн уялдаж болохыг шинжлэв.

*ХГҮА ба ТХЗБ-ын холбогдсон байдал (тоогоор)*

| ТХЗ | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТХ303.ЗҮ1 | | | 2 | | | | | | | | | | | | | | | |
| ТХ304.ЗҮ5 | | | | 1 | | | | | | | | | | | | | | |
| ТХ304.НСХ2 | | | | 1 | | | | | | | | | | | | | | |
| ТХ304.ЗҮ4 | | | | 2 | | | | | | | | | | | | | | |
| ТХ305.ТМ1 | | | | | 1 | | | | | | | | | | | | | |
| ТХ311.ТМ3 | | | | | | | | | | | 1 | | | | | | | |
| ТХ317.НСХ3 | | | | | | | | | | | | | | | 1 | | | |
| ТХ315.НСХ5 | | | | | | | | | | | | | | | | | | |
| ХГҮА | | | 1.1<br>1.3 | 2.1, 4.5<br>3.2, 3.1 | 1.5 | | | | | | 4.3 | | | | 5.3 | | 5.1 | **10** |
| Сэдэв | | | 03<br>09 | 07,08<br>07, 01 | 01 | | | | | | 08 | | | | 05 | | 09 | |

Хүснэгтийн тайлбар: ТХ-ын 3-р зорилт ХГҮА-ны 1.1,1.3-тай., 4-р зорилт ХГҮА-ны 2.1, 4.5, 3.2, 3.1-тэй., 5-р зорилт ХГҮА-ны 1.5-тай., 11-р зорилт ХГҮА-ны 4.3-тай.,15-р зорилт ХГҮА-ны 5.3-тай., 17-р зорилт ХГҮА-ны 5.1-тэй уялдаа холбоотой байна. Харин ТХЗ-ын 1, 2, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16-тай холбогдоогүй байна. Мөн танин мэдэхүйн-1, нийгэм сэтгэл хөдлөлийн-4, зан үйлийн-5 суралцахуйн зорилттой

хамааралтай байгаа нь ТХЗБ болон ХГҮА-ны холбоо хамаарлыг харуулж байна. Тогтвортой хөгжлийн сэдвийг авч үзвэл: Эрүүл мэнд, илүүдэл жин таргалалт, урлаг спорт, тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжих, 21-р зууны хэрэгцээт суурь чадвар, боловсрол нийтийн өмч, олон нийтийн үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт зэрэг сэдвүүдтэй холбогдсон байна.

Онцлон анхаарах зүйл: Эдгээр Интеграц бүхий 10 суралцахуйн зорилтыг анги тус бүрээр биш бага боловсролын түвшнээр нийтэд нь авч үзсэн болно. Мөн ерөнхий болон нийтлэг талуудын давхцал ихтэй байсан.

## Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

*ХГҮА-ны зорилт болон ТХЗБ-ын суралцахуйн зорилт, сэдвийг хэрэгжүүлэх аргын сонголт (тоогоор)*

| № | Бүлэг арга | Тоо давтамж | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр) | 10 | Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь амьдралын бодит байдалд тулгуурлан явагддаг ба энэ компанит ажил ба олон нийтээр хийгддэг. Тухайлбал: Сайн дурын болон тэмдэглэлт өдөр гм |
| 2 | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх | 2 | Үйл ажиллагаа бүрийг бүтээлч байдлаар хийхийг зорих боловч гарсан шүүмжийг хүлээн авах зөв шийдвэрлэх, хэлэлцүүлэг хийх |
| 3 | Алсын хараатай болох | 6 | Үйл ажиллагаа бүр уламжлал, шинэчлэл хоёрыг хослуулах ба ирээдүйн хөгжлийн чиг баримжаа харах, бодлогоо тодорхойлоход чиглэгдсэн байна. |

*Хүснэгт 4.13. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграц (Хичээлээс гадуурх үйл ажиллагаа)*

| Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ | Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт | Анги | | | ТХБ | | | Арга зүй | | | | | Цогц чадамж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 15 | 11 | 12 | ТХЗБ-ын суралцахуйн зорилт | ТХЗБ-ын сэдэв | Үндэслэл, тайлбар | Бодит үйл ажиллагаанд оролцох (компанит ажил, тэмдэглэлт өдөр, ....) | Шинжилгээ/ судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах) | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ....) | Алсын хараатай болох (ирээдүйг төлөвлөх шинжилгээ, утопи/утопи түүх ярих, урьдчилан төсөөлөх/ өнгөрсний нэхэн санах) | Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар / суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад/ | Код | Үндэслэл, тайлбар |
| **1** | **2** | **3** | | | **4** | **5** | **6** | **7** | | | | **8** | **9** | **10** |
| 1. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа | 15, 1.1. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа "Үдийн цай" хөтөлбөрөөр эрүүл, зөв хооллох соёлд суралцах | □ | | | ТХ303.ЗҮ1 | ТХ303.Сэ03 | "Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд суралцагчид эрүүл, зөв хооллох соёлд суралцах, эрүүл хоол хүнс сонгон (хугацаа, заавар, шошго) авах анхны мэдлэг, чадвартай болох, бусдын хийсэн хоолыг талархан идэх, хүндэтгэл үзүүлэх, гарсан бохир, хог хаягдлыг тохирох саванд ангилан хаяж хэвших Зөв хооллох нь байгаль хүрээлэн буй орчин болон бусдад үлгэр дуурайлал үзүүлэх давуу талтай. | 1 | □ | □ | | Хоол идэхийн өмнө сурагчид гараа угаах, амаа зайлах, Хоол хүнс бэлтгэн өгсөн хүмүүст талархах Эрүүл, хоол хүнс сонгох дадлага хийх Бохир, хог хаягдлыг тохирох саванд ангилан хаях талаар санамж бичиж бусдад танилцуулах | 7 | Суралцагч эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох тул-7 |
| 1. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа | 15, 1.3.Сургуулийн өдөр тутмын ажлын хүрээнд “Хөгжимт, хөдөлгөөнт гимнастик” үйл ажиллагаагаар Хүүхдийн эрүүл мэнд болон бие бялдрын хөгжлийг хангах | □ | □ | | ТХ303.ЗҮ1 | ТХ303.Сэ09 | Суралцагч хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, бие бялдраа хөгжүүлэхийн тулд, “Хөгжимт, хөдөлгөөнт гимнастик” -ийг тогтмол хийж хэвшил болгох, улмаар хөдөлгөөний эрүүл мэндийн ач тусыг ойлгож, эрүүл амьдралын зан үйлийг өөртөө болон бусдад хэвшүүлэх болгох боломжтой. | 1 | | 1 | | Хөдөлгөөний дутагдлаас үүсдэг янз бүрийн бэрхшээл (өвчин, эмгэг)-ийг жишээ баримтад тулгуурлаж ярилцах замаар хөдөлгөөний ач тусыг ойлгох , өөрийгөө эргэцүүлэх хөдөлгөөний дутагдлаас сэргийлэхэд чиглэгдсэн янз бүрийн дасгал, хөдөлгөөнийг хамтран дэглэх, зохиомжлох Түүнийгээ анги болон сургуулийн бусад сурагчдад үзүүлэх, заах, сургах | 5,7 | Илүүдэл жин ба таргалалт хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хамтаараа хийж хэвших тул-5 Эрүүл бус хоол хүнс хэрэглэхгүй байх ба үүнийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох тул-7 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа | 15, 1.5.Уншлагын цаг үйл ажиллагааны хүрээнд ном унших чадвараа хөгжүүлэх | ı | ☐ | | ТХ304.ЗҮ5 | ТХ304.Сэ01. | Суралцагч уншлагын цаг үйл ажиллагааны цагийн ном унших нь өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, эзэмшсэн ойлгосон зүйлээ өдөр тутмын амьдрал, нөхцөл байдалд хэрэглэж чаддаг болох, хөгжил, төлөвшилд нь эерэг нөлөө үзүүлэх Хүний насан туршийн тогтвортой боловсрол болдог. | 1 | | | 1 | Ном уншихын ач холбогдлыг бусдад таниулах Номын богц аян зохион байгуулах Гэрийн номын сангаа баяжуулах хэн хамгийн олон ном уншсан бэ уралдаан тэмцээн зохион байгуулах | 2 | Суралцагч бага наснаас эхлэн ном уншсанаас мэдлэг, ойлголтын хэмжээ дээшилж өдөр тутмын амьдралдаа хэрэглээ болгох тул-2 |
| 2. Урлаг спортын үйл ажиллагаа | 15, 2.1.Урлаг спортын оролцоогоор дамжуулан зөв дадал хэвшил эзэмшүүлэх т сэдэл төрүүлэх,Үнэт зүйлээ мэдрэх | ☐ | ☐ | | ТХ304.НСХ2 | ТХ304.Сэ07 | Урлаг, спортын үйл ажиллагаа нь хүний бодит оролцоон дээр тулгуурладаг бөгөөд хүүхдийн ертөнцийг үзэх үзэл, төлөвшил, харилцаа хандлага, хүндлэл, хүлээлт, итгэлцэл дээр тулгуурлан явагддаг. Энэ нь бусдад үлгэр болох, сэдэл төрүүлэх, тогтвортой хөгжихийг хөхиүлэн дэмжих, цаашлан суралцах, өөрийгөө хөгжүүлэх, суралцагчийн өөрийн авьяас чадвар, зан үйлд тулгуурлан амжилт гаргах боломжийг бүрдүүлж байдаг. | 1 | | | | Өөрийн сонирхлын дагуу дугуйланд явах, амжилтад хүрэх учраас 1-р аргыг Гаргасан амжилтынхаа талаар бусдад танилцуулах, ярилцлага хийх/сэдэл төрүүлэх/ тул 1-р аргыг Хүүхдийн төрөлх авьяас -үнэт зүйл тэмцээн зохион байгуулах учраас мөн 1-р аргыг | 7 | Өөрийнхөө урлаг, спортын талаарх авьяас, сонирхлоо илрүүлж, хөгжүүлэх тул-7 |
| 3.Ангийн ажлын хүрээнд “Ангийн хурал, цуглаан ” | 15, 3.1.Ангийн хурлаар тулгамдсан асуудлаа хэлэлцэж хамтын шийдвэр гаргах, түүнийг дагаж мөрдөх | ☐ | ☐ | | ТХ304.ЗҮ4 | ТХ304.Сэ01 | Ангийн хурлаар тулгамдсан асуудлаа хэлэлцэн шийдвэрлэхэд өөрийн үзэл бодол, саналыг илэрхийлж шийдвэрт тусгуулах, мөн бусдын санал бодлыг хүндэтгэн хүлээж авах замаар хамтын шийдвэр гаргах чадвараар хөгжүүлэх | 1 | | | | Ангийн хурал хийх дэгт суралцах Ангид тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, хурлаараа хэлэлцэж шийдвэр гаргах Хурлын шийдвэрийн биелэлтэд бүгд хяналт тавих, үнэлж дүгнэх | 5 | Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, өөрийн үзэл бодлыг бусдад тулгахгүйгээр харилцан ойлголцож хамтын шийдвэр гаргахад суралцах , тэдэнд эрх мэдэл олгох баталгаа олгох тул-5 |
| 3.Ангийн ажлын хүрээнд “Ангийн хурал, цуглаан ” | 15,3.2.Ангийн цуглаанаар гаргасан шийдвэрийн дагуу өөрийн үүргийг ухамсарлаж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах | ☐ | ☐ | | ТХ304.ЗҮ4 | ТХ304.Сэ07 | Гэнэтийн цаг үеийн асуудлаар ангийн цуглаан зохион байгуулж, түүнийг зохистойгоор шийдвэрлэж сурах хэрэгцээтэй цогц чадамж эзэмшиж эхлэх Өөрөөр хэлбэл ирээдүйд/21 зуунд/ бэлтгэгдэх. тухайлбал: Уралдаан тэмцээн, "тухайлсан" үйл ажиллагаанд оролцож хамтран ярилцаж шийдвэр гаргах, оролцох | 1 | | | 1 | Намрын спартикатад оролцох, эзэнжүүлэх Төрсөн өдөр тэмдэглэх Урлагийн үзлэг зохион байгуулах, оролцох Ангийн "авьяаслаг, спортлог, ухаалаг, тусархаг, сайхан сэтгэлтэй, ажилсаг, хүүхэд" шалгаруулах | 6 | Суралцагчид ангийн хурал цуглаанаар гарсан шийдвэртэй үнэнч байж биелүүлэх эрмэлзэлтэй, түүнийг хийх " эрх мэдэл" олгохыг хөхиүлэн дэмждэг болох-6 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4. Тэмдэглэлт өдөр | 15, 4.5.Орон нутгийн уламжлал, соёлоор бахархах, өвлөх | □ | | | ТХ305.ТМ1 | ТХ305.Сэ02 | Тэмдэглэлт өдрийн ухагдахуун, мөн чанарыг ойлгодог болох, уламжлалт үүрэг хариуцлагын тухай мэддэг болох,жендэрийг харгалзахгүйгээр нийгэм соёлын үйл ажиллагаанд оролцох | 1 | | | 1 | Тэмдэглэлт өдөр үйл ажиллагааны хүрээнд Орон нутгийн ойн баяр тэмдэглэх явцдаа орон нутгийнхаа түүхээ мэдэх, байгалийн дурсгалт газар болон амьдрах орчноо хамгаалах чадвар суралцана. Тухайлбал:Цэцэг тарих уралдаан зарлах, санаачлах, зохион байгуулах явцад үүрэг хариуцлагыг мэдэх | 4 | Анги хамт олны дунд жендэрийн харгалзаагүйгээр болон нийгэм соёлын үйл ажиллагаанд оролцох нь тухайн хүүхдийн хөгжил, нийгэмшил, төлөвшлийн үндэслэл болох тул-4 |
| 4. Тэмдэглэлт өдөр | 15.4.3.Монгол үндэсний тоглоомоор дамжуулан өв уламжлалыг сайжруулан хадгалах, хойш үедээ өвлүүлэн тогтвортой авч үлдэх | □ | | | ТХ311.ТМ3 | ТМ311.Сэ08 | Тэмдэглэлт өдрийн үйл ажиллагаагаар Монгол үндэсний ёс заншил, соёл өвийг уламжлан хойч үедээ авч үлдэх Монголын үндэсний тоглоом нь байгалийн гаралтай "эко" бүтээгдэхүүн байх бөгөөд суралцагчдын танин мэдэх, үйл ажиллагаар хөгжүүлэх, олон хүнийг хамруулж нийгмийн харилцаанд татан оролцуулдаг онцлогтой | 1 | | | 1 | Монгол үндэсний соёл, хэв маяг, ёс зан заншил, арга ухааныг харуулсан байдаг. Монголын үндэсний тоглоом нь танин мэдэхүйн, ухаарлын, бодомжийн шинжтэй, сэтгэлгээ хөгжүүлэх үндэслэлтэй учраас нас насны онцлогт тохируулан тоглох боломжтой. Тухайлбал: Оньсон болон хөлөгт тоглоомуудаар тэмцээн зохиох | 5 | Үндэсний тоглоомоор тоглох явцдаа нь тухайн улсын зан заншил, соёл, өв уламжлалаас хамтран суралцах тул-5 |
| 5. Сайн дурын үйл ажиллагаа | 15, 5.1. Бусдын сайн сайхны төлөө хийх үйлүүд | □ | | | ТХ317.НСХ3 | ТХ317.Сэ09 | Сайн дурын үйл ажиллагаа нь өөрийн хүсэл сонирхлоор оролцдог учраас тухайн хүүхдийн танин мэдэхүй, ойлголт, хүсэл зориг, аливаад хандах хандлагын илрэл бөгөөд энэ цаашдаа тогтвортой хөгжлийн ихэнх зорилтыг хэрэгжүүлэх дэмжлэг болдог. | 1 | | 1 | 1 | Сургуулийн бага насны хүүхдийн Сайн дурын үйл ажиллагаа нь хүний сэтгэлийн мөн чанарыг илэрхийлэл байдаг. Тухайлбал: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах, судлагдахууны агуулгаас хоцорсон хүүхдэд туслах, "халуун сэтгэлийн аян" зохион байгуулах | 4 | "Сайн дурын үйл ажиллагаа" нь хүний сайн сайхны төлөө, сайхан үйлс, тогтвортой хөгжлийн төлөө, үндэсний аюулгүй байдал, хамтын үйл ажиллагааны төлөө учраас үүнийг хөхиүлэн дэмжих тул-4. |
| 5. Сайн дурын үйл ажиллагаа | 15, 5.2.Сайн дурын үйл ажиллагаанд оролцож бусадтай нөхөрлөх, итгэл хүлээх, зүй зохистой хүнлэг харилцах чадвараа хөгжүүлэх | □ | | | ТХ317.НСХ4 | ТХ317.Сэ10 | Суралцагч сайн дурын үйл ажиллагаагаар дамжуулан аливаа зүйлд/ТХ3-д хүрэхийн тулд/ өөриймсөг, чин сэтгэлээс ханддаг болох Өөрийн гэсэн чадавх төлөвшиж эхлэх | 1 | | | 1 | Сайн дурын үйл ажиллагаа нь хүний өөрийн хүсэлт, өөрийн оролцоонд тулгуурладаг учраас бодит байдалд хийгддэг Тухайлбал: Өнчин хүүхдэд туслах аян. Судлагдахууны мэдлэг ойлголтын зөрүү, хоцрогдолтыг багасгахад туслах Ангийн "онцлог ялгаатай хүүхэд"-тэй чин сэтгэлээсээ харилцах, хандаж сурах | 5 | Суралцагч ТХ3-д хүрэхийн тулд аль болох бага наснаас суралцах, хэрэгжүүлэх, нийгэмших үйл ажиллагаанд оролцох чадвараа хөгжүүлэх тул-5 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. Сайн дурын үйл ажиллагаа | 15.5.3 Орон нутгийнхаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх экосистемийн талаарх ойлголт | I | | | ТХ315.НСХ5 | ТХ315.Сэ05 | Уур амьсгалын өөрчлөлтөд хог хаягдал нь хэрхэн нөлөөлдөг болохыг ойлгох, хог хаягдлыг ангилан ялгах, зөв булшлах зэргийн ач холбогдлыг ухамсарлаж суралцагч байгальтай харилцан зохицсон аж амьдралын алс хэтийн хараатай болох чадвараа хөгжүүлнэ. | 1 | | 1 | | Уур амьсгалын талаарх үндсэн ойлголт, асуудал, түүнд нөлөөлөх хүчин зүйл хог хаягдлын талаарх ойлголт түүний хор уршиг, гамшиг, түүнд хүүхэд бидний оролцоо чухал болохыг судлах<br><br>“Чихрийн цаасны дууль”-ийг “Чихрийн цаасны урлан” болгох Чихрийн цаасаар урлагийн бүтээл хийх<br><br>Хог хаягдлыг ашиглан бүтээсэн зүйлсээр тайлант үзэсгэлэн гаргах | | Стратегийн цогц чадамж Тус үйл ажиллагааны хүрээнд хүүхэд орон нутгийн болон анги танхим, орчин тойрондоо хог хаягдлаа зориулалтын саванд хийж хэвших, хоёр дахь түүхий эд гарын доорх материалаар шинэлэг, дэвшилтэд “бүтээл” хийх нь ирээдүйд зохион бүтээх чадвартай болно.<br><br>Хамтран ажиллах цогц чадамж:<br>Тус үйл ажиллагаагаар бусдаас суралцах чадвар, бусдын хэрэгцээ шаардлага, үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож, хүндэтгэх чадвар (өөрийгөө бусдын оронд тавьж ойлгох чадвар), бусдыг ойлгож, харилцан хамааралтай байж, мэдрэмжтэй хандах чадвар (сэтгэл санааны манлайлал), багаараа хамтран ажиллах, хүүхэд бүрийн оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэхэд зохицуулах чадвартай болно.<br><br>Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж:<br>Улсын болон орон нутгийн түвшинд өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох чадвар,<br>хэн бүхний үйл хэрэгт тасралтгүй үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын урам зориг хайрлах чадвар, хэн нэгний мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх чадвартай болно. |

## 4.4. Б. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ: УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД - ХҮҮХЭД БИДНИЙ ОРОЛЦОО /ХОГ ХАЯГДЛЫН ЖИШЭЭН ДЭЭР/

### Сэдэв сонгосон тайлбар, үндэслэл

Дээрх сэдэв нь сайн дурын үйл ажиллагаагаа хэлбэрээр зохион байгуулагдахаар сургалтын хөтөлбөрт тусгагдсан байна. Сайн дурын үйл ажиллагаа нь хүний өөрийн хүсэл сонирхлын дагуу, өөрийн биеэр оролцож, бусдын сайн сайхны төлөө, тэдэнд өөрийн чадах хувь нэмэр оруулахад чиглэгддэг. Тухайлбал: Сургуулийн бага наснаас эхлэн ТХЗ болох өвчин эндэгдэл, ядууралгүй байх, хүний эрх эрх чөлөөг хангасан, үндэсний соёл уламжлал, ёс заншил, орон нутаг, байгаль орчноо хамгаалсан, экосистем болон уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх сөрөг хүчин зүйлийг мэдэж амьдралд ээрэгээр хэрэгжүүлж сурах нь тухайн үйл ажиллагааны үндэслэл болно.

Хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтөд сөргөөр нөлөөлдөг байна. Тухайлбал: Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн Сайн дурын үйл ажиллагаа “Гэр бүл, анги танхим, сургуулийн орчинд болон орон нутгийн хэмжээнд хог хаягдлаа зөв зохистой булшлаагүйгээс, хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтөд сөргөөр нөлөөлдөг болохыг илрүүлэх, сурталчилгаа хийх” гэсэн суралцахуйн зорилт нь **ТХ315.НСХ5.** Суралцагч байгальтай харилцан зохицсон аж амьдралын алс хэтийн хараатай болох, **ТХ315.Сэ05**. Уур амьсгалын өөрчлөлт ба биологийн төрөл зүйлийн олон янз байдал нь нүүрсхүчлийн хийг шингээгч, гамшгийн эрсдэлийг бууруулагч болох нь гэсэн суралцахуйн зорилт, сэдэвтэй холбогдож интеграцчилагдаж байна гэж үзлээ.

Дээрх Интеграц бүхий үйл ажиллагаагаар хүүхэд дараах чадамжтай болно. Үүнд:

***<u>Стратегийн цогц чадамж</u>*** /Strategic competency/

Тус үйл ажиллагааны хүрээнд хүүхэд орон нутгийн болон анги танхим, орчин тойрондоо хог хаягдлаа зориулалтын саванд хийж хэвших, хоёр дахь түүхий эд гарын доорх материалаар шинэлэг, дэвшилтэд “бүтээл” хийх нь ирээдүйд зохион бүтээх чадвартай болно.

***<u>Хамтран ажиллах цогц чадамж</u>****:* /Collaboration competency/

Тус үйл ажиллагаагаар бусдаас суралцах чадвар, бусдын хэрэгцээ шаардлага, үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож, хүндэтгэх чадвар (өөрийгөө бусдын оронд тавьж ойлгох чадвар), **бусдыг ойлгож, харилцан хамааралтай байж, мэдрэмжтэй хандах чадвар (сэтгэл санааны** манлайлал), багаараа хамтран ажиллах, хүүхэд бүрийн оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэхэд зохицуулах чадвартай болно.

***<u>Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж</u>****:* /Self-awareness competency/

Улсын болон орон нутгийн түвшинд өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох чадвар, хэн бүхний үйл хэрэгт тасралтгүй үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын урам зориг хайрлах чадвар, хэн нэгний мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх чадвартай болно.

## Үйл ажиллагааны цагийн төлөвлөлт:

_Зорилго:_ Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг хэрэглэх, бататгах, баяжуулах, өөрийгөө танин мэдэх, нээн илрүүлэх, хөгжих явцдаа хүний эрх, эрх чөлөө, нэр төр, нийгмийн шударга ёсыг эрхэмлэн үзэж, үндэстэн, угсаатны болон хэл, соёлын ялгаатай байдлыг ухамсарлан ойлгож, эрх тэгшээр хамтран оршихдоо байгаль, нийгэм, эдийн засгийн тогтолцоог бүхэлд авч үзэж түүнийг үйлдэл, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд оршино.

***Үйл ажиллагааны цөм агуулга:***

| № | Үйл ажил-лагааны сэдэв | Цөм хөтөлбөр ба ТХ-ын суралцахуйн зорилтын Интеграц | Мэдлэг, ойлголт | Чадвар | Хандлага |
|---|---|---|---|---|---|
| 1 | " Уур амьсгал ба Хог хаягдал" | **ТХ315.НСХ5** /Суралцагч байгальтай харилцан зохицсон аж амьдралын алс хэтийн хараатай болох/ | Уур амьсгалын үндсэн ойлголт, түүнд нөлөөлөх хүчин зүйл Хог хаягдлын талаарх мэдлэг ойлголт | Уур амьсгалыг "амьд"-аар байлгах Хог хаягдлыг зориулалтын саванд хийж сурах, зөв "булшлах" чадвартай болох | Эрүүл эко орчинд, зөв сайхан амьдрах хандлага бий болох, хэвших |
| 2 | "Чихрийн цаасны дууль" /эмгэнэлт/ зохион бичлэг, зураг, уран бүтээл | **ТХ315.Сэ05** /Уур амьсгалын өөрчлөлт ба биологийн төрөл зүйлийн олон янз байдал / | Энгийн, "жижиг" хэрнээ "том" асуудал болдог гэдгийг ойлгох, ухаарах, мэдэж авах | "Чихрийн цаасны дууль"-ийг "Чихрийн цаасны урлан" болгох Чихрийн цаасаар урлагийн бүтээл хийх | Урлагийн бүтээлээ бусдад сурталчлах Боломж буй гэдгийг нээлттэй харуулах |
| 3 | "Уур амьсгал-Хог хаягдал-Хүүхэд бидний оролцоо" сэдэвт тайлант үйл ажиллагаа | **15.5.3/ ЦХС3/** / Орон нутгийнхаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх экосистемийн талаарх ойлголт/ | Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалдаг талаар мэдэх | Стратегийн цогц чадамж Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж Хамтран ажиллах цогц чадамж | Эрүүл орчин, зөв амьдрах Ирээдүйгээ харж, төлөвлөж амьдрах Хамтран ажиллах чадвар |

| Үйл ажиллагаа-1: Уур амьсгал ба Хог хаягдал | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт:** Уур амьсгалын талаарх үндсэн ойлголт, асуудал, түүнд нөлөөлөх хүчин зүйл (I),хог хаягдлын талаарх ойлголт түүний хор уршиг, гамшиг(II), түүнд хүүхэд бидний оролцоо чухал болох(III)- ыг ойлгох, зэрэг хэрэглээнд сурах мэдлэг, чадвар, хандлагатай болоход чиглэгдэнэ. | | | | | | |
| д/д | Алхам | Чадвар | Зохион байгуулагч | Арга зүй/ зохион байгуулалт | Хэрэглэгдэхүүн | Үнэлгээний шалгуур |
| 1 | Алхам1. Үндсэн ойлголт<br><br>Алхам2. Төлөвлөлт хийх | - Уур амьсгал болон та хог хаягдлын талаар үндсэн мэдлэг, ойлголттой болох, зөв зохистой хэрэглээнд суралцах<br>-ҮА-г төлөвлөхдөө цаг хугацаа баримтлах, хариуцах эзэн, биелэлт зэрэг баримтлах зарчимд суралцах | Багш Мэргэжилтэн Суралцагч /сонголттой/ | Ярилцлага, хэлэлцүүлэг хийх | Дүрт үзүүлэн, видео бичлэг, ярилцлага, кино | -**Хүүхэд бүр**ийн санал<br>-Хүүхэд бүрийн оролцоог харгалзан үзэж үнэлнэ. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Алхам3. Аргачлал боловс-руулах | Дараагийн үйл ажиллагааны бэлтгэл, хэрэглэгдэхүүн, аргачлал боловсруулах | | Багаар ажиллах | | |
| Үйл ажиллагаа-2: “Чихрийн цаасны дууль” сэдэвт зохион бичлэг(I) ба зураг(II), Ээрэг бүтээл хийх(III) | | | | | | |
| **Зорилт:** “Эрхэмсэг оршихуй Энгийнээс эхэлдэг” гэдэг шиг энгийн жижиг зүйл/асуудал/ энгүй ихээр олширч асуудал болдог. Бидний идсэн чихэр/амттан/-ийн цаас олон болж ямар асуудал үүсэж болох талаар уран сайхны зохиомжит, эмгэнэлт байдлаар зохион бичлэг бичих(I), зураг зурах(II), ээрэг байдлаар зохиомжит бүтээл хийх(III) Өөрөөр хэлбэл сургуулийн бага наснаас эхлэн байгаль эх орон, газар нутаг, эрүүл орчинд амьдрах хүний эрх эрх чөлөө, экосистем болон уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх сөрөг хүчин зүйлийг мэдэж уур амьдралд ээрэгээр хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. | | | | | | |
| 2 | Алхам1. Чиглүүлэгч: Сэдэлж-үүлэх Бичих аргачлал танилцуу-лах<br><br>Алхам2. Зохион бичлэг зураг зураг Бүтээл хийх | -Хүүхэд бүхэн чихэр идэх дуртай. Чихрийн цаасаа бид...? гэсэн асуудлыг хөндөх<br>-Бидний идсэн чихрийн цаас уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байгаа байдлаар эмгэнэлт зохион бичлэг бичих, зурах, бүтээл хийх/ээрэг/ | Багш Ангийн төлөөлөл /хүүхдийн саналаар/ | Бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээний арга<br><br>Ганцаар-чилсан, анги нийтээр | Зохион бичлэг Зураг Бүтээл<br><br>Зураг /А4 цаас/ | **Асуудлын гол санааг** гаргасан байдлаар<br><br>Агуулгыг зургаар илэрхийлсэн байдлаар Хүүхэд бүрийн санааг харгалзан үзэх**, дотоод сэтгэлээ илэрхийлж** буй байдлаар |
| Үйл ажиллагаа-3: Уур амьсгалын өөрчлөлтөд-Бидний оролцоо” сэдэвт тайлант үйл ажиллагаа | | | | | | |
| **Зорилт:** Уур амьсгалын өөрчлөлт хүний буруу үйл ажиллагаанаас болдог, үүнийг таслан зогсоох арга барилд суралцах, сөрөг үйлийг ээрэг болгоход чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэгдэнэ. | | | | | | |
| 3 | Алхам1. Тайлант үзэсгэлэнд бэлтгэх<br><br>Алхам2. Тайлант үзэсгэлэн гаргах<br><br>Алхам3. Дүгнэлт | Зохион бичлэг, зураг, Уран бүтээлийг ээрэг, сөрөг агуулгаар ангилан байршуулах | Багш Суралцагч нар | Бодит үйл ажиллагаанд оролцох<br><br>Багаар ажиллах | Зохион бичлэгийн баг Зургийн баг Уран бүтээлийн баг Тайлант үзэсгэлэн /Ангид, сургуульд/ | Судлагдахууны/ үйл ажиллагааны/ агуулгын мөн чанарыг **ойлгосон** байдлаар Ач холбогдол, хор холбогдлыг илэрхийлсэн/ бичсэн, дүрсэлсэн, бүтээсэн/ **чадвараар** Өөрийн бүтээлээ тайлбарлаж, бусдад сурталчлах, **итгэл үнэмшил** болгож “Бидний оролцоо чухал” гэсэн байр суурингаас хандаж буй **хандлагаар** үнэлэгдэнэ. |

***Дүгнэлт:***

Үйл ажиллагааг төлөвлөхдөө дараах үзэл баримтлал, эх сурвалж, суралцахуйн зорилтыг тусгалаа.

1. Дэлхий нийтийн болон Монгол улсын ТХ, ТХБ-ын хөгжлийн стратеги
2. ТХБ-ын үндсэн ойлголт, цогц чадамж, сэдвүүд
3. ТХЗБ-ын суралцахуйн зорилтууд
4. Цөм хөтөлбөрийн агуулгын хүрээ болон эзэмших чадвар
5. Бусад баримт бичгүүд

ТХЗ суралцахуйн зорилт, сэдэв, арга зүй, цогц чадамжийг цөм хөтөлбөртэй интеграцчиллаа.

Уур амьсгалын өөрчлөлтөд хог хаягдал сөрөг нөлөө, хог хаягдлыг бид өөрсдөө бий болгодог, үүнээс шалтгаалан нүүрсхүчлийн хий үүсэх, хөрс бохирдох, усны ундарга багасах нь уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйл болдог гэсэн агуулгыг багтаан авч үзлээ. Тухайлбал: Орон нутгийнхаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх экосистемийн талаарх ойлголттой болж түүнийгээ амьдралд зөв зохистой байдлаар хэрэгжүүлэх арга, арга барилд суралцах чадвар, хандлагатай болгоход чиглэгдэнэ. Үүнийг 5-р анги буюу 10 настай хүүхдийн нас бие сэтгэлзүй, оюун ухаан, танин мэдэхүйн онцлогт тохируулан зохион бичих, зурах, бүтээх хэлбэрээр гурван цагийн үйл ажиллагааг төлөвлөн авч үзлээ.

Нэгж хичээл/үйл ажиллагаа/-аар дараах чадамжтай болно. Тухайлбал:

- Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж-Systems thinking
- Урьдчилан тооцоолох цогц чадамж-Anticipatory
- Стратегийн цогц чадамж-Strategic
- Хамтран ажиллах цогц чадамж-Collaboration
- Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж-Self-awareness
- Асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамж-Integrated problem-solving

Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар уралдуулах, өрсөлдүүлэх, байр эзлүүлэх зорилго чиглэлтэй **биш** учраас хүүхэд бүр өөрийн бичсэн, зурсан, бүтээсэн бүхнээ адил тэгш эрхтэйгээр гарган тавих, илэрхийлэх боломжтой байдгаараа онцлог давуу талтай. Өөрөөр хэлбэл боловсролыг хүүхдэд тохируулах биш, хүүхдийн онцлогт боловсролыг тохируулах гэсэн зарчимд тулгуурладаг.

Үнэлгээ нь бодит байдалд ил тод, хүүхдийн бодит оролцоонд тулгуурлахаас гадна гарсан ахиц дэвшил, өөрчлөлтөөр үнэлэгддэг.

# НОМ ЗҮЙ


1. БСШУЯ. (2007-2014). Ерөнхий боловсролын 12 жилийн сургалттай сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж. УБ
2. БСШУЯ. (2014-2018). Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрүүд. УБ
3. БСШУЯ. (2014-2018). Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зөвлөмжүүд. Боловсролын хүрээлэн. http\\www.mier.mn\mn
4. UNESCO. (2017). Education for Sustainable Development Goals: Learning Objectives.

# ХАВСРАЛТ

## Хавсралт 1.

### ТХЗ-ын төлөөх боловсролын суралцахуйн зорилт

Танин мэдэхүйн, Нийгэмшил-сэтгэл хөдлөлийн, Зан үйлийн гэсэн 3 ай тус бүрийн 5, нийт 15, ТХ-ийн 17 зорилгын хувьд 255 суралцахуйн зорилтыг тодорхойлсон байна.

Энэ гарын авлагад ТХЗБ-ын суралцахуйн зорилтыг дараах зарчмаар кодолсон болно.

| Код | Түүний тайлал |
|---|---|
| ТХ301.ТМ2. | ТХ-ийн 1-р зорилгын Танин мэдэхүйн айн 2 дахь суралцахуйн зорилт |
| ТХ315.НСХ1. | ТХ-ийн 15-р зорилгын Нийгэмшил-сэтгэл хөдлөл айн 1 дэх суралцахуйн зорилт |
| ТХ310.ЗҮ5. | ТХ-ийн 10-р зорилгын Зан үйлийн айн 5 дахь суралцахуйн зорилт |

ТХЗ-ын 255 суралцахуйн зорилтыг орчуулснаа доор үзүүллээ. Ингэхдээ энэхүү Хоёр дахь хэвлэлд ЮНЕСКО-оос 2020 онд боловсруулан хэвлүүлсэн “ТХБ-2030 үйлийн хүрээ”-нд шинээр дэвшүүлсэн *ТХБ бол ТХ-ийн бүх 17 зорилгын амжилтад хүргэх боломжийг олгогч* гэсэн шинэ дүгнэлтийн товч агуулгыг ТХЗ бүрийн өмнө нэмж оруулав.

**ТХ301 ЯДУУРАЛГҮЙ БОЛОХ: Газар бүрд ядуурал, түүний бүх хэлбэрийг төгсгөл болгох**

***“ТХБ-2030”: Тогтвортой амьжиргаа эрхлэх болон баялгийн тэгш бус хуваарилалтыг шийдвэрлэхэд шаардлагатай амьдрах ур чадварыг дэмжих***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ301.ТМ1. Суралцагч туйлын (нэн) болон харьцангуй ядуурлын тухай ухагдахуун, үзэл баримтлалыг ойлгодог болж, өөрсдийн соёлын болон хэвшмэл (норматив) ойлголтууд, бодит амьдралын талаар эргэцүүлэн бодож, шүүмжлэлтэй ханддаг болох |
| | ТХ301.ТМ2. Суралцагч орон нутгийн, үндэсний, дэлхий нийтийн түвшинд хэт ядуурал болон туйлын баян чинээлэг байдлын тархалтын талаар мэддэг болох |
| | ТХ301.ТМ3. Суралцагч ядуурлын учир шалтгаан болон хор хөнөөлийн талаар, тухайлбал, баялгийн болон эрх мэдлийн тэгш бус хуваарилалт, колоничлол, зөрчил мөргөлдөөн, байгалийн хүчин зүйлээс үүдсэн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтөөс үзүүлэх нөлөөлөл, хүрээлэл орчны доройтол болон технологиос шалтгаалсан эрсдэл, нийгмийн хамгааллын тогтолцоо, түүний хэрэгжилтэд учирч буй доголдол, дутагдалтай байдал зэргийг мэддэг болох |
| | ТХ301.ТМ4. Суралцагч туйлын нэн ядуу, туйлын баян чинээлэг байдал нь хүний үндсэн эрх болон суурь хэрэгцээнд хэрхэн сөргөөр нөлөөлдөг болохыг ойлгодог болох |
| | ТХ301.ТМ5. Суралцагч ядуурлыг бууруулах стратеги, түүнийг үнэлэх хэмжилтийн талаар мэддэг болж, ядуурлыг үнэлэх “хомсдолд суурилсан (deficit-based)” болон “давуу талд суурилсан (strength-based)” гэсэн хоёр арга хандлагыг ялгаж чаддаг болох |

| | |
|---|---|
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ301.НСХ1. Суралцагч орон нутгийн олон нийтэд ногдох нөөц баялаг, эрх мэдлийн хуваарилалтыг өөрчлөхөд нөлөөлж, хувь хүн болон орон нутгийн иргэдэд боломж, эрх мэдэл олгоход бусадтай хамтран ажиллаж чаддаг болох |
| | ТХ301.НСХ2. Суралцагч туйлын нэн ядуу, туйлын баян чинээлэг байдлын тухай ойлголтыг ухуулан таниулж, тодорхой шийдлүүдийн талаарх хүмүүсийн санаа бодол, харилцан яриаг урамшуулан дэмжиж чаддаг болох |
| | ТХ301.НСХ3. Суралцагч ядуурлын асуудалд мэдрэмжтэй байгаагаа харуулж чаддаг болох Тухайлбал, ядуу болон эмзэг нөхцөлд байгаа хүмүүсийн сэтгэл санааг дэмжиж, тэдний төлөө эв нэгдэлтэй байгаагаа харуулдаг болох |
| | ТХ301.НСХ4. Суралцагч ядууралтай холбоотой өөрсдийн хувийн туршлага, буруу ташаа ойлголтыг тодорхойлж чаддаг болох |
| | ТХ301.НСХ5. Суралцагч тэгш бус байдал дэлхийн хүн амын дунд оршсоор байгаад хувь хүний зүгээс хүлээх өөрийн үүрэг, оролцоондоо шүүмжлэлтэй хандан эргэцүүлж чаддаг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ301.ЗҮ1. Суралцагч ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, өргөжүүлэн тэлэх чадвартай болох |
| | ТХ301.ЗҮ2. Суралцагч нийгэм, эдийн засгийн шударга ёсыг хангах, эрсдэлийг бууруулах, ядуурлыг устгахад тус тус чиглэсэн бодлого, стратегийг боловсруулж, тэдгээрийг үйл ажиллагааны түвшинд бүрэн хамруулахыг дэмжиж, уг асуудлаар олон нийтийн нэрийн өмнөөс шаардлага тавьж чаддаг болох |
| | ТХ301.ЗҮ3. Суралцагч орон нутгийн, үндэсний, олон улсын аж ахуйн нэгж байгууллагын ядуурлын бий болох, устгах талаар баримталж буй удирдлагын стратеги, энэ талаар гаргаж буй шийдвэрийг нь үнэлэх, түүнд оролцох, нөлөөлөх чадвартай болох |
| | ТХ301.ЗҮ4. Суралцагч өөрийн амьдралын хэрэглээний сонголтоо хийхдээ ядуурлыг бууруулах, нийгмийн шударга ёсыг хангах, авлига, хээл хахуулийг арилгах асуудал хэрхэн хамааралтай байгааг олж харж анхаарал хандуулдаг болох |
| | ТХ301.ЗҮ5. Суралцагч ядуурлын асуудалд тогтолцооны үүднээс хандан асуудал шийдвэрлэх шийдлийг санал болгож чаддаг болох |

## ТХ302 ӨЛСГӨЛӨНГ ТЭГЛЭХ: Өлсгөлөнг эцэслэж, хүнсний аюулгүй байдал, чанар, шим тэжээлийг сайжруулах, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих

***"ТХБ-2030": Өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлын шалтгаан, үр дагаврыг арилгах***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ302.ТМ1. Суралцагч өлсгөлөн, хүнс тэжээлийн дутагдал, тэдгээрийн хүнд үзүүлдэг бие бялдар, сэтгэл зүйн гол нөлөөлөл болон эдгээрт өртөмтгий эмзэг бүлгийнхний тухай мэддэг болох |
| | ТХ302.ТМ2. Суралцагч өлсгөлөн, хүнс тэжээлийн дутагдлын тухай орон нутаг, улс орон, олон улсын түвшний тоо баримт, тархалтын талаарх өнөөгийн болон өмнөх түүхийн талаар мэддэг болох |
| | ТХ302.ТМ3. Суралцагч хувь хүн, орон нутаг, үндэстэн болоод дэлхий нийтийн түвшинд өлсгөлөнг үүсгэгч хүчин зүйлс, түүний үндэс шалтгааныг мэддэг болох |
| | ТХ302.ТМ4. Тогтвортой хөдөө аж ахуйн зарчмуудыг мэддэг, түүнийг дэмжихэд шаардлагатай нөхцөл болох газар болон өмч эзэмших хууль ёсны эрхийн талаар, түүний хэрэгцээ шаардлагыг ойлгодог байх |
| | ТХ302.ТМ5. Суралцагч дэлхий нийтээр өлсгөлөн, хүнс тэжээлийн дутагдлын эсрэг тэмцэхэд тогтвортой хөдөө аж ахуй шаардлагатай болохыг ойлгож, өлсгөлөн, хүнс тэжээлийн дутагдал болон хүнсний чанарт анхаарах талаар баримталж буй бодлого стратегийг мэддэг болох |

| | |
|---|---|
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ302.НСХ1. Суралцагч өлсгөлөнтэй тэмцэх, тогтвортой хөдөө аж ахуйг хөхиүлэн дэмжих, хүнсний тэжээллэг чанар яагаад чухал болох болон тэдгээрийн хоорондох уялдаа холбоо ба нөхцөл байдлын асуудлаар харилцаж чаддаг болох |
| | ТХ302.НСХ2. Суралцагч өлсгөлөнтэй тэмцэх, тогтвортой хөдөө аж ахуйг хөхиүлэн дэмжих, хүнсний чанарыг сайжруулахад бусдад урам зориг өгөх, боломж, эрх мэдэл олгоход тэдэнтэй хамтран ажиллах чадвартай болох |
| | ТХ302.НСХ3. Өлсгөлөнгүй, хүнс тэжээлийн дутагдалгүй дэлхий ертөнцийн төлөөх алс хэтийн хараатай болох |
| | ТХ302.НСХ4. Суралцагч өөрсдийн үнэт зүйлсийн талаар эргэцүүлэн бодож, өлсгөлөн, хүнс тэжээлийн дутагдалтай тэмцэх, тогтвортой хөдөө аж ахуйг хөхиүлэн дэмжихтэй холбогдох ялгаатай үнэт зүйлүүд, хандлага, стратегийн талаар эргэцүүлэх чадвартай болох |
| | ТХ302.НСХ5. Суралцагч өлсгөлөнд нэрвэгдэж, хүнс тэжээлийн дутагдлаас шалтгаалан зовж шаналж буй хүмүүсийн сэтгэл санааг дэмжиж, хариуцлага, эв нэгдлийг мэдэрч чаддаг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ302.ЗҮ1. Суралцагчид өлсгөлөнтэй тэмцэх, тогтвортой хөдөө аж ахуйг хөхиүлэн дэмжих чиглэлээр хувь хүний болон орон нутгийнхаа түвшинд үнэлгээ хийх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх чадвартай болох |
| | ТХ302.ЗҮ2. Суралцагчид өлсгөлөн ба хүнс тэжээлийн дутагдлын эсрэг тэмцэх, тогтвортой хөдөө аж ахуйг хөхиүлэн дэмжихтэй холбоотой төрийн бодлогод хамаарах асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөх, оролцох, үнэлэх чадвартай болох |
| | ТХ302.ЗҮ3. Суралцагч өлсгөлөн ба хүнс тэжээлийн дутагдалтай тэмцэх, тогтвортой хөдөө аж ахуйг хөхиүлэн дэмжих талаар орон нутаг, үндэсний, олон улсын түвшний үйлдвэр, аж ахуйн байгууллагын удирдлагын стратегид хамаарах асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөх, оролцох, үнэлэх чадвартай болох |
| | ТХ302.ЗҮ4. Суралцагч өлсгөлөнтэй тэмцэх сорилтыг даван туулахад хувь нэмэр оруулах дэлхийн идэвхтэй иргэний үүргээ хариуцлагатайгаар биелүүлж чаддаг болох |
| | ТХ302.ЗҮ5. Суралцагч өлсгөлөнгийн эсрэг тэмцэхэд, тогтвортой хөдөө аж ахуйг хөхиүлэн дэмжихэд тус тус хувь нэмэр оруулахын тулд өөрсдийн үйлдвэрлэл болон хэрэглээндээ өөрчлөлт хийх чадвартай болох |

## ТХ303 САЙН ЭРҮҮЛ МЭНД, САЙН САЙХАН БАЙДАЛ: Эрүүл аж төрөх нөхцөлөөр хангаж, бүх насны нийт хүмүүсийн сайн сайхан байдлыг дэмжих

***"ТХБ-2030": Сэтгэлзүйн болон бие бялдрын уян хатан чанар, тэсвэр тэвчээр, сайн сайхан байдлыг хангах***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ303.ТМ1. Суралцагч эрүүл мэнд, ариун цэвэр, сайн сайхан байдлын тухай ухагдахуун, үзэл баримтлалыг мэддэг болж тухайлбал, эрүүл энх, сайн сайхан аж амьдралд жендэрийг чухалчлахын ач холбогдлыг ойлгох зэрэг эдгээр үзэл баримтлалын талаар шүүмжлэлтэй хандан эргэцүүлж чаддаг болох |
| | ТХ303.ТМ2. Суралцагч ноцтой, түгээмэл халдварт болон халдварт бус өвчний тухай, өвчлөл болон богино насалж байгаа эрсдэл ихтэй бүлэг хүмүүс, бүс нутгийн талаар тоо баримтыг мэддэг болох |
| | ТХ303.ТМ3. Суралцагч эрүүл мэнд, сайн сайхан байдлын нийгэм-улс төр-эдийн засгийн хэмжигдэхүүнийг ойлгодог болж, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих стратеги болон тэдгээрийг ухуулан сурталчлахын үр нөлөөг мэддэг болох |
| | ТХ303.ТМ4. Суралцагч сэтгэцийн эрүүл мэндийн ач холбогдлыг ойлгодог байх.Таньж мэдэхгүй буюу өөрсдөөсөө өөр хэн нэгнээс (гадаад хүмүүс байж болно) айж түгших хариу үйлдэл (xenophobia), ялгаварлан гадуурхах, бүлэглэн гадуурхаж шоовдорлох зэрэг зан үйл нь сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл хөдлөлийн сайн сайхан байдалд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг, мөн архи, тамхи болон бусад төрлийн мансууруулах бодист донтох нь эрүүл мэнд, сайн сайхан байдалд хэрхэн хор хөнөөл учруулдаг болохыг ойлгодог болох |
| | ТХ303.ТМ5. Суралцагч бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжихэд шаардлагатай урьдчилан сэргийлэх стратегиудыг тухайлбал, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга замын талаар мэддэг болох |

| | |
|---|---|
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ303.НСХ1. Суралцагч өвчнөөс шалтгаалан зовж шаналж байгаа хүмүүстэй харилцаа тогтоож, тэдний нөхцөл байдал, зовнил мэдрэмжүүдийг ойлгон мэдэрч чаддаг болох |
| | ТХ303.НСХ2. Суралцагч эрүүл мэндийн асуудлаар тухайлбал, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал, ялангуяа тэдгээрийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн урьдчилан сэргийлэх стратегиудын ач холбогдлын талаар цэц булаалдан харилцан ойлголцож чаддаг болох |
| | ТХ303.НСХ3. Суралцагч бүх нийтийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд ач тустай шийдвэр гаргаж, үйл хэрэг бүтээхэд нь бусдыг урамшуулан зоригжуулж чаддаг болох |
| | ТХ303.НСХ4. Суралцагч эрүүл мэнд, сайн сайхан байдлын тухай бүхэл бүтэн, цогц ойлголттой болж, тэдгээрт хамаарах үнэт зүйлс, итгэл үнэмшил, хандлагыг илрүүлэн тодруулж чаддаг болох |
| | ТХ303.НСХ5. Суралцагч эрүүл мэнд, нийгмийн халамжийн чиглэлээр сайн дурын ажилд оролцох, мэргэжлийн ажил эрхлэх зэргээр өөрийн болон гэр бүлийнхнийхээ, мөн бусдын эрүүл мэнд, сайн сайхан байдлын төлөө хүлээх үүрэг оролцоогоо хөгжүүлж чаддаг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ303.ЗҮ1. Суралцагч эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох |
| | ТХ303.ЗҮ2. Суралцагч эрүүл мэндийг дэмжих стратегиудыг тухайлбал, өөрийн, гэр бүлийнхний, бусдын төлөө бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, түгээн дэлгэрүүлэх чадвартай болох |
| | ТХ303.ЗҮ3. Суралцагч бусдад тусламж хэрэгтэй үед нь тэднийг мэдэрч ойлгох чадавхтай байж, өөрийн болон бусдын төлөө тусламж эрэлхийлэх чадвартай болох |
| | ТХ303.ЗҮ4. Суралцагч эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хөхиүлэн дэмжсэн бодлого боловсруулахыг олон нийтийн хамт шаардан, дэмжиж чаддаг болох |
| | ТХ303.ЗҮ5. Суралцагч боломжийн үнээр эм, эмийн бүтээгдэхүүнийг худалдан авах хүсэлтэй олон нийтийн ашиг сонирхол болон эмийн үйлдвэрийнхний хувийн ашиг сонирхол хооронд гарч болзошгүй зөрчлийг шийдвэрлэх арга замыг санал болгодог болох |

**ТХ304 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ: Хүн бүрийн тэгш оролцоо, тусгай хэрэгцээг хангахуйц (inclusive) чанартай боловсрол эзэмших шудрага нөхцөлөөр хангаж, насан туршдаа сурч боловсрох боломжийг нь хөхүүлэн дэмжих**

***“ТХБ-2030”: Суралцахуйн чанартай агуулга, түүний хүн төрөлхтний оршин тогтнох, цэцэглэн хөгжихөд оруулах хувь нэмрийг онцлон тодруулах***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ304.ТМ1. Суралцагч нь хүн төрөлхтний амьдралыг сайжруулж, тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд бүх нийтийн боловсрол ба насан туршийн суралцахуй (албан, албан бус, өдөр тутмын ахуй амьдралын суралцахуй) нь тогтвортой хөгжлийн гол залуурдагч, болохыг ойлгодог байх |
| | ТХ304.ТМ2. Суралцагч боловсрол бол олон нийтийн болоод дэлхий нийтийн өмч, хүний үндсэн эрх бөгөөд бусад эрхээ мэдэж эдлэхийн үндсэн баталгаа болохыг ойлгодог болох |
| | ТХ304.ТМ3. Суралцагч боловсролын хүртээмж, түүнээс хүртэх үр өгөөж, тухайлбал охид ба хөвгүүдийн болон хот ба хөдөөгийн хооронд тэгш бус байгааг, тэд чанартай боловсролд тэгш хамрагдах, насан туршдаа тасралтгүй суралцах боломж хомс байгаагийн шалтгааныг ойлгодог болох |
| | ТХ304.ТМ4. Суралцагч нь тогтвортой байдлыг дэмжихэд соёл чухал үүрэгтэйг ойлгодог болох |
| | ТХ304.ТМ5. Суралцагч боловсролоор дамжуулан илүү тогтвортой, эрх тэгш, энх амгалан дэлхийг цогцлоох боломжтойг ойлгодог болох |

| | |
|---|---|
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ304.НСХ1. Суралцагч нь бүх нийтийн чанартай боловсрол, боловсролын хүмүүнлэг, энэрэнгүй болон асуудлыг бүхэл бүтэн тогтолцоонд авч үзэх арга хандлага, тогтвортой хөгжлийн боловсрол болон тэдгээрт холбогдох арга хандлагын ач холбогдлыг бусдад ухуулан таниулж чаддаг болох |
| | ТХ304.НСХ2. Суралцагч нь оролцооны аргаар дамжуулан боловсрол эзэмших боломжийг шаардах, ашиглахад нь бусдыг сэдэлжүүлэн тэдэнд дэмжлэг үзүүлж чаддаг байх |
| | ТХ304.НСХ3. Суралцагч боловсролын үнэлэмж, үнэт зүйлс, ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, хувь хүнийхээ хөгжилд шаардлагатай өөрийн суралцахуйн хэрэгцээгээ шинжлэн тодорхойлж чаддаг болох |
| | ТХ304.НСХ4. Суралцагч ахуй амьдралаа сайжруулахад тухайлбал, хөдөлмөр болон бизнес эрхлэхэд өөрийнх нь ур чадвар чухал ач холбогдолтойг ойлгож хүлээн зөвшөөрдөг болох |
| | ТХ304.НСХ5. Суралцагч хувь хүнийхээ зүгээс тогтвортой хөгжлийн боловсролын үйл хэрэгт идэвхтэй оролцдог болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ304.ЗҮ1. Суралцагч бүх нийтийн чанартай боловсрол болон тогтвортой хөгжлийн боловсрол, тэдгээрт холбогдох өөр өөр түвшний арга хандлагыг хэрэгжүүлэхэд дэм тус үзүүлж, хувь нэмэр оруулж чаддаг болох |
| | ТХ304.ЗҮ2. Суралцагч боловсрол дахь жендэрийн эрх тэгш байдлыг хөхиүлэн дэмжиж чаддаг болох |
| | ТХ304.ЗҮ3. Суралцагч үнэ төлбөргүй, тэгш боломжийг бүрдүүлсэн бүх нийтийн чанартай боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол болон тэдгээрт холбогдох арга хандлагууд түүнчлэн боловсролын аюулгүй, хүртээмжтэй, хүн бүрийн тусгай эрэлт хэрэгцээ ба оролцоог хангасан (inclusive) хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хангалтыг тус тус хөхиүлэн дэмжсэн бодлого боловсруулахыг олон нийтийн хамт шаардан, дэмжиж чаддаг болох |
| | ТХ304.ЗҮ4. Суралцагч хүүхэд залуучуудад боломж, эрх мэдэл олгохыг хөхиүлэн дэмжиж чаддаг болох |
| | ТХ304.ЗҮ5. Суралцагч амьдралынхаа туршид өөрийн боловсролын төлөө бүхий л боломжийг ашиглаж чаддаг болж, тогтвортой хөгжлийг дэмжихийн төлөө эзэмшсэн мэдлэгээ өдөр тутмын нөхцөл байдалд хэрэглэж чаддаг болох |

## ТХ305 ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ: Жендэрийн тэгш байдалд амжилт олох, охид, эмэгтэйчүүдэд эрх мэдэл, боломж олгох

***"ТХБ-2030": Жендэрийн тэгш байдлыг, ялангуяа тогтвортой байдлын жендэрийн тодорхой сорилтуудыг даван туулахыг урамшуулан дэмжих***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ305.ТМ1. Суралцагч жендэр, жендэрийн тэгш байдал, жендэрийн ялгаварлан гадуурхлын тухай ухагдахуун, үзэл баримтлалыг ойлгодог болж, бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхал, хүчирхийлэл, тэгш бус байдал (эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг засах, гэр бүлийн нэр хүнд гутаасан нэрийдлээр амь насыг нь бүрэлгэх, хүүхэд насанд нь гэрлүүлэх, хөдөлмөр эрхлэх тэгш бус нөхцөл боломж ба цалин хөлс, зориудаар зохиосон хэл яриа (language construction), жендэрийн тухай уламжлалт үүрэг хариуцлага, байгалийн гамшгийн жендэрт үзүүлэх нөлөөллийн тухай мэддэг болох. Мөн жендэрийн тэгш бус байдлын өнөөгийн болон түүхэн учир шалтгааныг ойлгодог болох |
| | ТХ305.ТМ2. Суралцагч нь охид эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн мөлжлөг, хүчирхийллээс ангид байх эрх чөлөө болон нөхөн үржихүйн эрх зэргийг багтаасан үндсэн эрхийн тухай ойлгодог болох |
| | ТХ305.ТМ3. Суралцагч өөрийн улс орон болон ахуй соёл дахь жендэрийн тэгш бус байдлын түвшинг дэлхийн хэм хэмжээтэй харьцуулах замаар тухайлбал, жендэр нь ур чадвар, шашин, арьс өнгөний үзэл зэрэг нийгмийн бусад ангилал зэрэглэлтэй холбоотой болохыг ойлгодог болох |
| | ТХ305.ТМ4. Суралцагч нь улсын төсвийн хуваарилалт, хөдөлмөрийн зах зээл, төрийн болон хувийн салбарын шийдвэр гаргалт зэрэг хууль тогтоох, засаглах үйл явцад жендэрийн эрх тэгш байдал, оролцоог бүрэн хангахын учир шалтгаан, ашиг тус, боломж бололцоог мэддэг болох |
| | ТХ305.ТМ5. Суралцагч хүйсийн тэгш оролцоог хангаж, тэднийг эрх мэдэлтэй болгоход нь технологи эзэмших, хууль тогтоох боломж олгодог боловсролын үүргийг ойлгодог болох |

| | |
|---|---|
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ305.НСХ1. Суралцагч ахуй соёлын мэдрэмжүүдийг хүндэтгэхийн зэрэгцээ жендэрийн үүрэг хариуцлагын тухай уламжлалт ойлголтод шүүмжлэлтэй хандан эргэлзэхийг хүлээн зөвшөөрдөг байх |
| | ТХ305.НСХ2. Суралцагч жендэрийн ялгаварлан гадуурхлын бүх хэлбэрийг тодорхойлж, тэдгээрийн эсрэг дуу хоолойгоо хүргэж, бүх жендэрийн хүмүүст бүрэн дүүрэн боломж, эрх мэдэл олгохын ашиг тусыг хэлэлцэн мэтгэлцэж чаддаг болох |
| | ТХ305.НСХ3. Суралцагч жендэрийн ялгаварлан гадуурхал, хүчирхийллийг зогсоохоор, эрхийг нь хааж боогдуулсан хүмүүст дэмжлэг үзүүлэхээр, түүнчлэн бүх түвшинд хүндлэл, бүрэн дүүрэн эрх тэгш байдлыг бий болгохоор тус тус ажиллаж буй хүмүүстэй холбоо тогтоож чаддаг болох |
| | ТХ305.НСХ4. Суралцагч өөрийн жендэрийн онцлог, жендэрийн үүргийнхээ талаар эргэцүүлж чаддаг болох |
| | ТХ305.НСХ5. Суралцагч жендэр, үүрэг оролцооны талаарх хувийн болон олон нийтийн тогтсон үзэл бодлоос өөрөөр амьдарч буй хүмүүсийн сэтгэл санааг ойлгож, эв нэгдэлтэй байж чаддаг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ305.ЗҮ1. Суралцагч жендэрийн чиг хандлагаас болоод ялгаварлан гадуурхагдаж буй хүмүүсийг эсвэл өөрийгөө дэмжүүлэхийн тулд эргэн тойрныхондоо хандсан арга хэмжээ авч чаддаг болох |
| | ТХ305.ЗҮ2. Суралцагч жендэрийн эрх тэгш байдал, оролцооны талаар гаргасан шийдвэрт үнэлгээ өгөх, оролцох, нөлөөлөх чадвартай болох |
| | ТХ305.ЗҮ3. Суралцагч нь жендэр хоорондын ойлголцлыг нэмэгдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхал, хүчирхийллийг зогсооход оролцож, бусдыг дэмжиж чаддаг болох |
| | ТХ305.ЗҮ4. Суралцагч жендэрийн ялгаварлан гадуурхлыг ажиглан судалж, түүнийг тодорхойлж чаддаг болох |
| | ТХ305.ЗҮ5. Суралцагч жендэрийн тэгш байдлыг дэмжсэн стратегиудыг төлөвлөх, хэрэгжүүлэх, дэмжих, үнэлэх чадвартай болох |

**ТХ306 ЦЭВЭР УС БА АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ: Бүх нийтийг усны нөөц ба ариун цэврийн байгууламжийн хүрэлцээтэй, тогтвортой менежментээр хангах**

***"ТХБ-2030": Дэлхий нийтийн сайн сайхны төлөөх зохих шаардлага хангасан усны тэгш хүртээмжийг хурдасгах***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ306.ТМ1. Суралцагч ус нь амьдралыг тэтгэгч үндсэн нөхцөл болох тухай болон усны чанар, тоо хэмжээний ач холбогдол, усны бохирдол, хомсдолын учир шалтгаан, нөлөө, үр дагаврын тухай ойлголттой болох |
| | ТХ306.ТМ2. Суралцагч ус нь дэлхийн түвшний олон тооны нарийн нийлмэл харилцан хамаарал болон тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг гэдгийг ойлгодог болох |
| | ТХ306.ТМ3. Суралцагч дэлхийн хүн амд ундны усны аюулгүй байдлын хангамж, ариун цэврийн байгууламж, тэдгээрийн хүртээмж харилцан адилгүй тэгш бус хуваарилагдсан байгааг мэддэг болох |
| | ТХ306.ТМ4. Суралцагч "виртуал ус" гэдэг ойлголт, үзэл баримтлалыг ойлгодог болох |
| | ТХ306.ТМ5. Суралцагч усны нөөцийн нэгдсэн менежмент (УННМ) болон үер, ган гачгийн эрсдэлийн менежмент зэрэг усны ба ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ, тогтвортой менежментээр хангах зорилготой бусад стратегийн талаар ойлгодог болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ306.НСХ1. Суралцагч нь орон нутгийн хэмжээнд ус ба ариун цэврийн байгууламжийн менежментийг сайжруулах үйл ажиллагаанд оролцож чаддаг болох |
| | ТХ306.НСХ2. Суралцагч усны бохирдол, хүртээмж, ус хэмнэх арга хэмжээний асуудлаар бусадтай харилцаа холбоо тогтоож, амжилт дагуулсан түүхийг илрүүлэн тодруулж чаддаг болох |
| | ТХ306.НСХ3. Суралцагч нь усны өөрийн хэрэглээг хянаж, хариуцлагаа мэдэрч чаддаг болох |
| | ТХ306.НСХ4. Суралцагч ариун цэвэр эрүүл ахуйн сайн, зөв стандарттай байхын үнэ цэнийг олж харж чаддаг болох |
| | ТХ306.НСХ5. Суралцагч нь ундны ус ба ариун цэврийн байгууламжийн тэгш бус хүртээмжид нийгэм-эдийн засгийн байр суурь болон хүйсийн, жендэрийн ялгаа нь тодорхой хэмжээгээр нөлөөлөх хүчин зүйл болж байгааг ойлгож чаддаг болох |

| | |
|---|---|
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ306.ЗҮ1. Суралцагч орон нутаг нь усны болон ариун цэврийн байгууламжийн хэрэгцээг өөрсдөө хангахуйц чадавхтай болоход орон нутгийн удирдлагуудтай хоршин ажиллаж чаддаг болох |
| | ТХ306.ЗҮ2. Суралцагч орон нутгийнхаа түвшинд усны нөөцийн менежментэд хувь нэмэр оруулж чаддаг болох |
| | ТХ306.ЗҮ3. Суралцагч усны хувийн хэрэглээ дэх ул мөрөө багасгаж, ус хэмнэх дадал зуршилтай болж, түүнийгээ өдөр тутмын ажил амьдралдаа хэвшүүлдэг болох |
| | ТХ306.ЗҮ4. Суралцагч усны чанар, аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулахуйц үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, түгээн дэлгэрүүлэх чадвартай болох |
| | ТХ306.ЗҮ5. Суралцагч орон нутгийн, үндэсний, олон улсын бизнесийн байгууллагын усны бохирдлын менежментийн стратегийн шийдвэрт үнэлгээ өгөх, оролцох, нөлөөлөх чадвартай болох |

## ТХ307 БОЛОМЖИЙН ҮНЭТЭЙ, ЦЭВЭР ЭРЧИМ ХҮЧ: Бүх нийтийг боломжийн үнэтэй, найдвартай, тогтвортой, цэвэр эх үүсвэр бүхий эрчим хүчээр хангах *“ТХБ-2030”: Тогтвортой, цэвэр, боломжийн үнэтэй эрчим хүч болон ногоон амьдралын хэв маягийг идэвхижүүлэн дэмжих*

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ307.ТМ1. Суралцагч сэргээгдэх болон үл сэргээгдэх эрчим хүчний нөөцийн тухай, тэдний харьцангуй давуу болон сул талууд тухайлбал, тэдгээрийн хүрээлэл орчин ба эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдал, эрчим хүчний хүрэлцээ хангамж болон орон нутгийн, үндэсний, дэлхий нийтийн түвшинд эдгээр эрчим хүчний төрлүүдийн эзлэх хувь зэргийг мэддэг болох |
| | ТХ307.ТМ2. Суралцагч дэлхийн өнцөг булан бүрд ямар эрчим хүчийг гол төлөв ашигладгийг мэддэг болох |
| | ТХ307.ТМ3. Суралцагч эрчим хүчний үр ашигтай байх, өөрийн хэрэгцээг хангах тухай ухагдахуун, үзэл баримтлалыг ойлгож, энэ чиглэлээр баримталж буй бодлого, нийгэм-технологийн урт хугацааны шийдлүүдийн талаар мэддэг болох |
| | ТХ307.ТМ4. Суралцагч эрчим хүчний үйлдвэрлэл, эрэлт, нийлүүлэлт, хэрэглээг өргөжүүлэн хөгжүүлэхэд бодлого, стратеги хэрхэн нөлөөлдгийг ойлгодог болох |
| | ТХ307.ТМ5. Суралцагч эрчим хүчний үр ашиг багатай, хор нөлөө ихтэй үйлдвэрлэлийн тухай мэддэг байж, сэргээгдэх эрчим хүчний технологи нь тогтвортой хөгжлийг хэрхэн жолоодохыг мөн шинэ, дэвшилтэт технологи, ялангуяа улс орнууд хооронд яагаад технологи шилжүүлж хамтран ажиллах ёстой хэрэгцээ шаардлагыг ойлгодог болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ307.НСХ1. Суралцагч эрчим хүчний өөрийн хэрэгцээг хангах, хэрэглээ нь үр ашигтай байх шаардлагыг таниулан мэдээлж чаддаг болох |
| | ТХ307.НСХ2. Суралцагч бусад хүмүүс, улс орон, бүс нутаг дахь боломжийн үнэтэй, найдвартай, тогтвортой, цэвэр эрчим хүчний хэрэгцээг ойлгож, үнэлж чаддаг байх |
| | ТХ307.НСХ3. Суралцагч эрчим хүчний технологийг янз бүрийн хам нөхцөлд шилжүүлэн нутагшуулах, өөрсдийн орон нутгийн эрчим хүчний хэрэглээний сайн туршлагыг бусдад түгээхэд тэдэнтэй хоршиж, хамтран ажиллаж чаддаг болох |
| | ТХ307.НСХ4. Суралцагч эрчим хүчний үйлдвэрлэл ба ашиглалтын талаар хувь хүний хэм хэмжээ, үнэт зүйлсийг тодруулж, үр ашиг, дотоодын хэрэгцээг хангах гэсэн ойлголтын хүрээнд эрчим хүчний хэрэглээнийхээ талаар эргэцүүлж, үнэлж чаддаг болох |
| | ТХ307.НСХ5. Суралцагч өөрийн орны эрчим хүчний найдвартай, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээ, нийлүүлэлтийн талаар алс хэтийн хараагаа хөгжүүлж чаддаг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ307.ЗҮ1. Суралцагч өөрийн хувийн хүрээлэл дэх эрчим хүчний үр ашиг, өөрийн хэрэгцээг хангах болон тухайн орон нутгийнхаа эрчим хүчний холимог эх үүсвэрүүдээс сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг тус тус нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, үнэлэх чадвартай болох |
| | ТХ307.ЗҮ2. Суралцагч тухайн нөхцөл байдал тохирсон сэргээгдэх эрчим хүчний хамгийн тохиромжтой стратегийг тодорхойлон ажиллах зарчмуудыг хэрэглэж чаддаг болох |
| | ТХ307.ЗҮ3. Суралцагч нь янз бүрийн сонирхлын бүлгүүдийн хувьд (байгаль орчин мөн хамаарна) эрчим хүчний томоохон төслүүд (далай, тэнгист салхин парк байгуулах гэх мэт) болон эрчим хүчний талаар баримталж буй бодлогын урт хугацааны үр дагаврыг задлан шинжилж чаддаг болох |
| | ТХ307.ЗҮ4. Суралцагч эрчим хүчний үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээтэй холбоотой төрийн бодлогод нөлөөлж чаддаг болох |

| | |
|---|---|
| | ТХ307.ЗУ5. Суралцагч эрчим хүчний шийдлийн хувилбарыг олохын тулд бизнесийн янз бүрийн загварууд, тэдгээрт тохиромжтой эрчим хүчний шийдлийг харьцуулан үнэлж, аюулгүй, найдвартай, тогтвортой эрчим хүчийг үйлдвэрлэхэд нь эрчим хүчний нийлүүлэгчдэд нөлөөлж чаддаг болох |

## ТХ308 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ: Эдийн засгийн тасралтгүй, хүмүүсийн тусгай хэрэгцээгээ хангах тэгш оролцоог дэмжсэн (inclusive), тогтвортой өсөлт болон орон тооны, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

***“ТХБ-2030”: Эргэн ашиглагддаг, хүрэлцэхүйц хангалттай, жудагтай, эв этэй байх амьдралын хэв маягийн олон хувилбарт үнэт зүйлс, эдийн засгийн загварыг хөхиүлэн дэмжих***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ308.ТМ1. Суралцагч тасралтгүй, хүмүүсийн тусгай хэрэгцээ, тэгш оролцоог хангасан (inclusive), тогтвортой эдийн засгийн өсөлт, орон тооны, бүтээмжтэй ажил эрхлэлт болон зохистой ажил эрхлэлт тухайлбал, жендэрийн харьцаа ба тэгш боломжид ахиц гаргахын ач холбогдол зэрэг ухагдахуун, үзэл баримтлалыг ойлгох, эдийн засгийн бусад сонголтууд бүхий загварууд, индикаторууд талаар мэддэг болох |
| | ТХ308.ТМ2. Суралцагч дэлхийн янз бүрийн бүс, улс оронд салбар бүрийн албан хөдөлмөр эрхлэлтийн түвшин, албан бус хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл тус бүрийн тархалт, мөн нийгмийн аль бүлэг нь ажилгүйдэлд онцгойлон илүү өртдөг тухай мэддэг болох |
| | ТХ308.ТМ3. Суралцагч хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн өсөлт хоорондын харилцан хамаарлыг ойлгож, ажиллах хүчийг нэмэгдүүлэх, эсвэл ажлын байрыг орлох шинэ технологи нэвтрүүлэх зэрэг энэхүү харилцан хамааралд нөлөөлөх бусад хүчин зүйлсийг мэддэг байх |
| | ТХ308.ТМ4. Суралцагч тэгш бус байдал, ядуурал, нийгмийн тайван бус байдлыг үүсэхэд нөлөөлдөг ажиллах хүчин урт цагаар ажилласан ч бага цалин хөлс авдаг, гэтэл менежер (захирал), өмчийн эзэн, хувьцаа эзэмшигчдийн цалин, ашиг нь асар өндөр байдаг нөхцөл байдал байсаар байгааг ойлгодог болох |
| | ТХ308.ТМ5. Суралцагч инноваци, хувиараа бизнес эрхлэлт, шинээр ажлын байр бий болгох зэрэг нь зохистой ажлын байр болон тогтвортой хөгжилд хөтөлсөн эдийн засгийг хэрхэн бий болгодог, эдгээр нь эдийн засгийн өсөлтөд байгалийн гамшиг, хүрээлэл орчны доройтол, түүнээс үзүүлэх хор уршиг, нөлөөллийг арилгахад хэрхэн хувь нэмэр оруулдгийг тус тус ойлгодог болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ308.НСХ1. Суралцагч эдийн засгийн загвар болон эдийн засаг, нийгмийн алс хэтийн ирээдүйд шүүмжлэлтэй хандан хэлэлцэж, олон нийтэд түгээн танилцуулж чаддаг болох |
| | ТХ308.НСХ2. Суралцагч ажил олгогч болон улс төрчдөөс нэг ижил ажил хөдөлмөрт шударга, эрх тэгш хандахыг тухайлбал, шударга цалин хөлс, хөдөлмөрлөх эрх шаардаж буй хүмүүстэй хамтран ажиллаж чаддаг болох |
| | ТХ308.НСХ3. Суралцагч дэлхийн эдийн засгийн хүрээнд хүмүүсийн хэрэглээ хэрхэн бусад олон хүмүүсийн ажиллах нөхцөлд нөлөөлж байдгийг ойлгож чаддаг болох |
| | ТХ308.НСХ4. Суралцагч өөрийн хувь хүний эрхээ тодорхойлж, ажил хөдөлмөртэй холбоотой хэрэгцээ, үнэт зүйлсээ илрүүлэн тодруулж чаддаг болох |
| | ТХ308.НСХ5. Суралцагч өөрийн хувийн цогц чадамж, тухайн нөхцөл байдалдаа хийсэн задлан шинжилгээнд тулгуурлан хувийн амьдралынхаа эдийн засгийн алс хэтийн хараа болон төлөвлөгөө боловсруулж чаддаг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ308.ЗҮ1. Суралцагч хүн бүрийн оролцоог хангаж, тэдэнд ашиг тус хүртэх тэгш боломж олгосон (inclusive), тогтвортой эдийн засаг ба зохистой ажил эрхлэлтийн хэтийн шинэ төлөв, загваруудад татагдан оролцож чаддаг болох |
| | ТХ308.ЗҮ2. Суралцагч шударга бус цалин, нэг ижил ажилд тэгш бус цалин хөлс олголт, ажлын муу орчин нөхцөлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж чаддаг болох |
| | ТХ308.ЗҮ3. Суралцагч тогтвортой байдалд хөтөлсөн инновац ба аж ахуй, бизнес эрхлэлтийн сэдэл, шинэ санааг хөгжүүлэн, үнэлж чаддаг болох |
| | ТХ308.ЗҮ4. Суралцагч бизнес эрхлэх төслүүдийг төлөвлөж, хэрэгжүүлж чаддаг болох |
| | ТХ308.ЗҮ5. Суралцагч байгалийн гамшиг, хүрээлэл орчны доройтлын нөлөөллөөс үйлдвэрлэлийг хамааралгүй болгох хүчин чармайлт болон ажлын шударга нөхцөлийг дэмжих арга хэрэгсэл болохуйцаар өөрийн хэрэглээг хариуцлагатай байлгах шалгууруудыг мэдэж, хэрэглэж чаддаг болох |

**ТХ309 ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦ, ДЭД БҮТЭЦ: Дэд бүтцийг байгуулж, хүмүүсийн тусгай хэрэгцээгээ хангах, тэгш оролцоог бүрдүүлсэн (inclusive) тогтвортой үйлдвэржилтийг дэмжих, инновацыг тэтгэх**

***"ТХБ-2030": Ногоон технологи, тогтвортой үйлдвэрлэлийн үл алагчилагдсан шудрага шилжилтийг хөхиүлэн дэмжих***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ309.ТМ1. Суралцагч тогтвортой дэд бүтэц, үйлдвэрлэлийн үзэл баримтлал болон тэдгээрийг хөгжүүлэхэд шаардлагатай тогтолцоот арга хандлагыг чухалчлах нийгмийн хэрэгцээг ойлгодог болох |
| | ТХ309.ТМ2. Суралцагч нь дэд бүтэц, үйлдвэрлэлийн тогтвортой байдалд хүрэхэд орон нутаг, улс үндэстэн болон дэлхий нийтэд тохиолдож буй сорилт бэрхшээл, зөрчил маргааныг ойлгодог болох |
| | ТХ309.ТМ3. Суралцагч модульчлал, олон янз байдал зэрэг түлхүүр ухагдахууныг ойлгон мэдэж, дэд бүтэц, орон зайн төлөвлөлтийн уян хатан чанар (resilience) гэж юу болохыг тодорхойлж, түүнийг орон нутаг, үндэсний хэмжээнд хэрэглэж чаддаг болох |
| | ТХ309.ТМ4. Суралцагч тогтвортой бус үйлдвэрлэлийн урьдчилан тооцоологүй сул талуудын зэрэгцээ аливаа саад, сорилтыг даах уян хатан, хүмүүсийн тусгай хэрэгцээг хангасан, тогтвортой үйлдвэрлэлийн жишээ, онцгой байдлын үеийн төлөвлөлт хэрэгтэй байдгийг тус тус мэддэг байх |
| | ТХ309.ТМ5. Суралцагч урт хугацаанд тогтвортой байх инновац бүхий уян хатан чанартай дэд бүтэц, үйлдвэрлэлийн хөгжлийн төлөөх шинэ боломжууд, зах зээлийн талаар мэддэг болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ309.НСХ1. Суралцагч өөрийн орон нутагтаа тогтвортой, хүмүүсийн тусгай хэрэгцээг хангасан, уян хатан, өндөр чанартай дэд бүтцийг бий болгохын төлөө тэмцэх |
| | ТХ309.НСХ2. Суралцагч оршин суугаа орон нутгийнхаа дэд бүтэц, үйлдвэрлэлийн хөгжлийг илүү тогтвортой, уян хатан болгохын төлөө нутгийн иргэдийг урамшуулан зоригжуулж чаддаг болох |
| | ТХ309.НСХ3. Суралцагч байнга хувьсан өөрчлөгдөж буй сорилтуудад хариу өгөх, мөн шинэ зах зээл нээхийн тулд орон нутгийнхаа онцлогт тохирсон, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр хамтрах түншлэгчдээ олж тодорхойлж чаддаг болох |
| | ТХ309.НСХ4. Суралцагч нүүрстөрөгч, ус, хүнс тэжээл зэрэг экологийн ул мөрөө тодорхойлж, орон нутгийн дэд бүтцэд хувийн зүгээс үзүүлэх эрэлт болон нөлөөллөө хүлээн зөвшөөрч, эргэцүүлэн тусгадаг болох |
| | ТХ309.НСХ5. Суралцагч байгалийн баялгийн нөөц, түүнд гарч буй өөрчлөлт (газрын тосны оргил үе буюу хамгийн их хэмжээтэй олборлолт болон баялгийн бусад оргил үе), гадаад хүчин зүйлсийн дарамт, нөлөөлөл (байгалийн гамшиг, зөрчил мөргөлдөөн гэх мэт)-ыг дагаад дэд бүтцийн талаарх хувь хүний үзэл бодол, эрэлт хэрэгцээ нь мэдээлэл харилцааны технологи, тээврийн болон эрүүл ахуйн сонголтууд зэрэгт зориулсан сэргээгдэх эрчим хүчний хүрэлцээнээс хамааран үндсээрээ өөрчлөгдөх шаардлагатайг ойлгодог болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ309.ЗҮ1. Суралцагч өөрийн үндэстэн ба соёлын дэд бүтцийг илүү ногоон, байгальд ээлтэй, уян хатан байлгах арга хандлагууд болон тэдгээрийн нийгэмд үзүүлэх бүхий л ашиг тусыг, нэн ялангуяа гамшгийн эрсдэлийг бууруулахад үзүүлэх ашиг тусын тухай ойлголтыг бий болгох боломжуудыг тодорхойлж чаддаг болох |
| | ТХ309.ЗҮ2. Суралцагч үйлдвэрлэлийн янз бүрийн хэлбэрүүдэд үнэлгээ өгч, тэдгээрийн уян хатан чанарыг нь харьцуулж чаддаг болох |
| | ТХ309.ЗҮ3. Суралцагч өөрийн улс орныхоо үйлдвэрлэлийн хэрэгцээг хангах тогтвортой бизнесийг санаачилж, хөгжүүлж чаддаг болох |
| | ТХ309.ЗҮ4. Суралцагч өөрсдийн бизнесийг дэмжих зорилгоор зээл, бичил зээл гэх мэт санхүүгийн үйлчилгээ авч чаддаг болох |
| | ТХ309.ЗҮ5. Суралцагч тогтвортой дэд бүтцийн (интернэтэд холбогдох гэх мэт) ашиглалтыг сайжруулахад шийдвэр гаргагчидтай хамтран ажиллаж чаддаг болох |

## ТХ310 ТЭГШ БУС БАЙДЛЫГ БАГАСГАХ: Улс орнуудын дотоод дахь болон улс орнуудын дундах тэгш бус байдлыг багасгах

### *"ТХБ-2030": Тэгш бус байдлын бүх хэлбэртэй тэмцэх, ялангуяа хүрээлэл орчны хууль зүйн шудрага байдалд онцгой анхаарах*

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ310.ТМ1. Суралцагч тэгш бус байдлын янз бүрийн хэмжээсүүд, тэдгээрийн хоорондох харилцан хамаарал, хэрэгцээтэй статистик тоо баримтуудын тухай мэддэг болох |
| | ТХ310.ТМ2. Суралцагч нь тэгш бус байдлыг хэмжиж, тодорхойлдог индикаторуудыг мэдэж, шийдвэр гаргахад хэрхэн хэрэглэдгийг ойлгодог болох |
| | ТХ310.ТМ3. Суралцагч тэгш бус байдал бол нийгмийн асуудлуудыг үүсгэж, хувь хүнийг сэтгэл ханамжгүй байдалд хүргэдэг шалтгаан болохыг ойлгодог болох |
| | ТХ310.ТМ4. Суралцагч орон нутгийн, үндэсний, дэлхийн түвшний тэгш байдалд эрсдэл учруулдаг болон дэмжиж байдаг үйл явцууд (санхүүгийн, цалингийн, нийгмийн хамгааллын бодлого, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа гэх мэт)-ын талаар мэддэг болох |
| | ТХ310.ТМ5. Суралцагч тэгш байдлыг дэмждэг ёс зүйн зарчмуудыг ойлгож, ялгаварлан гадуурхдаг зан араншин, шийдвэр гаргалтыг өөгшүүлдэг сэтгэлзүйн үйл явцуудыг ухамсарладаг болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ310.НСХ1. Суралцагч тэгш бус байдлын тухай олон нийтийн ухамсрыг дээшлүүлж чаддаг болох |
| | ТХ310.НСХ2. Суралцагч ялгаварлан гадуурхагдсан хүмүүсийн сэтгэл санааг мэдэрч, ялгаварлан гадуурхахын эсрэг байгаа хүмүүстэй эв нэгдэлтэй байгаагаа харуулж чаддаг болох |
| | ТХ310.НСХ3. Суралцагч хамтын үнэт зүйлс, ёс зүйн зарчмуудад үндэслэн янз бүрийн бүлгүүдийн эрхийн асуудлаар зөвшилцөн хэлэлцээр хийж чаддаг болох |
| | ТХ310.НСХ4. Суралцагч өөрийн эргэн тойрондоо болон дэлхийн хэмжээнд тохиолдож буй тэгш бус байдлын талаар ухаарч, асуудал дагуулсан үр дагаврууд байгааг хүлээн зөвшөөрч чаддаг болох |
| | ТХ310.НСХ5. Суралцагч шударга ёс, тэгш боломж бүхий дэлхийг цогцлоох алс хэтийн хараатай болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ310.ЗҮ1. Суралцагч өөрийн орон нутгийн хүрээлэл орчинд тохиолдож буй тэгш бус, шударга бус байдалд чанарын (ялгаатай хэд хэдэн чиглэлээр, хувь хүнд учруулах чанарын нөлөөлөл) болон тоон (индикаторууд, хувь хүнд учруулах тоон нөлөөлөл) үнэлгээ хийж чаддаг болох |
| | ТХ310.ЗҮ2. Суралцагч тэгш бус байдлын тухайд янз бүрийн бүлгүүд, улс орнуудыг харьцуулахын тулд объектив бодит индикаторыг тодорхойлж, боловсруулж чаддаг болох |
| | ТХ310.ЗҮ3. Суралцагч тэгш бус байдлыг бий болгодог үндэслэл, шалтгааны олон төрлийг тодорхойлон шинжилж чаддаг болох |
| | ТХ310.ЗҮ4. Суралцагч тэгш бус байдлыг багасгах стратегиудыг төлөвлөж, хэрэгжүүлж, үнэлж чаддаг болох |
| | ТХ310.ЗҮ5. Суралцагч тэгш бус байдлыг багасгах зорилготой төрийн бодлого боловсруулах болон хамтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд итгэл үнэмшилтэйгээр оролцож чаддаг болох |

**ТХ311 ТОГТВОРТОЙ ХОТ СУУРИН БА ОРШИН СУУГЧИД: Хот суурин болон суурьшмал хүн амын амьдралыг тэдний тусгай хэрэгцээнүүд, тэгш оролцоог хангахуйц (inclusive), аюулгүй, уян хатан, тогтвортой болгох**

***“ТХБ-2030”: Хувирган өөрчлөлт бүрэн утгаараа хэрэгжүүлэх гол талбар болох хотууд олон нийтийн байгууллагуудыг шийдвэрлэх үүргээ гүйцэтгэхэд нь туслах***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ311.ТМ1. Суралцагч нь хүний материаллаг, сэтгэлзүйн, нийгмийн суурь хэрэгцээг ойлгож, тэдгээр хэрэгцээг өөрийнх нь хот, хотын захын хороолол, хөдөөгийн сууринд тус тус хэрхэн хангагдсаныг тодорхойлж чаддаг болох |
| | ТХ311.ТМ2. Суралцагч нь өөрийн болон бусад суурин газрын тогтвортой байдлын тогтолцоо тухайлбал, хоол хүнс, эрчим хүч, тээвэр, ус, усны цэвэршүүлэлт, аюулгүй байдал, тусгай эрэлт хэрэгцээг хангасан байдал, хүртээмжтэй байдал, боловсрол, ногоон орчныг бүрдүүлсэн байдал, гамшгийн эрсдэл бууруулсан байдлын хэрэгцээг хэрхэн хангаж байгааг үнэлж, харьцуулж чаддаг болох |
| | ТХ311.ТМ3. Суралцагч суурин амьдралын хэв маягийн түүхэн шалтгааныг ойлгож, соёлын өв уламжлалыг хүндэтгэхийн сацуу сайжруулсан, тогтвортой тогтолцоог хөгжүүлэхийн тулд зөвшилцөлд хүрэх хэрэгтэйг ойлгодог болох |
| | ТХ311.ТМ4. Суралцагч тогтвортой төлөвлөлт, барилгажилтын суурь зарчмуудыг мэддэг байж, өөрсдийн амьдарч буй газраа илүү тогтвортой, тусгай хэрэгцээ ба тэгш оролцоо нь хангагддаг (inclusive) болгох боломж бололцоог тодорхойлж чаддаг болох |
| | ТХ311.ТМ5. Суралцагч орон нутгийн шийдвэр гаргагчдын болон оролцоонд тулгуурласан засаглалын гүйцэтгэх үүргийг, түүнчлэн өөрсдийн оршин буй газрынхаа хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тогтвортой байдлын дуу хоолойгоо хүргэж байхын ач холбогдлыг ойлгодог байх |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ311.НСХ1. Суралцагч орон нутгийнхаа төлөвлөлтийн тогтолцоо дахь нийтэд зориулсан бүтээн байгуулалт, үйл ажиллагааны эхлэлийн үеийг тодорхойлох ба ашиглах, өөрсдийн оршин буй газартаа тогтвортой дэд бүтэц, байшин барилга, цэцэрлэгт хүрээлэн барихад хөрөнгө оруулалт татах, урт хугацааны төлөвлөлтийн давуу талын талаар мэтгэлцэхэд тус тус өөрсдийн дуу хоолойгоо хүргэж чаддаг болох |
| | ТХ311.НСХ2. Суралцагч оршин суугаа нутгийнхаа олон нийтийн тогтвортой ирээдүйн талаарх алсын харааг хөгжүүлэхэд олон нийтийн бүлгүүдэд зориулан биечлэн болон онлайнаар холбогдож туслалцаа үзүүлж чаддаг болох |
| | ТХ311.НСХ3. Суралцагч өөрсдийн онцлогоо хөгжүүлэхдээ тухайн нутгийнхаа байгаль, нийгэм, технологийн үүрэг зориулалт болон тэдгээрийг бүтээсэн, бүтээж байгаа соёл, өвөрмөц зүйлсээ ухааран ойлгож, бүс нутгийнхаа талаар эргэцүүлж чаддаг болох |
| | ТХ311.НСХ4. Суралцагч орон нутгийн болон дэлхий нийтийн аль алиных нь тогтвортой суурьшлын төлөө өргөн цараатай экосистемийн чадавхын хүрээнд өөрсдийн хэрэгцээг холбон тодорхойлж чаддаг болох |
| | ТХ311.НСХ5. Суралцагч өөрийн амьдралын хэв маягийн хүрээлэл орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөлд хүлээх хариуцлагаа мэдэрч чаддаг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ311.ЗҮ1. Суралцагч орон нутгийнхаа олон нийтэд суурилсан тогтвортой хөгжлийн төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх чадвартай болох |
| | ТХ311.ЗҮ2. Суралцагч орон нутгийн олон нийтэд хамаарах асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцон шийдвэрт нөлөөлж чаддаг болох |
| | ТХ311.ЗҮ3. Суралцагч орон нутгийнх нь олон нийтийн төлөө гаргасан шийдвэрийг дэмжих эсвэл эсэргүүцэхээ илэрхийлж чаддаг, мөн дэмжсэн эсвэл эсэргүүцсэн дуу хоолойгоо нэгтгэн зохион байгуулалтад орж чаддаг болох |
| | ТХ311.ЗҮ4. Суралцагч өөрсдийн тусгай эрэлт хэрэгцээ, тэгш оролцоог хангасан (inclusive), аюулгүй, уян хатан, тогтвортой орон нутгийг хамтран бүтээлцэж чаддаг болох |
| | ТХ311.ЗҮ5. Суралцагч орон нутгийн түвшинд нүүрсхүчлийн хийн ялгарлыг хамгийн бага байлгах арга хандлагад дэмжлэг үзүүлж чаддаг болох |

## ТХ312 ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ БА ҮЙЛДВЭРЛЭЛ: Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн хэв шинжийг хангах

***“ТХБ-2030”: Үйлдвэрлэл, хэрэглээний соёлыг хувирган өөрчлөх***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ312.ТМ1. Суралцагч хувийн амьдралын хэв маягийн сонголт нь нийгэм, эдийн засаг, хүрээлэн орчны хөгжилд хэрхэн нөлөөлдгийг ойлгодог болох |
| | ТХ312.ТМ2. Суралцагч үйлдвэрлэл, хэрэглээний хэв шинж, өртгийн сүлжээ, бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба хэрэглээ хоорондын харилцан хамаарал (эрэлт ба нийлүүлэлт, хортой бодис, нүүрсхүчлийн хийн ялгаруулалт, хог хаягдал, эрүүл мэнд, ажлын нөхцөл байдал, ядуурал гэх мэт)-ын талаар ойлгодог болох |
| | ТХ312.ТМ3. Суралцагч бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба хэрэглээнд оролцон тоглогч олон талууд (хэвлэл мэдээлэл ба сурталчилгаа, аж ахуйн нэгж байгууллагууд, нутгийн засаг захиргаанд, хууль эрх зүй ажилтнууд, хэрэглэгчид гэх мэт)-ын эрх, чиг үүрэг, хариуцлагын талаар мэддэг болох |
| | ТХ312.ТМ4. Суралцагч тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээний стратегиуд, практик туршлагуудын талаар мэддэг болох |
| | ТХ312.ТМ5. Суралцагч тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийг амжилтад хүргэхэд тогтолцооны өөрчлөлт шаардлагатайг, мөн ямар сонголт хийх, юуг яаж сольж өөрчилж болох талаар ойлгодог болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ312.НСХ1. Суралцагч үйлдвэрлэл ба хэрэглээнд тогтвортой практик туршлага хэрэгтэйг бусдад таниулан сурталчилж чаддаг болох |
| | ТХ312.НСХ2. Суралцагч хэрэглээ, үйлдвэрлэлийн тогтвортой практик туршлагыг бүтээлцэхэд бусдыг дэмжин урамшуулан зоригжуулж чаддаг болох |
| | ТХ312.НСХ3. Суралцагч хэрэгцээ болон хүслийг ялгаж чаддаг болж, унаган төрхөөрөө байх дэлхий ертөнц, бусад хүмүүс, соёл, улс орон, ирээдүйн залгамж үеийнхний бүх хэрэгцээг бодолцох замаар хувийн хэрэглээ, зан үйлийнхээ талаар эргэцүүлж чаддаг болох |
| | ТХ312.НСХ4. Суралцагч тогтвортой амьдралын хэв маягийн талаар урьдчилан төсөөлж чаддаг болох |
| | ТХ312.НСХ5. Суралцагч нь үйлдвэрлэгч ба хэрэглэгч болохынхоо тухайд хувийн амьдралын хэв маяг нь хүрээлэл орчин, нийгэмд хэрхэн нөлөөлж буйд хариуцлага хүлээж буйгаа мэдэрдэг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ312.ЗҮ1. Суралцагч тогтвортой байдлын өнөөгийн шалгуурыг ашиглан хэрэглээтэй холбоотой үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх чадвартай болох |
| | ТХ312.ЗҮ2. Суралцагч төрийн салбар дахь худалдан авалтын асуудлаар шийдвэр гаргах үйл явцад үнэлгээ хийх, оролцох, нөлөөлөх чадвартай болох |
| | ТХ312.ЗҮ3. Суралцагч тогтвортой үйлдвэрлэлийн хэв шинжийг хөхиүлэн дэмжиж чаддаг болох |
| | ТХ312.ЗҮ4. Суралцагч зах зээлийн идэвхтэй оролцогч тал болохынхоо хувьд өөрийн гүйцэтгэх үүрэгтээ шүүмжлэлтэй хандаж чаддаг болох |
| | ТХ312.ЗҮ5. Суралцагч нь хэрэглээ ба үйлдвэрлэл дэх нийгэмд тогтсон үзэл бодол, соёлын чиг баримжааны талаар асуудал дэвшүүлж чаддаг байх |

## ТХ313 УУР АМЬСГАЛЫН ТӨЛӨӨХ ҮЙЛ ХЭРЭГ: Уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөлөлтэй тэмцэх яаралтай арга хэмжээ авах

***“ТХБ-2030”: Боловсролыг сайжруулах, мэдлэг ухамсарыг дээшлүүлэх, хүний болон байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх***

| | | |
|---|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ313.ТМ1. | Суралцагч хүлэмжийн хийн тусгаарлагч давхаргаас үүссэн байгалийн үзэгдэл болох хүлэмжийн хийн нөлөөллийг ойлгодог болох |
| | ТХ313.ТМ2. | Суралцагч өнөөгийн уур амьсгалын өөрчлөлт нь хүлэмжийн хийн ялгарлыг ихэсгэхэд хүргэсэн хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан үзэгдэл болохыг ойлгодог болох |
| | ТХ313.ТМ3. | Суралцагч дэлхий нийт, улс үндэстэн, орон нутаг, хувь хүний түвшин дэх хүний үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нөлөө үзүүлдгийг мэддэг болох |
| | ТХ313.ТМ4. | Суралцагч орон нутгийн, үндэсний, дэлхий нийтийн экологи, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд уур амьсгалын өөрчлөлт хэрхэн нөлөөлж,ямар үр дагавар үзүүлж буйг мэддэг болж, эдгээр үр дагавар нь эргээд уур амьсгалын өөрчлөлтийг эрчимжүүлэн түргэсгэгч хүчин зүйл болдгийг ойлгодог болох |
| | ТХ313.ТМ5. | Суралцагч гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн, хувь хүнээс дэлхий нийт хүртэлх бүх түвшинд, мөн ялгаатай өөр өөр нөхцөл байдалд хэрэгжүүлэх шаардлагатай урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, дасан зохицох стратегиудыг мэддэг болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ313.НСХ1. | Суралцагч экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэн орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг болох |
| | ТХ313.НСХ2. | Суралцагч уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад бусдыг урамшуулан дэмжиж чаддаг болох |
| | ТХ313.НСХ3. | Суралцагч нь нийтээрээ хүлээн зөвшөөрсөн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх стратегийг боловсруулж бусадтай хамтран ажиллаж чаддаг болох |
| | ТХ313.НСХ4. | Суралцагч орон нутгийн болон дэлхий нийтийн түвшний алс хэтийн төлөвийг харж, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд хувь хүний зүгээс үзүүлж болох нөлөөллийг ойлгож чаддаг болох |
| | ТХ313.НСХ5. | Суралцагч дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, хамгаалах нь хүн бүрийн өдөр тутмын үндсэн үүрэг болохыг түүнчлэн энэ хүрээнд өөрсдийн ертөнцийг үзэх үзэл болон өдөр тутмын зан үйлээ дахин үнэлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч чаддаг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ313.ЗҮ1. | Суралцагч хувийн болон ажил хэрэгтэй холбоотой үйл ажиллагаа нь уур амьсгалд ээлтэй эсэхийг үнэлж, хэрэв ээлгүй бол үйл ажиллагаагаа өөрчилж чаддаг болох |
| | ТХ313.ЗҮ2. | Суралцагч уур амьсгалын өөрчлөлтөд өртөж буй хүмүүсийн тусын тулд үйлдэл хийж чаддаг болох |
| | ТХ313.ЗҮ3. | Суралцагч хувь хүн, орон нутаг, үндэсний хэмжээний шийдвэр ба үйл ажиллагаа нь бусад хүн, дэлхийн бусад бүс нутагт ямар нөлөөлөл үзүүлэхийг урьдчилан таамаглах, тооцоолох, үнэлэх чадвартай болох |
| | ТХ313.ЗҮ4. | Суралцагч уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, хамгаалах төрийн бодлогыг дэмжиж чаддаг болох |
| | ТХ313.ЗҮ5. | Суралцагч уур амьсгалд ээлтэй эдийн засгийн үйл ажиллагааг дэмжиж чаддаг болох |

## ТХ314 УСАН ДООРХ АМЬДРАЛ: Тогтвортой хөгжлийн төлөө далай, тэнгис, эрэг хавийн газрын *нөөцийг хадгалан хамгаалах ба тогтвортой ашиглах*

## *“ТХБ-2030”: Далай судлалын бичиг үсэгт тайлагдсан үйлээр дамжуулан далай тэнгисийн нөөцийг хамгаалах*

| | |
|---|---|
| Сулцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ314.ТМ1. Суралцагч далайн ёроолын үндсэн экологи, экосистем, араатан-идэш (predator-prey) хоорондын харилцан хамаарлыг ойлгодог болох |
| | ТХ314.ТМ2. Суралцагч нь олон хүн далайгаас хамааралтай амьдардгийг, түүнчлэн хүмүүс далай тэнгисийн амьдралтай холбогдсоноор тэдэнд хүнс тэжээл, ажлын байр болон сэтгэл догдлом боломжууд олгодог далай тэнгисийн үүрэг зориулалтыг ойлгодог болох |
| | ТХ314.ТМ3. Суралцагч уур амьсгалын өөрчлөлтийн урьдач нөхцөл болж улмаар уур амьсгалд далайн гүйцэтгэх үүргийн талаар мэддэг болох |
| | ТХ314.ТМ4. Суралцагч бохирдол, загасны хэт их агналт зэрэг нь далайн экосистемд аюул занал учруулдгийг ойлгодог, түүнчлэн шүрэн хад, далайн ёроол дахь хүчилтөрөгчгүй үхлийн бүс зэрэг далайн маш олон экосистемийн харьцангуй эмзэг байдлыг тайлбарлаж чаддаг болох |
| | ТХ314.ТМ5.Суралцагч далай тэнгисийн амьд нөөцийг тогтвортой ашиглах боломжуудыг мэддэг болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ314.НСХ1. Суралцагч тогтвортой загасчлалын практик туршлагыг хэлэлцэн мэтгэлцэж чаддаг болох |
| | ТХ314.НСХ2. Суралцагч далайд үзүүлэх хүний хүчин зүйлийн нөлөөлөл (биомассын алдагдал, хүчилжих, бохирдол гэх мэт) болон эрүүл, цэвэр далайн үнэ цэнийг хүмүүст үзүүлж таниулж чаддаг болох |
| | ТХ314.НСХ3.Суралцагч далайн бүтээгдэхүүний тогтворгүй үйлдвэрлэл ба хэрэглээнд оролцдог бүлэг этгээдэд нөлөөлж чаддаг болох |
| | ТХ314.НСХ4. Суралцагч далайн хүнсний хязгаарлагдмал нөөцийг хоол хүнсэндээ тогтвортой ашиглах дадал зуршилтай эсэх талаар асуудал дэвшүүлж, өөрсдийн хоол хүнсний хэрэгцээний талаар эргэцүүлж чаддаг болох |
| | ТХ314.НСХ5. Суралцагч загасчлах практик туршлагын өөрчлөлт ахуй амьдралд нь нөлөөлсөн хүмүүст анхаарал хандуулж чаддаг болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ314.ЗҮ1. Суралцагч өөрийн улс орны далай, тэнгисээс хамааралтай байх байдлыг судалж чаддаг болох |
| | ТХ314.ЗҮ2. Суралцагч загас агнуурын тоо хэмжээнд хатуу квот тогтоох эсвэл устах аюулд өртсөн загасны төрөл зүйлийг агнахыг хориглох зэрэг загасчлалын тогтвортой аргуудын талаар мэтгэлцэж чаддаг болох |
| | ТХ314.ЗҮ3. Суралцагч тогтвортойгоор өсгөж үржүүлсэн тухайлбал, баталгаажуулсан эко шошготой далайн бүтээгдэхүүнийг тодорхойлох, үнэлэх, худалдан авах чадвартай болох |
| | ТХ314.ЗҮ4. Суралцагч загасны хэт агнуур нь орон нутгийнхны амьжиргаанд хэрхэн сөргөөр нөлөөлдөг талаар холбогдох төлөөллүүдтэй холбоо тогтоон ажилладаг болох |
| | ТХ314.ЗҮ5. Суралцагч загас агнадаггүй бүс болон далайн тэнгисийн нөөц газрыг өргөжүүлэн тэлэх, тэдгээрийг шинжлэх ухааны үндэслэлтэй хамгаалах тухай компанит ажил зохион байгуулж чаддаг болох |

**ТХ315 ГАЗАР ДЭЭРХ АМЬДРАЛ: Хуурай газрын экосистемүүдийн тогтвортой ашиглалтыг хамгаалах, сэргээх, дэмжих, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, цөлжилтийн эсрэг тэмцэх, хөрсний доройтлыг зогсоох, сэргээх, биологийн төрөл зүйлийн алдагдлыг зогсоох**

***"ТХБ-2030": Хүний оршихуй, цэцэглэн хөгжих үндэс болсон биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хадгалан хамгаалах, нөхөн сэргээх ажлыг урамшуулан дэмжих***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ315.ТМ1. Суралцагч орон нутгийнхаа болон дэлхийн экосистемтэй холбоотой үндсэн экологийг ойлгож, орон нутгийн амьтдын төрөл зүйлийг тодорхойлох, биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хэмжихийн чухлыг ойлгодог болох |
| | ТХ315.ТМ2. Суралцагч биологийн төрөл зүйлийн олон янз байдалд нүүрлэж буй амьдрах орчин алдагдах, ой мод устаж мөхөх, фрегментаци, хэт агналт, хөнөөлт хортон шавж зэрэг аюул заналыг ойлгодог болж, эдгээрийг орон нутгийн биологийн олон янз байдалд хамааруулан ойлгодог болох |
| | ТХ315.ТМ3. Суралцагч орон нутгийн экосистемийн үйлчилгээний ангиллыг: туслах (supporting), дэмжих (provisioting), зохицуулах (regulating), соёлын үйлчилгээний (cultural servises), түүнчлэн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн экосистемийн үйлчилгээ (ecosystems servises) гэх мэтээр ялган ангилж чаддаг болох |
| | ТХ315.ТМ4. Суралцагч хөрс маш удаан хугацаанд нөхөн сэргэдэг болохыг, мөн байгалиараа нөхөн сэргээгдэх хугацаанаас нь урьтаад түүнийг сүйтгэн устгаж байгаа олон хор хөнөөл тухайлбал, газар тариалан, ойн салбарын үйл ажиллагаа зэргийн талаар ойлгодог болох |
| | ТХ315.ТМ5. Суралцагч байгаль хамгаалах стратегийн бодитой ажлууд нь байгалийн цэвэр нөөцийг хадгалахаас гадна хууль эрхзүйн зохицуулалтыг сайжруулах, доройтолд орсон амьдралын орчин, хөрсийг нөхөн сэргээх, онгон зэрлэг байгалийн коридоруудыг холбох, тогтвортой хөдөө аж ахуй, ойн аж ахуй эрхлэх, хүн ба онгон байгалийн хоорондын харилцан хамаарлыг сэргээх үүрэг зориулалттайг тус тус ойлгодог болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ315.НСХ1. Суралцагч биологийн төрөл зүйлийн олон янз байдал алдагдахад хүргэдэг хүрээлэл орчны хор уршигтай практик туршлагын эсрэг мэтгэлцэж чаддаг болох |
| | ТХ315.НСХ2. Суралцагч экосистемүүдийн үйлчилгээ, бодит үнэ цэнийг хамарсан олон талт үндэслэлд суурилан биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалах асуудлыг хэлэлцэн мэтгэлцэж чаддаг болох |
| | ТХ315.НСХ3. Суралцагч орон нутгийн байгаль орчинтой харилцаж, дэлхий дээрх хүмүүний бус аж амьдралыг ойлгож чаддаг болох |
| | ТХ315.НСХ4. Суралцагч хүмүүс бид байгалиас салангид бус харин байгалийн нэг хэсэг нь болохыг ухаарч, хүн нь нийгмийн болон байгалийн хоёрдмол шинжтэй болох талаар асуудал дэвшүүлж чаддаг болох |
| | ТХ315.НСХ5. Суралцагч байгальтай харилцан зохицсон аж амьдралын алс хэтийн хараатай болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ315.ЗҮ1. Суралцагч өөрийн нутагт биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хадгалан хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа орон нутгийн иргэдийн бүлгүүдтэй харилцаа холбоо тогтоож чаддаг болох |
| | ТХ315.ЗҮ2. Суралцагч зэрлэг байгальд зориулан хамгаалалтын зурвасыг байгуулах, газар тариалан-хүрээлэл орчны схем боловсруулах, байгаль экологийн нөхөн сэргээлт хийх зэрэг олон арга замаар онгон байгальтайгаа харьцаж, түүнд илүү ойрхон байхад нь хот, хөдөөгийн суурингуудад туслалцаа үзүүлэхэд чиглэсэн шийдвэр гаргах үйл явцад өөрийн дуу хоолойгоо үр дүнтэйгээр хүргэж чаддаг болох |
| | ТХ315.ЗҮ3. Суралцагч биологийн төрөл зүйлийн олон янз байдал болон байгаль хамгаалах тухай хууль тогтоомж хийгээд тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор бодлого боловсруулагчидтай хамтран ажиллаж чаддаг болох |
| | ТХ315.ЗҮ4. Суралцагч хөрс нь хоол хүнсийг ургуулдаг маш чухал материал болохын түүнчлэн хөрсний эвдрэлийг зогсоох эсвэл нөхөн сэргээхийн ач холбогдлыг чухалчлан үзэж чаддаг болох |
| | ТХ315.ЗҮ5. Суралцагч амьтны төрөл зүйлийг их хэмжээгээр агнаж буй асуудлаар олон улсад мэдлэг мэдээлэл түгээх компанит ажилд нэгдэж, ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ-ийн дүрэм журмыг боловсруулж, хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж чаддаг болох |

**ТХ316 ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁС БА ХҮЧИРХЭГ ИНСТИТУЦУУД: Тогтвортой хөгжлийн төлөөх энх амгалан, хүн бүрийн тусгай хэрэгцээ, тэгш оролцоог хангасан (inclusive) нийгмийг хөхиүлэн дэмжиж, бүх нийтээрээ шударга ёсыг эдэлдэг болгож, бүх түвшинд үр нөлөөтэй, эгэх хариуцлагатай (accountable), хүмүүсийн тусгай хэрэгцээнд тулгуурласан тэдний адил тэгш оролцоог хангах чадавхтай (inclusive) институцуудыг байгуулах**

***“ТХБ-2030”: Тогтвортой байдлын үндэс болсон шударга ёс, амар амгалан байдал, хүн бүрийн хэрэгцээнд суурилсан тэгш оролцоог хангах***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ316.ТМ1. Суралцагч шударга ёс, тусгай хэрэгцээгээ хангахуйцаар хүмүүсийн адил тэгш оролцоо (inclusion), энх тайван зэрэг ухагдахуун, үзэл баримтлал болон тэдгээр нь хууль эрх зүйтэй хэрхэн харилцан хамааралтай байдгийг ойлгодог болох |
| | ТХ316.ТМ2. Суралцагч нь орон нутгийн, үндэсний хууль тогтоох ба засаглах тогтолцоонуудыг, тэдгээрт хэрхэн төлөөлөлтэй болох, мөн авлигал, хээл хахууль нь хүмүүсийн эрхийг хэрхэн шамшигдуулдгийг тус тус ойлгодог болох |
| | ТХ316.ТМ3. Суралцагч өөрийн орны шүүхийн тогтолцоог бусад улс орныхтой харьцуулж чаддаг болох |
| | ТХ316.ТМ4. Суралцагч шударга ёс, тусгай хэрэгцээгээ хангахуйцаар хүмүүсийн адил тэгш оролцоог хангасан байдал ба энх тайвныг тус тус тогтоон барихад, өөрийн улс орны, дэлхий нийтийн хүчирхэг тогтолцоо, институцыг дэмжихэд хувь хүний болон бүлэг хүмүүсийн үзүүлэх ач холбогдлыг ойлгодог болох |
| | ТХ316.ТМ5. Суралцагч хүний эрхийн талаар ажилладаг олон байгууллагын бүтэц, үйлийн хүрээ (framework)-ний ач холбогдлыг ойлгодог болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ316.НСХ1. Суралцагч улс орондоо энх тайван, шударга ёс, тусгай хэрэгцээгээ хангахуйцаар хүмүүсийн адил тэгш оролцоог хангасан байдал болон хүчирхэг тогтолцоо, институцуудыг дэмжин тусалж чадах хүмүүстэй харилцаа холбоо тогтоож чаддаг байх |
| | ТХ316.НСХ2. Суралцагч орон нутгийн, дэлхий нийтийн түвшний энх тайван, шударга ёс, тусгай хэрэгцээгээ хангахуйцаар хүмүүсийн адил тэгш оролцоог хангасан байдал болон хүчирхэг тогтолцоо, институцэд хамаарах асуудлаар мэтгэлцэж чаддаг болох |
| | ТХ316.НСХ3. Суралцагч өөрийн болон бусад улс оронд шударга бус байдлаас шалтгаалан шаналан зовж байгаа хүмүүсийн сэтгэл санааг ойлгох, эв нэгдэлтэй байж чаддаг болох |
| | ТХ316.НСХ4. Суралцагч энх тайван, шударга ёс, тусгай хэрэгцээгээ хангахуйцаар хүмүүсийн адил тэгш оролцоог хангасан байдал болон хүчирхэг тогтолцоо, институтай холбоотой асуудалд өөрийн гүйцэтгэх үүргийн талаар эргэцүүлж чаддаг болох |
| | ТХ316.НСХ5. Суралцагч хувь хүнийхээ хувьд олон янзын бүлэг (жендэрийн, нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, ёс суртахууны, ястан үндэстний, чадварын, бэлгийн чиг хандлагын хувьд гэх мэт)-т хэрхэн харьяалагдаж байгааг, улмаар шударга ёс, хүмүүнлэг чанар өөрт нь үйлчилж буй эсэх талаар эргэцүүлэх чадвартай болох |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ316.ЗҮ1. Суралцагч өөрийн бүс нутгийн, үндэсний, дэлхий нийтийн хэмжээнд энх тайван, шударга ёс, тусгай хэрэгцээгээ хангахуйцаар хүмүүсийн адил тэгш оролцоог хангасан байдал болон хүчирхэг тогтолцоо, институцэд тулгарч буй асуудалд шүүмжлэлтэй хандан үнэлж чаддаг болох |
| | ТХ316.ЗҮ2. Суралцагч энх тайван, шударга ёс, тусгай хэрэгцээгээ хангахуйцаар хүмүүсийн адил тэгш оролцоог хангасан байдал болон хүчирхэг тогтолцоо, институцийг дэмжсэн бодлого боловсруулахыг чухалчилсан олон нийтийн шаардлагыг дэмжин ажиллаж чаддаг болох |
| | ТХ316.ЗҮ3. Суралцагч нь шударга бус байдал, зөрчил мөргөлдөөнтэй тулгарсан нийгмийн бүлгүүдтэй хамтран ажиллаж чаддаг болох |
| | ТХ316.ЗҮ4. Суралцагч шударга бус үйлдлийн эсрэг дуугарч, орон нутгийн шийдвэрийг өөрчилж чаддаг болох |
| | ТХ316.ЗҮ5. Суралцагч орон нутгийн, үндэсний түвшинд зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулж чаддаг болох |

## ТХ317 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ: Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийг дахин сэргээх, хэрэгжилтийг бататган бэхжүүлэх

***"ТХБ-2030": Тогтвортой байдлыг хангах нийгмийн хувирган өөрчлөлтийн төлөө түншүүд болон нөөцүүдийг дайчлах***

| | |
|---|---|
| Суралцахуйн танин мэдэхүйн зорилтууд | ТХ317.ТМ1. Суралцагч хөгжилд зориулсан санхүүжилт, татвар, өр төлбөр, худалдааны бодлого болон улс орон, ард иргэдийн хоорондын холбоо, харилцан хамаарал зэргийг хамарсан дэлхийн хэмжээний асуудлыг ойлгодог болох |
| | ТХ317.ТМ2. Суралцагч дэлхий нийтийн эрх ашгийн сонирхлын олон талуудын түншлэл болон тогтвортой хөгжлийн төлөө хүлээсэн тэдний хамтын үүрэг хариуцлагын ач холбогдлыг ойлгодог болж, дэлхий нийтийн түншлэлийн сүлжээнүүд, институтууд, кампанит ажлуудын жишээг мэддэг болох |
| | ТХ317.ТМ3. Суралцагч дэлхий нийтийн засаглал ба дэлхийн иргэн гэсэн ухагдахуун, үзэл баримтлалыг мэддэг болох |
| | ТХ317.ТМ4. Суралцагч шинжлэх ухаан, технологи, инновацын хүртээмжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллахын түүнчлэн мэдлэг хуваалцахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч чаддаг болох |
| | ТХ317.ТМ5. Суралцагч тогтвортой хөгжлийн ахиц дэвшлийг хэмжиж үнэлэх тухай үзэл баримтлалыг мэддэг болох |
| Суралцахуйн нийгэмшил-сэтгэл хөдлөлийн зорилтууд | ТХ317.НСХ1. Суралцагч тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийн ач холбогдлыг олон нийтэд ухуулан ойлгуулж чаддаг болох |
| | ТХ317.НСХ2. Суралцагч тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийг хөхиүлэн дэмжихэд, тогтвортой хөгжлийн зорилгын төлөө Засгийн Газартай хариуцлага тооцоход бусадтай хамтран ажиллаж чаддаг болох |
| | ТХ317.НСХ3. Суралцагч тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхийн тулд өөриймсөг ханддаг болох |
| | ТХ317.НСХ4. Суралцагч дэлхий нийтийн тогтвортой нийгмийн төлөөх алс хэтийн хараатай болох |
| | ТХ317.НСХ5. Суралцагч нь хүний эрхээс үүдсэн бусадтайгаа өөрсдийн үнэт зүйлсийг, хариуцлагыг хамтран үүрэх нийтлэг шинжийг мэдрэх чадвартай болох. |
| Суралцахуйн зан үйлийн зорилтууд | ТХ317.ЗҮ1. Суралцагч тогтвортой хөгжлийн зорилгыг бодит үйл хэрэг болгон өөрчлөгч этгээд болж, идэвхтэй, нухацтай, дэлхийн, тогтвортой байдлыг дэмжигч иргэнийхээ үүргийг хүлээж чаддаг болох |
| | ТХ317.ЗҮ2. Суралцагч тогтвортой хөгжлийн төлөөх орон нутгийн, үндэсний, дэлхий нийтийн түншлэлийг дэмжин хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж чаддаг болох |
| | ТХ317.ЗҮ3. Суралцагч тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийг дэмжих бодлого боловсруулахыг олон нийтийн хамт шаардан дэмжиж чаддаг болох |
| | ТХ317.ЗҮ4. Суралцагч хөгжлийн төлөөх хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж чаддаг болох |
| | ТХ317.ЗҮ5. Суралцагч тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлд оролцоход нь компаниудад нөлөөлж чаддаг болох |

## ХАВСРАЛТ 2. ТХЗ-ЫН ТӨЛӨӨХ БОЛОВСРОЛЫН СЭДЭВ

ТХ-ийн үндсэн асуудлуудыг ТХЗ тус бүрд харгалзуулан тодорхой сэдвүүд болгон тодорхойлсон байгаа бөгөөд ТХЗ13 буюу Уур амьсгалын төлөөх үйл хэрэгт 11 сэдэв, бусад 16 ТХЗ тус бүрд 10 сэдэв, нийт 171 сэдвийг санал болгосон байна. Эдгээр санал болгосон сэдвүүдийг суралцахуйн зорилттой нэгэн ижил зарчмаар кодолсон бөгөөд жишээлбэл, ТХЗ13.Сэ01 гэсний ТХ-ийн 13-р зорилгын санал болгосон 1-р сэдэв гэж тайлж уншина.

ТХЗ-ын хүрээнд санал болгон дэвшүүлсэн 171 сэдвийг орчуулснаа доор үзүүллээ.

| | |
|---|---|
| **ТХЗ01 ЯДУУРАЛГҮЙ БОЛОХ** | |
| ТХЗ01.Сэ01. | Ядуурлын тодорхойлолт |
| ТХЗ01.Сэ02. | Олон улсын, үндэсний, орон нутгийн хүрээнд туйлын нэн ядуу, туйлын баян чинээлэг байдлын хуваарилалт, тэдгээрийн шалтгаан |
| ТХЗ01.Сэ03. | Нийгмийн хамгааллын тогтолцоо болон түүний үйлчлэх хүрээ, зорилтот бүлэг, агуулга, ач холбогдол |
| ТХЗ01.Сэ04. | Эдийн засгийн нөөц болон суурь үйлчилгээ, газар, бусад хэлбэрийн өмч, тэдгээрт тавих хяналт, түүнчлэн өв залгамжлал, байгалийн нөөц, зохистой шинэ технологи, санхүүгийн, бичил санхүүгийн үйлчилгээ зэргийг адил тэгш эрхтэй хүртэхийн ач холбогдол |
| ТХЗ01.Сэ05. | Ядуурал, байгалийн гамшигт үзэгдэл, уур амьсгалын өөрчлөлт болон эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны бусад дарамт цохилтын харилцан хамаарал |
| ТХЗ01.Сэ06. | Орчин үеийн боолчлол, хөдөлмөрийн мөлжлөг, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт зэрэг ядууралтай холбоотой ажлын нөхцөл байдал |
| ТХЗ01.Сэ07. | Ядуу болон эмзэг байдалд байгаа хүмүүсийн дасан зохицох байдал |
| ТХЗ01.Сэ08. | Хоол тэжээлийн дутагдал, эх хүүхдийн эндэгдэл, гэмт хэрэг, хүчирхийлэл зэрэг ядуурлын үр дагаврууд |
| ТХЗ01.Сэ09. | Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа |
| ТХЗ01.Сэ10. | Ядууст чиглэсэн, жендэрийн эмзэг асуудлыг харгалзан үзсэн, хөгжлийн стратегид суурилсан олон улсын, үндэсний, бүс нутгийн бодлогын шийдлүүд, хэрэгжүүлэх стратегиуд |
| **ТХЗ02 ӨЛСГӨЛӨНГ ТЭГЛЭХ** | |
| ТХЗ02.Сэ01. | Өлсгөлөн, хүнс тэжээлийн дутагдлын тухай ухагдахууны тодорхойлолт |
| ТХЗ02.Сэ02. | Өлсгөлөн болон хүнс тэжээлийн дутагдалд илүү өртөмтгий эмзэг бүлгүүд |
| ТХЗ02.Сэ03. | Өлсгөлөн болон хүнс тэжээлийн дутагдлыг бий болгодог үндсэн шалтгаан, хүчин зүйлс тухайлбал, уур амьсгалын өөрчлөлт, хоол, хүнсний хүрэлцээ, хөрсний доройтол хоорондын харилцан хамаарал |
| ТХЗ02.Сэ04. | Өлсгөлөн болон хүнс тэжээлийн дутагдлаас үүдэн нийт хүн амын эрүүл мэнд, сайн сайхан амьдралд үзүүлэх нөлөө, үр дагавар. Тухайлбал, дасан зохицохын тулд шилжилт хөдөлгөөн хийж нүүж суудаг болох нь |
| ТХЗ02.Сэ05. | Хүний бие бялдар, сэтгэл хөдлөл болон нийгэм-соёлын хүрээнд хоол хүнсний гүйцэтгэх үүрэг |
| ТХЗ02.Сэ06. | Өлсгөлөн ба хоол хүнсний хаягдал, илүүдэл, хэт тарגалалт |
| ТХЗ02.Сэ07. | Дэлхий дахины хүнс: импорт, экспорт, үрийн сан, олон улсын татвар, татаас, арилжааны систем, хэмжилт болон генетикийн өөрчлөлттэй (хувиргасан) амьд организм (ХАО)-ыг ашиглахын эрсдэл, сорилт, ач тус |
| ТХЗ02.Сэ08. | НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Foodwatch (Хүн амд эрүүл, аюулгүй, хямд хоол хүнсээр хангахын төлөө олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага), Slow Food (Орон нутгийн хүнсний соёл, уламжлал устахаас урьдчилан сэргийлэх зорилготой), Via Campesina (жижиг, дунд үйлдвэрлэгчид, хөдөө аж ахуйн ажилчид, хөдөөгийн орон нутгийн эмэгтэйчүүд, нутгийн уугуул иргэдийн төлөөх олон улсын хөдөлгөөн), олон нийтэд түшиглэсэн хөдөө аж ахуй зэрэг өлсгөлөн болон тогтвортой хөдөө аж ахуйтай холбоотой байгууллага ба хөдөлгөөн |
| ТХЗ02.Сэ09. | Тогтвортой хөдөө аж ахуйн үзэл баримтлал болон зарчмууд. Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, органик ферм, биодинамик ферм, байгаль ахуйн өөрөөрөө нөхөн төлжих зүй тогтолд нийцсэн (permaculture) хөдөө аж ахуй-нийгмийн тогтолцоо, ойн аж ахуй |

| | |
|---|---|
| ТХ302.Сэ10. | Амьтан, ургамал, үрийн, ялангуяа зэрлэг амьтан, ургамалтай хамаатай биологийн олон янз байдал |
| **ТХ303 САЙН ЭРҮҮЛ МЭНД, САЙН САЙХАН БАЙДАЛ** | |
| ТХ303.Сэ01. | Ноцтой халдварт болон халдварт бус өвчнүүд |
| ТХ303.Сэ02. | Эмзэг бүлгийн, хамгийн эмзэг бүс нутаг дахь хүмүүсийн эрүүл мэндийн асуудал, мөн жендэрийн тэгш бус байдал нь тэдний эрүүл мэнд ба сайн сайхан амьдралд хэрхэн нөлөөлдөг талаарх ойлголт |
| ТХ303.Сэ03. | Эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг дэмжих гол стратегиуд: Тухайлбал, вакцин, эрүүл хүнс, биеийн тамирын дасгал, сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл мэндийн зөвлөгөө, боловсрол, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол (аюулгүй бэлгийн харилцаа болон хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх аргууд) |
| ТХ303.Сэ04. | Эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг дэмжих дам стратегиуд (нийгмийн эрүүл мэнд): Тухайлбал, эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрүүд, эмийн боломжийн үнэ, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх, шинэ мэдлэг, технологийг шилжүүлэх, бохирдол ба бохирдуулагч бодисын хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах. |
| ТХ303.Сэ05. | Аз жаргал, сайн сайхан байдал, амьдралын чанарын талаарх философи, ёс суртахууны үзэл баримтлал |
| ТХ303.Сэ06. | Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол. Тухайлбал, гэр бүл төлөвлөлт |
| ТХ303.Сэ07. | ХДХВ-ийн халдвартай хүмүүс, бусад өвчин, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байх хандлага |
| ТХ303.Сэ08. | Зам тээврийн осол |
| ТХ303.Сэ09. | Илүүдэл жин ба таргалалт хөдөлгөөний дутагдал, эрүүл бус хоол хүнс |
| ТХ303.Сэ10. | Химийн бодис, агаар, ус, хөрсний бохирдол, тэдгээрийн дамжин бохирдолт (contamination) |
| **ТХ304 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ** | |
| ТХ304.Сэ01. | Боловсрол – нийгмийн өмч, дэлхий нийтийн өмч, хүний үндсэн эрх бөгөөд бусад эрхээ эдлэх баталгаа |
| ТХ304.Сэ02. | “Боловсрол-2030 хөтөлбөр” ба “ТХБ-2030” зэрэг дэлхий хэмжээнд гарсан шинэ санаачилга ба үр өгөөжтэй хэрэгжиж буй туршлагууд, кэйсүүд |
| ТХ304.Сэ03. | Хүн бүрийн тэгш оролцоо, боловсролын тусгай хэрэгцээгээ хангахуйц (inclusive) чанартай боловсрол эзэмших шударга нөхцөлөөр хангаж, насан туршдаа суралцах боловсрох боломжуудыг (албан, албан бус, дүйцсэн боловсролд хамрагдах, мэдээлэл харилцааны технологийг ашиглах гэх мэт)-ыг дэмжих болон хүмүүсийн амьдралыг сайжруулах, тогтвортой хөгжлийг хангах зэрэг бүх түвшний үйлийн нийц |
| ТХ304.Сэ04. | Боловсролын хүртээмж хангалтгүй байгаа шалтгаан (ядуурал, зөрчил мөргөлдөөн, гамшиг, жендэрийн тэгш бус байдал, боловсролын төсөв, санхүүжилтийн хүрэлцээгүй байдал, төрийн санхүүжилт дутмаг байдал, хувьчлал нэмэгдэж буй байдал) |
| ТХ304.Сэ05. | Унших, бичих, тоолох үндсэн чадварыг эзэмшсэн байдлын дэлхийн түвшин |
| ТХ304.Сэ06. | Олон янз байдал (хүмүүсийн боловсролын эрэлт хэрэгцээний олон янз байдал) ба тэгш оролцоо, тусгай эрэлт хэрэгцээг хангахуйц (inclusive) боловсрол |
| ТХ304.Сэ07. | 21-р зуунд хэрэгцээтэй суурь чадварууд ба цогц чадамжууд |
| ТХ304.Сэ08. | Тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйл |
| ТХ304.Сэ09. | Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)-ын үзэл баримтлал. ТХ-ийн төлөө Байгууллага бүхлээрээ ажиллах арга хандлага (Whole-Institution Approach) бол ТХБ-ын үйлийн далайцыг нэмэгдүүлэх гол стратеги болох нь. Тогтвортой байдлын цогц чадамжийг хөгжүүлдэг багшлах арга зүй |
| ТХ304.Сэ10. | Хүүхэд залуучуудад болон нийгмээс гадуурхагдсан эмзэг бүлгийнхэнд боломж, эрх мэдэл олгох |
| **ТХ305 ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ** | |
| ТХ305.Сэ01. | Жендэр бол нийгэм, соёлыг цогцлоон бүрдүүлэгч болох нь |
| ТХ305.Сэ02. | Жендэрийн тэгш бус байдал, уламжлалт үүрэг оролцоо, бүтцийн ялгаварлан гадуурхал (structural discrimination-ялгаварлан гадуурхлын шууд бус, хэвшмэл, ерөнхий хэлбэр) |

| | |
|---|---|
| ТХ305.Сэ03. | Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн эрх тэгш байдал, оролцоо |
| ТХ305.Сэ04. | Жендэр ба хөдөлмөр эрхлэлт. Тухайлбал, хөдөлмөрийн хөлсний ялгаатай байдал, цалин хөлсгүй хөдөлмөрийг хүлээн зөвшөөрөх |
| ТХ305.Сэ05. | Жендэр ба боловсрол. Тухайлбал, бага, дунд болон гурав дахь шатны боловсрол эзэмшихэд жендэрийн тэгш боломжийг хангах |
| ТХ305.Сэ06. | Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх |
| ТХ305.Сэ07. | Жендэр ба ядуурал. Тухайлбал, хүнсний аюулгүй байдал ба санхүүгийн хамааралтай байдал |
| ТХ305.Сэ08. | Нийгмийн хөгжил, хөдөлгөөн дэх жендэр (шийдвэр гаргалт, засаглал, хүүхэд асрах, боловсрол, зөрчлийг шийдвэрлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох) |
| ТХ305.Сэ09. | Охид, эмэгтэйчүүдийн мөлжлөг, хүний наймаа |
| ТХ305.Сэ10. | Чадамж, шашин шүтлэг, арьс өнгө гэх мэт нийгмийн ангилал, зэрэглэл ба жендэр хоорондын харилцан хамаарал |
| **ТХ306 ЦЭВЭР УС БА АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ** | |
| ТХ306.Сэ01. | Дэлхийн усны эргэлт ба усны нөөцийн тархац |
| ТХ306.Сэ02. | Аюулгүй, боломжийн үнэтэй усны эрх тэгш хүртээмжийг чухалчлахын ач холбогдол (Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд чанартай, хүрэлцээтэй усаар хангах: Тухайлбал, усны хомсдол үүсгэдэг ган гачиг болон хэт их устай үер зэрэг байгалийн гамшгийн давтамжаас шалтгаалан үүсэх нийгэм эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг бууруулах хэрэгцээ) |
| ТХ306.Сэ03. | Усны чанар  хэмжээ болон эрүүл ахуй, ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ, тэгш хүртээмж зэрэг эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн ач холбогдол |
| ТХ306.Сэ04. | Ус ашиглах хүний эрх. Ус нь дэлхийн хүн амын нийтийн өмч болох нь. |
| ТХ306.Сэ05. | Усны бохирдлын хор нөлөө, химийн хорт бодис болон бусад материалыг хаяж, асгаснаас үүдэлтэй усны чанарын доройтол |
| ТХ306.Сэ06. | Усны хомсдол ба зохистой хэрэглээ |
| ТХ306.Сэ07. | Ус бүхий экосистемийн ач холбогдол |
| ТХ306.Сэ08. | Ус болон ариун цэвэртэй холбоотой үйл ажиллагаа ба хөтөлбөрүүд. Тухайлбал, ус цуглуулж нөөцлөх, давсгүйжүүлэх, усны үр ашигтай байдлыг хангах, усны чанарыг патентжуулах, гүний усыг нөхөн сэргээх газар зүйн зураглал хийх болон хаягдал усыг боловсруулж цэвэршүүлэн ашиглах технологи усны нөөцийн нэгдсэн менежмент зэрэг багтана. |
| ТХ306.Сэ09. | Усны экспорт (виртуал ус-Аливаа бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон үйлчилгээнд зарцуулсан ус) |
| ТХ306.Сэ10. | Ус ба тогтвортой хөгжил (жишээ нь: ус ба жендэр, ус ба тэгш бус байдал, ус ба ажил мэргэжил, ус ба ногоон хөгжил, ус ба уур амьсгалын өөрчлөлт, ус ба гамшгийн эрсдэл, ус ба хүнсний аюулгүй байдал, ус ба эрчим хүч, ус ба хотууд, ус ба эрүүл мэнд |
| **ТХ307 БОЛОМЖИЙН ҮНЭТЭЙ, ЦЭВЭР ЭРЧИМ ХҮЧ** | |
| ТХ307.Сэ01. | Эрчим хүчний төрлүүд. Нар, салхи, ус, газрын гүний дулаан, далайн түрлэг зэргээр үүсэх сэргээгдэх эрчим хүч. |
| ТХ307.Сэ02. | Улс орнуудын эрчим хүчний үйлдвэрлэл, эрэлт, нийлүүлэлт, хэрэглээ. |
| ТХ307.Сэ03. | Эрчим хүчний хэрэглээний өөрийн хэрэгцээг хангах байдал ба үр өгөөж-бүтээмж |
| ТХ307.Сэ04. | Стратегиуд: төвлөрсөн болон төвлөрсөн бус эрчим хүчний үйлдвэрлэлийн ялгаа, эрчим хүчний бие даасан (хараат бус) байдал. Тухайлбал, орон нутгийн эрчим хүчний хангамжийн компаниуд (LESCOs) |
| ТХ307.Сэ05. | Эрчим хүчний улс төр, эдийн засаг, нийгмийн цар хүрээ болон эрх мэдлийн бүлэглэлтэй холбогдох байдал: Тухайлбал, том хэмжээний нарны эрчим хүчний ферм эсвэл усан цахилгаан станцын далангийн бүтээн байгуулалт гэх мэт эрчим хүчний мега төслүүдээс үүсэж болзошгүй ашиг сонирхлын зөрчил (улс төр, эдийн засгийн эрх дарх (хил дамнасан), нэн онцлог нутгийн уугуул иргэдийн эрх зөрчигдөх) |
| ТХ307.Сэ06. | Эрчим хүчний үйлдвэрлэл, нийлүүлэлт, ашиглалтаас үүсэх асуудлууд болон хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл (жишээ нь: уур амьсгалын өөрчлөлт, саарал эрчим хүч (grey energy - бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн турш хэрэглэгдэж байгаа нийт эрчим хүч) |
| ТХ307.Сэ07. | Нүүрстөрөгчийн исэлдэл бага ялгаруулах эрчим хүчний шийдлийг хөгжүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын үүрэг, оролцоо |

| | |
|---|---|
| ТХ307.Сэ08. | Газрын тос гэх мэт нөхөн сэргээгдэхгүй эх үүсвэрээс хэт хамааралтай эрчим хүчний хүрэлцээ хангамж ба газрын тосны үйлдвэрлэлийн оргил үе |
| ТХ307.Сэ09. | Технологийн гарцууд болон чулуужсан түлш ашиглах “цэвэр” технологи |
| ТХ307.Сэ10. | Эрчим хүчний үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээтэй холбоотой жендэрийн асуудал |
| **ТХ308 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ** | |
| ТХ308.Сэ01. | Хүний сайн сайхан байдалд эдийн засгийн оруулах хувь нэмэр болон ажилгүйдэл нь хувь хүн хийгээд нийгэмд үзүүлэх нөлөө. |
| ТХ308.Сэ02. | Эдийн засгийн ёс зүй |
| ТХ308.Сэ03. | Эдийн засгийн өсөлтийн онолын таамаглал, загварууд, үзүүлэлтүүд (Дотоодын нийт бүтээгдэхүүн-ДНБ,Үндэсний нийт орлого-ҮНО, Хүний хөгжлийн индекс-ХХИ) |
| ТХ308.Сэ04. | Эдийн засгийн бусад сонголт загварууд ба үзүүлэлтүүд: улс орны дотоодын тогтвортой байдлын үеийн эдийн засгийн загвар (steady-state), нийгмийн халамжийн эдийн засаг, de-growth буюу "экологийн эдийн засаг, хэрэглээний эсрэг, капитализмын эсрэг үзэл баримтлалд тулгуурласан улс төр, нийгэм эдийн засгийн хөдөлгөөн", амин зуулгын эдийн засаг, баялгийн тэгш хуваарилалтын индексүүд (Inclusive Wealth Index - байгалийн, хүний, бүтээгдэхүүний капитал), дэлхийн өлсгөлөнгийн индекс |
| ТХ308.Сэ05. | Санхүүгийн тогтолцооны гол ойлголт үзэгдлүүд, тэдгээрийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө (хөрөнгө оруулалт, зээл, хүү, банк, хөрөнгийн бирж дээрх арилжаа, инфляц гэх мэт) |
| ТХ308.Сэ06. | Ажиллах хүч (төрөлтөөс үүдэлтэй хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн гэх мэт) |
| ТХ308.Сэ07. | Эдийн засаг дахь жендэрийн эрх тэгш байдал, гэртээ бусдыг халамжлан өнгөрүүлж буй цагийн эдийн засгийн үнэлэмж |
| ТХ308.Сэ08. | Хөдөлмөрийн зах зээл дэх тэгш бус байдал: Нийгмийн ялгаатай бүлгүүдийн төлөөлөл ба оролцоо, улс орон, бизнесийн салбар, нийгмийн бүлэг, жендэр хоорондын ялгаатай орлого буюу цалин хөлс, долоо хоногт ажиллах ажлын цаг |
| ТХ308.Сэ09. | Албан болон албан бус хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрх, ялангуяа цагаач, дүрвэгч, албадан хөдөлмөр эрхлэгчид, боолууд болон хүний наймаанд өртсөн хүмүүст зориулсан ажил хөдөлмөр эрхлэх эрх |
| ТХ308.Сэ10. | Тогтвортой хөгжлийн төлөөх аж ахуй эрхлэлт, (нийгмийн) инновац, шинэ технологи, орон нутгийн эдийн засаг |
| **ТХ309 ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦ, ДЭД БҮТЭЦ** | |
| ТХ309.Сэ01. | Мэдээлэл харилцааны технологийн тогтвортой байдал. Тухайлбал, нийлүүлэлтийн гинжин холбоо, хог хаягдлын устгал, дахин боловсруулалт гэх мэт |
| ТХ309.Сэ02. | Чанартай дэд бүтэц ба нийгэм, эдийн засаг, улс төрийн зорилгыг биелүүлэхийн хоорондын харилцан хамаарал |
| ТХ309.Сэ03. | Зам тээвэр, мэдээлэл харилцааны технологи, ариун цэвэр, цахилгаан эрчим хүч, ус зэрэг үндсэн дэд бүтцүүдийн хэрэгцээ шаардлага |
| ТХ309.Сэ04. | Хүмүүсийн тэгш оролцоо, тусгай хэрэгцээг хангасан (inclusive), тогтвортой инновац ба аж үйлдвэржилт |
| ТХ309.Сэ05. | Уян хатан дэд бүтцийн хөгжил |
| ТХ309.Сэ06. | Тогтвортой цахилгаан эрчим хүч: Үндэсний цахилгаан шугам сүлжээ, сэргээгдэх эх үүсвэр ашиглаж өөрсдийн хэрэгцээгээ хангах цахилгаан үйлдвэрлэсний төлөө төлөх төлбөр (feed-in-tarrif), сэргээгдэх эрчим хүчний тогтвортой эх үүсвэрийн өргөжилт, зөрчил |
| ТХ309.Сэ07. | Тогтвортой хөдөлмөрийн зах зээл, боломж нөхцөлүүд ба хөрөнгө оруулалт |
| ТХ309.Сэ08. | Интернэтийн тогтвортой байдал - ногоон чат групп (green chat group)-ээс хайлтын системийн серверийн экологийн ул мөр хүртэл |
| ТХ309.Сэ09. | Тээврийн дэд бүтцийн тогтвортой байдал |
| ТХ309.Сэ10. | Орон нутгийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт болж буй алтернатив мөнгөн тэмдэгт (alternative currencies – бартер, интернэт оноо, кэнди оноо, ЖЖ оноо гэх мэт) |
| **ТХ310 ТЭГШ БУС БАЙДЛЫГ БАГАСГАХ** | |
| ТХ310.Сэ01. | Нийгэм, эдийн засаг, улс төрийн түвшний оролцоо ба үндэсний, дэлхий нийтийн түвшинд буй тэгш бус байдал - ялгаварлан гадуурхалтын түгээмэл төрлүүд |
| ТХ310.Сэ02. | Тэгш бус байдлыг хэмждэг янз бүрийн үзүүлэлтүүд |
| ТХ310.Сэ03. | Эрх тэгш байдлыг хангахад газар, өмч болон байгалийн баялаг эзэмших эрх эдлэхийн утга учир, эмзэг байдал болон чадавхад үзүүлэх тэгш бус байдлын нөлөөлөл |

| | |
|---|---|
| ТХ310.Сэ04. | Төсөв санхүү, цалин хөлс болон нийгмийн хамгааллын бодлогууд |
| ТХ310.Сэ05. | Дэлхийн худалдааны систем, татварын дэглэм гэх мэт түүний зохицуулалтууд |
| ТХ310.Сэ06. | Хөдөлмөр эрхлэлтийн стандарт |
| ТХ310.Сэ07. | Нийгмийн ялгаатай бүлэг буюу үндэстэн ястны төлөөллийг засгийн газарт эсвэл шаардлагатай гэж үзсэн эрх бүхий хүчирхэг тогтолцоо, институцийн удирдах зөвлөлд оруулж ажиллуулах |
| ТХ310.Сэ08. | Олон улсын хөгжлийн тусламжийн мөнгөн дүн, түүний үр нөлөө |
| ТХ310.Сэ09. | Өнөөгийн тэгш бус байдлын түүхэн үүсэл гарлын шалтгаан (үндэстэн дамнасан компаниудын үүрэг оролцоо гэх мэт) |
| ТХ310.Сэ10. | Хүмүүсийн цагаачлал, шилжилт хөдөлгөөн |
| **ТХ311 ТОГТВОРТОЙ ХОТ СУУРИН БА ОРШИН СУУГЧИД** | |
| ТХ311.Сэ01. | Орон гэр, аюулгүй байдал, хүн бүрийн тэгш оролцоо, эрэлт хэрэгцээг тусгасан байдал (inclusiveness): хувь хүний болон хэсэг бүлэг хүмүүсийн харилцан адилгүй хүсэл хэрэгцээг жендэр, нас, орлого, чадварын дагуу хам нөхцөлд нь холбон үзсэн, хүний хэрэгцээ |
| ТХ311.Сэ02. | Байгалийн нөөц баялаг (сэргээгдэх болон үл сэргээгдэх)-ийн менежмент, ашиглалт |
| ТХ311.Сэ03. | Тогтвортой эрчим хүч (суурин газрын эрчим хүчний хэрэглээ, сэргээгдэх эрчим хүч, орон нутгийн эрчим хүчний схем) болон түгээлт |
| ТХ311.Сэ04. | Тогтвортой хүнс хоолоор хангагдах (хөдөө аж ахуй, органик хөдөө аж ахуй, байгалийн онцлог, хэв шинжтэй уялдсан газар тариалан нийгмийн загвар (permaculture), орон нутгийнхны дэмжлэгтэй хөдөө аж ахуй, тодорхой хүн амд зориулсан хүнс тэжээл үйлдвэрлэдэг газар нутаг (foodshed), хүнсний бүтээгдэхүүн боловсруулалт, диет /хооллох дэглэм/-ийн сонголт, хэрэглээний зуршил, хог хаягдал) |
| ТХ311.Сэ05. | Суурин газрын экологи болон ан амьтад хүний суурьшилд хэрхэн дасан зохицож байгаа нь |
| ТХ311.Сэ06. | Тогтвортой, бат бөх – аюул ослын сөрөн дааж гарах чадвар бүхий барилга, байгууламж ба байршлын төлөвлөлт, (барилгын материал, эрчим хүч хэмнэлт, төлөвлөлтийн үйл явц) |
| ТХ311.Сэ07. | Хог хаягдал, түүний менежмент (урьдчилан сэргийлэх, бууруулах, дахин боловсруулах, дахин ашиглах) |
| ТХ311.Сэ08. | Орон нутгийн иргэд, тэдний дунд гарч буй өөрчлөлтүүд (шийдвэр гаргалт, засаглал, төлөвлөлт, зөрчил мөргөлдөөний шийдэл, бусад сонголтууд, орон нутгийн иргэд эрүүл саруул байх нь, орон нутгийн иргэд бусдын оролцоог хангасан байх, эко тосгон, хот суурины өөрчлөлт хувиралт) |
| ТХ311.Сэ09. | Байгаль дахь усны эргэлт ба хот төлөвлөлтийн дизайнаар хөрсний усыг сэлбэх, (Ногоон дээвэр, борооны ус цуглуулах, голын хуучин голдирлыг өөрчлөх, хотын тогтвортой ус зайлуулалт) |
| ТХ311.Сэ10. | Гамшгийн эсрэг бэлэн байдал ба түүнийг сөрж даван гарах чадвар, цаг агаарын асуудалд болон ирээдүйн болзошгүй нөхцөлд бэлэн байж сөрөн гарах чадвартай байх, гамшгаас урьдчилан сэргийлэх болон бэлэн байдалд шилжих чадвар |
| **ТХ312 ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ БА ҮЙЛДВЭРЛЭЛ** | |
| ТХ312.Сэ01. | Мэдээлэл сурталчилгаа, үе тэнгийнхний дарамт шахалт, адил сонирхлоор ижилсэх ба харьяалагдах |
| ТХ312.Сэ02. | Бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба хэрэглээний түүх, хэв маягууд ба үнэ өртгийн гинжин хэлхээ, байгалийн нөөц баялаг (сэргээгдэх болон үл сэргээгдэх)-ийн менежмент ба ашиглалт |
| ТХ312.Сэ03. | Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээний байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөө |
| ТХ312.Сэ04. | Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ (тээвэр, бизнесийн болон орон сууцны эрчим хүчний ашиглалт, сэргээгдэх эрчим хүч) |
| ТХ312.Сэ05. | Хоол хүнсний үйлдвэрлэл, хэрэглээ (хөдөө аж ахуй, хоол хүнсний боловсруулалт, диетийн сонголт ба дадал зуршил, хог хаягдал, ойн хомсдол, хоол хүнсний хэт их хэрэглээ ба өлсгөлөн) |
| ТХ312.Сэ06. | Аялал жуулчлал |
| ТХ312.Сэ07. | Хог хаягдал, түүний менежмент (урьдчилан сэргийлэх, бууруулах, дахин боловсруулах, дахин ашиглах) |
| ТХ312.Сэ08. | Тогтвортой амьдралын хэв маяг ба тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний олон янзын практик туршлага |

| | |
|---|---|
| ТХ312.Сэ09. | Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний шошгожуулах тогтолцоо, гэрчилгээжүүлэлт |
| ТХ312.Сэ10. | Ногоон эдийн засаг (cradle-to-cradle /үйлдвэрлэл ба хэрэглээ нь хог хаягдал, хор уршиггүйгээр дахин ашиглагддаг байх буюу өлгийнөөс өлгийнд шилжих/, circular эдийн засаг /материаллаг болон хүний нөөц, энерги зэрэг хамгийн бага оролт*ын нөөцүүдээр, хог хаягдалгүй, энергийн алдагдалгүй нөхөн сэргээгдэх чадвартай тогтолцоо/*, ногоон өсөлт, degrowth */хэрэглэгчийн эрх ашиг ба капиталист үзэл санааны эсрэг экологид суурилсан эдийн засгийг дэмждэг хөдөлгөөн/*) |
| **ТХ313 УУР АМЬСГАЛЫН ТӨЛӨӨХ ҮЙЛ ХЭРЭГ** | |
| ТХ313.Сэ01. | Хүлэмжийн хийнүүд (нүүрсхүчлийн хий, метан, азотын дутуу исэл (II), фтор агуулсан хийнүүд) тэдгээрийн үүсэл, ялгаралт |
| ТХ313.Сэ02. | Эрчим хүч, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлээс үүсэх хүлэмжийн хийн ялгаралт |
| ТХ313.Сэ03. | Ган гачиг, цаг агаарын онцгой үзэгдэл гэх мэт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг дагуулсан аюултай үзэгдлүүд. Тэдгээрийн айл өрх, орон нутаг, улс орон болон улс орнуудын хооронд үзүүлэх нийгэм, эдийн засгийн харилцан адилгүй нөлөөлөл. |
| ТХ313.Сэ04. | Далайн усны түвшин ихсэх, түүний улс орнуудад учруулж буй үр дагавар (Жишээ нь, жижиг арлын улсууд) |
| ТХ313.Сэ05. | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөн, дайжилт |
| ТХ313.Сэ06. | Дасан зохицох, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх стратегиуд, тэдгээрийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед хариу арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагаатай холбогдох байдал |
| ТХ313.Сэ07. | Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг эрхэлсэн олон улсын, үндэсний, орон нутгийн байгууллагууд |
| ТХ313.Сэ08. | Уур амьсгалын өөрчлөлтөөс сэргийлэх орон нутгийн, үндэсний, олон улсын стратеги |
| ТХ313.Сэ09. | Ирээдүйн төсөөлөл (дэлхийн температурын өсөлтийн талаарх өөр бусад тайлбарууд) |
| ТХ313.Сэ10. | Ой мод, далай тэнгис, мөсөн бүрхүүл, биологийн олон янз байдал зэрэг томоохон эко системд үзүүлэх нөлөөлөл ба үр дагавар |
| ТХ313.Сэ11. | Ёс зүй ба уур амьсгалын өөрчлөлт |
| **ТХ314 УСАН ДООРХ АМЬДРАЛ** | |
| ТХ314.Сэ01. | Усан мандал: Байгаль дахь усны эргэлт, үүл бүрэлдэлт, ус бол уур амьсгалын гол зохицуулагч болох нь |
| ТХ314.Сэ02. | Далай тэнгисийн нөөц баялаг (сэргээгдэх болон үл сэргээгдэх)-ийн менежмент ба ашиглалт: Далайн нөөц нь дэлхий нийтийн дундын өмч болох нь, хэт их загас агнуур ба квот тогтоох хэлэлцээр, далай тэнгисийн үржүүлэг, далайн замаг ба эрдсийн нөөц |
| ТХ314.Сэ03. | Далай тэнгисийн тогтвортой эрчим хүч (сэргээгдэх эрчим хүчнүүд, салхин сэнс, тэдгээрийн ашиглалттай холбоотой санал зөрөлдөөн) |
| ТХ314.Сэ04. | Далай тэнгисийн экологи – далай доторх амьдралын хүнс тэжээлийн хэлхээ, араатан-идэш (predators & prey), амьдралын төлөөх тэмцэл, мөхөл сүйрэл |
| ТХ314.Сэ05. | Шүрэн хад, эрэг орчмын газар ба мангро мод (далайн эргийн сөөг мод),тэдгээрийн экологийн ач холбогдол |
| ТХ314.Сэ06. | Далайн усны түвшин нэмэгдэх, түүнээс болж газар нутгаа бүхэлд нь эсвэл, хэсэгчлэн алдаж буй улс орон; уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан дүрвэгчид, улс орон тусгаар тогтнолоо алдах зэрэг болзошгүй аюулууд |
| ТХ314.Сэ07. | Далай тэнгис ба олон улсын хууль тогтоомжууд: Олон улсад хамаарах ус болон газар нутгийн зөрчил ба маргаан, далайн тээвэрт далбаагаа мандуулах эрх, түүнтэй холбоотой асуудлууд |
| ТХ314.Сэ08. | Далай тэнгисийн усны бохирдуулагч зүйлс: Хуванцрууд, бичил хэмжээтэй хуванцар бүтээгдэхүүн (microbead), бохир ус, тэжээлийн бодис, химийн бодис |
| ТХ314.Сэ09. | Далайн гүн ба далай, тэнгисийн гүний амьд биетүүд |
| ТХ314.Сэ10. | Далай, тэнгисийн соёл иргэншлийн ач холбогдол– далай нь экосистемийн соёлын үйлчилгээний эх үүсвэр болох нь: сэтгэл санаа сэргээж, урам зориг өгөх, соёлын өвөрмөц онцлогийг бий болгох |

| ТХ315 ГАЗАР ДЭЭРХ АМЬДРАЛ | |
|---|---|
| ТХ315.Сэ01. | Экологи: Амьдралын төлөөх тэмцэл, араатан-идэш (predators & prey), бүлгэмдлийн динамик, хоол тэжээлийн хэлхээгээр энергийн урсгал, тархалт ба хүрээ. Онцлог шинжтэй экосистемүүд- тухайн газар нутгийн болон дэлхийн хэмжээн дэх унаган экосистемүүд, таримал ой зэрэг хүний гараар бүтээгдсэн экосистемүүд |
| ТХ315.Сэ02. | Биологийн олон янз байдалд нүүрлэж буй аюул занал: Амьдрах орчноо алдах, ой устах, фрагментаци /хуваагдал/, хор хөнөөлтэй амьтан, ургамлын зүйл, хэт ашиглалт (зохисгүй үйлдвэрлэл, хэрэглээний практикууд ба зохисгүй технологиуд гэх мэт) |
| ТХ315.Сэ03. | Төрөл зүйлийн устах, мөхөх аюул занал: Нэн ховор ба ховордсон төрөл зүйлүүд. Хэрхэн төрөл зүйл мөхөн устаж үүрд үгүй болдог, биологийн төрөл зүйл үүсэхэд маш урт удаан хугацаа шаардагддаг, төрөл зүйл устахад нөлөөлсөн үндсэн 6 гол хүчин зүйлийн талаарх мэдлэг |
| ТХ315.Сэ04. | Онгон байгалийг сэргээх, хүмүүс нь онгон байгалиа сэргээн анагаагч хүч |
| ТХ315.Сэ05. | Уур амьсгалын өөрчлөлт ба биологийн төрөл зүйлийн олон янз байдал. Экосистем нь нүүрсхүчлийн хийг шингээгч, гамшгийн эрсдэлийг бууруулагч болох нь, экосистемүүд (экосистем нь байгалийн аюулт үзэгдлүүдээс хамгаалах байгалийн хамгаалалт болох нь) |
| ТХ315.Сэ06. | Хөрс, түүний үүсэл ба бүтэц, найрлага |
| ТХ315.Сэ07. | Цөлжилт, ой устах, тэдгээрийн эсрэг тэмцэж буй хүчин чармайлт |
| ТХ315.Сэ08. | Хүмүүс амьд байгалийн нэг хэсэг бөгөөд тэдний байгальтайгаа холбогдох байдал |
| ТХ315.Сэ09. | Экосистемийн үйлчилгээ (соёлын, материаллаг нөөц хангамжийн, зохицуулалтын, дэмжин тэтгэх) |
| ТХ315.Сэ10. | Хувьсал ба генетик, генетикийн нөөц, ёс зүй |
| **ТХ316 ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁС БА ХҮЧИРХЭГ ИНСТИТУЦУУД** | |
| ТХ316.Сэ01. | "Шударга ёс"-ны тодорхойлолт. Залхаан цээрлүүлэх, засан хүмүүжүүлэх |
| ТХ316.Сэ02. | Гэмт хэрэг ба ял шийтгэл, хууль эрх зүй ба ял шийтгэлийн дэлхийн түвшний харьцуулалт |
| ТХ316.Сэ03. | Уур амьсгалын шударга ёс */Уур амьсгалын өөрчлөлтөд хариуцлага хүлээх болон түүнийг бууруулахад хувь нэмэр оруулахад баримтлах шударга ёс - Climate justice/* |
| ТХ316.Сэ04. | Худалдааны шударга ёс (Trade justice) |
| ТХ316.Сэ05. | Хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн мөлжлөг |
| ТХ316.Сэ06. | Дайн, энх тайван, дүрвэгчидтэй холбоотой дэлхий нийтийн гэрээ хэлэлцээр |
| ТХ316.Сэ07. | Хээл хахууль, түүнийг хэрхэн хэмжих тухай |
| ТХ316.Сэ08. | Хууль бус зэвсгийн худалдаа |
| ТХ316.Сэ09. | Тамхи, мансууруулах бодисын хууль бус хэрэглээний зуршил, түүний худалдаа |
| ТХ316.Сэ10. | Олон улсын гэмт хэргийн шүүх, түүний гүйцэтгэх үүрэг |
| **ТХ317 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ** | |
| ТХ317.Сэ01. | Тогтвортой хөгжлийн төлөөх улс орнуудын засгийн газрууд, хувийн хэвшил, иргэний нийгэм хоорондын дэлхийн түвшний (global) түншлэлүүд, тэдний хамтын хариуцлага ба өөр өөр тоглогчдын хооронд үүсэж болзошгүй зөрчил, маргаан |
| ТХ317.Сэ02. | Орон нутаг, үндэстэн, дэлхийг бүхэлд нь хамарсан бүтэц, зохион байгуулалтын тогтолцоонууд болон эрх мэдлийн динамик |
| ТХ317.Сэ03. | Тогтвортой хөгжилд чиглэсэн /ТХ-ийн үзэл санаа туссан/ дэлхий нийтийн засаглал, бодлого, дэлхийн зах зээл ба худалдааны тогтолцоо |
| ТХ317.Сэ04. | “Хоригдлын делимма”, “ардын эмгэнэл” шиг тогтвортой хөгжлийг дэмжсэн дэлхий нийтийн засаглал ба зах зээлийг бий болгоход нүүрлэж буй сорилт |
| ТХ317.Сэ05. | Дэлхийн иргэншил ба тогтвортой хөгжлийн төлөөх өөрчлөлтийг бүтээгчид болох иргэд |
| ТХ317.Сэ06. | Шинжлэх ухаан, технологи, инновацын хүртээмж, хамтын ажиллагаа, мэдлэг хуваалцах |
| ТХ317.Сэ07. | Интернэтийн хүртээмжийн дэлхийн тархалт |
| ТХ317.Сэ08. | Хөгжлийн хамтын ажиллагаа, хөгжлийн тусламж, олон эх сурвалжаас хөгжиж буй орнуудад үзүүлж буй санхүүгийн нэмэлт нөөц |
| ТХ317.Сэ09. | Тогтвортой хөгжлийн бүх зорилтыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг дэмжих хүний нөөцийн чадавх |
| ТХ317.Сэ10. | Тогтвортой хөгжлийн ахиц дэвшлийн хэмжүүрүүд |

## Хавсралт 3.

### ТХЗ-ын төлөөх боловсролын арга хандлага, арга техник

ТХЗ тус бүрээр сургалтын арга, техникийн 7 жишээ, нийт 119 жишээг өгсөн байна. Сургалтын аргын эдгээр жишээг суралцахуйн зорилт ба сэдэвтэй мөн нэгэн адил зарчмаар кодолсон. Тухайлбал, ТХ302.Аз4. гэснийг ТХ-ийн 2-р зорилгын жишээ болгосон 4 дэх арга гэж тайлж уншина. Бид эдгээр 119 сургалтын аргын жишээг харьцуулан судалж, 20 тодорхой аргыг ялган төрөлжүүлэн, ТХЗБ-ын сургалтын түлхүүр 4 аргын аль төрөлд хамаарахыг тодорхойлсон болно.

| Аргын төрөл | Тодорхой арга | АХД |
|---|---|---|
| I. Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох арга | 1. Тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх | 6 |
| | 2. Аян, кампанит ажилд оролцох, зохион байгуулах | 7 |
| | 3. Түншлэл (partnership)-ийг хөгжүүлэх | 5 |
| | 4. Дадлага (internship) хийх | 2 |
| | 5. Үйл ажиллагаанд оролцох, хамрагдах, төлөвлөх | 11 |
| | 6. Үйл ажиллагааны төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, оролцох | 9 |
| | 7. Видео үзэх | 2 |
| II. Шинжилгээ/ судалгаа хийх арга | 1. Задлан шинжилгээ, судалгаа хийх | 11 |
| | 2. Тохиолдлын шинжилгээ | 10 |
| | 3. Шинжилгээнд суурилсан төсөл (enquiry-based project) | 16 |
| | 4. Туршилт хийх | 2 |
| | 5. Судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх | 6 |
| III. Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан арга | 1. Эссэ бичих, хэлэлцүүлэг хийх | 7 |
| | 2. Дүрд хувилан тоглох | 10 |
| | 3. Экскурс, танилцах аялал | 8 |
| | 4. Веб, блог хөтлөх, видео клип хийх | 3 |
| IV. Алсын хараатай болох арга | 1. Хэтийн зорилго тодорхойлох | 1 |
| | 2. Түүх намтар зохиох | 2 |
| | 3. Ирээдүйд тодорхой нөхцөлд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах | 2 |
| | 4. Үзэл баримтлал, зарчим боловсруулах | 1 |
| Нийт | | 121 |

*АХД-Аргын хэрэглэгдсэн давтамж*

ТХЗ-ын төлөөх боловсролын сургалтын аргын 119 аргыг орчуулснаа доор үзүүллээ. Мөн бидний ялгаж төрөлжүүлсэн 20 тодорхой аргын алинд хамаарахыг харууллаа. Хамгийн эхний “ТХ301.Аз1. Дэлхийн янз бүрийн бүс дэх дунд сургуулиуд болон их сургуулиуд хоорондын түншлэлийг хөгжүүлэх (Өмнөд–Хойд, Өмнөд–Өмнөд)” гэсэн аргыг “I” гэсэн эхний баганад “3” гэж тэмдэглэсэн нь I төрлийн 3-р арга буюу “Түншлэл (partnership)-ийг хөгжүүлэх” арга болохыг илэрхийлж байна.

| № | ТХЗ | Сургалтын аргын жишээ | Аргын төрөл | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | I | II | III | IV |
| 1 | ТХ301. ЯДУУРАЛГҮЙ БОЛОХ | ТХ301.Аз1. Дэлхийн янз бүрийн бүс дэх дунд сургуулиуд болон их сургуулиуд хоорондын түншлэлийг хөгжүүлэх (Өмнөд–Хойд, Өмнөд–Өмнөд буюу Хөгжингүй болон Хөгжиж байгаа улс хооронд, Хөгжиж байгаа улсууд болон бүсийн хооронд гэх мэт) | 3 | | | |
| 2 | | ТХ301.Аз2. Орон нутаг болон дэлхий нийтийн түвшин дэх ядуурлын талаар мэдээллийн кампанит ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх | 2 | | | |
| 3 | | ТХ301.Аз3. Шударга худалдааны бүтээгдэхүүн борлуулах сурагчдын компанийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх | 5 | | | |
| 4 | | ТХ301.Аз4. Ядуусын янз бүрийн аюул осолд өртөмтгий байдлыг бууруулж, зохицох чадварыг нэмэгдүүлэхийн тулд тэдэнд боломж эрх мэдэл олгож, өөрсдийн хэрэгцээгээ хангахдаа суралцахуйд тодорхой үүрэг хүлээж, идэвхтэй оролцох боломжийг олгосон орон нутгийн суралцахуйн үйлчилгээ (local service–learning)-г ТББ, хувийн хэвшил болон нутгийн бүлгийнхэнтэй хамтарч, төлөвлөн хэрэгжүүлэх | 5 | | | |
| 5 | | ТХ301.Аз5. Ядуурал ба баян чинээлэг байдлын бодит судалгааг тодорхой нэг улсыг сонгож холбогдох материалыг судлах замаар эсвэл орон нутгийнхаа түвшинд экскурс, ярилцлагын аргаар хийх | | 2 | | |
| 6 | | ТХ301.Аз6. Ядуурлын чиглэлээр ажилладаг байгууллагуудад дадлага хийлгүүлэх | 4 | | | |
| 7 | | ТХ301.Аз7. “Ядуурал ихсэж байна уу? Багасаж байна уу?” гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл (enguiry-based project) боловсруулах, хэрэгжүүлэх | | 3 | | |
| 8 | ТХ302. ӨЛСГӨЛӨНГ ТЭГЛЭХ | ТХ302.Аз1. Татвар, төрийн татаас, тариф, квот зэргийн нөлөөлөлд өртөмтгий дэлхийн зах зээлийн том тоглогчид болох бизнес эрхлэгчдийг жижиг дунд бизнес эрхлэгчидтэй харьцуулан дүрд хувилан тоглох | | | 2 | |
| 9 | | ТХ302.Аз2. Орон нутгийн, үндэсний хэмжээний хоол хүнсний үйлдвэрлэл, хэрэглээний тогтолцоо, хүнсний үйлдвэрлэлийн тогтолцоонд байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үзүүлэх нөлөөллийн талаар тооцоолол (scenario) ба задлан шинжилгээ хийх | | 1 | | |
| 10 | | ТХ302.Аз3. Өлсгөлөнтэй тэмцэх, хоол хүнсний хаягдлыг бууруулах, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих зорилготой төрийн бодлого, менежментийн стратегиудын тохиромжтой эсэхийг тогтоох баримтжуулсан кэйс судалгаа явуулж задлан шинжилгээ хийх (case study analysis) | | 2 | | |
| 11 | | ТХ302.Аз4. Тогтвортой хөдөө аж ахуйн чиглэлээр сайн туршлага хуримтлуулж буй газруудад экскурс хийх, танилцах аялал (field trips) зохион байгуулах | | | 3 | |
| 12 | | ТХ302.Аз5. Суурин газрын эсвэл сургуулийн ногооны талбайн төсөл хэрэгжүүлэх гэх мэтээр хоол хүнсийг фермд тарьж ургуулахаас эхлээд, хоол бэлтгэгдэх хүртэлх үе шатуудыг судлах | | 5 | | |
| 13 | | ТХ302.Аз6. Илүүдэл хоол хүнсний үлдэгдлийг хэрэгцээтэй хүмүүст нь хүргэх хүчин зүтгэлд сурагчдыг татан оролцуулах | 5 | | | |
| 14 | | ТХ302.Аз7. Хоол хүнсний үйлдвэрлэл, хэрэглээний эргэлтийн мөчлөгүүдийг шинжлэх (Life cycle analyses-LCA) | | 1 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15 | ТХ303. САЙН ЭРҮҮЛ МЭНД, САЙН САЙХАН БАЙДАЛ | ТХ303.Аз1. Олон нийт цуглардаг газарт мэдээлэл, тухайлбал, "Дэлхийн ДОХ-ын өдөр (12-р сарын 1)"-т зориулсан самбар бэлтгэж тавих | 1 | | | |
| 16 | | ТХ303.Аз2. Эрүүл зан үйлийг дэмжсэн видео үзэх. Тухайлбал, аюулгүй сексийн төлөө бэлгэвч хэрэглэх, тамхи татахаас татгалзах гэх мэт | 7 | | | |
| 17 | | ТХ303.Аз3. Эрүүл саруул, сайн сайхан байдлын утга учир гэж юу болох тухай ёс зүй, эргэцүүллийн хэлбэртэй эссэ бичиж, хэлэлцүүлэгт оролцох | | | 1 | |
| 18 | | ТХ303.Аз4. Хүнд өвчинд нэрвэгдсэн, хар тамхинд донтсон хүмүүсээр түүхийг нь яриулах арга хэмжээнд оролцох | 5 | | | |
| 19 | | ТХ303.Аз5. Эрүүл мэндийг дэмжиж, өвчнөөс урьдчилан сэргийлэх стратегийн талаар сургалт зохион байгуулах, Тухайлбал, биеийн тамир спортын үйл ажиллагаанд оролцох, эрүүл хоол хүнс бэлтгэх, бэлгэвч хэрэглэх, шумуулаас хамгаалах тор суурилуулах, усаар дамжин халдварладаг өвчний эх сурвалжийг илрүүлэх, арилгах арга хэмжээ авах гэх мэт | 5 | | | |
| 20 | | ТХ303.Аз6. Тахал, орон нутгийн онцлогтой өвчинд холбогдох төслүүд хэрэгжүүлэх: Ололт амжилт ба сорилт бэрхшээлүүд (Халуун хижиг, Zika, Ebola вирус гэх мэт) | | 5 | | |
| 21 | | ТХ303.Аз7. "Урт удаан амьдрах нь сайн зүйл мөн үү?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 22 | ТХ304. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ | ТХ304.Аз1. Дэлхийн янз бүрийн бүс дэх дунд сургуулиуд, их сургуулиуд болон боловсролын үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагууд хоорондын түншлэлийг хөгжүүлэх (Өмнөд – Хойд, Өмнөд – Өмнөд) | 3 | | | |
| 23 | | ТХ304.Аз2. Чанартай боловсролын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулахад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны кампанит ажил төлөвлөн, хэрэгжүүлэх | 2 | | | |
| 24 | | ТХ304.Аз3. Сонгож авсан тодорхой нэг нутагт эсвэл тухайн нэг улс орны боловсролын тогтолцоо, түүний хүртээмжийн талаар кэйс судалгаа хийх Тухайлбал, бага боловсролын хамран сургалт гэх мэт | | 2 | | |
| 25 | | ТХ304.Аз4. Дунд сургууль, их сургууль эсвэл орон нутгийн олон нийтийн бүлэгт зориулсан ТХБ-ын төслийг төлөвлөн хэрэгжүүлэх | 6 | | | |
| 26 | | ТХ304.Аз5. НҮБ-ын “Залуучуудын ур чадварын өдөр” (7-р сарын 15), “Олон улсын бичиг үсэгт тайлагдах өдөр” (9-р сарын 8), эсвэл “Олон улсын багш нарын өдөр” (10-р сарын 5) тэмдэглэн өнгөрүүлэх эсвэл “Боловсролын төлөөх дэлхий нийтийн үйлийн долоо хоног”-ийн үйл ажиллагаанд оролцох | 1 | | | |
| 27 | | ТХ304.Аз6. Орон нутаг, бүс нутаг, үндэсний түвшинд “Тогтвортой хөгжлийн боловсролын өдөр”-ийг зохион байгуулах | 1 | | | |
| 28 | | ТХ304.Аз7. "Тогтвортой сургууль гэж юу вэ?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 29 | ТХ305. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ | ТХ305.Аз1. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг арилгах олон улсын өдөр” (11-р сарын 25)-ийг тэмдэглэн өнгөрүүлэх | 1 | | | |
| 30 | | ТХ305.Аз2. Жендэрийн ялгаа, бэлгийн чиг хандлагад суурилсан, хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг урьж, илтгэл тавиулах | 5 | | | |
| 31 | | ТХ305.Аз3. Жендэрийн үүрэг оролцоонд суурилсан тусгай хэрэгцээ, онцлог шинжийг олж илрүүлэх зорилгоор дүрд хувилан тоглох | | | 2 | |
| 32 | | ТХ305.Аз4. Жендэрийн тухай өөр өөр арга хандлагатай дэлхийн янз бүрийн хэсэгт байгаа хүмүүсийн бүлгүүдтэй түншлэл тогтоох | 3 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 33 | | ТХ305.Аз5. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн уламжлалт ажил үйлд нэг өдрийн туршид гар бие оролцож үзэх (ажил үүргээ сольж гүйцэтгэх) | 5 | | | |
| 34 | | ТХ305.Аз6. Байгалийн гамшиг, аюул занал нь охид, эмэгтэйчүүд ба хөвгүүд, эрчүүдэд хэрхэн ялгаатайгаар нөлөөлж байгааг олж илрүүлэх | | 1 | | |
| 35 | | ТХ305.Аз7. "Эрх тэгш байдал (equality) ба нийгэм соёлын ялгаатай байдал (equity) гэсэн ойлголт ямар ялгаатай вэ? Эдгээр ойлголт ажил хөдөлмөр дээр хэрхэн хэрэглэгддэг вэ?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 36 | ТХ306. ЦЭВЭР УС БА АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ | ТХ306.Аз1. Өөрсдийн усны хэрэглээний ул мөрийг тооцоолох | | 2 | | |
| 37 | | ТХ306.Аз2. Амжилтын түүхүүдэд үндэслэн орон нутгийн усны тогтвортой хэрэглээ ба нийлүүлэлтийн тухай тодорхой үзэл баримтлал боловсруулах | | | | 4 |
| 38 | | ТХ306.Аз3. Усны нөөц ихтэй эсвэл усны хомсдолтой бүс нутагт орших байгаа сургууль хоорондын түншлэлийг хөгжүүлэх | 3 | | | |
| 39 | | ТХ306.Аз4. Орон нутгийн усны дэд бүтэцтэй танилцах экскурс зохион байгуулах, сургуулийн ба гэрийнхээ усны чанарт хяналт-шинжилгээ хийх | | | 3 | |
| 40 | | ТХ306.Аз5. Ус, түүний ач холбогдлын тухай олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулахад чиглэсэн ухуулга сурталчилгааны кампанит ажил эсвэл залуучуудын оролцоо бүхий тодорхой үйл ажиллагааны төсөл (youth action project) төлөвлөж, хэрэгжүүлэх | 2, 6 | | | |
| 41 | | ТХ306.Аз6. Харагддаггүй ч бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд зарцуулдаг усны асуудлаар төслийн ажил боловсруулах. Тухайлбал, 1 литр шар айраг, 1 кг үхрийн мах, 1 футболкийг үйлдвэрлэхэд зарцуулдаг усны хэмжээ гэх мэт | | 5 | | |
| 42 | | ТХ306.Аз7. "Ус байхгүй бол хүний үйл ажиллагаанд юу тохиолдож болох вэ?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 43 | ТХ307. БОЛОМЖИЙН ҮНЭТЭЙ, ЦЭВЭР ЭРЧИМ ХҮЧ | ТХ307.Аз1. Сэргээгдэх эрчим хүчний технологиор туршилт явуулах | | 4 | | |
| 44 | | ТХ307.Аз2. Өөрсдийн эрчим хүчний хэрэглээний талаар эргэцүүлэн бодож хэлэлцэх. Тухайлбал, суурь хэрэгцээ (хоол хийхэд зарцуулах эрчим хүч)-гээ хангаж байна уу, эсвэл тансаг амьдралын хэв маягт (усан сан ашиглахад зарцуулах эрчим хүч) зориулан хэрэглэж байна уу гэсэн чиглэлээр эрчим хүчний хэрэглээний шалтгаанаа эрэмбэлэх | | | 1 | |
| 45 | | ТХ307.Аз3. Эрчим хүчний үйлдвэрлэл ба түгээлтийн сүлжээнд хамрагдах газруудаар хийх экскурсийг эрчим хүчний төрлүүд ба төслүүдийн давуу, сул талын ёс зүйг хөндсөн хэлэлцүүлэгтэйгээр зохион байгуулах | | | 1, 3 | |
| 46 | | ТХ307.Аз4. Эрчим хүчний ирээдүйн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээний талаар тооцооллын шинжилгээ (scenario analyses) хийх | | 1 | | |
| 47 | | ТХ307.Аз5. Өөрийн байгууллагын эсвэл орон нутгийн түвшинд эрчим хүч хэмнэх кампанит ажил зохион байгуулах | 2 | | | |
| 48 | | ТХ307.Аз6. Бидэнд өдөр тутам хэрэгцээтэй талх, овьёос зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хэдий хэмжээний эрчим хүч зарцуулдаг тухай бүлэг хүмүүсийн төсөл (group project) хэрэгжүүлэх | | 5 | | |
| 49 | | ТХ307.Аз7. "Эрчим хүч нь хүний сайн сайхан байдалтай хэрхэн холбогддог вэ?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 50 | ТХ308. ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ | ТХ308.Аз1. Эдийн засгийн өсөлтийн янз бүрийн загварын талаар сөрөг аргумент дэвшүүлэн мэтгэлцэж тоглох | | | 2 | |
| 51 | | ТХ308.Аз2. Эрсдэл хүлээж болзошгүй ч нийгэмд тусгайлсан ашиг тусаа өгөх бизнес (social entrepreneurial) ба эрсдэл хүлээж болзошгүй ч нийгэмд нийтлэг ашиг тусаа өгөх бизнес (entrepreneurial) төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх | | | | 3 |
| 52 | | ТХ308.Аз3. Сурагчдыг орон нутгийн бизнестэй холбож дадлагажуулах | 4 | | | |
| 53 | | ТХ308.Аз4. Ажил олгогч ба ажиллагчидтай ярилцлага хийж, тэдний хэрэгцээ, ирээдүйн чиг хандлагыг олж илрүүлэх | | 1 | | |
| 54 | | ТХ308.Аз5. Амьдралын болон ажил мэргэжлийн албан тушаалын хэд хэдэн түүх замналын зураглал хийх | | | | 2 |
| 55 | | ТХ308.Аз6. Танхимын сургалтад ажил олгогчдыг оролцуулах | 5 | | | |
| 56 | | ТХ308.Аз7. "Миний ажил мэргэжил, албан тушаал тогтвортой хөгжилд ямар хувь нэмэр оруулж чадах вэ?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 57 | ТХ309. ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИ, ДЭД БҮТЭЦ | ТХ309.Аз1. Цахилгаан эрчим хүч огт байхгүй хэмээн төсөөлж, дүрд тоглох | | | 2 | |
| 58 | | ТХ309.Аз2. Байгалийн аюулт үзэгдлийн дараа бизнес, аж ахуйн байгууллагууд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд нь зориулсан орон нутгийн төлөвлөгөө боловсруулах | | 2 | | |
| 59 | | ТХ309.Аз3. Өөрийн оршин суугаа газрын эрчим хүчний хүчдэл унасан тохиолдолд хэрхэн ажиллах төлөвлөгөөг боловсруулах | | | | 3 |
| 60 | | ТХ309.Аз4. Чулуужсан түлш нефтэн бүтээгдэхүүн ашигладаггүй тээвэртэй дэлхийг төсөөлсөн хэтийн зорилгыг тодорхойлох | | | | 1 |
| 61 | | ТХ309.Аз5. Өөрөө харьяалагддаг нийгмийн бүлгийн хувьд аль нэг материаллаг болон нийгмийн дэд бүтцийг сонгон авч судлах төслийг боловсруулах | | 5 | | |
| 62 | | ТХ309.Аз6. Олон нийтийн бүлгүүд цуглан хамтрах орон зайг бий болгоход сурагчид, хүүхэд залуучуудыг татан оролцуулах | 5 | | | |
| 63 | | ТХ309.Аз7. "Инновац бүхэн сайн зүйл мөн үү?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 64 | ТХ310. ТЭГШ БУС БАЙДЛЫГ БАГАСГАХ | ТХ310.Аз1. Шударга бус, тэгш бус хандлагын сэтгэл зүйд үзүүлэх үр нөлөөний тухай эсвэл байгалийн гамшгаас учрах үр дагавар нь орон нутгийн иргэдийн хувьд өмнө нь байсан тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлдэг талаар хэлэлцэх зорилготой дүрд хувилан тараан хуваарилах тоглоом (simple distribution game) тоглох | | | 2 | |
| 65 | | ТХ310.Аз2. Өөрийн байгууллагадаа ажилладаг хүмүүсийн нийгмийн ялгаатай зэрэг зиндаанд харьяалагдах байдлыг шинжлэн судлах | | 1 | | |
| 66 | | ТХ310.Аз3. Дэлхий нийтийн худалдааны тогтолцоо дахь тэгш бус байдлын асуудлаар олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааны болон улс төрийн кампанит ажил төлөвлөх | 2 | | | |
| 67 | | ТХ310.Аз4. Өөрийнхөө ажил амьдралын явцад давуу эрх эдэлж байсан эсвэл эсрэгээр ялгаварлан гадуурхагдаж байсан үеийн хувийн түүхийг задлан шинжлэх | | 1 | | |
| 68 | | ТХ310.Аз5. Эмзэг байдалд байгаа хүмүүстэй ярилцлага хийх (цагаачид гэх мэт) | | 2 | | |
| 69 | | ТХ310.Аз6. Орон нутагт нь байгаа цагаачид, дүрвэгчдийн нөхцөл байдлын талаарх ойлголтоо веб хуудас болон блог хөтөлж тэмдэглэх | | | 4 | |
| 70 | | ТХ310.Аз7. “Хүмүүсийн аз жаргалд тэгш бус байдал хэрхэн нөлөөлдөг вэ?” гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 71 | ТХ311. ТОГТВОРТОЙ ХОТ СУУРИН БА ОРШИН СУУГЧИД | ТХ311.Аз1. Эко тосгон болон "амьдралын лабораториуд (living laboratories)" гэж нэрлэгддэг туршилтын хотхон, бохир ус цэвэрлэх байгууламж, өнөөгийн тулгамдсан болон сайн туршлагуудыг харж болох үйлчилгээний бусад төвүүд дээр танилцах аялал хийх | | | 3 | |
| 72 | | ТХ311.Аз2. Тогтвортой хот, орон нутгийн нэгжүүдэд зориулсан залуучуудын оролцоо бүхий тодорхой үйл ажиллагааны төсөл (youth action project) боловсруулж хэрэгжүүлэх | 6 | | | |
| 73 | | ТХ311.Аз3. Хүн амын суурьшил нь цаг хугацааны туршид хэрхэн өөрчлөгдөж ирсэн талаар ахмад хүмүүсийг урьж ярилцлага хийх. Тэднээс тухайн бүс нутгийнхаа байгальд (bioregion) хэрхэн дасан зохицож амьдарсан талаар асуух. Аливаа суурьшлын бүс нутаг, түүний өөрчлөлтийн түүхийг судлан мэдэхдээ уран зураг, уран зохиол, түүхийн эх сурвалжийг ашиглах | 5 | | | |
| 74 | | ТХ311.Аз4. Орон нутгийн цэцэрлэгт хүрээлэн байгуулах | 5 | | | |
| 75 | | ТХ311.Аз5. Зураглал гаргах төслүүд: зураглалд нийтийн эзэмшлийн задгай талбайг сайн ашиглаж буй хэсгүүд, хүний биеийн хэмжээст тохируулсан төлөвлөлт, тухайн орон нутаг дахь анхаарал тавих шаардлагатай хэсгүүд, ногоон байгууламж зэргийг тэмдэглэх. Мөн байгалийн аюул, гамшигт өртсөн буюу сайжруулах шаардлагатай газар нутгийг тэмдэглэж болно. | | 5 | | |
| 76 | | ТХ311.Аз6. Тогтвортой хот, суурины жишээг харуулсан 2 минутын видео клип хийх | | | 4 | |
| 77 | | ТХ311.Аз7. "Хэрэв бид бүгдээрээ хот суурин газарт амьдардаг байсан бол илүү тогтвортой байдлыг хангаж чадах байсан уу?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 78 | ТХ312. ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ БА ҮЙЛДВЭРЛЭЛ | ТХ312.Аз1. Хувь хүний экологийн ул мөрийг тооцоолж, эргэцүүлэн тусгах | | 2 | | |
| 79 | | ТХ312.Аз2. Гар утас, компьютер, хувцас зэрэг янз бүрийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба хэрэглээний эргэлтийн мөчлөгүүдийг (Life Cycle Analysis /LCA) задлан шинжлэх | | 1 | | |
| 80 | | ТХ312.Аз3. Тогтвортой бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулах чиглэлээр оюутан сурагчдын компани ажиллуулах | 6 | | | |
| 81 | | ТХ312.Аз4. Худалдааны системд оролцдог үйлдвэрлэгч, сурталчлагч, хэрэглэгч, хог хаягдлын менежер зэрэг янз бүрийн тоглогчдын дүрд хувилан тоглох | | | 2 | |
| 82 | | ТХ312.Аз5. Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба хэрэглээний хэв загварыг ойлгож мэдэхэд нь туслах зорилгоор суралцагчдад богино хэмжээний уран сайхны, баримтат кино үзүүлэх. (*Story of Stuff* by Annie Leonard http://storyofstuff.org/movies/story-of-stuff) | 7 | | | |
| 83 | | ТХ312.Аз6. Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба хэрэглээтэй холбоотой залуучуудын оролцоо бүхий тодорхой үйл ажиллагааны төсөл боловсруулан хэрэгжүүлэх (загвар зохион бүтээх, технологи гэх мэт) | 6 | | | |
| 84 | | ТХ312.Аз7. "Тогтвортой байдалд хүрэхэд аливаа зүйлийг дураа хүрэхээр хийдэг, дургүйгээ хүрэхээр хаядаг байж болох уу?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 85 | | ТХ313.Аз1. Цаг уурын өөрчлөлттэй холбоотой үзэгдлийн нөлөөллийг тал бүрээс нь үнэлж тооцох, мэдэрч ойлгохын тулд дүрд тоглох | | | 2 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 86 | ТХ313. УУР АМЬСГАЛЫН ТӨЛӨӨХ ҮЙЛ ХЭРЭГ | ТХ313.Аз2. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой таамаглал, үр дагавар, хөгжлийн өмнөх замналын талаарх янз бүрийн тооцоололд задлан шинжилгээ хийх | | 1 | | |
| 87 | | ТХ313.Аз3. Уур амьсгалын өөрчлөлтөөс сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааны төсөл, кампанит ажил боловсруулан хэрэгжүүлэх | 2 | | | |
| 88 | | ТХ313.Аз4. Уур амьсгалын өөрчлөлтөд хамаарах асуудлуудыг шийдвэрлэхэд олон нийтийн хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэхийн тулд веб хуудас, блог үүсгэж хөтлөх | | | 4 | |
| 89 | | ТХ313.Аз5. Уур амьсгалд зэлтэй түүх намтрыг зохиох | | | | 2 |
| 90 | | ТХ313.Аз6. Тухайн нэг орон нутагт уур амьсгалын өөрчлөлт нь гамшгийн эрсдэлийг хэрхэн нэмэгдүүлж байгаа тухай кэйс судалгаа боловсруулах | | 2 | | |
| 91 | | ТХ313.Аз7. "Агаар мандалд хамгийн их хохирол учруулж буй этгээд нь хохирлын төлбөрийг төлөх ёстой" гэсэн мэдэгдлийн дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 92 | ТХ314. УСАН ДООРХ АМЬДРАЛ | ТХ314.Аз1. Усан доорх амьдралтай холбоотой залуучуудын оролцоо бүхий тодорхой үйл ажиллагааны төсөл боловсруулан хэрэгжүүлэх. | 6 | | | |
| 93 | | ТХ314.Аз2. Далай тэнгисийн эрэг орчмын газарт экскурс хийх | | | 3 | |
| 94 | | ТХ314.Аз3. Сургууль дээрээ загас агнуурын нөөцийн тогтвортой менежмент, хэрэглээний талаар мэтгэлцэх | | | 1 | |
| 95 | | ТХ314.Аз4. Далайн усны түвшин нэмэгдсэнээс шалтгаалан эх газарт нүүдэллэж буй арлын иргэдийн дүрд хувиран тоглох | | | 2 | |
| 96 | | ТХ314.Аз5. Янз бүрийн улс орон дахь далай тэнгистэй холбоотой соёлын болон ахуй амьжиргааны харилцан хамаарлын талаар кэйс судалгаа явуулах | | 2 | | |
| 97 | | ТХ314.Аз6. Далайн ус хүчиллэг чанартай байдгийг сурагчдад нотолж харуулах лабораторийн туршилт явуулах | | 4 | | |
| 98 | | ТХ314.Аз7. "Бидэнд далай хэрэгтэй юу эсвэл далайд бид хэрэгтэй юу?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 99 | ТХ315. ГАЗАР ДЭЭРХ АМЬДРАЛ | ТХ315.Аз1. Төрөл бүрийн зэрлэг ан амьтны тоо толгойн тархалт, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнд саад тотгор учруулдаг г зам харгуй мэтийн саад тотгорууд ба хор нөлөөлөлтэй амьтан ургамлын төрөл зүйл зэргийг тэмдэглэх | | 2 | | |
| 100 | | ТХ315.Аз2. Орон нутгийн иргэд цуглаж, тухайн газар нутагт байгаа амьтны төрөл зүйлээс аль болох олныг бүртгэх үйл ажиллагаа буюу био-довтолгооны жил бүрийн нэг өдөр тогтмол хэрэгжүүлж, биологийн төрөл зүйлийн бүртгэл (bioblitz)-ийн зураглал хөтлөх | | | 3 | |
| 101 | | ТХ315.Аз3. Органик материалын найрлага, үүсэл гарлыг үзүүлж, таниулах зорилготой хаягдлын боловсруулалттай бордоогоор хөрс бордох семинар сургалт зохион байгуулах | 6 | | | |
| 102 | | ТХ315.Аз4. Соёлын үүргийг харуулах зорилготой тухайлбал, нөхөн сэргээх, амраах тайвшруулах, урлаг/уран зургийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ойролцоох цэцэрлэгт хүрээлэнд экскурс хийх | | | 3 | |
| 103 | | ТХ315.Аз5. Зэрлэг ан амьтанд зориулсан байгалийн зэрлэг цэцэрлэг байгуулах. Тухайлбал, зөгийд ээлтэй цэцэг тарих, хорхой шавжид тохиромжтой сууц барих, усан сан, цөөрөм байгуулах гэх мэт | 6 | | | |
| 104 | | ТХ315.Аз6. "Эх дэлхийн өдөр" (4-р сарын 22), "Дэлхийн хүрээлэл орчны өдөр (6-р сарын 5)"-ийг тус тус тэмдэглэн өнгөрүүлэх | 1 | | | |
| 105 | | ТХ315.Аз7. "Биологийн төрөл зүйлийн олон янз байдал яагаад чухал юм бэ?" гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 106 | ТХ316. ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁС БА ХҮЧИРХЭГ ИНСТИТУЦУУД | ТХ316.Аз1. Шударга бус байдлын хохирогч болсон дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүсийн дүрд хувиран тоглох | | | 2 | |
| 107 | | ТХ316.Аз2. Шударга ёс, тэгш байдлын тухай сургууль, коллежийн хотхонд үзэл бодол, итгэл үнэмшлээ хуваалцах шашин хоорондын харилцан яриа (interfaith dialogues) зохион байгуулах | | | 1 | |
| 108 | | ТХ316.Аз3. Орон нутгийн шүүх, цагдаагийн байгууллагад экскурс зохион байгуулах | | | 3 | |
| 109 | | ТХ316.Аз4. Сургуулийн “Шударга ёс гэж юу вэ?” сэдэвт зурагт хуудас бүтээх | | | 1 | |
| 110 | | ТХ316.Аз5. Түүхийн болон соёлын хам нөхцөлтэй холбоотой шударга ёсны асуудлаар мэтгэлцээн хийх. Тухайлбал, Аргентин дахь шударга ёс хумигдалт, Өмнөд Африк дахь арьс өнгөний ялгаварлан гадуурхалт болон хэрхэн тэдгээр шударга ёсны асуудлууд шийдвэрлэгдэж хөгжсөн гэх мэт | | | 1 | |
| 111 | | ТХ316.Аз6. Олон улсын “ Энх тайвны өдөр” (9 сарын 21) -ийг тэмдэглэн өнгөрүүлэх | 1 | | | |
| 112 | | ТХ316.Аз7. “Энх амгалан дэлхий ямар харагдах вэ?” гэсэн асуултын дагуу шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |
| 113 | ТХ317. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ | ТХ317.Аз1. Дэлхийн өнцөг булан бүрд байдаг дунд сургуулиуд их дээд сургуулиуд, болон боловсролын бусад байгууллагуудын хоорондох түншлэл ба олон улсын вебэд суурилан зайнаас боловсролын туршлагаа хуваалцах солилцоог хөгжүүлэх (Өмнөд ба Хойд; Хойд ба Хойд буюу хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудын хооронд) | 3 | | | |
| 114 | | ТХ317.Аз2. Уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн олон янз байдлын асуудлаар дэлхий нийтэд баримталж буй бодлогуудын замнал хөгжил болон тэдгээрийн хэрэгжилтийг задлан шинжлэх | | 1 | | |
| 115 | | ТХ317.Аз3. Дэлхий нийтийн болон үндэсний түвшинд ТХЗ-ын хэрэгжилтээр гарч буй ахиц дэвшилд задлан шинжилгээ хийж, илэрсэн амжилт ололт болон алдаа дутагдалд хэн хариуцлага хүлээх ёстойг тодорхойлох | | 1 | | |
| 116 | | ТХ317.Аз4. ТХЗ-ын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх кампанит ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх | 2 | | | |
| 117 | | ТХ317.Аз5. Тогтвортой хөгжлийн гол асуудлыг зөвшилцөн хэлэлцэх олон улсын бага хурлуудыг загварчлан дуурайж тоглох (Simulation games). Тухайлбал, НҮБ-ын Үндэсний Загвар гэх мэт | | | 2 | |
| 118 | | ТХ317.Аз6. ТХЗ, тэдгээрийн ач холбогдлын талаар залуучуудын оролцоо бүхий тодорхой үйл ажиллагааны төсөл төлөвлөн хэрэгжүүлэх | 6 | | | |
| 119 | | ТХ317.Аз7. "Бид хамтдаа чадна... гэсэн түгээмэл хэллэгийг ухаарч, түүнийг ТХЗ-ийг хэрэгжүүлэхэд хэрхэн ашиглагдаж байгаа” сэдвээр талаар шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах | | 3 | | |

## Хавсралт 4.

### Тогтвортой байдлын түлхүүр 8 цогц чадамж

**1.** Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж **(Systems thinking competency):**

- аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэн, ойлгох чадвар,
- нийлмэл тогтолцоог задлан шинжлэх чадвар;
- тогтолцоо нь төрөл бүрийн ай болоод хэмжээсийн хүрээнд хэрхэн уялдан нэгдсэн байдаг тухай сэтгэн бодох чадвар;
- тодорхойгүй байдлыг авч үзэх чадвар зэрэг болно.

2. Урьдчилан тооцоолох цогц чадамж (Anticipatory competency):

- боломжтой, магадлалтай, эсвэл хүсүүштэй гэх мэт ирээдүйд болох олон янзын үйл явдлыг ойлгож, үнэлэх чадвар;
- ирээдүйд зориулан өөрийн үзэл бодол, дүр зургийг бий болгох чадвар;
- урьдчилан сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх чадвар;
- үйлийн үр дагаврыг үнэлж, дүгнэх чадвар;
- эрсдэл болон өөрчлөлтийг шийдвэрлэх чадвар;

3. Хэм хэмжээний цогц чадамж (Normative competency):

- хэн нэгний үйл, хөдлөлийн учир шалтгаан болсон хэм хэмжээ, үнэлэмжийг ойлгож, түүний талаар эргэцүүлэн бодох чадвар;
- тогтвортой байдлын үнэт зүйл, зарчим, зорилго, зорилтын талаар ашиг сонирхлын зөрчилтэй, харилцан ашигтай, тодорхойгүй мэдлэг чадвартай, эсэргүүцэлтэй тулгарсан нөхцөл байдалд ч хэлэлцээр хийх чадвар;

4. Стратегийн цогц чадамж (Strategic competency):

- Орон нутгийн болон илүү өргөн хүрээнд цаашдын тогтвортой байдлыг дэмжсэн шинэлэг, дэвшилтэт үйл хэргийг хамт олноороо нэгдэн боловсруулж, хэрэгжүүлэх чадвар;
- Тухайн асуудлын төлөв байдалд интервенц, шилжилт хийх, засаглалыг хувирган өөрчилж, сайжруулах стратегийн хувилбарууд боловсруулах, сонгох чадвар

5. Хамтран ажиллах цогц чадамж (Collaboration competency):

- бусдаас суралцах чадвар;
- бусдын хэрэгцээ шаардлага, үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож, хүндэтгэх чадвар (өөрийгөө бусдын оронд тавьж ойлгох чадвар);
- бусдыг ойлгож, харилцан хамааралтай байж, мэдрэмжтэй хандах чадвар (сэтгэл санааны манлайлал);
- багаараа хамтран аливаа зөрчил, мөргөлдөөнийг шийдвэрлэх чадвар;
- асуудлыг шийдвэрлэхэд оролцоог ханган хамтын хүчийг зохицуулах чадвар;

### 6. Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж (Critical thinking competency):

- тогтсон хэм хэмжээ, дадал туршлага, үзэл бодлын талаар асуудал дэвшүүлэх чадвар;
- өөрийн үнэлэмж, ойлголт, үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох чадвар;
- тогтвортой байдлын тухай яриа хэлэлцээрт өөрийн гэсэн байр суурьтай байх чадвар;

### 7. Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж (Self-awareness competency):

- дэлхий нийтийн болон орон нутгийн түвшинд өөрийн гүйцэтгэх үүрэг оролцоог үнэлэх, эргэцүүлэн бодох чадвар;
- өөрийн үйл ажиллагаанд тасралтгүй үнэлгээ дүгнэлт өгч, цаашид урам зориг өгөх чадвар;
- өөрийн мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх чадвар;

### 8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамж (Integrated problem-solving competency):

- ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд төрөл бүрийн тогтолцоог хэрэглэх чадвар;
- ТХ-ийн нарийн нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд бусад цогц чадамжуудаа хэрэглэн хүмүүсийн тусгай хэрэгцээ шаардлага (inclusive) ба эрх тэгш байдал (equitablity)-ыг хангасан шийдлийн хувилбар боловсруулах чадвар багтана.

## Хавсралт 5.

## Сургалтын цөм хөтөлбөрийн ТХЗБ-д хамаарах суралцахуйн зорилт

| № | БТ | Хичээлийн нэр | ТХЗБ-ын СЗ | Тогтвортой хөгжлийн зорилго | | | | | | | | | | | | | | | | | Σ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | |
| Хэл, хүмүүнлэгийн ухаан | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | ББ | Монгол хэл | **Нийт** | **1** | | **4** | | **1** | **3** | | | | | **2** | **2** | | | | **1** | | ***14*** |
| | | | ТМ | | | 1 | | | 1 | | | | | | | | | | | | ***2*** |
| | | | НСХ | 1 | | 2 | | | 1 | | | | | 1 | 2 | | | | 1 | | ***8*** |
| | | | ЗТ | | | 1 | | 1 | 1 | | | | | 1 | | | | | | | ***4*** |
| 2 | СБ | Монгол хэл | **Нийт** | | | **3** | | | **2** | | | | | | **1** | **1** | | **1** | | | ***8*** |
| | | | ТМ | | | 1 | | | 1 | | | | | | | 1 | | 1 | | | ***4*** |
| | | | НСХ | | | 1 | | | 1 | | | | | | 1 | | | | | | ***3*** |
| | | | ЗТ | | | 1 | | | | | | | | | | | | | | | ***1*** |
| 3 | БДБ | Монгол хэл | **Нийт** | **1** | | **1** | **1** | | | | | | | | | | | **2** | | | ***5*** |
| | | | ТМ | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | НСХ | 1 | | | | | | | | | | | | | | 1 | | | ***2*** |
| | | | ЗТ | | | 1 | 1 | | | | | | | | | | | 1 | | | ***3*** |
| 4 | СБ | Уран зохиол | **Нийт** | | | **3** | **2** | | | | | | | | | | | **1** | | | ***6*** |
| | | | ТМ | | | 1 | | | | | | | | | | | | | | | ***1*** |
| | | | НСХ | | | | 2 | | | | | | | | | | | 1 | | | ***3*** |
| | | | ЗТ | | | 2 | | | | | | | | | | | | | | | ***2*** |
| 5 | БДБ | Уран зохиол | **Нийт** | **1** | | **1** | **1** | | | | | | | | | | | **1** | | | ***4*** |
| | | | ТМ | 1 | | | 1 | | | | | | | | | | | | | | ***2*** |
| | | | НСХ | | | 1 | | | | | | | | | | | | 1 | | | ***2*** |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | СБ | Үндэсний бичиг | **Нийт** | | | | **1** | | **1** | | | **1** | | | | | | **2** | | | ***5*** |
| | | | ТМ | | | | 1 | | 1 | | | 1 | | | | | | 1 | | | ***4*** |
| | | | НСХ | | | | | | | | | | | | | | | 1 | | | ***1*** |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 7 | БДБ | Үндэсний бичиг | **Нийт** | | | | | | | | | | | | **1** | **1** | | | | | ***2*** |
| | | | ТМ | | | | | | | | | | | | 1 | 1 | | | | | ***2*** |
| | | | НСХ | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 8 | ББ | Англи хэл | **Нийт** | | | | **5** | | | | | | | | | | | | | | ***5*** |
| | | | ТМ | | | | 3 | | | | | | | | | | | | | | ***3*** |
| | | | НСХ | | | | 2 | | | | | | | | | | | | | | ***2*** |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 9 | СБ | Англи хэл | **Нийт** | | | **2** | **5** | | | | | | | | | | | **3** | | | ***10*** |
| | | | ТМ | | | | 3 | | | | | | | | | | | | | | ***3*** |
| | | | НСХ | | | | 2 | | | | | | | | | | | 3 | | | ***5*** |
| | | | ЗТ | | | 2 | | | | | | | | | | | | | | | ***2*** |
| 10 | БДБ | Англи хэл | **Нийт** | | **1** | | | | | | | | | **2** | **3** | **3** | | | | | ***9*** |
| | | | ТМ | | 1 | | | | | | | | | 1 | 1 | 3 | | | | | ***6*** |
| | | | НСХ | | | | | | | | | | | 1 | 1 | | | | | | ***2*** |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | 1 | | | | | | ***1*** |
| 11 | СБ | Орос хэл | **Нийт** | | | **2** | | | **1** | | | | | | | | | **1** | | | ***4*** |
| | | | ТМ | | | 1 | | | 1 | | | | | | | | | 1 | | | ***3*** |
| | | | НСХ | | | 1 | | | | | | | | | | | | | | | ***1*** |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | ББ | Биеийн тамир | **Нийт** | | | **6** | | | | | | | | | | | | | | | *6* |
| | | | ТМ | | | 2 | | | | | | | | | | | | | | | *2* |
| | | | НСХ | | | 1 | | | | | | | | | | | | | | | *1* |
| | | | ЗТ | | | 3 | | | | | | | | | | | | | | | *3* |
| 13 | СБ | Биеийн тамир | **Нийт** | | | **9** | | | | | | | | **1** | | | | | | | *10* |
| | | | ТМ | | | 4 | | | | | | | | | | | | | | | *4* |
| | | | НСХ | | | 1 | | | | | | | | 1 | | | | | | | *2* |
| | | | ЗТ | | | 4 | | | | | | | | | | | | | | | *4* |
| 14 | БДБ | Биеийн тамир | **Нийт** | | | **14** | | | | | | | | | | | | | | | *14* |
| | | | ТМ | | | 6 | | | | | | | | | | | | | | | *6* |
| | | | НСХ | | | 1 | | | | | | | | | | | | | | | *1* |
| | | | ЗТ | | | 7 | | | | | | | | | | | | | | | *7* |
| Математик, мэдээллийн технологи | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 15 | ББ | Математик | **Нийт** | | | **1** | | | | **1** | | | | **1** | | | | **1** | | | *4* |
| | | | ТМ | | | | | | | 1 | | | | | | | | 1 | | | *2* |
| | | | НСХ | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | ЗТ | | | 1 | | | | | | | | 1 | | | | | | | *2* |
| 16 | СБ | Математик | **Нийт** | **1** | | | **4** | | | | **2** | | | **1** | | | | | | | *8* |
| | | | ТМ | 1 | | | 1 | | | | | | | 1 | | | | | | | *3* |
| | | | НСХ | | | | 2 | | | | 2 | | | | | | | | | | *4* |
| | | | ЗТ | | | | 1 | | | | | | | | | | | | | | *1* |
| 17 | БДБ | Математик | **Нийт** | **1** | **1** | | | | **1** | **1** | **3** | | **1** | | | | | | | **2** | *10* |
| | | | ТМ | 1 | 1 | | | | | 1 | 3 | | 1 | | | | | | | 2 | *9* |
| | | | НСХ | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | ЗТ | | | | | | 1 | | | | | | | | | | | | *1* |
| 18 | СБ | Мэдээллийн технологи | **Нийт** | | | | | | **2** | | | **1** | | | | | | **1** | | **1** | *5* |
| | | | ТМ | | | | | | 1 | | | 1 | | | | | | 1 | | 1 | *4* |
| | | | НСХ | | | | | | 1 | | | | | | | | | | | | *1* |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 19 | БДБ | Мэдээллийн технологи | **Нийт** | **2** | **1** | **1** | | | **4** | | | **1** | | | | | | | **1** | | *10* |
| | | | ТМ | 1 | 1 | | | | | | | 1 | | | | | | | | | *3* |
| | | | НСХ | | | | | | 4 | | | | | | | | | | | | *4* |
| | | | ЗТ | 1 | | 1 | | | | | | | | | | | | | 1 | | *3* |
| Түүх, нийгмийн ухаан | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 20 | ББ | Хүн ба орчин | **Нийт** | | | **3** | | **3** | | | | | **1** | **18** | **3** | **7** | | **3** | | | *38* |
| | | | ТМ | | | 1 | | | | | | | | 11 | | 3 | | | | | *15* |
| | | | НСХ | | | 1 | | | | | | | 1 | 6 | 3 | 3 | | 3 | | | *17* |
| | | | ЗТ | | | 1 | | 3 | | | | | | 1 | | 1 | | | | | *6* |
| 21 | ББ | Хүн ба нийгэм | **Нийт** | | | **3** | | | | | | | | **4** | **1** | | | **1** | | **1** | *10* |
| | | | ТМ | | | | | | | | | | | 2 | 1 | | | | | | *3* |
| | | | НСХ | | | 1 | | | | | | | | 1 | | | | 1 | | 1 | *4* |
| | | | ЗТ | | | 2 | | | | | | | | 1 | | | | | | | *3* |
| 22 | СБ | Түүх | **Нийт** | | **2** | **1** | **1** | **1** | | | | **1** | **1** | **1** | **1** | | | **1** | **2** | | *12* |
| | | | ТМ | | 2 | | | | | | | | 1 | 1 | 1 | | | | 1 | | *6* |
| | | | НСХ | | | 1 | 1 | 1 | | | | 1 | | | | | | 1 | 1 | | *6* |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 23 | СБ | Нийгмийн ухаан | **Нийт** | **1** | | | **2** | **1** | **1** | **1** | **4** | | **1** | **1** | **1** | | | | | **1** | *14* |
| | | | ТМ | | | | 2 | 1 | | | 1 | | | | 1 | | | | | | *5* |
| | | | НСХ | | | | | | | 1 | 2 | | | 1 | | | | | | 1 | *5* |
| | | | ЗТ | 1 | | | | | 1 | | 1 | | 1 | | | | | | | | *4* |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | БДБ | Нийгмийн ухаан | **Нийт** | **1** | | **1** | **1** | **1** | | | **3** | **1** | **1** | | **2** | | | | **4** | **2** | ***17*** |
| | | | ТМ | 1 | | 1 | 1 | | | | 2 | 1 | 1 | | | | | | 3 | 1 | ***11*** |
| | | | НСХ | | | | | | | | 1 | | | | | | | | 1 | | ***2*** |
| | | | ЗТ | | | | | 1 | | | | | | | 2 | | | | | 1 | ***4*** |
| Урлаг, дизайн, технологи | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 25 | ББ | Хөгжим | **Нийт** | | | **2** | **1** | | **1** | | | | | **1** | | **1** | | | **1** | | ***7*** |
| | | | ТМ | | | | 1 | | | | | | | | | | | | | | ***1*** |
| | | | НСХ | | | | | | 1 | | | | | 1 | | 1 | | | 1 | | ***4*** |
| | | | ЗТ | | | 2 | | | | | | | | | | | | | | | ***2*** |
| 26 | СБ | Хөгжим | **Нийт** | | | **1** | **1** | | **1** | | | | | | | **1** | | **1** | | | ***5*** |
| | | | ТМ | | | | 1 | | | | | | | | | | | | | | ***1*** |
| | | | НСХ | | | 1 | | | 1 | | | | | | | | | 1 | | | ***3*** |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | 1 | | | | | ***1*** |
| 27 | ББ | Дүрслэх урлаг, технологи | **Нийт** | | | **1** | | | | | **1** | | | **1** | **2** | | | **1** | | | ***6*** |
| | | | ТМ | | | | | | | | | | | 1 | 1 | | | | | | ***2*** |
| | | | НСХ | | | | | | | | 1 | | | | | | | 1 | | | ***2*** |
| | | | ЗТ | | | 1 | | | | | | | | | 1 | | | | | | ***2*** |
| 28 | СБ | Дүрслэх урлаг, технологи | **Нийт** | | | | **1** | | | | | | | **1** | **1** | | | **3** | | | ***6*** |
| | | | ТМ | | | | 1 | | | | | | | 1 | | | | 1 | | | ***3*** |
| | | | НСХ | | | | | | | | | | | | 1 | | | 2 | | | ***3*** |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 29 | СБ | Дизайн, технологи | **Нийт** | | **1** | **1** | **3** | | | | **2** | **1** | | | **3** | | | **1** | | **1** | ***13*** |
| | | | ТМ | | | | 1 | | | | 1 | 1 | | | | | | | | | ***3*** |
| | | | НСХ | | | | 2 | | | | 1 | | | | 2 | | | 1 | | | ***6*** |
| | | | ЗТ | | 1 | 1 | | | | | | | | | 1 | | | | | 1 | ***4*** |
| 30 | БДБ | Дизайн, технологи | **Нийт** | | **3** | **2** | **1** | **1** | | | **2** | | | **1** | | | **1** | | | | ***11*** |
| | | | ТМ | | 3 | | 1 | | | | | | | 1 | | | | | | | ***5*** |
| | | | НСХ | | | 2 | | 1 | | | 1 | | | | | | | | | | ***4*** |
| | | | ЗТ | | | | | | | | 1 | | | | | | 1 | | | | ***2*** |
| Байгалийн ухаан | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 31 | ББ | Хүн ба байгаль | **Нийт** | | | **1** | | | | **1** | | | | **1** | | | | **2** | | | ***5*** |
| | | | ТМ | | | | | | | | | | | | | | | 2 | | | ***2*** |
| | | | НСХ | | | | | | | 1 | | | | 1 | | | | | | | ***2*** |
| | | | ЗТ | | | 1 | | | | | | | | | | | | | | | ***1*** |
| 32 | СБ | Физик | **Нийт** | | **1** | | | | **1** | **7** | | | | | | | | | | | ***9*** |
| | | | ТМ | | *1* | | | | *1* | *5* | | | | | | | | | | | ***7*** |
| | | | НСХ | | | | | | | *2* | | | | | | | | | | | ***2*** |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 33 | БДБ | Физик | **Нийт** | | | | | | | **7** | | | | | **1** | **2** | | | | | ***10*** |
| | | | ТМ | | | | | | | *4* | | | | | *1* | *1* | | | | | ***6*** |
| | | | НСХ | | | | | | | *3* | | | | | | *1* | | | | | ***4*** |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 34 | СБ | Биологи | **Нийт** | | **4** | **12** | | | | | | | | | **1** | | | **7** | | | ***24*** |
| | | | ТМ | | *3* | *7* | | | | | | | | | *1* | | | *3* | | | ***14*** |
| | | | НСХ | | *1* | *1* | | | | | | | | | | | | *3* | | | ***5*** |
| | | | ЗТ | | | *4* | | | | | | | | | | | | *1* | | | ***5*** |
| 35 | БДБ | Биологи | **Нийт** | | **1** | **16** | | | **3** | | | | | | **1** | **4** | | **9** | | | ***34*** |
| | | | ТМ | | *1* | *12* | | | *2* | | | | | | *1* | *4* | | *7* | | | ***27*** |
| | | | НСХ | | | *1* | | | *1* | | | | | | | | | *1* | | | ***3*** |
| | | | ЗТ | | | *3* | | | | | | | | | | | | *1* | | | ***4*** |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | СБ | Хими | **Нийт** | | | | | | **5** | | | | | | | **2** | | **1** | | | **8** |
| | | | ТМ | | | | | | 1 | | | | | | | 1 | | 1 | | | **3** |
| | | | НСХ | | | | | | 1 | | | | | | | | | | | | **1** |
| | | | ЗТ | | | | | | 3 | | | | | | | 1 | | | | | **4** |
| 37 | БДБ | Хими | **Нийт** | | **1** | | | | **1** | **4** | | **5** | | | **5** | **2** | | **1** | | | **19** |
| | | | ТМ | | 1 | | | | 1 | 4 | | 5 | | | 5 | 2 | | 1 | | | **19** |
| | | | НСХ | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | ЗТ | | | | | | | | | | | | | | | | | | |
| 38 | СБ | Газарзүй | **Нийт** | | | | | | **2** | **2** | **1** | **1** | | | **1** | **4** | | **5** | | **1** | **17** |
| | | | ТМ | | | | | | | 2 | 1 | 1 | | | | 4 | | 3 | | | **11** |
| | | | НСХ | | | | | | 1 | | | | | | 1 | | | 1 | | | **3** |
| | | | ЗТ | | | | | | 1 | | | | | | | | | 1 | | 1 | **3** |
| 39 | БДБ | Газарзүй | **Нийт** | **2** | **2** | **1** | **1** | | **6** | **3** | **6** | **2** | **2** | **3** | **2** | **5** | **1** | **5** | | | **41** |
| | | | ТМ | 2 | 1 | 1 | 1 | | 4 | 3 | 6 | 2 | 1 | 2 | 2 | 3 | 1 | 3 | | | **32** |
| | | | НСХ | | | | | | 1 | | | | 1 | 1 | | 1 | | | | | **4** |
| | | | ЗТ | | 1 | | | | 1 | | | | | | | 1 | | 2 | | | **5** |
| Сургалтыг дэмжих үйл ажиллагаа | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 40 | ББ | Иргэний боловсрол | **Нийт** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **17** |
| | | | ТМ | | 1 | | 1 | | | | | | 1 | | | | 1 | | | | **4** |
| | | | НСХ | 1 | | | | 1 | 1 | 1 | 1 | 1 | | 1 | 1 | 1 | | | 1 | 1 | **11** |
| | | | ЗТ | | | 1 | | | | | | | | | | | | 1 | | | **2** |
| 41 | СБ | Иргэний боловсрол | **Нийт** | | | **2** | **7** | **1** | | | **1** | | **2** | | | **1** | | **4** | **1** | | **19** |
| | | | ТМ | | | | 3 | | | | | | 1 | | | 1 | | 1 | | | **6** |
| | | | НСХ | | | 2 | 3 | 1 | | | 1 | | 1 | | | | | 2 | 1 | | **11** |
| | | | ЗТ | | | | 1 | | | | | | | | | | | 1 | | | **2** |
| 42 | ББ | Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа | **Нийт** | **2** | **3** | **1** | **1** | **1** | **2** | **2** | | | | **1** | | **1** | | **2** | | | **16** |
| | | | ТМ | | 1 | 1 | | 1 | 1 | 1 | | | | | | 1 | | 1 | | | **7** |
| | | | НСХ | 2 | 2 | | 1 | | | | | | | 1 | | | | | | | **6** |
| | | | ЗТ | | | | | | 1 | 1 | | | | | | | | 1 | | | **3** |
| 43 | СБ | Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа | **Нийт** | **1** | **1** | **2** | **1** | **1** | **2** | **2** | **1** | **1** | | **1** | **1** | **1** | | **2** | **1** | **1** | **19** |
| | | | ТМ | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | НСХ | | | 1 | 1 | | | 1 | 1 | | | 1 | 1 | | | 2 | | | **8** |
| | | | ЗТ | 1 | 1 | 1 | | 1 | 2 | 1 | | 1 | | | | 1 | | | 1 | 1 | **11** |
| 44 | ББ | Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | **Нийт** | | | **4** | **4** | | | | | | | **1** | | | | | **3** | **2** | **14** |
| | | | ТМ | | | 1 | | | | | | | | 1 | | | | | 2 | | **4** |
| | | | НСХ | | | 1 | 1 | | | | | | | | | | | | | 2 | **4** |
| | | | ЗТ | | | 2 | 3 | | | | | | | | | | | | 1 | | **6** |
| 45 | СБ | Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | **Нийт** | | **1** | **5** | **4** | **1** | **1** | | | | **1** | **1** | **1** | | | | | | **15** |
| | | | ТМ | | 1 | 1 | 1 | 1 | | | | | | 1 | | | | | | | **5** |
| | | | НСХ | | | 1 | 3 | | | | | | 1 | | 1 | | | | | | **6** |
| | | | ЗТ | | | 3 | | | 1 | | | | | | | | | | | | **4** |
| 56 | БДБ | Сургуулийн мэдлийн цаг | **Нийт** | **1** | | **1** | **3** | **1** | **4** | **1** | **1** | **1** | **1** | **2** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **1** | **22** |
| | | | ТМ | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | НСХ | | | | 3 | | 2 | 1 | 1 | | | 2 | 1 | | | 1 | | 1 | **12** |
| | | | ЗТ | 1 | | 1 | | 1 | 2 | | | 1 | 1 | | | 1 | 1 | | 1 | | **10** |
| Нийт (ТХЗБ-ын СЗ) | | | | **16** | **24** | **18** | **52** | **14** | **45** | **33** | **28** | **17** | **12** | **46** | **36** | **38** | **4** | **64** | **16** | **14** | **567** |
| Танин мэдэхүй (ТМ)-н айн СЗ | | | | 7 | 18 | 41 | 23 | 3 | 15 | 21 | 14 | 13 | 6 | 23 | 16 | 25 | 2 | 28 | 6 | 4 | **265** |
| Нийгэмшил-сэтгэл хөдлөл (НСХ) айн СЗ | | | | 5 | 3 | 21 | 23 | 4 | 16 | 1 | 12 | 2 | 4 | 19 | 15 | 7 | | 27 | 6 | 6 | **18** |
| Зан үйл (ЗҮ)-ийн айн СЗ | | | | 4 | 3 | 46 | 6 | 7 | 14 | 2 | 2 | 2 | 2 | 4 | 5 | 6 | 2 | 9 | 4 | 4 | **122** |

## Хавсралт 6.

### Сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗБ-д хамаарах сургалтын арга

| № | Хичээл | БТ | ТХЗ-ын төлөөх боловсролын сургалтын арга | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бодит үйл ажиллагаанд оролцох | Шинжилгээ/ судалгаа хийх | Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх | Алсын хараатай болох | |
| Хэл, хүмүүнлэгийн ухаан | | | | | | | |
| | Монгол хэл | ББ | 6 | 5 | 6 | 6 | 23 |
| | | СБ | | | 8 | | 8 |
| | | БДБ | | 3 | 2 | | 5 |
| | Уран зохиол | СБ | 2 | 6 | 5 | 2 | 15 |
| | | БДБ | | 3 | 4 | | 7 |
| | Үндэсний бичиг | СБ | 1 | 1 | 1 | 2 | 5 |
| | | БДБ | | 1 | 2 | | 3 |
| | Англи хэл | ББ | 1 | 4 | 5 | | 10 |
| | | СБ | 4 | | 7 | 1 | 12 |
| | | БДБ | 4 | 15 | 16 | 3 | 38 |
| | Орос хэл | СБ | 1 | | 3 | 2 | 6 |
| | Биеийн тамир | ББ | 9 | 2 | | | 11 |
| | | СБ | 12 | 2 | 3 | 1 | 18 |
| | | БДБ | 11 | 5 | 8 | | 24 |
| Математик, мэдээллийн технологи | | | | | | | |
| | Математик | ББ | 3 | 2 | 2 | 3 | 10 |
| | | СБ | 6 | 7 | 2 | 6 | 21 |
| | | БДБ | | 6 | 2 | 2 | 10 |
| | Мэдээллийн технологи | СБ | 2 | 4 | 2 | | 8 |
| | | БДБ | 6 | 5 | 5 | 4 | 20 |
| Түүх, нийгмийн ухаан | | | | | | | |
| | Хүн ба орчин | ББ | 14 | 31 | 9 | 12 | 66 |
| | Хүн ба нийгэм | ББ | 7 | 3 | 8 | 3 | 21 |
| | Түүх | СБ | 1 | 6 | 10 | 2 | 19 |
| | Нийгмийн ухаан | СБ | 3 | 11 | 8 | 4 | 26 |
| | | БДБ | 6 | 11 | 6 | 3 | 26 |
| Урлаг, дизайн, технологи | | | | | | | |
| | Хөгжим | ББ | 2 | | 4 | 1 | 7 |
| | | СБ | 1 | 2 | 3 | | 6 |
| | Дүрслэх урлаг, технологи | ББ | 1 | 2 | 3 | | 6 |
| | | СБ | 2 | 2 | 3 | | 7 |
| | Дизайн, технологи | СБ | 5 | 4 | 2 | 2 | 13 |
| | | БДБ | 2 | 3 | | | 5 |
| Байгалийн ухаан | | | | | | | |
| | Хүн ба байгаль | ББ | 4 | 2 | 2 | 3 | 11 |
| | Физик | СБ | 3 | 7 | 3 | 4 | 17 |
| | | БДБ | 6 | 8 | 2 | 2 | 18 |
| | Биологи | СБ | 11 | 5 | 14 | 7 | 37 |
| | | БДБ | 13 | 18 | 3 | | 34 |
| | Хими | СБ | | 7 | | 4 | 11 |
| | | БДБ | 2 | 17 | 5 | 4 | 28 |
| | Газар зүй | СБ | 7 | 13 | 10 | 3 | 33 |
| | | БДБ | 5 | 26 | 9 | 1 | 41 |
| Сургалтын дэмжих үйл ажиллагаа | | | | | | | |
| | Иргэний боловсрол | ББ | 7 | 2 | 7 | 3 | 19 |
| | | СБ | 7 | 5 | 4 | 3 | 19 |
| | АЧСҮА | ББ | 8 | 6 | 5 | | 19 |
| | | СБ | 16 | 9 | 8 | 6 | 39 |
| | Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | ББ | 10 | | 2 | 6 | 18 |
| | | СБ | 13 | 11 | 13 | 12 | 49 |
| | СМЦ | БДБ | 11 | 15 | 7 | 13 | 46 |
| Нийт | | **Тоо** | **235** | **297** | **233** | **130** | **895** |
| | | **Хувь** | **26.3%** | **33.2%** | **26.0%** | **14.5%** | **100.0** |

## Хавсралт 7.

### Тогтвортой байдлын цогц чадамжийн төлөвшилд цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр

| № | Хичээл | БТ | ТБ-ын цогц чадамж | | | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1. Тогтолцоот сэтгэлгээний | 2. Урьдчилан тооцоолох | 3. Хэм хэмжээний | 4. Стратегийн | 5. Хамтран ажиллах | 6. Шүүмжлэлт сэтгэлгээний | 7. Өөрийгөө таньж мэдэх | 8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн | |
| Хэл, хүмүүнлэгийн ухаан | | | | | | | | | | | |
| | Монгол хэл | ББ | 5 | 7 | 3 | 3 | 7 | 7 | 7 | | 39 |
| | | СБ | 1 | | | | 8 | 8 | 6 | 3 | 26 |
| | | БДБ | 3 | | | | 2 | 3 | 1 | | 9 |
| | Уран зохиол | СБ | 5 | 2 | 2 | 3 | 3 | 5 | 2 | 1 | 23 |
| | | БДБ | 1 | 1 | 1 | | 2 | 2 | 1 | 1 | 9 |
| | Үндэсний бичиг | СБ | | 1 | | | 1 | 1 | 2 | | 5 |
| | | БДБ | | | | | 1 | 2 | | | 3 |
| | Англи хэл | ББ | 1 | 4 | | | 4 | | | | 9 |
| | | СБ | | | | | 7 | 1 | 3 | | 11 |
| | | БДБ | 8 | 7 | 6 | | 6 | 8 | 7 | | 42 |
| | Орос хэл | СБ | 3 | 1 | 1 | | 1 | 1 | 1 | | 8 |
| | Биеийн тамир | ББ | 1 | | 2 | | 3 | | | | 6 |
| | | СБ | 1 | 6 | 3 | | 9 | 3 | 8 | | 30 |
| | | БДБ | 4 | 3 | 4 | | 6 | 2 | 7 | | 26 |
| Математик, мэдээллийн технологи | | | | | | | | | | | |
| | Математик | ББ | | 3 | 1 | 1 | | | 1 | 1 | 7 |
| | | СБ | 7 | 6 | 2 | 2 | 3 | | | 1 | 21 |
| | | БДБ | 2 | 4 | | | 1 | 1 | 1 | | 9 |
| | Мэдээллийн технологи | СБ | | 2 | 2 | | 1 | 3 | | | 8 |
| | | БДБ | 1 | 1 | 1 | 2 | 3 | 2 | | 1 | 11 |
| Түүх, нийгмийн ухаан | | | | | | | | | | | |
| | Хүн ба орчин | ББ | 8 | 10 | 5 | 6 | 13 | 9 | 4 | 12 | 67 |
| | Хүн ба нийгэм | ББ | 4 | 2 | | | 6 | 3 | 7 | 4 | 26 |
| | Түүх | СБ | 2 | 5 | 1 | | | 5 | 1 | | 14 |
| | Нийгмийн ухаан | СБ | 3 | 3 | | | 2 | 8 | 3 | | 19 |
| | | БДБ | 8 | 1 | 4 | 3 | 3 | 3 | 2 | 1 | 25 |
| Урлаг, дизайн, технологи | | | | | | | | | | | |
| | Хөгжим | ББ | | 1 | | | 1 | 3 | 2 | | 7 |
| | | СБ | 2 | 1 | 1 | | 1 | 1 | 1 | | 7 |
| | Дүрслэх урлаг, технологи | ББ | 4 | | | | 2 | 3 | 2 | | 11 |
| | | СБ | 4 | | 1 | | 1 | 2 | 4 | | 12 |
| | Дизайн, технологи | СБ | 4 | 2 | 1 | 2 | 2 | 1 | | 1 | 13 |
| | | БДБ | 1 | 2 | 2 | 1 | 4 | | 1 | | 11 |
| Байгалийн ухаан | | | | | | | | | | | |
| | Хүн ба байгаль | ББ | 2 | 2 | | 2 | 1 | | 1 | | 8 |
| | Физик | СБ | 5 | 2 | 1 | 2 | 2 | 6 | | 1 | 19 |
| | | БДБ | 4 | 2 | 1 | 2 | 4 | 6 | | 4 | 23 |
| | Биологи | СБ | 11 | 14 | 4 | 2 | 9 | 4 | 7 | 1 | 52 |
| | | БДБ | 13 | 14 | | | 5 | 2 | | | 34 |
| | Хими | СБ | 1 | | 1 | | | | 6 | | 8 |
| | | БДБ | 9 | 11 | 5 | 1 | | 1 | 6 | 1 | 34 |
| | Газар зүй | СБ | 6 | 6 | 1 | 5 | 5 | 4 | 4 | 2 | 33 |
| | | БДБ | 24 | 5 | | 1 | 3 | 2 | 3 | 3 | 41 |
| Сургалтыг дэмжих үйл ажиллагаа | | | | | | | | | | | |
| | Иргэний боловсрол | ББ | 2 | 2 | 1 | 2 | 5 | 3 | 1 | 2 | 18 |
| | | СБ | 2 | 2 | 2 | 1 | 5 | | 1 | 3 | 16 |
| | АЧСҮА | ББ | 3 | 4 | 2 | 4 | 3 | 3 | 3 | 2 | 24 |
| | | СБ | 6 | 6 | | 1 | 11 | 7 | 4 | | 35 |
| | Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | ББ | | 1 | | 2 | 4 | 1 | 3 | | 11 |
| | | СБ | 10 | 7 | 3 | 7 | 12 | 6 | 14 | | 59 |
| | СМЦ | БДБ | | 6 | 2 | 1 | 6 | 4 | 9 | | 28 |
| Нийт | | Тоо | 181 | 159 | 66 | 56 | 178 | 136 | 136 | 45 | 957 |
| | | Хувь | 18.9 | 16.6 | 6.9 | 5.9 | 18.6 | 14.2 | 14.2 | 4.7 | 100% |



ISBN 9919-9714-1-3
9 789919 971410